

Улсын бүртгэлийн
дугаар.....

Нууцын зэрэглэл: А

Аравтын бүрэн ангиллын код

Төсөл гүйцэтгэх гэрээний
дугаар: ШуУз-2017/07

БОЛОВСРОЛЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ
“МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ
(1992-2017)
ТУРШЛАГА, СУРГАМЖ”

Шинжлэх ухаан, технологийн төслийн тайлан
2017-2019

Төслийн удирдагч:

Н.Бэгз – Академич

Санхүүжүүлэгч байгууллага:

Шинжлэх Ухаан, Технологийн Сан

Захиалагч байгууллага:

Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан,
Спортын Яам

Тайлан өмчлөгч байгууллага:

Боловсролын Шинжлэх Ухааны
Академи

Улаанбаатар

2019

Гүйцэтгэгчид:

Р.Бандий	БШУА, Доктор (Ph.D.), дэд проф.
Б.Баярмаа	Боловсролын хүрээлэн, Магистр
Б.Баярсайхан	Боловсролын хүрээлэн, Магистр
Б.Баярцэцэг	БШУА, Доктор (Ph.D.)
Н.Бэгз	БШУА, Академич
Ц.Лхагвасүрэн	Боловсролын хүрээлэн, Магистр (Psy.Ed.), дэд проф.
Д.Наранцэцэг	Боловсролын хүрээлэн
Ш.Оюунцэцэг	Багшийн мэргэжил дээшлүүлэх институт
О.Пүрэв	БШУА, доктор (Sc.D.), проф.
С.Санжаабадам	Боловсролын хүрээлэн, Доктор (Ph.D.), дэд проф.
Х.Цэцэгжаргал	Боловсролын хүрээлэн, Магистр
Б.Энхбаяр	Боловсролын хүрээлэн, Магистр (Psy.Ed.)
Г.Энхбат	Ажил мэргэжлийн стандарт, ур чадварын Төв, Магистр

Хамтран ажилласан байгууллага:

Боловсролын хүрээлэн
Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний Зөвлөл
Завхан аймгийн БСУГазар
МУБИС-ийн Сэтгэл судлалын тэнхим
Хөвсгөл аймгийн БСУГазар
ШУА-ийн Түүхийн хүрээлэн
ШУТИС-ийн Олон улсын дээд боловсролын төв

Хамтран ажилласан хүмүүс:

Б.Анхбаяр, Магистр
Ж.Ариунболд, Доктор (Ph.D.)
Ж.Батдэлгэр, Доктор (Ph.D.), дэд, проф.
Е.Батчулуун, Доктор (Ph.D.), дэд, проф.
Д.Баяр, Магистр
Ц.Гэлэгжамц, Доктор (Ph.D.), дэд, дэд проф.
У.Туяа, Доктор (Ph.D.)

Агуулга

Хүснэгтийн жагсаалт.....	5
Зургийн жагсаалт.....	7
Товчилсон үгийн жагсаалт.....	8
Талархал.....	9
ХУРААНГУЙ.....	10
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ	18
Боловсролын бодлогын үндсэн асуудлууд.....	18
Боловсролыг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэх бодлого.....	19
Боловсролын бодлогын баримт бичгүүдийн шинжилгээ.....	20
Хямралын жилүүдийн Монголын боловсролын бодлого, хэрэгжилт.....	27
Боловсрол дахь хямралыг даван туулсан нь.....	32
Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгын хөгжил, байдал.....	39
Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хөгжлийн шинжилгээ.....	56
Дүгнэлт.....	62
Боловсролын зорилго, агуулга, зохион байгуулалт.....	63
Сурах бичгийн бодлого, тогтолцоо.....	66
Сургуулийн өмнөх боловсрол.....	68
Дээд боловсролын хөгжлийн бодлого.....	73
Багш нарын мэргэшил дээшлүүлэх үйл явц.....	75
Монголын боловсрол судлалын шинэчлэл, өөрчлөлт.....	100
Боловсролын магадлан итгэмжлэл.....	107
Боловсролын эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа.....	109
Албан бус боловсрол.....	114
Үндэсний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсрол.....	117
ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ.....	119
Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн судалгааны үр дүн.....	119
Сургуулийн өмнөх боловсролын хөгжил.....	137
Монгол улсын ерөнхий боловсрол.....	139
Үндэстний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсрол.....	154
Тусгай хэрэгцээт боловсрол.....	160
Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн байдал, хөгжил.....	166

Дээд боловсролын хөгжлийн өнөөгийн байдал, хөгжил	177
Боловсролын магадлан итгэмжлэл.....	214
Сурах бичиг.....	220
Багш боловсролын хөгжлийн байдал	232
Сургалтын орчны өнөөгийн байдал	258
ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУРШЛАГААС АВАХ СУРГАМЖ	293
Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгын хөгжлийн сургамж, асуудал	293
Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний талаар практикийн хувьд (багш нараас гаргасан саналын үндсэн дээр) авах сургамж, шийдэх зарим асуудал:	295
Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар цаашид шийдвэрлэх асуудлууд.....	297
Монголын боловсрол судлалын хөгжлийн цаашдын хандлага, шаардлага.....	298
Багшийн хөгжлийн хандлага, шийдэх асуудлууд	304
Монгол улсын үндэсний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролыг цаашид хөгжүүлэх нь	310
Насан туршийн боловсролын ирээдүй	315
Боловсролын эрх зүйг цаашид шинэчлэх зорилт	318
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАМЖААС ХИЙХ ДҮГНЭЛТ	320
ТАВДУГААР БҮЛЭГ. АЖ ҮЙЛДВЭРИЙН ДӨРӨВ ДЭХ ХУВЬСГАЛЫН ҮЕИЙН МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН НОМЛОЛ.....	324
Нэг. Үндэслэл	324
Хоёр. Өөрчлөгдөн буй Дэлхий, амьдралын орчны хөгжлийн шинэ хандлага	324
Гурав. Шинэ цаг үеийн монгол хүний хөгжилд тавигдаж буй шаардлагууд.....	326
Дөрөв. Монголын боловсролын шинэ бодлого	330
СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	332
ХАВСРАЛТ.....	343

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Боловсролын санхүүжилтийн үзүүлэлт (1990-1997).....	29
Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийн үзүүлэлт	29
Хүснэгт 3. 1990-1999 онд сургууль завсардсан хүүхдийн тооны өөрчлөлт	30
Хүснэгт 4. Бага, дунд сургуулийн сурагчдын тооны өөрчлөлт	32
Хүснэгт 5. Үндсэн ба туслах багшийн тоо	34
Хүснэгт 6. 1994-1995 оны хичээлийн жилд мөрдөх ЕБС-ийн сургалтын төлөвлөгөө	42
Хүснэгт 7. Агуулгын болон боловсролын стандартын харьцуулалт.....	45
Хүснэгт 8. Сургалтын хөтөлбөрүүдийн шинэчлэл (2008-2015 оны байдлаар).....	50
Хүснэгт 9. Монголын ерөнхий боловсролын байгалын ухааны сургалтын агуулгын түвшинг олон улсынхтай харьцуулсан нь	52
Хүснэгт 10. 1998-2016 онд хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдийн бүтэц, агуулгын хэсэгчилсэн тойм шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр)	53
Хүснэгт 11. Зарим улс орнуудын ба Монголын сургалтын хөтөлбөрийн зорилгын харьцуулалт	58
Хүснэгт 12. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн эмпирик судалгааны үр дүнгээс	59
Хүснэгт 13. Бодлогын баримт бичгүүд	63
Хүснэгт 14. Үнэт зүйлсийн жагсаалт	64
Хүснэгт 15. Сурах бичгийн тогтолцоо	66
Хүснэгт 16. Сурах бичгийн бодлогын баримт бичгүүд	67
Хүснэгт 17. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын агуулга.....	71
Хүснэгт 18. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл	100
Хүснэгт 19. 1998-2016 онд хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдийн бүтэц, агуулгын хэсэгчилсэн тойм шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр)	142
Хүснэгт 20. Ээлжит хичээл төлөвлөхөд тулгардаг бэрхшээлүүд, хувиар	146
Хүснэгт 21. Зарим улс орон ба Монголын сургалтын хөтөлбөрийн зорилгын харьцуулалт ..	151
Хүснэгт 22. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн эмпирик судалгааны үр дүнгээс	152
Хүснэгт 23. Унших, бичих чадварын сорилын ерөнхий дүн	157
Хүснэгт 24. Сурагчийн 2013 болон 2017 оны унших, бичих чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэл (хувиар).....	158
Хүснэгт 25. Багшийн 2013 болон 2017 оны унших, бичих, хэл зүйн мэдлэг, чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэл (хувиар)	158
Хүснэгт 26. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн үечлэл	167
Хүснэгт 27. Монгол улсын дээд боловсролын салбарын зарим үзүүлэлт, 2016	180
Хүснэгт 28. Их сургуулийн нийт ажиллагчдын тоо, 2016	181
Хүснэгт 29. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажилд ороход зарцуулсан хугацаа, сургуулийн төрлөөр	183
Хүснэгт 30. I-V ангид хэрэглэх багц сурах бичгийн жин (граммаар).....	229
Хүснэгт 31. ЕБС-ийн анги бүрийн бүх хичээлийн сурах бичгийн үнийн дундаж	231
Хүснэгт 32. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш нарын тоо.....	238
Хүснэгт 33. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан удирдах болон бусад ажилтны тоо	238
Хүснэгт 34. Суудлын тоо	263
Хүснэгт 35. Анги танхимын талбай.....	266

<i>Хүснэгт 36. Кабинетийн талбай</i>	269
<i>Хүснэгт 37. Самбарын хэмжээ (см)</i>	270
<i>Хүснэгт 38. Шалнаас самбарын доод ирмэг хүртэлх зай (см)</i>	270
<i>Хүснэгт 39. Сандал, ширээний зохист хэмжээ (хөвгүүд/охид)</i>	272
<i>Хүснэгт 40. Төслүүдийн санхүүжилтийн хэмжээ</i>	285
<i>Хүснэгт 41. Боловсролын салбарын хөнгөлөлттэй зээлийн төслүүд</i>	287

Зургийн жагсаалт

Зураг 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо.....	33
Зураг 2. Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын биеийн жингийн дундаж үзүүлэлт, см .	126
Зураг 3. Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт, кг	127
Зураг 4. 6-21 настай хүүхэд, залуучуудын хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек.....	128
Зураг 5. 6-21 настай хүүхэд, залуучуудын тэсвэрийн чанарын дундаж үзүүлэлт, сек.....	130
Зураг 6. Монгол улсын боловсролын тогтолцоо	167
Зураг 7. МБС-ын удирдлагын тогтолцооны бүтэц (2004-2009 он)	170
Зураг 8. МБС-н удирдлагын тогтолцоо 2009-2012 он.....	171
Зураг 9. МБС-ын удирдлагын тогтолцоо (2012-2016).....	172
Зураг 10. МБС-ын удирдлагын тогтолцоо (2016 оноос хойш).....	173
Зураг 11. Мэргэжлийн боловсрол, сургалтын хэв шинж	176
Зураг 12. Төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын орлогын бүтэц	182
Зураг 13. Дээд боловсролын салбарын өсөлт ба магадлан итгэмжлэлийн явц	215
Зураг 14. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо	216
Зураг 15. Магадлан итгэмжлэгдсэн.....	216
Зураг 16. 2014-2018 онд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийг мэргэжлийн чиглэлээр харуулсан байдал.....	216
Зураг 17. Урьдчилсан магадлан итгэмжлэлийн хөтөлбөр, 2017-2018.....	217
Зураг 18. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр	218
Зураг 19. Үндсэн сургалтын бүтэц.....	238
Зураг 20. Барилга байгууламжийн насжилт	259
Зураг 21. Сурагчдад үйлчлэх үйлчилгээ.....	263
Зураг 22. Кабинетийн зориулалт.....	268
Зураг 23. Самбарын өнгө	271
Зураг 24. Сурагчдын оролцоо ба анги зохион байгуулалтын хэлбэр	278
Зураг 25. Сурагчдын идэвх, оролцоонд гарсан өөрчлөлт	278
Зураг 26. Анги зохион байгуулалт ба сурлагын амжилтын хамаарал	278
Зураг 27. Сурагчдын стрессийн өөрчлөлт	279
Зураг 28. Эцэг эхийн оролцоо ба сурлагын амжилтын хамаарал	280
Зураг 29. Багшийн дарамт шахалт ба сурлагын амжилтын хамаарал	280
Зураг 30. Үе тэнгийнхний харилцааны дарамт ба сурлагын амжилтын хамаарал	280

Товчилсон үгийн жагсаалт

АББ	Албан бус боловсрол
АББЗСҮТ	Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв
АХБ	Азийн Хөгжлийн Банк
БДБ	Бүрэн дунд боловсрол
БМИҮЗ	Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл
БХАН	Боловсролын хамтын ажиллагааны нийгэмлэг
БСШУЯ	Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны Яам
БНБД	Барилгын норм ба дүрэм
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ЕБ	Ерөнхий боловсрол
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗАН	Заах аргын нэгдэл
ЗХУ	Зөвлөлт холбоот улс
ИДС	Их, дээд сургууль
ЭЕШ	Элсэлтийн ерөнхий шалгалт
МСҮТ	Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв
МУБИС	Монгол улсын боловсролын их сургууль
МХТ	Мэдээлэл, харилцааны технологи
НТБ	Насан туршийн боловсрол
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
СӨББ	Сургуулийн өмнөх боловсролын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТМБ	Техник, мэргэжлийн боловсрол
ҮЦГМХБСС	Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдүүдийн боловсролын судалгааны сектор
ХБНГУ	Холбооны бүгд найрамдах Герман улс
ХБХЭТК	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц
ХЗЗ	Хөдөлмөрийн зах зээл
ШУА	Шинжлэх ухааны академи

Талархал

Монгол Улсын хувьд 1992-2017 он нь нийгмийн социалист чиг баримжаатай байгууллаас зах зээлийн эдийн засгийн байгуулалд шилжих шилжилтийн шинэ тутам, хямралт байдалтай хүнд үе байсан юм. Энэ утгаараа Монгол Улсын боловсролын түүхэн дэх 1990-2017 он бол манай боловсролын системийн шинэчлэлийн чухал үе юм.

Энэ үеийн боловсролын тогтолцооны хөгжлийн замналыг тодруулж харах юм бол Монгол улсын боловсролыг төрөөс удирдахдаа 1/ боловсролыг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэх бодлогын үе, 2/ нийгэм, эдийн засгийг бүхэлд нь хамарсан хямралын жилүүдийн боловсролын бодлогын үе, 3/ боловсролыг хямралаас гаргаж, улмаар түүний хөгжлийг дэмжиж байсан бодлогын үе гэж хувааж авч үзэж болохоор харагдаж байна.

Энэ адармаатай цаг үеийн боловсролын хөгжлийн үйл явц, төлөв байдал, түүнээс авах сургамжийг олж тогтооно гэдэг нь цаг хугацаа, ажлын их дадлага, туршлага шаардсан ажил байна. Монголын боловсролын энэ үеийн хөгжлийн асуудалд сүбъектив байр сууринаас үнэлэлт дүгнэлт өгөхөөсөө илүүтэй, явж ирсэн цаг хугацааных нь дүр төрхийг байгаа байдлаар нь тэмдэглэж үлдээхийг илүүтэйд үзэж, он дарааллын бичиглэлийн арга зүйг ашиглаж энэ судалгааг хийлээ. Учир нь нийгмийн аливаа үйл явц хүний нэгэн үе солигдоход мартагдаж, хувь хүмүүс өөр өөрийнхөө байр сууринаас түүхийг нь гажуудуулдаг ажгуу.

Монгол Улсын боловсролын хөгжлийн чиг баримжаа, үзэл баримтлал өөрчлөгдөж, олон улсын боловсролын хөгжлийн нийтлэг жишигт орж хөгжих гэж алдаж, онож, нийт нийгмээрээ чармайж зүтгэсэн он цагийн бичгийг гаргах санааг дэмжиж, энэ төслийг батлаж өгсөн БСШУСЯ-ны ШУТБГ-т талархлаа илэрхийлж байна. Судалгааны ажлыг хэрэгжих боломжоор хангаж санхүүжүүлсэн ШУТС-д бас талархаж байна.

Уг судалгааг хийхэд өөрсдийн хүч бололцоогоо дайчлан ажилласан судалгааны үндсэн багийн гишүүд- ш/у-ны доктор, профессор О.Пүрэв, доктор, дэд профессор С.Санжаабадам, ш/у-ны доктор, профессор Ц.Оюун, доктор Б.Баярцэцэг, судлаач Ц.Лхагвасүрэн, Б.Энхбаяр, Б.Баярмаа, Д.Наранцэцэг, Х.Цэцэгжаргал, Г.Энхбат, Ш.Оюунцэцэг болон гэрээт судлаачдадаа талархал илэрхийлж байна.

Мөн өөрсдийн судалгааны материалаас авч ашиглах бололцоо олгосон доктор, профессор Ж.Батдэлгэр, доктор, профессор Е.Батчулуун, доктор, дэд профессор Ц.Гэлэгжамц, доктор У.Туяа, доктор Ж.Ариунболд, судлаач Д.Баяр нарт бас талархлаа илэрхийлж байна.

Судалгааны багийн ахлагч Н.БЭГЗ

ХУРААНГУЙ

Монгол улсын боловсролын түүхэн дэх 1992-2017 он бол манай Монгол улсын боловсролын системийн шинэчлэлийн нэн чухал үе юм. XXI зууны эхний 25 жилийн боловсролын бодлого, түүний хэрэгжилтийг бид тухайн үед авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээнийх нь мөн чанараар нь хэд хэдэн үе шатанд хуваан авч үзлээ. Үүнд:

1. Боловсролыг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэх бодлогын үе
2. Хямралын жилүүдийн боловсролын бодлогын үе
3. Боловсролын хөгжлийг дэмжиж бодлогын үе

Монгол Улсын боловсролын түүхэн дэх 1990-2017 он бол манай боловсролын системийн шинэчлэлийн чухал үе юм. Энэ хугацаанд төрөөс Монгол улсын боловсролын тогтолцоог шинэ цаг үеийн хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэх талаар авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ололт, дутагдал, хэтийн хандлагагыг тодорхойлох нь түүний цаашдын хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Төслийн судалгааны аргазүй

Нэг. Төслийг хэрэгжүүлэх үндэслэл, шаардлага

Шинэ Үндсэн хуулиа батлаж, социалист хөгжлийн баримжаагаа өөрчлөн, зах зээлийн эдийн засгийн харилцаатай, олон тулгуурт гадаад бодлого бүхий Монгол Улсаа тунхагласнаас хойших 25 жилийн (1992-2017) боловсролын үйл явцыг нэг дор нэгтгэн харуулсан бүтээл гараагүй байна.

Энэ чиглэлээр гарсан бүтээлүүд нь энэ 25 жилийн боловсролын хөгжлийг бүхэлд нь биш, аль нэг үеийг хамарсан, нөгөө талаар үйл явц, үр дүнд аль нэг судлаачийн хувийн байр сууринаас, субъектив хандлагаар үнэлгээ өгч бичигдсэн нь олонхи байна.

Хоёр. Судалгаанд баримталсан зарчим, арга

Ийм учир Монгол Улсын боловсролын 1992-2017 оны хөгжлийн үйл явцыг явж ирсэн түүхэн зүй тогтлоор нь, хэн нэгний хөндлөнгийн байр сууринаас өгсөн үнэлгээ, дүгнэлтээс ангид, түүхийн “он дарааллын бичиглэл” хийх аргаар бичихийг зорьсон болно.

Гурав. Судалгааны зорилго

Монгол Улсын боловсролын хөгжлийн 25 жилийн үйл явц, хүрсэн түвшинг боловсролын секторуудаар харуулах, цаашдын хөгжилд харгалзан үзэх, анхаарах сургамжийг гаргаж тавих, үүний үндсэн дээр боловсролын цаашдын хөгжлийн номлолын төслийг тодорхойлох явдал байв.

Дөрөв. Судалгаанаас гарсан үр дүн

Тавьсан зорилгын дагуу Монгол Улсын боловсролын хөгжлийн 25 жилийн үйл явц, өнөөгийн төлөв байдлын тодорхойлолт гарав.

Үүний үндсэн дээр боловсролын дэд тогтолцоо бүрээр сайжруулан хөгжүүлэх бодлогыг томъёолов.

Судалгааны ажлын үр дүнд Монголын боловсролын цаашдын хөгжилд баримтлах номлолын төслийг гаргалаа.

Энэ төслийн үр дүнгээр “Монголын боловсролын хөгжлийн 25

жил:туршлага,сургамж” сэдэвт монографи бичиж хэвлүүлээ.

Туслийн судалгааны тайланг гарсан үр дүнгээр 354 хуудсанд багтаан нэгтгэн бичив.

Судалгааны шинэлэг дэвшилттэй тал

Монголын боловсролын хөгжлийн үйл явц, үр дүнд хийх судалгааг анх удаа 25 жилийг хамруулан хийснээрээ хүний нэгэн үе солигдох хугацааны түүх мартагдах, гажуудах явдлаас сэргийлэх боломжтой болов.

Төслийн эдийн засаг, нийгмийн үр ашиг, нийгмийн ач холбогдол

Монголын боловсролын хөгжлийн шинэ номлолыг боловсруулан, бүх түвшний боловсролын хөгжлийн үзэл баримтлал, хэрэгжүүлэх хууль, дүрэм журам, хөтөлбөр, төлөвлөгөөнд суулгаж хэрэгжүүлбэл манай орны боловсрол нэгдмэл нэг үзэл санаанд тулгуурлан хөгжих боломжтой болно.

Нөгөөтэйгүүр боловсролын хөгжлийн үзэл санаа, номлолыг олон улсын боловсролын хөгжлийн нийтлэг жишигт нийцүүлэн, дэлхийн хөгжилд гарч байгаа шинэ эрэлтэд нийцүүлэн гаргаснааэр монгол хүний хөгжлийн чиг баримжааг зөв тогтоох, улмаар боловсролын хөгжлийн бодлогыг дөрөв, дөрвөн жилээр өөрчлөөд байхгүй тогтвортой хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Төслийг хэрэгжүүлсэн үйл явц

Монголын боловсролын хөгжлийн 25 жилийн үйл явцыг түүхэн судалгааны аргазүйд үндэслэн, баримт бичгийн судалгааны аргыг ашиглан хэрэгжүүлэв. Үүнд бодлогын баримт бичгүүд, түүнийг хэрэгжүүлэх талаар гаргасан удирдамж, заавар, дүрэм, журмын хэрэгжилт, үр дүнг 1992-2017 оны хугацаанд манай орны сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд, дээд болон мэргэжлийн боловсролын салбарт монгол хүүхдийн хөгжлийн судалгаа, сургалтын агуулга, аргазүй, үнэлгээ, сургалтын хэрэглэгдэхүүн, сурах бичиг, хүний нөөц, сургалтын орчны гэсэн дэд хэсгээр, түүхийн он дарааллын бичиг бүтээх зарчмыг баримтлан гаргахыг оролдсон болно.

Баримт бичгийн шинжилгээгээр гарсан үр дүнг нийслэл хот, манай орны баруун, төвийн, хангайн, говийн бүсийг төлөөлөх аймгуудад газар дээр нь цэцэрлэг, сургууль, Боловсрол, соёлын газруудад сургалтын орчны бүрдэл, сургалтын агуулгын хэрэгжилт, сурагчдын стандарт хангалт, багш нарын сургалтын аргазүйн хөгжил гэсэн чиглэлээр бататгах судалгаа хийж, тайланд тусгав.

Боловсролын шинжлэх ухааны академийн хэрэгжүүлсэн энэ удаагийн судалгааны үр дүн нь Монгол Улсын боловсролын хөгжлийн 25 жилийн үйл явц, үр дүнг харуулсан төгс төгөлдөр бүтээл биш бөгөөд энэ чиглэлийн судалгаа, үр дүнгийн нэгэн хувилбар юм. Бусад байгууллага, судлаачид өөр өнцгөөс, өөр арга зүйгээр ийм судалгаа хийх нь чөлөөтэй бөгөөд мөн өөрийн гэсэн үр дүн, хувилбар гаргах нь шинжлэх ухааны мэдлэгийг хөгжүүлэх зүй тогтолт үзэгдэл болох тул бид тэр үр дүнг дуртайяа хүлээн авч, өнгөрсөн үед хийгдсэн өөрсдийн болон бусад судалгаануудтай харьцуулах болно.

Монголд 1990-ээд оноос эхэлсэн өөрчлөн байгуулалтууд нь манай орны нийгмийн амьдралын бүх хүрээг хамарч, боловсролын системд зарчмын шинжтэй том шинэчлэлтүүд хийхэд хүргэв. Нийгэмд гарсан өөрчлөлтүүд нь юуны

өмнө Монгол Улс 1992 онд Шинэ Үндсэн хууль батлаж, олон тулгуурт гадаад бодлого баримтлах болсонтой холбоотой юм.

Мөн өмчийн социалист хэвшлээс татгалзаж, төрийн, хувийн, холимог, хамтарсан зэрэг өмчийн олон хэвшлийг хүлээн зөвшөөрсөн, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгаас зах зээлийн эдийн засагт шилжих болсон, хөдөө аж ахуйд суурилсан эдийн засгаас улс орноо уул уурхайн үйлдвэрлэлд тулгуурлан хөгжүүлэх бодлогод шилжсэн, үйлдвэрлэлийн технологи, тоног, төхөөрөмж шинэчлэгдсэн зэрэгтэй холбоотой байлаа.

Түүнээс гадна XXI зууны эхэнд глобаль гадаад орчин хурдтай шинэчлэгдэж, олон улсын боловсролын тогтолцооны нийтлэг жишиг ихээхэн өөрчлөгдсөн тул монголынхоо боловсролыг түүнд нийцүүлэн өөрчлөж шинэчлэх шаардлага бий болсон юм. Үүнтэй холбоотойгоор, Монгол Улсын боловсролд хийгдсэн шинэчлэлтүүд нь дараах зорилтуудыг агуулж ирэв. Үүнд:

Албан ба албан бус боловсролыг иж бүрнээр нь, зэрэгцүүлэн хөгжүүлэх, өмчийн олон хэвшилд үндэслэсэн сургалтын байгууллагын эрх зүйн шинэ орчин бүрдүүлэх, цэцэрлэг, сургуулийн хамралтыг нэмэгдүүлэх, бүх шатны боловсролын чанарыг дээшлүүлэх асуудал тулгамдаж байв.

Түүний зэрэгцээгээр мэдлэгийн баримжаатай сургалтын агуулгыг чадвар төвтэй болгон хөгжүүлэх, багш төвтэй сургалтын аргыг суралцагч төвтэй арга болгож төгөлдөржүүлэх, бага, дунд боловсролын киррикулимдын ачааллыг оновчтой тогтоох хэрэгцээ ч нэмэгдэв.

Мөн энэ үед 2006/2007 оны хичээлийн жилээс ЕБС-ын сургалтыг 11 жилийн, 2008/2009 оны хичээлийн жилээс дунд боловсролын 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх улс төрийн шийдвэр гарсанаар олон улсын жишгээр бүрэн дунд сургуулийн ахлах ангиудад сонгон суралцах агуулга бэлтгэх, түүнд тохирсон ахлах сургуулийн сурах бичиг бичих, хэвлэх асуудал шийдвэрлэгдээгүй байхад эдгээр шилжилтүүдийг богино хугацаанд хийсэн нь олон сөрөг үр дагаварыг бий болгов.

Боловсролын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх, дээд боловсролын сургуульд суралцагчдыг бүрэн хамарсан сургалтын зээл, тусламжийн системийг бий болгож, цаашлаад шинэчлэн боловсронгуй болгох, боловсролын удирдлагын төвлөрлийг сааруулж, сургалтын байгууллагуудын бие даасан байдлыг нэмэгдүүлэх асуудал бүрэн шийдвэрлэгдээгүй байсан нь эдгээр жилүүдийн мэргэжлийн болон дээд боловсролын хөгжилд зарим талаар сөрөг нөлөө үзүүлж ирсэн байна.

Боловсролын чанарыг хөндлөнгөөс үнэлэх тогтолцоо бүрдүүлэх, сурлагын үнэлгээний системийг өөрчлөх, үнэлгээн дэх субъектив хүчин зүйлийн нөлөөг бууруулах асуудлыг шийдвэрлэх хэрэгтэй болов. Багш нар, боловсролын ажилтныг шинээр сургах, давтан бэлтгэх, тэдний ажлын ачаалал, хөдөлмөрийн үнэлгээг боловсронгуй болгож нэмэгдүүлэх асуудал ч шийдвэрээ хүлээж байлаа. Гадаад хэл, мэдээллийн технологийн сургалтыг эрчимжүүлэх, түүнийг үзэх анги, сургалтын цагийг оновчтой тогтоох, сурах бичиг, гарын авлага болон өндөр мэргэжлийн багш бэлтгэх асуудал ч нэг мөр болоогүй байв.

Эдгээр өөрчлөлтүүдийг хэрэгжүүлэхийн тулд урьд өмнө мөрдөж байсан олон хууль, дүрэмд өөрчлөлт оруулж, заримыг шинэчлэснээс гадна Монгол Улсын боловсролын шинэчлэлийн эрх зүйн шинэ орчныг бүрдүүлж, дараах бодлогын баримт бичгүүдийг батлан мөрджээ. Үүнд:

БНМАУ-ын Боловсролын хууль (1991), МУ-ын Боловсролын Мастер Төлөвлөгөө (1993), Боловсролын тухай хууль (1991, 1995) (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт) Бага, дунд боловсролын тухай хууль (1995) (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт), Дээд боловсролын тухай хууль (1995) (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008), Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хууль (2011) юуны түрүүнд орно.

Мөн Монгол Улсын Засгийн Газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл (1997), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (1995), Монгол Улсын XXI зууны тогтвортой хөгжлийн Хөтөлбөр (1998), Боловсролын салбарыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги (2000), Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртлэх Үзэл баримтлал (2000), Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах Үндсэн чиглэл (2001), Боловсролын мастер төлөвлөгөө (2006), МУ-ын Үндэсний хөгжлийн цогц бодлого (2009), Боловсрол Үндэсний Хөтөлбөр (2010), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2015) зэрэг болно.

Дээрх үзэл, баримтлал, эрх зүйн шинэ орчинд үндэслэж, энэ 25 жилд дараах өөрчлөлт, шинэчлэлтийг хэрэгжүүлэв. Монгол Улсын боловсролын системийг 1993 оноос эхлэн 3 удаагийн өөрчлөлтөөр сургуулийн өмнөх боловсрол (3 жил), бага боловсрол (5 жил), дунд боловсрол (4 жил), бүрэн дунд боловсрол (3 жил), дээд боловсрол (4+1,5+3)-оос бүрдэхээр болж шинэчлэгджээ.

Бага сургуульд 6 настай хүүхэд элсүүлж, 9 жилийн суурь боловсролыг заавал эзэмшүүлэхээр хуульчиллаа. Энэ шилжилт 2013/2014 оны хичээлийн жилд бүрэн дуусав. Сургуулийн өмнөх боловсрол, бага, дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтыг иргэд үнэ төлбөргүй эзэмшиж байна.

Бүрэн дунд боловсрол эзэмшсэн суралцагчид дээд боловсролын сургуульд элсэхдээ 1993 оноос эхлэн төлбөртэй сурах болов. Үүнтэй холбоотойгоор суралцагчдад туслах Сургалтын зээл, тусламжийн асуудал эрхлэх Төрийн сургалтын сан байгуулав. Хүний хөгжил Сангаас иргэдийн авах үйлчилгээний төрөлд дээд боловсролын үйлчилгээг хамруулав. Энэ нь дээд боловсролын байгууллагад тавих чанарын шаардлагыг өндөржүүлэх хөшүүрэг болжээ. 2010/2011 оны хичээлийн жилээс АХБ-ны дээд боловсролын чанарыг дээшлүүлэх төсөл хэрэгжиж эхлэв.

Бүх шатны сургуулийн сургалтын агуулгад онол, практикийн харьцааг зохистой тогтоож, шинэчлэн сайжруулав. Дээд боловсролыг бакалавр, мастер докторын зэргийн сургалттай болгов.

Сургууль завсардсан хүүхэд, ажилгүй залуучууд, насанд хүрэгчид, гэрийн эзэгтэй нар, өндөр настанд зориулсан АББ-ын сургалтыг буй болгов. 2007/2008 оны хичээлийн жилээс манай улсад Боловсролын телевиз ажиллаж эхлэв. Хот,

хөдөөд Албан бус боловсрол, зайн сургалтын Гэгээрлийн төвүүд ажиллаж байв. Энэ бүтцийг цаашид хөгжүүлэн Насан туршийн боловсролын тогтолцоог төлөвшүүлэх шатанд явж байна.

1991 оноос өмнө Монгол Улсад зөвхөн төрийн өмчийн сургууль үйл ажиллагаа явуулдаг байв. Одоо төрийн өмчийн, хувийн, холимог өмчийн, гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан сургуулиуд ажиллаж байна. Монголын ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийг 2008/2009 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх ажил эхлэв. Энэ зорилгоор сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрэн шинэчлэж, багш нарыг сургалтад дахин хамруулав.

Дунд сургууль төгсөгчдөөс авах ЕШ-ын системийг БСШУЯ-ны харьяа Боловсролын үнэлгээний Төв 2006 оноос нэвтрүүлж хэрэгжүүлэв.

Сургалтын агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүнийг шинэчилж, бага ангийн сурах бичгийг 80.0-100.0 хувь, дунд, ахлах ангийн сурахыг 40.0 хувь төрөөс хангах бодлого үргэлжилж байна.

2010-2011 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын агуулга, сурах бичиг, багш бэлтгэх хөтөлбөрийг Кембрижийн стандартын үзэл санаагаар хөгжүүлэн боловсронгуй болгох ажил эхлэв.

Боловсролын хүрээлэн, Багшийн мэргэжил дээшлүүлэх институтыг 2012 оноос төрийн төсөвт санхүүжилттэй болгов.

Социализмын үед ажиллах хүчний бэлтгэлийг дангаараа шахам хангадаг байсан техник мэргэжлийн боловсрол, сургалт улсын эдийн засгийн хямралыг дагаад 1990-ээд онд уналтад орсон ба одоо Монгол Улсад мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоог сэргээн хөгжүүлж байна. 2008 оноос АНУ-ын Засгийн газраас олгох Мянганы сорилын Сангийн тусламжийн нэг хэсгийг энэ салбарыг хөгжүүлэхэд зарцуулав. 2010-2011 оны хичээлийн жилээс МСҮТ-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, сургалтын орчныг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дорвитой алхам хийгдэж эхлэв.

Дундын дараах шатны боловсролын секторт байгууллагын магадлан итгэмжлэлийн тогтолцоог 1998 оноос эхлэн бий болгов. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүнгийн чанарыг дээшлүүлэхэд энэ нь чиглэж байна. Одоо хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг эрчимжүүлэх, түүнийг чанарыг сайжруулах асуудал чухал болж байна.

Төрийн өмчийн 16 их, дээд сургуульд бүтцийн өөрчлөлт хийв. Их сургуулийн хотхоныг нийслэлийн Бага нуур (өмнө нь Налайхад) дүүрэгт барьж байгуулах ажлыг эхлүүлэв.

Хэдийгээр төрөөс боловсролын хямралыг даван туулах талаар өнгөрсөн жилүүдэд бодлогтойгоор шат дараалсан арга хэмжээ авч ирсэн боловч манай системээс хамааралгүй нийгмийн том хүчин зүйлийн нөлөөгөөр боловсролд ихээхэн ачаалал болж байгаа үйл явц гарч ирж байв. Тухайлбал, хөдөөгөөс хот суурин газрыг чиглэсэн шилжих хөдөлгөөн их байгаагаас төв суурин газрын сургуулиудын ачаалал ихсэж, хөдөөгийн сургуулиудын анги дүүргэлт хэт багасах хандлага 20-иод жил үргэлжилж байна.

Монгол Улсад нийгмийн хөгжлийн нэгдсэн төлөвлөлтгүй болсон, ажиллах хүчний эрэлтийг тогтоох үйл ажиллагаа хийгдэхгүй байгаас дээд болон техник мэргэжлийн боловсролын элсэлт, сургалтын бодлого нь хөдөлмөрийн зах зээлийн ажиллах хүчний эрэлттэй уялдаж чадахгүй байсаар байна. Үүнээс болоод дээд боловсролтой олон мянган залуус мэргэжлийн ажлаа хийж чадахгүй байна.

Иймээс дээд боловсролын сургалтын байгууллагын үйл ажиллагааны чанарыг дээшлүүлэх, сургалт, судалгааны ажлыг нь ажиллах хүчний зах зээлийн эрэлтэд нийцүүлэх талаар авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээг тууштай үргэжлүүлэх, шинэ бүтэц зохион байгуулалтаар ажиллаж байгаа сургуулиудыг эрх зүй, эдийн засгийн аргаар дэмжих талаар төв, орон нутгийн холбогдох түвшний байгууллагууд онцгой анхаарч ажилласаар байна.

Сургуулийн гадна буй хүүхэд, залуус, насанд хүрэгчид албан бус боловсролын үйлчилгээнд хамрагдах боломж хангалтгүй байна. Насанд хүрэгсдийн сурах, амьдрах хэрэгцээнд тохирсон, тасралтгүй боловсролын үйлчилгээ жигд бус байна. Насан туршийн боловсролын байгууллагуудын хүний нөөцийн чадавх сул, үйл ажиллагаа нь санхүүжилтгүй, сургалтын орчин боловсролын бүх түвшинд шаардлагын хэмжээнд хүрээгүй, насанд хүрэгчдийн сургалтын агуулга, арга зүй бүрэн боловсрогдоогүй байгааг хаана хаанаа анхаарч, боловсролын бие даасан тогтолцооны хувьд бэхжүүлэх талаар ойрын үед арга хэмжээ авмаар харагдаж байна.

Шинэ стандарт, нээлттэй каррикулумын хэрэгжилтийг хангахад бага, дунд сургуулиудын багшийн мэргэжил, арга зүйн цогц дэмжлэг дутагдаж байна. Багшийн мэргэшил, аргазүйг шинэчлэх ажил шаардлагатай хэмжээнд сайжрахгүй байна.

Сургууль, цэцэрлэгийн барилгын хүчин чадал хот суурин газарт хүрэлцээгүй, барилгын чанар, дэд бүтэц, цэвэр ус, дулаан, цахилгаан хангамж хот, хөдөөд ялгаатай байгаагаас хүүхдүүд ээлтэй орчинд суралцах тэгш боломжоор тэр бүр хангагдаж чадахгүй байна.

Боловсролын чанарын хяналтын үндэсний тогтолцоо бүрэн бүрдээгүй байна. Бага, дунд сургуулиудыг анги дэвших болон сургууль төгсөх улсын шалгалттай болгох, дээд боловсролын сургуулиудын элсэлтийн нэгдсэн шалгалтыг боловсронгуй болгох, олон улсын боловсролын чанарын нэгдсэн шалгалтад тогтмол оролцдог болох бэлтгэлийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Боловсролын хүрээлэн, Боловсролын үнэлгээний Төв зэрэг холбогдох байгууллагуудыг судалгааны хүний нөөц, аргазүйн талаар дэмжиж бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна.

Дээд боловсролын судалгаа, сургалтын ажлын уялдааг сайжруулж, судалгааны байгууллагуудыг мэргэшсэн шинэ залуу ажилтнаар хангаж, сэлбэх бодлогыг төгөлдөржүүлж, боловсролын эрдэм шинжилгээг зохих хэмжээнд дэмжих хэрэгтэй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн нийт багшийн 80,1 хувь нь эмэгтэй багш байгаа юм. Удирдах түвшинд энэ тоо бүр ч багасдаг. Суралцагчдын хүйсны

тэнцвэрт байдал ч боловсролын түвшин ахих тутам алдагдаж байна. Энэ нь Монгол Улс Мянганы хөгжлийн зорилтоо шийдвэрлэхэд бэрхшээл үүсгэж байгааг анхаарч, боловсролын хөгжлийн бодлогод энэ асуудлыг тусгаж ажиллах шаардлага тулгарч байна.

Суралцагчдын шинжлэх ухааны мэдлэг эзэмшилтээс тэдний иргэний төлөвшил, хүмүүжил ихээхэн хоцорч байгааг иргэд ихээхэн шүүмжилж байна. Энэ нь бүх шатны сургууль, боловсролын байгууллагын үйл ажиллагаанд залуу үеийн иргэний төлөвшилд илүүтэй анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

Манай системд одоо хамгийн ачаалалтай байгаа сектор нь сургуулийн өмнөх боловсрол болоод байна. Хүн ам, хүүхдийн тооны өсөлтөөс цэцэрлэг, сургуулийн тооны өсөлт хоцорч байна.

Манай сургуулиудын сургалтын орчныг хүүхдэд ээлтэй, аюулгүй байхаар стандарчлуулах шаардлагатай болов.

Бага ангийн багш нар 6 настай хүүхэдтэй ажиллахдаа 8 настай хүүхдийн жишгээр хандах байдлыг арилгах чиглэлээр мэргэшил дээшлүүлэх сургалтуудыг өөрлөх нь цаг алдалгүй хийх ажил юм.

Бүх шатны боловсролын агуулгын стандарт, хөтөлбөр, төлөвлөгөөнд үнэлгээ хийж, тэдгээрийг боловсролоороо дэлхийд тэргүүлж буй орны жишигт ойртуулан боловсронгуй болгож байх, түүнчлэн бага, дунд сургуулийн сургалтын Хөтөлбөрийг бага, дунд ангийн суралцагчдын сургалтын ачаалалыг оновчтой тооцох, түүний зохистой хэмжээг тогтоох, багшийн ажлыг хөнгөвчлөх чиглэлээр сайжруулах шаардлага гарч байна.

Үндэсний цөөнхийн сургуулийн Хөтөлбөр, сургалтын аргазүйн шинэчлэлийг эрчимжүүлэх, гадаадад амьдарч сурч байгаа монгол хүүхдийн боловсролыг дэмжих ажлыг сайжруулах нь манай боловсролын бодлогын чухал хэсэг мөн. Сурах бичиг судлалыг шинэ шатанд гаргаж хөгжүүлэх ажлыг боловсролын судалгааны нэг чухал хэсэг болговол зохино.

Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын багш бэлтгэх, мэргэжлийг дээшлүүлэх шинэ тогтолцоо буй болгох,ТБМС-ын (зах зээлийн баримжаатай) шинэ агуулга, аргазүй боловсруулах, сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлтгэх ажлыг салбар хоорондын зохицуулалтаар хийж хэрэгжүүлэх хэрэгтэй.

Дээд боловсролын байгууллагуудын сургалт, судалгааны ажлын нэгдлийг хангах, бүтцийг боловсронгуй болгох зорилгоор эхэлсэн бүтцийн өөрчлөлтийг гүнзгийрүүлж, их сургуулийг хотхоноор хөгжүүлэх ажлын судалгаа, хэрэгжилтийг эрчимжүүлбэл зохино гэж харагдаж байна.

Бүх шатны боловсролын тогтолцоог цаг үеийн шинэ шаардлагад нийцүүлэн байнга өөрчлөн шинэчилж, боловсролын үйлчилгээний хүртээмжид баримжаалсан бодлогоос боловсролын чанар, үр өгөөжийг тогтмол дээшлүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд ойртуулан төгөлдөржүүлэхэд чиглэсэн бодлогод шилжих нь энэ үеийн боловсролын шинэчлэлийн онцлог байна.

Энэ хүрээнд мэргэжлийн болон дээд боловсролыг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлж, Насан туршийн боловсролыг өргөтгөн хөгжүүлж, иргэдэд чиглэсэн бүх нийтийн насан туршийн боловсролын нээлттэй тогтолцоог бүрэн

төлөвшүүлэх ажил ойрын жилүүдийн боловсролын шинэчлэлийн нэг гол зорилт гэж харагдаж байна.

Монгол Улсын боловсрол 1992-2017 онд нийгмийн шинэ эрэлтэд тулгуурлан хөгжлийнхөө шинэ түвшинд гарч байгаа ч сургуулийн өмнөх, бага, дунд, дээд боловсролын сургалтын үйл ажиллагаа, үр дүнд чанарын өөрчлөлт гарч, энэ нь нийгмийн хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хүртэл хөгжих шилжилтийн шатандаа явна.

Монголын боловсролд хийх шинэчлэлт нь байнгын үйл явц юм. Энэ нь боловсролын хөгжлийн бодлого, зохион байгуулалт, хэрэгжилтэд шинээр хандах удирдлагыг шаардаж байна.

Монгол улсад системийн бодлогыг нэгжид хэрэгжүүлэх бүх түвшний багш, удирдах ажилтны менежментийн ур, чадвар энэ шинэ шаардлагыг бүрэн хангахгүй байна. Тэднийг бэлтгэх сургалт, мэргэжил дээшлүүлэх, мэргэшүүлэх нэгдсэн систем тогтоох, тогтвор суурьшилтай ажиллуулах нь боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлогын чухал хэсэг байх ёстой.

Боловсролын шинэчлэлтийг өөрийн орны нөхцөлд тохируулан, олон улсын жишгээр, глобаль орчны эрэлтэд тулгуурлан хийхээр бодож төлөвлөж, хэрэгжүүлэх нь бидний цаашид ч баримтлах чиглэл байх болно.

Үүний хүрээнд цаг алдалгүй хийх ёстой нэг чухал ажил бол Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үеийн монгол хүний хөгжлийн бодлого, сургалтын асуудлыг судлан томъёолж, бусад улс орнуудын адилаар хэрэгжүүлж эхлэх явдал юм. Энэ судалгааны хүрээнд бид энэхүү бодлого-номлолын төслийг санал болгож байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ТОГТОЛЦООНЫ ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Боловсролын бодлогын үндсэн асуудлууд

Монголын нийгэм, эдийн засаг, соёл, байгаль орчны тогтвортой хөгжил нь монгол хүний хөгжил, төлөвшлийн эх үндэс болсон боловсролоос шууд хамаатай юм. Манай иргэдийн эзэмшиж байгаа боловсролын агуулга прагматик, хэрэглээний шинжтэй болж, хүн амын амьдралын хэв маяг, нийгмийн давхраажилд эерэгээр нөлөөлж эхэлж байна.

Хүний сайн сайхан амьдрах хүсэл мөрөөдөл санааны зоргоор хэрэгжихгүй ч эзэмшсэн боловсролын чанар чухал хүчин зүйл болох учир иргэдийнх нь боловсролын чанар бол нийгмээс анхаарах нэг гол асуудал, төрөөс иргэдийнхээ ирээдүйн төлөө хийж байгаа үндсэн хөрөнгө оруулалт юм. Иймээс иргэддээ чиглэсэн төрийн үйлчилгээний чанарыг улам дээшлүүлж, глобаль ертөнцөд монгол хүний өрсөлдөн амьдрах чадварыг нэмэгдүүлэхэд боловсролын салбарын хамт олон Монгол улсын боловсролын шинэчлэлийнхээ бодлогыг чиглүүлэн ажиллаж байна.

Манай хүүхэд, залуус, иргэдэд бие, оюун, сэтгэлийн баялаг, аж төрөх ухаан болох мэдлэг, боловсрол, хүмүүжил олгоод зогсохгүй, тасралтгүй суралцагч нийгмийг төлөвшүүлэх чиг үүрэгтэй боловсрол хэмээх институцийг шинжлэх ухааны үндэстэй цогц бодлого, үзэл баримтлал, орчин үеийн стратеги, менежментийн үүднээс удирдан жолоодох асуудал өнөөгийн хувь хүний болон нийгмийн хөгжлийн эрэлт, хэрэгцээ, шаардлагаас урган гарч байна. Иймээс шинэ зууны эхний 25 жилийн Монгол Улсын боловсролын бодлого нь ард түмнээ шинэ зуунд хөтлөн оруулж, улс орныг хөгжил дэвшлийн замд гаргах талаар төрөөс авч хэрэгжүүлсэн шат дараалсан арга хэмжээгээр илэрч байлаа.

XXI зууны эхний 25 жилийн боловсролын бодлого, түүний хэрэгжилтийг бид тухайн үед авч хэрэгжүүлж ирсэн арга хэмжээнийх нь мөн чанараар нь хэд хэдэн үе шатанд хуваан авч үзлээ. Үүнд:

Боловсролыг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэх бодлого

Хямралын жилүүдийн боловсролын бодлого

Боловсролын хөгжлийг дэмжиж бодлого

Монгол Улсын боловсролын бодлогын баримт бичгүүдийг дотор нь 1/ хөгжлийн бодлогын баримт бичгүүд (номлол, үзэл баримтлал), 2/ хэрэгжүүлэх бодлогын баримт бичгүүд (хууль, хөтөлбөр, төлөвлөгөө) гэж ангилж авч үзлээ.

Боловсролыг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэх бодлого

Манай оронд боловсролын хөгжлийн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх талаар сүүлийн 50-иад жилд нэлээд ажил хийгджээ. Эрх баригч МАХН(МАН)-ын их, бага, бүгд хурлын шийдвэрт боловсролын ойрын болон дунд хугацааны хөгжлийн зорилтууд тусч, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн цогц төлөвлөгөөний нэг хэсэг болж хэрэгжиж ирэв. Монгол Улсад 1960-аад оноос боловсролынхоо хөгжлийн үзэл баримтлалыг үе шаттайгаар боловсруулан хэрэгжүүлж ирэв. Үүнээс өмнөх үед болон 1989 он хүртэлх хугацаанд боловсролын хөгжлийн асуудлуудыг улс орны нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан, МАХН(МАН)-ын Программын зорилт болгон батлаж мөрдөж байв.

Монгол Улсын төрөөс боловсролынхоо хөгжлийн үзэл баримтлалыг өнгөрсөн хугацаанд 3 удаа боловсруулан мөрдөв. БНМАУ-д боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал (1991), Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого(1995,2014)-ыг баталснаас гадна боловсролын бодлогыг нийгмийн хөгжлийн цогц бодлоготой уялдуулах чиглэлээр “Боловсрол” Үндэсний хөтөлбөрийг ЗГ-аас 2012 онд батлаж гаргав.

Үзэл баримтлалын чанартай эдгээр баримт бичгийн үзэл санааны хүрээнд БНМАУ-ын боловсролын хууль (1991), Боловсролын тухай Монгол Улсын хууль(1995), Бага, дунд боловсролын тухай хууль (1995), Дээд боловсролын тухай Монгол Улсын хууль (1995), Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль (2002), Сургуулийн өмнөх боловсролын тухай Монгол Улсын хууль (2008), Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн бааталгааны тухай хууль (2011) зэрэг бие даасан хуулиудыг батлан гаргаж, эхнээс нь олон удаагийн нэмэлт өөрчлөлт оруулан мөрдөж ирлээ. Ийнхүү Монгол Улс 1990-ээд оноос хойш боловсролын тогтолцоондоо хөгжлийн үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх эрх зүй, удирдлага, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын шинжтэй шинэчлэлтийг тасралтгүй хийж, боловсролын хүртээмж, чанар, үр ашгийн зохих үр дүнд хүрэв. Өнгөрсөн хугацаанд сургуулийн өмнөх, бага дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын болон дээд боловсролын түвшинд сургалтын агуулгыг оновчилж, орчны бүрдэл, багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулах талаар авч хэрэгжүүлсэн бодлогын баримт бичгүүдийн хэрэгжилтээр нэлээд ахиц гарчээ.

Төв суурин газруудад цэцэрлэг, сургуулийн барилга байгууламжийн хангамж, хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсрол сургалтын

санхүүжилт, төгсөгчдийн ажил эрхлэлтийг сайжруулах, дээд боловсролын сургалтын зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах ажил одоо ч үргэлжилж байна. Сургууль завсардагчдад чиглэсэн албан бус боловсролын сургалтын тогтолцоог бий болгох асуудал эхлэлийн шинжтэй, бүх нийтийн насан туршийн боловсролын тогтолцоо бүрдээгүй байна.

Судалгаанаас харахад өнгөрсөн хугцаанд боловсруулж хэрэгжүүлсэн бодлогын дүнд Монгол Улсын боловсролын тогтолцоог нэг нийгмиеэс нөгөө нэг шинэ нийгмийн эрэлтэд нийцүүлэн өөрчлөх, улмаар хөгжлийн замд оруулах ажил тасалдалтай, доголдолтой ч зохих хэмжээнд хэрэгжсээр иржээ.

Гэвч сүүлийн үед боловсролын салбарын бодлогын баримт бичгүүдийг боловсруулж батлахдаа өмнө гарсан баримт бичгүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, шинэ бодлогын үндэслэл, хэрэгцээг судлаж тооцоолохгүй, тухайн үед төр барьж байгаа намын үзэл бодлын үүднээс хандаж ирсэн нь бодлогын онол, аргазүйн суурь явцуурах, бодлогын замгамж чанар алдагдахад зарим үед хүргэж байжээ.

Нөгөө талаар бодлогын баримт бичгүүдийг хэлэлцэж батлахдаа тэдгээрийн ранг, зиндааг алдагдуулж, хольж хутгаж байсан нь эдгээр баримт бичгийн ач холбогдол, үнэ цэнийг бууруулахад хүргэж байв. Тухайлбал, эдгээр бодлогын дутагдалтай талыг нөхөх, бодлогын тавилыг сайжруулах зорилгоор, мөн НҮБ-аас баталсан 2030 он хүртэлх Дэлхийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого (2014-2024)-ын үзэл санаа, томьёололд зохих өөрчлөлт оруулж бодлогын баримт бичгийг шинэчлэн боловсруулах шаардлагатай болж мэдэхээр байна.

Боловсролын бодлогын баримт бичгүүдийн шинжилгээ

Монгол Улсын төрөөс боловсролынхоо нэгэн үеийн хөгжлийн бодлогыг тодорхойлж хэрэгжүүлсэн туршлага, үр дүн, сургамжийг дараа үеийнхэнд үлдээх нь судалгааны ажлын зорилго юм. Удирдахуйн ухааны онолын эх сурвалжуудаас үзэхэд амжилттай хэрэгжиж, сайн үр дагавартай болсон үйл ажиллагааг туршлага гэдэг. Тодорхой нэгэн үйл ажиллагааг хэрэгжүүлээд өмнөх үеэс ахьсан түвшин буюу гаралт, түүнд түшиглэн цаашид гарах үр өгөөжийн нэгдлийг үр дүн гэж ойлгодог. Харин хүссэн үр дүнд хүрч чадаагүй, эсхүл муу үр дагавартай болсны улмаас дахин давтахгүй байх санааг сургамж гэж тодорхойлсон байдаг.

Аливаа улс боловсролын тогтолцоогоо тогтвортой, залгамж холбоотой хөгжүүлэх бодлого баримталдаг нь нийтлэг жишиг юм. Манай орны хувьд эл зарчмыг ямар нэгэн байдлаар баримталж иржээ.

Төрөөс боловсролын талаар баримталж ирсэн бодлого хийгээд эдүгээ цагт энэ салбарт ямар бодлого баримталж байгааг тодорхойлох эх сурвалж, эш баримт нь тухайн үед төр, засгийн төв байгууллагаас боловсруулан баталж хэрэгжүүлсэн, хэрэгжүүлж буй бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх зүйн актуудаас бүрдэж байна. Тухайлбал, 1991 онд баталсан “БНМАУ-д боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал”, УИХ-ын 1995 оны 36 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, УИХ-ын 2015 оны 12 дугаар тогтоолоор баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого(2014-2024 он)” эдгээр баримт бичгийг харьцуулж үзэхэд дараах дүр зураг ажиглагдаж байна.

1991 онд баталсан “БНМАУ-д боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал”-д *“Боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлэх чиглэлийг баримтална”* гэсэн алсын хараа тодорхойлсонд гол ач холбогдол оршиж байна. Мөн боловсролын тогтолцоонд сургуулийн өмнөх боловсролыг хамруулан иж бүрэн байдалтай болгожээ.

Иргэдэд боловсролыг албан ёсны буюу албан бус арга замаар эзэмшүүлэх бөгөөд албан боловсролын агуулгыг төрийн байгууллагаас тогтоох, албан бус боловсролын хувьд чөлөөтэй байхаар заасан байна. Албан ёсны бус боловсролыг боловсролын тогтолцоонд оруулж түүнд ихээхэн анхаарал тавьснаараа дэлхийн боловсролын хөгжилт, чиг хандлагад монголын боловсролыг нийцүүлэх үүднээс үр дүнтэй алхам болсон гэж үзэж болно.

Энэ баримт бичигт ерөнхий боловсролын сургуулийн үе шат бүрт олгох боловсролын зорилго, агуулга, арга хэлбэрийг нарийвчлан тодорхойлсон байна. Мэргэжлийн сургуулийн сургалтын агуулга, хэлбэрийг шинэтгэн тогтоож, ТМС-ийн суурин дээр фермерийн аж ахуй эрхлэх мэргэжилтэй ажилчин, малчдыг бэлтгэх зорилт дэвшүүлсэн нь сургалт амьдралын холбоог бэхжүүлэх бодитой санаа, шинэлэг тал байлаа.

Зарчим гэдэг бол тухайн үйл ажиллагаанд тогтвортой, тууштай дагаж мөрдөх байр суурийг хэлдэг. 1991 онд баталсан боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлалд боловсролын талаар явуулах төрийн бодлогод баримтлах, бүх шатны

боловсролын агуулгыг өөрчлөхөд баримтлах зарчмуудыг тодорхойлсон нь шинэтгэн сайжруулах чиг хандлагыг оновчтой зөв тогтооход ач тустай зүйл болсон юм. Боловсролын талаар төрөөс баримтлах үзэл баримтлалыг боловсруулж хэрэгжүүлэхдээ дор дурдсан зарчмуудыг удирдлага болгохоор уг баримт бичигт заасан. Үүнд:

1. Боловсрол нь хүмүүнлэг, ардчилсан, тасралтгүй байх, хүн төрөлхтний болон үндэсний соёл иргэншлийн өв уламжлал, шинжлэх ухаанд үндэслэх.
2. Хүүхэд, залуучуудад боловсрол эзэмшүүлэх асуудал төрийн ивээл, хяналтад байх.
3. Иргэдийг сурч боловсроход ялгаварлан гадуурхахгүй байх.
4. Бүх хүүхэд, залуучуудад суурь боловсролыг 17 хүртэлх насанд нь заавал эзэмшүүлэх.
5. Төрийн сургуулиар анхан шатны болон суурь, дунд боловсролыг төлбөргүй олгох.
6. БНМАУ-ын иргэдийг эх хэл дээр нь сурч боловсрох нөхцөлөөр хангах
7. Боловсрол эзэмшүүлэх арга хэлбэр, зохион байгуулалт олон хувилбартай чөлөөтэй, нээлттэй байх.
8. Сургуулийг өмчийн аль ч хэлбэрт тулгуурлан байгуулж ажиллуулж болох.

Агуулгыг өөрчлөхдөө:

- Үндэсний соёл, зан заншил, оюуны өв уламжлалд үндэслэн үндэсний
- шинжтэй болгохын хамт хүн төрөлхтний соёлын ололтод тулгуурлан баяжуулна.
- Улс төржсөн, үзэл сурталжсан байдлаас ангижруулах болно.
- Шинжлэх ухаан техник, технологийн шинэ ололт, байгаль, эдийн засаг, экологийн орчин үеийн асуудлыг бүтээлчээр тусгана.
- Боловсрол эзэмшихэд нэн шаардлагатай шинжлэх ухааны тулгуур онол, хууль, ухагдахуун, таамаглал, төсөөлөл, баримтыг оновчтой сонгон судлуулах, мэдлэгээ амьдралд хэрэглэх дадал эзэмшүүлэх асуудлыг хүчтэй болгох замаар хичээлүүдийн онолын болон хэрэглээний чиглэлийг зохистой хослуулна.
- Сурагчдын нас бие, сэтгэхүйн онцлогт тохируулан нэгтгэх ба төрөлжүүлэх зарчмыг зохистой хослуулна.

- Шинжлэх ухааны танин мэдэхүйн, арга судлалд тулгуурласан сургалтын арга технологийг нэвтрүүлнэ.
- Сургалтыг монгол бичгээр явуулах арга, технологийг боловсруулан хэрэгжүүлнэ.
- Мэдээллийн техник, сургалтын хэрэглэгдэхүүнийг өргөн ашиглана.

Ерөнхий боловсролын сургуулийн шат бүрт сурагчдын эзэмших мэдлэг, чадварын доод төвшинг тусгасан суурь ба хөтөлбөрийг хичээл бүрээр боловсруулна. Эдгээр зарчмын асуудлыг оруулж ирснээрээ 1991 оны Төрөөс боловсролын талаар баримтлах болого нь өмнөх үеийн бодлогын баримт бичгүүдээс илт давуу талтай болсон бөгөөд зах зээлийн нийгэмд манай улсын боловсролын тогтолцоог шилжүүлэх түүхэн үед баримтлах жанжин шугамыг тогтоож өгсөн гэж үзэж болно. Энэ баримт бичгийн үзэл санааг 1992 онд баталсан Монгол Улсын Үндсэн хуульд харин явцууруулсан тал гарчээ.

Дээд боловсролын байгууллагаар бакалавр, магистр, докторын зэрэгтэй боловсон хүчин бэлтгэх зорилгод нийцүүлэн үндэсний их сургуулийн сургалтын агуулга, техник технологийг бүхэлд нь шинэчилж, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн интеграцыг хангах зорилгоор их сургуулиудыг сургалт-эрдэм шинжилгээний байгууллага болгох чиглэлээр өөрчилж түүний хүрээнд коллеж, магистрантур, докторантур, эрдэм шинжилгээний хүрээлэн, лаборатори, аж ахуйн нэгж байгуулан ажиллуулах дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлсэн билээ.

Ийнхүү 1991 онд баталсан “Үзэл баримтлал” нь өмнөх үеийн боловсролын зорилго, агуулга, зарчим, боловсролын байгууллагын бүтэц зохион байгуулалтад олон улсын боловсролын хөгжлийн орчин үеийн чиг хандлагад ойртуулсан олон шиэнэтгэл өөрчлөлтүүд хийхээр зааснаар Монголын боловсролыг социалист хэв маягаас зах зээлийн эдийн засагтай орны боловсролын хэв шинжид шилжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн.

УИХ-аас 1995 онд батлан хэрэгжүүлсэн “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” нэртэй бодлогын баримт бичгийг боловсролын тухай ерөнхий хууль, бага дунд боловсролын тухай, дээд боловсролын тухай хуулиудын төсөлтэй хамтатган нэгэн багц байдлаар боловсруулсан нь төрийн бодлого, түүнийг хэрэгжүүлэх харилцааг зохицуулах эрх зүйн баталгааг иж бүрэн цэгц байдлаар тодорхойлсон сайн талтай болсон байна.

Бодлого, хуулиудын төслийг боловсруулахдаа энэ асуудлаар судалгаа шинжилгээний ажил эрхэлдэг эрдэмтэн-мэргэд, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтнууд, бүх шатны сургуулийн багш ажилтнууд, суралцагчид, эцэг эх, олон нийтийн төлөөллийг аль болох өргөн хамруулахыг хичээж санал бодлыг нь авсан байна. Үнэ цэнтэй, шинэлэг олон санал гарсныг ажлын дэд хэсгүүдэд чиглэл чиглэлээр нь хуваарилан өгч дүн шинжилгээ хийлгэж, төслүүдэд тусгуулахыг эрхэмлэсэн нь тухайн үеийн УИХ-ын үйл ажиллагааны тэмдэглэлд тусаж үлджээ.

Боловсролыг цаашид хөгжүүлэхэд баримтлах зарчмыг тодорхойлохдоо өмнөх баримт бичгүүдээс иргэдийг сурч боловсроход ялгаварлан гадуурхахгүй байх, бүх нийтийн боловсролыг иргэдэд төрөөс үнэ төлбөргүй олгох, суурь боловсролыг иргэдэд заавал эзэмшүүлэх зэрэг зарчмуудыг залгамжлан авсан. Харин дор дурдсан шинэ шинэлэг зарчмуудыг баримтлах зайлшгүй шаардлага үүссэн гэж үзэж уг баримт бичигт тусгасан:

- a) Боловсролыг төрийн ивээл, дэмжлэг, зохицуулалт, төр, олон нийтийн хяналтад байлгах;
- b) хүүхдэд зохих шатны боловсрол эзэмшүүлж, тэднийг ажил, амьдралд бэлтгэх нь эцэг, эх, асран хамгаалагчийн үүрэг гэж үзэх;
- c) багш мэргэжлийн нэр хүндийг дээшлүүлж, багшийн хөдөлмөрийг бодитой үнэлэх;
- d) боловсролын тогтолцоог иж бүрэн, түүний үйл ажиллагаа, агуулгыг тогтвортой бөгөөд тасралтгүй, залгамж холбоотой байлгаж, боловсрол эзэмших арга, хэлбэрийг олон хувилбартай, чөлөөтэй, нээлттэй болгох;
- e) 8.өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр боловсролын байгууллагад адил шаардлага тавьж, зохих дэмжлэг үзүүлэх;
- f) аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй сургалт, хүмүүжлийн ажлыг зохион байгуулахыг хориглох;
- g) боловсролыг хөгжүүлэх үйл хэрэгт төр, олон нийтийн болон мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хүлээх үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх, тэдний хувь нэмрийг хөхиүлэн дэмжих зэрэг болно.

Боловсролын талаар төрөөс баримтлах бодлогыг хэрэгжүүлэх хүчин зүйлүүдийг тодорхойлж, тэдгээрийн нөлөөллийг тооцож тодорхойлсон зүйл өмнөх баримт бичгүүдэд тусгагдаагүй байсан учраас хэрэгжилт хангалтгүй, тунхаглалын

шинжтэй болдог гэсэн олон нийтийн санал шүүмжлэлийн дагуу боловсролыг хөгжүүлэхэд дараахь хүчин зүйлүүдийг харгалзан үзэхээр тусгасан байна:

1. Монгол орны эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хүн ам зүй, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн баталгаа, нутаг дэвсгэрийн бодлого;
2. судалгаа, шинжилгээний ажлын үр дүн, олон нийтийн санал, хүсэлт;
3. боловсролын хөгжлийн өнгөрсөн, одоо, ирээдүйн байдал;
4. боловсролын удирдлага, багшлах боловсон хүчин, санхүүгийн чадавхи, материаллаг нөөц;
5. боловсролын эрх зүйн харилцааны зохицуулалт;
6. өөрийн орны онцлог, олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх нөхцөл, боломж.

Бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагааг үр дүнд хүргэхийн тулд боловсролын удирдлага зохион байгуулалтыг шинэтгэн сайжруулах дараах арга хэмжээнүүдийг авах нь зүйтэй болохыг тусгасан нь боловсролын хөгжлийг нийгмийн өөрчлөлттэй нягт уялдуулахад тус дөхөм үзүүлсэн. Үүнд:

1. боловсролыг хөгжүүлэх ойрын болон хэтийн бодлого, төлөвлөлтийг улсын эдийн засаг, нийгэм, шинжлэх ухаан, технологийн хөгжил, хөдөлмөр, хүн ам зүйн бодлоготой нягт уялдуулах;
2. төрийн захиргааны төв, нутгийн захиргааны байгууллага, цэцэрлэг, бүх шатны сургуулийн удирдлагын үйл ажиллагааны зааг ялгаа, бүрэн эрх, чиг үүргийг харилцан уялдаа холбоотой нарийвчлан тогтоож, эрх зүйн хувьд баталгаажуулах;
3. олон нийтийн төлөөлөлтэй магадлан итгэмжлэх байгууллага бий болгох;
4. бүх шатны боловсролын стандартыг шинэчилж, хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавих мэргэжлийн хяналтын эрх, үүрэг, хариуцлагыг өндөржүүлэх;
5. удирдах ажилтан, судлаачдыг бэлтгэх, мэргэжлийг нь дээшлүүлэх, мэргэшүүлэх;
6. дээд боловсролыг шинжлэх ухаан, үйлдвэрлэлтэй интеграцчилах замаар бий болсон оюуны болон хөдөлмөр, санхүү, материалын чадавхийг үр өгөөжтэй ашиглахуйцаар зохион байгуулалтыг боловсронгуй болгох;
7. дээд боловсрол эзэмшүүлэх байгууллагыг тэдгээрийн зорилго, онцлогтой уялдуулан сургалт-эрдэм шинжилгээний, сургалт-эрдэм шинжилгээ-үйлдвэрлэлийн, эрдэм шинжилгээ-сургалтын, сургалт-үйлдвэрлэлийн, эрдэм шинжилгээний хүрээлэн зэрэг хэлбэрээр хөгжүүлэх;

8. хүүхэд, залуучуудын үүсгэл санаачлагын байгууллагыг дэмжих, тэдэнд туслалцаа үзүүлэх, эрх ашгийг нь хамгаалахад төрөөс анхаарах;
9. боловсролын онол, арга зүй, хөгжлийн асуудлаархи судалгаа, шинжилгээний ажлыг өргөжүүлж, түүний шинжлэх ухааны үндэслэл, үр дүнг дээшлүүлэх, боловсрол судлаачдыг бэлтгэх.

Боловсролыг хөгжүүлэх хоёр болон олон талын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлэх; олон улсын болон бүс нутгийн боловсролын байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, боловсролын бодлогыг уялдуулан зохицуулах; олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах, түүний үр өгөөжийг дээшлүүлэх; боловсролын байгууллага хоорондын шууд хамтын ажиллагааг өргөжүүлж, тал бүрээр дэмжих; олон улсын болон гадаад орны боловсролын байгууллагатай боловсролын түвшин, диплом, эрдмийн зэрэг, цолыг харилцан хүлээн зөвшөөрөлцөх; дэлхийн болон олон улсын боловсролын төрөлжсөн байгууллагад гишүүнээр элсэх, конвенцид нэгдэн орох; тэгээрийн зарим салбар, нэгжийг өөрийн оронд нээж ажиллуулах арга, хэлбэрээр боловсролын гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлүүдийг тодорхойлсон нь манай орны боловсролын тогтолцоог дэлхийн болон олон улсын чиг хандлагад нийцүүлэн хөгжүүлэхэд үр дүнгээ өгч байна.

1995 онд батлуулсан энэ баримт бичгийг бүрэн төгс болсон гэж үзэж болохгүй. Эргээд харахад сургуулийн өмнөх боловсрол бол харьцангуй бие даасан, өвөрмөц онцлогтой бие даасан дэд хэсэг байдаг атал энэ харилцааны эрх зүйн зохицуулалтыг бага, дунд боловсролын хуульд тусгасан, мэргэжлийн боловсролын асуудлыг орхигдуулсан, боловсролын харилцааг зах зээлийн эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулах асуудлыг мөхөс тусгасан дутмаг тал ажиглагдаж байна.

Мөн 2015 онд УИХ-аас баталсан “Боловсролын талаар төрөөс баримтлах бодлого (2014-2024 он)”-д өмнөх бодлогуудын зарим сайн талыг орхигдуулсан, боловсрол олгох нарийн нягт, иж бүрэн үйл ажиллагааг иргэдэд үзүүлэх ердийн л нэг үйлчилгээ мэт өнгөцхөн төсөөлсөн, эрдмийн эрх чөлөө, үндэсний түүх, соёл, өв уламжлал, зан заншлыг боловсролын хөгжилд нөлөөлөх хүчин зүйлийн зиндаанд биш, хүндэтгэн үзэх төдийхнөөр дурдсан байна.

Нөгөө талаар энэ баримт бичгийн бүтцэд бодлогын баримт бичгүүдийн ранг зиндааг хольсон, үзэл баримтлал, хөтөлбөр, төлөвлөгөөний элемент зэрэгцэж орсон байдал харагдаж байна.

Хямралын жилүүдийн Монголын боловсролын бодлого, хэрэгжилт

Боловсролыг иргэн төлөвшүүлэх нийгмийн институт гэдэг үзэл санаанд тулгуурлан боловсруулж батласан 1991 оны Боловсролын хууль бол манай орны боловсролын системд хийгдсэн системийн чанартай том өөрчлөлтийн түүчээ болсон үнэт чухал баримт бичиг мөн. Энэ хуулийн үзэл санааны дагуу Монгол Улсад боловсролыг албан ба албан бус боловсролын дэд тогтолцооноос бүрддэг гэх ойлголт нийгэмд төлөвшиж, сургууль, боловсролын байгууллагыг өмчийн олон хэвшилд үндэслэн хөгжүүлэх зам нээгдсэн билээ.

Боловсролын хуулийг шинэ нөхцөлд 1991 онд батлан гаргасан боловч, тэр жилүүд нь монголын нийгэм-эдийн засагт нүүрлэсэн хямралын нөлөөгөөр төрөөс боловсролыг баталгаатай санхүүжүүлэх хөрөнгө зардлын хэмжээ багассан, хүн хүчний талаар төрөөс авч хэрэгжүүлсэн арга хэмжээ зохих үр дүнд хүрээгүй, үндсэндээ социалист нийгмийн үед суурь нь тавигдсан боловсрол задарч, шинэ үеийн боловсрол өнгө төрхөө олоогүй байсан үе байв. Эдийн засаг хямарснаас ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны зардлын зарим хэсэг, дээд боловсролын сургалтын зардлыг суралцагч, эцэг эхэд хариуцуулах болсноор сургуулийн өмнөх, бага дунд, боловсролын хамран сургалтын үзүүлэлт тэдгээр жилүүдэд буурч, сургууль завсардалт эрс нэмэгджээ.

1991,1995 онд Боловсролын хуулийг багцлан шинэчилж байсан ч хүүхдийн сургууль завсардалт урьд өмнө байгаагүй хэмжээнд хүрч, төр, олон нийтийн зүгээс хүүхдийн цэцэрлэг хийгээд сургуулийн өмнөх насны хүүхдэд тавих анхаарал хяналт суларч, төсөв мөнгөний хомсдолоос болж цэцэрлэгийн хүүхдийн хоол хүнсний хангамж муудаж, хөдөө орон нутгийн цэцэрлэгийн халаалтад хүндрэл учирч цэцэрлэгийн хэвийн үйл ажиллагаа доголдсон юм. Цэцэрлэгийн тоо 1994 оныг 1990 онтой харьцуулахад 23.5 хувиар, түүнд хамрагдах хүүхдийн тоо 37.4 хувиар тус тус буурч, 0-2 насны хүүхдэд үйлчилдэг байсан яслийн тоо эрс багассан юм.

Гэвч энэ эгзэгтэй үед 1995 оны Монгол улсын Засгийн газрын 46 тоот тогтоолоор “Сургуулийн өмнөх боловсрол” үндэсний хөтөлбөрийг батлаж амжилттай хэрэгжүүлсэн нь СӨБ-ын хөгжилд учирч байсан бэрхшээл, хүндрэлийг даван туулахад үнэлж баршгүй хувь нэмэр оруулжээ. Уг хөтөлбөр нь нүүдлийн болон

суурин соёл иргэншлийн нөхцөлд тохирсон сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог бий болгох, сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил сургалтын ажлын агуулга, арга зүйг боловсронгуй болгох, төрийн бус өмчид суурилсан сургуулийн өмнөх боловсролын байгууллагыг дэмжих, хүүхдэд СӨБ олгоход эцэг эхийн үүргийг нэмэгдүүлэх, СӨББ-ийн боловсон хүчнийг чадавхижуулах зорилтыг дэвшүүлсэн юм. Боловсролын олон улсын шинжээч Д. Кеслер "... эл хөтөлбөр нь Төв Азид хэрэгжиж буй сургуулийн өмнөх боловсролын салбарыг шинэчлэхэд чиглэсэн цорын ганц санаачилга бөгөөд энэ утгаараа хүүхдийн сайн сайхны төлөө үйлсийг манлайлах эрхэм завшаан Монголын Засгийн газарт тохиосон билээ" хэмээн хөтөлбөрийн ач холбогдлыг үнэлсэн байна.

Гадаад хүчин зүйл талаас нь НҮБ-ын Ерөнхий Ассемблейн чуулганаар баталсан Хүүхдийн эрхийн конвенци (1989), Бүх нийтийн боловсролын асуудлаарх Жомтейны болон Дакарын бага хурлын баримт бичиг (1990,2000)-үүдийн заалтыг Монголын засгийн газар хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлага тэр үед бий болсон байна. Нөгөөтэйгүүр, олон улсын байгууллагууд - Английн Хүүхдийг Ивээх сан (1995), Дэлхийн зөн (1996) Соросын сангийн " Алхам Алхмаар" хөтөлбөр (1998 он), НҮБ-ын Хүүхдийн сан (2002), Японы Жайка олон улсын хамтын ажиллагааны байгууллага (2007)-ын хамтын үйл ажиллагаа чухал үүрэг гүйцэтгэжээ. Сургуулийн өмнөх боловсролын үндэсний цуврал хөтөлбөрүүд (1.2)-ийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрсэн байна.

- Цэцэрлэгийн өдрийн бүлэгт хамрагдсан цэцэрлэгийн насны хүүхдийн тоо 20-27 хувь хүртэл өсөж хувилбарт сургалтын олон хэлбэр бий болж нийт хүүхдийн 14 хувь хамрагдан хүртээмж нэмэгдсэн.
- Орон нутгийн засаг захиргаа, эцэг эх, олон нийт, орон нутгийн байгууллагаас сургуулийн өмнөх боловсролд хандах хандлага өөрчлөгдөж сургуулийн өмнөх боловсролын үнэ цэнийг ойлгож ухамсарлах болсон.
- Олон улсын байгууллага, иргэдийн дэмжлэгийг хүлээсэн Төрийн бус өмчид суурилсан СӨБ эзэмшүүлэх байгууллагууд бий болж хөгжиж эхэлсэн.

- Төв суурин газраас алслагдсан малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамрах сургалтын шинэлэг хэлбэрийг туршиж, зуны гэр цэцэрлэг, ээлжийн болон цагийн сургалтад хүүхдүүд хамрагдаж эхэлсэн. СӨБ-ын агуулга аргагүйн шинэчлэлийн хүрээнд сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг боловсруулж, хүүхэд төвт сургалтын аргагүйг нэвтрүүлэх туршилт судалгааг явуулж, үнэлгээ хийсэн байна.

Тэр үед ЕБС-ийн үйл ажиллагаа мхээхэн доголдож байсны үр дагавар болж сургууль завсардалт өсөн нэмэгдэв. Сургууль завсардалтын байдлыг аймаг, нийслэлээр авч үзвэл Увс аймагт нийт суралцагчдын 8.2 хувь, Өвөрхангай аймагт 7.6 хувь, Завханд 6.8 хувь, Хөвсгөлд 6.7 хувь нь тус тус завсардсан байсан нь хамгийн өндөр үзүүлэлт бөгөөд Улаанбаатар хотод нийт суралцагчдын 0.35 хувь нь завсардсан гэж байгаа нь хамгийн бага үзүүлэлт байлаа.

Хүснэгт 1. Боловсролын санхүүжилтийн үзүүлэлт (1990-1997)

17.6*	22.7	26.2	15.7	16.2	17.0	16.0	15.0
11,5**	10,7	6,8	5,8	5,8	5,5	5,5	6,0
1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997

Тайлбар: * Улсын төсөв дэх боловсролын төсвийн эзлэх хувь

**ҮНБ –д боловсролын төсвийн эзлэх хувь

Хөдөөд мал ихтэй газар хүүхдийн хөдөлмөрийн хэрэгцээ өндөр байдаг, мөн олон жил зуд турхан болсон, зах зээлээс алслагдсан аймгуудаас хот, суурин газар луу хүн амын шилжих хөдөлгөөн нэмэгдсэн зэрэг нь хүүхэд сургууль завсардахад бас нөлөөлж байгаа судалгаа ч бас тэр үед гарсан байна (20.21).

Сургууль завсардаж байсан нийт хүүхдийн 96.5 хувь нь 1-7 дугаар ангидаа сургууль завсардаж байгаа нь Боловсролын хүрээлэн, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Албан бус боловсролын төвөөс хийж байсан судалгаагаар тогтоогджээ (20. 32).

Хүснэгт 2. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийн үзүүлэлт

Он	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Цэцэрлэгийн тоо	883	806	723	696	660				650
хүүхд. хамр**	27,9	24,4	22,8	19,3	18,8	20,2	21,9	24,3	27,3

*Эх үүсвэр: Боловсрол. 1980-1995. Статистик судалгаа, 41-р тал.

** Mongolian National Report on Education for All Assessment-2000, p.31

Сургууль завсардалт гэдэг нь тухайн үедээ олон хүчин зүйлээс хамааралтай үзэгдэл байв. 1998-1999 оны хичээлийн жилийн байдлаар сургууль завсардалтын байдалд хийсэн анализаас харахад нийт завсардагчдын 9.8 хувь нь амьдралын гачигдлаар, 6.1 хувь нь сурах дургүй гэдэг шалтгаанаар, мал аж ахуйн

үйлдвэрлэлд гарахаар 4.8 хувь нь, хот суурин газарт ажил хийхээр 0.3 хувь нь, шалтгаан нь тодорхой бус байдлаар 79.1 хувь нь сургуулиа орхисон байв.

Дотуур байранд суух сурагчдын тоо 1990 онд 62 мянга байсан бол 1992 онд 35 мянга хүртэл буурч, суурь боловсрол эзэмшээгүй хүүхдийн тоо 79,9 мянгад хүрч, сургуульд огт суугаагүй 9-11 насны хүүхэд 20 мянгад хүрээд байсан юм. Малыг хувьчилсан, иргэд хувийн өмчтэй болсон тэр үед боловсрол эзэмших талаар иргэд суралцагчдын хүлээх үүрэг хариуцлага сулрав. Ялангуяа, сургуулийн өмнөх, бага, дунд боловсролын хамран сургалт буурч, сургууль завсардалт огцом өссөн нь олон хүчин зүйлээс хамаарч байв.

Хүснэгт 3. 1990-1999 онд сургууль завсардсан хүүхдийн тооны өөрчлөлт

Он	ЕБС-ийн тоо	ЕБС-д суралцагчдын тоо	Сургууль завсардагчдын тоо	Суралцагчдын тооны өөрчлөлт
1991	643	411696	33530	-29290
1992	679	384069	33886	-27627
1993	663	370302	23073	-13767
1994	659	381204	16346	10902
1995	664	403847	14272	22643
1996	658	418293	16095	14446
1997	645	435061	14804	16768
1998	630	447121	15053	12060
1999	668	470038	-	22917

ЕБС-ийн тоо ЕБС-д суралцагчдын

Эх сурв: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны 1999-2000 оны хичээлийн жилийн статистик

Боловсрол, соёл шинжлэх ухааны яамны харъяа Боловсролын хүрээлэнгээс 1998 онд Архангай аймагт явуулсан судалгаа, Албан бус боловсролын төвөөс 1997-1998 онд Дундговь, Баянхонгор аймгуудад явуулсан судалгаанаас үзэхэд энэ шалтгаан тодорхойгүй гэдгийн дотор хөдөөгийн сургуулийн дотуур байрны хүрэлцээ муутайгаас, эсвэл байрны хоолны зардлыг дийлэхгүйгээс болон орон нутагт сургалтын чанар хангалтгүй учир малчдын хүүхэд сургуулиа орхих явдал нэлээд үзэгдэж байсан байна. 1990-ээд оны эхнээс боловсролд тохиолдсон хямралын нөлөөгөөр сургуулийн дотуур байрны хүүхдийн тоо ч тодорхой хугацаанд их хэмжээгээр хорогдсон юм. Ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн тоо 1991 оноос эхлэн жил бүр буурч, энэ үзэгдэл 1995-1996 оны хичээлийн жил хүртэл үргэлжлээд, харин 1996-1997 оны хичээлийн жилээс эхлэн эргэж өсөх хандлагатай болжээ.

Монголын сургуульд тохиолдож байсан бэрхшээл, хүндрэл нь бүс нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжлийн хүрсэн түвшин, хүн амын суурьшил, иргэншил

зэрэг олон хүчин зүйлээс хамаарч, хот, хөдөөд ялгаатай байдаг байв. Улсын хэмжээнд аваад үзэхэд тэр үеийн сургууль, боловсролын байгууллагын амьдралд гарсан хямрал нь ихэнхдээ санхүүгийн бэрхшээл, мөнгөний хомсдолтой холбоотой, хөдөө талдаа сургуулийн барилга байшингийн ашиглалтын байдал их муудсан, багш нарын хангамж дутагдалтай, сурах бичиг байхгүй, сургалтын орчин бүрдээгүй зэрэгтэй холбоотой байв.

Нэгдэл тарснаар сум, суурин газрын эдийн засгийн орчин их муудав. Сумын төвийнхөн гэж хотын дайтай ахуйн үйлчилгээгүй, хөдөөнийхнийг бодвол хүнсний хангамжгүй ядарсан газар болсоноор энд ах дүүгээсээ хол хүний нутгийн, өөрийн гэсэн мал өмчгүй хүн ирж ажиллах боломжгүй болж, хөдөөгийн сургууль багшаар гачигдах болов. 1990-ээд оноос хойш хөдөөгийн зарим газарт үндсэрхэг жалга довны үзэл гaarч, хүний нутгийн багш, мэргэжилтнийг цагаач гэж дайрч доромжлох, хавчиж хяхах ч энүүхэнд болсон нь хөдөөгийн сургуулийн багшийн хангамжид бүр ч муугаар нөлөөлжээ.

1990-ээд оны дунд үе хүртэл орон нутагт эрчим хүчний эх үүсвэргүй болсон, шуудан холбоо ажиллахаа больсон зэргээс хөдөөгийнхөн мэдээллээс тасрав. Багш нарын мэргэжил дээшлүүлэх систем ажиллахаа болив. Энэ бүхэн нь хөдөөгийн сургууль хаагдах, хичээл удаан хугацаагаар зогсох, эцэг эх хүүхдээ төв суурин газрын сургууль бараадуулах болсоноор хөдөөд сургуулийн анги дүүргэлт багасаж, төв суурин газрын сургуулийн ачааллыг нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

Ийм нөхцөл бүрэлдсэн тухайн хугацаанд төрөөс боловсролын талаар баримталсан бодлого нь боловсролын салбарын хямралыг гарз багатай даван туулж, улмаар хөгжих эдийн засаг, эрх зүй, удирдлагын таатай орчинг бүрдүүлж, иргэдэд өөрсдийн авъяас, сонирхол, чадварын хэрээр боловсрол эзэмших боломжийг хангах нөхцөл бүрдүүлэхэд чиглэсэн байна. Энэ талаар Боловсролын яамнаас шат дараалсан олон арга хэмжээ ав хэрэгжүүлсэн байна.

1990-ээд онд хот, хөдөөд олон сургууль, улирлаар, бүтэн хичээлийн жилээр хаагдаж, багш нарын цалинг тавьж чадахгүйд хүрч байлаа. 1990 оноос хойш 2 жилийн дотор 1267 багш мэргэжлийн ажлаа орхижээ. Ингэснээр улсын хэмжээнд мэргэжлийн 1600 багш дутагдаж Улаанбаатарт гэхэд л 101 сургуульд 438 багш дутуу байлаа. Мөн энэ үед багш мэргэжлээр төгссөн 1471 хүний 25,7 хувь нь томилогдсон газраа очсонгүй. Цахилгаан, дулаан, хоол хүнсний болон бусад шалтгааны улмаас тэр тусмаа хөдөөгийн сургуулиудын байдал хүндэрч 9 сургууль бүр хаагджээ.

Эдийн засгийн либералчлалын дүнд томоохон аж ахуйн байгууллагууд задралд орж, хөдөлмөрийн захын бүтэц, байгууллагууд дахь хөдөлмөрийн хуваарилалт өөрчлөгдөж, мэргэжилтэй ажиллах хүчнийг бэлтгэх, хангах захиргааны аргыг нөхөх шинэ тогтлолцоог бүрдүүлж чадаагүйтэй холбоотойгоор мэргэжлийн анхан, дунд шатны сургуулиудын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлсэн юм.

Хүснэгт 4. Бага, дунд сургуулийн сурагчдын тооны өөрчлөлт

1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
440986	411696	384069	370302	381204	403847	418293	435061	447121	470038

Эх сурвалж: Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Статистик.

Боловсрол дахь хямралыг даван туулсан нь

Улс орны нийгэм, эдийн засгийн бүхий л хүрээний шинэчлэл, хүний амьдралын үнэт зүйлсийн агуулга, чанар, хэв маяг өөрчлөгдсөн нь боловсролын тогтолцоог шинэчлэх зайлшгүй шаардлагыг буй болгов. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын анхны байнгын ажиллагаатай парламент-Улсын Бага хурал 1991 онд Боловсролын хуулийг батлан гаргасан юм. Ингэснээр зөвхөн сургуульд суурилсан албан ёсны төдийгүй, албан бус боловсролын тогтолцоог хуульчилж, боловсрол, мэдлэгээ ахиулах иргэдийн сонгох эрх, боловсролын хэргийг удирдах олон нийтийн оролцоог баталгаажуулав. Өмчийн олон хэвшилд суурилсан боловсролын шинэ тогтолцоо бүрдэв. Улмаар бүх шатны сургуульд хамрагдагсдын тоо 1999 онд 5.9 хувиар өсч 560,1 мянгад хүрсэн нь 1996 оноос хойших хамгийн өндөр үзүүлэлт юм.


Боловсрол дахь хямралт үеийн даван туулсан жилүүдэд СӨБ-ын салбарын бодлого, эрх зүйн таатай орчин бүрэлдээд байлаа. Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008)-д цэцэрлэгийн хэв шинж, үйл ажиллагааны зохион байгуулалт, санхүүжилт, СӨБ-ын харилцаанд оролцогчдын эрх үүргийн зэрэгцээ хувилбарт сургалтын хэлбэр, зохион байгуулалтын эрх зүйн үндсийг хуульчилж өгсөн. Ингэснээр төв суурин газраас алслагдсан СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа малчдын, цөөнхийн, шилжин суурьшсан хүүхдийг хамруулах боломжийг баталгаажуулж өглөө.

Бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих цогц бодлого (2005)-д бага насны хүүхдийн хөгжил, эх хүүхдийн эрүүл мэнд, хоол тэжээл, асаргаа нийгмийн халамж, хамгааллын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагуудын хамтарсан нэгдмэл зохицуулалт бүхий бодлого, хэрэгжүүлэх арга замыг тодорхойлов. Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт (2011)-д хот суурин

хийгээд хөдөө орон нутгийн цэцэрлэг, өрх гэрт амьдарч буй шинээр мэндэлсэн хүүхдээс эхлэн сургуульд орох насны бүх хүүхэд эзэмших мэдлэг чадварт, дадал хэвшилд тавигдах наад захын минимум шаардлагыг тусгасан, бүх нийтээрээ мөрдөх албан баримт бичиг юм. Энэ нь бага насны хүүхдэд үзүүлж байгаа нийгмийн үйлчилгээг дэмжих, түүний чанарыг үнэлж боловсронгуй болгоход ашиглаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлого (2007) СӨББ-д бага насны хүүхдийг хөгжүүлэх үндсэн сургалтын цаг, норм нормативыг тогтоож өгөөд байв. 2009 онд Монгол улсын засгийн газраас баталсан “Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардлын дундаж норматив батлах тухай” 85-р тогтоолд хүүхдийн хоолны нормативыг өдрийн цэцэрлэгт өдөрт 1100 төг, 24 цагийн цэцэрлэгт 1600 төгрөгөөр тогтоов. 2011 оны байдлаар Улсын хэмжээнд сургуулийн өмнөх насны 197,046 хүүхэд байгаагаас сургуулийн өмнөх боловсролд 157,181, үүнээс цэцэрлэгт 122,105, хувилбарт сургалтад 35,056 хүүхэд хамрагдаж байна. Тэдгээрийн 22,277 нь малчдын хүүхдүүд байна. Өөрөөр хэлбэл, СӨБ-ын хамран сургалт 77.2 хувь, цэвэр жин 62.0 хувь байна.

Зураг 1. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын тоо



Дээрх зургаас харахад, сүүлийн 7 жилд хүүхдийн цэцэрлэгийн тоо дунджаар 20-иор нэмэгдэж хувийн цэцэрлэг 2008-2009 онд 15-аар буурснаа дахин өссөн үзүүлэлт харагдаж байна.

2006-2007 онд хамрагдагчид 4,3-аар багассаныг эс тооцвол хүүхдийн тоо жилээс жилд өссөн байна. Эл өсөлтөд хүн ам, хүүхдийн төрөлтийн тооны өсөлт, олон нийт сургуулийн өмнөх боловсролын үнэ цэнийг ойлгосон нийгмийн сэтгэл зүй, төрөөс хувийн хэвшлийн цэцэрлэгийг дэмжсэн бодлого, сургуульд хүүхдээ бэлтгэж оруулах гэсэн, эцэг эх, асран хамгаалагчдын хэрэгцээ шаардлага зүй ёсоор нөлөөлж байна. Түүнчлэн СӨБ-д хамрагдаж чадахгүй байгаа малчдын

болон шилжин суурьшсан, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамруулах хувилбарт сургалтын эрх зүйн татай орчин бүрдсэн нь хүртээмжид шууд нөлөөлж байна.

Хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжил – сургалтын хөтөлбөрийг 8 удаа шинэчлэн хэрэгжүүлж ирсэн бөгөөд 1998 оноос СӨБ-ын сургалтын агуулгын стандартыг анх удаа боловсруулан мөрдөж эхэлсэн. Стандарттай болсноор сургуулийн өмнөх насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, гоо сайхан, нийгэмшихийн хөгжлийн наад захын шаардлагыг тогтоож өгч улмаар боловсролын үйлчилгээний чанарыг үнэлэх, СӨББ стандартад тулгуурлан сургалтын хөтөлбөрөө уян хатан боловсруулах боломжийг нээсэн юм. Агуулгын стандартыг 2004, 2011 онд шинэчлэх ажил хийгдсэн байна.

Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд СӨБ эзэмшүүлэх сургалтын агуулга нь “... бие бялдарын хувьд эрүүл чийрэг өсгөж хөгжүүлэх, ариун цэвэр, эрүүл ахуйн зөв дадал хэвшилтэй болгох, хэл яриа сэтгэхүйн чадвар эзэмшүүлэх, хүрээлэн байгаа орчин, юмс үзэгдлийн талаар анхны мэдэгдэхүүнтэй болгох, хүүхдийн гоо зүйн мэдрэмжийг хөгжүүлэх, хүүхэд өөрөө өөрийгөө зөв илэрхийлэх чадвар эзэмшихэд туслах” –д чиглэхээр заажээ.

2000 оноос эхлэн бага насны хүүхдийн хөгжлийн дэлхийн чиг хандлага нь хүүхэд эрүүл байх, чанартай хоол тэжээлээр хангагдах, хөгжих, хамгаалагдсан байх суурь хэрэгцээг цогцоор нь хангахад чиглэсэн. Манай улсын засгийн газар ч бүсийн хэмжээнд бага насны хүүхдийн цогц хөгжлийн талаар бодлого боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн билээ. Эл үзэл санааг энэ хичээлийн жилээс эхлэн хэрэгжиж буй “Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт”-ад тодорхой тусгасан юм. Энэ нь Засгийн газраас хүүхдийн цогц хөгжлийн талаар баримталж буй зорилтыг хэрэгжүүлж байгаагийн нэг илрэл мөн.

СӨБ-ын чанар, үр ашигт нөлөөлдөг нэгэн хүчин зүйл бол багшлах боловсон хүчний хүртээмж, чанарын асуудал юм. Тухайн үед улсын хэмжээнд нийт 839 цэцэрлэг (төрийн өмчийн 722, төрийн бус өмчийн 117) –ийн 5198 бүлэгт 4651 үндсэн багш, 4082 туслах багш ажиллаж байв.

Хүснэгт 5. Үндсэн ба туслах багшийн тоо

	2006-2007	2007-2008	2008-2009	2009-2010	2010-2011
Үндсэн	3262	3446	4242	4465	4651
Туслах	3197	3408	3632	3885	4082

Эх сурвалж. Боловсролын салбарын 2010-2011 оны хичээлийн жилийн статистикийн мэдээллийн эмхтгэл, БСШУЯ, УБ, 2011, 7-р тал

Судалгаанаас харахад, үндсэн хийгээд туслах багшийн тоо жилээс жилд тогтвортой нэмэгдэж байжээ. 1983 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт байгуулагдсан үеэс цэцэрлэгийн багш нар тав таван жилээр мэргэжил дээшлүүлдэг тогтолцоотой байсан юм. Харин 1991 онд уг институтыг татан буулгаснаар мэргэжил дээшлүүлэх тогтолцоо задарч, 2010 оныг хүртэл МУБИС-ийн СӨБ-ын сургууль, Боловсролын хүрээлэн, аймаг, нийслэлийн боловсролын газарт богино хугацааны төрөлжүүлсэн курст суралцаж мэргэжлээ дээшлүүлж байв. 2010-2011 оны хичээлийн жилээс БСШУЯ-аас багш нарыг тав, таван жилээр мэргэжил дээшлүүлэх үндэсний хэмжээний сургалт дахин сэргэж эхэлсэн бөгөөд зардлыг төрөөс дэмжих болжээ.

Түүнчлэн 2008 онд баталсан Монгол улсын сургуулийн өмнөх боловсролын хуулийн 12.1-д заасанчлан "...СӨБ-ын байгууллагад сургуулийн өмнөх боловсролын чиглэлээр дипломын болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй багш ажиллуулна" гэсэн нь СӨБ-ыг мэргэжлийн, бакалаврын зэрэгтэй боловсон хүчнээр хангах эрх зүйн орчныг бий болгожээ.

Хэдийгээр ийм нааштай алхмууд хийгдэж байгаа ч цэцэрлэгийн тоо хүн амын болон хүүхдийн төрөлтийн тооны өсөлтөөс хоцорч байгаагаас цэцэрлэгийн нэг бүлэгт байгаа хүүхдийн тоо харьцангуй их байгаа нь багш нарын ачааллыг ихээхэн нэмэгдүүлж энэ нь сургалтын чанарт сөргөөр нөлөөлж байв.

Түүнчлэн багш нарын олон төрлийн бичиж гүйцэтгэх ажил, уралдаан тэмцээн болон багш нарын ажлын үнэлгээ нь зарим талаар дээрх үзүүлэлтээр дүгнэгдэх гаж гэмээр үнэлгээ нь багш нарын ачаалалд улам нэмрээс болж бага насны хүүхэдтэйгээ ажиллах, тэдэнд анхаарал хандуулах, мэргэжил боловсролоо дээшлүүлэх боломжийг хязгаарлаж байлаа. Гэсэн ч СӨБС нь 2001 онд байгууллагын, 2006 онд Дээд боловсролын Магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлөөр сургалтын хөтөлбөрөө батлуулж үйл ажилагаагаа явуулж байв. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөө 2009 онд Стандартчилал, хэмжил зүйн газраар батлуулсан "Сургуулийн өмнөх боловсролын багш"-ын стандарт болон МУБИС-ын "Багшийн олон талт загвар"-т тулгуурлан боловсруулан хэрэгжүүлж байлаа.

Боловсролын ажлыг өөрчлөн шинэчлэх ажлын нэг чухал хэсэг нь сургалтын агуулга, аргазүйн өөрчлөлт байв. Энэ үед бага, дунд, дээд боловсролын агуулгын

стандартыг батлан мөрдүүлснээр сургалтын агуулгыг суралцагсдын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн уян хатан, нээлттэй, олон хувилбартай болгож, сургалтыг прагматик чиглэлтэй болгон, суралцагчдыг тасралтгүй хөгжүүлэх, сэтгэлгээг чөлөөтэй болгох чиг хандлагыг хэрэгжүүлэх боломжтой болов.

“Монгол Улсын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөө”-г Засгийн газар батлан хэрэгжүүлж эхэлсэн нь харьцангуй урт хугацааны салбар дамнасан хөгжлийн тогтвортой бодлогыг баримталсан, хүнийхээ хөгжилд чанарын дэвшил гаргахад дотоод, гадаад хөрөнгийн эх үүсвэрийг нэгдмэл зохицуулагатай удирдах боломж олгосон стратеги төлөвлөлтийн баримт бичиг болсон юм.

Боловсролын Мастер төлөвлөгөө (1993)-нд тусгасны дагуу боловсролын хүний нөөцийг бэхжүүлэх ажил амжилттай хэрэгжиж эхлэв. Боловсролын шинэчлэлийн шилжилтийн хүнд үед, олон улсын санхүүгийн байгууллага Азийн хөгжлийн банкнаас техникийн туслалцаа авч шилжилтийн эхэн үеийн бэрхшээлийг даван туулах анхны Мастер төлөвлөгөөг боловсруулсан нь цагаа олсон үр нөлөөтэй арга хэмжээ болов.

Мастер төлөвлөгөөний зорилтыг үндсэнд нь хэрэгжүүлснээр 1990-ээд оны сүүл үеэс албан боловсролын хүрээн дэх хөгжлийн бууралт саармагжиж, албан бус сургалтын үйлчилгээний эх суурь тавигдаж, хувийн хэвшлийн сургуулиуд төлөвшиж эхэлсэн байна. Боловсролын төсөв ДНБ-ний 6.4 хувь болж арван жилийн өмнөхтэй харьцуулахад 1.1 пунктээр буюу тоон дүнгээрээ 5 дахин өссөн байна. Үүний дотор багшийн давхардсан цалингийн өсөлт 2.6 дахин, урсгал зардал 18 дахин, хөрөнгө оруулалт 15 дахин тоон дүнгээрээ тус тус өссөн дүнтэй байна. Тухайлбал, өнгөрсөн хугацаанд ерөнхий боловсролын сургуулийн нийт төсөвт цалингийн сангийн эзлэх хувь 1997 онд 43.2 хувь байсан бол 2000 онд 54.8 хувь болж өссөн байна.

Энэ төлөвлөгөөний дагуу 2006-2007 оны хичээлийн жилээс “Үдийн цай” хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлжээ. Тухайн онд “Үдийн цай” хөтөлбөрт 1-4 дүгээр ангийн 110.0 мянган хүүхэд хамрагдаж, улсаас 9,7 тэрбум төгрөг төсөвлөн зарцуулж байв. Эцэг эх, иргэдээс авсан санал асуулгын дүнгээс үзвэл тэдний 94.0 хувь нь энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэнд талархалтай хандаж байлаа.

Хүн амын дийлэнх болсон хүүхэд залуучуудад боловсролын үйлчилгээг хүргэх хөрөнгө зардлыг улс дангаараа хариуцах эдийн засгийн ерөнхий чадавхи сул

байсан тэр үед гадаадын хандивлагчдын хөрөнгө санхүүгийн дэмжлэг туслалцаа чухал ач холбогдолтой байв. Энэ үед боловсролын салбарт хамтран ажиллаж, цаг үеэ олсон тусламж дэмжлэг үзүүлж ирсэн ЮНЕСКО, Азийн хөгжлийн банк, Япон, Солонгос, Дани, ХБНГУ-ын Засгийн газар, ЮНЕСКО, ЮНИСЕФ, Соросын сан-Нээлттэй нийгмийн хүрээлэн зэрэг түншүүд тэр жилүүдэд боловсролын шинэчлэлийн үйл хэрэгт үзүүлсэн санхүү, материал, хүн хүч, онол-аргазүйн дэмжлэг нь боловсролын хямралт байдлыг даван туулахад Монгол улсын засгийн газарт тусласан юм. Энэ хамтын ажиллагааны дунд “шавь төвтэй”, “бүтээлч” зэрэг сургалтын олон үзэл баримтлал түгэн дэлгэрч, стандартад суурилсан сургалтын тогтолцоо, чанарын хяналтын хөндлөнгийн мэргэжлийн хяналт, магадлан итгэмжлэлийн механизм үүсч тогтсон юм.

Монгол Улсын боловсрол дэлхий нийтийн боловсролын сүлжээнд нэгдэн орсоноор “Бүх нийтийн боловсрол”-ын нийтлэг зорилтуудыг биелүүлэх, монгол иргэний эзэмшсэн боловсрол, мэргэжлийг хүлээн зөвшөөрөх үндсэн шаардлагыг хангах, өргөн хүрээнд хөрвөж ашиглах боломжийг бүрдүүлэх зэрэг глобал шинжтэй асуудал бидэнд бодит хэрэгцээ болж ирэв.

X-XI зууны эхний жилүүдэд боловсролын шинэчлэлийн томоохон алхамыг хийж, 2002 онд УИХ-аас шинэчлэн найруулсан боловсролын багц хуулиудыг батлав. Энэхүү багц хуулиар ЕБ-ыг 11 жилийн сургалтын тогтолцоонд, 2006 оны боловсролын багц хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, түүний бэлтгэлийг хангах, суралцагчийн нас, сурах орчин нөхцөл, сурах бичгийг ерөнхий боловсролын шинэ стандарттай уялдуулах сайжруулахад чиглэгдсэн харилцаа, хамрах хүрээг тодорхойлсноор Монгол улсын боловсролыг дэлхийн нийтлэг жишиг, хандлагад нийцүүлэн хөгжүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлснээрээ түүхэн ач холбогдолтой болсон юм. Энэ үед дээр дурдсанаар Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулиудыг баталснаар боловсролын тогтолцооны үндсэн бүтцүүдийн эрх зүйн орчин бүрэн бүрдэв.

1991 оноос өмнө Монгол Улсад зөвхөн төрийн өмчийн сургууль ажилладаг байсан бол дурдан буй хугацаанд төрийн өмчийн, хувийн, холимог өмчийн, гадаадын хөрөнгө оруулалттай, хамтарсан сургуулиуд ажиллаж байв. 2010-2011 оны хичээлийн жилд улсын хэмжээнд 814 цэцэрлэгт 140 гаруй мянган хүүхэд сурч хүмүүжиж байлаа.

Монголын ерөнхий боловсролын бүрэн дунд 11 жилийн сургалтын төлөвлөгөөг 2005-2006 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж, бага болон ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд олон өөрчлөлтүүд орсон юм. 2008/2009 оны хичээлийн жилээс 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх ажил эхлэв. Энэ зорилгоор сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөр, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг бүрэн шинэчлэж, багш нарыг сургалтад дахин хамруулав.

Дунд сургууль төгсөгчдөөс авах ЕШ-ын системийг БСШУЯ-ны харъяа Боловсролын үнэлгээний Төв 2006 оноос нэвтрүүлж хэрэгжүүлэв.

“Үдийн цай” хөтөлбөрийг 2006-2007 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж эхэлсэн ба түүнийг Үдийн хоол болгон өргөтгөхөөр туршилт ажлыг эхлүүлэв.

Сургалтын агуулга, аргазүй, хэрэглэгдэхүүнийг шинэчилж, бага ангийн сурах бичгийг 80.0-100.0 хувь, дунд, ахлах ангийн сурахыг 40.0 хувь төрөөс хангах бодлого үргэлжилж байна. 2010-2011 оны хичээлийн жилийн байдлаар ерөнхий боловсролын 753 сургуульд 523.5 мянган хүүхэд суралцаж байлаа. Мөн тэр хичээлийн жилээс ерөнхий боловсролын агуулгын стандартыг Кембрижийн стандартын жишгээр сайжруулах ажил амжилттай хэрэгжиж эхэлсэн байна.

Монгол Улсад мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо ч сэргэж эхлэв. 2008 оноос АНУ-ын Засгийн газраас олгох Мянганы сорилын Сангийн тусламжийн нэг хэсгийг энэ салбарыг хөгжүүлэхэд зарцуулахаар төлөвлөв. 2010-2011 оны хичээлийн жилд мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн 64 төвд 45 мянган сурагч суралцаж байв. Дараагийн хичээлийн жилд нь МСҮТ-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, сургалтын орчныг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэхэд дорвитой алхам хийгдэхээр төлөвлөсөн байв. Үүний үр дүнд тухайн хичээлийн жилд мэргэжлийн боловсрол, сургалтын сургуулиудад нийтдээ 28.0 мянга орчим хүн сурч буй нь өнгөрсөн оноосоо даруй 7.0 мянгаар нэмэгдсэн байна. Харин их, дээд сургууль, коллежид 138.0 мянган залуус суралцаж байлаа.

Дундын дараах шатны боловсролын секторт байгууллагын магадлан итгэмжлэлийн тогтолцоог 1993 оноос эхлэн бий болгов. Дээд боловсролын сургалтын байгууллагуудын үйл ажиллагаа, үр дүнгийн чанарыг дээшлүүлэхэд энэ нь чиглэж байлаа. Төр засгаас дээд боловсролын үйлчилгээнд онцгой анхаарал хандуулж, түүний үйл ажиллагааг хөндлөнгөөс магадлах болсоноор 2010-2011 оны хичээлийн жилийн байдлаар Монгол Улсын төрийн өмчийн 14 их сургууль, тэдгээрийн бүтцийн 14 сургууль, 42 дээд сургууль, 14 коллеж, МСҮ-ийн

2 төв байгууллагын магадлан итгэжлэл хийлгээд байсан ба дараа шатны зорилт нь хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг эрчимжүүлэх, түүнийг чанарыг сайжруулах асуудал чухал болж байв.

2011 оны байдлаар 113 их, дээд сургууль, коллежид 168 мянга гаруй оюутан суралцаж байлаа. Төрийн өмчийн 16 их, дээд сургууль шинэ бүтцээр ажиллаж эхлэв. Их сургуулийн хотхоныг нислэлийн Налайх дүүрэгт барьж байгуулах ажлыг эхлүүлэв. Хүний хөгжил Сангаас иргэдийн авах үйлчилгээний төрөлд дээд боловсролын үйлчилгээг хамруулаад байв. Энэ нөхцөлд дээд боловсролын байгууллагад тавих чанарын шаардлагыг өндөржүүлэх хэрэгцээ өндөрсөв. Мөн тэр хичээлийн жилээс АХБ-ны дээд боловсролын чанарыг дээшлүүлэх төсөл хэрэгжиж эхлэв. Олон улсын хэмжээнд нийтлэг тогтсон аргачлалын дагуу боловсролын үр дүнг мэргэжлийн твшинд үнэлэх ажил эхэлж байна. 1990-ээд оноос хойш манай боловсролын тогтолцоонд хийгдсэн өөрчлөлт, шинэчлэлтийн нэг том хэсэг нь Монгол улсад боловсрол судлал шинэ агуулга, арга зүйгээр олон улсын нийтлэг хандлагын дагуу амжилттай хөгжиж байгаа явдал байв.

XI зуунд боловсрол судлалын шинжлэх ухаан, сурган хүмүүжүүлэх ухаан нь боловсролын түүх, философи, хүн судлал, сэтгэл судлал, бодлого судлал, менежмент, эдийн засаг, эрх зүй, социологи, ёс зүй, хэмжил зүй (үнэлгээ), статистик, харьцуулсан судлал, боловсрол, сургалтын онол, арга зүй, хүүхэд, багш судлал, нийгмийн, нийтийн боловсрол зэрэг олон салбар, чиглэлээр эрчимтэй хөгжиж байна. Манай улсын боловсрол, боловсролын байгууллагууд үе үеийн төр, засгийн зохих бодлого, шийдвэр хийгээд шинжлэх ухааны ололт, амжилтад тулгуурлан төлөвшиж, хөгжиж ирсэн нь тодорхой ч нэн ялангуяа, үндэсний боловсролын хөгжил, стратеги, төлөвлөлтийг боловсролын бодлого судлалын тусгайлсан судалгаа, шинжилгээний үүднээс тодорхойлж, хэрэгжүүлж ирж чадаагүй гэж хэлэх үндэстэй байна. Учир нь манайд Боловсролын Бодлого Судлал (Education Policy Studies), Боловсролын Бодлогын шинжилгээ (Education Policy Analysis) хөгжөөгүй байна.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгын хөгжил, байдал

Манай улсад сургалтын хөтөлбөр ялангуяа, ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр хөгжиж ирсэн түүхэн байдалд сургалтын онол, арга зүйн үүднээс тойм судалгаа, шинжилгээ хийхэд, тухайлбал, 1925 оноос сургуулийн хөтөлбөр, 1931 оноос хичээлийн программ, 1960-аад оноос хичээлийн хөтөлбөр, 1990-ээд оноос сургалтын агуулга, 2000 оноос цөм агуулга, агуулгын үлгэрчилсэн хүрээ, 2008

оноос үндэсний сургалтын хөтөлбөр, 2012-2013 оноос цөм хөтөлбөр гэсэн нэрээр боловсруулж, амьдралд хэрэгжүүлж ирсэн байна. Харин 1998 оны боловсролын агуулгын стандартад “Цөм хөтөлбөр” гэдэг нэр томъёог манайд анх хэрэглэжээ.

Ерөнхий боловсролын сургалтын агуулга нь сургалтын төлөвлөгөө болон сургалтын хөтөлбөрөөр тодорхойлогдоно. Сургалтын төлөвлөгөө бол бага, дунд сургуульд үзэж судлах хичээлүүдийн нэр, тоо, судлах цаг болон судлах дарааллыг тодорхойлсон удирдамж баримт бичиг юм. Сургалтын төлөвлөгөө нь сурагчдын үзэж судлах хичээлүүдийн нэр, судлах цагийн хэмжээг бага, дунд, ахлах ангиудаар, 7 хоног болон хичээлийн жилээр хэрхэн судлахыг тодорхойлохоос гадна багшийн ажлын норм, цалин хөлсийг тогтоох эрх зүйн үндэс болдог байна. Сургалтын хөтөлбөр бол зорилго, зорилт, агуулга (контент), арга зүй, хэрэглэгдэхүүн, үнэлгээ бүхий багшлахуй, суралцахуйн хөтөч-удирдамж баримт бичиг юм. (Пүрэв, 2016)

Боловсролын сайдын зөвлөлөөр 1990 онд “Дунд сургуулийн бүтэц, сургалтын агуулгыг өөрчлөх чиглэл” гэсэн баримт бичгийг хэлэлцэн баталжээ. Тус баримт бичигт “Дунд сургуулийн үйл ажиллагаа нь хүүхэд, залуучуудыг үндэсний соёл, ёс заншлын өв уламжлалаар хүмүүжүүлж, тэдэнд хүн төрөлхтний хуримтлуулсан шинжлэх ухааны мэдлэг, боловсролыг эзэмшүүлэх, хүнлэг энэрэнгүй үзэл, бүтээлч сэтгэлгээ төлөвшүүлэх, авъяас чадварыг нь хөгжүүлэх, бие даан суралцах, аж төрөх, арга барил олгоход чиглэгдэнэ” гэжээ. Мөн дунд сургуулийн сургалтын агуулга нь байгаль, техник, нийгэм, хүний тухай цэгцтэй мэдлэг, бүтээлч үйл ажиллагааны арга туршлагаас бүрдэнэ гэсэн байна. Боловсролын агуулгын онолын талаар ЗХУ (хуучин нэрээр)-ын сурган хүмүүжүүлэгчдийн үзэл, онолыг баримталж, монгол хэл, уран зохиол, гадаад хэл, математик, мэдээлэл зүй, байгалийн ухаан, нийгмийн ухаан, гоо зүй, биеийн тамир-эрүүл мэнд, хөдөлмөр-техник гэсэн 8 бүлэг хичээл судлахыг чиглэл болгожээ. Сургалтын агуулгыг өөрчлөхдөө:

- Агуулгыг үндэсний соёл, зан заншил, оюуны өв уламжлалд суурилан боловсруулах,
- Шинжлэх ухаан, техник, технологийн ололт, эдийн засаг, экологийн асуудлыг тусгах,

- Судлагдахууны онолын ба хэрэглээний чиглэлийг зохистой хослуулах,
- Сурагчдын сэтгэхүйн онцлогт тохируулах, интеграци, дифференциацийн зарчмыг зохистой хослуулах,
- Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлалын үндсийг тусгах зэрэг шаардлагыг харгалзан хэгэжүүлэх зорилт тавьсан байна.

Түүнчлэн Боловсролын сайдын 1991 оны 284 дүгээр тушаалаар баталсан үзэл баримтлалд "... Хүүхэд залуучуудад үндэсний соёлын өвийг хүн төрөлхтний соёл иргэншлийн ололттой хослуулан эзэмшүүлж, шинжлэх ухааны үндэстэй эрдэм боловсрол олгох..." гэж заасан байна. Энэ нь тус улсын бага, дунд боловсролын агуулгад үндэсний соёл, уламжлал нэн дутмаг тусгагдаж ирсэн тухайн үед чухал чиглэл болсон байна. Мөн бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмших хугацааг 6+2+2 гэсэн бүтцээр тогтоосон. Эдгээртэй холбоотойгоор бага, дунд боловсролын агуулгыг шинэчлэх дараах шаардлагууд тавигдсан байна. Үүнд:

- 1990-1991 оны хичээлийн жилээс 7 настай хүүхдийг сургуульд элсүүлэн сургах,
- Бага, дунд боловсролын агуулгад үндэсний өв уламжлал, түүх, соёлын үнэт зүйлсийг тусгах,
- Бэлтгэл хангагдсан сургуулийн 1 дүгээр ангиас үндэсний өв соёл болсон монгол бичгээ заах,
- "Ариун ёс журам" хичээл шинээр нэмж оруулах,
- Сурагчид сонирхлынхоо дагуу 5 дугаар ангиас орос, англи хэлийг сонгон судлах,
- Биеийн тамирын хичээлийг эрүүл мэнд, биеийн тамирын хичээл болгох,
- Ахлах ангийг төрөлжүүлсэн сургалтад шилжүүлэх зэрэг болно.

Мөн боловсролын түвшин бүрт сурагчдын эзэмших мэдлэг, чадварын эзэмших минимум түвшинг тусгасан суурь хөтөлбөрийг хичээл бүрээр боловсруулна. Суурь боловсролын сургалтын хөтөлбөрт хичээл тус бүрийн агуулгын 75-80 хувийг төр тогтоож өгөх ба 20-25 хувьд нь сургууль, багш бүр орон нутаг, сургуулийн онцлогийг бүтээлчээр тусгасан хөтөлбөр боловсруулан хэрэглэнэ гэж заасан нь сургалтын хөтөлбөрийг нээлттэй, уян хатан, олон хувилбартай байх эхлэлийг тавьсан.

Суурь боловсролын түвшинд байгалийн ухааны хичээлүүдийг дифференциаци байдлаар судлах, ахлах анги буюу бүрэн дунд боловсролын түвшинд төрөлжсөн сургалтыг математик, мэдээлэл зүй, байгаль, нийгмийн ухаан, хөдөлмөр, технологийн чиглэлээр зохион байгуулах болсон. Энэ дагуу ерөнхий

боловсролын агуулгыг шинэчлэх ажлыг эхэлсэн. Ийнхүү 1994 он гэхэд бүх хичээлийн хөтөлбөрийг шинэчлэн сургуулийн практикт нэвтрүүлсэн байна. Мөн сурагчид үндэсний соёл, зан заншил, оюуны өв уламжлалыг хичээлүүдээр судалдаг болсон.

Сургалтын агуулгыг шинэчлэх ажил 1992-1997 онд “Монголын бага, дунд боловсролыг дэмжих Монгол-Данийн хамтарсан төслийн хүрээнд хийгдсэнийг дурдах нь зүйтэй. 1991-1998 онд бага, дунд, бүрэн дунд боловсрол олгох хугацаа 1 удаа өөрчлөгдөж, сургалтын төлөвлөгөө, хичээлийн хөтөлбөрийг ч шинэчлэж эхэлсэн байна.

“Ерөнхий боловсрол” сэдэвт шинжлэх ухаан, технологийн төслийн хүрээнд 1994-1998 онуудад бага, дунд боловсролын агуулга, стандартыг боловсруулах судалгааны ажил хийгдсэн байна. Бага, дунд боловсролын агуулга, стандарт боловсруулахын тулд өмнөх онуудад боловсруулсан агуулгын хэрэгжилтийн байдалд үнэлгээ өгч, бусад улс орны боловсролын агуулгад харьцуулсан судалгаа хийжээ.

1994-1995 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөөг шинэчлэн мөрдсөн байна. Тухайлбал, Шинжлэх ухаан, Боловсролын сайдын 1994 оны 3-р сарын 26-ны өдрийн 75 тоот тушаалаар ЕБ-ын 10 жилийн сургуулиудад мөрдөх сургалтын төлөвлөгөөг дараах байдлаар баталсан байна. (Хүснэгт 6-г үзнэ үү.)

Хүснэгт 6. 1994-1995 оны хичээлийн жилд мөрдөх ЕБС-ийн сургалтын төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	7 хоногт үзэх цаг, ангиар										бүгд
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	
1	Монгол хэл	9	9	9	7	5	4	3	2	1	1	50
2	Утга зохиол					2	2	2	2	3	3	14
3	Гадаад хэл					5	5	3	3	3	3	22
4	Математик	5	5	5	5	5	5	5	5	5	5	50
5	Мэдээлэл зүй									1	1	2
6	Ёс заншил, эрх зүй	1	1	1	1	1	1	1	1			8
7	Түүх, нийгмийн тухай мэдлэг				2	2	2	2	2	1	2	13
8	Газарзүй						2	2	2	2		8
9	Орон нутаг судлал, байгалийн шинжлэл	1	2	2	2	2						9

10	Физик, одон орон						1	2	3	4	5	15
11	Биологи						2	2	2	1	2	9
12	Хими							2	2	3	3	10
13	Дүрслэх урлаг	2	2	2	2	1	1					10
14	Дуу хөгжим	2	2	2	2	2						10
15	Зохион бүтээх хөдөлмөр	1	1	1	1	2	2	3	3	2	2	18
16	Биеийн тамир, эрүүл мэнд	2	2	2	2	2	2	2	2	2	2	20
Амьдрах ухаан, мэргэжлийн баримжааны заавал сонгох хичээл						3	3	3	3	4	4	20
1	Оёдол ахуйн үйлчилгээ											
2	Хоол хүнс											
3	Мужаан дархан											
4	Мал аж ахуйн үндэс											
5	Газар тариалангийн үндэс											
6	Техникийн мэдэгдэхүүн											
7	Бизнесийн мэдэгдэхүүн											
Нийт цаг		23	24	24	24	32	32	32	32	32	33	288
Сонгон суралцах		1	1	1	1	2	2	3	3	3	3	288

Эх сурвалж Ерөнхий боловсролын холбогдолтой тушаал, заавар, журам. УБ., 1994

Дээрх сургалтын төлөвлөгөөний дагуу бага ангид монгол хэл, математик, ёс заншил, Эх орны түүхийн мэдэгдэхүүн, орон нутаг, дүрслэх урлаг, дуу хөгжим, зохион бүтээх хөдөлмөр, биеийн тамир гэсэн 9 хичээлийн хөтөлбөрийг боловсруулж, мөрдсөн байна. Харин дунд, ахлах ангид эдгээр хичээл дээр нэмээд эрх зүй, байгалийн шинжлэл, физик, одон орон, биологи, хими, дүрслэх урлаг, дуу хөгжим, зохион бүтээх хөдөлмөр, эрүүл мэнд гэсэн 16 хичээл болон амьдрах ухаан, мэргэжлийн баримжааны чиглэлээр сонгон судлах сургалтын төлөвлөгөөнд заасан нэр бүхий 7 хичээлийг судалсан байна.

Энэчлэн БСШУ-ны сайдын 1998 оны 100 дугаар тушаалаар баталсан сургалтын төлөвлөгөөг 1998-1999 оны хичээлийн жилээс ерөнхий боловсролын сургуулиудад мөрдөн хэрэгжүүлжээ. Эл сургалтын төлөвлөгөө нь 1994-1995 оны хичээлийн жилээс хэрэгжүүлсэн сургалтын төлөвлөгөөн дэх хичээлүүдийг үндсэндээ уламжлан хадгалсан бөгөөд мэдээллийн технологийн хийгээд тухайн үеийн хэрэгцээ, шаардлагатай холбоотойгоор 9-10-р ангид Мэдээлэл зүй, 4,5,6-р ангид Байгалийн шинжлэл хичээлийг шинээр судлахаар оруулсан байна. Мөн 1-

10-р ангид үздэг Зохион бүтээх хөдөлмөр хичээлд “зураг төсөл” -ийг нэмж тусгасан аж. Бас заавал суралцах болон сургууль зохицуулах хичээлүүдийг бага ангид 7 хоногт 1 цагаар, дунд, ахлах ангид 7 хоногт 2 цагаар үзэхээр заажээ.

Үүнтэй холбогдуулан жишээлбэл, эрүүл мэнд, экологи, эдийн засаг, эрх зүй, зэрэг бүх нийтийн ерөнхий боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн заавал суралцах бусад хичээлийг тухайн сургуулийн сурагчдын тооноос хамааран ангиар буюу факультет хэлбэрээр бүх сурагчдад судлахаар зохион байгуулжээ. Эдгээр хичээлийн агуулгыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална. Суралцагчдын эрэлт хэрэгцээ, авьяас сонирхолд үндэслэн ерөнхий эрдмийн аль ч чиглэлээр гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт, мөн техник технологи, үндсэн бус гадаад хэл, байгалийн ухааны нэгдмэл хичээл зэрэг сургууль нь зохицуулах хичээлийг ангиар, бүлгээр, холимог бүлгээр хичээлийн хуваарьт оруулан зохион байгуулж болно. Энэ төрлийн хичээлийн агуулгыг сургуулийн сурган хүмүүжүүлэх зөвлөл тогтооно. Албан сургалтын хүрээнд энд заасан нийлбэр цагаас илүү цагаар сургалт зохион явуулахыг зөвшөөрөхгүй хэмээн тухайн сургалтын төлөвлөгөөний тайлбарт тусгасан байна.

Бүх шатны боловсролын агуулга, стандартын талаар Монгол Улсын Их Хурал 1995 онд анхлан баталсан “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д “Бага, дунд, дээд боловсролын стандартыг төрөөс тогтоож, түүнийг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад нэгэн адил мөрдүүлэх, хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлэх механизмыг бий болгох” гэж заасны дагуу бэлтгэл ажлыг хангасан байна.

Монгол улсын боловсролын түүхэнд анхлан 1998 онд стандарт боловсруулж, хэрэгжүүлсэн. Энэ анхны стандарт бол бага, дунд боловсролын агуулгын стандарт юм.

Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгээс “Сүүлийн үед явуулсан судалгаа, ДАНИДА төслийн туршилтын шавь төвтэй сургалтын онол, арга зүйгээс харахад бидний олон жилийн ажиглалт, туршилт-судалгаа, задлан шинжилгээний үр дүнд өнөөгийн сургалтын талаар дараах дүгнэлт хийж болох байна. Нэгдүгээрт, сургалтын академик буюу онолын номлол ихсэж, эмпирик амьдралд хэрэгтэй зүйл нь багасч, ярьж чаддаг, хийж чаддаггүй боловсролтой гэгдэх хүмүүс олширсон нь сургалтын нэр хүндийг бууруулах гол хүчин зүйл болов. Хоёрдугаарт, сургалтыг зохион байгуулах хэлбэр нь зөвхөн багшийн үйл ажиллагаа голлосон багш төвтэй, анги хичээлийн тогтолцоо ноёлсоор өнөөг

хүрсэнээс сургалтын агуулга нүсэр, судлах хугацаа экстенсив, судалдаг хичээлүүдийн интеграци сул, суралцагчдын цээжилж тогтоосон, нэрлэсэн мэдээллийн жин их болжээ.... зургаадугаарт, нийгэм төвтэй боловсрол, сургууль төвтэй сургалт байсан ..." хэмээн агуулгын стандарт боловсруулан мөрдөхөөс өмнөх үеийн сургалтын агуулга, арга зүй, зохион байгуулалтын дутагдлыг цохон тэмдэглэсэн байна. Мөн "Манай орны хувьд сургалтын орчин үеийн арга, зохион байгуулалтын хэлбэрүүдийг бий болгох эрлийг багш, сурган хүмүүжүүлэгчид хийж байгаа боловч шийдэмгий эхэлж, тодорхой үр дүнд хүрч чадахгүй л байна" гэжээ. Агуулгын стандартыг Боловсролын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйчид, Улсын Багшийн Их Сургууль, Монгол Улсын Их Сургууль, Соёл Урлагийн Их сургуулийн багш нар болон ШУА-ийн зарим хүрээлэнгийн эрдэмтэд, ЕБС-ийн ахмад болон залуу багш нар, ДАНИДА төслийн баг, ТББ-ын төлөөлөл нийт 108 хүн оролцсон багаар боловсруулжээ.

Харин Бага, дунд боловсролын стандартыг БСШУ-ы сайдын "үзэл баримтлал батлах тухай" 2002 оны 202 дугаар тушаалаар баталсан "Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал"-д тулгуурлан боловсруулсан байна. Мөн бага, дунд боловсролын агуулгын стандартад хийсэн дээр дурдсан үнэлгээний үр дүн, дүгнэлтийг харгалзан үзжээ. Ийнхүү тухайн стандартыг боловсруулах ажлыг удирдан зохион байгуулах, мөн үзэл баримтлалын дагуу боловсруулах, хэлэлцэх, сайжруулах ажлыг хэрэгжүүлсэний үр дүнд бага, дунд боловсролын цогц стандартыг бий болгосон байна.

Тухайлбал, Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн зөвлөлөөр 2004 онд сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшний 4 стандарт (MNS 5420.1:2004, MNS 5420.2:2004, MNS 5420.3:2004, MNS 5420.4:2004) болон монгол хэл, уран зохиол, математик, мэдээлэл зүй, физик, хими, биологи, газарзүй, байгалийн шинжлэл, гадаад хэл, түүх, нийгмийн ухаан, дүрслэх, урлаг, зураг төсөл, технологи, биеийн тамир, эрүүл мэнд, хөгжим зэрэг боловсролын чиглэлийн 16 стандартыг тус тус боловсруулан батлуулсан. 1998 оны агуулгын стандарт болон 2004 оны бага, дунд боловсролын стандартын ялгааг харьцуулан харуулья. Үүнд:

Хүснэгт 7. Агуулгын болон боловсролын стандартын харьцуулалт

АГУУЛГЫН СТАНДАРТ	БОЛОВСРОЛЫН СТАНДАРТ
Судлагдахуун төвтэй	Цогц чадамж төвтэй

<ul style="list-style-type: none"> • Судлагдахууны стандартчилах суралцагчдын эзэмшсэн мэдлэг, чадварыг үнэлэх • Судлах агуулгыг цөм хөтөлбөрийн хүрээнд сонгон хэрэгжүүлэх • Багшийн үйл ажиллагаа давамгайл • Мэдээлэл дамжуулах • Судлагдахуунд төвлөрсөн • Салангид мэдлэг, чадварыг үнэлэх • Стандарт нь судлагдахуун • Киррикулим нь баримт бичиг 	<ul style="list-style-type: none"> • Боловсролын бүхий л үйл явцыг стандартчилах замаар боловсролын чанарыг суралцагчдад төлөвшсөн цогц чадамжаар хэмжих, киррикулим хөгжилд хөтлөх • Судлах агуулгыг цогц чадамжид баримжаалан багш нар сонгон хэрэгжүүлэх • Багш сурагчийн хамтын үйл ажиллагаа давамгайл • Мэдлэг бүтээлгэх • Мэдлэгээ хэрэглэх арга зүйд төвлөрсөн • Цогц чадамжийн төлөвшлийг үнэлэх • Стандарт үйл ажиллагааны бүтэцчилсэн хүрээ • Киррикулим нь үйл явц
---	--

Эх сурвалж: Дунд боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын агуулгын судалгаа УБ., 2009. 8 дахь тал

1998 онд УИХ-аас 1995 онд батлагдсан Боловсролын тухай багц хуулинд нэмэлт өөрчлөлт оруулж, жишээлбэл, 6-7 настай хүүхдийг тодорхой нөхцөл бололцоо бүрдсэн ЕБС-д элсүүлж суралцуулж болно гэсэн заалтыг шинээр тусгасан. Мөн 2002 онд УИХ Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулж, тухайлбал, “Бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 11 жилд эзэмшүүлнэ” хэмээн хуульчилсан ба зохих нөхцөл бололцоо бүрдсэн ЕБС-д 6 настай хүүхдийг элсүүлэн суралцуулж болно, ЕБС нь ердийн, гүнзгийрүүлсэн, мэргэжлийн, тусгай гэсэн хэв шинжтэй байна гэж тус тус заасан нь манай улсын ЕБС-ийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх эрх зүйн үндсийг тавьсан байна.

Боловсролын тухай хуулийн эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор ЕБС-иудыг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх, цаашид 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх бэлтгэлийг бүх талаар хангах тухайлбал, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг шинэчлэх, агуулгыг оновчтой тогтоох ажлыг дэс дараатай хийсэн байна.

Бага, дунд боловсролын тухай хуулийн заалт болон “Монгол Улсын Засгийн газраас 2004-2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр”-т дэвшүүлсэн зорилтыг үндэс болгон БСШУЯ-ны захиалгаар Боловсролын хүрээлэн 2004-2005 онд “Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр”, 2006-2007 онд “12 жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгын хүрээ”, мөн “12 жилийн сургалтын агуулга, хөтөлбөр” төслүүдийг тус тус хэрэгжүүлсэн байна.

2004-2005 онд хэрэгжүүлсэн “Бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөр” төслийн үр дүнд 10 жилийн тогтолцооноос 11 жилийн тогтолцоонд шилжилт хийхэд тохиолдох агуулга, арга зүйн бэрхшээлүүдийг илрүүлж, шилжилтийн агуулга боловсруулан туршсан. ЕБС-ийн хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ нь Бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх бүлэг сэдвийн болон ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээл төлөвлөхөд баримжаа болсон ач холбогдолтой ч бүтэц, агуулгын хувьд бусад улс орны ерөнхий боловсролын сургуульд мөрддөг сургалтын хөтөлбөрийн жишигт хараахан хүрээгүй дутагдал байгаа нь судалгаанаас харагдсан байна.

Ерөнхий боловсролын сургууль 11 жилийн тогтолцоонд шилжих бэлтгэлийг хангахтай холбоотойгоор жишээ нь, Булган, Дорноговь, Төв аймгийн тус бүр 3 сургууль, 3 цэцэрлэг, Нийслэлийн ердийн болон тусгай сургуулийн 8 сургууль, 4 цэцэрлэгт 2004-2005 оны хичээлийн жилд сургалтын төлөвлөгөө, агуулгын үлгэрчилсэн хүрээг магадлах, нягтлах зорилго бүхий туршилт хийжээ. Мөн бага, дунд боловсролын 11 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээний туршилтын ерөнхий арга зүй, аргачлал, БСГ-ын дарга, сургуулийн ерөнхий менежер, нийгмийн ажилтан, багш, эцэг эх, сурагчийн үйл ажиллагааны хүрээг Боловсролын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 2004 оны 6 дугаар сарын 22-ны өргөтгөсөн хурлаар баталсан байна.

Боловсролын хүрээлэнгийн захирлын “Сургалтын төлөвлөгөө, агуулгын үлгэрчилсэн хүрээг турших баг байгуулах тухай” 2004 оны 10 дугаар тушаалаар туршилтын менежментийн баг (9 хүн), орон нутаг дахь менежментийн баг (4), туршилтын арга зүйн баг (18)-ийг нийт 31 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж, турших үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлсэн. Тухайлбал, дээр дурдсанчлан 2004-2005 оны хичээлийн жилд сургалтын төлөвлөгөө агуулгын үлгэрчилсэн хүрээг магадлах туршилтыг Булган, Дорноговь, Төв аймгийн тус бүр 3 сургууль, 3 цэцэрлэг, Нийслэлийн ердийн болон тусгай 8 сургууль, 4 цэцэрлэгт хийж, туршилтын тайлан болон үр дүнг гаргасан байна.

Улмаар БСШУЯ, Хүрээлэнгээс ерөнхий боловсролын 11 жилийн тогтолцоонд шилжих шилжилтийн сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, аргачлалыг боловсруулж, хэрэгжүүлжээ. Хүрээлэнгээс ерөнхий боловсролын сургуулийн 1-11 дүгээр ангид үзэх хичээлүүдийн агуулгын хүрээг монгол хэл, уран зохиол, гадаад хэл, математик, мэдээлэл зүй, физик- одон орон, хими, биологи, хүн-байгаль, байгаль шинжлэл, газар зүй, нийгмийн ухаан, хөгжим бүжиг, эрүүл мэнд,

биеийн тамир, дүрслэх урлаг, технологийн чиглэлээр ерөнхий арга зүй, бүлэг сэдвийн үлгэрчилсэн хөтөлбөр судлах, агуулгын зөрүүг хэрэгжүүлэх арга зүй, ашиглах сурах бичиг болон боловсролын байгууллагын удирдлагын үйл ажиллагааны чиглэлээр тус тус зөвлөмж бичиж, сургууль, багш нарт түгээсэн байна.

Бага, дунд боловсролын 11 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээний туршилтын арга зүйг боловсролын хүрээлэнгийн эрдмийн зөвлөлийн 2005 оны 9 дүгээр сарын 06- ны өдрийн өргөтгөсөн хурлаар хэлэлцэн баталжээ. Мөн хүрээлэнгийн захирлын "сургалтын төлөвлөгөө, агуулгын үлгэрчилсэн хүрээг турших баг байгуулах тухай" 2005 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 12 дугаар тушаалаар туршилтын сургалтын төлөвлөгөө, туршилтын сургуулт, цэцэрлэг, туршилтын менежментийн баг, орон нутаг дахь менежментийн баг, туршилтын арга зүйн багийг нийт 19 хүний бүрэлдэхүүнтэй байгуулж үйл ажиллагааны чиглэл, төлөвлөгөөг тус тус баталжээ. Хүрээлэнгээс туршилтад хамрагдах сургууль цэцэрлэгийн удирдах ажилтан, багш эцэг эх, суралцагчийн үйл ажиллагааны хүрээ, төсөлт ажил, төрөлх нутаг, англи хэл, мэдээлэл зүй, ахлах ангийн байгалийн ухаан, ахлах ангийн сонгох хичээл, сургалтын менежерийн ачаалал, сургуулийн өмнөх боловсрол гэсэн чиглэлээр хэсэгчилсэн туршилт хийх арга зүй, мөн эдгээр чиглэлээр болон багшийн хүрэлцээ, хангамжийг тодорхойлох аргачлалыг боловсруулж хэрэгжүүлсэн байна.

2006 онд Боловсролын тухай хууль Бага, дунд, боловсролын тухай хуулинд оруулсан нэмэлт өөрчлөлтөөр ЕБС-ийн бүтцийг 6+3+3 байхаар заасан бөгөөд бага боловсролыг 6, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 11 жилд тус тус олгоно. ЕБС ердийн, гүнзгийрүүлсэн, мэргэжлийн тусгай гэсэн хэв шинжтэй байх заалтыг хэвээр хадгалав. БСШУ-ны сайдын 2006 оны 6-р сарын 6-ны өдрийн 236-р тушаалаар "ЕБС-д 2006-2007, 2007-2008" оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөө баталж, 2006 оноос манай улсын ЕБС-иуд 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж эхэлсэн. БСШУ-ны сайдын 2007 оны 8-р сарын 20-ны өдрийн 296-р тушаалаар "Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөөний хувилбарыг батлах тухай" шийдвэр гаргасан. Эдгээр сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зорилгоор Хүрээлэнгээс ерөнхий боловсролын сургуулийн бага, дунд, ахлах ангийн сургалтын төлөвлөгөө болон хичээлээс гадуурх үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга зүй, хичээлүүдийн агуулгын

үлгэрчилсэн хүрээ, түүний үндэслэл, бага, дунд, ахлах ангийн хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ (Боловсролын хүрээлэнгийн захирал “Хичээлүүдийн үлгэрчилсэн хүрээг батлах тухай” 2006 оны 8 дугаар сарын 6-ны өдрийн 15-р тушаалаар батлагдсан)-г тус тус боловсруулан амьдралд хэрэгжүүлжээ.

2006-2007 онд хэрэгжүүлсэн “12 жилийн сургалтын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгын хүрээ” төслийн хүрээнд 11 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтэц, хичээлүүдийн судлах агуулгын хүрээг боловсруулж, туршилт хийн, үр дүнг захиалагч талд хүлээлгэн өгсөн байна. Тус хоёр туршилт судалгааны ажлын үр дүн манай улсын төрийн болон төрийн бус өмчийн нийт сургуулийн практикт хэрэгжсэн байна. Түүнчлэн “12 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгын хүрээ” төслийн хүрээнд 12 жилийн сургуулийн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтэц, агуулгын бодлогыг боловсруулсан аж. Тухайлбал, “12 жилийн сургалтын агуулга, хөтөлбөр” (2008-2009) төсөл хэрэгжүүлэгч Боловсролын хүрээлэнгийн эрдэмтэн судлаачдаас голлон бүрдсэн багийнхан сургалтын агуулга гэдгийг “Сургах болон суралцах үйл ажиллагааны уян хатан ерөнхий төлөвлөгөө” гэж үзээд, энэ нь зорилго, зорилт, судлагдахуун, үр дүнг үнэлэх арга хэлбэр гэсэн бүтэцтэй хэмээн тэмдэглэжээ. Эл төслийн судалгааны үр дүнд “Дунд боловсролын 12 жилийн сургалтын агуулгын судалгаа” (2009) бүтээл гарчээ. Тус төслийн судалгаагаар гадаадын нэлээд улс орны 12 жилийн сургалтын агуулга, бүтцийг хэл, нийгмийн ухаан, математик, байгалийн ухаан, урлаг-гоо зүй, зураг төсөл, технологи, мэдээлэл зүйн сургалтын агуулгуудаар харьцуулан судалсан байна. Түүнчлэн ахлах ангийн гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн баримжаа олгох сургалтын туршлага, хөгжлийн хандлагыг гадаад улсуудын жишээн дээр судалжээ. Мөн 12 жилийн сургуулийн сургалтын агуулгын бодлогыг дээрх хичээлүүдээр гарган тавьсан байна. Жишээлбэл, бага ангийн Монгол хэлний хичээлийн бодлогыг ... “эх хэлээрээ уншиж, бичиж сурах, сургуулийн бага насны хүүхдэд зориулсан уранзохиолын болон бусад эх, ном зохиолыг уншиж ойлгох, ярьж тайлбарлах, болсон явдал, сонссон, уншсан зүйлийг үйл явдлын дэсээр хүүрнэн ярих, хүн юмс, үзэгдлийн гадаад шинжийг тоочин бичихээс гадна энэ талаар төрсөн сэтгэгдэл, санаа бодлыг илэрхийлэн ярих, бичих ур чадвар эзэмшүүлэхэд чиглэнэ.” “Дунд боловсролын 12 жилийн сургалтын агуулгын судалгаа” (2009. 99 дахь тал) хэмээн тодорхойлсон байна.

Манай улс 2008 оноос дунд боловсролын 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжиж, 2010 оноос бага, дунд боловсролын стандартыг кембрижийн стандартын жишгээр шинэчлэн хэрэгжүүлж эхэлсэн байна. Эдгээр шинэ хэрэгцээг хангах арга нь стандартад суурилсан боловсролын шинэчлэл, чадварт үндэслэгдсэн боловсролын хөтөлбөрийг бий болгох явдал байв. Энэ бүгд нь Монголд боловсролын агуулгадаа зарчмын шинэчлэл хийх хэрэгцээг бий болгов (Бэгз, 2010).

Монголын бага, дунд боловсролын хөтөлбөрийг үндэсний, орон нутгийн, сургуулийн 3 түвшинд мөрдөж, 2008 онд үнэлгээ хийсний дараа кембрижийн стандартад тулгуурлан шинэ стандарт, хөтөлбөр боловсруулж, туршиж, сайжруулсан байна.

Ийнхүү ЕБС-ийн сургалтын хөтөлбөр, стандарт, агуулга, арга зүйг судлах, боловсруулах жишээлбэл, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн зөвлөмжүүдийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Боловсролын яамны захиалга болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгыг ардчилсан нийгмийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэх; олон улсын жишгээр сургалтын 11, 12 жилийн тогтолцоонд шилжих шаардлага; гэсэн шалгуурыг үндэс болгон 1992-1999, 1999-2001, 2001-2006, 2007-2015 он гэсэн 4 үе шатаар хэрэгжүүлсэн гэж үзэж болохоор байна.

Дээр дурдсанчлан Монголын ерөнхий боловсролыг 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх, төлөвшүүлэх ажлын шинжлэх ухааны үндсийг судлан боловсруулах, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, арга зүйн зөвлөмжүүдийг боловсруулан, практикт нэвтэрүүлэх ажлыг Боловсролын хүрээлэнгийн идвэхтэй оролцоотойгоор хэрэгжүүлжээ.

Ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэнтэй холбоотойгоор сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлсэн байдал, тооцооллыг дараах хүснэгтээр харуулж болно. Үүнд:

Хүснэгт 8. Сургалтын хөтөлбөрүүдийн шинэчлэл (2008-2015 оны байдлаар)

<i>Анги</i>	<i>Шинэчлэн боловсруулсан он</i>	<i>Хэрэгжүүлж эхэлсэн хичээлийн жил</i>	<i>Хөтөлбөрийн тоо</i>
1	2008	2008-2009	7
2	2009	2009-2010	6
7			17
3	2010	2010-2011	6

8		2010-2011	18
4	2010	2011-2012	9
9			18
5	2011	2012-2013	10
10			13
6	2012	2013-2014	11
7		2014-2015	17
11		2013-2014	13
12		2014-2015	13
1-3	2011	2011-2012	Иргэний боловсролын 12 хөтөлбөр
4-12	2012	2012-2013	
1-12	2011	2012-2013	Шатар, усан спортын 5 хөтөлбөр
10-12	2012	2012-2013	Орос хэл сонгон суралцах 3 хөтөлбөр
Цэцэрлэг	2011	2011-2012	Бага, дунд, ахлах бэлтгэл ангийн 3 хөтөлбөр
Дүн			182

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл 1999-2014 онд УБ., 2014. 80 дахь тал

Жишээлбэл, 2008-2012 онд ЕБС-ийн сургалтын хөтөлбөр давхардсан тоогоор 182-ыг (Дээрх хүснэгтийг үзнэ үү) сайжруулсан болон шинээр боловсруулсан бөгөөд эдгээр хөтөлбөрийг ЕБС, их дээд сургуулийн багш нар, эрдэмтдийн төлөөлөл бүхий багаар судлан боловсруулсан байна. Тухайлбал, БШУ-ны сайдын “Бага, дунд боловсролын шинэчлэлийн зураглал, багийн бүрэлдэхүүн батлах тухай” 2013 оны 5 дугаар сарын 08- ны өдрийн А/155 дугаар тушаалаар Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зургаглал, Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлалыг баталсан. Мөн “Бага, дунд боловсролын үндэсний стандарт, хөтөлбөр шинэчлэх, боловсролын үнэлгээ, багшийн мэргэжил дээшлүүлэх, сурах бичиг, сургалтын орчин, боловсролын байгууллагын чадавхийг бэхжүүлэх асуудлаар үзэл баримтлал, бодлого, чиглэл боловсруулах үндсэн баг”-ийн бүрэлдэхүүн (120 хүн), багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөр шинэчлэх багийн ахлагчдын бүрэлдэхүүн (23 хүн)-ийг баталгаажуулан ажилласан байна. Багуудын гүйцэтгэх ажлын даалгавар, стандарт, хөтөлбөр, холбогдох баримт бичигт тавигдах шаардлагыг тодорхойлж, бага, дунд боловсролын шинэчлэл, үйл ажиллагааны хэрэгжилтийг мэргэжил, арга зүйн удирдлагаар Боловсролын хүрээлэн хангаж, хэрэгжилтэд хяналт- шинжилгээ, үнэлгээ хийж, стандарт, хөтөлбөр, холбогдох, баримт бичгийг шаардлагын дагуу хүлээж авах ажлыг Менежментийн баг хариуцан ажиллажээ. Сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах баг 2013 онд бага боловсролын 1-5 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг шинэчилж лаборатори сургуулиудад

туршсны дараа 2014-2015 оны хичээлийн жилд үндэсний хэмжээнд мөрджээ. Бага боловсролын 1-5 дугаар ангийн сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын лаборатори (40) сургуулиудад хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх бага боловсролын сургалтын шинэ технологи, арга зүйг турших баг туршин ажилласан байна.

Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн шинээр боловсруулсан сургалтын хөтөлбөрийг ерөнхий боловсролын олон улсын сургалтын хөтөлбөртэй харьцуулсан судалгааны үр дүнд манай улсын сургалтын агуулгын академик түвшин өндөр биш байгааг тодорхойлсон байна. Ялангуяа, байгалийн ухааны сургалтын агуулга тухайн шинжлэх ухааны онол, мэдлэгээс 50-100 жилээр хоцорчээ. Жишээлбэл, дунд ангийн математикийн агуулга ойролцоогоор 5%, бага ангийн математикийн агуулга 14%, биологийн агуулга 27%, химийн агуулга 3%, физикийн агуулга 10%, бага ангийн байгалийн шинжлэлийн агуулга 44%-ийн агуулгын түвшний хоцрогдолтой байгааг илрүүлжээ. Хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 9. Монголын ерөнхий боловсролын байгалын ухааны сургалтын агуулгын түвшинг олон улсынхтай харьцуулсан нь

№	Сургалтын хөтөлбөр	Агуулгын давхцал, хувиар	Агуулгын зөрүү, хувиар
1	Математик /дунд/	89	5
2	Математик /бага/	81	14
3	Физик	80	10
4	Хими	83	3
5	Биологи	56	27
6	Байгаль шинжлэл /бага/	57	44

Эх сурвалж: Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл 1999-2014 онд УБ., 2014. 185 дахь тал

Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийг 2016-2017 оны хичээлийн жилд 1-12 дугаар ангид бүрэн хэрэгжүүлсэн байна. Сургалтын шинэчилсэн хөтөлбөрийн хэрэгжилтэд 2017-2018 оны хичээлийн жилд үндэсний түвшний дотоодын үнэлгээ хийхээр төлөвлөсөн байна.

Өмнө дурдсанчлан 1998 оноос боловсруулж хэрэгжүүлсэн боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрүүд нь олон улсын чиг хандлагад баримжаалсан давуу талтай байсныг тэмдэглэе. Үүнийг дараах хэсэгчилсэн шинжилгээгээр тодруулан харуулж болно (Хүснэгт 10).

Хүснэгт 10. 1998-2016 онд хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдийн бүтэц, агуулгын хэсэгчилсэн тойм шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр)

	Зорилго, зорилт	Агуулга, бүтэц	Арга зүй, хэрэглэгдэхүүн	Үнэлгээ	Сургалтын хөтөлбөрийн онцлог
Боловсролын стандартын тогтолцоо: бага, дунд боловсрол. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв, (1998 он)	Суурь боловсролын стандарт нь төр, иргэд, олон нийтийн хүн амд үзүүлэх суурь боловсролын үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах, суралцагчдын хөгжлийн наад захын төвшинг тодорхойлсон нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэхээр сонирхогч талууд харилцан тохиролцож, сургалт хүмүүжлийн чанарт тавигдах шаардлага, шалгуур хэмжүүрийг тодорхойлсон норматив баримт бичиг юм. (1998 оны стандартын 2 дахь тал) Судлагдахуун тус бүрийн зорилтуудыг чадвар байдлаар гаргасан.	Суурь боловсролын түвшинд суралцагчдын хүрэх наад захын мэдлэг, чадварын тогтолцоо, хүрээг тодорхойлсон. Судлагдахуун бүрийн агуулгын түвшин, зорилт, цөм хөтөлбөрийг анги бүрээр тодорхойлсон.	Арга зүйн хувьд тодорхой шийдэл хийгээгүй байна. Харин байгалийн ухааны чиглэлийн судлагдахуунуудын дадлага ажлын чиглэлийг гаргасан байна.	Үнэлгээ тодорхой бус байна.	Энэхүү стандарт нь судлагдахуунд суурилж, сурагчдад мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна. Эл стандарт нь бага, дунд боловсролын агуулгыг анх удаа стандартчилж өгсөн онцлогтой байна.
Монгол улсын стандарт MNS5420-14:2004	Бага, дунд боловсролын стандартуудын зорилго нь: Суралцагчдыг хариуцлагатай, бодит чадвартай, бүтээлч иргэд болон хөгжихөд нь шаардагдах цогц чадамжийг төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний кирриколимыг	Судлагдахуун бүрийн агуулгыг айд тулгуурлан стандартчилсан.	Арга зүйн хөгжлийн үндсийн зарчим нь: -Боломжийг тэнцүү олгох -Судлах агуулгыг сонгох зарчим -Багшлахуйн зарчим -Суралцахуйн зарчим -Технолгийн зарчим -Үнэлгээний зарчим	Суралцагчдад хөгжих цогц чадамжийг танин мэдэхүйн түвшний шалгуураар үнэлнэ. Суралцагчдын цогц чадамжийг үнэлэх шалгуур болон	Агуулгын стандартаас боловсролын стандартад шилжих алхам хийсэн. Тухайн стандарт нь (2004) цогц чадамжид суурилсан, тухайн боловсролын хэрэгцээ, агуулга, үнэлгээ, арга зүйн хөгжлийн үндэс

	боловсролын стандартад нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэх ажлын чанарыг хэмжин үнэлж хөгжилд хөтлөхөд оршино.			жишиг даалгавруудыг тодорхойлж өгсөн онцлогтой.	зэрэг бүтэцтэйгээрээ шинэлэг юм.
Боловсролын хүрээлэн. ЕБ-ын 11 жилийн сургуульд 2006-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ. УБ. (2006 он)	Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ нь боловсролын стандартыг хэрэгжүүлэх зорилго бүхий үндэсний сургалтын хөтөлбөр (киррикулим)-тэй болох хүртэлх хугацаанд хэрэглэх баримт бичиг.	Анги бүрийн судлагдахуунуудын агуулгын (юунд сурахыг) үлгэрчилсэн хүрээг гаргасан.	Тодорхой бус байна. Харин зөвлөмжид ямар нэг байдлаар тусгаж өгчээ.	Тодорхой бус байна. Харин зөвлөмжид ямар нэг байдлаар тусгаж өгчээ.	Судлагдахуунуудын агуулгын хүрээг анги бүрээр гаргасан.
БСШУЯ. Ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж. УБ. (2008-2012 он)	Судлагдахуун бүрийн хүлээгдэж буй ерөнхий үр дүн (хүлээгдэж буй тодорхой үр дүн) буюу зорилтыг тодорхойлсон. Үндэсний сургалтын хөтөлбөрүүдийн хүлээгдэж буй ерөнхий үр дүнг мэдлэг, ойлголт, чадвар, хэрэглээ болгоход чиглэсэн зорилтуудыг тодорхойлсон.	Агуулга, бүтэц: - Мэдлэг - Чадвар - Хэрэглээ/Хандлага - Үнэлгээ	Аргазүй нь өөр өөрийн шийдэлтэй. Агуулгыг хэрэгжүүлэх онцлогийг тайлбарлах байдлаар аргазүйн шийдэл хийгдсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан түгээсэн.	Хүлээгдэж буй үр дүн биелэгдэж буй эсэхийг шалгах, үнэлэх байдлаар үнэлгээг авч үзсэн. Эзэмшсэн мэдлэг, чадвар, хэрэглээг түвшинчлэн үнэлэхийг зорьсон.	Үндэсний хөтөлбөр нь хүлээгдэж буй ерөнхий үр дүнгүүдийг тодорхой болгосон ба тухайн боловсролоор эзэмших мэдлэг, чадвар, хэрэглээ/хандлагыг тодорхойлсон онцлогтой.
Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ, 2014, 2015, 2016	... сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний	Бүтэц:	Бүтэц:	Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ - Үнэлгээний зорилго, зорилт	Цөм хөтөлбөрт суралцагчдын хүрэх зорилго, зорилтыг нэгдмэл байдлаар тодорхойлох оролдлого хийж,

<p>(Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, гарын авлага, УБ. 2015, 18-22 дахь тал)</p>	<p>хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн болон төлөвших боломж олгоход оршино. Зорилт: - Сурах хүсэл сонирхолтой, сурах үйлээ удирдан өөрийн удирдлагатай суралцдаг бүтээлч хариуцлагатай иргэн болох - Үндэсний хэл, соёл, түүх, уламжлалаа хүндэтгэн, өвлөн хэрэгжүүлдэг, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэн эрхэмлэдэг, хүн, байгаль, нийгэмтэй зүй зохистой харилцдаг иргэн болох - Бүтээлчээр сурах арга барилтай, насан туршдаа суралцах чадвартай иргэн болох - Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг эзэмшин, амьдрал үйлдээ хэрэглэх чадвартай иргэн болох</p>	<ul style="list-style-type: none"> • Нийтлэг үндэслэл • Цөм хөтөлбөрийн зарчим • Цөм хөтөлбөрийн зорилго, зорилт • Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт • Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ 	<ul style="list-style-type: none"> • Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргазүй орчин • Цөм хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөлт 	<ul style="list-style-type: none"> - Үнэлгээний зарчим - Үнэлгээний төрөл, хэлбэр - Үнэлгээний шалгуур - Үнэлгээний арга хэрэгсэл - Сургуулийн менежмент ба үнэлгээний үйл явц 	<p>сурах арга барил, шинжлэн судлах аргыг тодорхой тусгасан шинэлэг талтай бөгөөд үнэлгээний зорилт, үнэлгээний шалгуурыг цогцоор тодорхой болгосон зэрэг онцлогтой байна.</p>
---	--	--	--	---	--

Дээрх хэсэгчилсэн шинжилгээгээр илэрсэн дутагдал:

- Сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд өөрчилж, шинэчилсэн.
- Судлагдахууны агуулгыг мэдлэг, чадвар, хэрэглээний хүрээнд эзэмших суралцахуйн зорилтын тоо олон.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга хэт их буй нь багш төвт философи голлон баримталж байсантай холбоотой.
- 1990 оноос хойш хэрэглэсэн сургалтын хөтөлбөр нь сурагч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхэд анхаарсан ч сургалтын хөтөлбөрийг сайжруулах, боловсруулах, үнэлэх дүгнэх орчилт үе шатыг тогтоогоогүй. Үүнд хөгжингүй улс орнууд сургалтын хөтөлбөрөө сайжруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, шинэчлэх хугацаа дунджаар 10 жил байгааг харгалзах.
- Сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд боловсруулж байгаа нь сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг чанартай боловсруулахад сөрөг нөлөө үзүүлж буй зэрэг болно.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн хөгжлийн шинжилгээ

Одоо сургалтын хөтөлбөрийн дидактик (сургалтын онол, аргазүй) шинжилгээнээс товч тодруулъя.

Сургалтын хөтөлбөрийн дидактик асуудал нь сургалт (сурах, сургах үйл явц)-ыг бүрдүүлдэг олон элементийг задлан шинжилж, тайлбарладгаараа боловсрол судлаачид, багш, сурган хүмүүжүүлэгчдийн анхаарлыг ихээхэн татсан, боловсрол судлалын шинжлэх ухаанд харьцангуй шинэ, бас эрчимтэй хөгжиж байгаа судалгааны чухал талбар билээ.

Манай улсад сургалтын хөтөлбөр (киррикулим) гэдэг ойлголтыг олон янзаар тодорхойлж, ойлгож, хэрэглэж байна. Тухайлбал:

- Сургалтын хөтөлбөр нь тодорхой төрлийн судлагдахууны (хичээлийн) сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, заах, үнэлэх дүгнэх үндэс болдог
- Нийгэм ба суралцагчдын хэрэгцээ, тэдгээрийн талаарх үзэл, хандлага, баримтлал; зорилго зорилт; агуулга буюу судлагдахуун; явуулах арга зам /арга зүй, сурах орчин, үнэлгээ гэсэн 5 бүрэлдэхүүн хэсэг бүхий систем мөн [Лувсандорж, 2004]
- Сургалтын хөтөлбөрийн бүтэц: хамрах хүрээ – үндэслэл – зарчим - зорилго, зорилтууд – агуулга - арга зүй – үнэлгээ – хөтөлбөрийн шалгуур

- Тухайн сургалтаар олгох өөр хоорондоо уялдаатай мэдлэг, чадвар, тогтсон хандлагын талаар урьдчилан тогтож, түүнийг хэрхэн олгох, суралцагчдыг хэрхэн үнэлж дүгнэхийг урьдчилан төлөвлөсөн баримт бичиг, багш болон суралцагчийн сургалтын үйл ажиллагааны удирдамж юм. [Пүрэв, 2013]
- Олон улсын түвшинд “Сургалтын явц дахь үзэгдлүүдийн хоорондоо нягт дотоод уялдаа холбоотой болохын тодорхойлолт, баталгаануудын (тухайн үзэгдлийг тайлбарлан төрөлжүүлсэн, системчилсэн бүтцийг бий болгосон) цогц” байдгаараа сургалтын хөтөлбөр бол онол юм [Gail, 1982] гэх зэргээр тодорхойлсон байна.

Түүнчлэн сүүлийн 20-иод жилийн судалгаа, шинжилгээ, мэтгэлцээн болон практик үйл ажиллагааны дүнд сургалтын хөтөлбөр (киррикулим)-ийг “тодорхой бүрэлдэхүүн хэсэг бүхий зорилго-үр дүнд чиглэсэн, хөгжин боловсронгуй болж байх нээлттэй тогтолцоо, бага, дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэх зорилгоор боловсруулсан сургалтын удирдамж баримт бичиг” хэмээн тодорхойлжээ.

Сургалтын хөтөлбөр (киррикулим) нь суралцагчдын хөгжил, төлөвшилд зориулсан хөдлөнги (статик) хийгээд өөрчлөмтгий (динамик) тогтолцоо бүхий өргөн агуулгатай бөгөөд жишээ нь, тодорхой төрлийн судлагдахууны (хичээлийн) сургалтыг төлөвлөх, зохион байгуулах, үнэлэх, дүгнэх удирдамж болдог ба мөн сургалтын төлөвлөгөөгөөр тогтоосон хугацаанд, санхүүгийн болон хүний нөөцийн тусламжтайгаар хэрэгждэг онцлогтой байна.

Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрхэн хөгжүүлж, хэрэгжүүлж байгааг Их Британий Боловсрол Судлалын Үндэсний Нийгэмлэгийн дэргэдэх Олон Улсын Мэдээллийн Төв хэмээх олон улсын судалгааны байгууллага судалж, үр дүнг нь жил бүр өөрсдийн эрхлэн гаргадаг Олон улсын хөтөлбөр ба түүний бүтэцчилсэн хүрээ INCA цахим архивт хадгалдаг аж. Энэ архивт хадгалагдсан Америк, Ази, Европ, Австрали тивийг хамарсан дэлхийн 20 улс дараах үнэт зүйлсийг боловсролын болон сургалтын хөтөлбөрийн агуулга, бүтцүүдэд тусгасан байна.

Үүнд:

- Хувь хүний хөгжил, хувь чанар, нийгэмшихүй
- Тэгш боломж, соёлын ялгаа
- Сурагчдыг амьдрал, ажилд бэлтгэх суурь мэдлэг, чадвар, ойлголт
- Бичиг үсгийн боловсрол, гадаад хэл

- Математикийн суурь чадвар
- Шинжлэх ухаан, технологийн чадвар
- Иргэний боловсрол, ардчилал, соёл
- Эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, эцэг эхийн оролцоо
- Сурлагын амжилт
- Сэтгэхүйн хөгжил
- Үндэсний эдийн засгийн бүтээмж
- Бүтээлч сэтгэхүй, насан туршид суралцахуй зэрэг болно.

Эдгээр улсуудын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд шинэ зууны суралцагчийн дүр төрхийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх
- Насан туршдаа суралцан хөгжих
- Мэдээллийг оновчтой сонгон хэрэглэх
- Асуудалд хариуцлагатай хандаж, оновчтой шийдвэр гаргах зэрэг болно.

Гадаадын 20 улсад дараах 22 зорилгыг нийтлэг байдлаар тодорхойлсон байгааг [Sharon O' Donnell, 2008] өөрийн улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилготой харьцуулж үзвэл (Хүснэгт 11):

Хүснэгт 11. Зарим улс орнуудын ба Монголын сургалтын хөтөлбөрийн зорилгын харьцуулалт

Улс орнуудын боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго	Монгол улсын бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилт
<ul style="list-style-type: none"> - Хувь хүний хөгжил - Үнэт зүйл, ёс зүй - Дотоод ертөнцийн хөгжил, мэдрэмж, шашин - Нийгмийн хөгжил - Хувь хүний шинж чанарууд (төлөвшил) - Тэгш боломж /олон соёлын - Үндэсний эдийн засаг - Ажил /албан тушаал/ амьдралд бэлтгэх - Үндсэн ур чадвар – Литерац, бичиг үгсийн болон тоон чадвар - Шинжлэх ухаан/ технологийн ур чадвар - Ирээдүйн боловсролын суурь мэдлэг/ур чадвар/ ойлголт - Иргэншил/нийгэмлэг/,ардчилал - Соёлынөв уламжлал - Бүтээлч байдал - Гадаад хэлний ур чадвар - Хүрээлэн буй орчин/ тогвортой хөгжил - Эрүүл мэнд - Насан туршийн боловсрол - Эцэг эхийн оролцоо - Суралцахуйн тусгай хэрэгцээг хангах (бэрхшээлтэй болон авьяастай сурагч) г.м. 	<ul style="list-style-type: none"> - Хувь хүний төлөвшилтэй байх - Ёс зүйн хэм хэмжээг баримтлах - Эрүүл аж төрөх дадал хэвшилд суралцах - Сурах арга барилтай болох - Амьдрах ухаанд суралцах - Шинжлэх ухаанч хандлагатай болох - Мэдлэг, чадвартай болох - Бие даах чадвар эзэмших - Бүтээлчээр суралцах чадвартай болох - Үндэсний түүх, соёл, уламжлалаа дээдлэх - Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг эрхэмлэх - Хариуцлагатай иргэн болох - Өөрийн удирдлагатай суралцах - Хүн, байгаль, нийгэмтэй зохистой харилцах - Насан туршдаа суралцах - Ардчиллыг дээдлэх - Мэдлэг, чадвараа ахуй амьдралдаа хэрэглэх - Үнэт зүйлийг дээдлэх - Шийдвэр гаргах - Суралцах чадвартай байх - Эзэмших мэргэжлийн суурь чадамжтай болох

Судалгаанд оролцсон ихэнх улсуудын 2000-2008 онд ЕБ-ын хүрээнд хийсэн шинэчлэл нь боловсролын түвшин бүрийн хүлээгдэж буй үр дүнг бодитой, хүрэхүйцээр тодорхойлох, судлагдахууны хүрээг хичээлээр хязгаарлахгүй онол, дадлагыг хослуулах, тогтвортой хөгжлийн бодлого, хүүхдийн эрх, жендэрийн тэгш байдал, мөн нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг сургалтын хөтөлбөрт түлхүү оруулахад чиглэсэн байна. Эдгээр улсуудаас Франц, Герман, Шинэ Зеланд зэрэг улсуудад хөтөлбөрийн шинэчлэл хийх болсон шалтгаан, үндэслэл нь Олон улсын үнэлгээний байгууллагын дүн мэдээтэй холбоо хамааралтай байв.

Даяаршил, бүс нутагшил хийгээд мэдээллийн технологийн зуун дахь хөгжлийн хувьсал, өөрчлөлтүүд нь хувь хүний амьдралын чанарт шинэ шаардлага дэвшүүлж, өөрөөр хэлбэл, хувь хүн өөрийн амьдралын болон нийгмийн байр сууриа өндөржүүлэхийн тулд өөрийгөө удирдах, аж төрөх чадвартай байх, бие хүн болж төлөвшихөд нь сургалтын хөтөлбөрийн чиг үүрэг, зориулалт, агуулга, бүтэц, хэрэгжилт, үнэлгээг нэн тодорхой болгох шаардлага тулгарч байна. Хувь хүн нийгмийн амьдралын аливаа өөрчлөлтийг угтан харах, өөрчлөлтөд бэлэн байх, тогтвортой хөгжиж, төлөвших чадвар нь сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн үр дүнд биелэлээ олж байх зүй тогтолтой.

2016 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд аймаг, нийслэлийн лаборатори ба лаборатори бус (лаб., лаб. бус) 37 сургуулийн 3 ба 7 дугаар ангийн 807 багшаас мэдээлэл цуглуулсан судалгааны үр дүнд шинжилгээ хийсэн (Хүснэгт 12).

Хүснэгт 12. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн эмпирик судалгааны үр дүнгээс

Хөтөлбөрийн бүтэц (Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ, 2014, 2015 он)	Судалгааны үр дүн
Зорилго	Нийт багш нарын 90% нь “цөм хөтөлбөр нь олон шинэлэг санаа агуулсан” гэдэгтэй санал нэгдсэн. 4 багш тутмын 3 нь “цөм хөтөлбөрийн судлагдахууны зорилго, зорилтуудыг ойлгодог” гэжээ. Суралцахуйн зорилт ба цөм хөтөлбөрийн зорилгын уялдаа холбоог ойлгомжтой гэж (лаб. 42%, лаб. бус 30%) үзэж байна.
Хэрэгжилт	Нийт судалгаанд оролцсон багш нарын 70 гаруй хувь нь цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зарчмыг ойлгодог гэсэн боловч цөм хөтөлбөрийг ойлгож, хэрэгжүүлэхэд хялбар эсэхэд хоёрдмол байр суурьтай байна. Гэвч, лаб. сургуулийн багш нарын 78-иас дээш хувь, лаб. бус сургуулийн багш нарын 2/3 нь “цөм хөтөлбөр хэрэгжсэнээр сурагчдын идэвх сайжирч байна” гэж үзжээ.
Агуулга	Судалгаанд оролцсон багш нарын (лаб. 37%, лаб. бус 28%) “цөм хөтөлбөр агуулга ихтэй тул бүгдийг нь заахад цаг хүрэлцдэггүй” гэж үзсэн. Цөм хөтөлбөр нь “хэт олон чадвар олгох зорилготой

	тул шинэ мэдлэг олгох цаг бага” гэдэгтэй багш нар (лаб. 36%, лаб. бус 26%) санал нийлжээ.
Аргазүй	Лаб. болон лаб. бус сургуулийн 80.7% нь “ялгаатай түвшний сурагчдад ялгаатай үйл ажиллагаа, даалгавар төлөвлөх нь маш чухал” гэсэн ч 51.4% нь “ялгаатай түвшний сурагчдад ялгаатай үйл ажиллагаа, даалгавар төлөвлөх амаргүй байдаг” гэжээ. Мөн, 65% нь “ялгаатай түвшний сурагчдад ажиллахад хичээлийн цаг хүрэлцэхгүй” гэж үзсэн бол 45% нь “ялгаатай түвшний мэдлэг, чадвар бүхий сурагчдад зориулж ялгаатай түвшний үнэлгээний зорилт, шалгуур боловсруулахад хүндрэлтэй байдаг” гэжээ.
Үнэлгээ	Нийт багш нарын 72% нь “сурагчдын хөгжил, төлөвшлийг дэмжих, түүнийг үнэлэх ажлыг тогтмол хийдэг” гэсэн байхад 64% нь “хичээлээр сурагчдын хөгжил, төлөвшлийг үнэлж чаддаг” гэжээ. 69% нь “сурагчдын хөгжил, төлөвшлийг үнэн зөв үнэлэхэд цаг их ордог” гэсэн. 32% нь “сурагчдын хандлагын үнэлгээний шалгуур хэт ерөнхий тул үнэлэхэд хүндрэлтэй байдаг” гэж үзсэн бол багш нарын тал хувь ялгаатай байдал гэдгийг ихэвчлэн сурлагын амжилтаар тодорхойлжээ. Мөн 21% нь “надад сурагчдыг хөгжил, төлөвшилд сургах, үнэлэх туршлага дутаж байна” гэсэн бол 36% нь “хангалттай туршлагатай” гэж өөрсдийгөө үзжээ. Үнэлгээний зорилт, шалгуурт үндэслэн хичээлийг төлөвлөх боломжийн талаар асуухад багш нарын 53% нь “цөм хөтөлбөрийн үнэлгээний зорилтоос хичээлийн үнэлгээний шалгуурыг гаргах боломжтой” гэжээ. 5 багшийн 1 буюу 20% нь “суралцахуйн зорилтын үнэлгээний шалгуур хангалттай SMART биш” гэжээ. Багш нар нь эцсийн үнэлгээг зөв сонгож, ашиглах тал дээр санал хуваагдсан. ¼ нь “үнэлгээний хэрэгслийг оновчтой сонгон ашиглах амаргүй байдаг” гэсэн бол багш нар эцсийн үнэлгээний тестийг боловсруулах чадавхын талаар 24% нь “суралцахуйн зорилт (хөтөлбөрийн зорилгод) үндэслэн эцсийн үнэлгээний даалгавар боловсруулах нь хүндрэлтэй байдаг” гэв. Хөндлөнгийн үнэлгээний талаар 40% нь “Боловсролын үнэлгээний төвийн хөндлөнгийн шалгалтууд суралцах чадварыг үнэлдэггүй” гэсэн бол “сургууль, дүүргийн БГ-ын хөндлөнгийн үнэлгээгээр хийж буй даалгаврууд нь цөм хөтөлбөрт нийцүүлэн өөрчлөгдөөгүй хэвээр байгаа” хэмээн 34% нь үзэв. Нийт багш нарын 32% нь “сурагчдын чадварыг багшийн ажиглалтаар үнэлэхэд хүндрэлтэй байдаг” гэсэн бол 30% нь “чадварт суурилсан жишиг даалгаврууд боловсруулахад хүндрэлтэй” гэв. Сурагчдын өөрийн үнэлгээ талаар лаб. сургуулийн 10 багш тутмын 5, лаб. бус сургуулийн 3 багш тутмын 1 нь “сурагчдын өөрийн үнэлгээ найдвартай гэхэд эргэлздэг” байна. Гэвч багш нар (лаб. 91% ба лаб. бус 86%) “сурагчдыг зөв үнэлэхэд сурагчид илүү идэвх сонирхолтой, хариуцлагатай болдог” гэдэгтэй санал нийлжээ.

Дээрх эмпирик судалгаагаар илэрсэн сул талууд:

- *Аргазүйн хувьд:* Суралцах олон талын хэрэгцээг хангах болон сурагч нэг бүрийн сурах чадварт тохирсон үйл ажиллагаа зохион байгуулахын ач холбогдлыг өндөр үнэлж байгаа ч, эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах нь бэрхшээлтэй байгаа юм байна.
- *Үнэлгээний хувьд:* Сурлагын амжилтын үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үнэлгээний тохирох арга хэрэгслийг сонгох, төлөвлөх, явцын болон сурагчийн өөрийн үнэлгээний талаар багш нарын ойлголт дутмаг, нэгдмэл бус байна.

- Багш нарт мэргэжил дээшлүүлэх сургалт хэрэгцээтэй байна.

Боловсролын хүрээлэнгийн 2016 оны 10 дугаар сард ЕБС-ийн 10 дугаар анги бүхий 367 сургуулиас авсан судалгааны үр дүнгээс харахад, бүрэн дунд болосвролын сургалтын цөм хөтөлбөрийн заавал судлах, заавал сонгох, сонгон гүнзгийрүүлэх хичээлүүдээр сурагчид сонголт хийж байгаа нь онцлог байв. Хичээл сонголт хийлгэх, сургуулийн мэдлийн цагийг хэрэгжүүлэх, мэргэжлийн багш нар илүүдэх, дутагдах, кредитийн үнэлгээг хэрэгжүүлэх, сурах бичиг хэвлэгдэхгүй байх, боловсролын баримт бичгийн агуулгын зөрүү гарах зэрэг бэрхшээлүүд тулгарч байгаа ч сургалтын хөтөлбөрийг сонголттой болгоход ахиц гарсан гэж үзэж байна.

2016 оны 4-9 дүгээр сард Дээд боловсролын хөгжлийн асуудлаар Монголын их, дээд сургуулиудын 300 гаруй багш нарыг хамруулан хийсэн зарим судалгааны үр дүнгээс үзвэл, “Дээд боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд гол нь ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатй талаар судалгаанд оролцогчдын өгсөн саналын хувь: Багшийн хандлага, арга барилын өсөлт, хөгжил – 56.3%, Элсэгчдийн суурь түвшин – 55.5%, Орчин үеийн стандарт хангасан сургалтын орчин – 43.8%, Мэргэжлийн хөтөлбөрүүдийн чанар 36.7%, Сургалтыг нийгмийн хэрэгцээтэй уялдуулах – 37.5%, Сургалт – Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн холбоо – 28.9%, Дээд боловсролын бодлого, үйл ажиллагааны шинжлэх ухааны үндэслэл – 19.5%” гэсэн баримтууд илэрсэн байна.

Манай улсын дээд боловсролын салбарт нэн түрүүнд засууштай зүйлийн талаар гарсан саналын тойм: ЕБС-ийн сургалтын чанар мэдэгдэхүйц унаж байгааг анхаарах. Удирдлагыг намаас хараат бус, тогтвортой ажиллуулах, боловсролын бодлого залгамж чанартай байх. Гадаадын сургуулиудын бүтэц, туршлагыг тэр хэвээр нь шууд хуулахгүй, өөрийн улсын нөхцөлд тохируулж буулгах” хэмээн тэмдэглэсэн байна.

Дүгнэлт

- Багш төвтэй сургалт нь боловсролын философийн эссенциализм ба переннеализм чиглэлд суурилдаг байна. Боловсролын энэхүү хоёр философи нь багш “төв”-тэй сургалтын суурь үндэслэгээ болдог бөгөөд тухайн улс орны боловсролын бодлогод үйлчилдэг байна. 1990 оноос өмнөх манай улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрүүд эдгээр философийн хүрээнд хийгдэж байсан нь судалгаанаас харагдав.
- 1990 оноос хойш манайд хийгдэж, хэрэгжиж ирсэн сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, агуулгын бүтцийг шинжлэхэд, философи баримтлал нь прогрессивизм, экзистенциализм, нийгмийн конструктивизм зэрэг чиглэлүүдийн хүрээнд байжээ хэмээн дүгнэж болохоор байна.
- Бид боловсролын философийн суралцагч төвт урсгал, чиглэлийн үнэт зүйлсээс сургалтын хөтөлбөрийн зорилго, агуулга, аргазүй, үнэлгээний хэсэгт тусгах оролдлогыг боломжийн хэрээр хийж байна.
- Сургалтын хөтөлбөрийн тойм судалгаанаас үзвэл, Монголын бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөр нь өөрийн улсын эрдэмтэд, багш нарын судалгаа, туршлага болон гадаадын хөгжингүй улсуудын сургалтын хөтөлбөр судлалын судалгааны зарим ололтод тулгуурлан хөгжиж ирсэн байна.
- Манай улсад сургалтын хөтөлбөр ялангуяа, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн талаар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон эрдэм шинжилгээ, аргазүйн байгууллагаас хөтөлбөр судлалын шинжлэх ухааны үндэстэй судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлтийг залгамж чанартай, тогтвортой хийж чадахгүй байгаа нь бидний судалгаанаас ажиглагдав. Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрүүдийг сургалтын хөтөлбөр судлал (киррикулим)-ын шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэх орчил (цикл)-ыг зайлшгүй тогтоон мөрдөх шаардлагатай байна.
- Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт (2015, 2016 он) тусгасан судлан шинжлэх арга барил болон үнэлгээний зорилт, шалгуур үзүүлэлтийг тасралтгүй, залгамжтайгаар цаашид хөгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг судлах, боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны тодорхой үндэслэлтэй болгохын тулд бидний хөндөж буй хөтөлбөр судлалын шинжлэх ухаанч зарим санаа, загваруудыг бүтээлчээр ашиглаж, хэрэглэж болох юм.

Боловсролын зорилго, агуулга, зохион байгуулалт

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хууль болон холбогдох бодлогын баримт бичгүүдэд тодорхойлсон боловсрол, сургалтын зорилгын уялдаа холбоог дараах байдлаар харьцуулан шинжилж үзэж байна.

Хүснэгт 13. Бодлогын баримт бичгүүд

<i>Баримт бичиг</i>	<i>Заалт</i>
Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого	1. Нийтлэг зүйл. Боловсролын үндсэн зорилго нь хүн бүрийг шинжлэх ухааны мэдлэгийг зохих түвшинд эзэмшсэн, шударга ёс, хуулийг дээдлэн сахидаг, эх оронч, соёлч, хамтач, эрүүл чийрэг, байгаль орчноо хайрлан хамгаалдаг, бие даан суралцах, ажиллаж амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.
Боловсролын тухай хууль	4.1.Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино.
Бага, дунд боловсролын тухай хууль	2.1.Бага, дунд боловсролын зорилго нь суралцагчид ерөнхий боловсрол эзэмшүүлэх, эх оронч үзэл төлөвшүүлэх, хүмүүнлэг ёсонд суралцах, авьяас чадвараа хөгжүүлэх, амьдрал, хөдөлмөрт болон тасралтгүй суралцахад өөрийгөө бэлтгэхэд нь туслахад оршино.
Бага, дунд боловсролын каррикулум болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал	Боловсролын зорилго нь "...иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдарын зохих чадавхитай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, амьдрах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино. ...боловсролын эрхэм зорилго нь боловсролын эрэлтийг "чанартай хангах нийлүүлэлт"-ийг илэрхийлнэ. Мэдэхийн тулд суралцахуйн зорилго нь суралцагч шаардлагатай мэдлэгээ эзэмшсэнээр өөртөө шинэ зүйл нээж танин мэдэхүйн сайхныг амтлах төдийгүй өөрөө шинэ мэдлэг бүтээх ур ухаанаа хөгжүүлэхэд чиглэнэ. Хийж гүйцэтгэхүйн тулд суралцахуйн зорилго нь иргэд ажил хөдөлмөр хийхэд зайлшгүй шаардлагатай чадварыг эзэмшиж, энэ чадвараа нөхцөл байдлын өөрчлөлтөд нийцүүлэн байнга хөгжүүлэх арга ухаанд суралцах, ажлын байрны төлөө шударгаар өрсөлдөх чадвар эзэшихэд оршино. Оршин байхуйн тулд суралцахуйн зорилго нь хүн өөрийгөө тал бүрээр хөгжүүлэх, тухайлбал, бие бялдар, оюун ухаан, сэтгэл хөдлөл, гоо сайхан, ёс суртахууны мэдрэмжээ хөгжүүлэхэд чиглэнэ. Хамтдаа нийгэмшин аж төрөхийн тулд суралцахуйн зорилго нь орчин үеийн хүн төрөлхтний даяаршил, үндэстэн болон шашин хоорондын зөрчил мөргөлдөөнөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг тайван аргаар бүх талын сонирхолыг харгалзан шийдвэрлэж сурах, бусдын эрхийг хүндэтгэх, тэдэнтэй нэг дэлхий, нэг бүс нутаг, нэг нийгэм, нэг хот тосгонд аж төрж сурах чадварыг хүмүүс эзэмшихэд оршино.
Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын зорилго нь суралцагчдын хөгжлийг хангах, бага, суурь, бүрэн дунд боловсролын стандартыг хэрэгжүүлэхэд оршино.

Энэ бүхнийг нэгтгэн үзвэл Монгол улсын ерөнхий боловсролын зорилго нь бүхэлдээ:

- хүн бүрийн сурч боловсрох эрхийг хангах;
- суралцагчдад ерөнхий боловсрол эзэмшүүлэх;

- суралцагчдад үнэт зүйл төлөвшихөд туслах замаар тэдний хөгжлийг хангахад чиглэж байна.

Боловсролын зорилго нь боловсролын чанараар хэмжигдэх бөгөөд энэ нь олон улсын хэмжээнд стандартад суурилсан боловсролын бодлого, үзэл санаа болж байна. Бидний, шинжилгээний хүрээнд авсан бодлогын баримт бичгээс үзэхэд Монгол улс ч энэхүү үзэл санааг дэмжиж, боловсролын стандартыг чухалчилсан нь харагдаж байна.

Эдгээр бодлогын баримт бичгүүдэд тодорхойлсон боловсролын зорилгоос үзэхэд мэдлэг, оюун ухааны хөгжлийг эрхэмлэх, бие даан суралцах, ажиллаж амьдрах, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг байх зэрэг үнэт зүйлсийг эдгээрт чухалчлан үзсэн бол бусад үнэт зүйлсийн хувьд учир дутагдалтай байна.

Хүснэгт 14. Үнэт зүйлсийн жагсаалт

Үнэт зүйл ¹	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого	Боловсролын тухай хууль	Бага, дунд боловсролын тухай хууль	Бага, дунд боловсролын карриколим болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал	Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого
мэдлэг, оюун ухааны хөгжлийг эрхэмлэх	+	+	+	+	+
шударга ёс, хуулийг сахих	+				
эх оронч үзэл	+		+		
соёлч, хамтач, эрүүл чийрэг	+				
байгаль орчноо хайрлан хамгаалах	+				
бие даан суралцах, ажиллаж амьдрах	+	+	+	+	
хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг		+	+	+	
ёс суртахууны зохих чадавхитай		+		+	
бие бялдрын зохих чадавхитай		+		+	
авьяас чадвараа хөгжүүлэх			+		

б) Бага, дунд боловсролын агуулгыг дээр дурдсан хууль, бодлогын баримт бичгүүдээс гадна Үндэсний хөгжлийн цогц бодлого, Боловсрол үндэсний хөтөлбөрт хэрхэн тусгасныг нэгтгэн үзлээ.

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод² бүх шатны боловсролын агуулгын талаар болон боловсролын түвшин бүрийн агуулгын талаар баримтлах бодлогыг тодорхойлсон бол Боловсролын тухай хуульд түүний агуулгыг хэрхэн

¹ Үнэт зүйлсийн жагсаалтыг бодлогын баримт бичгийн эрэмбээр оруулав.

² III. Иргэдийн боловсрол эзэмших эрхийг баталгаажуулах талаар хэсгийн 1. Иргэдийн боловсрол эзэмших эрхийг Үндсэн хуульд заасны дагуу баталгаажуулахад баримтлах чиглэлд

ойлгохыг хуульчилсан байна. Бага, дунд боловсролын стандартад бага, суурь, бүрэн дунд боловсролын агуулгын үндсэн чиглэлийг зорилт хэлбэрээр тодорхойлсон нь багтаамжийн (агуулгын) хувьд Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогод тодорхойлсонтой, бүрэлдэхүүний хувьд Боловсролын хуульд заасан “боловсролын агуулга”-тай тус тус нийцэж байна.

Боловсролын агуулгыг тогтооход сонирхлын бүлгүүдийн эрэлт, хэрэгцээ, санал, бодлыг тусгах тухай төрийн бодлогыг хэрэгжүүлэх арга механизм нь бидний авч үзсэн баримт бичгүүдэд тодорхой харагдахгүй байна. Сургалтын зохион байгуулалт (сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөр, хичээлийн жилийн бүтэц)-тай холбоотой бодлого, зохицуулалтын хүрээнд дараах зарим дүгнэлтийг хийх боломжтой байна.

“Бага, дунд боловсролын киррикулим болон стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал” батлагдсанаас дөрвөн жилийн дараа, Бага дунд боловсролын стандарт хэрэгжиж эхэлсэн 2004 оноос хойш хоёр жилийн дараа үндэсний хэмжээнд “ЕБС-ийн агуулгын үлгэрчилсэн хүрээ”³ баримт бичгийг сургалтын хөтөлбөрийн үүргээр мөрдөж байсан бөгөөд түүнд хичээлүүдийн судлах үндсэн агуулгыг тодорхойлсон нь дээрх үзэл баримтлалтай нийцээгүй байна.

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлогын 6-д тодорхойлсон сургалтын төлөвлөгөө нь 4-т тусгасан сургалтын агуулга, хэлбэрийн хэсэгтэй давхардаж, тухайлсан сургалтын төлөвлөгөөний талаарх бодлогыг илэрхийлж чадаагүй байна. Сургалтын төлөвлөгөөг боловсролын эрдэм шинжилгээ арга зүйн байгууллага боловсруулж, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хянаж батлах зохицуулалтыг Бага, дунд боловсролын тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 7.3-т заасан байна. Мөн хуулийн дөрөвдүгээр бүлгийн 15.2-т зааснаар, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоох хичээлийн жилийн үргэлжлэх дуусах хугацаа болон хичээлийн жилийн бүтэц нь стандарт болон сургалтын төлөвлөгөө өөрчлөгдөөгүй байхад тогтвортой байх нь чухал. Сургалтын төлөвлөгөө нь боловсролын зорилго, сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын агуулгыг тодорхой хугацаанд хэрэгжүүлэх зохион байгуулалт (агуулгыг хэрэгжүүлэх хэлбэр, бүтэц), төлөвлөлтийг (хичээл, үйл ажиллагааны цаг хуваарилалт) ерөнхий боловсролын түвшин болон анги бүрээр харуулсан

³ Боловсролын хүрээлэнгийн захирлын 2006 оны 8 дугаар сарын 16-ны өдрийн 15 дугаар тушаалын гуравдугаар хавсралт

матриц болох талаас нь түүнийг хийхэд баримтлах шаардлага, хамаарлыг тусгах нь илүү оновчтой, бодлогын шинжтэй удирдамж болох боломжтой.

Сурах бичгийн бодлого, тогтолцоо

Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад зориулсан сурах бичгийн талаар Боловсролын тухай (2002) болон Бага, дунд боловсролын тухай хууль (2002)-д тодорхой заалтууд туссан байна. Хуулийн эдгээр заалтуудыг хэрэгжүүлэх зорилгоор “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх журам”-ыг 2006 онд (108 дугаар тушаал), 2007 онд (хоёр удаа, 102, 278 дугаар тушаал) 2008 онд ойр ойрхон өөрчилснөөс үзэхэд 2005-2008 онд хэвлэн нийтлэл төвтэй, хувилбартай сурах бичгийн бодлогыг хэрэгжүүлж байх үед нэлээд тогтворгүй байсан дүр зураг харагдаж байна.

Хүснэгт 15. Сурах бичгийн тогтолцоо

Сурах бичиг: үйл явц	1990 оноос өмнө	1990-2004 он	2005-2009	2009-одоог хүртэл
Эхийг зохиох, түгээх	Яам төвтэй, үндсэн сурах бичигтэй	Яам төвтэй, үндсэн сурах бичигтэй	Хэвлэлийн газар төвтэй, хувилбарт сурах бичигтэй (2005, 2006 онд 3, 2007 онд 2 хувилбартай)	Хосолсон, үндсэн сурах бичигтэй <ul style="list-style-type: none"> Эх зохиох-яам Хэвлэлийн эх бэлтгэх болон хэвлэх, түгээх-Хэвлэлийн газартай хамтран
Сурах бичгийн үнэ	Үнэтэй-худалдан авдаг байсан	Үнэгүй-100% ЗГ санхүүжүүлдэг	<ul style="list-style-type: none"> Үнэтэй Үнэгүй-(30%) <p style="text-align: center;">олгодог</p>	<p>Үнэгүй:</p> <ul style="list-style-type: none"> Бага ангид 100% Дунд, ахлах анги: эмзэг бүлгийн сурагчдад үнэ төлбөргүй 40 орчим % <p>Үнэтэй: Үлдсэн нь</p>
Сурах бичгийн хүртээмж	100% ⁴	Дутагдалтай (номын сангаар дамжуулан хэрэглэдэг) ⁵	<ul style="list-style-type: none"> 2006-2007 онд ННФ, ЛЭОС⁶ болон бие даасан судлаач Д.Нарантуяа⁷ нарын хийсэн судлагаанаас үзэхэд хүртээмжтэй гэж үзэх боломжгүй байна. 	<ul style="list-style-type: none"> Бага ангид харьцангуй хүртээмжтэй. Дунд, ахлах ангид сургуулийн номын сангаар дамжуулж төрөөс олгож буй сурах бичгийг (40%)тэгшитгэн хэрэглэх байдал түгээмэл. Дунд, ахлах ангийн үлдсэн 60%-д хүртээмжийн талаар судалгаа алга байна.

Харин “БДБ-ын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага” (2008), “ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам” (2009)-ыг батлан өнөөг хүртэл мөрдөж, нийтлэг зохицуулалт хийж байна.

⁴ ЕБС-ийн сурах бичгийн тогтолцоо, шинэчлэлийн тухай танилцуулга. БШУЯ. БДБГ. 2007.10.30

⁵ Мөн тэнд

⁶ Нээлттэй нийгэм Форум, Либерал эмэгтэйчүүдийн оюуны сан “Сурах бичиг” төслийн мониторингийн тайлан”. 2006 он

⁷ Д.Нарантуяа “ЕБС-ийн сурах бичгийг үнэ төлбөргүй олгох бодлого-Ядуу болон эмзэг өрхийн хүүхдэд сурах бичиг үнэгүй олгох бодлогын хэрэгжилт”. 2007 он

Хүснэгт 16. Сурах бичгийн бодлогын баримт бичгүүд

<i>Бодлогын баримт бичиг, зүйл, заалт</i>		<i>Бодлогын хэрэгжилт, зохицуулалтын хүрээнд</i>
Боловсролын тухай хууль	цэцэрлэг, бүх шатны сургууль, боловсролын эрдэм шинжилгээ, мэргэжил, арга зүйн байгууллагыг зориулалтын ... хичээлийн хэрэглэгдэхүүн, ном, сурах бичгээр хангах ажлыг холбогдох байгууллагатай хамтран зохион байгуулах (28.1.7)	“БДБ-ын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага”: - Ерөнхий шаардлага - СБ-ийн эх зохиоход тавих шаардлага “ЕБС-ийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”:
Бага, дунд боловсролын тухай хууль	... сурах бичиг нь боловсролын стандарт, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байх сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн ЗГ-ын гишүүний баталсан журмын дагуу зохион байгуулах (8.1, 8.2)	- 6 зүйл, 29 заалттай - Нэг: Нийтлэг зүйл - Хоёр: Сурах бичгийн эх зохиох, бэлтгэх - Гурав: Сурах бичиг хэвлэх, дахин хэвлэх, түгээх - Дөрөв: Сурах бичгийн ашиглалт - Тав: Сурах бичгийн нөхөн хангалт - Зургаа: Бусад зүйл
ЕБС-ийн сургалтын талаар баримтлах бодлого	... сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний агуулга, арга зүйг нээлттэй, хувилбартай, сонголттой болгох зарчмыг баримтлан шинэчлэн хөгжүүлэх	

Бодлогын баримт бичгээс үзэхэд 2009 оноос боловсролын асуудал хариуцсан яам болон хэвлэлийн газруудын хамтын ажиллагаанд түшиглэсэн “үндсэн сурах бичиг” төвтэй сурах бичгийн бодлого өнөөг хүртэл хэрэгжиж байна гэж үзэх боломжтой байна. Сурах бичгийг зохиох багийг сонгох, шалгаруулах үйл явц нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд үндэслэн явагдаж байна.

Сүүлийн жилүүдэд АХБ-ны дэмжлэгтэйгээр сурах бичгийн түрээсийн бодлогыг туршиж үзэж байгаа бөгөөд нэгдсэн тайлан алга байна (эсхүл хэвлэгдээгүй). Мөн 2009 оноос хэрэгжсэн сурах бичгийн бодлогод үнэлгээ, мониторинг хийж давуу, сул талыг илрүүлсэн судалгаа хараахан алга байна. Гэвч Боловсролын хүрээлэнгээс 2009 оноос сурах бичгийн процесст оролцсон туршлага, сургамжаас үзэхэд дараах асуудал тулгарч байсан байна. Үүнд:

- Тавигдаж буй шаардлагад нийцсэн сурах бичиг боловсруулах болон хүний нөөц хангалтгүй (англи хэл, иргэний боловсрол г.м) байна.
- Зохиогчийн багийн сонгон шалгаруулалтын тусгайлсан журам үгүй. “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуульд үндэслэн заавал сонгон шалгаруулалт явуулдаг нь тэр болгон бодит байдалтай нийцэхгүй байна.

- Сурах бичгийг зохиох, боловсруулах хугацаа бага, турших, боловсронгуй болгоход хүрэлцэхүйц хугацаа үгүй байна. Сурах бичгийг зохиохоос эхлээд сурагчийн ширээн дээр хүрэх хүртэлх хугацаа ямар байх талаар бодлого зохицуулалт үгүйлэгдэж байна.
- Тусгай хэрэгцээт, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад зориулсан сурах бичиг болон казах хэлээр сургалт явуулж буй сургуулийн сурагчдад зориулсан эх хэл, монгол хэлний сурах бичгийн асуудал зохицуулалтгүй урсгалаар явж байна.
- Түгээлт, ханган нийлүүлэлтийн тухайд сурах бичиг сурагч бүрд хүрэх асуудал ялангуяа, дунд, ахлах ангийн сурагчдын хувьд хангалттай байж чадахгүй байна.

Сургуулийн өмнөх боловсрол

Сургуулийн өмнөх боловсролын зорилго

Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль (2008) болон Сургуулийн өмнөх боловсролын талаар баримтлах бодлого (2008)-д сургуулийн өмнөх боловсролын зорилгыг тодорхойлсон байна.

<i>Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль</i>	<i>Сургуулийн өмнөх боловсролын талаар баримтлах бодлого</i>
Бага насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих, сургуульд бэлтгэхэд оршино.	Сургуулийн өмнөх боловсролын зорилго нь бага насны хүүхдийг нийгэм, боловсролын орчинд дасган, сургуульд бэлтгэх замаар, тэдний бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг хангахад оршино.

Эдгээр зорилтод хүүхдийн хөгжлийг цогц байдлаар үзсэний зэрэгцээ тэднийг хөгжлүүлэх асуудлыг гэр бүл, нийгмийн зэрэг микро, мезо системд нь авч үзсэн учраас зорилтот бүлэгтээ чиглэсэн, онцлогтой нийцсэн зорилго гэж үзэж байна. Зорилго бүр хүүхдээс ангид бус, хүүхдийг гол цөмөө болгосон байна. Сургуулийн өмнөх боловсролын хуулинд уг хуулийн зорилт, боловсролын зорилго болон СӨБ-ын сургалтын зорилгыг тодорхойлсон боловч сургуулийн өмнөх боловсрол гэж юуг ойлгох тухай тодорхойлоогүй байна. СӨБ нь Боловсролын зорилго, эрхэм зорилгыг хангахуйц иргэн бэлтгэх анхан шатны бэлтгэлийг хангахад үйлчилж байна. Эндээс сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын зорилго нь түвшин бүрийн бодлогын баримт бичигт үндсэндээ нэгэн агуулгатай туссан харагдаж байна.

Сургуулийн өмнөх боловсролын агуулга

Манай улс 1998 оноос өмнө нийт 8 удаа сургалт хүмүүжлийн программ боловсруулан хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжил сургалтын үйл ажиллагаанд мөрдөж байсан байна. 1998 онд Бага, дунд боловсролын агуулгын стандартыг

боловсруулах ажлын хүрээнд “Сургуулийн өмнөх боловсролын агуулгын стандартыг хүүхдийн хөгжлийн зорилт, хүрэх түвшинг нас тус бүрээр тодорхойлон боловсруулж, мөрдөж байжээ. Эл стандарт нь хүүхдийн хөгжлийг цогц байдлаар авч үзэхийн хамтад сургалтын агуулгыг уян хатан, нээлттэй болгож, хэрэгжүүлэх арга, хэрэглэгдэхүүнийг олон хувилбартай болгох зорилтыг агуулснаараа онцлог байсан юм. Энэ стандарт нь “бие бялдар”, “оюун ухаан”, “урлаг уран сайхан ба сэтгэл хөдлөл”, “нийгэмшил”-ийн хөгжил гэсэн 4 үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй.

2003 онд хүний хөгжилд баримжаалан боловсролыг шинэчлэх зорилгоор цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болгон шинэчлэх зорилтын хүрээнд сургуулийн өмнөх боловсролын стандартыг боловсруулан батлуулж 2005-2006 оны хичээлийн жилээс хүүхдийн цэцэрлэгүүдэд мөрдсөн. Энэхүү стандартыг хэрэгжүүлснээр багшид сургалтын үйл ажиллагаагаа төлөвлөх, хөтөлбөрөө боловсруулах, сургалтын арга зүй болон үнэлгээний уян хатан арга барилыг хэрэгжүүлэх, хүүхдийн хөгжлийг дэмжиж ажиллах бололцоог бүрдүүлсэн давуу талтай гэж үзсэн.

Сургуулийн өмнөх боловсролын стандарт нь ай, цогц чадамж, үнэлгээний стандарт, танин мэдэхүйн түвшин, шалгуур, жишиг даалгавар зэрэг олон ухагдахууныг боловсролд оруулж ирсэн. Стандартын агуулга хүүхдийн насны ангиллаар хийгдээгүй нь цэцэрлэгийн бүлэг бүрийн сургалтын агуулгыг боловсруулахад хүндрэл учирдаг.

2010 онд Бага насны хүүхдийн хөгжлийн стандартыг боловсруулан батлуулж одоо хүчин төгөлдөр хэрэгжүүлж байна. 2008 оноос эхлэх Монгол улсын ерөнхий боловсролын сургууль хүүхдийг 6 настайгаас нь сургуульд элсүүлж эхэлсэн, мөн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих бодлого, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд өөрчлөлтийг хийх зайлшгүй шаардлага гарсан байна. Тухайлбал, сургуулийн өмнөх боловсролын стандартын агуулгад тусгах насыг хүүхэд төрснөөс эхлэн сургуульд орох хүртэлх буюу 0-6 хүртэлх нас болгон өөрчлөх, бага насны хүүхэдтэй гэр бүл, эцэг эхийн заавал үзүүлэх туслалцаа дэмжлэг, түүнд тавигдах наад захын шаардлага, зөвлөмжийг олон нийтэд ойлгомжтой, тодорхой боловсруулах, стандартад тусгах, хүүхэд боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээнээс гадна нийгмийн халамж, хоол тэжээлийн үйлчилгээ авах, энэ төрлийн үйлчилгээ эрхэлж буй байгууллагуудын ажлын уялдаа холбоог сайжруулах, сургуулийн өмнөх боловсролын стандартыг шинэчлэн сайжруулах эрэлт хэрэгцээ гарч ирсэн. Бага насны хүүхдийн хөгжлийн стандарт нь сургалтын

хөтөлбөрийн агуулгын хүрээг тодорхойлох, гол чиглэл болно. Мөн энэ стандарт нь хүүхдийн хөгжлийг үнэлэх үнэлгээний хүрээ буюу агуулгыг тодорхойлох, арга, хэрэгслийг сонгоход гол чиглэл, баримжаа болно.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуульд сургуулийн өмнөх боловсролын түвшинд эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, дадлыг цогц байдлаар нарийвчлан тогтоохдоо хүүхдийн хөгжлийн онцлогийг харгалзсан байна. Стандартын агуулгыг тогтоохдоо агуулгын болон насны тохирцын үнэлгээг хийсэн нь онцгой ач холбогдолтой юм.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулинд сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэх үндсэн ба хувилбарт сургалтыг зохион байгуулах талаар тусгасан байдаг. Хувилбарт сургалт нь ээлжийн бүлэг, явуулын, нүүдлийн бүлгийн хэлбэрээр зохион байгуулахыг заасан байдаг. Ээлжийн болон нүүдлийн бүлгийн сургалт нь танхимын хэлбэрээр, явуулын багшийн сургалт нь гэр бүлд түшиглэж явдаг.

Хувилбарт сургалтын бүлэг зохион байгуулалт тухайн хамран сургах тойргийн хүүхдийн тооноос хамаарч насны бүлэг холимог зохион байгуулалт давамгайлж байна. Ээлжийн бүлгийн хамрах нас нь сургуульд орохын өмнөх буй 5 настай хүүхдийг түлхүү хамруулдаг байна. Нүүдлийн бүлэгт холимог насны бүлэг зонхилдог. Мөн улирлын шинжтэй бөгөөд тэдгээрийн үргэлжлэх хугацаа ялгаатай байна. Нүүдлийн бүлэг 1 өдөрт дунджаар 8-10, орон нутагт зарим цэцэрлэг 24 цагаар 2-5 насны хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгож байна.

Хичээл, үйл ажиллагааны нэр, цагийн харьцааг сургуулийн өмнөх боловсролын сургалтын талаар баримтлах бодлогод хичээл, үйл ажиллагааны төлөвлөгөөг тусгасан байдаг. Хувилбарт сургалтыг зохион байгуулж буй байдлаас үзэхэд жилийн доод хэмжээнд хүрэхгүй байх асуудал гарч байна. Мөн багш нар цэцэрлэгийн хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны цагийн харьцааг ойлгож хэрэгжүүлэхэд ихээхэн бэрхшээлтэй тухай дурддаг.

Учир нь хөгжүүлэх үйл ажиллагааг тоглуулах, ажиглалт, энгийн туршилт хийлгэх, нийгэм, байгаль орчинтой харьцах, өөртөө үйлчлэхэд сургах зэрэг хэлбэрээр, хичээлийн бус цагаар зохион байгуулах тухай сайн ойлгоогүйгээс цэцэрлэгийн амьдралд хөгжүүлэх үйл ажиллагааг нэгэн төрлийн хичээлийн үргэлжлэл, “ширээний ард суугаад сургууль шиг хийдэг маш олон тасралтгүй хичээл” мэтээр ойлгож байна. Үүнээс болоод багш нар маш их бичих ажил хийж байна. Хүүхэдтэй ажиллах цаг бага, хүүхэд тасралтгүй хичээл хийх боллоо гэсэн шүүмжлэл гарч,

өөрчлөхийг хүсэж байна. Үнэндээ энэ үйл ажиллагааны гэсэн цагт багш хүүхэдтэй ганцаарчилж болон хэсгээр ажиллах зэрэгт чиглэх цаг юм.

Хүснэгт 17. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын агуулга

<i>Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагаа</i>	<i>Бага</i>	<i>Дунд</i>	<i>Ахлах</i>	<i>Бэлтгэл</i>
Хэл яриа	Цэцэрлэг зохицуулна	36 / 54	48 / 72	60 / 90
Математик		36 / 54	48 / 72	60 / 90
Биеийн тамир		36 / 54	48 / 72	60 / 90
Дүрслэх урлаг		36 / 54	48 / 72	60 / 90
Хөгжим		36 / 54	48 / 72	60 / 90
Харилцаа		36 / 54	48 / 72	60 / 90
Жилийн нийт цаг		540	720	900
Долоо хоногийн дундаж ачаалал		6/9	8/12	10/15
Өдрийн дундаж ачаалал		1.2/1.8	1.6/2.4	2/3

Тайлбар: Хичээл, хөгжүүлэх үйл ажиллагааны сургалтын цаг нь 40:60 харьцаатай байна. Хичээлийн сургалтын цагт хүүхдэд шинэ мэдлэг, чадвар эзэмшүүлэх болон түүнийг бататгах цагийг оруулан тооцсон болно.

Сурах-сургах үйл буюу сургалтын арга зүй

- Багш хүүхдийн хөгжилд тэдний идэвхитэй үйл ажиллагаа чухал гэсэн конструктивизмын онолыг сургалтын хөтөлбөр боловсруулах, суралцахуйн үйлийг дэмжсэн арга зүйдээ баримтлахыг зорьдог. Багш, хүүхдийн хамтын үйл ажиллагаа, хүүхдийн идэвхтэй үйлийг дэмжих замаар мэдлэгийг бүтээнэ. Сургуулийн өмнөх насны хүүхэд тоглох, судлах, турших, хүмүүстэй болон эд юмстай харилцан идэвхтэй үйл хийх замаар суралцдаг.
- Бодит байдал дээр сургалтын үйлийн орчинд багш нарын шууд удирдлага, төлөвлөх, заах арга давамгайлж байна. Багшийн хичээл, үйл ажиллагаанд ажиглалт хийхэд багшийн хичээлийн заах арга нь ихэвчлэн тайлбар яриа, нэрлэсэн асуултанд хариулт авах, биеэр үзүүлэх, заах, тайлбарлах зэрэг үйл ажиллагаа харагдаж байлаа.
- Сургалтын үйлийн орчинг “бүтээлч” байхад их нэмэр болох зүйл бол сонгосон хэрэглэгдэхүүн, түүнийг ашиглан хийх хүүхдийн үйлдэл юм. Хүүхдийн бүтээлч, сонирхолтой байх, асуудлыг шийдвэрлэх, хийх үйлээ төлөвлөх, сонголт хийхэд боломжтой үйлийн орчинг бүрдүүлэхэд дутагдалтай байна. Хувилбарт сургалтын хөтөлбөрийн агуулга, сэдэвт нийцүүлэн сургалтын булангууд өөрчлөгдөн шинэчлэгдэх байдлаар уян хатан байж чадахгүй байна. Энэ нь сургалтын материаллаг байдлын нөөц, боломж, багшийн арга барилаас их хамааралтай байна.

- Хүүхэд төвтэй сургалтын үйлийн орчин нь хүүхдийн чөлөөт байдлыг дээдэлсэн, хүүхдэд өөрөө сурах боломжийг олгодог байхаар зохион байгуулах хэрэгтэй юм. Багш нар нийтээр хичээллэх үйл ажиллагааг зохилон зохион байгуулахад анхаарч байна. Ганцаарчилсан болон хэсгээр зохион байгуулсан хүүхдийн чөлөөтэй, идэвхтэй оролцоо дутагдалтай байна.

Сургуулийн өмнөх боловсролын үнэлгээ

2004 оны Сургуулийн өмнөх боловсролын үнэлгээний стандартад хүүхдийн эзэмших мэдлэг чадвар дадлыг үнэлэхэд шаардлагатай наад захын түвшинчилсэн хэмжээс байхгүйг байсан. Энэ нь цэцэрлэг, багш бүр өөрсдийн үзэмжээр үнэлгээний арга хэрэгсэл, шалгуураа боловсруулж харилцан адилгүй үр дүн танилцуулдаг бөгөөд энэ нь стандарт хэрэгжилтийг үнэлэх нэгдсэн хяналт шинжилгээ хийхэд ихээхэн учир дутагдалтай байсан нь Сургуулийн өмнөх боловсролын стандартад үнэлгээ хийхэд ажиглагдаж байсан.

Сургуулийн өмнөх боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.-д “Хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдал, мэдлэг, чадвар, дадал, хэвшлийг сургалтын явцад болон хичээлийн жилийн эцэст боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ”, 7.2-д “Цэцэрлэгийн үйлчилгээний чанарыг боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталсан журмын дагуу үнэлж, дүгнэнэ” гэсэн үнэлгээтэй холбоотой заалт тус тус байна. Гэхдээ энэ үнэлгээний журмын төслийг боловсруулсан боловсруулалтын түвшинд байгааг хэлэх нь зүйтэй байх. Ерөнхийдөө үнэлгээтэй холбоотой асуудал сургуулийн өмнөх боловсролд маш ерөнхий, тодорхойгүй байна. Одоогийн байдлаар цаас ашиглаж тестийн аргаар, нийт хүүхдийг хамарсан шалгалт мэт үнэлгээг цэцэрлэгийн олон багш нар хийж, “хангалттай, хангалтгүй, нэмэх хасах” гэх мэт тэмдэглэл ашиглан “байдлыг тогтоох”, “явцын”, жилийн эцсийн” гэсэн тоон үнэлгээг хийж байгааг өөрчлөх хэрэгтэй гэж үзэж байна.

Сүүлийн 3 жил Зүүн Ази, Номхон далайн орны туршилтын арга зүйгээр Бага насны хүүхдийн хөгжлийн багц шалгуурын дагуу хүүхдийн хөгжлийг үнэлэх судалгаа, Таван настай хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгааг зэргийг хийсэн. Энэхүү судалгааны ажлууд нь хүүхдийн хөгжлийн түвшинг тогтооход чиглэсэн байсан. Эдгээр аргачлалаар багш бүр хүүхдийн хөгжлийг үнэлэх ажлыг хийх нь бэрхшээлтэй учир нь багшийн ажлын гол чиг үүрэг бол хүүхдийн хөгжлийн түвшинг тогтоохоос илүү хүүхдийн хөгжил хэрхэн ахиж өөрчлөгдөж байгаа илрүүлж түүний үндсэн дээр сургалтын хөтөлбөр, өдөр

тутмын сургалтыг сайн зохион байгуулахад чиглэнэ гэж үзэж байгаатай холбоотой. Энэ үнэлгээг хийх арга нь ажиглалт бөгөөд багш өдөр бүр хүүхдийг тогтсон хуваарийн дагуу ажиглаж тэмдэглэл хөтлөх, хяналтын хуудас бөглөх зэрэг олон аргачлалыг ашиглаж сурах нь хамгийн чухал асуудал болоод байна. Хүүхдийн хөгжлийн түвшинг цэцэрлэг, орон нутгийн хэмжээнд тогтоох нь багшийн тусламжтай хийх ажил бөгөөд энэ тоон үнэлгээгээр сургуульд бэлтгэгдсэн байдал зэргийг тогтоох, харьцуулалт хийхэд ашиглаж болно. Багшийн ангидаа чанарын үнэлгээ байж чадаж байгаа болов? Багшид ямар дэмжлэг хэрэгтэй байгаа тухай судалсан судалгаа дутагдалтай байна.

Сургалтын орчин: сургуулийн өмнөх боловсролын орчны стандартыг боловсруулах, одоо мөрдөж байгаа норм, дүрмийг мөрдөх нь дутагдалтай байна. Тухайлбал цэцэрлэгийн барилга байгууламжтай холбоотой БНМАУ-ын Улсын барилгын хорооны 1988 оны 103 дугаар тогтоолоор батлагдсан “Сургалт хүмүүжлийн байгууллагын барилга байгууламж” барилын норм ба дүрэм БНБД II-66-88-ийн холбогдох заалтыг зөрчиж байна.

Дээд боловсролын хөгжлийн бодлого

Дээд ба мэргэжлийн боловсролын үйл хэргийг төрийн зүгээс нэгдсэн бодлого зохицуулалт, санхүүгийн тогтвортой эх үүсвэрээр хангаж, аж ахуйн нэгж, олон нийт, иргэдийн оролцоог дэмжин, ил тод, нээлттэй, хяналттай байлгах;

Дээд ба мэргэжлийн боловсролын бодлого, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй, нээлттэй, техник, технологийн дэвшилд суурилсан, залгамж холбоотой байх;

Дээд болон мэргэжлийн боловсрол нь хөдөлмөрийн даяарчлагдсан зах зээлд амжилттай өрсөлдөх, бие даан ажлын байр бий болгох, улс үндэстний болон орон нутагт тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхийг бэхжүүлэхэд хувь нэмрээ оруулах чадамж эзэмших үе хэмээн хөгжүүлнэ.

Бүрэн дунд, мэргэжлийн, дээд боловсролын агуулга, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөх тогтолцоог бүрдүүлнэ.

Боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш шаардлага тавьж, хууль тогтоомжийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

Боловсролын байгууллагын хараат бус, бие даасан байдал, дээд болон мэргэжлийн боловсролын байгууллагуудын академик эрх чөлөөг хангана.

Дээд боловсролын байгууллагын судалгааны үйл ажиллагааг дэмжинэ.

Дээд болон мэргэжлийн боловсролын хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлттэй уялдуулна.

Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагаанд өөрийн үнэлгээ, дотоод мониторингийн тогтолцоог хөгжүүлнэ.

Иргэн бүрт насан туршдаа боловсрол эзэмших орчин, нөхцөл боломжийг бүрдүүлэн, нас, бие, сэтгэцийн онцлог, авьяас, хүсэл сонирхолд нийцүүлж мэргэжил, чадвараа дээшлүүлэх сургалтын төрөл, хэлбэрийг дэмжин хөгжүүлнэ.

Боловсролын агуулга, стандарт, сургалтын технологи, хэрэглэгдэхүүн, сургалтын байгууллагын үйлчилгээнд стандарт, шаардлагыг тогтвортой мөрдөж, чанар, үр дүнг тогтмол үнэлж зохицуулалт хийнэ.

Бүх шатны сургалтын хөтөлбөр агуулга, арга зүйд монголын түүх, хэл, соёл, үндэсний өв уламжлал, зан заншил, эх оронч сэтгэлгээ, хувь хүний төлөвшил, хөгжил, хүн төрөлхтөний нийтлэг үнэт зүйлийг тусган хэрэгжүүлнэ.

Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын хөтөлбөрийг хөгжлийн бодлого, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлт, шинжлэх ухаан, технологийн дэвшил, иргэдийн сурах хэрэгцээ, ажлын байранд тавигдах шаардлагатай уялдуулан тасралтгүй хөгжүүлнэ.

Дээд болон мэргэжлийн боловсролын чанарын баталгаажилт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог төгөлдөржүүлэх, олон улсын сургалтын хөтөлбөр, боловсролын зэргийг харилцан хүлээн зөвшөөрөлцөх нөхцөлийг бүрдүүлнэ.

Дээд болон мэргэжлийн боловсролыг олон улсын нийтлэг жишгийг баримжаалан төрөл бүрийн хэв шинжтэйгээр хөгжүүлнэ.

Багш бэлтгэх сургалтын байгууллагын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг сайжруулж, бүх талын дэмжлэг үзүүлнэ.

Багшийн мэргэжлийн ур чадвар, нэр хүнд, ёс зүй, шаардлага, хариуцлагыг өндөржүүлэн, хөдөлмөрийг бодитой үнэлэх тогтолцоог бүрдүүлнэ.

Боловсролын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургаж бэлтгэх, дадлагажуулах, тогтвор суурьшилтай ажиллах нөхцөлийг бүрдүүлнэ.

Бүх шатны боловсролын байгууллагын үйл ажиллагааны санхүүжилт, хөрөнгө оруулалтын хэмжээг үйлчилгээний стандарт, чанар, хүрэх үр дүнтэй уялдуулан тогтооно.

Боловсролын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох, зориулалтын дагуу үр өгөөжтэй ашиглана.

Багш, ажилтан, суралцагчийн хөгжлийг дэмжих, нийгмийн асуудлыг шийдвэрлэх санхүүгийн уян хатан, үр дүнтэй тогтолцоог бүрдүүлнэ.

Сургалтын материаллаг баазыг бэхжүүлэхэд үндэсний үйлдвэрлэл, хөрөнгө оруулагчдыг дэмжинэ.

Бүх шатны сургалтын байгууллагыг хүний нөөцийн хөгжил, хөрөнгө оруулалт, санхүүжилтээр дэмжсэн аж ахуйн нэгж, байгууллага, олон улсын байгууллага, хандивлагч орны зээл, тусламж, иргэдийн бодит дэмжлэгийг хөхиүлэн дэмжинэ.

Олон улс, бүс нутгийн байгууллагын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох, хамтарсан хөтөлбөр, төсөл хэрэгжүүлэх, харилцан мэдээлэл солилцох, боловсролын бодлогыг уялдуулан зохицуулна.

Дэлхийн болон олон улсын боловсролын төрөлжсөн байгууллагад гишүүнээр элсэх, салбар, нэгж байгуулах, конвенцид нэгдэн орохыг дэмжинэ.

Тэргүүлэх чиглэлийн дээд болон мэргэжлийн боловсролын 20-иос доошгүй хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдсэн байна.

Монгол Улсын дөрвөөс доошгүй их сургуулийг Азийн шилдэг 100 их сургуулийн эгнээнд хүргэсэн байна.

Багш нарын мэргэшил дээшлүүлэх үйл явц

1990 оны ардчилсан хувьсгалаар Монголын нийгэм эдийн засгийн хөгжлийн хандлага эрс өөрчлөгдөж, 1992 онд шинэ үндсэн хууль батлагдсан. Нийгмийн энэ шинэ нөхцөл байдалд нийцүүлэн боловсролын тогтолцоо, агуулгыг бүхэлд нь шинэчлэн сайжруулах, шинэчлэх ажил өрнөжээ. 1992 онд Улсын бага хурлаас “БНМАУ-д боловсролын хөгжүүлэх үзэл баримтлал”, “БНМАУ-ын боловсролын хууль”-ийг баталсан нь Монгол Улсын боловсролын зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчмыг шинээр тодорхойлсон байна. 1995 онд Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого батлагдаж, Боловсролын тухайн хууль шинэчлэгдэж, суурь хуулиас гадна Бага, дунд боловсролын тухай хууль, дээд боловсролын тухай хууль гэсэн салбар хуулиудтай болсон. Эдгээр хуульд багш, сурган хүмүүжүүлэгчийн мэргэжил дээшлүүлэх тухай тусгайлсан заалт байхгүй боловч Бага, дунд боловсролын тухай хуулийн 24-р зүйлд “...цэцэрлэг, сургуулийн багшийг багш бэлтгэх их сургууль, коллежоор бэлтгэх, багшийн мэргэжил эзэмшээгүй иргэнийг сурган хүмүүжүүлэх боловсрол эзэмшсэний дараа багшлуулах, багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, багшлах эрх,

мэргэжлийн зэрэг олгох, хасах тухай журмыг Засгийн газар тогтоох” гэсэн заалт шинээр оруулсан байна.

Энэ үед бага, дунд боловсролын агуулга тогтворгүй болж, төсөв, санхүү, материаллаг бааз хүнд байдалд орсон төдийгүй багш нарын нийгмийн байдал доройтож, цөөнгүй багш нар ажлаа орхисон, сургууль завсардалт нэмэгдсэн, шилжилт хөдөлгөөний улмаас зарим сургууль хүүхэд цөөтэй, төв суурин газрын зарим сургуульд хүүхдийн ачаалал хэтэрч байсан юм.

1992-1993 оны хичээлийн жилийн ерөнхий боловсролын сургуулийн байдлын талаар Шинжлэх ухаан, боловсролын сайд Н.Өлзийхутаг “Багшлах боловсон хүчин их дутагдаж байна. Сүүлийн хоёр жилд 1267 багш мэргэжлийн ажлаа орхилоо. Улсын хэмжээнд мэргэжлийн 1600 багш дутагдаж байна. Улаанбаатарт л гэхэд 101 сургуульд 438 багш дутуу. 1992 онд багш мэргэжлээр төгссөн 1471 хүний 25,7 хувь нь томилогдсон газартаа очсонгүй. Цахилгаан дулаан, хоол хүнсний болон бусад шалтгааны улмаас ялангуяа хөдөөгийн сургуулийн байдал их хүндэрлээ. Одоогийн байдлаар есөн сургууль бүр хаагдав. 1991-1993 оны хичээлийн жилд манай орны ерөнхий боловсролын 679 сургуулиас 130 нь урт, богино хугацаагаар хичээллэсэнгүй” гэж сэтгүүлчийн асуултад ...хариулж байжээ [Ш.Шагдар. Монголын боловсролын түүхийн тойм. УБ.,2003. 105-р тал].

1991-2001 онд багшлах арга зүйн онол, арга зүйн үндсийг шинжлэн судлах, арга зүйг шинэчлэх агуулга ба стратегийг тодорхойлох, сургалтын менежментийг шинэчлэх, тэдгээрийн үзэл санаа, арга зүйг нийт багш нарт түгээн дэлгэрүүлж, хэрэгжүүлэх ажил эхэлж, цаашид тогтвортой хөгжих үндэс суурь нь тавигдсан байна.

1991 онд “Төрийн албан хэргийг монгол бичгээр хөтлөн явуулах бэлтгэл хангах тухай” Улсын бага хурлын тогтоол гарсантай холбогдуулан монгол бичгийн багш бэлтгэх нэг сарын сургалт зохион байгуулж, 1991 онд 159, 1992 онд 175 багшийг сургасан байна. Мөн мэргэжил дээшлүүлж байгаа бүх мэргэжлийн сургалтын цагийн тодорхой хувьд монгол бичгийн хичээл зааж байх тушаал гарган хэрэгжүүлжээ. Ерөнхий боловсролын сургуульд англи хэлний хичээл заах болсонтой холбогдуулан орос хэлний багш нарыг англи хэлийн багш болгох зорилгоор нэг жилийн дамжаа хичээллүүлж, 1991 оноос 86, 1992 онд 134, 1993 онд 91 багш бэлтгэсэн бөгөөд тус сургалтад АНУ-ын Англи хэлний институттэй байгуулсан гэрээний дагуу америк багш нар энэ сургалтад хичээл зааж байв. Ийм

сургалт зөвхөн УБИС-аас гадна МУИС, Ховд, Архангай аймгийн багш бэлтгэдэг сургуулиадад болж англи хэлний багш нарыг бэлтгэж байжээ.

“БНМАУ-ын Засгийн газрын 154-р тогтоол гарч, их сургуулиудад сургалт-эрдэм шинжилгээний үйл ажиллагаа эрхлэх чиглэл өгч, дэргэдээ эрдэм шинжилгээний хүрээлэн, төв, туршилт-үйлдвэрлэлийн нэгж байгуулж ажиллуулахыг зөвшөөрсөн байна. Ийм учраас Багш нарын мэргэжил дээшлүүлэх интситутийг УБДС-ийн сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлалын тэнхимүүдтэй нэгтгэн “Мэргэжил дээшлүүлэх институт” болгон зохион байгуулсан. Мэргэжил дээшлүүлэх институт нь хэдийгээр бүтцийн хувьд өөрчлөгдсө ч өмнөх уламжлалын дагуу багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын графикийг жилээр гаргаж, төвлөрсөн сургалтуудаа зохион байгуулж байсан. 1992 онд мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал 8,2 сая төгрөгөөр батлагдаж байжээ. Баримтаас харахад 1991 онд 18 мэргэжлээр 2343, 1992 онд найман мэргэжлээр 860, 1993 онд долоон мэргэжлийн 236 багшийг 21-24 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулж, зардлыг тухайн үед мөрдөж байсан журмын дагуу улсын төсвөөс санхүүжжээ. Харин 1992 онд БМДИ-ийн захирал аймаг, хотын САЗТ-ийн захирлууд, багш нарын хүсэлтийг үндэслэн “Төлбөртэй курс хичээллүүлэх тухай” 31 тоот тушаал гаргаж, улсын хэмжээнд дутагдалтай байсан биеийн тамир, техник хөдөлмөр, бага ангийн багш нарыг 45 хоногийн хугацаатай, 1500 төгрөгийн төлбөртэй курсээр бэлтгэх шийдвэр гаргасан. Энэ нь багшийн мэргэжил эзэмшээгүй боловч ерөнхий боловсролын сургуульд ажиллаж байсан “багш” нарт хамаарсан шийдвэр бөгөөд 1992 онд биеийн тамирын 99, техник хөдөлмөрийн 85 хүнийг 30-45 хоног, 155 хүнийг цэцэрлэгийн багш бэлтгэх гурван сарын төлбөртэй сургалтад хамруулан “багшлах эрх”-тэй болгосон бол бага ангийн 156 багшийг коллежийн дээд боловсролтой болгожээ. Харин 1993 онд биеийн тамирын 172, техник хөдөлмөрийн 157, цэцэрлэгийн 24 багшийг эдгээр сургалтад хамруулж, бага ангийн 74 багшийг коллежийн дээд боловсролтой болгон төгсгөжээ. ЕБС-д гурав ба түүнээс дээш жил багшилсан хүнийг 30 хоног, гурав хүртэл жил багшилсан хүнийг 45 хоногийн сургалтад хамруулж байжээ (Захирлын тушаал, 1992, 1993 он).

Мэргэжил дээшлүүлэх институт нь 1992 оны 9 дүгээр сарын 14-23-ны өдөр “Багш нарын мэргэжил дээшлүүлэх асуудал” олон улсын эрдэм шинжилгээний бага хурал зохион байгуулсан байна. Энэ хуралд Дани, Польш, АНУ болон ОХУ-аас Буриадын Улаан-Үүд, Чита мужийн Багш нарын мэргэжил дээшлүүлэх институтийн удирдлага, аймгуудын Судалгаа арга зүйн төвийн захирлууд

оролцжээ. Мөн онд Засгийн газар хоорондын хамтран ажиллах гэрээний дагуу Дани улсаас 11 хүн ирж оролцсон Монгол-Данийн төслийн хамтарсан семинар ярилцлага болж, “Данида” төслийн талаар хэлэлцэж, дунд сургуулийн бүтэц, агуулгыг боловсронгуй болгох, багш бэлтгэх, мэдргэжил дээшлүүлэх шинэ тогтолцоо бүрдүүлэхэд техникийн дэмжлэг үзүүлэх, аймгуудын Судалгаа арга зүйн төвүүдийг хөгжүүлэх, сурах бичиг, багш нарт зориулсан гарын авлагын хэвлэхэд туслах, мэргэжилтэн солилцох гэсэн таван чиглэлээр хамтран ажиллах тогтжээ.

Шинжлэх ухаан, боловсролын сайдын 1993 оны 3-р сарын 04-ны өдрийн 70-р тушаал гарч, Боловсролын хөгжлийн хүрээлэнгийн агуулгын сектор, сэтгэл судлал, физиологийн хэсгийг төслүүдийн хамт УБИС-ийн бүрэлдэхүүнд шилжүүлсэнтэй холбогдуулан УБИС-ийн захирлын 76 дугаар тушаал гарч, УБИС-ийн мэргэжил дээшлүүлэх салбар, “Багш” төслийн хамтлаг, Боловсролын хөгжлийн хүрээлэнгээс шилжиж ирсэн “Хүүхэд залуучуудын сэтгэц, физиологийн хөгжлийг судлах хамтлаг”, “Дунд сургуулийн сургалтын агуулга, технологийг судлах төслийн хамтлаг”, “Мэргэжлийн боловсролын сургуулийн сургалтын агуулга, технологийг судлах хамтлаг” зэргийг нэгтгэх шийдвэр гаргасан. Үүнийг үндэслэн Сургалтын агуулга, арга зүйн институт (СААЗИ)-ийг шинээр зохион байгуулж, Мэргэжил дээшлүүлэх институтийн арга зүйчид бусад ажилтан, СХУ-ны факультетийн багш, эрдэм шинжилгээний ажилтнууд, Боловсролын хүрээлэнгээс ирсэн эрдэм шинжилгээний ажилтан, туслах ажилтан нарыг 1. Сургалтын, 2. Мэргэжил дээшлүүлэх, 3. Эрдэм шинжилгээний гэсэн гурван салбарт заасан орон тоонд багтаан зохих албан тушаалд ажиллуулах шийдвэр (тушаал №25) гаргасан.

1993 онд өмнөх уламжлалаар дуу хөгжим, уран зохиол, газар зүй, хөдөлмөр техник, түүх нийгмийн тухай мэдлэг, биеийн тамирын 236 багшийг 21-24 хоногийн мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдсан нь мэргэжил дээшлүүлэх төвлөрсөн тогтолцооны сүүлчийнх болжээ. Өөрөөр хэлбэл 1974 оноос эхэлсэн багш нарын мэргэжлийг таван жил тутам дээшлүүлдэг төвлөрсөн тогтолцоо задарсан гэж үзэж болно.

Харин ЕБС-д ажиллаж байсан мэргэжлийн бус “багш нар-”-т мэргэжил олгох төлбөртэй сургалтуудыг үргэлжлүүлэн зохион байгуулж, 1993 онд биеийн тамирын 172, техник хөдөлмөрийн 157, цэцэрлэгийн 24 багшийг 30-45 хоногийн сургалтад хамруулан багшлах эрх олгож, бага ангийн 74 багшийг коллежийн дээд боловсролтой болгон төгсгөжээ. Энэ байдлаар 1994 онд 36 удаагийн сургалтад

1194 багш, 1995 онд 35 удаагийн сургалтад 1369 багшийг тус тус хамруулсан байна.

УИХ-аас 1995 онд төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хууль батлагдсанаар багшийн талаар баримтлах бодлого, багшийн эрх үүрэг, мэргэжлийн ёс зүй, багшлах эрх, мэргэжлийн ур чадварын өсөлт, нийгмийн ахмгаалалттай холбоотой суурь харилцаанууд хуульчлагджээ.

1995 оны 3 дугаар сард СААЗИ-ийн бүтэц, зохион байгуулалт дахин өөрчлөгдөж, Эрдэм шинжилгээ, арга зүй, сургалтын алба, Зайн сургалт, мэдээллийн төвийн албатай болсон. Энэхүү зохион байгуулалттай холбоотойгоор эрдэм шинжилгээний ажилтан, арга зүйч гэсэн ялгааг арилган аль аль ажилд эрх тэгш оролцуулахаар ажил үүргийн хуваарьтай болж, ажлын нормыг шинэчлэн тогтоожээ. 1995 онд тус институтэд эрдэм шинжилгээний ажилтан судлаач 27, хэвлэлийн эх бэлтгэгч хэвлэгч, номын санч зэрэг туслах ажилтан 9, санхүү захиргаа, аж ахуй, үйлчилгээний 11, бүгд 47 хүн ажиллаж байв.

Боловсролын тухай хуулийн (1995) 12.1-д “Ерөнхий боловсролын сургууль нь боловсролын стандартаар тогтоосон бага, суурь, бүрэн дунд боловсрол эзэмшүүлэх сургалтын байгууллага мөн.”, Төрөөс боловсролын талаар баримтлах бодлогын (1995) 3.1.20-д “Бага, дунд, дээд боловсролын стандартыг төрөөс тогтоож, түүнийг өмчийн бүх хэлбэрийн сургалтын байгууллагад нэгэн адил мөрдүүлэх, хэрэгжилтэд нь хяналт тавих, үнэлэх механизмыг бий болгох...” гэж заасан. Бага, дунд боловсролын стандарт ямар байх талаар Дани улсаас хэрэгжүүлсэн Монголын бага, дунд боловсролын хөгжлийг дэмжих Монгол-Данийн ДАНИДА төсөл ихээхэн үүрэг гүйцэтгэсэн. Энэ хугацаанд СААЗИ нь Данида төслийн үзэл санааг багш нарт хүргэх зорилгоор орон нутагт сургалтууд зохион байгуулж, Данийн зөвлөх багш нар 800 гаруй багшид лекц уншсан байна. Монгол Данийн хамтарсан төслийн хүрээнд нийслэл, аймгуудын Боловсролын төвийн захирал, арга зүйч бүгд 251 хүнийг Улаанбаатар хотод төвлөрүүлэн 10 хоногийн сургалт семинарт хамруулж, Увс, Өмнөговь, Дорноговь аймагт зөвлөн туслах группээр ажилласан. Архангай, Дорноговь, Сэлэнгэ аймагт анхан шатны сургууль, байгалийн шинжлэл, математикийн хичээлийн шинэ агуулга, арга зүйн туршилт судалгааны ажил хийгдэж, багш нарт семинар зохион байгуулж байв. Тус төслийн “Стандарт” дэд төслийн сургалт-семинаруудад оролцож байсан Дани улсын Вангийн Их сургуулийн эрдэмтэд, их дээд сургууль, Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн ЭША-арга зүйчдийн оролцоотойгоор судлагдахууны ба гүйцэтгэлийн стандартын талаар ойлголттой болж, 1998 онд ерөнхий

боловсролын бүх хичээлээр анхны судлагдахууны стандарт, зөвлөмжийг боловсруулсан түүхтэй.

1996 онд Шинжлэх ухааны боловсролын сайдын 310 тоот тушаалаар Боловсролын хөгжлийн хүрээлэн, УБИС-ийн Сургалтын агуулга, арга зүйн институтийг нэгтгэн Боловсрол судлалын үндэсний хүрээлэн байгуулагдаж 1997 оны 6-р сар хүртэл бие даасан статустай ажилласан байна.

1996 онд Багш нарын мэргэжил дээшлүүлэх шинэ журам Гэгээрлийн сайд, Сангийн сайдын хамтарсан тушаалаар батлагдсан бөгөөд энэ журмаар багш нарын мэргэжил дээшлүүлэх арга хэмжээний нийт зардал Сангийн яамнаас аймаг, нийслэлийн Боловсрол соёлын төвд шууд олгогдож, харин их дээд сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, сургуулиуд багш нарын мэргэжил дээшлүүлэх төлөвлөгөө, хөтөлбөрөө урьдчилан зарласны үндсэн дээр өөрсдөө зохион байгуулах, багш нарт аль байгууллагын сургалт, семинарт оролцохоо өөрсдөө сонгох боломж олгосон юм.

Багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын зардал нь эрхийн бичгээр баталгаажин хувь хүндээ шууд олгогдох болсон. Мөн багш нарын бие дааж мэргэжлээ дээшлүүлэхэд шаардагдах зарим ном, сэтгүүл, мэдээлэл авах зардлын асуудлыг тодорхой хэмжэээнд шийдвэрлэж байхаар шийджээ. Энэ нь мэргэжил дээшлүүлэх чиг үүрэг зөвхөн хуучин шигээ нэг байгууллагад төвлөрөхөө больж, багш бэлтгэдэг бусад их, дээд сургуулийн оролцоог нэмэгдүүлсэн шийдвэр болсон. Өөрөөр хэлбэл, багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг чанартай сайн зохион байгуулж байж л оршин тогтнох нөхцөл үүссэн гэсэн үг.

Ийм учраас тус институт багш нарын мэргэжил дээшлүүлэх арга хэмжээний агуулга, хэлбэр, зохион байгуулалтыг судалж, хэрэгжүүлэх шинэ хэрэгцээ шаардлага гарсан тул удирдах ажилтан, багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтын график, агуулга, хугацааг хариуцах эзэнтэйгээр төлөвлөн аймаг, нийслэлийн Боловсролын газруудад хүргүүлж, энэ төлөвлөгөөний дагуу зохион байгуулж байсан. Тухайлбал, 1996 онд 7-30 хоногийн хугацаагаар 43 удаагийн сургалт зохион байгуулж, 1726; 1997 онд 32 удаагийн сургалтад 1500 хүнийг хамарсан байна. Мөн орон нутаг, сургууль багш нарын хүсэлтээр тодорхой сэдвээр сургалтууд зохион байгуулж, багш нарын бие дааж мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд зориулсан бичмэл, аудио, видео бичлэг бэлтгэх, зөвлөмж гарын авлага бичих нийтлүүлэх зэргээр ажиллаж байв.

1997 онд Гэгээрлийн сайдын “Боловсролын хүрээлэн, багш бэлтгэдэг сургуулиудын талаар авах зарим арга хэмжээний тухай” 168 дугаар тушаал гарч, БСҮХ-г татан буулгаж, Гэгээрлийн яамны дэргэд Боловсролын хүрээлэнг дахин байгуулж, БСҮХ-ийн сургуулийн өмнөх ба ерөнхий боловсролын сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгох, багш нарын мэргэжил дээшлүүлэх, давтан сургах шинээр мэргэжил эзэмшүүлэх ажлын чиг үүргийг УБИС-д дахин шилжүүлсэн.

Үүнтэй холбогдуулан мөн оны 6-р сарын 27-ны өдөр УБИС-ийн ректорын 212 дугаар тушаалаар Боловсролын хөгжлийн сургууль байгуулсан. Тус сургуулийн дүрэмд “БХС нь сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгох, багшийн мэргэжлээр төгсөгчдийн сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, заах арга, багшлах дадлага практикийн сургалтын агуулгыг боловсронгуй болгох, хүүхдийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль, иргэдийг шаардлагатай мэдээллээр хангах, аймаг нийслэлийн Боловсролын төвүүдэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, боловсролын зарим удирдах ажилтан, багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, давтан сургах, шинээр мэргэжил эзэмшүүлэх чиг үүрэгтэй арга зүйн байгууллага” гэж тодорхойлжээ.

1997 онд тус сургуулиас зохион байгуулсан багш нарын мэргэжил дээшлүүлэх нийт 32 удаагийн сургалтад 22 мэргэжийн 1500 багш, 1998 онд нийт 19 удаагийн сургалтад 14 мэргэжлийн 607 багш тус тус хамрагджээ. Англи хэлний багш бэлтгэх дамжааг 9 сарын хугацаагаар зохион байгуулдаг болсон. Энэ онд тус сургуулийн арга зүйчид 12 аймагт сургууль багш нарт зөвлөн тусалжээ. Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх арга хэмжээг санхүүжүүлэх журам өөрчлөгдөж, баучерийн системд орсонтой холбогдуулан 1998 онд тусгай эрхийн бичгийн загвар батлуулж, хэвлүүлж орон нутагт хүргүүлсэн.

Хэдийгээр 1990-ээд оноос багш нарын мэргэжил дээшлүүлэх төвлөрсөн тогтолцоо задарч, мэргэжил дээшлүүлэх арга, хэлбэр өөрчлөгдсөн хэдий ч гадаад улсын төсөл хөтөлбөрүүд Монголын боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэж ирсэн. Тухайлбал: 1992 оноос эхэлсэн Данидагийн төслүүд нь орон нутаг, сургуулийн түвшинд багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжих болон сургалтын арга зүйн шинэчлэлд шавь төвтэй сургалтын үзэл санааг анх удаа оруулж ирсэн.

Данидагийн төслийн хүрээнд 1997-1998 оны хичээлийн жилээс ЕБС-ийн суралцагчдын үнэлгээ шинэ тогтолцоонд шилжсэн. “Стандарт” дэд төслийн сургалт-семинаруудад оролцож байсан Дани улсын Вангийн Их сургуулийн эрдэмтэд, их дээд сургууль, Боловсрол судлалын үндэсний хүрээлэнгийн ЭША-арга зүйчдийн оролцоотойгоор хичээлийн ба гүйцэтгэлийн стандартын талаар ойлголттой болж, 1998 онд ерөнхий боловсролын бүх хичээлээр анхны судлагдахууны стандарт, зөвлөмжийг боловсруулсан түүхтэй. Суралцагчдын үнэлгээний шинэ аргыг хэрэглэхэд нь багш нарт хялбар биш байсан тул тэдэнд туслах мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааны шинэ чиглэл, агуулга ийнхүү бий болсон билээ. 2000 оны 6-р сараас “Сургалтын шинэчлэл” сонин гаргаж эхэлсэн. Энэ нь шинээр батлагдсан Бага дунд боловсролын агуулгын стандартыг хэрэгжүүлэхэд хот, хөдөөгийн сургуулийн багш нарыг онол, арга зүйн шинэлэг мэдлэг, мэдээллээр хангахад чухал үүрэг гүйцэтгэсэн.

1994 оноос НҮБ-ийн Хүүхдийн сан, 1996 оноос Азийн хөгжлийн банкны дэмжлэгээр эхэлсэн Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрүүд, 1998 оноос эхэлсэн Монголын нээлттэй нийгмийн хүрээлэн (МННХ)-ийн Монголын боловсролын шинэчлэлийг дэмжих хөтөлбөрүүд, 1998 оноос АХБ-аас санхүүжилттэй Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрүүдийн хүрээнд БСШУЯ-аас багшлахуй арга зүйн шинэчлэлийн чиглэлээр хэрэгжсэн, хэрэгжиж байгаа хөтөлбөр, төслүүдийн үр өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын технологийн шинэчлэлийн онол арга зүйн үндэслэлийг *нэгэн зэрэг бүх сургууль, багш* нарт таниулан, сургалтын тогтолцооны шинэчлэлийн агуулга, мөн чанарыг ойлгуулж ухамсарлуулах, багшлах арга зүйн шинэчлэлийг сургууль, багш нар үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх менежмент арга замыг хамтран хэлэлцэж сонгох зорилготой агуулга арга зүйн нэгдмэл холбоо бүхий зургаан цуврал сургалтыг үндэсний хэмжээнд зохион байгуулсан. Үүнд:

1. "Сургалтын технологийн шинэчлэл" (ЕБС-ийн хичээлийн эрхлэгч, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөхбагш нарт зориулсан)
2. "Хичээл хоорондын холбоо-багш нарын хамтын ажиллагаа" (ЕБС-ийн ЗАН-ийн ахлагч, Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөх багш нарт зориулсан)
3. "Сургалтын арга зүй" (ЕБС-ийн хичээлийн эрхлэгч, ЗАН-ийн ахлагч, аймаг, нийслэлийн Боловсрол, соёлын төвийн арга зүйч, зөвлөх багш нарт зориулсан)
4. “Хичээлийн технологийн шинэчлэл” (8 мэргэжлийн багш нарт зориулсан)
5. “Сургалтын менежмент” (ЕБС-ийн хичээлийн эрхлэгчид зориулсан)

6. “Сургуулийн менежмент”: Сургалтыг технологийн менежмент дэд модуль (ЕБС-ийн захирлуудад зориулсан)

Эдгээр сургалт нь 1998 онд батлагдсан боловсролын агуулгын шинэ стандартыг бүтээлчээр хэрэгжүүлэх, хуулиар хүлээлгэсэн сургалтын төлөвлөгөө, сургалтын хөтөлбөрөө багш нар өөрсдөө боловсруулах шинэ үүрэг хариуцлагаа хэрэгжүүлэх, үнэлгээний шинэ тогтолцоонд шилжих зэрэгсургуулийн багш, удирдлагуудын өмнө тулгамдчихаад байсан олон зорилтыг хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. Эдгээр сургалтыг сургалтын хөгжлийн чиг хандлага, энэ талаар төрөөс баримтлах бодлого, шийдлийн үндэслэл, хэрэгжүүлэх арга замыг шүүн хэлэлцэж, хамтран ажиллах арга зүй бүхий "хийж суралцах"(workshop) хэлбэрээр зохион байгуулсан нь шинэлэг байв (Н.Нэргүй, Багшлахуйн хөгжил, багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагааны менежмент, 2013,11-р тал).

1996 оноос эхэлсэн НҮБ-ын Хүн амын сангийн Өсвөр үеийнхний нөхөн үржихүйн эрүүл мэндийн хөтөлбөрүүд, 1998 оноос эхэлсэн Швейцарийн хөгжлийн агентлаг (ШХА), Германы хамтын ажиллагааны нийгэмлэг (ГХАН), Азийн сангийн (АС)-ийн Тогтвортой хөгжлийн боловсрол, байгаль орчны боловсролын хөтөлбөрүүд, түүнчлэн гадаад дотоодын бусад байгууллагаас хэрэгжүүлсэн олон төсөл, хөтөлбөр нь сургуулийг хөгжүүлэх, сургалтын чанар, үр өгөөжийг сайжруулах, сургалтын арга зүйг шинэчлэхэд бодитой дэмжлэг үзүүлж, манай орны боловсролын шинэчлэлд сургуульд суурилсан өөрчлөлтийн үзэл санаа, арга зүйг хэлбэржүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Тухайлбал, Соросын сангийн санхүүжилтээр МННХ-ээс 1998 оноос эхлэн “Сургууль 2001”, “Нийгмийн ухаан-эрх зүйн боловсрол”, “Англи хэл”, “Шүүмжлэлт сэтгэлгээ ба унших бичих чадвар”, “Мэтгэлцээн”, “Алхам алхмаар” зэрэг төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлснээр сургуульд суурилсан шинэчлэлийн үзэл санааг үндэсний түвшинд түгээсэн. НҮБ-ын ЮНЕСКО-ийн сурлагын амжилтын хяналт-шинжилгээ, албан бус боловсролын төслүүд, Хүүхдийн сангийн сургууль завсардсан хүүхдүүдэд зориулсан албан бус боловсрол, бага ангийн багш нарын мэргэжил дээшлүүлэх хөтөлбөрүүд, Хүн амын сангийн ерөнхий боловсролын сургуульд эрүүл мэндийн хичээл болон нөхөн үржихүйн боловсролын төсөлт хичээлийг тус тус институтчилэх хөтөлбөрүүд хэрэгжсэнээр багш нар үнэлгээний даалгавар боловсруулж, сурагчдаа үнэлэх, амьдрах ухаанд суралцах, асуудал шийдвэрлэх зэрэг шинэ арга зүйтэй танилцахад ач холбогдолтой байв.

2001-2012

2001 онд УБИС-д байгуулсан Боловсрол судлалын сургуулийн харьяанд Сургалтын агуулга, арга зүйн төв ажиллах болсон. 2000-2001 оны хичээлийн жилд багш нарын мэргэжил дээшлүүлэх 27 удаагийн сургалт зохион байгуулж, 728 багшийг хамруулжээ. 2002 оны 3-р сарын 04-ний өдийн Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Багш бэлтгэх ажлыг улам боловсронгуй болгох ажлыг улам боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай” тушаал гарч, УБИС-ийн Боловсролын хөгжлийн сургуулийн гүйцэтгэж буй сургуулийн өмнөх болон бага, дунд, мэргэжлийн анхан, дунд шатны боловсролын агуулга, арга зүйг судлах, боловсронгуй болгох чиг үүргийг Боловсролын хүрээлэнд шилжүүлэн гүйцэтгүүлэх шийдвэр гарсан. Ийм учраас УБИС-ийн Боловсрол судлалын сургуулийн бүтцэд багтаж байсан Сургалтын агуулга, стандартын төв, Багш нарны мэргэжил дээшлүүлэх ба зайн сургалтын төвийн ажилтан, арга зүйчид сонгон шалгаруулатаар Боловсролын хүрээлэнгийн мэдэлд шилжиж ажилласан. Боловсролын хүрээлэн тухайн үед шинжлэх ухаан технологийн санд төсөл бичих журмаар санхүүжүүжиж байсан тул 2004-2005 онд “Арван хоёр жилийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, агуулгын хүрээ”, “12 жилийн сургалтын агуулга, хөтөлбөр”, 2009-2012 онд Ахлах ангийн сурагчдад ажил мэргэжлийн чиг баримжаа олгох асуудал” зэрэг төсөл хэрэгжүүлсний зэрэгцээ БСШУЯ-ны захиалгат, гэрээт ажлыг давхар гүйцэтгэс ирсэн.

1995 онд батлагдсан төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай хуулийн холбогдох заалтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1996 онд Засгийн газрын 38-р тогтоолоор “Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах” журам батлагдсан байдаг. Энэхүү журамд багшлах эрхийн үнэмлэхийг дипломын хавсралт болгон олгох, хасах; багшийн мэргэжлийн “заах аргач”, “тэргүүлэх”, “зөвлөх” зэрэг олгох, хүчингүй болгох болзол шалгууртай болжээ.

Багшийн мэргэжил дээшлүүлэх талаар баримтлах бодлого нь 2001 оноос эхлэн Засгийн газрын үндэсний хөтөлбөрүүд ба салбарын хөтөлбөр хэлбэрээр тодохойлогдож иржээ. Тухайлбал 2001 онд Засгийн газрын 120 дугаар тогтоолоор “Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр” батлагдсан. Энэхүү хөтөлбөр нь бага, дунд боловсролын багш бэлтгэх, тэдний мэргэжлийг тасралтгүй дээшлүүлэх, багш хүн байнга хөгжиж байх шинэ тогтолцоог бүрдүүлэх зорилгын хүрээнд дараах зорилт дэвшүүлжээ. Үүнд:

1. Багш бэлтгэх тогтолцоог шинэчлэх

2. Багш нарын мэргэжил дээшлүүлэх уян хатан, төвлөрсөн бус тогтолцоог түншлэлд тулгуурлан төлөвшүүлэх
3. Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын орчныг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох
4. Багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, тэдний идэвхтэй үйл ажиллагааг дэмжих механизм бүрдүүлэх

Энэ хөтөлбөрийг 2001-2004, 2005-2010 гэсэн хоёр үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

5.2 Багш нарын мэргэжил дээшлүүлэх уян хатан, төвлөрсөн бус тогтолцоог түншлэлд тулгуурлан төлөвшүүлэх

- Багш нарын мэргэжлийг үндэсний хэмжээнд, орон нутагт, ажлын байранд гэсэн 3 түвшинд сургалтын олон хувилбар бүхий хөтөлбөр /модуль/-өөр тэдний сонирхол, хэрэгцээнд тулгуурлан тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бүрдүүлэх.
- Орон нутаг дахь боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагыг түшиглэн багш нарын мэргэжил дээшлүүлэх бүсийн төвүүд байгуулан ажиллуулах.
- Зайны болон албан бус сургалтаар багш нарын мэргэжил дээшлүүлэх агуулга, хөтөлбөр, арга зүйг боловсруулан хэрэгжүүлэх.
- Багш нарын мэргэжил дээшлүүлэхэд төрийн бус болон олон улсын байгууллага, олон нийт, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх.

5.3 Багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх сургалтын баазыг бэхжүүлэх, санхүүжилтийн механизмыг боловсронгуй болгох

- Багш бэлтгэдэг сургуулиудын сургалтын агуулгын болон орчны стандартыг боловсруулан мөрдүүлэх.
- Аймаг, нийслэлийн боловсрол, соёлын төв, мэргэжил дээшлүүлэх бүсийн төв, багш бэлтгэдэг их сургууль, коллежийн сургалт, судалгааны баазыг бэхжүүлэх хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх.
- Багш нарыг мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэхэд зориулж гарын авлага, сургалтын материал боловсруулан хэвлүүлж түгээх, мэргэжлийн мэдээлэл, туслалцаа авах боломж, нөхцөлийг сайжруулах.

5.4 Багшийн ажлын үнэлгээг боловсронгуй болгох, тэдний идэвхтэй арга, үйл ажиллагааг дэмжих механизм бүрдүүлэх

- Багшийн ажлыг бодитой үнэлэх нөхцөл бүрдүүлэх:
- Багш үйл ажиллагаандаа үнэлгээ өгөх болон багшийн үйл ажиллагаанд мэргэжлийн үнэлгээ өгөх цогцолбор үзүүлэлт боловсруулан мөрдүүлэх,
- Багшийн үйл ажиллагааг үнэлэхэд эцэг, эх, сонирхлын бүлгийн оролцоог нэмэгдүүлэх.
- Багшийн идэвхтэй үйл ажиллагааг дэмжих арга, хэлбэрийг боловсронгуй болгох:
- Үйл ажиллагааны үр дүн, бүтээлч байдал, мэргэжлийн түвшин, ур чадварыг харгалзан багшид нэмэгдэл олгох асуудлыг боловсронгуй болгох.
- Багш нарыг тогтвор суурьшилтай ажиллуулах асуудал боловсруулж хэрэгжүүлэх.

Эдгээр баримт бичигт дэвшүүлсэн зорилтууд, үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу багшийн ажил, үүрэгтэй холбоотой “Багшийн ажлын байрны “- 2001, 2003 онд шинэчлэн баталж, мөрдүүлжээ. 2002 онд УИХ-ын тогтоолоор батлагдсан Бага, дунд боловсролын тухай хуулийн 21 дүгээр зүйлд эдгээр заалт үндсэндээ хэвээр боловч “багш нь багшлах эрхтэй байна, багш бус хүн заах арга зүйн сургалтад хамрагдсаны дараа багшлах эрх авна, ЕБС-ийн багшид заах аргач багш, тэргүүлэх багш, зөвлөх багш гэсэн мэргэжлийн зэрэг олгоно, багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах тухай журмыг Засгийн газар тогтоох” заалт нэмэгдсэн.

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2002 оны 202 тоот тушаалаар “Бага, дунд боловсролын киррикюлим хөгжил, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал”-ыг баталсан. Энэхүү үзэл баримтлалын үзэл санаа буюу цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, тухайлбал сургуулийн өмнөх, бага, суурь, бүрэн дунд боловсрол гэсэн дөрвөн түвшний стандарт, судлагдахууны 15 стандарт батлагдан 2004 оноос мөрдөгдсөн. Энэ нь багшийн албан тушаалын үндсэн чиг үүрэг, багшлах үйлийн агуулга, хөдөлмөрийн харилцааг цоо шинээр авч үзэж, шийдвэрлэх хүндхэн сорилтыг бий болгосон байна. Учир нь энэ үзэл баримтлал болон стандарт нь суралцахуйн конструктив онолын суурь зарчмууд, хүн судлалын шинжлэх ухааны интеграцыг суралцахуйд буулгасан дидактикийн ухааны гол шийдлүүдэд суурилсан байжээ. [Монгол улсын боловсролын суурь мэдээллийн тайлан, Уб, 2019, 248-р тал]

“2002 оноос Бага дунд боловсролын стандарт боловсруулан хэрэгжүүлэх, ерөнхий боловсролын сургуулийг 11, 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх агуулга, хөтөлбөр боловсруулах, долоо, зургаан настай хүүхдийг сургуульд элсүүлэхтэй

холбогдсон асуудлаар багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтыг төвлөрөсөн ба бүсчилсэн байдлаар зохион байгуулах, СӨБ, хүүхдийн цэцэрлэгийн багшийн мэргэжил дээшлүүлэх шинэ журам хэрэгжүүлэх ажлыг БСШУЯ-ны удирдлагын дор Боловсролын хүрээлэн хийж гүйцэтгэсээр ирсэн байна. 2002 оноос эхэлсэн бага, дунд боловсролын стандарт боловсруулах, турших, хэрэгжүүлэх зөвлөмж бичих, түгээн дэлрэгүүлэх сургалт зохион байгуулах бүхий л үйл ажиллагаанд тус хүрээлэнгийн агуулга, арга зүй хариуцсан эрдэм шинжилгээний ажилтнууд оролцож ирсэн.

2003 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар УБИС-ийг Монгол Улсын Боловсролын их сургууль болгон өөрчилсөн. МУБИС-ийн Багш, боловсролын ажилтны мэргэжил дээшлүүлэх төв дараах сургалтуудыг жил бүр явуулж байсан. Үүнд:

- ЕБС-ийн сурагчийн 1 ба 3 дугаар улирлын амралтаар багш нарын мэргэжил дээшлүүлэх 5 өдрийн 40 цагийн модуль сургалт
- Багшийн мэргэжил эзэмшээгүй боловч багшлах ажил хийж буй хүмүүст багшийн боловсрол олгох 45 хоногийн сургалт
- Багш бус мэргэжлийн бакалаврын боловсрол эзэмшсэн иргэдэд зориулсан багшийн мэргэжил олгох 1 жилийн сургалт
- Бусад их дээд сургуулийн багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалт

2006 онд “Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөө” Засгийн газрын 192 дугаар тогтоолоор батлагдсан бөгөөд багшийн хөгжлийн талаар баримтлах стратегийг тодорхойлжээ. Тухайлбал:

1. Багшийн хангалт, ашиглалт ба багшийн ачааллыг оновчтой болгох (4)
2. Багш, удирдах ажилтан бэлтгэх тогтолцоог сайжруулах (6)
3. Сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоо төлөвлөх (5)
4. Шинэ стандарт, кинрикулим хэрэгжүүлэх багш нарын мэргэжил, арга зүйн ур чадварыг дээшлүүлэх (5)
5. Багш, арга зүйчид, удирдах ажилтны хөдөлмөрийн үнэлэмжийг бодитой болгож, тэдний цалин, нэсэгдэл, нэмэгдэл хөлс, тэтгэлэг, урамшууллын тогтолцоог шинэчлэн мөрдүүлэх (6)

2007 оны 4 дүгээр сарын 26-27 нд Улаанбаатар хотноо болсон Монголын багш нарын “Улсын анхдугаар зөвлөгөөн”-д Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд Ө.Энхтүвшиний хэлэлцүүлсэн “Боловсролын шинэчлэлийг гүнзгийрүүлж, багшийн манлайллыг дээшлүүлье” илтгэлд “Багшийг хөгжүүлэхэд цогц чадамжид суурилсан стандартыг хэрэгжүүлэх явдал сайн үр нөлөө үзүүлнэ гэж үзэж байгаа,

... стандарт дахь арга зүйг хөгжүүлэх чиглэл нь өөрийгөө хөгжүүлэх гэсэн багш нарын хэрэгцээтэй нийцэж байна. Энэхүү стандарт багш нар ажлын байрандаа мэргэжил арга хэлбэрийг тууштай нэвтрүүлэхэд сайнаар нөлөөлж байгаа юм. Сургууль түшиглэсэн сургалт зохион байгуулах нь хүндээ наалдацтай, үр өгөөжтэй, өртөг зардал багатай байх болно” гэжээ (Багш сонин. 2007 он, тусгай дугаар, 5 дахь тал).

2008 онд Засгийн газрын 316-р тогтоолоор “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр”, 54-р тогтоолоор “Төрийн өмчит ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэгийн багш, бусад албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр мөнгөн урамшуулал журам”-ыг тус тус баталсан байна. Шинээр батлагдсан үндэсний хөтөлбөр нь багш бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх тогтолцоог ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн өөрчлөлт, цогц чадамжид суурилсан боловсролын стандарт болон сургалтын хөтөлбөрийг суралцагчдын эрэлт хэрэгцээнд тохируулан хэрэгжүүлэх чадвартай багш бэлтгэх, багшийн мэргэшил, арга зүйг тасралтгүй дээшлүүлэх, цаашид тогтвортой хөгжих нөхцөлийг хангах зорилго дэвшүүлсэн. Энэхүү хөтөлбөрийг 2008-2015 онд хэрэгжүүлсэн бөгөөд дараах хоёр гол зорилтын хүрээнд 12 тодорхой зорилт, 55 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр тусгажээ. Үүнд:

1. Багш боловсролын зорилго, агуулгын өөрчлөлт, бага, дунд боловсролыг чанарыг тасралтгүй сайжруула байх хэрэгжээ шаардлага, ЕБС-ийн бүтэц, хэмжээ, хэв шинжийн онцлогт нийцсэн, багшийн хөдөлмөрийн хөдөлмөрийн зах зээлийн эрэлт нийлүүлэлтэд баримжаалсан багш бэлтгэх, уян хатан, тогтвортой тогтолцоог бүрдүүлж төлөвшүүлэх
2. Нийгмийн аж төрөх ёсонд нийцсэн, ажлын байран дээрээ багш тасралтгүй хөгжих бодит хэрэгцээнд суурилсан, сургууль төвтэй мэргэшил дээшлүүлэх нээлттэй, сонголттой, тогтвортой тогтолцоог хөгжүүлэх

Үндэсний хөтөлбөрийн багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн зорилт нь дараах 6 тодорхой зорилт багтсан бөгөөд тус бүрийн хүрээнд хэрэгжүүлэх, хийгдэх ажлыг тодорхойлсон байна.

Зорилт (МД1) Ерөнхий боловсролын сургуулийг мэргэжлийн багшаар бүрэн хангах:

1.1 сум, тосгон, багт ажиллаж байгаа сургууль, цэцэрлэгийн багшаас бусад удирдах болон мэргэжлийн албан тушаалтанд 5 жил тутамд 6 сарын тэтгэлэг олгох асуудлыг судалж холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлж хэрэгжүүлэх;

1.2 багшийн ажлын байрыг хөдөлмөрийн биржээр дамжуулан хангах арга хэмжээ авах;

1.3 багшийн ур чадварыг нэмэгдүүлэх, сургалтад үзүүлэх нөлөө, хариуцлагыг дэмжсэн урамшууллын механизмтай уялдуулж багшлах эрх, багшийн мэргэшлийн зэрэг олгох журмыг шинэчлэн мөрдөх;

1.4 багшийн ажлын чанар, хөдөлмөрийн үр бүтээлийн үнэлгээг боловсролын чанарын үнэлгээний шинэ тогтолцооны бүрэлдэхүүн хэсэг болгох.

Зорилт (МД2) Ажлын байран дээрээ багш мэргэшил дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчныг бүрдүүлэх:

2.1 багш, ажилтан сургууль дээрээ мэргэшил дээшлүүлэх, бүтээлчээр ажиллах нөхцөл бүрдүүлэхэд шаардлагатай технологийн болон материаллаг орчны стандарт боловсруулж мөрдөх;

2.2 орон нутгийн өмчийн бүх сургуулийн багш нарын өрөө-ажлын байрыг стандартын шаардлагын дагуу тохижуулах;

2.3 мэргэжлийн чиглэл бүрээр зайны сургалтын материал, хэрэглэгдэхүүн бэлтгэж багш нарт нийлүүлэх;

2.4 сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэх болон сурагчийг үнэлэх, дүгнэхэд нь шаардлагатай программ хангамжаар хангах;

2.5 багш нарт зориулсан ном, гарын авлага, сургалтын хэрэглэгдэхүүн худалдан авахад төрөөс дэмжлэг үзүүлэх;

Зорилт (МД3) Мэргэшил дээшлүүлэх сургалтын төрлийг нэмэгдүүлж, менежментийг сайжруулах:

3.1 багш, ажилтны мэргэшил дээшлүүлэх талаар холбогдох журам баталж мөрдөх;

3.2 багш ажиллах хугацаандаа 3-аас доошгүй удаа мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагддаг тогтолцоо бий болгож, төлөвшүүлэх;

3.3 дээд боловсролтой боловч багшийн мэргэжилгүй багш нарыг мэргэжил эзэмшүүлэх болон тухайн мэргэшлийн багшид өөр мэргэшил олгон суралцуулах хөрвөх сургалтыг бий болгох;

3.4 мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаа болон түүний үр дүнгийн мэдээлэл, хяналт-шинжилгээний тогтолцоог бий болгох.

Зорилт (МД4) Мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааны хэрэгжилтийн чанар, менежментийг хариуцдаг тогтолцоо бий болгох:

4.1 багшлах эрх олгох, мэргэшлийн зэрэг олгох, мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагааг уялдуулах бодлогын хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг бүхий "Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт" байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх;

4.2 мэргэшил дээшлүүлэх үндсэн болон кредит олгох төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийж шалгаруулдаг механизм бүрдүүлэх;

4.3 мэргэшил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх шинжээч, сургагч багш нарыг бэлтгэх;

4.4 сургууль, цэцэрлэгийн "Заах аргын нэгдэл"-ийн бүтэц, үйл ажиллагааны арга хэлбэрийг уян хатан болгож, сургалтын хөтөлбөр боловсруулах, хичээл заах, дүн шинжилгээ хийхэд багаар ажиллах соёлыг бий болгох.

Зорилт (МД5) Мэргэшил дээшлүүлэх сургалтын зардал, санхүүжилтийн зохистой тогтолцоог бий болгох:

5.1 мэргэшил дээшлүүлэх үндсэн сургалтын зардлыг улсын төсөвт жил бүр тусган санхүүжүүлж байх;

5.2 мэргэшил дээшлүүлэх зардлыг тусгай зүйлээр сургуулийн төсөвт тусгаж санхүүжүүлэх;

5.3 мэргэшил дээшлүүлэх кредит олгох болон бусад төрөлжсөн сургалт, хөрвөх сургалтыг эрэлтэд суурилсан санхүүжилттэй болгох.

Зорилт (МД6) Багш нарын зорилтот бүлэг бүрт зориулан боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжсэн сургалт зохион байгуулах:

6.1 мэргэшил дээшлүүлэх сургалтын үндэсний болон орон нутгийн түвшний дунд хугацааны төлөвлөгөө боловсруулж мөрдөх;

6.2 багш, удирдах болон мэргэжлийн ажилтны мэргэшил дээшлүүлэх сургалтын модулийн тогтолцоо боловсруулж, магадлан шинжилгээ хийж бүртгэх;

6.3 мэргэшил дээшлүүлэх, үндсэн, төрөлжсөн, хөрвөх, бие даах сургалт зохион байгуулах;

6.4 гадаад оронд багш нарыг мэргэшил дээшлүүлэх сургалтад хамруулж, дэвшилтэт туршлага, арга зүйг судлах, нэвтрүүлэх.

Ийнхүү багшлах эрх зүйн орчин өөрчлөгдсөнтэй холбоотойгоор 2007-2008 онд багшийн ажилтай холбоотой багц журам гарсан. “Цэцэрлэг, ЕБС-ийн багшийн ажлын норм тогтоож, багш, зарим албан тушаалтны цалин хөлсийг тооцж олгох журам” 2007 оны хамтарсан 307/91/237-р тушаалаар батлагдаж, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын тушаалаар дараах журмууд батлагдан хэрэгжжээ. Үүнд:

- ЕБС, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм, 2007 оны 41-р тушаал
- Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт, 2007 оны 354, 179-р тушаал
- Улс, аймаг, нийслэлийн “Оны тэргүүний багш шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал, 2007 оны 440-р тушаал
- “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, 2008 оны 72-р тушаал
- Багшийн мэргэжлийн зэрэг олгох, хасах журам, 2007 оны 73-р тушаал
- Багшлах эрх олгох, хасах журам, 2007 оны 74-р тушаал
- Багшийн хөгжлийн танхимын стандарт, 2008 оны 114-р тушаал

2008-2010 онд ТХБ-ын цогц чадамжид суурилсан боловсролын стандарт, сургалтын үндэсний хөтөлбөр, сурах бичгийг хэрэгжүүлэх хүрээнд багштай холбоотой эдгээр журмыг шинэчилжээ. Багшийн мэргэжил, мэргэжлийн ур чадвартай холбоотой 2008 оны багц журамд багшлах эрхийг багш мэргэжлийн онцгой хариуцлага, үндсэн чиг үүрэг, мэргэжлийн ёс зүйг эрхэмлэх чадварыг баталгаажуулах; мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг багш нэг бүрийн хөгжлийн дэмжих, багш бүрд тэгш боломж олгох; мэргэжлийн ур чадварын өсөлтийн төлөө шударга өрсөлдөөнийг гурван шатлал бүхий хэмжээсжүүлсэн шалгуураар үнэлэн шалгаруулж, боловсролын агуулга, араг зүйн шинэчлэлийг сургууль, орон нутаг, үндэсний түвшин бүрд түүчээлэн үр нөлөөгөө үзүүлж, хөгжлийн дотоод хүч болгох бодлогыг тус тус баримтлан боловсруулжээ (Монгол улсын тогтвортой хөгжлийн боловсрол, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа. 2016, 148-149-р тал).

Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 8-р сарын 20-ны өдрийн 297 дугаар “Туршилт явуулах тухай” тушаал гарч, 2007-2008 оны хичээлийн жилээс нэгдүгээр ангид зургаан настай хүүхдийн судлах хичээлүүдийн агуулга, арга зүй, сургалтын орчны тохирцыг турших ажлыг Боловсролын

хүрээлэнд даалгасан. Туршилтад Баянхонгор аймгийн “Номгон” сургууль, Жаргалант сумын дунд сургууль, Дархан-Уул аймгийн “Од” цогцолбор, Шарын гол сумын дунд сургууль, Дундговь аймгийн нэгдүгээр сургууль, Дэрэн сумын дунд сургууль, Увс аймгийн “Эрдэм-Оргил” цогцолбор, өндөрхангай сумын дунд сургууль, Хэнтий аймгийн нэгдүгээр сургууль, Бэрх сумын дунд сургууль, нийслэлийн Чингэлтэй дүүргийн 24, 57, Бявдурх дүүргийн 48,68, Налайх дүүргийн “Голомт”, “Чандмань” цогцолбор сургууль, нийт 16 сургуулийн нэг нэг бүлэг, 16 багш, 500 хүүхдийг тус туршилтад хамруулсан. Туршилтын үр дүнд эдгээр ангид мөрдсөн сургалтын төлөвлөгөө, хичээлийн жилийн бүтэц, хичээлүүдийн агуулгыг туршилт судалгааны явцад гарсан санал зөвлөмжийг тусган сайжруулсны үндсэн дээр цаашид ерөнхий боловсролын сургуулийн нэгдүгээр ангид мөрдөх боломжтойг тогтоосон байна.

Тухайн үеийн байдлаар дэлхийн улс орнуудаас хүүхдэд ерөнхий дунд боловсролыг 10 жилээр олгож байгаа гурван улс байгаагийн нэг нь манай улс байгаад дүгнэлт хийж ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хугацааг 11, улмаар 12 жилийн тогтолцооны шилжилт хийх нь Боловсролын Мастер төлөвлөгөөний нэг томоохон зорилт болж байсан. Энэ зорилтыг хэрэгжүүлэх шилжилтийн графикийн дагуу 2004-2005 оны хичээлийн жилд бүх ангийг нэг анги алгасан “үсэргэх” замаар 10 жилийн тогтолцоог 11 жилд шилжүүлсэн бол 2008-2015 оны хооронд 12 жилийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлсэн. Бага, дунд боловсролын стандартад нийцүүлэн сургалтын үндэсний хөтөлбөрийг боловсруулан баталж хэрэгжүүлэх, сурах бичгүүдийг бэлтгэн түгээх, багш нарыг сургалтад хамруулах зэрэг бэлтгэл ажил хийгдсэн.

Ерөнхий боловсролын сургуулийг 11 жилийн тогтолцоонд шилжүүлэх зорилтын хүрээнд 2004 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын “Сургалтын төлөвлөгөө, агуулгын үлгэрчилсэн хүрээг турших тухай” 132 дугаар тушаал гарч, ерөнхий боловсролын 11 жилийн сургуулийн бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, судлах агуулгын хүрээг батлан эдгээрийг турших, хэрэгжүүлэх бэлтгэл хангах ажлыг Боловсролын хариуцан гүйцэтгэсэн. Мөн энэ оны 8 дугаар сарын 13-ны өдөр “Долоон настай хүүхдийг сургах ажлыг зохион байгуулах тухай” 268 тоот тушаал гарч 2004-2005 оны хичээлийн жилд ЕБС-ийн нэгдүгээр ангид элссэнээс бусад долоон настай хүүхдийг сургуулийн “0” бүлэг, цэцэрлэгийн бэлтгэл бүлэгт тус тус хамруулан суралцуулах шийвдэр гарсан тул долоон настай хүүхдэд заах сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, багш нарыг бэлтгэх сургалтыг орон даяар зохион байгуулсан.

Ийнхүү 11 жилийн тогтолцоонд шилжихдээ шууд шилжилгүй бүтэн нэг хичээлийн жилийг “шилжилт” гэж нэрлэн сургалтын төлөвлөгөө, хичээлүүдийн агуулгын хүрээг тусгайлан боловсруулж хэрэгжүүлсэн нь хүүхдэд ээлтэй зохион байгуулалт болсон. 2005-2006 оны хичээлийн жилд мөрдөх шилжилтийн сургалтын төлөвлөгөөг 2005 онд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд 164-р тушаалаартөлөвлөгөөг баталж, тус хүрээлэн хичээлүүдийн шилжилтийн үед мөрдөх агуулыг боловсруулан, зөвлөмжийн хамт сургууль багш нарт хүргэж хэрэгжүүлсэн. 2008 онд Боловсрол, шинжлэх ухааны сайдын 72-р тушаалаар нэг, хоёрдугаар ангийн сургалтын төлөвлөгөө, 303 тугаар тушаалаар хичээлийн жилийн бүтэц, 424-р тушаалаар сургалтын хөтөлбөрийг тус тус баталсан нь улс даяар 2013 он хүртэл мөрдөгдсөн байна.

Нэгдүгээр

ангийн бага
нарыг бэлтгэх
сургалт

Нэгдүгээр ангийн
багш нарыг
бэлтгэх
сургалтад

Дэлхийн банкны
Каталик сангаас
санхүүжүүлсэн

“Бүх нийтийн
боловсролын үр

дүнд түргэн хүрэх санаачилгын түншлэл” хөтөлбөрийн “Бага боловсролын чанарыг дээшлүүлэх” төсөл чухал үүрэг гүйцэтгэсэн. Ерөнхий боловсролын сургуулийн тогтолцооны шилжилт хийх зорилтыг хэрэгжүүлэхэд хүүхдийн сургуульд элсэх насыг урагшлуулж сургах шаардлага гарсан. Үүнтэй холбогдуулан бага ангийн багш нарт энэ насны хүүхдийн онцлогийг судлан мэдэж, түүнд тохирсон сургалтын арга зүйд суралцах тулгамдсан хэрэгцээ бий болсон. Ийм учраас бага ангийн багш нарыг 6 ба 7 настай хүүхдийг сургах арга зүйд, тухайлбал, зургаан настай хүүхдийг сургууль, нийгмийн орчинд дасгаж, сурах арга барил эзэмшүүлэх, тэдний бие бялдар, оюун ухаан, сэтгэл нийгэмшлийн хөгжлийг багшлах үйлээр дэмжин тэтгэх арга зүйд бага ангийн бүх багшийг сургах зорилгоор харилцан уялдаатай хэд хэдэн модуль бүхий нэгдсэн

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 405 дугаар тушаалын хавсралт

1. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх график

Хичээлийн жил	Анги												
	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	
2007-2008													
2008-2009	I												
2009-2010	I	II					VII						
2010-2011	I	II	III				VII	VIII					
2011-2012	I	II	III	IV			VII	VIII	IX				
2012-2013	I	II	III	IV	V		VII	VIII	IX	X			
2013-2014	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI		
2014-2015	I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII	

Тайлбар:

1. 2008-2009 оны хичээлийн жилд, 5 дугаар анги төгсөгчдийг 12 жилийн сургуулийн 7 дугаар ангид дэвшүүлж шилжилтийн хөтөлбөрөөр хичээллүүлэх замаар 5 жилд багтан бүх ангийн шилжилтийг дуусгана. 2008-2009 оны хичээлийн жилд 6 буюу түүнээс дээш ангийн суралцагчид шилжилтэд хамрагдалгүйгээр 11 жилээр суралцаж төгсөнө. 12 жилийн сургуулийн анжны төгсөлт 2014-2015 онд болно.

2. Шилжилтийн үед сургуульд элсэх, төгсөх үйл явц тасралтгүй явагдана.

агуулгатай цуврал сургалтыг гурван жил дараалан зохион байгуулсан. Эдгээр сургалтад нийт 339 сургагч багш, 4832 нэгдүгээр ангид хичээл заах багш, 532 бага ангийн сургалтын менежер, 589 дотуур байрны багш, 624 нийгмийн ажилтан, нийт 6916 хүн хамрагдсан⁸ байна. Жил бүрийн сургалтад хичээл заах багш нараас гадна сургууль дээр 6 настай хүүхэдтэй ажиллах сургалтын менежер, нийгмийн ажилтан, дотуур байрны багш зэрэг мэргэжлийн бусад албан тушаалтанд зориулсан сургалтуудыг тусгай агуулга, гарын авлага бүхий бие даасан сургалтын хөтөлбөрөөр зохион байгуулсан байна.

Зургаан настай хүүхдийг сургуульд сургах бэлтгэлийг хангах хүрээнд БСШУЯ-наас 2008-2010 онд зохион байгуулсан 3 удаагийн сургалтад зориулан “Зургаан настай хүүхдийн сурах, сургах арга зүй” (2008), “Зургаан настай суралцагч” (2009), “Сурлагын амжилтын үнэлгээ” (2010) гэсэн нийт 57 хэвлэлийн хуудас бүхий багшид зориулсан гарын авлагыг бэлтгэн, 15000 ширхэг хэвлэж, хичээл заах багш, сургалтын менежерүүд, БСГ-ын арга зүйчид, багш бэлтгэдэг их дээд сургуулийн багш, оюутанд хуваарилж түгээжээ.

2011-2012 онд нэгдүгээр ангид хичээл заах багш нарт зориулсан сургалтыг Боловсролын хүрээлэн зохион байгуулсан бөгөөд өмнөх жилүүдийн сургалтын агуулгыг гурван өдөрт багтаан интеграцчилсан ажээ. Сургалтыг зохион байгуулахдаа өмнөх гурван жилд сургалтад хамрагдсан багш нарыг төвлөрсөн сургалтад хамруулан сургагч багшаар бэлтгэн 27 бүсэд сургалт зохион байгуулж, 1703 багшийг хамруулжээ. Харин 2012 оноос нэгдүгээр ангид хичээл заах багш нарын сургалтыг аймаг, нийслэл хариуцан зохион байгуулж байна.

Дэлхийн банкны READ төсөл

Дэлхийн банкны санхүүжилтээр бага ангийн багш нарт зориулсан READ төслийг хэрэгжүүлсэн бөгөөд энэ төсөл нь сурагчдыг сургалтын хэрэглэгдэхүүн, номоор хангах, сурагчдын бүтээлч чадварыг хөгжүүлэх, эцэг эх, олон нийтийн оролцоог хангах, дижитал уншлагын орчин бүрдүүлж, арга зүйг нэвтрүүлэхээр олон талын ач холбогдолтой цогц үйл ажиллагааг агуулсан байв. Төслийн хүрээнд Улаанбаатар хот, аймгийн төвөөс бусад бүх сум, багийн 383 сургуулийн бага ангийн 3,870 бүлэгт номын сан нийлүүлсэн бөгөөд ангийн номын санд зориулан 600,000 ширхэг ном хэвлэн анги бүлгээр багцлан сургуулиудад хүргүүлсэн байна. Ангийн номын санг ашиглах арга зүйд сургахаар багш нарт зориулсан “Сурагчдад бүтээлчээр унших, сонсох, бичих чадвар эзэмшүүлэх арга зүй”-н цуврал

⁸БСШУЯ-ны 2008, 2009, 2010 оны үйл ажиллагааны тайлан

сургалтыг олон улсын тендерт шалгарсан Монголын БХАН хариуцан зохион байгуулжээ. 2007-2008 онд 10 сарын хугацаанд сургагч “ментор” багш нарыг бэлтгэх хоёр шатны туршилтын сургалтыг зохион байгуулж, 5 аймгийн 159 сургуулийн 1384 ментор багш бэлтгэгдэж, сүлжээний сургалтын I, II шатны сургалтад нийт 160 сургуулийн 2053 бага ангийн багш хамрагдсан байна.

Бага ангийн багш нарын суурь чадварыг дэмжих сургалтууд

“Бага боловсролын чанарыг дээшлүүлэх” төслийн хүрээнд хөдөөгийн сургуулийн бага ангийн заах аргын нэгдэлд нийлүүлсэн зөөврийн компьютер, LCD проектор, телевизор, дэлгэц зэргээс бүрдсэн тоног төхөөрөмжийг сургалтад хэрэглэх чадвартай болгох, математикийн заах аргыг сайжруулах зорилгоор бие даан суралцах хоёр гарын авлага боловсруулан, нийт 2260 хувийг хэвлэж сургууль, багш нарт түгээсэн байна. Бие даан суралцах гарын авлагыг нийт багш нараар ашиглуулахын тулд математикийн арга зүйн чиглэлээр бага ангийн нийт 1100 багш, мэдээлэл харилцааны технологи ашиглах зорилгоор 1100, нийт 2200 багшийг 5 хоногийн сургалтад хамруулсан ажээ. Дээрх тоног төхөөрөмжийн хөрөнгө оруулалт болон сургалтын үр дүнд багш бие дааж суралцах гарын авлага ашиглан мэдээлэл харилцааны шинэ технологит суралцах, түүнийгээ сургалтдаа хэрэглэхэд нь бодит дэмжлэг үзүүлсэн цогц арга хэмжээ болсон юм.

МХТ-ийн анхан шатны сургалтыг 2008 онд ЕБС-ийн бүх бага ангийн багш нарыг хамран явуулж, бие даан суралцах гарын авлагаар хангасан бол 2009 онд тэдэнд зориулсан МХТ-ийнахисан түвшний боловсрол олгох сургалтыг “Үр дүнд түргэн хүрэх түншлэлийн санаачлага” төслийн хүрээнд дотоодод зарласан зөвлөх үйлчилгээний тендерээс “Интек” ХХК шалгарч үндэсний хэмжээнд 4 шаттайгаар зохион байгуулсан байна.

Шилжилт хийгдэж буй ангийн багш нарын сургалт

ЕБС-ийн сургалтыг 12 жилд үе шаттайгаар шилжүүлэх графикийн дагуу жилд хоёр ангийн бүх хичээлийн сургалтын үндэсний хөтөлбөрүүд, тэдгээрийг хэрэгжүүлэх багш нарт зориулсан зөвлөмжүүдийг тус тус боловсруулан сургууль бүрд хүргэжээ. Хичээл бүрийн үндэсний хөтөлбөрийн бүтэц, дизайны үндсэн бүрэлдэхүүний бие даасан хэсэг болгон тухайн бүлгээр эзэмших мэдлэг, чадварыг суралцагчдад эзэмшүүлэх ерөнхий арга зүйг тодорхойлж, зөвлөмжид нь тэдгээр ерөнхий арга зүйг хэрэгжүүлэх нарийвчилсан тусгай аргуудыг тайлбарласан байна. Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх бэлтгэл хангах хүрээнд жил бүрийн намар аймаг, нийслэлийн БСГ-ын мэргэжилтэн болон орон нутгийн

сургагч багш нарыг бэлтгэж, шилжилт хийж буй ангид хичээл заах бүх багшийг хамруулсан орон нутгийн сургалтыг зохион байгуулж ирсэн. Өөрөөр хэлбэл, бүх сургуулийн багш бүр (томоохон цогцолбор сургуулиудаас бусад) жил бүр зааж буй хичээлээрээ орон нутгийн түвшинд шилжилтийн сургалтад хамрагдсан байна.

Англи хэлний багш нарын сургалт

Англи хэлний сургалтын чанарыг сайжруулах, нийт багшийн англи хэлний мэдлэгийг дээшлүүлэх, сургалтын орчныг бүрдүүлэхэд зориулж 2008 онд улсын төсвөөс 1.6 тэрбум төгрөг зарцуулж, багш нарын англи хэлний боловсролын чанарыг дээшлүүлэх доор дурдсан 4 цогц арга хэмжээ бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна. Уг хөтөлбөрийг зөвлөх үйлчилгээний олон улсын тендерт ялсан Монголын “Golden bridge” гадаад хэлний сургалтын компани гүйцэтгэжээ.

- Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх төсөл хөтөлбөрүүд боловсруулан хэрэгжүүлэх,
- Англи хэлний сургалтын материал, хэрэглэгдэхүүний хангамжийг эрс нэмэгдүүлэх,
- Англи хэлний багш нарын мэргэшлийг дээшлүүлэхэд олон улсын жишиг, шаардлагад нийцсэн, дэвшилтэт арга хэлбэрүүдийг нэвтрүүлэх,
- Багш нарын мэдлэг чадварыг системтэйгээр дээшлүүлэх, мэргэжлийн ур чадварыг нь олон улсын жишигт нийцсэн сертификат олгох замаар хэмжээсжүүлэх.

Англи хэлний сургалтыг сайжруулах 7 төсөл орон даяар хэрэгжсэн байна. Энэ арга хэмжээний хүрээнд 3000 багш интернэтээр мэргэжлээ дээшлүүлж, 2100 багш орчин үеийн сургалтын материалтай болж, 360 багш олон улсын сертификат авчээ.

Багш нарын ТХБ, байгаль, орчны боловсролыг дээшлүүлэх сургалтууд

Монгол Улс сургалтын үндэсний хөтөлбөрүүдийг боловсруулахдаа яамнаас ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйд суурилсан байх стратегийг баримталсан бөгөөд энэ стратегийг хэрэгжүүлэхэд ШХА-ийн “Цөлжилтийг бууруулах нь” хөтөлбөр томоохон хувь нэмэр оруулж, 2007-2009 онд үндэсний хөтөлбөр боловсруулагчдад олон цуврал сургалт явуулж, багш нарт зориулсан гарын авлагууд боловсруулан түгээсэн ажээ. Тогвортой хөгжил ба ТХБ-ын үзэл санаа, агуулга, арга зүйд суурилсан үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх багш нарт тэдгээрийн агуулга, ач холбогдолыг ойлгуулах, сургалтын арга зүйдээ бүтээлчээр

хэрэглэхэд нь зориулж Германы хамтын ажиллагааны нийгэмлэг нь “Байгаль Орчны Мэдээлэл Сургалт” хэмээх ТББ-тай хамтран 4 модуль бүхий сургалтын хөтөлбөр боловсруулж туршин, хэвлэж түгээсэн явдал нь багш нарт жижиглэсэн “ээлжит” бус, дидактик нэгжийг томсгосон “нэгж” хичээлд суурилсан сургалтын төлөвлөлт хийх, хөтөлбөрөө боловсруулах, арга зүйгээ шинэчлэх онол, арга зүйн үндсийг тодруулж өгсөн чухал ач холбогдолтой дэмжлэг болсон юм.

ТХБ болон байгаль орчны боловсролыг дэмжиж, цаг уурын өөрчлөлт, байгаль хамгаалах үйл ажиллагаанд багш, суралцагчдыг татан оролцуулах зорилготой төсөл хөтөлбөрүүдийг олон улсын болон хөгжилтэй орны Засгийн газрын хөгжлийг дэмжигч байгууллагууд БСШУЯ-тай хамтран хэрэгжүүлж ирсэн. Тухайлбал, ШХА-ын дэмжлэгтэй “Экосургууль”, ДБХС-ын дэмжлэгтэй “Ногоон сургууль”, Азийн сангийн дэмжлэгтэй “Голын ус болон хөрсний чанарын үнэлгээ” гэсэн төслүүд нь дээрх төслүүдийн загвар аймгийн сургуулийн багш сурагчдад орон нутгийнхаа байгаль орчны тулгамдсан асуудлыг төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэйгээ хамтран шийдвэрлэхэд манлайлан оролцох мэдлэг, чадвар, хандлагыг төлөвшүүлэхэд бодитой хувь нэмэр оруулсаар байна. Эдгээр төслийн хүрээнд анги танхимд эзэмшсэн мэдлэгээ асуудал шийдвэрлэх үйл ажиллагаандаа хэрэглэж сургах арга зүйг багш нарт зөвлөдөг юм. Эдгээр төслийн хүрээнд боловсрогдсон арга зүйн чиглэлийн 10 гаруй номыг багцлан бүх сургуульд түгээсэн нь ТХБ болон БОБ-ын чиглэлээр багш нар арга зүйгээ шинэчлэн сайжруулах тэгш боломжийг бүрдүүлсэн байна.

Кембрижийн сургалтын хөтөлбөрийг судлах, турших үеийн арга зүй (2010-2017)

Боловсролын чанарыг олон улсын жишигт хүргэж, хүлээн зөвшөөрүүлэх зорилтын хүрээнд 2009 оноос эхлэн БСШУЯ-наас Олон улсын Кембрижийн хөтөлбөрийг Монголын нөхцөлд тохируулан хэрэгжүүлэх боломж нөхцөлийг туршин тогтоох ажил эхэлж, 2011 оны 04 дүгээр сарын 13-ны өдөр “Монгол Улсын ЗГ болон КИС-ийн Олон улсын шалгалтын төвийн хооронд бага, дунд боловсролын стандарт, хөтөлбөрийг шинэчлэх талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичиг” байгуулагдсан байна. Олон улсын Кембрижийн хөтөлбөрийг шууд хэрэгжүүлдэг, хос хэлний сургалттай 3 сургууль 2011 оноос Улаанбаатарт хичээллэж эхэлсэн. Мөн математик, байгалийн ухаан (физик, хими, биологи), англи хэлний хичээлийн хөтөлбөрийг олон улсад нийцүүлэн боловсруулах мэргэжлийн баг байгуулж ажиллуулснаар 1-10 дугаар ангид судлах эдгээр хичээлийн хөтөлбөрийг 2011-2012 онд боловсруулж

батлуулсан. Эдгээр хөтөлбөрийг туршин хэрэгжүүлэх нийт 31 лаборатори сургуультай болсон.

“Хичээлийн судалгаа”-ны арга зүй (2007-2012)

БСШУЯ, Япон улсын ЖАЙКА байгууллагатай хамтран Японы Засгийн газрын буцалтгүй тусламжийн дэмжлэгтэйгээр 2007-2009 онд “Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйн хөгжил”, 2010-2012 онд “Багшлах шинэ арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” нэртэй 2 шаттай төсөл хэрэгжсэн.

Хичээлийн судалгаа нь зөвхөн улсдаа олон жилийн өв түүхтэй төдийгүй өнөөдөр дэлхийн олон улсад багшийг ажлын байранд нь тасралтгүй хөгжүүлэх шилдэг арга механизм болон хурдацтай хөгжиж байна. “Хичээлийн судалгаа”-нд суурилсан багшлах үйлийн хөгжлийн менежмент Монгол Улсад мөрдөж буй эрх зүйн актуудаар баталгаажсан багшийн ажлын шинэ агуулга, бүтэц, нэгж, ажлын байрны тодорхойлолт, ажлын төлөвлөлт, үнэлгээ, дүгнэлт, цалин хөлс урамшууллын тогтолцооны харилцан зохицолдоо нийцэл нь дээрх төслийн хүрээнд багшлах үйлийн нэгдсэн шинэ арга зүйг боловсруулан хөгжүүлэх таатай боломжийг олгосон юм (Нэргүй, ...).

Эхний төсөлд МУИС, МУБИС-ийн сургалт, судалгааны 4 төвийн 70 орчим судлаачид (профессор, доктор, магиструуд) тодорхой сэдвээр ээлжит болон нэгж хичээлийн жишээн дээр хичээлийн судалгаа хийх арга зүйг боловсруулж, Токиогийн Гакүгэй багшийн их сургуулийн профессор 10 гаруй багш нар зөвлөн тусалж, Улаанбаатар Дорнод, Сэлэнгэ аймгийн 9 сургуулийн багш хамтран туршиж сайжруулсан.

Хоёр дахь төслийг БСШУЯ нь ЖАЙКА-тай хамтран 2010-2012 онод “Багшийн хөгжлийн арга зүйг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх” төслийг хэрэгжүүлсэн. Энэ төсөлд Завхан, Булган аймаг, нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн нийт 14 сургууль загвар аймаг, сургуулиар сонгогдож, “Хичээлийн судалгаа” хийх замаар багшлах арга зүйгээ хөгжүүлэх менежментийг өөрийн аймаг, дүүргийн төдийгүй загвар бус аймгийн сургуулиудад түгээн дэлгэрүүлэх ажиллагааг хэрэгжүүлсэн. Энэ төслийн гол зорилго нь их, дээд болон ерөнхий боловсролын сургуулийн багш нарын хамтран боловсруулсан олон шинэ арга зүйгээр сургалтын шинэ шинэ модуль боловсруулж, үндэсний хэмжээнд сургалтууд зохион байгуулсан. Хоёр шатны төслийн хүрээнд багш, мэргэжилтнүүдийг Япон, Индонез улсын туршлага судлах, япон мэргэжилтнүүд

Монголд ирж туршлага хуваалцах, зөвлөгөө өгөх, сургалт зохион байгуулах, хяналт-шинжилгээ хийх зэргээр хамтран ажилласан байна.

Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2008 оны 72-р тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”- д заасан багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг эхлэн зохион байгуулах шаардлага гарсан. Үүний тулд БСШУЯ-аас 2010-2012 оны багшийн мэргэжил дээшлүүлэх хэрэгцээний судалгааг аймаг, нийслэлээс авч, ойрын 3 жилийн сургалтын төлөвлөлт, зураглал хийх, сургалтын хөтөлбөр боловсруулах, сургалтыг зохион байгуулах бэлтгэл ажил хангасан байна. Журмыг эхлэн хэрэгжүүлэхдээ үндсэн сургалтад эхний жилдээ болон 5 жилдээ ажилласан багш нарыг эхлэн хамруулах бодлого баримталсан. Учир нь 2009-2010 оны хичээлийн жилийн байдлаар нийт багш нарын гуравны нэг гаруй нь эхний тав, зургаан жил ажилласан туршлага багатай багш нар байсан тул тэдэнд боловсролын стандарт, ТХБ-ын үзэл санаанд суурилсан үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйд нь дэмжлэг үзүүлж, улмаар ажлын байрандаа хөгжих үндэс суурийг тавихыг зорьсонтой болбоотой.

БСШУЯ нь 2010, 2011 онд Боловсролын хүрээлэнтэй “Бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээ” байгуулсны дагуу 72-р тушаалаар батлагдсан мэргэжил дээшлүүлэх журмыг хэрэгжүүлж, үндсэн сургалтыг зохион байгуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Тухайлбал, 2010 онд ерөнхий боловсролын сургуульд тав дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг монгол хэл, математик мэдээлэл зүй, байгалийн ухаан, хөгжим, зураг технологи, түүх нийгмийн ухаан, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 чиглэлээр Улаанбаатар, Ховд, Архангай гэсэн 3 бүсэд тус бүр 7 хоногийн хугацаагаар зохион байгуулсан. Эдгээр сургалтад нийт 847 багш хамрагдаж, улсын төсвөөс 202,0 сая төгрөг зарцуулсан байна. 2011 онд нийт 9 удаагийн 41 сургалтад цэцэрлэгийн 205, ерөнхий боловсролын сургуулийн 1242, нийт 1447 багш хамрагдаж, улсын төсвөөс 320.5 сая төгрөг зарцуулжээ.

“Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-д заасан сургууль, багш нарын тусгай хэрэгцээ буюу тэдний эрэлтэд суурилсан кредит олгох төрөлжсөн сургалтууд 2008-2012 онд тасралтгүй зохион байгуулагдаж ирсэн. Энэ төрлийн мэргэжил дээшлүүлэх сургалт нь үйлчлүүлэгчийн тусгай хэрэгцээнд баримжаалсан, үйлчлэгч талуудыг сонирхол, оролцоонд тулгуурласан үйлчилгээний зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн нээлттэй байх зарчим, чанарын

төлөөх шудрага өрсөлдөөний зарчмыг тус тус боловсролын үйлчилгээнд нэвтрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх зориулалттай байлаа. Сургалтын чанар, үр өгөөжийн баталгааг хангах үндсэн нөхцөлийн нэг болгон кредит олгох төрөлжсөн сургалтын хөтөлбөрт БСШУЯ-аас томилогдсон экспертийн баг магадлан шинжилгээ хийж, түүнд үндэслэн БСШУ-ны сайдын зөвшөөрлөөр сургалт явуулах эрхийг нээж, сертификатын олголтод бүх нийтээрээ хяналт тавих боломж олгон нийтэд мэдээлэгддэг болсон. 2009-2012 онд кредиттэй төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийсэн байдлыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 18. Сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

Он	Хөтөлбөр ирүүлсэн байгууллагын тоо	Ирүүлсэн хөтөлбөрийн тоо	Зөвшөөрөгдсөн хөтөлбөрийн тоо	Сайдын тушаалын огноо, дугаар
2009	25	175	83	2009 оны 179
2010	32	177	86	2010 оны 244
2011	30	211	66	2011 оны 262
2012	45	180	106	2012 оны 320

Энэ төрлийн сургалтын зардал нь төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, сургуулийн үйл ажиллагааны орлого болон оролцогчдын сургалтын төлбөрөөс тус тус санхүүжигддэг онцлогтой.

Монголын боловсрол судлалын шинэчлэл, өөрчлөлт

Монгол Улсын боловсролын 1990-ээд оны ээлжит шинэчлэл, өөрчлөлтийн урьдач нөхцөл, бас түүний нэг үндсэн хэсэг нь өнгөрсөн жилүүдэд Монголын боловсрол судлалд гарсан хөгжил дэвшил байлаа. Энэ үйл явцад үнэлэлт, дүгнэлт өгөх нь бие даасан том судалгааг шаардах боловч Монгол Улсын боловсролын их тогтолцооны сүүлийн 25 жилийн хөгжилд боловсрол судлалын оруулсан хувь нэмрийг тоймлон үзүүлж, түүний хөгжлийн хүрсэн түвшин, цаашдын хандлага, төлөвийг тодорхойлох, цаашид өргөжүүлэн гүйцээж гаргах нь цаг хугацааны асуудал болно.

Манай орны сурган хүмүүжүүлэгч эрдэмтдийн ахмад үеийнхэн эх орондоо орчин цагийн сургуулийн системийг ХХ зууны эхнээс үүсгэн хөгжүүлэхдээ түүний судалгааны үндсийг зэрэг тавьж өгсөн байдаг. Тэр үеийн Монгол Улсын боловсролын үзэл баримтлал, онол сургаал нь Энэтхэг, Түвд, Хятадаас эхтэй Ази, дорно дахины болон Орос Зөвлөлтөөр дамжин орж ирсэн европын боловсролын хөгжлийн онол, сургаалын аль алинд нь суурилсан гэж үзэж болно. Аливаа шинэ юм бүхэн өмнөх хуучны үргэлжлэл, түүний хөгжлийн үр дүн байдгийн адилаар 1990-ээд оноос хойших манай үеийнхний боловсролд хандах шинэ хандлага, үзэл санаа нь гэнэтхэн, цоо шинээр, нүцгэн цулгуй газар дээр өөрөө урган цэцэглэсэн хэрэг биш юм. Тэдгээрийн урьдач нөхцөл нь нэг талаас

Я.Коменский, Ж.Ж.Руссо, К.Маркс, Ф.Энгельс, А.Дистервег, К.Д.Ушинский, В.И.Ленин, Н.К.Крупская, А.С.Макаренко, Л.С.Выготский, О.Мур, Г.Песталоцци, Жон Дьюи, Г.Н.Волков, Ю.К.Бабанский зэрэг европ, америк зүгийн боловсролын онолчдын сургаал, бүтээлийн үзэл санаа байсан юм.

Бидний болон бидний өмнөх үеийнхэн түүхэн бодит шалтгааны улмаас Ази, дорно дахины боловсрол, соёлын өвөөс 1930-аад оноос хойш нэг хэсэгтээ таслагдсанаар 1990-ээд оныхны боловсролын хөгжлийн үзэл баримтлал төлөвшихөд ийнхүү европ төвийн үзэл голлон нөлөөлөв. Харин 1970-1980-аад оны үеийн ЗХУ-ын шинэчлэгч багш нарын бүтээл, санаачилга нь манай тэр үеийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн дунд шинийг эрэлхийлэх хэрэгцээг бий болгож, төлөвшүүлэхэд хүчтэй түлхэц болсон байна.

Монгол хүн төлөвшлийн асуудлаар манай орны ахмад үеийн эрдэмтдийн бүтээлүүд шинэ үеийнхний сурган хүмүүжүүлэх үзэл санаа төлөвших үнэтэй суурь дэвсгэр болов. Мөн гавьяат алдарт, бүтээлч багш нараас манай оронд тодорхой хичээлийн заах аргыг хөгжүүлэхэд их хувь нэмэр оруулсныг тэмдэглэх хэрэгтэй.

Боловсролын хэвлэл, мэдээллийн байгууллагууд, тэнд ажиллаж байсан бүтээлч, судлаач ажилтан нарын олон жилийн хөдөлмөр, зүтгэлийн үр дүнд дэлхийн олон улсын боловсролд гарч байсан шинэчлэлийн мэдээлэл, өөрийн орны шилдэг сургууль, багш нарын тэргүүн туршлагыг монголын нийгэмд сурталчилж, өөрсдөө шинэ санаа сэдсэн материал бичиж нийтэлдэг байсан нь өнөөгийн үеийнхний үзэл бодол төлөвшихөд мөн үнэтэй суурь, дэвсгэр болсон юм.

Монгол хүний хөгжил, төлөвшлийн асуудлаарх доктор эрдэмтдийн судалгаа нь ХХ зууны эцэст боловсролын шинэ үзэл санаа, хандлага төлөвшихөд үнэтэй хувь нэмэр, урьдач нөхцөл болов.

Манай улсад 1958 оноос хойш 2017 он хугацаанд боловсрол судлалын олон салбараар философийн доктор (дэд эрдэмтэн, дэд доктор)-ын зэргийг 300 гаруй хүн хамгаалаад байгаа юм. Үүний дотроос хамгийн олон хүн боловсролын онол, түүхээр, тодорхой хичээлийн заах аргаар, боловсролын түүх, сургалтын сэтгэц судлалаар хамгаалжээ. Харин монгол хүүхдийн хөгжлийн судалгаа, монгол хүүхдийн сурах чадварын судалгаа бараг хийгдээгүй байна.

Монгол Улсын боловсролын судалгаанд 1970-аад оны эцсээр хамгаалж эхэлсэн шинжлэх ухааны доктор (доктор)-ын зэрэг горилсон судалгааны ажлууд чухал байр эзэлдэг юм. 1970-1980-аад онд хийгдсэн сурган хүмүүжүүлэх ухааны

докторын диссертацийн судалгаанууд голчлон ЕБС-ийн сургалтын агуулга, аргазүйн асуудлаар багш талаасаа харж хийгдсэн бол 90-ээд оноос эхлэн боловсролын их тогтолцооны элемент, бүрдлүүдийн судалгаанд нэлээд анхаарах болсон байдал харагдаж байна. Дурдан буй хугацаанд сурган хүмүүжүүлэх ухаан, заах аргын асуудлаар судалгаа хийж байсан ихэнх судлаач эрдэмтэдийн бүтээл, тэргүүний багш нарын хөдөлмөр зүтгэл нь багш төвтэй сургалтыг социалист сурган хүмүүжүүлэх ухааны онол, сургаалийн хүрээнд боловсронгуй болгоход чиглэж, түүний заах аргыг улам төгөлдөржүүлэх зорилгоор хийгдсэн байна.

Манай оронд 1980-аад оны дунд үеэс эхэлсэн нийгмийн өөрчлөн байгуулалтын нөлөөгөөр, өмнөх нийгэмд үйлчилж байсан социалист агуулгатай боловсрол шинэ хэрэгцээг хангахгүй болж, түүний шинэ хэрэгцээ богино хугацаанд бүрэлдэн буй болов. 1990-ээд оны эхний хэдэн жилд нийгэмд нүүрлэсэн хямралын нөлөөгөөр манай улсад боловсрол нь хэрэглэгч талаасаа үнэгүйдэж, үйлчлэгч талаасаа эзэнгүйдэх хандлагатай болж, үүнээс үүдэн төр ба иргэдийн зүгээс боловсролын агуулга, аргазүй, зохион байгуулалтын шинэ хэлбэрүүдийг эрж хайхад хүрэв. Судлаачдын үзэж байгаагаар тэдгээр хямралын жилүүдэд манай орны боловсролын систем задралын өмнөх төлөв байдалд орсон шинж байдал ажиглагдаж байжээ⁹.

Хэдийгээр эдгээр он жилүүдэд боловсролын шинэ тогтолцооны төлөвшлийг хангах зорилгоор түүний эрх зүйн орчныг ойр ойрхон шинэчилж, 1991, 1995 онд Боловсролын хуулийг багцлан шинэчилж байсан ч хүүхдийн сургууль завсардалт урьд хожид дуулдаагүй хэмжээнд хүрч, сургууль санхүүжилтгүй, багш нар цалингүй болж, сургуулиуд урт богино хугацаагаар хаагдан, боловсролын удирдлагын урагшгүй, хөшүүн байдалд цөхөрч бухимдсан багш нарын ажил хаялт олон хоног, сараар үргэлжилж байв. Бага, дунд боловсролын хүрээнд сургалтын нэгдмэл агуулга үндсэндээ алдагдаж, сургалтын зохион байгуулалтын шинэ шинэ хэлбэрүүдийг хүссэн хүн дуртай газраа дураараа бий болгон турших оролдлого хавтгайрах янзтай болсны цаад талд шинэ нийгмийн эрэлтэд нийцсэн боловсролын шинэчлэлийн үйл явц явж байсан байна.

Социалист боловсролын онол, сургаалиар олон жил явсан орны хувьд монголын боловсролыг дэлхийн олон улсын нийтлэг жишигт нийцүүлэн хөгжүүлнэ гэхэд 90-ээд оныхонд сонсож мэдээгүй, үзээгүй хараагүйн зовлон алхам тутамд

⁹ Y.C.Kim, Y.K.Han, S.H.Choi, Begz.N, Bandii R. A Study on Mongolian Educational System: An Ananalysis and Its Tasc for Future Development. KEDI, 1995

тохиолдож байлаа. Боловсролдоо шинэчлэлт, өөрчлөлт хийсэн энэ 25 жилд гаднаас сурах, өөрсдөө олж нээхийн баяр баясгалан, алдаж онохын харуусал, цөхрөлийн аль алиныг амсаж, өнөөдрийн өдрийг хүрсэн ч тэдэнд оносон, олсон нь алдаж эндсэнээсээ хавьгүй илүү байлаа.

Шинэ Монгол Улс бий болж, Үндсэн хуулиа баталснаас хойших энэ 25 жилийн эрэл хайгуулын үр дүнд монголын боловсрол судлаач эрдэмтдийн шинэ үе төрөн гарав. Тэд Монголын боловсролын шинэ тогтолцоог нийгмийн амьдралын нийт том орон зайгаар төсөөлж, түүний формаль ба формаль бус хэлбэрийг ялган салгаж, сургалтын олон хэлбэр, хэв шинжийг хуульчлан бататгаж, хөгжлийнх нь үзэл баримтлалыг бий болгоход хүчин зүтгэж эхлэв.

Эдгээр эрдэмтэн судлаачид, удирдах ажилтан нар болон сургууль, боловсролын байгууллагыг шинэ үзэл хандлагаар байгуулж, хөгжүүлэн авч яваа багш, сурган хүмүүжүүлэгчдийн хөдөлмөр, зүтгэлийг болон өнгөрсөн хугацаанд энэ салбарын үйл ажиллагаанд гарсан гажуудал, завхарлын шалтгаан, үр дагаварыг ултай шинжлэж, боловсролын түүхэнд үнэн зөвөөр тэмдэглэн үлдээж, зохих байрыг нь эзлүүлэх, үйл ажиллагаанд нь бодитой үнэлэлт, дүгнэлт өгч, түүнээс түүхэн сургамж авах нь энэ ба хойт үеийнхний судлаачдын хүндтэй, хариуцлагатай үүрэг болж тавигдаж байна.

Аливаа орны боловсролын системд хийгдэж байгаа өөрчлөлтийн эх сурвалж, хөдөлгөгч хүч нь нийгэмд гарч байгаа боловсролын шинэ эрэлт байх ба түүнийг урьдчилж ухаж мэдэрсэн хүмүүсийн оюун санаанд гарч байгаа шинэлэг үзэл санаа байдаг. Зөвлөлтийн боловсролын загвараас социалист гэгдэж байсан орнууд, дараахнаар нь оросууд өөрсдөө татгалзаж эхэлсэн тэр үед дэлхийн олон орны боловсролын хөгжлийн нийтлэг хандлагад нийцсэн Монголын боловсролыг шинэчлэх энэ шинэ үзэл санаа манай орны боловсрол судлаач эрдэмтдийн оюун санаанд 1990-ээд оны эхний жилүүдэд зарим талаар бүрэлдэж, нийгэм олон түмэнд мэдрэгдэж эхэлсэн байсан гэж үзэж болохоор байна.

1990 оны 5 дугаар сарын 16-нд АБЯ-ны дэргэд байгуулагдсан Мэргэжлийн боловсролын арга зүй, судалгаа-ны Төвийн эрдэмтдийн бүтээл, уг Төвөөс эрхлэн гаргаж байсан *Мэргэжлийн боловсрол (1990-1995)*, *Боловсрол судлал (1995-1999)* судалгаа, аргазүйн цувралуудад нийтлэгдэж байсан асуудал дэвшүүлсэн өгүүллүүд, онол, аргазүйн материалуудыг өнөөдөр сөхөж үзэхэд боловсролыг зөвхөн албан боловсролын хүрээнд, сургуульчлан ойлгох хандлагаас татгалзаж,

түүнийг нийгмийн том орчинд авч үзэх хандлага манай зарим эрдэмтдэд төлөвшсөн байсан нь харагдаж байна¹⁰.

1991 оны 2-р сард байгуулагдсан Боловсролын хүрээлэн уг шинэ хандлагыг буухиалан авч үргэлжлүүлсэн юм. Дээрх *Мэргэжлийн боловсрол (1990-1995)*, *Боловсрол судлал (1995-1999)* цувралуудын загвар жишгээр Боловсролын хүрээлэнгээс хэсэгхэн хугацаанд гаргасан *Ерөнхий боловсрол* нэртэй эрдэм шинжилгээ, арга зүйн цувралд ч энэ үзэл санаа уламжлагдан үргэлжилсэн байна. Энэ шинэ үеийн Монголын нийгэм, эдийн засгийн хөгжлийн эх булаг нь олон улсын нийтлэг жишигт нийцсэн, өөрийн үндэсний онцлог бүхий XXI зууны шинэ боловсрол байх тул түүний ирээдүйн хөгжилд ихээхэн ач холбогдол өгч, хөгжлийнх нь зүй тогтлыг урьдчилан судлаж тодорхойлох нь боловсролын төдийгүй улс орны хөгжлийн тулгамдсан асуудал байсан юм¹¹.

Дэлхийн социалист систем 1992 оноос оршин тогтнохоо больж, ЗХУ задарч, түүний бүрэлдэхүүнд байсан 15 Бүгд Найрамдах улс тусгаар хамтын нөхөрлөлийн орнууд гэх нэртэйгээр салан тусгаарлав. Дал шахам жил Зөвлөлт, оросын соёлын нөлөөнд байж, оюун санааны хувьд “пролетарийн интернационализмын” зарчмаар амьдарч байсан монголчуудын дунд ч үндэсний соёл, дэвшилтэт уламжлалаа сэргээх хөдөлгөөн өрнөв. Түүний нэг илрэл нь боловсролын салбар дахь монгол туургатан ард түмнүүдийн хамтын ажиллагааг бий болгох, харилцан ойртох явдал байлаа.

Энэ үед Боловсролын хүрээлэнгээс эрхлэн, 1992 онд “Монгол туургатны сурган хүмүүжүүлэгч эрдэмтдийн олон улсын анхдугаар уулзалт” нэрээр боловсрол судлаач монголч эрдэмтдийн хүчийг нэгтгэх арга хэмжээг анх удаа зохион байгуулав. Үүний хүрээнд “Монгол ардын сурган хүмүүжүүлэх уламжлал ба орчин үе” сэдэвт олон улсын эрдэм шинжилгээний бага хурлыг 1992 оны 9-р сарын 2-4-нд Улаанбаатар хотноо хуралдуулав. Уг арга хэмжээнд ОХУ-ын Халимаг, Буриад, БНХАУ-ын Өвөр Монгол, Шинжиан-Уйгарын өөртөө засах орон, БНСУ-ын төлөөлөгч илтгэл тавьж оролцсон юм. Солонгосын төлөөлөгчөөр KEDI-ийн дэд ерөнхийлөгч Монголд ирж олон улсын хуралд оролцсон нь Монгол-Солонгосын боловсролын хамтын ажиллагааны эхийг тавилцсан хэрэг байлаа.

Тэр үед доктор Б.Энхтүвшин, Н.Бэгз, Д.Ванчигсүрэн, С.Ламбаа, Р.Бандий, Д.Бадарч, Б.Чулуундорж зэрэг эрдэмтэд дээд боловсролын шинэчлэлийн

¹⁰ Боловсрол өнөөдөр. Боловсролын хүрээлэн. УБ, 1991, 16-18-р тал.

¹¹ Бэгз Н. 1996. Боловсролын онол, аргазүйн зарим асуудал. УБ, 155-р тал.

асуудлаар “Мэргэжлийн боловсрол” цувралд илтгэл, өгүүллүүд нийтлүүлж байв. Ерөнхий дунд боловсролын өөрчлөлт, шинэчлэлтийн асуудлаарх З.Өлзийхутаг, Д.Монхор, Г.Содномваанчиг, О.Пүрэв, Б.Жадамба, Д.Баттогтох, С.Батхуяг, Н.Нэргүй нарын бүтээлүүд, Монгол Улсад албан бус боловсролыг үүсгэн хөгжүүлэх талаар бичиж хөөцөлдөж байсан Х.Дүгэрийн санал санаачлагууд амьдралд хэрэгжиж эхэлж байв.

Доктор О.Мягмар, Б.Туяа, Л.Уранцэцэг, Ж.Батдэлгэр, Г.Бадамхатан нарын зэрэг сургалтын сэтгэл судлаачдын судалгаа, Г.Батхүрэл, Р.Бандий, Ч.Пүрэвдорж зэрэг эрдэмтдийн боловсролын удирдлага, эдийн засгийн хүрээний асуудлууд, Т.Намжилын үүсгэж хөгжүүлж байсан монгол гэр бүлийн судалгаа, Д.Нямжав, түүний шавь нарын гадаад хэлний сургалтын дидактик асуудлууд нь өөр өөрийн орон зайтай, судлаачтай, сонирхон дэмжигчидтэй болж байлаа.

Эрх зүйн орчны шинэчлэлийн хүрээнд тэр жилүүдэд Монгол Улсын боловсролын хөгжлийн шинэ хандлагын хүрээний асуудлаар олон тооны сонирхолтой судалгааны ажил хийгдэв. Зах зээлд шилжих үеийн монголын дээд сургуулийн менежментийн загвар боловсруулж турших асуудлаар Д.Оюунхорол, Г.Батхүрэл¹², Ц.Ганбат¹³ нар, монголын боловсролын шинэчлэлийн менежментийн асуудлаар Ж.Нарантуяа¹⁴, Б.Сүхээ зэрэг хүмүүс диссертацийн ажил бичиж хамгаалав. Боловсролын эдийн засгийн шинэ дэд тогтолцоо бүрдүүлэх үйл явцын асуудлаар Л.Болдбаатар¹⁵, Б.Оюунцэцэг, Э.Эрдэнэчимэг, Юн Сүн Жэ¹⁶, А.Хандмаа¹⁷ нарын зэрэг олон эрдэмтэд судалгаа хийжээ.

Боловсролын чанар ба монголын хүний хөгжлийн хамаарлын асуудлаар С.Санжаабадам¹⁸ докторын ажил бичиж, боловсролын эцсийн үр дүнг боловсролтой хүн нийгмийн орчинд амьдралаа хэрхэн авч яваа байдлаар үнэлэх ёстой гэдэг санааг манай улсад анх түрүүлэн дэвшүүлэв. Дээд боловсролын чанарын судалгааг А.Баярмаа, Э.Эрдэнэчимэг нар үргэлжлүүлэв.

Монголчуудын боловсролын шинэ үеийн философи үндэслэлийг тодорхойлох асуудлаар Ц.Бүжидмаа¹⁹, Монгол Улсын боловсролын тогтолцооны социологийн асуудлаар Д.Зоригт, Б.Баярцэцэг²⁰, О.Сарантуяа нар, ерөнхий дунд боловсролын

¹² Батхүрэл Г. Шаталсан сургалтын технологи нэвтрүүлэх удирдлагын зарим асуудал. УБ, 1997.

¹³ Ганбат Ц. Кредит систем нэвтрүүлэх удирдлагын асуудлууд. УБ, 2000

¹⁴ Нарантуяа Ж. Боловсролын мэргэшсэн менежер бэлтгэх асуудалд. УБ, 2000

¹⁵ Болдбаатар Л. Дээд боловсролын байгууллагын санхүүгийн менежментийг боловсронгуй болгох зарим асуудал. УБ, 2003.

¹⁶ Юн Сүн Жэ. Монголын хувийн их дээд сургуулийн санхүүгийн удирдлагын зарим асуудлын судалгаа. УБ, 2008. 127х.

¹⁷ Хандмаа А. Дээд боловсролын байгууллагын хүний нөөцийн менежментийн шинэчлэлийн зарим асуудал. УБ, 2010.

¹⁸ Санжаабадам .С. Боловсролын чанар ба монголын хүний хөгжлийн хамаарал. УБ, 2000.

¹⁹ Бүжидмаа Ц. Монголын боловсролын философийн хөгжлийн судалгаа. УБ, 2001.

²⁰ Баярцэцэг. Б. Багшийн сургалтын ажлыг социологийн аргаар үнэлэх аргазүй. 2003.

эрх зүйн үүсэл, хөгжил, шинэчлэлийн асуудлаар Ц.Гэлэгжамц²¹, У.Туяа, Монгол Улсын боловсролын түүхийн асуудлаар Ш.Шагдар, Б.Батсайхан зэрэг хүмүүс судалгаа хийж, бүтээл гаргав.

Багшийн хөгжлийн асуудлаар Б.Жадамба, Н.Туул, Б.Түмэндэмбэрэл, Монгол Улсын бага, дунд боловсролын сургалтын агуулгын стандарт тогтоох, түүнийг цаашид боловсронгуй болгох судалгааг Г.Содномваанчиг, Ц.Дорж, Ж.Батдэлгэр, Б.Бурмаа, Н.Нэргүй, Ц.Лувсандорж, Д.Хөхөө зэрэг эрдэмтэд хийж, түүний үзэл санаагаар бага, дунд боловсролын стандартыг шинэчлэн сайжруулах судалгааг 2000-2004 онд хийж гүйцэтгэв.

Монголын сургуулийн өмнөх боловсролын сургалтын агуулгыг оновчтой тогтоох, 6-7 настны сурах чадварыг тодорхойлох судалгаа эрдэмтдийн сонирхлыг стэр жилүүдэд нэлээд татах болж, хэд хэдэн судалгааны ажил хийгдэв. Д.Энхтуяа, Н.Норжхорлоо, Г.Бадамхатан, Ц.Цовоо, Ц.Нацагдолгор нар сургуулийн өмнөх боловсролын тогтолцоог шинэчлэхэд болон өсвөр насныхны төлөвшлийн асуудлаар чухал ач холбогдол бүхий судалгааны ажлууд хийж, нийтийн хүртээл болгожээ.

Доктор Л.Туяа²² сурах бичгийн шинжилгээний аргазүй, түүний үнэлгээний системийг боловсруулав. Энэ чиглэлээр сүүлийн жилүүдэд хэд хэдэн судлаач судалгаа хийж, докторын зэрэг хамгаалав.

Гадаад хэлний сургалт 1990-ээд он болтол бараг дан ганц орос хэлний сургалтын асуудал шахам байдаг байв. МУИС-д англи, франц, япон, түвд хэлний сургалт байсан ч нэг их нийтийг хамарсан том асуудал болж чаддаггүй байлаа.

Харин 1992 оны шинэ Үндсэн хуулийн үзэл санаагаар монголын гадаад харилцаа эрчимжиж, иргэд чөлөөтэй гадаадад зорчдог болсонтой холбоотойгоор гадаад хэлний сургалт маш эрчимтэй хөгжив. Иймээс сүүлийн 20 гаруй жилд хийгдсэн докторын түвшний судалгаанд гадаад хэлний сургалтын онол, аргазүйн асуудал чухал байр эзлэх болов. Англи, орос хэлний сургалтыг боловсронгуй болгох, монгол хүнд англи хэл заах аргазүй, үнэлгээг төгөлдөржүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулах асуудлаар Ц.Оюунсүрэн, Д.Алтанцэцэг, Б.Нансалмаа, Ж.Амаржаргал, Ц.Үрэлмаа²³, С.Эрдэнэчимэг, Ц.Бурмаа²⁴ нарын зэрэг хүмүүс судалгаа хийж хамгаалжээ.

²¹ Гэлэгжамц Ц. Монголын ерөнхий дунд боловсролын эрх зүйн зохицуулалтын хөгжил, шинэчлэл. УБ, 1999.

²² Туяа Л. Гадаад хэлний сурах бичгийн шинжилгээний аргазүйн зарим асуудал. УБ, 2005, 89х.

²³ Үрэлмаа Ц. Англи хэлний сургалтыг эрчимжүүлэх аргын нэгэн хувилбар. 2008

²⁴ Бурмаа Ц. Суралцагчдад англи хэлээр уншиж ойлгох чадвар эзэмшүүлэх аргазүйн судалгаа. УБ, 2011.

Энд дурдсан судалгаанууд нь үзэл суртлын цензур, намын хяналтаас чөлөөтэй байж, судлаачийн байр сууринаас, шинэ нийгмийн эрэлт хэрэгцээг үндэслэн хийгдсэн сайн бүтээлүүд болсон бөгөөд монголын боловсролыг олон улсын нийтлэг жишигт ойртуулахад чухал хувь нэмэр болсон ажлууд юм.

Шинэ Монгол Улсын боловсролын түүхийн эхний 25 жилийн хугацаанд манай улсад боловсрол судлалын шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан 9 ажил хийгдсэн юм. Ч.Пүрэвдорж шинэ зууны боловсролын хөгжлийн хандлага²⁵ (2000), Д.Нямжав монгол оюутны танин мэдэх үйл ажиллагааг орос хэлний сургалтаар идэвхжүүлэх²⁶ (2001), Н.Бэгз Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргагүйн үндсэн асуудлууд²⁷ (2001), Ш.Шагдар Монголын боловсролын түүхийн асуудлууд²⁸ (2002), Х.Дүгэр Монголын албан бус боловсролын тогтолцооны судалгаа²⁹, Ц.Содов мэргэжлийн боловсрол, сургалтын зохион байгуулалт³⁰, (2002), Б.Жадамба сургуулийн хөгжлийн онол, туршлагын судалгаа³¹ (2003), О.Пүрэв XXI зууны монголын түүх, нийгмийн ухааны боловсролын онол, арга судлалын асуудлууд³² (2003), Ц.Оюун монгол хэлний сургалтын дидактик³³, Д.Мөнхбаяр зураг, загварчлалын чиглэлээр (2013) тус тус шинжлэх ухааны докторын зэрэг хамгаалсан судалгаа хийв.

Эндээс үзэхэд боловсрол судлалын шинжлэх ухааны докторын сүүлийн жилүүдийн судалгаа албан ба албан бус боловсролын тогтолцооны ирээдүйд илүүтэй чиглэсэн хандлагатай болж, судалгаанд систем шинжилгээний арга голлох болсон байна.

Сүүлийн жилүүдэд их сургуулиудын сургалтад болон бие дааж хийж байгаа судалгаа, сургалтын бодлогод боловсрол судлал зохих хэмжээгээр байр сууриа эзлэж, нийгмийн анхаарал илүүтэй татах боллоо.

Боловсролын магадлан итгэмжлэл

Монгол Улсын улс төр, нийгэм, эдийн засгийн бүх хүрээг хамарсан өөрчлөлтийн нэгэн хэсэг нь боловсролын салбарт хийгдсэн өөрчлөлт билээ. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үед улс төрийн нэгэн намын дангаар захиран жолоодох үүрэг ролийг шүүмжлэн хэлэлцэж, удирдлагын бүх шатанд ил тод байдал,

²⁵ Ч.Пүрэвдорж. Шинэ зууны боловсролын хөгжлийн хандлага: онол, аргагүйн судалгаа, боловсруулал.2000.

²⁶ Д.Нямжав. Хэлний бус ангийн монгол оюутны танин мэдэх үйл ажиллагааг орос хэлний сургалтаар идэвхжүүлэх нь. 2001.

²⁷ Н.Бэгз. Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргагүйн үндсэн асуудлууд. 2001.

²⁸ Ш.Шагдар. Монголын боловсролын түүхэн хөгжлийн зарим асуудал. 2002.

²⁹ Х.Дүгэр Монголын албан бус боловсролын тогтолцооны судалгаа. 2002.

³⁰ Ц.Содов мэргэжлийн боловсрол, сургалтын зохион байгуулалт, аргагүйн үндэс. 2002

³¹ Б.Жадамба сургуулийн хөгжлийн онол, туршлагын судалгаа. 2003

³² О.Пүрэв XXI зууны монголын түүх, нийгмийн ухааны боловсролын онол, арга судлал 2003

³³ Ц.Оюун. Монгол хэлний дидактикийн онол, аргагүйн асуудлууд. 2004

холбогдох талуудын оролцоо санаачилгыг баталгаажуулан хүний эрхийг төвд нь тавьсан систем бүрдүүлэх эрэл хайгуул эрчимтэй өрнөж байв. 1991 оноос манай улсад анхны хувийн хэвшлийн сургалтын байгууллагууд үүсэн байгуулагдаж, сургалтын тоо эрс өсч, сургууль мэргэжлээ сонгон суралцах боломж цоо шинээр нээгдсэн нь энэ салбарт сургалтын байгууллагын үйл ажиллагаа, чанарт, хөндлөнгийн хараат бус чанарын баталгаажуулалт хийж магадлан итгэмжлэх шаардлагыг бий болгосон юм.

Мөн боловсролын байгууллага, үйлчилгээ либералчлагдаж, боловсрол дахь төрийн монополь задарч, өмчийн олон хэвшилтэй болохын зэрэгцээ хэмжээний хувьд тэлж, сургах мэргэжлийн чиглэл, төрөл олширч эхэлснээр суралцагчдын эзэмших боловсролын чанар, нийцийг хянах баталгаажуулах тогтолцоог шинэчлэн бүрдүүлэх шаардлага тавигдсан юм.

Энэ шаардлагыг соргоогоор мэдэрсэн тухайн үеийн төр, засаг 1995 оноос эрх зүйн орчныг нь бүрдүүлсэн, 1998 онд Дээд боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлийг байгуулсан нь социалист системээс ардчилал, зах зээлийн харилцаанд шилжсэн орнуудын хувьд анхдагч нь байлаа. Магадлан итгэмжлэлийн үндэсний байгууллагыг анхнаас нь АНУ, Азийн өндөр хөгжилтэй зарим орны боловсролын магадлан итгэмжлэлийн олон жилийн туршлагатай байгууллагуудын жишиг, хэв шинжээр байгуулан ажиллаж байна.

Магадлан итгэмжлэл нь боловсролын магадлан итгэмжлэх төв байгууллагаас тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг ханган биелүүлсэн сургалтын байгууллага, хөтөлбөр, шинэ хөтөлбөрийн өөрийн үнэлгээнд тулгуурлан бие даасан хараат бус шинжээчид хөндлөнгийн үнэлгээ хийж, ахиц дэвшлийг дэмжин мэргэжлийн хүрээнд хүлээн зөвшөөрч чанарын баталгаажуулалт хийх үйл ажиллагаа юм.

Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөл нь 20 жилийн хугацаанд магадлан итгэмжлэх үйл ажиллагааг 3 үе шаттай хэрэгжүүлж ирсэн бөгөөд тухай бүр дээд болон мэргэжлийн боловсролын байгууллага, хөтөлбөр төдийгүй боловсролын салбарт хөгжлийг түүчээлэн шинэчлэл өөрчлөлт, ахиц амжилт авчирсан үйл явц болов.

Магадлан итгэмжлэлийн 1 дэх үе: 1998-2004 он

Дээд боловсролын сургалтын байгууллагууд сайн дурын үндсэн дээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн юм.

Магадлан итгэмжлэлийн 2 дахь үе: 2004-2014 он

Магадлан итгэмжлэлийн хугацаа нь дууссан дээд боловсролын сургалтын байгууллагууд 10 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.

Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд сайн дурын үндсэн дээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.

Дээд боловсролын сургалтын хөтөлбөрүүд сайн дурын үндсэн дээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн. 2012 оноос мэргэжлийн боловсрол, сургалтын хөтөлбөрүүд сайн дурын үндсэн дээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдсэн.

Шилжилтийн үе: 2014-2016 он

Шилжилтийн жил болгон зарлан, магадлан итгэмжлэх үйл ажиллагааг түр зогсоож, бүтэц бүрэлдэхүүн, эрх зүйн баримт бичгийн шинэчлэл хийсэн. АХБ-ны ДБШТ-ийн хүрээнд эрх зүйн шинэчлэлийг хийж, ижилсэх түншлэл хөтөлбөрийн хүрээнд Германы ASIIN байгууллагатай хамтран ажилласан.

Үндэсний зөвлөлийн баталсан (2015 онд) магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шалгуур шаардлагуудыг туршиж эхэлсэн. Мөн ASIIN-тай хамтран туршилтын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны журам, шалгуур шаардлагыг үндэсний зөвлөлөөр батлуулан 3 сургалтын байгууллага, 1 сургалтын хөтөлбөр, 3 шинээр нээх сургалтын хөтөлбөрт туршилт хийсэн.

Магадлан итгэмжлэлийн 3 дахь үе: 2016-2018

Дээд болон мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага заавал, сургалтын хөтөлбөрүүд сайн дурын үндсэн дээр 5 жилийн хугацаатай магадлан итгэмжлэгдэх болсон. БМИҮЗ болон ASIIN-ний туршилтын магадлан итгэмжлэлийн үйл ажиллагааны журам, шалгуур шаардлагуудыг харьцуулан олон улсын түвшинд хүрсэн магадлан итгэмжлэх үйл ажиллагааны журам, шалгуур шаардлагыг нийцүүлэн БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн хуралдаанаар 2018 оны 6 дугаар сарын 26-нд баталсан

Боловсролын эдийн засгийн гадаад хамтын ажиллагаа

Боловсролыг хямралаас гаргах, тогтвортой хөгжүүлэхэд олон улсын хандивлагчдын гүйцэтгэсэн үүрэг, сургамж, хандлага /1992-2017 он/

Аливаа шинэ юм бүхэн сайтар мартагдсан хуучин зүйлс юм гэсэн үг байдаг. Өчигдөргүйгээр өнөөдөр, өнөөдөргүйгээр маргааш гэж байдаггүй ч гэдэг.

Өнөөгийн манай орны боловсролын салбарын хөгжил нэлээд эрчимтэй явагдаж, ололт амжилт, алдаа дутагдлыг хослуулан урагшилсаар байна.

1992-2017 оны 25 жилийн хугацаанд бий болсон ололт, амжилтын эх үүсвэр ундарга, алдаа бэрхшээлийн эхлэлийн цаг үе ч гэж байдаг. Тэдгээрт нөлөөлсөн гадаад, дотоод эерэг, сөрөг хүчин зүйлсийг мега, макро, мезо, микро түвшинд нь харилцан уялдаа холбоотойгоор боловсролын философи, боловсролын түүх, боловсролын социологи, сурган хүмүүжүүлэх ухаан, сэтгэл судлал, боловсролын менежмент, боловсролын маркетинг, боловсролын эдийн засаг гээд шинжлэх ухааны уулзвар, түншлэл дээр өнгөрсөн, одоо, ирээдүй цагийн хэлхээнд нягт нямбай уялдуулан залгамж холбоотой судлах хэрэгцээ шаардлага үүсч байна.

Өнгөрсөн түүхэн хөгжил, алдаа онооны сургамжийг шинжлэх ухааны үндэс, нотолгоон дээр судлах нь хөгжлийн бий болсон ололт амжилтын сайн туршлагыг залгамжлан өвлүүлж баталгаажуулах, гарсан алдаа дутагдал дахин давтан гаргахгүй байх, урьдчилан сэргийлэх боломжийг нээснээрээ ихээхэн хөрөнгө санхүү, хүний хүчин зүйл, цаг хугацааг хэмнэж илүү шинэ үр дүнд богино хугацаанд хүрэх сайхан нөхцөл боломжийг бүрдүүлэх болно. Үүнийг эдүгээ XXI зууны 3 дахь арван жилдээ орж буй дэлхий дахины хөгжлийн түүх маш тодорхой харуулж байна.

Зарим улс орны хөгжил улам бүр хурдасч илүү үр дүн амжилтад хүрч байхад хөгжлийн нэг гараанаас бүр зарим нь тодорхой хугацааны өмнө улс төр, нийгэм-эдийн засгийн хямралыг даван туулж, шинэчлэлийг хийж эхэлсэн боловч эдүгээ тийм ч бодиттой дорвитой хөгжил, дэвшлийн өөрчлөлт гаргахгүй зогсонги байдалтай байна.

Өнөөдөр дэлхий даяараа ногоон хөгжил, ногоон боловсрол, хиймэл оюуны ухаалаг смарт дижитал технологи, аж үйлдвэржилтийн 4 дэх хувьсгал, сансар, далайг эзэмших, цөмийн болон сэргээгдэх эрчим хүчийг хүн, байгальд ээлтэйгээр ашиглах, био-нано технологийн туслалцаатайгаар шинэ материал, технологийг бий болгож, хий, цахилгаан эрчим хүчээр ажилладаг нисэгчгүй онгоц, жолоочгүй автобус, унааг бүтээж, цахим роботууд үйлдвэрлэл, ажил үйлчилгээг эрхэлж эхлээд байхад нөгөө нь нэг улс орон нь дотооддоо дайн самуун, авлигал, гэмт хэрэг, дээрмийг цэцэглүүлээд хөгжил, дэвшлийн сүүлийг барьж, хоцрогдож байна.

Бидний монголчуудтай бараг нэг гараанаас шинэ зах зээлийн харилцаанд шилжиж байсан Орос, Хятад, Вьетнам, Эстони, Латви, Казакстан, Беларусь гээд улсуудын хөгжил, түүний дотор боловсролынх нь хөгжил мэдэгдэхүйц хэмжээгээр урагшилсан байна. Манай монгол улсын боловсролын хөгжилд ч гэсэн ихээхэн

шинэлэг алхмууд хийгдэж, дэлхийн олон улсын боловсролын хөгжилд өөрийн гэсэн хувь нэмрээ оруулж, монголын боловсролын брэндүүд ч бага багаар бий болж байна. Тухайлвал, манай орны сургуулийн өмнөх боловсролд оруулж буй хөрөнгө оруулалт, энэ дэд салбарын чанар, хүртээмжийн өнөөгийн амжилтыг олон улсын байгууллагууд өндрөөр үнэлж байна, боловсролын салбарын цахим мэдээлэл холбооны технологийн сүлжээ, нэг компьютерт ногдож буй сурагчдын тоо, цахим сургалт - цахим ном зэрэг шинэ технологиуд мэдэгдэхүйц хөгжиж байна,

Боловсролыг кластераар хөгжүүлэх дэлхийн хандлагын эхлэлийг тавигдагчдын тэргүүн эгнээнд 1997 онд анх байгуулагдсан ерөнхий боловсролын эдүгээ 60 гаруй цогцолбор сургууль болоод байгаа сургуулийн сүлжээ, түншлэлүүд цогцолбор орж байна. Манай ерөнхий боловсролын сургуулиудын сурагчид дэлхийн шатар, даам, оюун ухааны болоод спортын тодохой төрлүүдийн дэлхий, тив, олон улсын тэмцээн уралдаанд алт, мөнгө, хүрэл медалийг багаараа болон хувиараа эзлэх боллоо.

Математик, физик, хими зэрэг байгалийн шинжлэх ухаан, уран зураг, хөгжим, бүжгийн авьяастнуудын олон улсын уралдаан тэмцээний тэргүүн байрыг эзлэх болсон нь манай орны боловсролын хөгжлийн томмохон тод илрэл дэвшил хэмээн үзэж байна. Харин энэхүү дэлхий дахин, олон улсын түвшинд гаргасан ололт амжилт, түүн й туршлагыг өөрийн орны дотооддоо нийтийн хүртээл болгох, бүгдээрээ энэхүү топ амжилт уруу хамтдаа тэмүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлвэл бид өнөөгийн амжилтаас илүү эрэмбийн амжилтад хүрэх боломжтой.

Боловсролын хөгжлөө дагаад улс орны маань хөгжил, дэвшил ахиж өөдлөн дэвжиж байгааг бас энд онцлон тэмдэглэх учиртай. Тийм учраас энэхүү сайхан ололт, амжилтийн эх үүсвэр, суурь хэзээнээс тавигдсан, түүнчлэн эдүгээ бий болсон хүндрэл, бэрхшээлийн угшил, мөн чанар юунд байгааг боловсрол судлалын цогц судалгааны хүрээнд нарийвчлан судлаж, тодруулахад 1992-2017 оны боловсролын хөгжлийн түүхэн хөгжил, түүний сургамж маш их чухал бодлогын, оюуны хөрөнгө оруулалт болно хэмээн бодож байна.

1992-1995 оны нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал

- Монгол Улсын шинэ “Үндсэн Хууль” батлагдсан
- Улс төр, нийгэм, эдийн засаг, оюуны хямралаас гарах гарцыг хайж байсан

- Нийгэм, эдийн засгийн бүхий л салбар, түүний дотор боловсролын салбарт бодлого, хууль эрх зүйн шинэчлэл, өөрчлөлт хийх хүсэл зорилго маш их байсан.
- Тухайн үед хүмүүнлэг, ардчилсан, зах зээлийн тогтолцоонд шилжих тухай ойлголт, мэдлэг дөнгөж төлөвшиж байсан тул энэхүү бүх нийтийн мэдлэгийг дээшлүүлэх, түүнд суралцах олон хэлбэрийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж байв.
- Энэ чиглэлээр гадаад, дотоодод бэлтгэгдсэн туршлагатай багш, судлаач, эрдэмтэд мэргэжлийн боловсон хомсдолтой байснаас зарим буруу зөрүү ойлголт үүсч алдаа дутагдал гарч байлаа,

1993-1995 оны боловсролын салбарын нөхцөл байдал

- 1991 онд Боловсролын салбарыг хөгжлийн шинэ үзэл баримтлал, боловсролын тухай шинэчилсэн хууль тус тус батлагдаж хүмүүнлэг ардчилсан, зах зээлийн харилцааны нөхцөлд боловсролын үйл ажиллагааг уялдуулан эрх зүйн хүрээнд зохицуулах болон олон улсын зах зээлийн хөгжлийн хандлага, сайн туршлагыг иш үндэс болгосон шинэ үзэл санаа, асуудлуудыг тусгаж өгсөн.
- 1992 онд Боловсролын Яам, Боловсролын судлагааны байгууллага, орон нутгийн боловсролын удирдлага, сургуулийн удирдлага солигдож, хөдөлгөөнтэй байсан
- Сургууль завсардалт ихэссэн, сургуулийн төсөв, цалин хөлсний хомсдол, цахилгаан дулааны тасалдалт, багш нар ганзгын наймаанд олноор явах, сургалтын чанар доройтох, сургалтын барилга байгууламж, техник төхөөрөмж эвдэрч муудах, ном сурах бичиг дутагдах зэрэг олон зүйлээс шалтгаалж боловсролын үнэлэмж их унасан, ихээхэн уур бухимдалтай, багш нарын жагсаал хөдлгөөн, ажил хаялт хэдэн сараар үргэлжилж байв.
- Хувийн их, дээд сургуулиуд олноор бий болж тэдгээрийн чанар муу, зөвхөн богино хугацааны дамжаа курсын түвшинд чанаргүй, мэргэжлийн анги тэнхим, багш, сургалтын тоног төхөөрөмжгүй байгаа асуудал ихээр яригдаж байсан.

1993-1995 оны боловсролын салбарын шинэчлэл, өөрчлөлтийн үе

1991 он Боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал, боловсролын тухай хууль нь шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн гаргасан шинэ цагийн анхны эрх зүйн баримт бичиг болсон.

- АХБ-ны техникийн туслалцаатай "Боловсрол, хүний хүчин зүйлийн Сектор судлагаа, Мастер төлөвлөгөө"-г 1993-1994 онд боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн.
- ЮНЕСКО-гийн "Говийн эмэгтэйчүүдийн боловсрол", Дани Улсын ДАНИДА байгууллагын дэмжлэгтэй "Хөдөөгийн бага, дунд боловсролыг дэмжих" төсөл, ЮНЕСКО-гийн "Боловсролын удирдлагын чадавхийг дээшлүүлэх, Боловсролын удирдах ажилтныг чиг зорилготой бэлтгэх төсөл", АХБ-ны "Дээд боловсролыг дэмжих" техникийн тусалцаа нь боловсролын гадаад, нээлтэй бодлогыг хэрэгжүүлэх эхлэл болсон юм.

Энэ үеийн боловсролын хөгжлийн бодлого нь:

- Хүмүүнлэг, ардчилсан нийгэм, зах зээлийн харилцааны тухай онол, арга зүйн ойлголт, мэдлэгийг нийтийн хүртээл болгох, түүнд нийцүүлэн бодлого, хууль эрх зүйн баримт бичгийг боловсруулж, баталгаажуулах, шинэчлэлийг эхлүүлэх
- Ялангуяа боловсролын хямралыг цаашид гүнгийрүүлэхээс урьдчилан сэргийлэх, саармагжуулахад илүүтэй анхаарсан арга хэмжээг авч байлаа

Боловсролыг шинэчлэн өөрчлөх, нэр хүнд үнэлэмжийг дээшлүүлэх дан ганц сурган хүмүүжүүлэх бодлого, арга зүйг шинэчлэх бус боловсролыг санхүү, төсөв, хөрөнгө оруулалт, нөөц боломжийг богино хугацаанд бий болгож, энэхүү том салбарыг эдийн засаг, санхүүжилтын шинэ менементээр удирдахын чухлыг төр, засгийн удирдлагын бүх түвшинд ойлгож эхэлсэн. Ялангуяа дан ганц улсын төсөв, хөрөнгө оруулалтын тухайн үеийн нөөц боломж маш хязгаарлагдмал, дутагдалтай байгааг онцгой анхаарч олон улсын санхүү, эдийн засгийн байгууллага, хандивлагчдад хандах ёстойг бүрэн ойлгож энч иглэлээр ихээхэн санаачлагууд гарч байлаа.

1992 онд Японы Засгийн Газрын дэмжлэгтэйгээр Японы Токио хотноо монгол Улсад дэмжлэг үзүүлэх чиглэлээр Олон улсын хандивлагч байгууллагуудын уулзалтыг зохион байгуулах санаачлаг гарч түүнд бэлтгэх Засгийг газрын ажлыг хэсгийн нийгэм, эдийн засгийн бүхий салбарууд түүний дотор хүний нөөц, боловсролын асуудлыг хариуцсан ажлын хэсгийг байгуулж тодорхой танилцуулга, санхүү, хөрөнгө оруулалт хийх санал зөвлөмжийг боловсруулсан юм. Энэхүү ажлын хэсэгт эдийн засгийн ухааны доктор Б. Энхтүвшин, Хөдөлмөрийн сайд Ц.Цолмон, Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институтын захирал Д.Цэрэндорж, Д. Амаржаргал гээд олон хариуцлагатай хүмүүс, эрдэмтэн мэргэжилтнүүд, Боловсролын хүрээлэнгийн боловсролын удирдлага, эдийн засгийн секторын орлогч эрхлэгч Р.Бандий нар оролцож байв.

Энэ цаг үеэс Олон улсын хандивлагч дэмжигч байгууллагууд, тухайлбал АХБ, Дэлхийн банк, Олон улсын Валютын сан, ЖАЙКА гээд олон байгууллагын талаар тодорхой ойлголт мэдлэгтэй болцгоож байлаа. 1993 оноос Азийн хөгжлийн банкны техник тусалцааны төслийн буцалтгүй дэмжлэгтэйгээр “ Боловсрол, хүний хүчин зүйлийн Сектор судалгаа”, “Боловсрол, хүний хүчин зүйлийн Мастер төлөвлөгөө”-г анх удаагаа боловсруулж хэрэгжүүлэв.

1995 онд Монгол Улсын Их хурлаас “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”, Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль зэрэг боловсролын тухай багц хуулийг боловсруулж, хэлэлцэн баталж хэрэгжүүлсэн нь Монгол орны боловсролыг хямралаас гаргах, цаашид орчин үеийн нөхцөлд хөгжүүлэх төрийн бодлого, стратеги, хууль эрх зүйн орчныг бүрүүлж чадсан юм.

Албан бус боловсрол

БНМАУ-ын Боловсролын хуульд 1991 онд боловсрол нь албан ба албан бус боловсролын дэд тогтолцооноос тогтоно гэж анх тусгайлсан заалт орсон юм. Боловсролын хүрээлэнгийн нэг секторыг бие даасан Албан бус боловсролын Төв болгож гаргасан нь төв, орон нутгийн нутгийн түвшинд салбар нэгжтэй болж, олон улсын болон төрийн бус байгууллагуудтай хамтын ажиллагаа өргөжүүлэн нэлээд хэдэн жил ажиллаж ирэв. Улмаар 1992 оноос Монголын Улсын Засгийн газар ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Говийн малчин эмэгтэйчүүдийн сурах хэрэгцээг хангах албан бус боловсрол” төсөл хэрэгжүүлж эхэлсэн нь албан бус боловсролын тогтолцооны суурийг бий болгох эхлэл болсон байна.

АХБ-ны дэмжлэгтэйгээр 1993 онд хийсэн боловсролын салбарын судалгаанд “Монголд АББ, насанд хүрэгчийн ба тасралтгүй боловсрол одоохондоо хөгжөөгүй байгааг Төв аймгийн Аргалант суманд болсон сургууль завсардагсад ба гэрийн ажилтай хүмүүст зориулсан материал бэлтгэх сургалтаар жишээлэн дурдаад , цаашид энэхүү дэд салбрыг системтэйгээр буй болгоход нөлөөлөх бодлогын баримт бичиг, тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөө шаардлагатай, “ийм хөтөлбөр гаргахад Боловсролын хөгжлийн институт (хуучин нэрээр)-д тасралтгүй боловсролын асуудлаар хийгдэж буй 3 жилийн судалгаа хувь нэмэр болж чадна” хэмээн зөвлөмжилсөн байна (Ministry of Science and Education, 1993). Улмаар БСШУЯ, ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн бүсийн төв (ACCU), ЮНЕСКО гурав хамтран ажиллах; АББ тогтолцоо бүрдүүлэхэд ЮНЕСКО-гоос дэмжлэг үзүүлэх; АББ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр боловсруулах; 2000 он гэхэд сургууль завсардсан 80 хувь буюу 60000 хүүхдийг АББ-д хамруулах зэрэг тодорхой зорилт

дэвшүүлсэн нь салбарын бодлогын дараагийн алхмуудыг хийх үндэс болсон байна. 2002 оны 5 дугаар сард шинэчлэн баталсан Боловсролын тухай хуульд “Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан болон албан бус гэсэн тогтолцоотой байх ба албан бус боловсрол нь албан боловсролын гадна байгаа хүн амд зохион байгуулалттайгаар боловсролын үйлчилгээг хүргэнэ” гэж тодруулан заасан болно.

2007 оноос эхлэн “Боловсролын тухай” хуулийн шинэчлэгдэн батлагдсан 8.2, 40.2 дахь заалтын дагуу иргэд албан бус боловсролын дүйцсэн хөтөлбөрөөр тодорхой хугацааны боловсролыг нөхөн болон бие даан эзэмших боломжтой болж, түүнд зориулан улсын төсвөөс хувьсах зардал олгодог болсон нь иргэний олон талт хэрэгцээг харгалзан үзсэн уян хатан, нээлттэй сургалтын хувилбарыг сонгон хэрэгжүүлэх, танхимын бус сургалтын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх бололцоог нэмэгдүүлсэн байна.

2010 онд БСШУЯ-наас “Албан бус боловсролын сургалтын талаар баримтлах бодлого”- баталсан байна. 2016 онд Боловсролын тухай хуульд “Насан туршийн боловсрол” гэж бүх насны иргэд боловсролын албан болон албан бус хэлбэрээр ёс суртахуун, гоо зүй, иргэн, гэр бүл, шинжлэх ухаан, амьдрах ухааны боловсролыг тасралтгүй эзэмших үйл ажиллагааг” хэмээн нэмэлт заалт орсон байна (2016 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн хуулиар нэмэлт оруулсан, 2018 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан).

Боловсролын салбарын Мастер төлөвлөгөө болон үндэсний хөтөлбөрүүд. 1993 онд хийсэн Боловсролын суурь судалгаанд АББ-ыг хөгжүүлэх бодлого боловсруулах талаар зөвлөмжилж (БСШУЯ, 1993), Боловсролын салбарын анхны Мастер төлөвлөгөө (1993-2000)-нд: сургуулийн гаднах хүүхэд залууст боловсролын үйлчилгээ үзүүлэх, АББ-ын тогтолцооны эрхэм зорилго, зорилт, тэргүүлэх чиглэл, бүтэц, үүрэг хариуцлагыг тодорхойлж энэ талаар баримтлах төрийн бодлогын үндсийг боловсруулах, эдгээр арга хэмжээг авах нөөц бололцоог судалж тогтоох шаардлагатай байгааг дурдсан байна (МУГЗ, БСШУЯ, 1994). Энэхүү төлөвлөгөөний үр дүнд 1995 онд Боловсролын тухай багц хуульд “Монгол Улсын боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байна” гэсэн заалт орсон байна.

“Боловсролын мастер төлөвлөгөө” (2006-2015)-нд “АББ ба насанд хүрэгчдийн боловсрол”-ын асуудлыг бие даасан бүлэг болгон тулгамдсан асуудлыг тодорхойлж, хүртээмж, чанар, менежментийн чиглэлээр дараах зорилтуудыг

дэвшүүлжээ. Үүнд албан бус боловсролын үйлчилгээг хэрэглэгчдийн хэрэгцээнд нийцүүлэх, албан бус боловсролын бүх түвшинд сургалтын орчин, чанарыг сайжруулж, нөөцийн чадавхыг дээшлүүлэх, албан бус боловсролын салбарын бодлого, стратегийг боловсронгуй болгож, мэдээлэл, санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, бичиг үсэгт тайлагдалтын түвшинг 2008 он гэхэд 97.7-99.0 хувьд хүргэх, ЕБС-иас завсардсан сурагчдын 40.0 хувьд албан бус боловсрол, дүйцсэн хөтөлбөрийн сургалтаар боловсрол нөхөн олгох, Албан бус боловсрол, зайны сургалтын үндэсний төв, сум, дүүргийн албан бус боловсролын төвийн санхүүжилтийг жил тутам 8.0 хувиар өсгөх, багшийн мэргэжил дээшлүүлэх зардлыг мэргэжил дээшлүүлэх нэгдсэн зардалд тусган, жил бүр санхүүжүүлэх, Мэдээлэл, хяналт-шинжилгээний үндэсний систем бий болсон байх зэрэг болно. АББ-ын салбарыг дэмжих, өргөжүүлэх, оновчтой бүтэц, менежментийн тогтолцоог бий болгох чиглэлээр Засгийн газрын түвшинд хэд хэдэн үндэсний хөтөлбөр гарсан юм. Монгол Улсын Засгийн Газрын 1995 оны 19-р тогтоолоор баталсан “Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр” (1995-2005) нь суурь боловсрол эзэмших нэг арга зам нь албан бус сургалт болохыг бодлогын хувьд тодорхойлсон баримт бичиг болсон байна.

1997 онд “АББ-ыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр” (1997-2004) Засгийн газрын 1997 оны 116 дугаар тогтоолоор батлагдсан нь дэд тогтолцоо бүрдэхэд ихээхэн нөлөө үзүүлсэн төрөөс баримтлах бодлогын гол баримт бичиг болсон байна. Хөтөлбөрийн эрхэм зорилго нь “Хүн амд хэрэгцээтэй боловсролыг сургуулиас гадуур өөрт нь тохиромжтой хэлбэрээр бололцоотой хугацаандаа тасралтгүй эзэмших тогтолцоо бүрдүүлж, үйлчлүүлэхэд оршино” гэж томъёолсон ба АББ-ыг хөгжүүлэх үндсэн 6 чиглэл болох 1/ хүн амын бичиг үсгийн боловсролын түвшинг дээшлүүлэх, 2/ хүн амын боловсролын ерөнхий түвшин дээшлүүлэх, 3/ хүн амд боловсрол нөхөн олгох, 4/ хүн амд мэргэжил эзэмшүүлэх, хөдөлмөр эрхлэх мэргэжлийн чадвар олгох, 5/ хүн амыг бүтээлч үйл ажиллагаанд суралцахад нь туслах, 6/ хүн амын бие дааж мэргэжил боловсролоо дээшлүүлэхэд нь туслахыг тодорхойлсон нь уг салбарын үйл ажиллагааны үндсэн чиглэл болсоор ирэв.

2002 онд Монгол улсын Засгийн газраас “Зайны сургалтын үндэсний хөтөлбөр” батлан гаргаж, үүний үр дүнд АББ-ын төвийг өргөтгөн АББЗСҮТ болгон өөрчилсөн юм. Хөтөлбөрийн хүрээнд 13 төрлийн аудио хичээл, 39 төрлийн видео хичээл, 50 теле хичээл гарч ЮНЕСКО болон НҮБ-ын Хүүхдийн сангаас хэд хэдэн төсөл хэрэгжүүлжээ.

2003 онд Монгол улсын санаачилгаар НҮБ-аас “Бичигтэн” болох арван жил (2003-2012)-ийг зарласан, энэ хүрээнд дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэх үүднээс 2004 онд Монгол улсын Засгийн газраас “Бичиг үсгийн боловсролын үндэсний хөтөлбөр” батлан гаргасан нь, АББ-ын үйл ажиллагаанд ихээхэн дэмжлэг болсон байна. Тухайлбал, АББЗСҮТ-өөс ЮНЕСКО-гийн дэмжлэгтэйгээр “Бичиг үсгийн боловсролыг зайнаас дамжуулан олгох нь” төсөл хэрэгжүүлж, насанд хүрэгчдийн бичиг үсгийн анхан, дунд ба дараах шатны цуврал сургалтын материалуудыг хэвлэмэл, видео болон СД хэлбэрээр боловсруулан түгээсэн нь 1990-ээд онд сургууль завсардсан хүн амд чиглэсэн боловсролын үйлчилгээний хүртээмжийг дээшлүүлжээ. Энэхүү үндэсний хөтөлбөрийн хүрээнд бичиг үсгийн боловсролын 101 хэвлэмэл материал гарч түгээгдсэн ба 2004-2012 оны хооронд нийт 83123 хүн бичиг үсгийн сургалтад хамрагдсан байна (АББЗСҮТ, 2014). Түүнчлэн “Англи хэлний зайны сургалт” төсөл хэрэгжүүлэх, ЮНЕСКО-гийн Ази, Номхон далайн бүсийн төв -тэй хамтран “Байгаль орчны сургалтын багц материал” боловсруулах зэргээр боловсролын үйлчилгээ үзүүлж ирсэн байна.

Үндэсний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсрол

Монгол Улсын нийт хүн амын 3.9 хувийг казах угсаатан, 0.1, 0.02 хувийг тува (түрэг), цаатан угсаатан тус тус эзэлж үндэстний цөөнх хэмээн тооцогддог³⁴. Казах, тувачуудын дийлэнх нь Баян-Өлгий аймагт, мөн Ховд, Сэлэнгэ аймаг, Улаанбаатар хотод тархан суурьшсан байна.

Монгол Улсын төр, засаг үндэстний цөөнхийн эх хэлээрээ сурч боловсрох эрхийг Үндсэн хуулиар³⁵ баталгаажуулж, холбогдох хууль тогтоомжийн³⁶ хүрээнд шийдвэрлэж ирсэний зэрэгцээ үндэстний цөөнхийн хүүхдэд төрийн албан ёсны хэл болон уламжлалт монгол бичгийг зааж сургах асуудлаар тухайн цаг үед тохирсон өвөрмөц бодлого баримталж, ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ирсний зэрэгцээ боловсролын үндэсний байгууллагуудын дэргэд сургалт арга зүй, судалгааны нэгжүүдийг тусгайлан байгуулж ажиллуулж ирсэн түүхтэй.

Бүр 1939 онд Намын Төв Хорооны Тэргүүлэгчдийн 13-р хурлаас тогтоол гаргаж, хасаг ард түмний дотор ардыг гэгээрүүлэх, боловсруулах ажлыг бодлогын үндсэн зорилго болгож явуулах ажлын ерөнхий төлөвлөгөөг баталж хэрэгжүүлж байжээ.

³⁴ Арьс үндсээр алагчлах үзлийн бүх хэлбэрийг устгах тухай олон улсын конвенцийн хэрэгжилт, Монгол Улсын 23-24 дүгээр ээлжит тайлан.

³⁵ Монгол улсын Үндсэн хууль, 1992

³⁶ Боловсролын тухай багц хууль, 2002

Боловсролын хүрээлэнгийн Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор (цаашид ҮЦГМХБСС гэх)-ын түүхэн замнал нь 1961 онд тухайн үеийн Ардын гэгээрлийн яамны (АГЯ) дэргэд Заах арга зүйн зөвлөл байгуулагдснаас эхтэй юм. Уг зөвлөлд хичээл тус бүрээр заах арга зүйн салбар зөвлөл байгуулагдахад казах хэлээр сургалт явуулдаг сургуулийн асуудал хариуцсан нэг мэргэжилтэн ажиллаж эхэлжээ. Уг мэргэжилтэн казах хэл дээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсруулж, АГЯ-аар баталгаажуулах бэлтгэлийг хангах, сургалтын төлөвлөгөөн дэх монгол хэлний цагийн багтаамжид тохируулан хичээлийн программыг боловсруулах ажлыг хариуцдаг байжээ. Энэ үеэс буюу 1962-63 оноос эхлэн монгол сурах бичгүүдийг казах хэлэнд орчуулан хэвлүүлж эхэлсэн бөгөөд 1962 онд казах сургуульд зориулсан анхны монгол хэлний сурах бичиг хэвлэгдэн гарчээ. Энэ үед Зөвлөлт Казахстан Улсын сурах бичгийг мөн сургалтад ашигладаг байсан бөгөөд энэ нь 1930-аад оны сүүл 1940-өөд оноос эхэлсэн байдаг.

1963 онд БМДИ-ийг Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэн болгож өргөтгөхөд казах хэлээр сургалт явуулдаг сургуулийн асуудал хариуцсан нэг эрдэм шинжилгээний ажилтан ажиллах болжээ.

1972-1992 онд Сурган хүмүүжүүлэх ухааны хүрээлэнгийн харьяа Казах сургуулийн сектор байгуулагдан ажиллаж, сургалтын агуулга, арга зүйг боловсруулах, судалгаа шинжилгээний ажил хийх, сурах бичиг зохиох, орчуулах ажлуудыг дагнан гүйцэтгэдэг болсон байна. Мөн казах хэл дээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын төлөвлөгөөг тус секторын эрдэм шинжилгээний ажилтнууд боловсруулж, Хүрээлэнгийн эрдмийн зөвлөлөөр зөвшөөрүүлэн Ардын Боловсролын Яамны сайдын тушаалын хоёрдугаар хавсралт болгон баталгаажуулан мөрддөг байжээ. 1992 оноос хойш 10-аад жилийн дараа Монгол Улсын Засгийн газрын “Казах хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 2010 оны 66 дугаар тогтоолын дагуу дагуу Боловсролын хүрээлэнгийн захирлын 2011 оны 15 тоот тушаалаар “Казах хүүхдийн боловсролын сектор” байгуулагдсан байна. Улмаар БСШУ-ны сайдын 2015 оны “Бүтэц, зохион байгуулалт шинэчлэн батлах” тушаалаар уг секторыг Үндэсний цөөнх болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны сектор болгон судалгаа, үйл ажиллагааг нь өргөтгөсөн байна. Уг сектор нь Монгол Улсын угсаатны цөөнхийн хүүхэд болон гадаад дахь монгол хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас явуулах бодлогын үндсийг боловсруулж, гарсан шийдвэрийг хэрэгжүүлэхэд арга зүйн туслалцаа үзүүлэх чиглэлээр судалгаа, арга зүйн ажлыг хийж, төрийн болон ТББ-ыг мэдээллээр хангаж ирсэн байна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ, САЙЖРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн судалгааны үр дүн

Бусад үндэстнээс хөгжлийнхөө хувьд Монгол хүний ялгарах онцлог юу вэ гэхэд олон хариулт гарна. Тэдгээр хариулт хэр үндэстэй вэ гэхээр мөн л ялгаатай хариулт гарна. Хүний хөгжил нь Монгол улсын хөгжлийн тэргүүлэх чиглэл болохынхоо хувьд хүнийхээ хөгжлийн онцлогт үндэслэсэн бодлого, түүнийг хэрэгжүүлэхэд зорилтод бүлгийн хүний хөгжлийн онцлогийг харгалзахын чухлыг илэрхийлж байгаа юм. Мөн бусдаас ялгарах ялгаагаа бид өөрсдөө тогтоож, улс орнуудын нээлттэй талбарт өөрсдийн орон зайг бий болгох хэрэгцээг тогтвортой хөгжлийн бодлого, боловсролынхны 2030 онд хүрэхээр амласан зорилтууд ч бий болгов.

Хүний хөгжлийг аль нэг бүрдэл талаас нь тодорхой насанд судалж ирсэн туршлага Монголд бий ч нэгдсэн арга зүйгээр, 6-21 насыг бүхэлд нь хамруулан үндэсний хэмжээнд боловсролын байгууллага хэрэгжүүлсэн нь үгүй билээ. Харин 2013-2017 онд Боловсролын хүрээлэнд хэрэгжүүлсэн Монголын хүүхэд залуучуудын хөгжлийн судалгаа анхных нь болсон байна.

Хүүхэд, залуучуудын хөгжлийн судалгааны онол, арга зүй

Бие бялдрын хөгжил Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн байдал нь ямар нэг өвчинтэй байгаагаар бус, харин тэдний бие бялдрын болон оюуны өв тэгш хөгжлөөр тодорхойлогдоно. Иймд хүүхдийн эрүүл мэндийг хамгаалан бэхжүүлэхэд чиглэсэн олон асуудлыг шийдвэрлэхэд өсөлт бойжилтын явцад бие махбодод явагдах биологийн өөрчлөлтийн шинж төрхийг заавал харгалзан үзэх шаардлагатай. *Өсөлт, хөгжил гэдэг нь бие махбодод явагдаж байгаа нэгэн процессийн хоорондоо харилцан уялдаатай хоёр тал юм. Өсөлт гэдэг нь бие махбод болон эд эрхтний хэмжээний хувьд өсөн нэмэгдэх тооны өөрчлөлт юм. Хөгжил гэдэг нь эд эрхтний бүтэц, үйл ажиллагааны хувьд боловсронгуй болж байгаа чанарын өөрчлөлт юм.* Насны үе шат бүрд бие махбодын өсөлт, хөгжил нь удаашрах, хурдсах зэргээр харилцан адилгүй явагдах бөгөөд түүний үндэс нь бодисын солилцоо юм (Батчулуун, Д., Цолмон, Ч. 1990).

Бие бялдрын хөгжил нь 3 бүлэг үзүүлэлтийн өөрчлөлтөөр тодорхойлогдож байдаг. Үүнд: Бие махбодын бүтэц (биеийн өндөр, жин, галбир, өөхөн давхаргын хэмжээ ба бусад)-ийн үзүүлэлтүүд. Эдгээр нь юуны өмнө хүний бүтэц зүйг тодорхойлж байдаг.

Хүний бие махбодын бүтэц ба физиологийн системүүдийн үйл ажиллагааны өөрчлөлтүүдийг харуулж байгаа эрүүл мэндийн үзүүлэлтүүд. Энэ нь хүний эрүүл мэндэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэдэг зүрх-судас, амьсгал, төв мэдрэлийн систем, хоол боловсруулах эрхтнүүд, ялгаруулах болон дулааныг зохицуулах механизмуудын үйл ажиллагаа юм.

Хүн судлалын шинжлэх ухааны салбар болох *Ауксологи* нь хүүхэд, өсвөр үеийнхнийг нас насанд нь судалдаг. “Ауксологи” – нэр томъёог анх өнгөрсөн зууны эхэн үед францын эрдэмтэн Пол Годен санал болгосон бөгөөд 1970-аад оны үед английн эрдэмтэн Жеймс Таннерийн илүү судалж, Америк, Европ, Азийн хөгжилтэй орнуудад тархсан юм. Харин манай орны хувьд энэ асуудал төдийлөн сайн судлагдаагүй байна. Ауксологи нь хүнийг эхээс төрснөөс эхлээд 18 нас буюу өсөлтийн үйл явц зогсох үе хүртэл авч үздэг. Гэхдээ 18 наснаас хойш огт өсөхгүй гэж бодож болохгүй, хүн бүр харилцан адилгүй учраас зарим залуус 18 наснаас хойш өсөх боломжтой байдаг. Хүний бие бялдрын өсөлт, хөгжлийн үндсэн үзүүлэлтэд “Биеийн өндөр”, “Биеийн жин”, “Цээжний тойрог”, “Толгойн тойрог” г.м. ордог. Хүүхдийн бие бялдрын өсөлт хөгжилд гарсан дээрх үзүүлэлтүүдийн өөрчлөлт нь хүүхдийн *эрүүл мэндийн түвшин*, өсөлт бойжилтын явцыг нарийвчлан дүгнэхэд онцгой ач холбогдолтой. Эдгээр хэмжээсийг антропометрийн тусгай аргуудаар, тусгай багажаар хэмждэг (Бунак, 1940). ОХУ-ын эрдэмтэн Бунакийн өндөр хэмжих антропометрийн сонгодог аргыг дэлхий нийтээрээ одоо ч ашиглаж байна. Дэлхийн улс орнууд хүүхдийн бие бялдрын өсөлтийг жилд 1-2 удаа хэмждэг байна. Хүүхдийн өсөлт, хөгжлийн үзүүлэлтийг байнга хэмжиж, судлах нь тухайн улс орон хүүхдэд зориулах хувцас, ширээ сандал, тоног төхөөрөмжийн хэмжээ, хэрэгцээг гаргах, Засгийн газраас хүүхдэд анхаарал тавих бодлого боловсруулж, эрүүл ахуйн асуудлуудыг шийдвэрлэхэд чухал ач холбогдолтой юм (Laura E. Berk, 2012).

Оюун ухаан гэсэн ухагдахуун Оюун ухаан бол танин мэдэхүйн сэтгэл судлалын бүхий л талыг агуулсан, бие даасан ойлголт юм. Чухамдаа оюун ухааны мөн чанарыг илэрхийлсэн тодорхойлолт нь юу вэ? Ойролцоогоор 70-аад тодорхойлолт байна (Legg & Hutter, 2007).

1921 онд “Боловсролын сэтгэл судлал” сэтгүүлийн зохиогчид оюун ухаан гэж юу вэ гэсэн асуултыг 14 нэрт сэтгэл судлаачдаас асуугаад уг ойлголт нь 1. хүний сурах чадвар 2. хүн хүрээлэн буй орчиндоо дасан зохицох чадвар гэсэн 2 шинжтэй гэж үзжээ.

65 жилийн дараа 24 сэтгэл судлаач болон оюун ухаан судлаачаас яг ийм асуултыг асуусан байна (Sternberg & Detterman, 1986). Тэд мөн ялгаагүй, сурах болон орчиндоо дасан зохицох чадвар гэдэг дээр нэмж танин мэдэхүйг онцлон тодорхойлсон аж.

Оюун ухааны үзэл хандлагыг дараах байдлаар авч үзэж болно. Үүнд:

- Оюун ухаан гэдэг нь тестээр хэмжигдэх үзүүлэлтүүд,
- Оюун ухаан бол сурах чадвар,
- Оюун ухаан нь хийсвэрлэн сэтгэх чадвар,
- Оюун ухаан нь шинэ орчин нөхцөлд үр дүнтэйгээр дасан зохицох чадвар.

Оюун ухааныг их олон талаас нь хэмжих боломжтой. Төрөл бүрийн тестээр янз бүрийн талыг нь хэмждэг (Daniel, 1997, 2000; Kaufman, 2000; Kaufman & Lichtenberger, 1998). Оюун ухааны зөвхөн нэг талыг нь тестээр хэмжээд тодорхойлох боломжгүй.

Оюун ухааныг сурах чадвар хэмээн тодорхойлсоор ирсэн уламжлалтай. Ийнхүү сурах чадвартай холбон үзэж байгаа тохиолдолд оюун ухаан нь үйл ажиллагааны нэг л төрөлтэй холбоотой болж, зөвхөн сургалтын үйл ажиллагааны хүрээнд үүсээд буй асуудал эсвэл даалгаврыг гүйцэтгэснээр л илрэх мэтээр ойлгогдож байна. Тэрчлэн, оюун ухааны хүрээнд хийгдсэн олон судалгааны ажлууд нь сурагчдын сурах чадвар, сурлагын амжилттай холбогдсон байдаг. Тухайлбал, Францын сэтгэл зүйч А.Бине 1905 онд Францын Боловсролын Яамны даалгавраар оюун ухааны хоцрогдолтой сурагчдыг судлах аргачлалыг боловсруулсан байдаг.

Зөвлөлтийн сэтгэл судлалын хүрээнд “оюун ухаан” гэсэн нэр томъёог сэтгэцийн хөгжлийн дээд үе шат гэж тодорхойлж, оюун ухааныг сэтгэхүйтэй холбон судалсаар ирсэн. Хүн аливаа мэдлэг, чадвар, туршлагыг хангалтгүй эзэмшиж байгаа нь тухайн эзэмших гэж буй дадал, чадварын онцлог, түүнийг зааж буй арга зүй, ялангуяа суралцагчийн сэтгэхүйн үйлдэл, онцлогтой холбоотой. Ийм учир шалтгааны улмаас оюун ухааныг шууд сурах чадвартай адилтган үзэх нь зохимжгүй юм.

Оюун ухааныг хийсвэрээр сэтгэх чадвар гэж үздэг ойлголт нь оюун ухааны илрэлийн процессыг түлхүү авч үздэгээрээ танин мэдэхүйн сэтгэл судлалын хүрээнд зорилтыг шийдвэрлэх чадвартай холбогддог. Оюун ухааныг тестээр хэмжиж байгаа тохиолдолд хийсвэр сэтгэхүйн илрэлүүдийг зайлшгүй судалдаг.

Олон судлаачид оюун ухааныг дасан зохицох чадвартай холбон тайлбарладаг. Гол төлөөлөгч Пиажегийн үзэж байгаагаар (Piaget, 1960) хүний хүрээлэн буй орчиндоо дасан зохицох хүчин чармайлтын үр дүн нь оюун ухаан аж. Дасан зохицолтын үндсэн үйлийг сэтгэхүйн үйл ажиллагаагаар тайлбарласан байдаг. Вернон (Vernon, 1960) хүний оюун ухаан нь зан төлөвийн уян хатан, мэдрэмжтэй хандлагын ерөнхий түвшнээр тодорхойлогдох бөгөөд хүний амьдралын турш хөгжиж байдаг гэж үзсэн байна. Оюун ухааныг хүний хүрээлэн буй орчинтойгоо харилцах гадаад зан үйл гэж үзэх нь мэдээж зохимжгүй. Оросын сэтгэл судлаачдын үзэж байгаагаар энэ харилцаа нь зүгээр нэг дасан зохицолт биш, харин хүний идэвхтэй үйл ажиллагаа юм. “Оюун ухааныг хувь хүний хүрээлэн буй орчинтойгоо харилцах харилцаа талаас нь тодорхойлж байгаа бол хүний тодорхой үйлдлүүдийг зайлшгүй авч үзэх шаардлагатай” (С.Л.Рубинштейн, 1940). Оюун ухааны эдгээр тодорхойлолтод үр дүн биш харин үйл явц илүүтэй яригдаж, оюун ухааныг сурах чадвар, хийсвэр сэтгэхүйтэй холбон үзэж байна.

Оюун ухааны ерөнхий шинжүүдийг тодорхойлбол:

- Мэдээллийг хүлээж авах, боловсруулах хурд,
- Танин мэдэхүйн процессын нэгдэл (сэрэл, хүртэхүй, ой, төсөөлөл, сэтгэхүй, зохион бодохуй),
- Орчиндоо дасан зохицох чадвар,
- Сурах чадвар,
- Бэрхшээлийн танин мэдэх, түүнийг шийдвэрлэх чадвар,
- Зорилго дэвшүүлэх, нөөцийг төлөвлөх, зорилгодоо хүрэх зан үйлээ төлөвлөх процесс.

Оюун ухаан нь чадвар болохынхоо хувьд танин мэдэх, сурах, хийсвэрээр сэтгэх, мэдээлэлд анализ хийх замаар мэдээллийг системчлэх, түүнийг ангилах, зүй тогтлыг нь олох, харьцуулах, холбох процесуудыг өөртөө агуулсан нэгдмэл тогтолцоо юм. Нөгөөтэйгүүр хүний зан төлөвийн зохицуулалттай салшгүй холбоотой. Судлаачид хүний бие хүний онцлог нь оюун ухаантай холбоотой талаар судалсан үр дүнгүүд байдаг байна (Ackerman, 1996, 2010).

Нийгэмшлийн тухай ойлголт

Олон улсын судалгааны туршлага, орчин үеийн чиглэлээс үзэхэд нийгэмшлийн хүрээг:

1. Нийгмийн харилцааны чадвар (social Skills),
2. Сэтгэлийн хөдөлгөөний чадвар (responsible Decision making),

3. Өөрийн ухамсар (self awareness),
4. Ээнэгшилт (attachment),
5. Бие хүний онцлог (personality) гэсэн дэд хүрээнд судалдаг байна.³⁷ гэж үзэх нь нийтлэг байна.

Олон улсын боловсролын салбар нь хүүхдийн Нийгэмшлийг үнэлэн боловсролын тогтолцоондоо нэвтрүүлж ирсэн. Үүнийг “Нийгэм-сэтгэлийн хөдлөлд суралцах” (SEL) болон Skills for Life (SFL) гэсэн нэр томъёонууд олон улсын боловсролын салбарт чухал хүчин зүйл болсноор тайлбарлаж болно. Энэхүү загварын үндсэн ойлголт нь хүүхэд болон насанд хүрэгчдэд амьдралын үндсэн чадварууд болон өөрийн зохион байгуулалт, харилцааны чадвар, ёс зүй эзэмшүүлэх зорилготой байдаг байна (Edutopia, 2014).

Нийгмийн харилцааны чадвар

Хүүхэд бүр бусдын адилаар өөртөө болон нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах чадвартай байдаг бөгөөд бусадтай нээлттэй сайн харилцаатай байх нь түүний нийгмийн чадамжийн түвшинг нэмэгдүүлдэг аж. Жишээ нь: харилцаанд бусадтай нээлттэй биш, өөрийн байр суурийг тогтоож чадаагүй хүүхдүүд хэвийн харилцаатай хүүхдүүдээс илүү эвдэн сүйтгэх хандлагатай, түрэмгий авиртай байдаг (Hartup, 1992). Нөгөө талаас хүүхэд бусадтай тоглох, харилцах цаашлаад өөрийгөө энэ нийгмийн нэгээхэн хэсэг гэж мэдэрснээр тухайн хүүхдийн бусадтай харилцах харилцаанд илүү бат бөх чадвар суугаад зогсохгүй эерэг харилцааны ур чадваруудыг эзэмшдэг аж.

Нийгэм-сэтгэл зүйн дасан зохицол

Нийгэм-сэтгэл зүйн дасан зохицол гэдэг нь хүн нийгмийн шинэ орчин нөхцөл, харилцан үйлчлэлд суралцах үйл явц юм. Энэ нь харилцаа болон тухайн нийгмийн бүлгээс ихээхэн шалтгаалдаг.³⁸ И.Б.Котова ба Е.Н.Шиянов нарын эрдмийн ажилд дурдсанаар дасан зохицол нь нийгэмшлийн нэг бүрэлдэхүүн хэсэг аж.

Америкийн сэтгэл зүйч К.Рожерс дасан зохицлыг өөрийгөө хүлээн зөвшөөрөх, бусдыг хүлээн зөвшөөрөх, сэтгэл хөдлөлийн тав тухтай байдал, манлайлах чиг хандлага гэсэн үзүүлэлтээр хэмжих боломжтой гэж үзжээ.

К.Рожерсийн үзэл баримтлал дээр тулгуурлан К.Рожерс, Р.Даймонд нар хүн нийгэмдээ хэрхэн төлөвшиж, нийгэм сэтгэл зүйн хувьд дасан зохицож байгаад

³⁷ Kyla Boyse, RN, MS. Reviewed by Layla Mohammed, MD. Updated August 2013

³⁸ [Гриценко В.В.](#), доктор психологических наук, профессор

бие хүний хөгжлийн хөдөлгүүр хүч болох өөрийн үнэлэмж, өөрийгөө болон бусдыг хүлээн зөвшөөрөх чадвар, нийгэм дэх чиг баримтлал, манлайлах тэмүүлэл мөн бусдыг даган дуурайх хандлага зэрэг чухал нөлөөлдөг гэж үзсэн байдаг.³⁹

Энэхүү үзлийн дагуу дээрх бие хүний үзүүлэлтүүдийг илрүүлэх мөн нийгэм сэтгэл зүйн дасан зохицох чадварыг илрүүлэх сэтгэл зүйн оношилгоо судалгааны аргыг 1954 онд боловсруулан гаргажээ. Энэхүү аргыг 2004 онд ОХУ-ын Сэтгэл судлалын шинжлэх ухааны доктор А.К.Осницкий өөрчлөн гаргасан.

Үүнээс харахад дасан зохицол бол нийгэмшлийг бүрдүүлэгч, механизм хэлбэр гэж ойлгож болохоор байна.⁴⁰

Өөрийн ухамсар

Өөрийн ухамсрын онолд өөрийн ухамсар бол хүрээлэн буй үйл явдлууд дунд өөрийн хувийн байдал, амьдрал, биемахбодио ухааран ойлгох байдал⁴¹ гэж дэвшүүлсэн (Duval & Wicklund, 1972, p.2).

LeFrancois (1996)-ийн дэвшүүлснээр өөрийн ухамсрыг өөртөө итгэлтэй байдал, өөрийн тухай ойлголт төсөөлөл, өөрийн идэвхжүүлэлт гэсэн хэсгүүд бүрдүүлнэ. Өөрийн ухамсар бол танин мэдэхүйн механизм дээр үндэслэсэн өөрийн талаарх төсөөлөл гэж зарим судлаачид үздэг. (Alison Gornik, 1994). Оксфордын толь бичигт тайлбарласнаар “Өөрийн зан төлөв, мэдрэмж, хүсэл, сэдлийг ухамсарласан мэдлэг”⁴². Бие хүний өөрийн ухамсар нь өөрийгөө бусдын нүдээр харж үнэлэх чадвар⁴³ зэргээр тайлбарласан байна.

Сэтгэлийн хөдөлгөөн

Хүүхдийн хөгжилд сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, ялган таних чадвар маш чухал үүрэг гүйцэтгэдэг бөгөөд энэхүү чадвар нь ирээдүйн асуудал үүссэн үеийн сэтгэлийн хөдөлгөөний загварыг бий болгодог (J. Ciarrochi, 2006). Хэдийгээр өнгөрсөн хугацаанд бие хүний ажиллах бүтээмжийг үнэлэх үндсэн арга нь оюун ухааны тест байсан боловч сүүлийн жилүүдэд сэтгэлийн хөдөлгөөнийг судлах түүнийг боловсролын тогтолцоонд нэвтрүүлэхийг дэмжих сэтгэл судлаачдын тоо нэмэгдсэн (Qualter, 2007).

1990 онд сэтгэл судлаач Петер Саловей, Жонн Маейр нар “Сэтгэлийн хөдөлгөөний оюун ухаан” гэсэн ойлголтыг гаргасан бол энэхүү ойлголтыг олон

³⁹ Dymond R. Adjustment changes over Therapy Self-sorter. // Psychotherapy and Personality Changes. / Ed. by Rogers and R. Dymond. Chicago, 1954.

⁴⁰ http://vestnik.yspu.org/releases/pedagoka_i_psichologiy/12_3/

⁴¹ Duval, Shelley. , & Wicklund, Robert, A. (1972). *A theory of objective self awareness*. (pp. 2-4). New York, New York: Academic Press, Inc.

⁴² <http://www.oxforddictionaries.com/>

⁴³ Л.Уранцэцэг, М.Дэлгэржав, Бие хүний нийгмийн сэтгэл зүй, УБ., 2012, хуудас 151

нийтэд хүргэсэн хүн нь 1995 онд Emotional Intelligence – EQ номыг бичсэн Даниел Голмен юм. Үүнээс хойш сэтгэлийн хөдөлгөөний ухааны сорил 90-ээд оноос эхлэн дэлхий дахинд дэлгэрч эхэлжээ. Тухайлбал, эрдэмтэн Ваяне Паяне 1985 онд докторын зэрэг хамгаалах нэг сэдэвт бүтээлээрээ EQ (Emotional Intelligence test) сорилыг анх танилцуулсан байна. Улмаар 1987 онд EQ сорилыг ашиглаж судалгаа хийсэн анхны эрдэм шинжилгээний өгүүллүүдийг бичсэн.

Бие хүний онцлог

Бие хүний онцлогийг судалснаар сэтгэл хөдлөлийн хөгжлийн хувьд тухайн хүний суурь онцлогт тулгуурлаж (жишээлбэл сэтгэл санааны тогтвортой байдал, сэтгэл хөдлөлийн хариу үйлдлийн хурд), хөгжлийн бусад үзүүлэлттэй холбон харьцуулж, улмаар сэтгэл хөдлөлийн хөгжлийг нь тодорхойлох боломжтой. Мөн хүний суурь зан чанарын онцлог болоод бие хүний онцлогийг тодорхойлсноор нийгэмшихүйн хөгжлийн хувьд яагаад өөр байгааг эсвэл яагаад хоцрогдолтой байгаад дүн шинжилгээ хийх боломжтой болно. Зарим хүүхдүүд нийгмийн хэм хэмжээг дагахгүй байдлийг авч үзвэл энэ нь магадгүй тухайн хүүхдүүдийн сөрөг зан төлөвөөс (Ротбартын тестийн нэг хэмжүүр) болсон байх жишээтэй.

Бие хүний онцлог:

1. Идэвхтэй/гадагшаа (ээрэг хүлээлт, өдөөлттэй, өндөр идэвхтэй, мэдрэмжтэй),
2. Сөрөг нөлөөтэй (айдас, уйтгар таагүй байдал, уур, цөхрөл),
3. Хичээмтгий хяналт (анхаарал төвлөрүүлэх шилжүүлэх, саатуулах/хүлээж авахгүй байх хяналт, хүртэхүйн мэдрэмж, таашаал бага хүлээн авалт) гэж Ротбат үзсэн.

Ээнэгшилт

Ээнэгшилт нь хүмүүсийн хооронд үүссэн цаг хугацаа, орон зайнаас үл хамаарах сэтгэлийн хөдөлгөөний бат бөх, тогтвортой холбоо юм (Ainsworth, 1973; Bowlby, 1969).

Хүүхдийн нийгэм-сэтгэлийн хөдөлгөөний хөгжил тогтвортой явагдахын тулд хүүхэд анхдагч асран хамгаалагчтай тодорхой холбоо харилцаа үүсгэсэн байх хэрэгтэй. Энэхүү харилцааны загвар нь насан туршид хадгалагдаж, тухайн хүний зан үйлийг тодорхойлдог (Bowlby, 1969).

Хэм хэмжээ, үнэт зүйл

Хэм хэмжээ гэдэг нь нийгэмд хүмүүс хэрхэн биеэ авч явах хэрэгтэй байдаг талаархи итгэл үнэмшил ба нийтээр хүлээн зөвшөөрсөн зан үйлийн тогтсон загвар юм. Мөн зохистой болон зохисгүй хэм хэмжээ, үнэт зүйлс, итгэл үнэмшил,

хандлага болон зан үйлийн талаарх хүмүүсийн тогтоосон (хэрэглэдэг) дүрэм журам юм. Эдгээр дүрэм журмууд нь ил болон далд байж болно. Социологичид тодорхойлохдоо хэм хэмжээ гэдэг бол нийгмийн зан үйлийг жолоодож байдаг албан бус ойлголт хэмээн үзсэн.

Үнэт зүйл нь зан үйлийг бүрэлдүүлэгч, тогтсон хэм хэмжээ нь зан үйлээр хэр их илэрдэг, нийгмийн бүлэг тухайн илэрч буй зан үйлийг хэрхэн хүлээж авдаг вэ гэсэн хоёр хэмжүүрээр тодорхойлогдоно.

Үнэт зүйлсийн төрлүүдийг ёс зүй, ёс суртахуун, үзэл суртал, оршихуй, оюун санааны, нийгмийн, гоо сайхны үнэт зүйлс гэж авч үздэг. Эдгээр үнэт зүйлс нь хүний зан төлөв, үйлдлийн сонголтод нөлөөлж, түүний баримжаалал болж байдаг.

Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн онцлог (бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшил)

Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжлийн онцлог


Хүүхэд, залуучуудын бие бялдрын өсөлт, хөгжлийг судлан харьцуулж байх нь тэдний өсөлт, хөгжлийн хурдцыг тогтоохоос гадна тэдэнд тохирсон стандарт боловсруулах үндэслэл болдог. Бие бялдрын хөгжлийг *биеийн өндөр (см), биеийн жин (кг), толгойн тойрог (см), гарын атгах хүч (кг), уушгины амьсгал гаргах хурд (л/сек)*-ны үзүүлэлтүүдээр хэмжив.

Биеийн жин

Хүүхэд, залуучуудыг жин дээр эгц харж, хөдөлгөөнгүй зогсоогоод 0.01 кг хүртэл нарийвчлалтайгаар хэмжсэн.

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын биеийн жин нь нас нэмэгдэх тусам физиологийн онцлогийн дагуу өссөн үзүүлэлттэй байна.

Зураг 2. Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын биеийн жингийн дундаж үзүүлэлт, см



Судалгаанд хамрагдсан 6-21 настай эрэгтэй, эмэгтэй хүүхэд, залуучуудын биеийн жингийн индексийг тооцож үзэхэд 6-11 настай эрэгтэй, эмэгтэй хүүхдүүд *жин багатай*, харин 12 наснаас *хэвийн* жинтэй байна.

Цээжний тойрог

Цээжний тойргийг хэмжихдээ хулдаасан эсвэл даавуун метр ашиглан *эрэгтэй* хүүхэд, залуучуудын далны доод өнцөг, өвчүүний дундуур, хөхний товчийг дайруулан; *эмэгтэй* хүүхэд, залуучуудын далны доод өнцөг, өвчүүний дундуур, хөхний дээд талаар дайруулан мм-ийн нарийвчлалтайгаар хэмжив.

Судалгаанд хамрагдсан эрэгтэй, эмэгтэй хүүхэд, залуучуудын цээжнийтойргийн дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам нэмэгдсэн байна. 6-10 насанд эмэгтэй хүүхдүүдийн цээжнийтойрог 8.4-10.0 см-ээр, эрэгтэй хүүхдүүдийнх 7.5-7.9 см-ээр нэмэгдсэн бол 15 наснаас энэ үзүүлэлт багассан буюу эмэгтэй хүүхэд, залуучуудынх 1.3-2.4 см-ээр, эрэгтэй хүүхэд, залуучуудынх 2.4-5.3 см-ээр тус тус нэмэгджээ.

Эмэгтэй хүүхэд, залуучуудын цээжнийтойрог хамгийн ихдээ 11 насанд 5.3 см-ээр нэмэгдсэн байгаа нь тэдний биеийн өсөлттэй холбоотой. Цээжний тойрог ба байршил, сургуульд хамрагдалт ялгаагүй, хамааралгүй байна.

Толгойн тойрог


Хүүхэд/залуучуудыг эгц зогсоож *дагзны болон хөмсөгний төвгөр* хэсгийг дайруулан хулдаасан болон даавуун метр ашиглан 1 мм-ийн нарийвчлалтайгаар хэмжив.

Судалгаанд хамрагдсан 6-21 настай эрэгтэй, эмэгтэй хүүхэд, залуучуудын толгойн тойргийн хэмжээ 6-10 насанд ижил, 11-14 насанд эмэгтэй хүүхдүүдийнх 0.2 см-ээр нэмэгдэж, 21 насанд 55-57 см болдог байна.

Гарын атгах хүч

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын баруун ба зүүн гарын атгах хүчийг 50-100 хүртэл кг заадаг тусгай багаж болох динамометрээр хэмжив.

Зураг 3. Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт, кг



6-21 настай эмэгтэй хүүхэд, залуучуудын зүүн гарын атгах хүчний дундаж үзүүлэлт аажмаар өсөж, 12 насанд хамгийн их өссөн буюу

3.4 км-аар илүү атгаж, 17 насандаа хамгийн их буюу 22.4 кг байна. Эрэгтэй

хүүхэд, залуучуудын хувьд энэ үзүүлэлт нас нэмэхийн хэрээр байнга өсөж, ялангуяа 15 насанд зүүн гарын атгах хүч нэлээн өссөн буюу 4.9 кг-аар илүү атгажээ.

Уушгины амьсгал гаргах хурд

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын уушгины амьсгал гаргах хүчийг тусгай багаж болох спирометрээр хэмжив.

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын уушгины амьсгал гаргах хурдны дундаж нь нас нэмэгдэх тусам сайжирсан байна. Эрэгтэй хүүхдүүдийн уушгины амьсгал гаргах хурдны дундаж илүү байна.

Хөдөө орон нутгийн хүүхэд, залуучуудын уушгины амьсгал гаргах хурд нь хотын хүүхэд, залуучуудынхаас илүү байна.


Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын бие бялдрын бэлтгэлжилтийн онцлог

Судалгаанд хамрагдсан хүүхдүүдийн бие бялдрын бэлтгэлжилтийг хурд (сек), хүч (удаа), уян хатан (см), авхаалж самбаа (сек) болон байрнаас уртад харайх буюу доод мөчдийн динамик хүч (см) гэсэн чанаруудаар авч үзэв.

Хурдны чанар

6-21 настай хүүхэд залуусыг 30, 50 метрийн зайд гүйлгэж хурдны чанарыг тодорхойлохдоо секундомерийн 0,01 сек хүртэл нарийвчлалаар хугацааг хэмжив. 6-21 настай эрэгтэй хүүхэд, залуучуудын хурдны чанар нь нас нэмэгдэх тусам сайжирсан дүр зурагтай байна.

Зураг 4. 6-21 настай хүүхэд, залуучуудын хурдны чанарын дундаж үзүүлэлт, сек



Хүчний чанар

6-21 настай хүүхэд, залуучуудыг гар дээр нь сунилгаж хүчний чанарыг тодорхойлов.

Бага боловсролын түвшний хүүхдүүд хамгийн ихдээ 55 удаа (8 настай эрэгтэй), 33 (10 настай эмэгтэй) сунисан байна. Суурь боловсролын түвшний эрэгтэй

хүүхдүүд хамгийн ихдээ 51 удаа (17 нас) хамгийн багадаа, эмэгтэй хүүхдүүд 40 (14 нас) удаа суниажээ. Бүрэн дунд боловсролын түвшний эрэгтэй хүүхдүүд хамгийн ихдээ 60 удаа (17 нас), эмэгтэй хүүхдүүд 50 (17 нас) удаа суниажээ.

Мэргэжлийн болон дээд боловсролын түвшний эрэгтэй хүүхэд, залуучууд хамгийн ихдээ 58 удаа (20 нас), эмэгтэй хүүхдүүд 39 (20 нас) удаа суниажээ.

6-21 настай хүүхэд, залуучуудын хүчний чанар нь тэдний нас болон хүйснээс хамааран ялгаатай байна.

Уян хатны чанар

Эмэгтэй хүүхэд, залуучуудын хувьд уян хатны чанарын дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам өссөн дүр зурагтай байгаад 18 насанд хамгийн өндөр буюу 14 см-ийн үзүүлэлттэй байна. Энэ нь биеийн жин болон биеийн өндөр өссөнтэй холбоотой байна.

Эрэгтэй хүүхэд, залуучуудын хувьд уян хатны чанарын дундаж үзүүлэлт нас нэмэгдэх тусам аажмаар өссөн дүр зурагтай байгаад 20 насанд хамгийн өндөр буюу 13 см-ийн үзүүлэлттэй байна

Авхаалж самбаа

Судалгаанд хамрагдсан 6-21 настай хүүхэд, залуучуудын авхаалж самбааны чанарыг 10 м-т гурван удаа хамгийн дээд хурдаар гүйлгэж, 0.1 секундын нарийвчлалтайгаар хэмжив.


Судалгаанд хамрагдсан 6-21 настай хүүхэд, залуучуудын авхаалж самбааны чанар нь нас нэмэгдэх тусам ерөнхийдөө сайжирсан байна.

Газарзүйн байршлаар нь авч үзэхэд хөдөө орон нутгийн хүүхэд, залуучуудын авхаалж самбааны чанар нь хотын хүүхэд, залуучуудынхаас сайн байна. Мөн эрэгтэй хүүхэд, залуучуудын авхаалж самбааны чанар илүү байна.

Тэсвэрийн чанар

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын тэсвэрийн чанарыг тодорхойлохдоо 6 настнуудыг 300 м, 7-114 настнуудыг 500 м, 15-18 настай хүүхэд, залуучуудыг 1000 м, 19-21 настай залуучуудыг 1500 м-т гүйлгэв.

Зураг 5. 6-21 настай хүүхэд, залуучуудын тэсвэрийн чанарын дундаж үзүүлэлт, сек



Хүүхэд, залуучуудын тэсвэрийн чанар нь ялгаатай буюу нас нэмэгдэх тусам энэ чанар суларсан байна. Тэсвэрийн чанар нь хүүхэд, залуучуудын нас, хүйс болон газарзүйн байршилтай холбоотой буюу эрэгтэй хүүхдүүдийн тэсвэрийн чанар илүү, хөдөө орон нутгийн хүүхэд, залуучуудын энэ чадвар хотын хүүхэд, залуучуудынхаас сайн байна ($M=216.5$, $M=245.9$, $-.114^{**}$, $p<0.01$).

Мөн энэ чанар нь сургуульд хамрагдсан эсэхтэй холбоотой буюу сургуульд хамрагдаагүй болон сургууль завсардсан хүүхдүүдийн тэсвэрийн чанар сургуульд сурч буй хүүхэд, залуучуудынхаас илүү байна ($M=194.8$, $M=229.6$, $.083^{**}$, $p<0.01$).

Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын танин мэдэхүйн хөгжлийн онцлог

Бүх насанд хүүхэд, залуучуудын анхаарлын тогтворжилт сул байна. Юмсыг гадаад байдлаар нь харьцуулах чадвартай, дотоод мөн чанар, учир шалтгаанд нь харьцуулах нь сул. Байнга хэрэглэдэггүй үг хэллэгтэй мэдээллийг утгачлан тогтоох нь сул, өдөр тутам байнга хэрэглэдэг, бодит юмсыг заасан үгийн нөөц давамгайлдаг. Тэмдэг нэр, салаа утгатай үгийн нөөц сул, энгийн богино өгүүлбэрээр ярьдаг. “бөгөөд, гэвч, учраас, боловч, миний бодлоор” гэх мэт холбоос хэрэглэсэн нийлмэл өгүүлбэрийг нийт хүүхдүүд хэрэглэх нь маш сул. Санаагаа илэрхийлэх үгийн тоо нь дунджаар 5 хүртэлх минутад 20 байсан бол нас нэмэгдэх тусам үгийн тоо нэмэгдэж, ахлах ангид дунджаар 30 орчим үг ашиглан, эргээд 18 наснаас буурсан байгаа нь харагдлаа.

Ажигч чанар сайтай хүүхэд, залуучууд сонсоод мэдээллийг тогтоох, бодит үг тайлбарлах, салаа утгатай үг тайлбарлах, хийсвэр утгатай үг тайлбарлах, тэмдэг нэрийг утгын ижил төстэй шинжээр нь ангилах, нэрлэсэн үгийг утгаар нь бүлэглэх, хийсвэр болон салаа утгатай үгийг утгаар нь тайлбарлах чадвар сайн байна. Анхаарлын тогтворжилт ба анхаарлын шилжилт, ажиллах чадвар, утгын ой

тогтоолт, бодит үйлдлийн сэтгэхүй, бодит үг тайлбарлах, тэмдэг нэр үг бүлэглэх, салаа утгатай үг тайлбарлах хийсвэр үг тайлбарлах, тэмдэг нэр, салаа утгатай үг, хийсвэр утгатай үг бүлэглэх чадвар хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Анхаарлын тогтворжилт сайн хүүхэд, залуучууд анхаарлын шилжилт, утгын ой, хийсвэр үг тайлбарлах, тэмдэг нэр, салаа утгатай үг, хийсвэр утгатай үгийг бүлэглэх чадвар сайтай байна. Анхаарлын шилжилт нь ажиллах чадвар утгын ой тогтоолт, хийсвэр сэтгэхүй, бодит үйлдлийн сэтгэхүйн хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Сонорын ой тогтоолт нь утгын ой тогтоолт, үг тайлбарлах, үг бүлэглэх ба зургийн үйл явдлыг тоочиж санаагаа илэрхийлэх, зургийн гол санаа агуулгыг дүгнэж ярих чадварын хооронд ач холбогдол бүхий ялгаатай байна. Сонорын ой тогтоолт сайн хүүхэд, залуучуудын утгаар нь мэдээллийг тогтоох, хийсвэр, тэмдэг нэр, салаа үгсийг утгаар нь бүлэглэх чадвар сайн байна.

Утгын ой тогтоолт нь хийсвэр сэтгэхүй буюу сэтгэхүйн харьцуулах үйлдэл гүйцэтгэх чадвар, үг тайлбарлах, хийсвэр үг, тэмдэг нэр, салаа үг бүлэглэх чадвар хооронд статистик ач холбогдол бүхий ялгаатай байна.

Нийт судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын бодит утгатай үгийг бүлэглэх чадвар нь сургуульд хамрагдалтын хувьд ялгаа алга бол тэмдэг нэр, нэрлэсэн үг, салаа утгатай үг, хийсвэр үгсийг бүлэглэх чадвар нь сургуулийн сурагчдад илүү сайн байна.

Хүүхэд, залуучуудын үг тайлбарлах, бүлэглэх чадвар нь үгийн төрөл зүйлийн хувьд харилцан хамааралтай байгаа тул ухагдахууны төлөвшил хэвийн байна. Хүүхэд, залуучуудын үгийн нөөцийг сайжруулах нь чухал байна.

6-21 настай хүүхэд, залуучуудын танин мэдэхүйд ажигч чанар, анхаарлын тогтворжилт, шилжилт, сонорын ой, утгын ой тогтоолт чухал ач холбогдолтой байна.

Юмсын ялгаатай ба өвөрмөц талыг богино хугацаанд хүртэх, бүтээлч чанар, сэтгэхүйн хурд, сонсоод мэдээллийг тогтоох, мэдээллийг утгачлан тогтоох нь ухагдахуун төлөвшилд чухлаар нөлөөлдөг байна. Ялангуяа, хийсвэр үг, тэмдэг нэр, салаа утгатай ухагдахууны төлөвшилд эерэгээр нөлөөлж байна. Ийм онцлог бүхий хүүхэд, залуучууд ухагдахууны гол шинжийг нь тусган тайлбарлах, ангилах сэтгэхүйн чадвар сайн байна.

Монголын 6-21 настай хүүхэд, залуучуудын нийгэмшлийн онцлог

Өөртөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх нь эерэг. Нийцтэй, нөхөрсөг, бусадтай харилцах, хамтрах сонирхол сайтай. Өсвөр насанд бусдыг хүлээн зөвшөөрөх нь буурч, шүүмжлэлтэй хандлага бий болно. Өсвөр насанд эцэг эхтэйгээ дотно харилцах нь суларсан.

Дээд боловсролын түвшинд эцэг эхтэйгээ харилцах харилцаа, дотно хандлага сайжирч байна. Бусдын сэтгэл санааг ойлгож харилцах чадвар нь 11-17 насанд сул ($M=2.1$) харин 18-21 насанд сайн ($M=3.9$). Өсвөр насанд айдас нэмэгдсэн. 6-21 настай хүүхэд, залуучуудын сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан байдал нь тэдний сэтгэлийн хөдөлгөөний чадварын хөгжилтэй холбоотой байна ($p<0.01$).

Энэ настай хүүхэд, залуучуудын гэртээ амьдардаг эсэх нь тэдний нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх чадварын хооронд ач холбогдол бүхий ялгаа байна. Таньдаг айлд, хамаатныдаа болон дотуур байранд амьдардаг хүүхэд, залуучуудын хувьд сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, удирдах чадвар харьцангуй дундаж түвшинд байна. Хамаатныдаа амьдардаг нь дунджаас бага зэрэг доогуур, өвөө эмээгийн дээ эсвэл гэртээ амьдардаг хүүхэд, залуучуудын өөрийн болон бусдын сэтгэлийн хөдөлгөөний ойлгох чадвар нь дунджаас дээш өндөр түвшинд байна.

Амьдралын нөхцлийн ялгаатай байдал нь энэ настай хүүхэд, залуучуудын идэвхтэй, нийцтэй зан, ухамсартай зан, өөрийн сэтгэлийн хөдөлгөөний ойлгож, удирдахтай холбоотой байна.

Эцгийн боловсрол нь бусдыг хүлээн зөвшөөрөх чадвартай холбоотой байна. Мөн эцгийн боловсролын ялгаатай байдал нь аюулгүй хамгаалалттай байдал, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох, өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадваруудтай холбоотой байна.

Сургуулиас зохиосон ажил эсвэл олон нийтийн ажилд оролцдог хүүхэд, залуучуудын аюулгүй хамгаалалттай байдал, бусдаар хүндлүүлэх болон өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвартай эерэг хамааралтай байна.

Спортоор хичээллэдэггүй хүүхэд, залуучуудын олон нийтийн газар биеэ авч явах хэмжээ сул байна.

Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын унтдаг цаг нь өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэл, анхааралтай зан, идэвхтэй зангийн хооронд ач холбогдолтой ялгаа байна. Өөрөөр хэлбэл, хүүхэд хэдийчийнээ эрт унтана өөртөө итгэх итгэл сайжирч, анхааралтай зан, идэвхтэй зантай болж байна. Мөн өөрийн зан

төлөвийг удирдах бусдыг хүлээн зөвшөөрөх чадвар ба унтдаг цаг нь холбоотой байна.

Энэ судалгааны дүнд монголын судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын 50.7 хувь нь эмэгтэй, 57.3 хувь нь зургаагаас дээш гишүүнтэй гэр бүлд амьдардаг байна гэсэн үзүүлэлт гарлаа. Судалгаанд хамрагдсан хүүхэд, залуучуудын 78.6 хувь нь гэртээ амьдардаг, 56.3 хувь нь цэвэр ус, халуун хүйтэн усанд холбогдоогүй гэр хороололд амьдардаг.

Нийт хүүхдийн 12 хувь нь нийтийн тээврээр, 8 хувь нь хувийн унаагаар сургуульдаа очдог байна. Судалгаанд хамрагдагсдын 46.0 хувь нь спортоор хичээллэдэг, ихэнх нь багийн спортоор хичээллэдэг байна.

Судалгаанд хамрагдсан нийт хүүхэд, залуучуудын эхийн боловсролын түвшин өндөр байна. Мөн эдгээрийн 82.4 хувь нь 700.000 хүртэлх төгрөгний орлоготой гэр бүлд амьдарч байна.

Бие бялдрын хөгжил

- Бага боловсролын түвшинд буюу 10-11 насанд хүүхдийн өсөлт хамгийн их байгаа ба бүрэн дунд боловсролын түвшинд буюу 14-15 насанд хүүхдүүдийн биеийн өндөр хурдтай нэмэгддэг байна.
- Биеийн жингийн өсөлт 16 наснаас 20 насанд эрчимтэй явагддаг байна.
- Баруун, зүүн гарын атгах хүч 10-11 насанд, 14-15 насанд гарын атгах хүч нэмэгддэг бол 17-18 насанд бага зэрэг буурсан тал ажиглагдаж байна.
- Сургуулийн өмнөх боловсролд хамрагдсан хүүхэд, залуучуудын биеийн жин, биеийн өндөр, цээжний тойрог, баруун ба зүүн гарын атгах хүчний хөгжил сайн байна.
- Хүүхэд, залуучуудын уян хатан чанар 6-21 нас хүртэл сайжирсан үзүүлэлттэй байгаа ч ялангуяа 12 наснаас эмэгтэй хүүхдүүдийн хувьд уян хатан чанар эрчимтэй нэмэгддэггүй байна.
- Эрт буюу оройн 8 цагаас 10 цагийн хооронд унтах нь бие бялдрын бэлтгэлжилтэнд сайнаар нөлөөлдөг байна.
- Бие бялдрын хөгжлийн үзүүлэлтүүд нь харилцан хамааралтай хөгжиж байна.
- Гэр бүлийн харилцаа сайн байх тусам хүүхэд, залуучуудын биеийн хөгжил сайн байна.
- Сургуульд хамрагдсан 6-21 настай хүүхэд, залуучуудын биеийн жин нь сургуульд хамрагдаагүй хүүхэд, залуучуудынхаас илүү байна.

Бие бялдрын бэлтгэлжилт

- 6-12 насанд хүүхдүүд хурд сайтай байгаа ба 13 наснаас эхлэн эмэгтэй хүүхдүүдийн хурд буурдаг байна.
- Албан боловсролд хамрагдах нь хүүхэд, залуучуудын хурд, тэсвэр, авхаалж самбаатай байх чанарт нөлөөлдөг байна.
- Гэр бүлийн харилцаа сайн буюу эерэг байх нь хүүхэд, залуучуудын авхаалж самбааны хөгжилд нөлөөтэй байна.
- Хүчний чанар нь хүүхэд, залуучуудын нас, хүйс газар зүйн байршил буюу - хаана амьдарч буйгаас шалтгаалан ялгаатай хөгждөг байна.
- Уян хатан чанар нь мөн хүүхэд залуучуудын хүйс, сургуульд хамрагдалт, амьдарч буй газар зүйн байршилаас шалтгаалан ялгаатай хөгждөг байна.
- Хөдөө орон нутагт амьдарч буй хүүхэд, залуучуудын уян хатан чанар илүү сайн байна.
- Хөдөө орон нутагт амьдарч буй хүүхэд, залуучуудын уушгины амьсгал гаргах хурд сайн байна.
- Нас нь тэсвэрийн чанарт нөлөөлдөг байна. Мөн хөдөө орон нутгийн хүүхэд, залуучуудын тэсвэрийн чанар хотын хүүхэд, залуучуудынхаас илүү байна.
- Биеийн жин ба өндөр нэмэгдэх тусам хүчний чанар, уян хатан чанар нэмэгдэж, тэсвэртэй болж байна.
- Биеийн жин ба өндөр нэмэгдэх нь авхаалж самбааны чанарт сөргөөр нөлөөлдөг байна.
- Хүчний чанар сайтай байвал авхаалж самбаатай чанар сул байдаг байна.

Танин мэдэхүйн хөгжил

- Бага боловсролын түвшинд анхааралтай хүртэх чадвар сул түвшинд байгаа бол суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд ажигч чанар дунд түвшинд буюу тэд богино хугацаанд юмсын ялгаатай, өвөрмөц шинжүүдээс 5-7 хүртэлхийг ажигладаг нийтлэг онцлогтой байна.
- Сургууль завсардсан хүүхэд, залуучуудын болон сурагчдын ажигч чанар ялгаатай байна. Сургууль завсардсан хүүхэд, залуучуудын ажигч чанар сул түвшинд байна.

- Бага боловсролын түвшинд суралцаж буй хүүхдүүдийн анхааралын тогтворжилт, ажиллах чадвар сайтай байгаа бол суурь болон бүрэн дунд боловсролын түвшинд анхаарлын тогтворжилт, шилжилт сул буюу тодорхой хугацааны турш зорилго чиглэлтэйгээр анхаарлаа төвлөрүүлэн үйлдлийг гүйцэтгэх нь хангалтгүй байгаа нь тэдний бүтээлч чанар, сэтгэхүйн хурд сул байгаа илэрхийлж байна.
- Сонсоод мэдээллийг тогтоох нь дундаж түвшинд байна. Өөрөөр хэлбэл, богино хугацаанд үгсийг сонсоод 5-6 хүртэлхийг тогтоодог байна.
- Нийт хүүхэд, залуучуудын утгачлан тогтоох чадвар нь дундаж түвшинд байна.
- Богино хугацаанд мэдээллийг харж тогтоох чадвар доогуур түвшинд буюу богино хугацаанд 4-5 хүртэлх нэгжийг тогтоодог байна.
- Юмсын дотоод мөн чанарыг нь танин мэдэж, онцлог шинжийг нь харьцуулан нийтлэг болон ялгаатай шинжийг нь олох сэтгэхүйн харьцуулах чадвар сул байна.
- Албан ёсны сургалтын тогтолцоо нь хүүхдийн танин мэдэхүйн болон хэл ярианы хөгжилд чухлаар нөлөөлдөг байна.
- Боловсролын түвшин нэмэгдэх тусам хүүхэд, залуучууд зорилготойгоор санаа бодлоо илэрхийлэхдээ тоочиж,энгийн өгүүлбэрээр санаагаа ихэвчлэн илэрхийлж анги ахих тусам өгүүлбэрийн бүтэц өөрчлөгдөн, тоочин ярих нь буурч зургийн санааг дүгнэж ярьдаг байна.
- Сургуульд завсардсан хүүхэд, залуучууд зургийн гадаад шинж, үйл явдлыг байгаагаар нь тоочин ярьдаг бол анги ахих тусам сурагчид гол санааг дүгнэж ярьдаг байна.

Нийгэмшлийн хөгжил

- *Өөртөө хандах хандлагын* хувьд судалгаанд хамрагдсан хүүхдүүд өндөр түвшинд байгаа нь өөрийгөө байгаагаар нь хүлээн зөвшөөрдөг, өөрийнхөөрөө байж чаддаг ч цөөн тохиолдолд тайван байдлаа алддаг байна. Мөн өөрийн зан чанар, онцлогтой зөрчилдөөд байдаггүй, амьдралын баяр баясгалантай байдлаа хадгалж чаддаг ч заримдаа өөрийн хүчинд хэт эрдэх тал байна.

- *Зан төлөвийн* хувьд бага болон ахлах ангийн настай хүүхдүүд бусадтай нийцтэй харилцаатай, хийж буй ажил үйлдээ хариуцлагатай ханддаг, идэвх урам зориг сайтай. Уйтгарлан гуних нь хурдан, уйтгараасаа салах нь удаан учраас ямар нэг шүүмжлэлд эмзэг хандаж, гомдох талтай. Суурь болон дээд боловсролд суралцаж буй хүүхэд, залуучуудын хувьд хэвийн тогтвортой харилцаатай, өөрийн хийх ёстой гэж үзсэн, өөрийн сонирхсон зүйлээ идэвхтэй сайн гүйцэтгэдэг. Гэвч сэтгэл санааны байдал нь тухайн нөхцөл байдлаас шалтгаалан өөрчлөгддөг. Бусадтай харилцаа холбоо тогтоохдоо санаачилгатай биш ч бэрхшээдэггүй, хашир болгоомжтой зантай байна.
- *Ээнэгшилтийн* хувьд эцэг эх, ойр дотны хүмүүсийнхээ дэмжлэгэд бүрэн итгэдэг, эцэг эхийгээ үнэлдэг, тэдэнтэй хэвийн харилцаатай. 11-17 настай хүүхдүүдийн хувьд эцэг эх, хүүхдийн хөндийрэл дунджаас дээш буюу өндөр түвшинд байгаа нь заримдаа эцэг эхчүүдтэйгээ нээлттэй бус, эцэг эх, асран хамгаалагчдаасаа хол байх чадвартай байгааг харуулж байна.
- *Сэтгэлийн хөдөлгөөний* хувьд 6-10 настай хүүхдүүд болон 18-21 настай залуучуудын бусдын сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох болон өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг удирдах чадвар нь өндөр түвшинд байгаа нь хүний гадаад төрх байдлыг хараад тэдний сэтгэлийн хөдөлгөөн, учир шалтгааныг таних чадвар сайн байгааг илэрхийлж байна. Мөн эерэг сэтгэлийн хөдөлгөөнөө хадгалах, сөрөг сэтгэлийн хөдөлгөөнөө хянан зохицуулах нь сайн, нөхцөл байдалд зохицуулан сэтгэлийн хөдөлгөөний илрэлийг гаргаж чаддаг байх талтай Харин суурь болон бүрэн дунд боловсролын түвшний хүүхдүүдийн хувьд энэ гурван чадвар нь харьцангуй сул буюу дундаж түвшинд байна.
- 6-21 настай эмэгтэй хүүхэд, залуучуудын хувьд өөрийн сэтгэлийн хөдөлгөөнийг ойлгох чадвар сайн байна.
- *Харилцааны хөгжлийн* хувьд бусдын сэтгэл санааг ойлгож, харилцах чадвар суурь ба бүрэн дунд боловсролын настай хүүхэд, залуучуудад сул түвшинд байна.
- Нийгмийн хэм хэмжээг дагаж мөрдөх чадвар нас насанд харилцан адилгүй байна.
- Дасан зохицох чадвар нь 6-21 настай хүүхэд, залуучуудын нас, тэдний оршин буй газарзүйн байршлаас хамааран ялгаатай байна.
- Эцгийн боловсролын түвшин өндөр байх тусам хүүхэд, залуучуудын зан төлөв, ээнэгшил, аюулгүй хамгаалалттай байдал болон сэтгэлийн хөдөлгөөний хөгжил сайн байна.

- Түрээсийн байранд амьдардаг хүүхэд, залуучуудын өөрийн үнэлэмж болон өөртөө итгэх итгэл нь орон сууц, гэр хороолол болон дотуур байранд амьдардаг хүүхэд залуучуудынхаас сул байна. Орон сууцанд амьдардаг хүүхэд, залуучуудын өөртөө хандах хандлага нь өндөр түвшинд байна.

Сургуулийн өмнөх боловсролын хөгжил

2016-2017 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролд 243,432 хүүхэд хамрагдаж байгаа бөгөөд энэхүү үйлчилгээний гадна 63,458 хүүхэд байна. Энэ хичээлийн жилд үйл ажиллагаа явуулж буй 1354 цэцэрлэг (төрийн өмчийн 854, төрийн бус өмчийн 500)-т нийт 219,811 хүүхэд, хувилбарт сургалтын үйлчилгээнд 23,621 хүүхэд тус тус хамрагдаж байна.

Улсын хэмжээнд жил бүр 30 орчим цэцэрлэгийн барилга ашиглалтад оруулж буй хэдий ч насжилт өндөртэй 50-60 жил ашиглагдсан барилгууд ашиглалтын шаардлага хангахгүйд хүрч байгаа (жилд 20-30 барилга ашиглах боломжгүй болж байна) нь цэцэрлэгийн гаднах хүүхдийн тоог жил ирэх тутам нэмэгдүүлж байна. Сүүлийн жилүүдэд хүн амын төрөлт нэмэгдэж байгаа нь мөн л цэцэрлэгийн хэрэгцээг нэмэгдүүлсээр байна.

Ашиглалтын шаардлага хангахгүй талаар мэргэжлийн байгууллагын дүгнэлт гарсан хэдий ч сургуулийн өмнөх боловсролын үйл ажиллагааг тасалдуулахгүй явуулж байгаа цэцэрлэг ч цөөнгүй байгаа нь хүүхдийн эрүүл мэнд, аюулгүй байдалд эрсдэлт нөхцөл бий болгож байна. Түүнчлэн цэцэрлэгийн нэг бүлэгт байх хүүхдийн тоо 25 байх ёстой атал төвлөрсөн суурийн газруудад 50-66 хүүхэдтэй бүлэг олон байгаа нь хүүхдийн эрүүл, аюулгүй байдалд эрсдэл бий болгож, улмаар багшийн ачааллыг ихэсгэх, үйлчилгээний чанарт сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болж байна.

Цэцэрлэгийн 1 хүүхдэд ногдох орны үйлчилгээг бий болгоход 15.2 сая төгрөг шаардагддаг бөгөөд 100 хүүхдийн цэцэрлэг барихад 1.5-2 тэрбум төгрөг зарцуулж, 1-1,5 жилийн хугацаа шаардагдаж байна. Төв суурийн газруудыг чиглэсэн шилжилт, хүн амын өсөлт нэмэгдэж байгаа зэрэг хүчин зүйлс нь сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хүртээмжид ихээхэн нөлөөлж байгаа бас нэгэн хүчин зүйл юм. Иймд тухайн орон нутгийн нөхцөлд тохирсон олон хувилбарт арга хэмжээ хэрэгжүүлэх нь асуудлыг оновчтой шийдэх гарц гэж үзэн, зохих арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд байгууллагын цэцэрлэг байгуулах, төрийн бус өмчийн цэцэрлэг байгуулахыг

дэмжих, төрийн бус өмчийн цэцэрлэгийн ашиглалтгүй орон зайг ашиглан төрийн цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулах зэрэг арга хэмжээ авч байна. Тухайлбал, 2016-2017 оны хичээлийн жилд төрийн өмчийн 4,140 орны хүчин чадал бүхий 34 цэцэрлэг, төрийн бус өмчийн 4,431 орны хүчин чадал бүхий 73 цэцэрлэг шинээр байгуулагдсан.

Цаашид сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх хүрээнд төрийн өмчийн хөрөнгөөр нэн тэргүүнд хүн амын нягтшил ихтэй хот суурийн газруудад цэцэрлэг барих, хөдөө орон нутагт ашиглалтын шаардлага хангахгүй болсон цэцэрлэгийн барилгыг шинэчлэх болон хувилбарт сургалтын үйлчилгээг өргөжүүлэх бодлого баримталж байна.

Хүн амын нийслэл рүү чиглэсэн шилжилт, хүн амын нягтшил нэмэгдэж байгаа нь нийслэлийн сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд ихээхэн ачаалал үүсгэж байна. Улсын хэмжээнд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний гадна байгаа 63,458 хүүхдийн 70.4 хувь болох 44,500 хүүхэд Улаанбаатар хотод байна. Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 10,0 гаруй хувь болох 300,000 орчим хүн ам бүхий 25 хороо цэцэрлэггүй байна. Үүнд: Баянгол дүүрэгт 5 /1, 16, 21, 22, 23 дугаар хороо/ хороо, Баянзүрх дүүрэгт 6 хороо (2, 14, 17, 24, 25, 26 дугаар хороо), Налайх дүүрэгт 1 хороо (7 дугаар хороо), Сүхбаатар дүүрэгт 5 хороо (2, 5, 9, 12, 19 дүгээр хороо), Сонгинохайрхан дүүрэгт 6 хороо (5, 20, 23, 26, 28, 29 дүгээр хороо), Чингэлтэй дүүрэгт 2 хороо (5, 11 дүгээр хороо) тус тус цэцэрлэггүй байна⁴⁴.

Улаанбаатар хотод нийт цэцэрлэгийн 37 хувь болох 79 цэцэрлэгийн хүчин чадал хамран сургах тойргийн хүүхдэдээ хүрэлцэхгүй байна. Хамран сургах тойргийнхоо хүүхдийн зөвхөн 20 хувийг хамруулах хүчин чадалтай цэцэрлэгүүд цөөнгүй байна.

Сүүлийн үед шинээр ашиглалтад орж буй орон сууцны хорооллууд тухайн орчин дахь цэцэрлэгийн ачааллыг улам нэмэгдүүлж байна. Иймд шинээр баригдах орон сууцны зураг төсөвт тавигдах шаардлагад өөрчлөлт оруулж, цэцэрлэг, сургуулийг хамтад нь төлөвлөж байх хэрэгцээ байна. Энэхүү хэрэгцээг хангах үүднээс Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 8 дугаар сарын 17-ны өдрийн “Цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” 40 дүгээр тогтоолд “Улаанбаатар хотод сургуулийн өмнөх боловсрол олгох цэцэрлэгийн хүрэлцээг сайжруулах зорилгоор шинээр барих орон сууцны

⁴⁴ Нийслэлийн Боловсролын газраас 2017 оны 4 дүгээр сард авсан мэдээлэл

хороолол, хотхон болон конторын зориулалттай 9-өөс дээш давхар барилгын зураг төсөлд цэцэрлэг төлөвлөн тусгаж байхаар норм, дүрэмд оруулах"-аар шийдвэрлэсэн.

Цэцэрлэгийн хамран сургалтын нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2016-2017 оны хичээлийн жилд хүчин чадалдаа хүрч ажиллаж чадахгүй байгаа төрийн бус өмчийн цэцэрлэгийн сул орон зайд төрийн өмчийн цэцэрлэгийн үйл ажиллагаа явуулснаар 3087 хүүхдийг цэцэрлэгт хамруулж, улсын төсвөөс нийт 4,9 тэрбум төгрөг зарцуулж байна.

2017 онд Баянзүрх дүүргийн 24, Сонгинохайрхан дүүргийн 20, 22, Чингэлтэй дүүргийн 8 дугаар хороонд тус тус нэг цэцэрлэг (390 орны хүчин чадалтай) ашиглалтад орно. Сонгинохайрхан дүүргийн 188 дугаар цэцэрлэг, Хан-Уул дүүргийн 144 дүгээр цэцэрлэг, Чингэлтэй дүүргийн 102 дугаар цэцэрлэгт өргөтгөлийн барилга (450 орны хүчин чадалтай) ашиглалтад орно.

Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яамнаас нэн тэргүүнд нийслэлийн цэцэрлэггүй хороо, шинэ суурьшлын бүсэд шинээр цэцэрлэг барих, өндөр ачаалалтай, цэцэрлэгийн барилгаа өргөтгөх газартай, барилга нь давхарлах боломжтой цэцэрлэгүүдэд өргөтгөл барих бодлого баримталж байна. Гэсэн хэдий ч нийслэлийн хэмжээнд цэцэрлэгийн хэрэгцээг зөвхөн төрөөс цэцэрлэг барих замаар асуудлыг шийдвэрлэх боломжгүй байна. Иймд хувийн хэвшлийн цэцэрлэг байгуулахыг дэмжих, байгууллагын цэцэрлэгийн эрх зүйн орчин бий болгох, монгол орны нөхцөлд тохирсон сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний оновчтой арга, технологи, зохион байуулалтын шинэ арга хэлбэрийг судалж, нэвтрүүлэх шаардлага байна.

Монгол улсын ерөнхий боловсрол

2015-2016 оны хичээлийн жилийн байдлаар Монгол улсын ерөнхий боловсролын 768 сургуульд 535100 сурагч суралцаж, бага, дунд боловсролын 28490 багш ажиллаж байна². Монголын бүх шатны боловсролын сургалтад бараг 1 сая шахам хүүхэд, залуучууд суралцаж байгаагийн 50 гаруй хувийг ерөнхий боловсролын сургуулийн сурагчид эзлэж байна.

Монголын ерөнхий боловсролд зөвхөн сүүлийн 10 гаруй жилд тодорхой өөрчлөлт, шинэчлэлт гарав. Тухайлбал, 2004 оноос бага, дунд боловсролын стандартыг тогтоон хэрэглэсэн, 2006 оноос 11 жилийн сургалтын, 2008 оноос 12 жилийн боловсролын үндэсний сургалтын хөтөлбөрийг мөрдсөн, 2010 оноос Кембрижийн боловсролын стандартыг сурах бичиг, хөтөлбөр, үнэлгээ, багш

бэлтгэх бодлогын хүрээнд авч хэрэглэж, 2013 оноос сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэсэн зэрэг онцлог үйл явдал, өөрчлөлтүүд гарсан байна.

2004 оноос НҮБ-ын Боловсрол, соёл, шинжлэх ухааны байгууллага ЮНЕСКО-гоос судлан тодорхойлж, олон улсад дэвшүүлсэн 21-р зууны хүн ардын суралцахуйн 4 тулгуур үнэт зүйл буюу а. Мэдэж сурах б.Хийж сурах в. Бие даан амьдарч сурах г.Хамтаар нийгэмшин амьдарч сурах гэсэн чадамжид баримжаалсан бага, дунд боловсролын төвшний болон тухайн боловсролын (монгол хэл,математик, физик, хими, түүх, нийгмийн ухааны г.м.) стандартыг боловсруулан баталгаажуулж, сургалтад мөрдөж, хэрэгжүүлсэн ч ЕБС-ийн багш нарын мэдлэг, чадварын төвшин, хэрэглэгчдийн сэтгэл зүйн бэлтгэл, боловсролын салбарын удирдлагын нэгдмэл, бүтээлч хандлага дутсан зэрэг хүчин зүйлүүдээс шалтгаалж, амьдралд бүрэн хэрэгжиж чадаагүй юм. Гэсэн ч эл стандартыг албан ёсоор хүчингүй болгоогүй бөгөөд түүнийг боловсруулсан туршлага, сургамж нь өдгөөгийн Засгийн газраас стандартад суурилсан боловсролыг хөгжүүлэх зорилго, зорилтыг дэвшүүлэн тавьж байгаа нөхцөлд зохих ач холбогдолтой билээ.

Монгол Улсын Засгийн Газраас ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөрийг Кембрижийн ерөнхий боловсролын олон улсын хөтөлбөртэй уялдуулан шинэчилж эхлэх шийдвэрийг 2010 онд гаргасан юм. Эл шийдвэрийн хүрээнд 2011 оны 2 дугаар сард Кембрижийн Их Сургуулийн Олон Улсын Шалгалтын төв (ОУШТ)-ийн зөвлөхүүд хүрэлцэн ирж, хамтран ажиллах үйл ажиллагааны чиглэлээр Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Боловсролын хүрээлэн, Монгол Улсын Их Сургууль, Монгол Улсын Боловсролын Их Сургууль, Боловсролын үнэлгээний төв болон бусад мэргэжлийн байгууллага, эрдэмтэн, судлаачид, багш нарыг хамруулсан судалгаа, боловсруулалтын ажил хийж, эдгээрийн үр дүнд нийт ЕБС-иудад байгалийн ухааны боловсролын сургалтын олон улсын хөтөлбөр, арга зүй нэвтэрч байгаагийн зэрэгцээ Нийслэл Улаанбаатар хотноо Кембрижийн боловсролын хөтөлбөрөөр Шинэ эрин, Шинэ эхлэл,Монгол тэмүүлэл зэрэг ЕБ-ын сургуулиуд хичээллэж байна.

Монголын БСШУЯ 2012-2016 онд бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрүүд болон амьдрах чадвар, хичээлээс гадуурх үйл ажиллагаа, иргэний боловсролын чиглэлүүдийг боловсруулан гаргаж, нийт ЕБС-иудын сургалтад хэрэгжүүлэв. Сургалтын цөм хөтөлбөр юуны өмнө дараах 7 онцлог шаардлагыг хангасан байх ёстой гэж тэр үед шаардаж байжээ. Тухайлбал:

1. Бүх суралцагчийн хөгжил, төлөшлийн хувьд ханган биелүүлэх нийтлэг, нэгдмэл зорилгыг тодорхойлж өгсөн байх,
2. Бүх сурагчийн эзэмших нийтлэг мэдлэг, чадвар, хандлагыг тусган оруулах,
3. Хичээлүүд буюу судлагдахуунуудыг нэгтгэсэн, интеграцчилсан, тодорхой холбоо хамааралтай болгосон байх,
4. Судлагдахууны агуулгад суурилсан асуудал шийдвэрлэх арга зүй зонхилсон байх,
5. Багц цаг (кредит цаг)-аар зохион байгуулагдсан байх,
6. Багш суралцагчидтай хамтран суралцахуйгаа төлөвлөхийг дэмжсэн байх,
7. Суралцагчдад чиглүүлэг болох,

Эдгээр шаардлагын үүднээс үзвэл, нийт ЕБС-иудын сургалтад хэрэгжүүлж байгаа цөм хөтөлбөрийн зорилго, агуулга, бүтцэд засаж сайжруулах зүйл ч нэлээд байсан байна. Гэхдээ сургалтын энэхүү цөм хөтөлбөрт суралцагчийн үнэлгээний зорилго, шалгуур үзүүлэлт болон суралцагчийг шинжлэн судлах арга барилд суралцуулах асуудлыг шинээр тодорхой тусгасан нь чухал ололт бөгөөд залгамжлан хөгжүүлэх үнэт зүйл юм.

Хүснэгт 19. 1998-2016 онд хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдийн бүтэц, агуулгын хэсэгчилсэн тойм шинжилгээ (Суурь боловсролын жишээн дээр)

	Зорилго, зорилт	Агуулга, бүтэц	Аргазүй, хэрэглэгдэхүүн	Үнэлгээ	Сургалтын хөтөлбөрийн онцлог
Боловсролын стандартын тогтолцоо: бага, дунд боловсрол. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв, (1998 он)	Суурь боловсролын стандарт нь төр, иргэд, олон нийтийн хүн амд үзүүлэх суурь боловсролын үйлчилгээний нэгдмэл байдлыг хангах, суралцагчдын хөгжлийн наад захын төвшинг тодорхойлсон нийтлэг бөгөөд дахин давтан хэрэглэхээр сонирхогч талууд харилцан тохиролцож, сургалт хүмүүжлийн чанарт тавигдах шаардлага, шалгуур хэмжүүрийг тодорхойлсон норматив баримт бичиг юм. (1998 оны стандартын 2 дахь тал) Судлагдахуун тус бүрийн зорилтуудыг чадвар байдлаар гаргасан.	Суурь боловсролын түвшинд суралцагчдын хүрэх наад захын мэдлэг, чадварын тогтолцоо, хүрээг тодорхойлсон. Судлагдахуун бүрийн агуулгын түвшин, зорилт, цөм хөтөлбөрийг анги бүрээр тодорхойлсон.	Аргазүйн хувьд тодорхой шийдэл хийгээгүй байна. Харин байгалийн ухааны чиглэлийн судлагдахуунуудын дадлага ажлын чиглэлийг гаргасан байна.	Үнэлгээ тодорхой бус байна.	Энэхүү стандарт нь судлагдахуунд суурилж, сурагчдад мэдлэг, чадвар эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна. Эл стандарт нь бага, дунд боловсролын агуулгыг анх удаа стандартчилж өгсөн онцлогтой байна.
Монгол улсын стандарт MNS5420-14:2004	Бага, дунд боловсролын стандартуудын зорилго нь: Суралцагчдыг хариуцлагатай, бодит чадвартай, бүтээлч иргэд болон хөгжихөд нь шаардагдах цогц чадамжийг төлөвшүүлэхэд чиглэсэн үндэсний	Судлагдахуун бүрийн агуулгыг тунгурлан стандартчилсан.	Аргазүйн хөгжлийн үндсийн зарчим нь: -Боломжийг тэнцүү олгох -Судлах агуулгыг сонгох зарчим -Багшлахуйн зарчим -Суралцахуйн зарчим -Технолгийн зарчим	Суралцагчдад хөгжих цогц чадамжийг танин мэдэхүйн түвшний шалгуураар үнэлнэ. Суралцагчдын цогц чадамжийг үнэлэх	Агуулгын стандартаас боловсролын стандартад шилжих алхам хийсэн. Тухайн стандарт нь (2004) цогц чадамжид суурилсан, тухайн боловсролын хэрэгцээ, агуулга, үнэлгээ, аргазүйн хөгжлийн үндэс

	кирриюлимыг боловсролын стандартад нийцүүлэн төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх, хөгжүүлэх ажлын чанарыг хэмжин үнэлж хөгжилд хөтлөхөд оршино.		-Үнэлгээний зарчим	шалгуур болон жишиг даалгавруудыг тодорхойлж өгсөн онцлогтой.	зэрэг бүтэцтэйгээрээ шинэлэг юм.
Боловсролын хүрээлэн. ЕБ-ын 11 жилийн сургуульд 2006-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ. УБ. (2006 он)	Хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ нь боловсролын стандартыг хэрэгжүүлэх зорилго бүхий үндэсний сургалтын хөтөлбөр (кирриюлим)-тэй болох хүртэлх хугацаанд хэрэглэх баримт бичиг.	Анги бүрийн судлагдахуунуудын агуулгын (юунд сурахыг) үлгэрчилсэн хүрээг гаргасан.	Тодорхой бус байна. Харин зөвлөмжид ямар нэг байдлаар тусгаж өгчээ.	Тодорхой бус байна. Харин зөвлөмжид ямар нэг байдлаар тусгаж өгчээ.	Судлагдахуунуудын агуулгын хүрээг анги бүрээр гаргасан.
БСШУЯ. Ерөнхий боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр, зөвлөмж. УБ. (2008-2012 он)	Судлагдахуун бүрийн хүлээгдэж буй ерөнхий үр дүн (хүлээгдэж буй тодорхой үр дүн) буюу зорилтыг тодорхойлсон. Үндэсний сургалтын хөтөлбөрүүдийн хүлээгдэж буй ерөнхий үр дүнг мэдлэг, ойлголт, чадвар, хэрэглээ болгоход чиглэсэн зорилтуудыг тодорхойлсон.	Агуулга, бүтэц: - Мэдлэг - Чадвар - Хэрэглээ/Хандлага - Үнэлгээ	Аргазүй нь өөр өөрийн шийдэлтэй. Агуулгыг хэрэгжүүлэх онцлогийг тайлбарлах байдлаар аргазүйн шийдэл хийгдсэн. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зөвлөмжийг боловсруулан түгээсэн.	Хүлээгдэж буй үр дүн биелэгдэж буй эсэхийг шалгах, үнэлэх байдлаар үнэлгээг авч үзсэн. Эзэмшсэн мэдлэг, чадвар, хэрэглээг түвшинчлэн үнэлэхийг зорьсон.	Үндэсний хөтөлбөр нь хүлээгдэж буй ерөнхий үр дүнгүүдийг тодорхой болгосон ба тухайн боловсролоор эзэмших мэдлэг, чадвар, хэрэглээ/хандлагыг тодорхойлсон онцлогтой.
Бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ, 2014, 2015, 2016 (Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, гарын	... сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн	Бүтэц: - Нийтлэг үндэслэл - Цөм хөтөлбөрийн зарчим - Цөм хөтөлбөрийн зорилго, зорилт - Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх зохион байгуулалт	Бүтэц: - Цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх аргазүй орчин - Цөм хөтөлбөрийн хэрэгжүүлэх төлөвлөлт	Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ - Үнэлгээний зорилго, зорилт - Үнэлгээний зарчим - Үнэлгээний төрөл, хэлбэр	Цөм хөтөлбөрт суралцагчдын хүрэх зорилго, зорилтыг нэгдмэл байдлаар тодорхойлох оролдлого хийж, сурах арга барил, шинжлэн судлах аргыг тодорхой тусгасан

<p>авлага, УБ. 2015, 18-22 дахь тал)</p>	<p>болон төлөвших боломж олгоход оршино. Зорилт: - Сурах хүсэл сонирхолтой, сурах үйлээ удирдан өөрийн удирдлагатай суралцдаг бүтээлч хариуцлагатай иргэн болох - Үндэсний хэл, соёл, түүх, уламжлалаа хүндэтгэн, өвлөн хэрэгжүүлдэг, хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлсийг дээдлэн эрхэмлэдэг, хүн, байгаль, нийгэмтэй зүй зохистой харилцдаг иргэн болох - Бүтээлчээр сурах арга барилтай, насан туршдаа суралцах чадвартай иргэн болох - Шинжлэх ухааны мэдлэг, ойлголтыг эзэмшин, амьдрал үйлдээ хэрэглэх чадвартай иргэн болох</p>	<p>- Цөм хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ</p>		<p>- Үнэлгээний шалгуур - Үнэлгээний арга хэрэгсэл - Сургуулийн менежмент ба үнэлгээний үйл явц</p>	<p>шинэлэг талтай бөгөөд үнэлгээний зорилт, үнэлгээний шалгуурыг цогцоор тодорхой болгосон зэрэг онцлогтой байна.</p>
--	--	---	--	---	---

Дээрх хэсэгчилсэн шинжилгээгээр илэрсэн дутагдал:

- Сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд өөрчилж, шинэчилсэн.
- Судлагдахууны агуулгыг мэдлэг, чадвар, хэрэглээний хүрээнд эзэмших суралцахуйн зорилтын тоо олон.
- Сургалтын хөтөлбөрийн агуулга хэт их буй нь багш төвт философи голлон баримталж байсантай холбоотой.
- 1990 оноос хойш хэрэглэсэн сургалтын хөтөлбөр нь сурагч төвтэй хандлагыг хэрэгжүүлэхэд анхаарсан ч сургалтын хөтөлбөрийг сайжруулах, боловсруулах, үнэлэх дүгнэх орчилт үе шатыг тогтоогоогүй. Үүнд хөгжингүй улс орнууд сургалтын хөтөлбөрөө сайжруулах, үнэлэх, шинэчлэх хугацаа дунджаар 10 жил байгааг харгалзах.
- Сургалтын хөтөлбөрийг богино хугацаанд боловсруулж байгаа нь сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний чанарт сөрөг нөлөө үзүүлж байна зэрэг болно.

Энэ дүгнэлтүүд амьдрал дээр хэрхэн бодит агуулгатай байдгийг харуулах нэгэн судалгааг Боловсролын хүрээлэн 2017 оны эцэс, 2018 оны эхэнд боловсруулсан аргачлалаар авсан юм. Боловсролын хүрээлэнгээс хийж буй энэхүү судалгааны хүрээнд хэрэгжилтийн байдлыг нь тодорхойлохыг зорьж буй сургалтын хөтөлбөрийг боловсруулах, турших ажил⁴⁵ 2012 оноос эхэлж, 2013 онд БШУ-ны Сайдын А/155 тоот тушаалаар Бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн үзэл баримтлал, сургалтын хөтөлбөр боловсруулах багийг судлагдахуун бүрээр баталжээ. Эдгээр баг нь 2012-2017 онд танин мэдэхүй, нийгэмшил болон зан үйл, хандлагыг өв тэгш хөгжүүлэх, амьдрах чадвартай монгол хүүхэд төлөвшүүлэх, үндэснийхээ боловсролын агуулга, арга зүй, тогтолцоог олон улсын боловсролын жишигт хүргэх, бие даан сурах арга барил эзэмшүүлэх зорилгоор сургалтын цөм хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх суралцахуйн удирдамжуудыг боловсролын түвшин, судлагдахуун бүрээр боловсруулан дараах үе шатаар хэрэгжүүлэхээр ажилласан байна. Үүнд:

2014 оноос бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2015 оноос суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2016 оноос бүрэн дунд боловсролын 10-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд хэрэгжүүлсэн. 2017 оноос бүрэн дунд боловсролын 11-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг үндэсний хэмжээнд мөрджээ. Харин 2018 оноос бүрэн дунд боловсролын 12-р ангийн сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн байна. Бүрэн дунд боловсролын

⁴⁵ 2012 оны БШУ-ны Сайдын А/180-р тушаалаар

сургалтын цөм хөтөлбөрийг заавал судлах хичээлийн, заавал сонгон судлах хичээлийн гэсэн 2 хэлбэртэй боловсруулсан байна.

Боловсролын хүрээлэн нь энэхүү судалгаагаар сургалтын цөм хөтөлбөрийн тохироц хийгээд хэрэгжилтийг орон нутаг, сургууль, багш нарын хөтөлбөрийн менежментийн арга зүйтэй уялдуулан авч үзэж, хэрэгжилтийн нөхцөл байдлыг ирүүлэхийг зорьж, ерөнхий боловсролын сурах бичиг ба хөтөлбөрийн уялдааг авч үзэх, сургууль, багш нарын хичээлийн төлөвлөлт болон сургалтын хөтөлбөрийн уялдаа холбоог авч үзэх тохирцын шинжилгээ хийжээ.

Мөн энэ судалгаагаар сургалтын хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг 4, 8, 11 дүгээр ангийн бүх хичээлээр авч үзэх, сургалтын материаллаг орчин, хэрэглэгдэхүүний нөхцөл байдалд дүн шинжилгээ хийх, хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буй хүчин зүйлийг тогтоох, хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх санал зөвлөмж боловсруулах зорилго тавьж ажиллажээ. Судалгааны үр дүн дараах байдалтай гарсан байна. Үүнд:

Хичээлийн төлөвлөлт

Багш нар хичээлээ төлөвлөхдөө сурах бичгийг байнга ашиглаж, харин хөтөлбөр болон суралцахуйн удирдамжийг тэдний 50.0 хувь нь ашиглаж байна. Мөн багш нар хичээлдээ биет үзүүлэн болон зураг, дүрслэл бүхий үзүүлэнг түлхүү ашиглаж байна.

Багш нар жилийн болон улирал, нэгж, ээлжит хичээлийн төлөвлөгөөг харилцан уялдаатай боловсруулдаг ч ээлжит хичээлийн төлөвлөгөөг боловсруулалгүй хичээл заах тохиолдолд цөөнгүй байна. Багш нарын боловсруулсан төлөвлөгөөнд зорилго, зорилт, агуулгын залгамж холбоо, хэрэглэгдэхүүн, үнэлгээг тодорхой тусгахгүй байдал нийтлэг байна. Багш нарын хичээл төлөвлөлтийн бүтцийг авч үзэхэд агуулгын хуваарилалтийг аль ч түвшинд хангалттай сайн хийж байгаа боловч, зорилго, зорилт, үнэлгээ, агуулгын залгамж холбоо, жил, нэгж, ээлжит хичээлийн хоорондын уялдаа холбоог хангалтгүй төлөвлөж байна.

Хүснэгт 20. Ээлжит хичээл төлөвлөхөд тулгардаг бэрхшээлүүд, хувиар

<i>Бэрхшээлүүд</i>	<i>хэцүү</i>
хичээлийн зорилгыг цөм хөтөлбөртэй уялдуулах	26.0
сурагчдын өмнөх мэдлэг, чадвар, хандлагыг харгалзах	36.3
сурагчдын ялгаатай байдалд тохируулах	55.9
нэгж хичээлийн үнэлгээний даалгавар боловсруулах	24.9
явцын үнэлгээний арга, хэрэгслийг тусгах	23.7
дадлага, туршилтыг тусгах	26.4

асуултыг танин мэдэхүйн түвшнийг харгалзан боловсруулах	31.3
явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтийг сайжруулах	21.0
гэрийн даалгаврын гүйцэтгэлд тулгуурлах	22.7
цаг бага, төлөвлөөгүй ажил гарах	68.7
сургалтын хэрэглэгдэхүүнд зардал гарах	81.2

Хичээл төлөвлөлтийн явцад багш нарт дараах бэрхшээл нийтлэг учирдаг байна.

Үүнд:

- сурагчдын ялгаатай байдлыг тусгах
- ажлын төлөвлөгөөнд тусаагүй цаг үеийн ажил их байх
- сургалтын хэрэглэгдэхүүний зардал байхгүй зэрэг байна.

Багш нар явцын үнэлгээнд тулгуурлан төлөвлөлтөө сайжруулахыг чухалчилдаг нь харагдав. Судалгаанд хамрагдсан сургалтын менежерүүдийн 50.9 хувь нь хичээлийн зорилгоо сургалтын хөтөлбөрийн зорилготой уялдуулах, тодорхойлох, сурагчдын өмнөх мэдлэг чадварыг харгалзаж хичээлээ төлөвлөхөд нь ерөнхий зөвлөгөө өгөх байдлаар хөтөлбөрийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлдэг бол сурагчдын ялгаатай байдалд тохируулан үйл ажиллагаа, дасгал даалгаврыг боловсруулахад нь тэр бүр тусалж чаддаггүйг багш нар хэлжээ. Хичээлийн арга зүйн талаар тодорхой арга, аргачлал зөвлөдөг гэх сургалтын менежерүүдийн эзлэх хувь нь ерөнхий зөвлөгөө өгдөг сургалтын менежерүүдийн эзлэх хувиас доогуур үзүүлэлттэй гарсан байна.

Үнэлж дүгнэх үйл ажиллагаа

Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх явцад сурагчдын сурлагын амжилтын үнэлгээнд даалгавар боловсруулахтай холбоотой өөрчлөлт орсон гэж багш нарын 61.2 хувь нь, явцын үнэлгээнд үндэслэн сурагчдыг чиглүүлэх, зөвлөн туслах, сурагч өөрийгөө болон бусдыг үнэлэхэд өөрчлөлт орсон гэж багш нарын 50 орчим хувь нь үзжээ. Үнэлгээний зорилгоо томъёолох, шалгуур боловсруулах хийгээд ашиглах, үнэлгээний арга хэрэгслийг ашиглах аргачлалын талаар багш нарт дэмжлэг үзүүлэх, нөгөөтэйгүүр сургалтын менежерүүдийг багш нарт зөвлөгөө өгөх хэмжээнд сургаж, дадлагажуулах хэрэгтэй нь харагдав. Мөн сурагчийн үнэлгээний шинэчилсэн журмыг хэрэгжүүлэхтэй холбоотой цогц дэмжлэг шаардлагатай байгаа нь харагджээ.

Сурах бичгийн хангалт, хүртээмж

Боловсролын хүрээлэнгээс 2017 оны эцсээс бэлтгэж явуулсан уг судалгаанд түүврээр сонгогдсон 4, 8, 11 дүгээр ангийн анги удирдсан багшийн журнал дээрх сурах бичгийн бүртгэлээс сурах бичгийн хангалт, хүртээмжийн талаарх мэдээллээс харахад дараах дүр зураг харагдав.

Сурах бичгийн хангалт, түвшнээр

Бага ангид сурах бичгийн хангалт 93.7 хувь, дунд ахлах ангийн сурах бичгийн хангалт дунджаар 46.4 хувь байгаа ч ээлжит хичээлийн ажиглалтаар сурах бичигтэй сурагчдын тоо цөөн байв. Сурах бичгийн хангалтыг нийслэлийн сургуулийн ойролцоогоор 3 сурагч тутмын нэг, аймгийн сургуулийн 2 сурагч тутмын нэг, сумын сургуулийн 4 сурагч тутмын нэг нь сурах бичиггүй байна гэж тооцоолж болохоор байна. Судалгаанд хамрагдсан нийт сурагчдын 57.8 хувь нь сурах бичгээ номын сангаас, 42.1 хувь нь худалдаж авсан байна.

Сурах бичгийн хангалтыг байршлаар авч үзвэл, худалдаж авсан хүүхдийн эзлэх хувь суманд нийслэл болон аймгийн хувиас бага байгаа нь манай улсад сурах бичгийн худалдаа борлуулалтын нэгдсэн сүлжээ, зохицуулалт байхгүйтэй шууд холбоотой нь харагдажээ. Сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэх талаар эцэг эх, асран хамгаалагчийн 87.6 хувь нь төрөөс үнэгүй өгөх хэрэгтэй гэж үзсэн байна. Харин багш нарт багшийн номыг ашиглах хэрэгцээ их байгаа хэдий ч хүртээмж маш муу байна. Тухайлбал, дунд ангид хичээл заадаг багш нарын хүрээнд 14 багшид нэг л ном ашигладаг сургууль байна.

Сурах бичгийг ээлжит хичээлийн явцад шинэ мэдээлэл авах, даалгавар гүйцэтгэх, зураг дээр ажиллах зэргээр ашиглахаас гадна багш хичээл төлөвлөхөд, сурагчид гэрийн даалгавар хийхэд тус тус ашиглаж байгаа хэдий ч ээлжит хичээлийн ажиглалтаас харахад бага ангийн сурагчдын 60 орчим хувь, дунд ангийн сурагчдын 50 орчим хувь, ахлах ангийн сурагчдын 40 орчим хувь нь л сурах бичигтэй нь харагдав. Энэ нь ээлжит хичээлийн явцад сурагчдын сурах бичиг ашиглалт бүх сурагчдын хувьд хүртээмжтэй бус байгааг харуулна.

Нэг багшид ногдох хүүхдийн тоо, байршлаар

Нийслэлийн сургуулийн нэг багшид ногдох хүүхдийн тоог тухайн сургуулийн нийт багш, сурагчийн тоотой харьцуулахад бага ангид 5-13, дунд, ахлах ангид 2-4 хүүхдээр илүү байна. Харин бүлэг дүүргэлтийн хувьд судалгаанд хамрагдсан нийслэлийн төрийн өмчийн сургуулийн 4 дүгээр ангийн нэг бүлэгт дунджаар 40.5 сурагч байгаа бол төрийн бус өмчийн сургуулийнх 22 байсан байна.

“Сургалт-хүмүүжлийн байгууллагад мөрдөх эрүүл ахуй, халдвар хамгааллын үлгэрчилсэн дүрэм⁴⁶”-ийн 4.3-д нэг анги дахь хүүхдийн тооны дээд хэмжээг 30-35 байхаар заасан. Гэтэл нийслэлийн төрийн өмчийн нийт сургуулийн 87.5 хувийнх нь дөрөвдүгээр ангийн хүүхдийн тоо дурдсан хэмжээнээс илүү байна. Энэ нь

⁴⁶ МХЕГ-ын даргын 2017 оны А/179 дүгээр тушаалын дөрөвдүгээр хавсралтаар баталсан

нийслэлийн төрийн өмчийн сургуулийн бага ангийн багш аймаг, сумын сургуулийн бага ангийн багшаас илүү ачаалалтай байгааг харуулж байгаа юм.

Сургууль төвтэй мэргэжил дээшлүүлэх тогтолцоо бүрдүүлэх, багш ажлын байрандаа мэргэжил боловсролоо дээшлүүлэх, ээлжит хичээлээ хамтран бэлтгэх орчин нөхцөл бүрдүүлэх үүднээс БСШУ-ны сайдын 2008 оны 114 тоот тушаалаар "Багшийн хөгжлийн танхим" ажиллуулах зөвлөмж, шаардлагыг баталсан. Энэхүү зөвлөмж, шаардлагыг хэрэгжүүлэх хүрээнд нийт сургуулийн 70 орчим хувьд дээрх зориулалт бүхий багш хөгжлийн өрөөг тохижуулж, үйл ажиллагаа явуулж байгааг нь тогтоогдов.

Хичээлийн сорилын гүйцэтгэл

Судалгаанд хамрагдсан ангиудын бүх хичээлийн сорилыг боловсруулахдаа бага ангийн даалгаврын 50 хувь нь мэдлэг ойлголт, 50 хувь нь мэдлэг хэрэглэх байдлыг илрүүлэхийг зорьсон бол энэ харьцааг дунд ангийн хувьд 40 хувь нь мэдлэг ойлголтыг, 30 хувь нь мэдлэг хэрэглэх чадварыг, 30 хувь нь шинжлэх ухааны арга барилыг илрүүлэх, ахлах ангийн хувьд мэдлэг ойлголтыг 50 хувь нь, мэдээлэл боловсруулах асуудал шийдвэр чадварыг 30 хувь нь, туршилт гүйцэтгэх чадварыг 20 хувь нь илрүүлэх даалгавар байхаар тооцоолов.

Сорилын гүйцэтгэлийн ерөнхий дундаж бага ангид 46.7; дунд ангид 38.3; ахлах ангид 34.3 байна. Анги ахих тутам хөтөлбөр эзэмшилт буурсан ба аль ч ангид мэдлэг, ойлголтыг авч үзсэн даалгаврын гүйцэтгэл мэдлэг хэрэглэх болон асуудал шийдвэрлэх, шинжлэх ухаанч арга барилын эзэмшилтийг авч үзсэн даалгаврын гүйцэтгэлээс илүү байна.

Даалгаврын хүнд, хөнгөний байдал

Судалгаагаар анги ахих тусам сорилын даалгаврууд хүндэдсэн байдалтай гарсан байна. Суурь боловсролын түвшний даалгаврын 36.0 хувь нь хэт хүндэдсэн бол бүрэн дунд боловсролын түвшинд 40 гаруй хувь нь хүндэдсэн нь харьцангуй өндөр үзүүлэлт байна.

Сорилын гүйцэтгэлд нөлөөлж буй хүчин зүйлсийг авч үзэхэд, хувийн өмчийн сургуулийн сурагчдын хөгжмийн судлагдахууны мэдлэг, ойлголт нь төрийн өмчийн сургуулийн сурагчдаас илүү байсан. Хувийн өмчийн сургуулийн сурагчдын хөгжим, англи хэлний судлагдахууны мэдлэг ойлголтын үнэлгээний үзүүлэлт нь төрийн өмчийн сургуулийн сурагчдын гүйцэтгэлтэй харьцуулахад илүү үзүүлэлттэй байна.

Улаанбаатар хотын сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувь аймаг, сумын сургуулийн сурагчидтай харьцуулахад илүү байжээ.

Сургалтын хөтөлбөрийн хөгжлийн шинжилгээ

Үндэсний сургалтын хөтөлбөрийг хэрхэн хөгжүүлж, хэрэгжүүлж байгааг Их Британий Боловсрол Судлалын Үндэсний Нийгэмлэгийн дэргэдэх Олон Улсын Мэдээллийн Төв хэмээх олон улсын судалгааны байгууллага судалж, үр дүнг нь жил бүр өөрсдийн эрхлэн гаргадаг Олон улсын хөтөлбөр ба түүний бүтэцчилсэн хүрээ INCA цахим архивт хадгалдаг аж. Энэ архивт хадгалагдсан Америк, Ази, Европ, Австрали тивийг хамарсан дэлхийн 20 улс дараах үнэт зүйлсийг боловсролын болон сургалтын хөтөлбөрийн агуулга, бүтцүүдэд тусгасан байна. Үүнд:

- Хувь хүний хөгжил, хувь чанар, нийгэмшихүй
- Тэгш боломж, соёлын ялгаа
- Сурагчдыг амьдрал, ажилд бэлтгэх суурь мэдлэг, чадвар, ойлголт
- Бичиг үсгийн боловсрол, гадаад хэл
- Математикийн суурь чадвар
- Шинжлэх ухаан, технологийн чадвар
- Иргэний боловсрол, ардчилал, соёл
- Эрүүл мэнд, бие бялдрын хөгжил, эцэг эхийн оролцоо
- Сурлагын амжилт
- Сэтгэхүйн хөгжил
- Үндэсний эдийн засгийн бүтээмж
- Бүтээлч сэтгэхүй, насан туршид суралцахуй зэрэг болно.

Эдгээр улсуудын сургалтын хөтөлбөрийн үзэл баримтлалд шинэ зууны суралцагчийн дүр төрхийг дараах байдлаар тодорхойлсон байна. Үүнд:

- Бүтээлч, шүүмжлэлтэй сэтгэх
- Насан туршдаа суралцан хөгжих
- Мэдээллийг оновчтой сонгон хэрэглэх
- Асуудалд хариуцлагатай хандаж, оновчтой шийдвэр гаргах зэрэг болно.

Гадаадын 20 улсад дараах 22 зорилгыг нийтлэг байдлаар тодорхойлсон байгааг (Sharon O'Donnell, 2008) өөрийн улсын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилготой харьцуулж үзвэл дараах зураг гарсан байна.

Хүснэгт 21. Зарим улс орон ба Монголын сургалтын хөтөлбөрийн зорилгын харьцуулалт

Улс орнуудын боловсролын сургалтын хөтөлбөрийн зорилго	Монгол улсын бага, суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго, зорилт
<ul style="list-style-type: none"> - Хувь хүний хөгжил - Үнэт зүйл, ёс зүй - Дотоод ертөнцийн хөгжил, мэдрэмж, шашин - Нийгмийн хөгжил - Хувь хүний шинж чанарууд (төлөвшил) - Тэгш боломж /олон соёлын - Үндэсний эдийн засаг - Ажил /албан тушаал/ амьдралд бэлтгэх - Үндсэн ур чадвар – Литерац, бичиг үгсийн болон тоон чадвар - Шинжлэх ухаан/ технологийн ур чадвар - Ирээдүйн боловсролын суурь мэдлэг/ур чадвар/ ойлголт - Иргэншил/нийгэмлэг/,ардчилал - Соёлынөв уламжлал - Бүтээлч байдал - Гадаад хэлний ур чадвар - Хүрээлэн буй орчин/ тогвортой хөгжил - Эрүүл мэнд - Насан туршийн боловсрол - Эцэг эхийн оролцоо - Суралцахуйн тусгай хэрэгцээг хангах (бэрхшээлтэй болон авьяастай сурагч) г.м. 	<ul style="list-style-type: none"> - Хувь хүний төлөвшилтэй байх - Ёс зүйн хэм хэмжээг баримтлах - Эрүүл аж төрөх дадал хэвшилд суралцах - Сурах арга барилтай болох - Амьдрах ухаанд суралцах - Шинжлэх ухаанч хандлагатай болох - Мэдлэг, чадвартай болох - Бие даах чадвар эзэмших - Бүтээлчээр суралцах чадвартай болох - Үндэсний түүх, соёл, уламжлалаа дээдлэх - Хүн төрөлхтний нийтлэг үнэт зүйлийг эрхэмлэх - Хариуцлагатай иргэн болох - Өөрийн удирдлагатай суралцах - Хүн, байгаль, нийгэмтэй зохистой харилцах - Насан туршдаа суралцах - Ардчиллыг дээдлэх - Мэдлэг, чадвараа ахуй амьдралдаа хэрэглэх - Үнэт зүйлийг дээдлэх - Шийдвэр гаргах - Суралцах чадвартай байх - Эзэмших мэргэжлийн суурь чадамжтай болох

Судалгаанд оролцсон ихэнх улсуудын 2000-2008 онд ЕБ-ын хүрээнд хийсэн шинэчлэл нь боловсролын түвшин бүрийн хүлээгдэж буй үр дүнг бодитой, хүрэхүйцээр тодорхойлох, судлагдахууны хүрээг хичээлээр хязгаарлахгүй онол, дадлагыг хослуулах, тогтвортой хөгжлийн бодлого, хүүхдийн эрх, жендерийн тэгш байдал, нийгэм, эдийн засгийн тулгамдсан асуудлуудыг сургалтын хөтөлбөрт түлхүү оруулахад чиглэсэн байна. Эдгээр улсуудаас Франц, Герман, Шинэ Зеланд зэрэг улсуудад хөтөлбөрийн шинэчлэл хийх болсон шалтгаан, үндэслэл нь Олон улсын үнэлгээний байгууллагын дүн мэдээтэй хамааралтай байв.

Даяаршил, бүс нутагшил хийгээд мэдээллийн технологийн зуун дахь хөгжлийн хувьсал, өөрчлөлтүүд нь хувь хүний амьдралын чанарт шинэ шаардлага дэвшүүлж, өөрөөр хэлбэл, хувь хүн өөрийн амьдралын болон нийгмийн байр сууриа өндөржүүлэхийн тулд өөрийгөө удирдах, аж төрөх чадвартай байх, бие хүн болж төлөвшихөд нь сургалтын хөтөлбөрийн чиг үүрэг, зориулалт, агуулга, бүтэц, хэрэгжилт, үнэлгээг нэн тодорхой болгох шаардлага тулгарч байна. Хувь хүн нийгмийн амьдралын аливаа өөрчлөлтийг угтан харах, өөрчлөлтөд бэлэн

байх, тогтвортой хөгжих чадвар нь сургалтын хөтөлбөр, түүний хэрэгжилтийн үр дүнд биелэлээ олж байх зүй тогтолтой.

2016 оны 1 дүгээр сараас 6 дугаар сар хүртэлх хугацаанд аймаг, нийслэлийн лаборатори ба лаборатори бус (лаб., лаб. бус) 37 сургуулийн 3 ба 7 дугаар ангийн 807 багшаас мэдээлэл цуглуулсан судалгааны үр дүнд шинжилгээ хийсэн байна (Хүснэгт 22).

Хүснэгт 22. Бага, суурь боловсролын цөм хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн эмпирик судалгааны үр дүнгээс

Хөтөлбөрийн бүтэц (Бага, суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр, УБ, 2014, 2015 он)	Судалгааны үр дүн
Зорилго	Нийт багш нарын 90% нь “цөм хөтөлбөр нь олон шинэлэг санаа агуулсан” гэдэгтэй санал нэгдсэн. 4 багш тутмын 3 нь “цөм хөтөлбөрийн судлагдахууны зорилго, зорилтуудыг ойлгодог” гэжээ. Суралцахуйн зорилт ба цөм хөтөлбөрийн зорилгын уялдаа холбоог ойлгомжтой гэж (лаб. 42%, лаб. бус 30%) үзэж байна.
Хэрэгжилт	Нийт судалгаанд оролцсон багш нарын 70 гаруй хувь нь цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүйн зарчмыг ойлгодог гэсэн боловч цөм хөтөлбөрийг ойлгож, хэрэгжүүлэхэд хялбар эсэхэд хоёрдмол байр суурьтай байна. Гэвч, лаб. сургуулийн багш нарын 78-иас дээш хувь, лаб. бус сургуулийн багш нарын 2/3 нь “цөм хөтөлбөр хэрэгжсэнээр сурагчдын идэвх сайжирч байна” гэж үзжээ.
Агуулга	Судалгаанд оролцсон багш нарын (лаб. 37%, лаб. бус 28%) “цөм хөтөлбөр агуулга ихтэй тул бүгдийг нь заахад цаг хүрэлцдэггүй” гэж үзсэн. Цөм хөтөлбөр нь “хэт олон чадвар олгох зорилготой тул шинэ мэдлэг олгох цаг бага” гэдэгтэй багш нар (лаб. 36%, лаб. бус 26%) санал нийлжээ.
Аргазүй	Лаб. болон лаб. бус сургуулийн 80.7% нь “ялгаатай түвшний сурагчдад ялгаатай үйл ажиллагаа, даалгавар төлөвлөх нь маш чухал” гэсэн ч 51.4% нь “ялгаатай түвшний сурагчдад ялгаатай үйл ажиллагаа, даалгавар төлөвлөх амаргүй байдаг” гэжээ. Мөн, 65% нь “ялгаатай түвшний сурагчдад ажиллахад хичээлийн цаг хүрэлцэхгүй” гэж үзсэн бол 45% нь “ялгаатай түвшний мэдлэг, чадвар бүхий сурагчдад зориулж ялгаатай түвшний үнэлгээний зорилт, шалгуур боловсруулахад хүндрэлтэй байдаг” гэжээ.
Үнэлгээ	Нийт багш нарын 72% нь “сурагчдын хөгжил, төлөвшлийг дэмжих, түүнийг үнэлэх ажлыг тогтмол хийдэг” гэсэн байхад 64% нь “хичээлээр сурагчдын хөгжил, төлөвшлийг үнэлж чаддаг” гэжээ. 69% нь “сурагчдын хөгжил, төлөвшлийг үнэн зөв үнэлэхэд цаг их ордог” гэсэн. 32% нь “сурагчдын хандлагын үнэлгээний шалгуур хэт ерөнхий тул үнэлэхэд хүндрэлтэй байдаг” гэж үзсэн бол багш нарын тал хувь ялгаатай байдал гэдгийг ихэвчлэн сурлагын амжилтаар тодорхойлжээ. Мөн 21% нь “надад сурагчдыг хөгжил, төлөвшилд сургах, үнэлэх туршлага дутаж байна” гэн бол 36% нь “хангалттай туршлагатай” гэж өөрсдийгөө үзжээ. Үнэлгээний зорилт, шалгуурт үндэслэн хичээлийг төлөвлөх боломжийн талаар асуухад багш нарын 53% нь “цөм хөтөлбөрийн үнэлгээний зорилтоос хичээлийн үнэлгээний шалгуурыг гаргах боломжтой” гэжээ. 5 багшийн 1 буюу 20% нь “суралцахуйн зорилтын үнэлгээний шалгуур хангалттай SMART биш” гэжээ. Багш нар нь эцсийн үнэлгээг зөв сонгож, ашиглах тал дээр санал хуваагдсан. ¼ нь “үнэлгээний хэрэгслийг оновчтой сонгон ашиглах амаргүй байдаг” гэсэн бол багш нар

	<p>эцсийн үнэлгээний тестийг боловсруулах чадавхын талаар 24% нь “суралцахуйн зорилт (хөтөлбөрийн зорилгод) үндэслэн эцсийн үнэлгээний даалгавар боловсруулах нь хүндрэлтэй байдаг” гэв. Хөндлөнгийн үнэлгээний талаар 40% нь “Боловсролын үнэлгээний төвийн хөндлөнгийн шалгалтууд суралцах чадварыг үнэлдэггүй” гэсэн бол “сургууль, дүүргийн БГ-ын хөндлөнгийн үнэлгээгээр хийж буй даалгаврууд нь цөм хөтөлбөрт нийцүүлэн өөрчлөгдөөгүй хэвээр байгаа” хэмээн 34% нь үзэв. Нийт багш нарын 32% нь “сурагчдын чадварыг багшийн ажиглалтаар үнэлэхэд хүндрэлтэй байдаг” гэсэн бол 30% нь “чадварт суурилсан жишиг даалгаврууд боловсруулахад хүндрэлтэй” гэв. Сурагчдын өөрийн үнэлгээ талаар лаб. сургуулийн 10 багш тутмын 5, лаб. бус сургуулийн 3 багш тутмын 1 нь “сурагчдын өөрийн үнэлгээ найдвартай гэхэд эргэлздэг” байна. Гэвч багш нар (лаб. 91% ба лаб. бус 86%) “сурагчдыг зөв үнэлэхэд сурагчид илүү идэвх сонирхолтой, хариуцлагатай болдог” гэдэгтэй санал нийлжээ.</p>
--	---

Дээрх эмпирик судалгаагаар илэрсэн сул тал:

- *Арга зүйн хувьд:* Суралцах олон талын хэрэгцээг хангах болон сурагч нэг бүрийн сурах чадварт тохирсон үйл ажиллагаа зохион байгуулахын ач холбогдлыг өндөр үнэлж байгаа ч, эдгээр үйл ажиллагааг зохион байгуулах нь бэрхшээлтэй байгаа юм байна.
- *Үнэлгээний хувьд:* Сурлагын амжилтын үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тодорхойлох, үнэлгээний тохирох арга хэрэгслийг сонгох, төлөвлөх, явцын болон сурагчийн өөрийн үнэлгээний талаар багш нарын ойлголт дутмаг, нэгдмэл бус байна.
- Багш нарт мэргэжил дээшлүүлэх сургалт хэрэгцээтэй байна.

Боловсролын хүрээлэнгийн 2016 оны 10 дугаар сард ЕБС-ийн 10 дугаар анги бүхий 367 сургуулиас авсан судалгааны үр дүнгээс харахад, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн заавал судлах, заавал сонгох, сонгон гүнзгийрүүлэх хичээлүүдээр сурагчид сонголт хийж байгаа нь онцлог байв. Хичээл сонголт хийлгэх, сургуулийн мэдлийн цагийг хэрэгжүүлэх, мэргэжлийн багш нар илүүдэх, дутагдах, кредитийн үнэлгээг хэрэгжүүлэх, сурах бичиг хэвлэгдэхгүй байх, боловсролын баримт бичгийн агуулгын зөрүү гарах зэрэг бэрхшээлүүд тулгарч байгаа ч сургалтын хөтөлбөрийг сонголттой болгоход ахиц гарсан гэж үзэж байна.

2016 оны 4-9 дүгээр сард Дээд боловсролын хөгжлийн асуудлаар Монголын их, дээд сургуулиудын 300 гаруй багш нарыг хамруулан хийсэн зарим судалгааны үр дүнгээс үзвэл, “Дээд боловсролын үйлчилгээний чанарыг дээшлүүлэхийн тулд гол нь ямар асуудлыг шийдвэрлэх шаардлагатай талаар судалгаанд оролцогчдын өгсөн саналын хувь: Багшийн хандлага, арга барилын өсөлт, хөгжил – 56.3%, Элсэгчдийн суурь түвшин – 55.5%, Орчин үеийн стандарт хангасан сургалтын

орчин – 43.8%, Мэргэжлийн хөтөлбөрүүдийн чанар 36.7%, Сургалтыг нийгмийн хэрэгцээтэй уялдуулах – 37.5%, Сургалт – Эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн холбоо – 28.9%, Дээд боловсролын бодлого, үйл ажиллагааны ШУ-ы үндэслэл – 19.5%” гэсэн баримтууд илэрсэн байна.

Манай улсын дээд боловсролын салбарт нэн түрүүнд засууштай зүйлийн талаар гарсан саналын тойм: ЕБС-ийн сургалтын чанар мэдэгдэхүйц унаж байгааг анхаарах. Удирдлагыг намаас хараат бус, тогтвортой ажиллуулах, боловсролын бодлого залгамж чанартай байх. Гадаадын сургуулиудын бүтэц, туршлагыг тэр хэвээр нь шууд хуулахгүй, өөрийн улсын нөхцөлд тохируулж буулгах” хэмээн тэмдэглэсэн байна.

Монголын бага, суурь, бүрэн дунд боловсролын хөтөлбөр нь өөрийн улсын эрдэмтэд, багш нарын судалгаа, туршлага болон гадаадын хөгжингүй улсуудын сургалтын хөтөлбөр судлалын судалгааны зарим ололтод тулгуурлан хөгжиж ирсэн байна.

Манай улсад сургалтын хөтөлбөр ялангуяа, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн талаар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон эрдэм шинжилгээ, аргазүйн байгууллагаас хөтөлбөр судлалын шинжлэх ухааны үндэстэй судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлтийг залгамж чанартай, тогтвортой хийж чадахгүй байгаа нь бидний судалгаанаас ажиглагдав. Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрүүдийг сургалтын хөтөлбөр судлал (киррикулим)-ын шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, үнэлэх, хэрэгжүүлэх орчил (цикл)-ыг зайлшгүй тогтоон мөрдөх шаардлагатай байна.

Суурь, бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөрт (2015, 2016 он) тусгасан судлан шинжлэх арга барил болон үнэлгээний зорилт, шалгуур үзүүлэлтийг тасралтгүй, залгамжтайгаар цаашид хөгжүүлэх

Сургалтын хөтөлбөрийг судлах, боловсруулах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг шинжлэх ухааны тодорхой үндэслэлтэй болгохын тулд бидний хөндөж буй хөтөлбөр судлалын шинжлэх ухаанч зарим санаа, загваруудыг бүтээлчээр ашиглаж, хэрэглэж болох юм.

Үндэстний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсрол

Монгол Улсын төр, засгийн газраас казах, тува үндэстний цөөнхийн боловсролын онцлог хэрэгцээг хангаж, боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах зорилгоор өөрчлөлт шинэчлэлийн бодлогыг 2005 оноос эрчимтэй хэрэгжүүлсэн ба 2015 оноос хилийн чанад дахь монгол иргэд, тэдний үр хүүхдүүдийн монгол эх хэл,

түүх, соёл, ёс заншлын боловсролд ихээхэн анхаарахын зэрэгцээ хэлний цөөнх хүүхдийн боловсролыг дэмжих бодлогын орчныг судалж эхэлсэн байна.

Хэл ба боловсрол

Монгол Улс нь “Монгол хэл нь монгол үндэстний оюуны соёлын үнэ төв, үндэснийсоёлиргэншлийнязгуурүндэс, улс орны нэгдмэл байдал, үндэсний аюулгүй байдал, тусгаар тогтнолын нэгэн баталгаа мөн.”⁴⁷ гэж үзэж Монгол Улсын нутаг дэвсгэрт“ төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллага, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, албан хэрэг хөтлөлт; “төрөөс олгосон зөвшөөрлийн дагуу гадаад хэлээр сургалт явуулдаг байгууллагаас бусад бүх шатны боловсролын байгууллагын сургалт” монгол хэл дээр байхыг хуульчилсан. Мөн Боловсролын тухай болон Монгол хэлний тухай хуульд хэл, соёлын ялгаатай угсаатны ялгаатай бүлгийн хүүхэд, гадаадад амьдарч Монгол Улсын харьяат хүүхдийн хэл, соёлын боловсролтой холбоотой заалтууд байна.⁴⁸

Монгол Улсын хэл, соёлын ялгаатай бүлэг болох казах, тувачуудын дийлэнх нь Баян-Өлгий аймагт амьдардаг.⁴⁹ Хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн цөөнхийн хүүхдийн боловсролын чиглэлээр 2006-2016 онд дараах гол гол арга хэмжээг авсан байна. Үүнд:

Олон улсын байгууллага болон Боловсролын хүрээлэнгээс хэл, соёлын ялгаатай угсаатны бүлгийн цөөнхийн хүүхдийн боловсролын чиглэлээр 2005, 2009, 2013-2014, 2016 онд мэдээлэл цуглуулж, үндэстний цөөнхийн хүүхдийн боловсрол, түүний дотор хэлний боловсролд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдалд дүгнэлт⁵⁰ өгсөн.

2007 онд БСШУ-ны сайдын 425 тоот тушаалаар баталсан “Казах хүүхдийн боловсролыг дэмжих хөтөлбөр” хэрэгжиж эхэлсэн ба үр дүнд үндэстний цөөнхийн хүүхдийн (казах, тува) хэл, соёлын ялгаатай байдлаас шалтгаалан үүсэж байсан бэрхшээлийг багасгаж, тэдний өвөрмөц хэрэгцээнд нь нийцсэн боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, тэгш байдлыг сайжруулах цогц арга хэмжээг боловсруулан хэрэгжүүлсэн.

2010 онд Монгол Улсын Засгийн газараас баталсан “Баян-Өлгий аймгийн боловсрол, соёлын үйлчилгээний чанарыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай” тогтоолоор Баян-Өлгий аймгийн боловсрол, соёлын салбарын

⁴⁷Монгол хэлний хууль,

⁴⁸Дээрх хуулиуд

⁴⁹Баян-Өлгийн хүн амын тоо

⁵⁰“Казах хүүхдийн боловсролын байдлын дүн шинжилгээ”, судалгааны тайлан. Сандра С.Хуанг, Их Британий Хүүхдийг Ивээх сан, 2005 он;

тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, тус аймгийн боловсрол, соёл урлагийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах бодлогыг боловсруулан хэрэгжүүлэхдээ үндэстний цөөнх(казах, тува)-ийн хэлээр сургалт явуулж буй сургалтын агуулга, арга зүйг боловсронгуй болгох чиглэлээр судалгаа хийх чиг үүрэг бүхий Боловсролын хүрээлэнгийн нэгжийг байгуулж, 2015 оноос тус секторт гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны чиг үүргийг нэмсэн⁵¹ байна.

БСШУ-ны сайдын 2010 онд “Баян-Өлгий аймгийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө” баталсан ба 2 багц зорилт, 14 зүйл бүхий уг төлөвлөгөө нь 2010 -2013 онд тус аймгийн боловсролын салбарыг өөрчлөн шинэчлэх ойрын хугацааны төлөвлөгөө болсон.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн “Цаатан хүүхдийн боловсролыг дээшлүүлэх тухай” 42 тоот зарилгыг хэрэгжүүлэх зорилгоор БСШУ-ны сайдын 2013 оны тушаалаар “Цаатан хүүхдийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталж, үндэстний цөөнх болох Баян-Өлгий аймагт амьдарч буй тува, Хөвсгөл аймагт амьдарч буй цаатан иргэдийн хэл, соёл, боловсролын асуудалд онцгой анхаарч, орон нутгийн бодит байдал, чадамж болон сургалтын орчныг тооцоолж бага боловсролыг үндэстний хэлээр зохион байгуулах бүхий л боломжийг дэмжсэн арга хэмжээг төлөвлөсөн байна.

Боловсролын багц хуулиуд, “Монгол хэлний тухай хууль”-д гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудалтай холбогдох зүйл заалт бүхий нэмэлт өөрчлөлт⁵² орсон, түүнчлэн Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасны дагуу БСШУСЯ-наас хилийн чанадад ажиллаж буй сургалтын байгууллага, тэнд суралцаж буй хүүхдүүдэд зориулсан монгол хэл, соёлын жишиг сургалтын хөтөлбөрийг боловсруулан баталгаажуулах хэрэгтэй гэж үзсэн байна.

Монгол Улсын Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын 43 сургуулийн 2 нь сургалтаа монгол, 1 нь монгол-англи-турк, 6 нь монгол, казах зэрэгцсэн бүлэгтэйгээр, 1 сургууль тува, монгол холимог хэлээр, 33 сургууль казах хэлээр

⁵¹Засгийн газрын 2010 оны 66 дугаар тогтоол, БСШУ-ны сайдын 2010 оны 106 тоот тушаал, Боловсролын Хүрээлэнгийн захирлын 2011 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн 16 тоот тушаал;

⁵²Боловсролын тухай хуулийн 28.1.26.гадаад улсад амьдарч байгаа Монгол Улсын харьяат хүүхдэд монгол хэл, түүх, соёл, ёс заншил зааж сургахад дэмжлэг, туслалцаа үзүүлэх; Монгол хэлний тухай хуулийн 1 дүгээр бүлгийн 5.3.Монгол Улсын иргэн бүр монгол хэл, бичиг үсгээ сурах, монгол хэлээр мэдээлэл авах, өвлөх, өвлүүлэх, хамгаалах, хөгжүүлэх боломж, нөхцөлөөр хангагдах эрхтэй.,5 дугаар бүлэг 11.1.3.гадаад улсад оршин суугаа Монгол Улсын иргэн, түүний гэр бүлд монгол хэл, бичиг үсэг, уламжлалт зан заншил, түүх соёлын мэдлэг эзэмшихэд нь дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

сургалтаа явуулж ирсэн. Сүүлийн жилүүдэд казах сургалттай 33 сургууль болон зэрэгцсэн бүлэгтэй 6 сургуулийн казах сургалттай бүлгүүд хос хэлний сургалтад шилжиж байна. Хос хэлний сургалттай сургуулийн сурагчид бага боловсролын түвшинд бүх хичээлийг эх хэл дээр судалж, төрийн албан ёсны хэлийг бичиг үсэгт тайлагдасны дараа буюу 2 дугаар ангиасаа судалж эхэлдэг ба суурь боловсролын түвшинд эх хэл, уран зохиолоос бусад бүх хичээлийг төрийн албан ёсны хэл дээр судалдаг бол бүрэн дунд боловсролын түвшинд бүх хичээл монгол хэл дээр явагдаж, цөөн тооны сонгосон сурагчид эх хэлээ гүнзгийрүүлэн судалж байна.

ЕБС-ийн 22156 сурагчийн 19283 нь казах-монгол, 278 нь тува-монгол хос хэлээр суралцаж байна⁵³. Бага ангийн эх хэл дээрээ эзэмшиж буй казах хүүхдүүдэд зориулж бага ангийн бүх сурах бичгийг казах хэл дээр орчуулан түгээж байгаа бөгөөд 1 дүгээр ангид суралцаж буй тува хүүхдэд зориулан тэдний 5 сурах бичгийг тува хэлд орчуулан сургалтад хэрэглэж байна.

Хилийн чанад дахь монгол хүүхдийн эх хэл, соёлын боловсролын тухайд нийт 17 оронд үйл ажиллагаа явуулж буй 57 хэл, соёлын сургалтын төвд хичээллэн монгол хэл, соёлдоо суралцаж байна. Эдгээр төвд нийт 1500-2000 хүүхэд л хамрагдаж байгаа гэсэн тоо байна. Дээрх бодлого, төлөвлөгөөний үр дүнд дараах нааштай ололт амжилт байна гэж үзэж болохоор байна. Тухайлбал, Үндэсний хууль тогтоомж болон бодлогын баримт бичигт угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудлыг тусгайлан тусгах болсон.

Угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын асуудлыг тусгайлан хариуцан судлах нэгжтэй болсон. Ингэснээр эдгээр тусгай хэрэгцээт бүлгийн хүүхдүүдийн ялангуяа, эх хэлний боловсролын чиглэлээр мэдээллийн бааз бий болгох боломжтой болсон. Тухайлбал, 2016-2017 онд Боловсролын хүрээлэнгийн хариуцсан сектораас дараах мэдээллийг цуглуулсан байна.

Сурагчдын казах хэлний сорилын гүйцэтгэл 59 хувьтай, тува хэлний сорилын гүйцэтгэл 58.2 хувьтай, монгол хэлний сорил 38.7 хувьтай байна.

Хүснэгт 23. Унших, бичих чадварын сорилын ерөнхий дүн

Сорил	Авах ёстой оноо			Авсан оноо			Дундаж		
	казах	тува	монгол	казах	тува	монгол	казах	тува	монгол
Унших	1428	238		834	128	1307.5	53.4	53.7	50.7

⁵³Боловсролын хүрээлэн (2012) Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн суралцагчдын тоо, байршлыг угсаатны бүлгээр тогтоосон судалгааны тайлан.

Бичих	1224	204		794.8	128	1126.8	64.9	62.7	26.7
Нийт	2652	442		1628.8	256	2434,3	59	58.2	38.7

Хүснэгт 24. Сурагчийн 2013 болон 2017 оны унших, бичих чадварын сорилын харьцуулсан гүйцэтгэл (хувиар)

Сорил	Унших, бичих чадварын сорилын нийт гүйцэтгэл		Үүнээс			
			Унших		Бичих	
	2013	2017	2013	2017	2013	2017
Казах хэл	55.8	59	50.6	53.4	61	64,9
Тува хэл	42.6	58.2	42.8	53.7	42.5	62.7
Монгол хэл	43.3	38.7	49.9	50.7	36.7	26.7

Сурагчийн сорилын гүйцэтгэлийг 2013 оны гүйцэтгэлтэй харьцуулж үзэхэд тува, казах хэл дээр сорил өгсөн сурагчдын гүйцэтгэл ерөнхийдөө ахисан үзүүлэлттэй байна. Ялангуяа эх хэл дээр бичих сорилын даалгаврын гүйцэтгэл нэлээд ахисан, харин монгол хэл дээр буурсан үзүүлэлттэй байна.

Хүснэгт 25. Багшийн 2013 болон 2017 оны унших, бичих, хэл зүйн мэдлэг, чадварын сорилын⁵⁴ харьцуулсан гүйцэтгэл (хувиар)

Сорил	Унших, бичих, хэл зүйн мэдлэг, чадварын сорилын нийт гүйцэтгэл		Үүнээс					
			Унших		Бичих		Хэл зүй, зөв бичих дүрмийн сорил	
	2013	2017	2013	2017	2013	2017	2013	2017
Казах хэл	48.6	62	-	77	-	43	48.6	67
Тува хэл	25	77,8	-	80.6	-	85.7	25	67.1
Монгол хэл	44.7	43.6	58.6	40.8	34.8	46.5	40.8	65.2

Багш нарын сорилын үр дүнг 2013 оныхтой харьцуулахад ахисан үзүүлэлттэй байгаа бол, монгол хэлний унших чадварын сорилын гүйцэтгэл буурсан үзүүлэлттэй байна.

Мөн тэдний хэл, соёлын хэрэгцээг харгалзсан гарын авлага, цахим сурах бичиг боловсруулах, хэрэгжүүлэх эхлэл тавигдсан. Үүний жишээ нь, казах тува хүүхдэд зориулсан Монгол хэл 1, Монгол хэл 2 гарын авлага гарсны зэрэгцээ хилийн чанад дахь монгол хүүхдэд зориулсан “Монгол хэл, соёл” цахим сурах бичгийг боловсруулаад байна.

Боловсролын хүрээлэнгээс цуглуулсан мэдээлэл, түүнд хийсэн шинжилгээнээс харахад болон угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролын чиглэлээр дараах сорилт бэрхшээл байна. Үүнд:

Казах, тува хүүхдийн эх хэл болон монгол хэлний сургалтын үр дүнд дорвитой ахиц гарахгүй байгаа бөгөөд бүрэн дунд боловсрол төгсөгчид ЭЕШ-аар жил

⁵⁴ Эх хэл (казах, тува)-ний 2013 оны сорилын гүйцэтгэлийг 2017 оны сорилын гүйцэтгэлтэй харьцуулсан бол, монгол хэлний 2014 оны сорилын гүйцэтгэлийг 2017 оны сорилын гүйцэтгэлтэй харьцуулсан болно.

дараалан доогуур үнэлгээтэй шалгагдаж байна. Энэ нь тухайн хүүхдүүдийн дараагийн шатны боловсрол эзэмших, уламаар хөдөлмөрийн зах зээл дээр бусадтай эн тэгш өрсөлдөх чадварт сөргөөр нөлөөлж байна. Боловсролын хүрээлэнгийн КХБССекторээс явуулсан “Казах хэлээр сургалт явуулдаг сургуулийн бага боловсролын эх хэлний сургалтын үр дүнг тандах судалгаа”-ны үр дүнгээр казах хэлээр сургалт явуулж буй сургуулийн эх хэлний сургалтын түвшин 50,3%-тай гарсан нь суралцагчдын эх хэлний боловсролын түвшин доогуур байгаа нь удаах хэлийг сурахад сөрөгөөр нөлөөлж байж болзошгүй гэсэн таамаг дэвшүүлэхэд хүргэж байна. Учир нь “эх хэлний боловсрол бол хоёрдогч хэлийг ижил түвшинд сурах боломжийг бүрдүүлдэгийг” сүүлийн үед эрдэмтэд⁵⁵ нотлоод байна.

Хос хэлээр суралцаж буй хүүхдүүдэд хичээл, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж буй багш нар болон сургуулийн чадавх шаардлага хангахгүй байна. Тухайлбал, багш нар хос хэлний боловсролын онцлог, энэ чиглэлийн сургалтыг зохион байгуулахтай холбоотой мэдлэг чадвар хангалтгүй байгаагийн дээр сургуулийн удирдлага, сургалтын менежер нь багш нартаа хоёр дахь хэлийг заах болон зөвлөх чиглэлийн дэмжлэг илт дутагдаж байна. Мөн энэ чиглэлээр үндэсний хэмжээнд хийж буй санал, санаачилга хомс байна.

Хос хэлний сургалт явуулж буй бага ангийн багшийн хувьд эх хэлний (казах, тува) болон монгол хэлний мэдлэг, чадварын түвшин доогуур байгаа нь анхаарч үзэх сорилт болж байна.

Угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн болон гадаад дахь монгол хүүхдийн онцлогийг харгалзсан сургалтын хэрэглэгдэхүүн боловсруулахад арга зүйн болон хүний нөөцийн бэрхшээл учирч байна.

Монгол Улсад өөр хэл, соёл бүхий угсаатны цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлний орчинд олон хэл эзэмших боломжийг дэмжсэн сургалтын дидактик, оновчтой сургалтын хөтөлбөр одоогоор байхгүй байгаагийн зэрэгцээ хос хэл болон олон хэлний боловсролын багш нарыг бэлтгэж, тэдний мэргэжлийг дээшлүүлж ирсэн туршлага хомс байна. Дээрх сорилтыг даван туулахын тулд бидэнд дараах боломж байна. Үүнд:

⁵⁵Ориенийн Их сургуулийн хэсэг эрдэмтэдийн судалгаа

- Монгол Улсын өвөрмөц онцлогт тохирсон хос (олон) болон хэлний боловсролын бодлого, хөтөлбөр боловсруулах;
- Хос хэлний боловсролын хөтөлбөрийг туршиж, Баян-Өлгий аймгийн хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудад нэвтрүүлэх;
- Хос хэлний багш нарыг чадавхжуулах, монгол хэлний мэдлэг, чадварыг сайжруулах, хос хэлээр сургалт явуулах үйл ажиллагааг дэмжих чиглэлээр давтан бэлтгэх; Үүний тулд энэ чиглэлээр БМДИ-ын чиг үүрэгт тусгаж институтчилэх;
- Эх хэл болон монгол хэлний сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах;
- Багш нарыг хос хэл болон олон хэлний боловсролын зөвлөмж, гарын авлагаар хангах;
- Боловсрол, сургалтын байгууллагын үүний дотор тухайлан хос хэлээр сургалт явуулж буй Баян-Өлгий аймгийн боловсролын удирдах бүрэлдэхүүнийг хос хэл болон олон хэлний боловсролын чиглэлээр мэргэжлийг нь дээшлүүлэх;
- Улс орнуудад олон хэлний боловсролын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй туршлагыг⁵⁶ манай улсын өвөрмөц онцлогт тохируулан нутагшуулах зэрэг болно.

Тусгай хэрэгцээт боловсрол

“Тогтвортой хөгжлийн зорилго 2030”-ын боловсролын зорилго нь /ТХЗ 4/ бүх түвшинд тэгш хамран сургах, тэгш боломж бүхий чанартай боловсрол олгох зорилтын хүрээнд бүх хүүхэд, өсвөр үеийнхнийг тэгш хамран сургаж, 12 жилийн чанартай боловсрол (үүний 9 жил нь заавал байх)-ыг төрөөс санхүүжүүлэх, суралцагчийн олон янз байдал, хэрэгцээ шаардлагад нийцсэн, сурч боловсрох эрхийг хангахад саад болж байгаа алагчлал, ялгаварлан гадуурхалтын хэлбэрийг арилгахад чиглэсэн арга хэмжээг авч шийдвэрлэх⁵⁷ талаар тусгасантай холбоотой дараах ажлуудыг энэ чиглэлээр хийж байна. Үүнд:

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургаж байсан сургууль бүр ЕБС-ийн төлөвлөгөө, хөтөлбөрөөс баримжаалж агуулгыг сонгож, хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн уян хатан сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулж чадахгүй байгаагаас хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боломжит дээд нөөцөө дайчлан сурах эрхээ эдлэхэд саадтай байна. Энэ байдал нь сургалтын

⁵⁶ВКНМ, ОБСЕ, “Как разработать и внедрить устойчивую программу много язычного образования”, Бишкек, (2016)

⁵⁷ Инcheon ТХЗ-4

төлөвлөгөө, хөтөлбөрийг шинээр боловсруулах, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгож байна.

2013 онд БСШУС-ын сайдын 311 дүгээр тушаалын 4,5,6 дугаар хавсралтаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хэрэгцээг харгалзан тогтвортой агуулга, засан сайжруулах агуулга, сургууль зохицуулах үйл ажиллагаа гэсэн бүтэцтэй сургалтын төлөвлөгөөг Боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага боловсруулж, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална гэсэн заалт⁵⁸-ын хүрээнд боловсруулж, батлуулж, сургалтад хэрэгжүүлсэн.

Энэ үндсэн дээр оюуны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн бага боловсролын монгол хэл, математик, нийгэм ахуйн баримжаа, дүрслэх урлаг, технологи гэсэн 4 судлагдахууны сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хөтөлбөрийн шинэчлэлийн хүрээнд 9 сурах бичиг /монгол хэл-2, 3,4,5, математик-1, 2, 3, 4, дүрслэх урлаг 1-5 анги/, багшийн ном /нийгэм ахуйн баримжаа 1-5/ боловсруулж, хэвлэгдэн сургалтад хэрэгжүүлж байна.

Олон улсад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд амжилттай тэгш хамран сургахад хувьчилсан буюу ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлдэг. Манай улсад тэгш хамран сургах сургалтыг амжилтад хүргэхэд нөлөөлдөг олон хүчин зүйлийн нэг нь хүүхэд бүрийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа туйлын хангалтгүй байгааг эцэг эх, олон нийтийн зүгээс ихээхэн шүүмжилдэг.

Ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж, сургалтад хэрэгжүүлэх асуудал 2016 онд Монгол улсын Их Хурлаас баталсан⁵⁹ эрх зүйн баримт бичигт тусгалаа олсон.

Боловсролын хүрээлэн, Японы Жайка олон улсын байгууллагатай хамтран ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөний үлгэрчилсэн загвар, боловсруулах аргачлалыг 2014-2017 онуудад боловсруулж, туршиж, сайжруулж, 2018 онд БСШУС-ын сайдын тушаалаар баталгаажуулж, улсын хэмжээнд тэгш хамран сургаж байгаа бүх сургуулиудад 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж эхлээд байна.

⁵⁸ Бага, дунд боловсролын тухай хуулийн

⁵⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль 4 бүлэг 15.4

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн сургалтын хувьд 2017 онд бага боловсролын бэлтгэл хөтөлбөр, монгол хэл, математик, яриа бичиг, айзамт хөдөлгөөнт дасгал, биет зүйлийн судлагдахууны сургалтын хөтөлбөрийг боловсруулж 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хэрэгжүүлж байна⁶⁰.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд тулгуурласан засан сайжруулах сургалтыг СӨБ, ЕБС-д тэгш хамран суралцаж байгаа суралцагчдад огт ордоггүй нь хүүхдийн бэрхшээлийг эрт илрүүлсний үндсэн дээр хүүхдийн бэрхшээлийг засан сайжруулах, амжилттай суралцахад дэмжлэг болох үйл ажиллагаа хэрэгжихгүй байна.

Хэл засал, эмчилгээний биеийн тамир, ахуй засал, үлдэгдэл хараа хамгаалах, дохионы хэл, сонсгол дуудлага хөгжүүлэх, орон зайн баримжаа хөгжүүлэх зэрэг бэрхшээлийн хэлбэрээс хамаарсан ганцаарчилсан засан сайжруулах сургалтыг тэгш хамран сургах сургуулиудад хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага байгаа ч хөтөлбөр боловсруулагдаагүй, ажиллах багш, мэргэжилтэн дутагдалтай, сургалтын орчин, заслын техник хэрэгсэл байхгүй байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тэгш хамран сургах боловсролд хүндрэл учруулж байна (Хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн бэрхшээлийн онцлог хэрэгцээнд нь тохирох ном, сурах бичиг, гарын авлага материал, тусгай хэрэглээний сургалтын тоног төхөөрөмж, хэрэгслээр хангах⁶¹, сургалтын тусгай хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу сургалтыг явуулах⁶², хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн онцлог хэрэгцээнд нийцсэн заах арга зүй, арга барил эзэмшсэн багш, мэргэжилтэн сургалтыг явуулдаг байх⁶³) заалтыг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

МУ-ын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх мастер төлөвлөгөөнд тусгасан тусгай хэрэгцээт боловсролын зорилтын хүрээнд нийслэлийн боловсролын газар олон улсын байгууллагуудтай хамтарсан сургалтууд зохион байгуулж ирсэн бөгөөд ХБ-тэй хүүхдийг оношлох, үнэлэх, заах арга зүйн чиглэлээр сургалтын эрхийг 25 дугаар сургуулийн согог зүйч багш нар авч, 250 гаруй багш нарыг хамруулсан, 29 дүгээр сургууль нь 2003 оноос хойш 23 удаагийн дохио, хэл ярианы сургалтаар хот хөдөөгийн нийт 900 гаруй багш, ажилтныг хамруулсан байна.

Монгол улсын Засгийн газар, олон улсын байгууллагуудаас ихээхэн хөрөнгө оруулалт хийж, ахицтай байгаагийн дотроос томоохон нь Боловсролыг үр дүнд

⁶⁰ БСШУС-ын сайдын 2018 оны А/492

⁶¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 4 бүлэг 15.1.2

⁶² Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 4 бүлэг 15.1.3

⁶³ Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 4 бүлэг 15.1.4

түргэн хүрэх санаачилгын түншлэл хөтөлбөрөөр тусгай 6 сургуульд 128 нэр төрлийн 400 гаруй мянган долларын хөрөнгө оруулжээ. Гэвч хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг эрт илрүүлэх оношлох, нөхөн сэргээх асуудал хангалтгүй байгаагийн гол шалтгаан нь яамд болон байгууллагын хоорондын ажил үүргийн уялдаа холбоо хангалтгүй, нэгдсэн төлөвлөлт сул байгаатай холбоотой юм. Иймээс ХБ-тэй хүүхэд, иргэд боловсролд хамрагдаж байгаа гэх өнөөдрийн тоон үзүүлэлт ч харьцангуй үзүүлэлт юм.

Ердийн сургуульд тэгш хамруулан сургах сургалт руу хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг татан оруулах бодлогыг олон улсын чиг хандлага, бодлогын баримт бичиг, хөтөлбөр Инчеон 2030-д тодорхой заасан зөвлөмжийг хэрэгжүүлэхэд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн ялгаатай байдлыг хүндэтгэсэн, онцлог хэрэгцээнд тулгуурласан, хүртээмжтэй боловсролыг хүүхэд бүрт хүргэхэд анхаарч ажиллах хэрэгтэй байна.

БСШУ-ны болон ЭМ-ийн сайдын хамтарсан тушаал⁶⁴ Энэхүү хамтарсан тушаалд а/ ЕБ-ын тусгай сургууль, анги ажиллуулах, хамран сургах тойргийг тогтоох, элсэлтийг зохион байгуулах журам, б/ Эмнэлэг сурган хүмүүжүүлэх комиссын дүрэм, в/ 29 дүгээр тусгай сургуулийг ЕБ-ын тусгай сургууль, тусгай ангиудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах үүрэг бүхий төв сургууль гэсэн заалтуудыг гаргасан байна. Үүний зэрэгцээ: ЕБ-ын тусгай сургууль, ангийн суралцагчдын мэдлэг чадвар дадлыг үнэлж дүгнэх, анги дэвших, сургууль төгсөх шалгалт явуулахад Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон стандартыг баримтална.

Суурь боловсрол эзэмшсэн төгсөгчдийг аймаг, нийслэл, дүүргийн нийгмийн халамжийн байгууллагад шилжүүлж, тус байгууллага нь мэргэжил олгож ажлын байраар хангах үүрэг хүлээнэ.

Орон нутагт тусгай сургууль, анги төгсөгчдийг МАА-н үйлдвэрлэлд эцэг, эхийн болон өөрийн хүсэлтээр шилжүүлэх, дагалдуулан ажиллуулж болно.

ЕБ-ын тусгай сургууль, анги нь оюуны болон бие эрхтний согогтой сургуулийн насны хүүхдүүдэд суурь боловсрол болон хөдөлмөрийн чиг баримжааг эзэмшүүлэх сургалтыг зохион байгуулна.

Эмнэлэг-сурган хүмүүжүүлэх комиссын шийдвэрийг биелүүлэлгүй хүүхдээ сургуулиас завсардуулсан эцэг эхчүүд боловсролын хуулийн 41-р зүйлийн 2,3-д заасны дагуу хариуцлага хүлээнэ.

⁶⁴ 1996-4 сарын 22-ны өдрийн 125/А/70 тоот/

Ерөнхий боловсролын сургуулийн тусгай ангийн сургалтыг сургуулийн аль нэг хичээлийн эрхлэгч хариуцан ажиллах болно.

Анги дүүргэлт оюун ухааны согогтой хүүхдийн сургууль, ангид 10-15, харах сонсох эрхтний согогтой хүүхдийн сургууль ангид 8-12 сурагчтай байхаар зохион байгуулна.

Ерөнхий боловсролын тусгай сургууль, ангийн сурагчдын эзэмших мэдлэг, чадварын доод түвшинг тусгасан суурь хөтөлбөрийг хичээл тус бүрээр боловсруулж Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Энэхүү суурь хөтөлбөрт хичээл тус бүрийн агуулгын 70-80 хувийг тусгах ба 20-25 хувьд сургууль багш бүр орон нутаг, сургууль ба ангийн сурагчдын онцлогийг бүтээлчээр тусган баяжилт хийж байна.

Ерөнхий боловсролын сургуулийн тусгай ангид хичээл орсон багшид заасан цагт нь тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд хөнгөлөлт үзүүлэх, үйлчилгээний тухай хуулийн 8.8 дугаар заалтын дагуу тухайн багшийн нэг цагийн хөлсийг 10-30 хувийн нэмэгдэл хөлсийг үндсэн цалин дээр нь нэмж олгох зэрэг олон чухал заалтуудыг гаргасан байна. Гэвч өнөөдөр ихэнх заалтыг дагаж мөрдөхгүй байгаа.

Жишээлбэл, эмнэлэг- сурган хүмүүжүүлэх төв комиссын үйл ажиллагаа зогссон. Тусгай хэрэгцээт боловсрол эзэмшиж байгаа хүүхэд, залуучуудын анги дэвших, төгсөлтийн шалгалт зэргийг үнэлэх нэгдсэн аргачлал, стандарт байдаггүй. Орон нутагт МАА-аас гадна өөр өль нэг салбарыг сонгон ажиллах боломжтой байгааг нэмж оруулж өгөх шаардлагатай. Мэргэжлийн чиг баримжаа эзэмшүүлэх хөтөлбөр тодорхойгүй. Цаашилбал мэргэжлийн сургалтыг болиулах талын асуудал хөндөгдөж байгаа.

Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт тусгай анги хичээллэж байгаа тусгай анги, бүлгийн анги бүрдэлтийн болон сургалтын талаарх нэгдсэн мэдээлэл БСШУЯ-нд байхгүй. Статистик мэдээнээс хаана хичнээн хүүхэдтэй тусгай анги хичээллэж байгаа талаар мэдээлэл тусгагдаагүй байна.

Анги дүүргэлт 12-18 сурагчтай, сургуулийн хэмжээнд нэг согог зүйч багшид 40-50 хүүхэд ногдож байна. Өнөөдөр нийгмийн хөгжил, хүрээлэн байгаа орчны нөлөөллөөс шалтгаалан хөгжлийн бэрхшээлийн төрөл хүндэрч хавсарсан хэлбэрийн согогтой хүүхдийн тоо нэмэгдэж байгаа нь анги дүүргэлтийг аль болох цөөн байлгах шаардлагатай болж байна.

Сургуулиуд өөр өөрсдийн хөтөлбөрийг боловсруулан сургуулийнхаа захиргаагаар батлуулан хичээллэж байна. ХБ-тэй хүүхэд ЕБС-ийн ердийн ангид боловсрол эзэмшиж байгаа боловч эдгээр хүүхдүүдэд хичээл заасан багш нарын цалингийн 10-30 хувийн нэмэгдэл олгох, хөнгөлөлт үзүүлэх тухай эрх зүйн заалт байхгүй зэрэг болно.

Тусгай сургуулийн талаар хэрэгжүүлэх арга хэмжээтэй холбоотой дээр дурдсан журам батлагдсанаас хойш 20 гаруй жил өнгөрсөн учраас журмын заалтыг хэрэгжүүлэхэд хүндрэлтэй, орчин үеийн боловсролын чиг хандлагатай тохирохгүй заалт олон байгаа учраас 2018 оны БСШУСЯ, Боловсролын хүрээлэнгийн ажлын төлөвлөгөөнд “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах журам” шинээр боловсруулагдаад, хэлэлцүүлгийн шатандаа явж байна.

Хэрвээ энэхүү журам батлагдвал тэгш хамруулан сургах боловсролыг олон улсын чиг хандлага, олон улсын гэрээ конвенц, хөтөлбөр, баримт бичгийн үзэл санаанд нийцүүлэн өөрийн орны онцлог, нөхцөл боломжид нийцүүлэн зохион байгуулах, сурах олон хэлбэрийн уян хатан сонголтыг хэрэгжүүлэх, багшийн болон суралцагчийн тасралтгүй хөгжлийг хангах, тохируулгат зориулалтын сургалтын орчинг бүрдүүлэх талаар тодорхой заалтуудыг тусган оруулсан.

Тусгай хэрэгцээт боловсролд хамрагдсан суралцагчид нь ЕБС-д суралцагчдын сурлагын амжилтыг үнэлдэг журмаар зохицуулагдаж ирлээ. Харин 2018 онд батлагдсан үнэлгээний журамд тусгай хэрэгцээт боловсролын төлөвлөгөө, хөтөлбөрөөр хичээллэсэн суралцагчдыг тусгай шалгуураар⁶⁵, ганцаарчилсан сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр суралцагчдыг ахицын үнэлгээгээр⁶⁶ үнэлэх зохицуулалтыг тусгасан нь тэгш хамран сургах боловсролд маш их түлхэц өгсөн зарчмын хувьд нэг алхам урагшилсан ажил болсон.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай конвенц /ХБХЭТК/-ийн энэ бүлэгт хамаарах иргэдийн/хүүхдийн хэл ярианы асуудалтай холбогдох заалтууд дараах байдлаар туссан байна. Үүнд: “Брайль үсэг болон түүнтэй төстэй өөр үсэг, нэмэлт болон сонголтот хэлбэр, харилцаанд хэрэглэх бусад хэв маяг, түүнчлэн орон зайн чигийг баримжаалах болон хөдөлгөөн дэмжих ур чадвар эзэмшүүлэх...”⁶⁷ “Дохионы хэл сургахад туслалцаа үзүүлэх болон дүлий хүмүүсийн хоорондын хэл ярианы өвөрмөц онцлогийг хөхиүлэн дэмжих”⁶⁸ зэргээр хөгжлийн бэрхшээлтэй

⁶⁵ БСШУС-ын сайдын 2018 оны А/425 3.15

⁶⁶ БСШУС-ын сайдын 2018 оны А/425 3.16

⁶⁷ ХБХИТК 24.3.а

⁶⁸ ХБХИТК 24.3.б

иргэд, ялангуяа харааны болон сонсголын бэрхшээлтэй хүмүүсийн хэл, харилцааны хэлбэрийг дэмжих, дэлгэрүүлэх талаар зохицуулсан байна.

Брайль үсэг, дохионы хэлийг заах арга зүйд тэгш хамран сургах багш нарыг бэлтгээгүйн улмаас харааны болон сонсголын бэрхшээлтэй иргэдийн дунд бичиг үсэг тайлагдаагүй, бусадтай харилцах арга барил, дадал эзэмшээгүй хүмүүс нэлээдгүй байна.

Харин 2016 онд батлагдсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд “Монгол дохионы хэл бол сонсголгүй хүний эх хэл мөн бөгөөд сонсголгүй хүн дохионы хэлээрээ нийгмийн бүхий л харилцаанд оролцох эрхтэй”⁶⁹, “Брайль бичиг нь хараагүй хүний хэрэглэдэг үндсэн бичиг бөгөөд брайль бичгийг ашиглал мэдээлэл авах, боловсрол эзэмшин нийгмийн харилцаанд оролцох нөхцөл, боломжоор хангана”⁷⁰ гэсэн холбогдох заалтыг хэрэгжүүлэх зорилгоор дохионы хэлний сургалтыг зохион байгуулах, брайль үсгийн стандартыг боловсруулах ажлын хэсэг байгуулагдаад ажиллаж байна.

Ингэснээр Инчеон 2030 хөтөлбөрийн 4 заалтын хэрэгжилтийг хангахад сонсгол, харааны бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн харилцаанд адил тэгш оролцох боломжийг бүрдүүлэхэд ихээхэн түлхэц болно. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн чанартай боловсрол эзэмших хэрэгцээнд нь тулгуурласан биш, хөгжлийн бэрхшээлд нь тохирсон боловсрол эзэмшүүлэх гэсэн агуулгыг халснаар хүний адил тэгш сурч боловсрох эрхийг хангах болно.

Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн байдал, хөгжил

Боловсролын тогтолцоог бүтцийн хувьд албан боловсрол, албан бус боловсрол, амьдарч аж төрөх явцад олох информал боловсрол гэж өргөн хүрээгээр ангилдаг. Эдгээр нь боловсролын тогтолцоог бүрдүүлэгч элементүүд нь боловсролын нэгдсэн тогтолцоог бүрдэж байна.

Боловсрол нээлттэй, чөлөөтэй, олон хувилбартай байх нь хувь хүн, нийгмийн олон талт хэрэгцээг хангах боломжийг улам бүр нэмэгдүүлж байна.

Өнөөдөр хүн албан боловсролоор сурах бололцоогүй бол албан бус боловсрол, зайн сургалт, амьдарч аж төрөх явцад олох информал боловсролын аль нэг хувилбарыг ашиглах бүрэн боломжтой боллоо.

Боловсролын тогтолцоо нь өргөн хүрээтэй учраас уг тогтолцооны нэг чухал бүрэлдэхүүн болох мэргэжлийн боловсрол сургалт (МБС)-ын тогтолцоог


⁶⁹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 3 бүлэг 12.1

⁷⁰ Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль 3 бүлэг 12.2

хөгжлийн үйл явц, үе шатанд улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн зорилго, эрэлт хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн МБС-ыг хөгжүүлэх төрөл бүрийн зохицуулалтын арга хэлбэрийг хэрэгжүүлж ирсэн байна.

Монгол улсад информал боловсрол голлож байх үед шавь болон дагалдан сургалтын хэлбэртэй, сургалтын агуулга, арга зүй нь техникийн суурь мэдлэг шаарддаггүй энгийн хийцийн машин, тоног төхөөрөмж, гар багаж хэрэгсэл, түүхий эд материалыг боловсруулах уламжлалт технологид суурилсан мэдлэг ур чадвар, хөдөлмөрийн арга барилыг үр хүүхэд, нутаг усныхаа залуучуудад өв уламжлуулан эзэмшүүлж байжээ.

Зураг 6. Монгол улсын боловсролын тогтолцоо



Хүснэгт 26. Мэргэжлийн боловсрол, сургалтын хөгжлийн үечлэл

Хөгжлийн үе шат	Хамрах хугацаа	Удирдлагын бүтэц	Сургалтын агуулга	Сургалтын хэлбэр
Амьдрах аж төрөх явцад олох информал боловсрол	Нэн эртний үеэс 1921 оны ардын хувьсгал хүртлэх үе	Шашин, төр	Уламжлалт гар үйлдвэрлэлд суурилсан мэдлэг, ур чадвар, хөдөлмөрийн арга барил эзэмшүүлэх	Шавь болон өв уламжлах дагалдан сургалт
Албан бус тогтолцоо	1923-1963 оны хөгжлийн үе	Ардын гэгээрлийн яамны дэргэд Тусгай сургуулийн хэлтэс, Уран дарханы салаа, Урлан найруулах сургуулийн салаа, Тусгай дээд, их сургуулийн салаа	Машин техник ажилуулах техник технологийн үндсэн мэдлэг, мэргэжлийн ур чадвар дадалтай бие хүн бэлтгэх	Үйлдвэрийн техникум, фабрик заводын сургууль, сургууль комбинат, курс, техникийн дугуйлан, салбарын мэргэжлээр төрөлжсөн сургууль

Албан боловсролын тогтолцоо	1964-1990 оны төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үе	<ul style="list-style-type: none"> • Хөдөлмөр цалин хөлсний улсын хороо • Улсын дээд, тусгай дунд, техник мэргэжлийн боловсролын хороо • Ардын боловсролын яамны харъяа ТМБУЕГ 	Механик болон автомат техник, тоног төхөөрөмжийг ажиллуулах, тохиргоо хийх мэдлэг, чадвартай нийгмийн хариуцлагатай, коммунист ухамсартай инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчин бэлтгэх	Техник мэргэжлийн сургууль, техник мэргэжлийн дунд сургууль
Боловсролын иж бүрэн тогтолцоо	1991 оноос хойших зах зээлийн засгийн шилжилт болон өнөө үе	<ul style="list-style-type: none"> • Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам • Хөдөлмөрийн яам 	Эрэлт хэрэгцээнд нийцсэн цогц мэдлэг, чадамж, хандлагатай иргэн бэлтгэх	МСҮТ, Политехник коллеж, мэргэжлийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын болон боловсролын төв

Зах зээлийн эдийн засгийн харилцааны нөхцөл дэх боловсролын салбарын дотор мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоо нь нийгэм, хүмүүнлэгийн болон эдийн засгийн томоохон ач холбогдолтой нийгмийн бүх гишүүдэд ашиг өгдөг онцлог салбар юм.⁷¹

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үеийн мэргэжлийн боловсрол, сургалтын талаар Европын сургалтын сангийн тайланд Андреас де Грип доорхи байдлаар дүгнэсэн байна.

Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед үйлдвэрлэл ба сургалтын хооронд салшгүй нягт холбоо байсан. Энэ холбоо нь үйлдвэрлэл болон мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцоонуудын хооронд мэргэжилтэй ажилчдын ур чадварын эрэлт, нийлүүлэлтийн талаарх мэдээллийг дамжуулах боломжийг бүрдүүлсэн гэж дүгнэжээ.⁷²

Сургуулийн дадлагын газар, аж ахуйг түшиглэсэн жижиг, дунд үйлдвэр бий болгож үйлдвэр сургалтын дадлагын хичээл явуулахын зэрэгцээ зах зээлийн зарчмын дагуу аж ахуйн үйл ажиллагааны орлого олж багш, сурагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэл баримтлан техник мэргэжлийн сургуулийг Ардын боловсролын яам 1991 онд ТМС-иудыг МСҮТ, салбараар төрөлжсөн ТМС,

⁷¹ Мэргэжлийн боловсрол, сургалтын тогтолцооны үүсэл хөгжил хандлага. С.Цээпил. 2006 он

⁷² Боб Мансфилд, Ларс Андерсен. Чадамжид суурилсан сургалтын стандарт 2003 он 7 тал

техникумыг нэгтгэн Техникийн их сургуульд нэгтгэх, шаталсан сургалттай коллеж болгон өөрчлөн зохион байгуулсан. Мөн хувийн хэвшлийн мэргэжлийн сургууль байгуулах асуудлыг дэмжиж анхны сургуулиуд бий болжээ.

1991 онд УИХ “Боловсролын тухай хууль”, МБС-ын тогтолцоог зах зээлийн харилцаанд нийцүүлэн сэргээн хөгжүүлэхийн тулд Азийн хөгжлийн банкны дэмжлэгтэйгээр 1993 онд “Монгол улсын боловсрол, хүний хүчин зүйлийг хөгжүүлэх мастер төлөвлөгөө”, 1995 оны УИХ-ын 36-р тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтыг хөгжүүлэх томоохон бодлогын баримт бичиг болсон төдийгүй боловсролын багц хуулиуд батлагдан гарсан⁷³.

Европын холбооны ТАСИС хөтөлбөрийн санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл”-ийн хүрээнд 1995 онд хийгдсэн судалгаагаар Монгол улсын эдийн засгийн хөгжлийг түргэтгэхэд хөдөлмөрийн зах зээл тогтолцоог бүрдүүлэх, зах зээлийн зарчмаар ажиллуулахад дан ганц хувийн хөдөлмөрийн биржийн үүрэг хангалтгүй гэдэг нь харагдсан.

Хөдөлмөрийн зах зээлийн гол тоглогч ажилтан, ажил олгогч, эздийн байгууллага үйлдвэрлэлийн гол хүчин зүйл болох мэргэжилтэй ажиллах хүчийг бэлтгэх, ажлын байрыг хамгаалах, бүтээмжийг нэмэгдүүлэх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудалд анхаарлаа хандуулах болсноор үйлдвэрийн ашиг орлого нэмэгдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлүүлэх замаар ажилчдын эрх ашгийг хамгаалахад үйл ажиллагаанд учир буй гол бэрхшээл нь ХЗЗ-ийн эрэлт, МБС-ын нийлүүлэлтийг зохицуулах иж бүрэн тогтолцоо, хэрэгжүүлэх механизм дутагдаж байна гэдэг дүгнэлтэд хүрсэн.

ТМБ-ын үндэсний тогтолцоог өөрчлөн шинэчилж хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагааг зах зээлийн чөлөөт эдийн засгийн зарчим, шаардлагад нийцүүлэн зохион байгуулахад улсын төсөвт ихээхэн хэмжээний ачаалал бий болж санхүүжилтийн хүндрэл үүсч, төвлөрсөн эдийн засгийн тогтолцоо задарч үйлдвэрлэлийг ажиллах хүчээр хангах үүрэг үгүй болж, зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн уян хатан тогтолцоонд нийцсэн сургалтыг явуулах тал дээр анхаарал хандуулалгүй, нийлүүлэлтэд чиглэсэн сургалтын үйл ажиллагаа хэвээр үргэлжлүүлэх боломжгүй болсон байна.

Мэргэжлийн боловсрол, сургалтын эрх зүйн шинэчлэл

⁷³ МУ-ын МБС-ын эрх зүйн шинэчлэл, тулгамдсан асуудал, Б. Мшигжав, 2014 он


МБС-ын тогтолцоог шинэчлэх ажлын хүрээнд 1995 оны УИХ-ын 36-р тогтоолоор “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого”-д техникийн болон мэргэжлийн боловсролын сургалтыг хөгжүүлэх томоохон бодлогын баримт бичиг болсон төдийгүй боловсролын багц хуулиуд батлагдан гарсан байна.⁷⁴

1998 онд “Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”, “Техникийн мэргэжлийн сургалтын бодлого зохицуулалын Үндэсний зөвлөл”-ийг байгуулсан.⁷⁵

Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд чиглэсэн МБС-ын тогтолцоог хөгжүүлэх зорилгоор “Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай” хуулийг 2002 онд Улсын их хурал батлан гаргасан. Энэ нь боловсролын тогтолцоонд мэргэжлийн боловсрол, сургалтын эзлэх байр суурь, мөн чанар, хамрах хүрээг тодорхойлон нийгэм, эдийн засаг, хүмүүнлэгийн үүргийг өргөж, удирдлага, санхүүжилтийн механизмийг зах зээлийн нөхцөлд нийцүүлэх, МБС-ын байгууллагын удирдлагын тогтолцоо, сургуулийн шинэ, хэв шинжийг баталгаажуулж, нийгмийн түншүүдтэй хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлсэн юм.⁷⁶

“Монголын боловсролыг 2000-2005 онд хөгжүүлэх стратеги”, 2003-2007 онд АХБ-ны НОРДИК-ийн сангийн дэмжлэгээр “Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр”-ийн төслийн үр дүнд БСШУЯ, НХХЯ-ны салбар дундын зохицуулалттай МБС-ын мэргэжил арга зүйн нэгдсэн тогтолцоо шинээр бүрдсэн.

Зураг 7. МБС-ын удирдлагын тогтолцооны бүтэц (2004-2009 он)



МБС-ын хуулинд 2009 онд оруулсан шинэчлэсэн найрлагын нэмэлт өөрчлөлтөөр⁷⁷ “...эрэлтэд суурисан мэргэжлийн боловсролыг хөгжүүлэх,

⁷⁴ МУ-ын МБС-ын эрх зүйн шинэчлэл, тулгамдсан асуудал, Б. Мшигжав, 2014 он

⁷⁵ ХЗЗ-ийн эрэлтэд суурилсан МБ-ын тогтолцооны хөгжлийн институци, эрх зүйн асуудал, Д. Нармандах, 2014 он.

⁷⁶ “Төрийн мэдээлэл”, УБ, 2002 он

⁷⁷ “Төрийн мэдээлэл”, УБ, 2009 он

үндэсний зөвлөлийн статусыг МБС-ын дээд удирдлага болгох, сургалтын стандарт, агуулгыг шинээр тодорхойлох, багш, сурагч, сургуулийн эрх хэмжээ, чиг үүргийг боловсронгуй болгох, олон эх үүсвэр бүхий санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, МБС-ыг дэмжих сан ажиллуулах зэрэг шинэлэг зохицуулалтыг бий болгосон байна.

Мөн хуулийг хэрэгжүүлэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагын бүтцийг бий болгосон олон улсын нийтлэг жишиг, хандлагад нийцсэн, салбар дундын зохицуулалт, нийгмийн түншлэлийн хамтын ажиллагааг дэмжсэн чухал алхам болсон байна.

Зураг 8. МБС-н удирдлагын тогтолцоо 2009-2012 он



МБС-ын тухай хуулийн 2012 оны нэмэлт өөрчлөлтөөр⁷⁸ МБС-ыг ХЗЗ-ийн эрэлт, нийлүүлэлтийн бодлоготой уялдуулах, төгсөгчдийн ажил эрхлэлтийг дэмжих нөхцөл бүрдэж “Хөдөлмөр эрхлэлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр мэргэжлийн сургалтыг санхүүжүүлэн зохион байгуулах, сургуулиудыг ХЗЗ-ийн эрэлтийн тоон мэдээллээр хангах, төгсөгчдийг ажлын байртай болгох, хараат бус ажлын байрыг дэмжиж чиглэлээр санхүүгийн дэмжлэг олгох, мэргэжлийн баримжаа, зөвлөгөө өгөх арга хэмжээг хөдөлмөрийн болон мэргэжлийн боловсрол, сургалтын салбарын хэмжээнд нэгтгэн зохион байгуулдаг болсон.

Мэргэжлийн боловсролын сургалтын байгууллагын онолын болон дадлагын багшийн сургалтын цагийн ачаалал, цалин хөлс, амралтын хоног нь адил тэгш болсоноор үйлдвэрлэлийн ажлын зохих дадлагатай, мэргэжлийн өндөр зэрэгтэй, үйлдвэрлэл, технологийн туршлагатай, хүмүүсийг ажиллуулах боломж нөхцөлийг бүрдүүлсэн.

⁷⁸ “Төрийн мэдээлэл”, УБ, 2012 он

Суралцагчийн сурлагын амжилт, мэргэжлийн ур чадварыг ажил олгогчдод мэдээлэх, дадлагажуулах, төгсөгчийн сонирхолд тулгуурлан ажлын байранд зуучлах, аж ахуй эрхлэх санаачилгыг дэмжих замаар ажлын байраар хангах, тавиас дээш ажилтантай аж ахуйн нэгж суралцагчийн үйлдвэрлэлийн дадлагын ажлыг зохион байгуулж, удирдан чиглүүлэх үүрэг бүхий дадлагажуулагч багш ажиллуулах болсон хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй хангах, үйлдвэрлэлийн процессийн дагуу ажил үүрэг гүйцэтгэх, ур чадвар эзэмших болон дадлагын хугацаанд ажилтай болох, хувиараа аж ахуй эрхлэх, өөртөө ажлын байр бий болгох боломжийг бүрдүүлж өгсөн байна.

2012 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд байгуулагдсан Монгол улсын Засгийн газар МБС-ын агентлагыг татан буулгаж шинээр байгуулагдсан Хөдөлмөрийн яам яамны харъяа бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар байгуулан чиг үүргийг хариуцуулан ажиллах болсон.

Хөдөлмөрийн яам МБС-ыг ХЗЗ-ийн эрэлт, нийлүүлэлтийн бодлоготой нийцүүлэх, ажилгүй иргэдийг “Хөдөлмөр эрхлэлийг дэмжих сан”-гийн санхүүжилтээр мэргэжлийн сургалтад хамруулан мэргэжил олгох, МСҮТ-ийг төгсөгчдийг ХЗЗ-ийн эрэлтийн дагуу ажлын байранд зуучлах нэгдсэн зохицуулалтыг хэрэгжүүлэх зорилготой холбон тайлбарлаж болох юм.

Зураг 9. МБС-ын удирдлагын тогтолцоо (2012-2016)




2016 оны МБС-ын хуулийн шинэчилсэн найруулгад орсон нэмэлт өөрчлөлтөөр МБС-ын талаарх төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд ажил олгогчид, яамдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх, улсын хэмжээнд мөрдөх ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт,

мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах, ажил олгогч, салбар зөвлөлийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлах батлах зэрэг үйл ажиллагааны чиглэлээр МБС-ын үндэсний зөвлөлийн хамрах хүрээг өргөтгөж өгсөн нь томоохон дэвшил болжээ.

“Үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв”-ийг байгуулсан нь МБС-ын байгууллагыг аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах, мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах, мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах, мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи статистик болон бусад мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сан бүрдүүлэх, хөтлөх, мэргэжлийн сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоодын оролцоотойгоор ажил, мэргэжил, ур чадварын стандарт боловсруулах, модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах боломжтой болсон байна.

Зураг 10. МБС-ын удирдлагын тогтолцоо (2016 оноос хойш)



МБС-ын үндэсний зөвлөлийг ажиллах хүчний талаар баримтлах төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага, ажил олгогчид, яамдын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, мэргэжлийн боловсрол, сургалттай холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилт, мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог хөгжүүлэх, хяналт тавих эрхтэй болсон.

Ажил, мэргэжлийн үндэсний ангилал, тодорхойлолт, мэргэжлийн стандарт, мэргэжлийн боловсрол, сургалтын агуулгыг хэлэлцэж дүгнэлт гаргах, ажил олгогч болон салбар зөвлөлийн хамтарсан дүгнэлтийг үндэслэн мэргэшлийн түвшний хүрээ, ажил мэргэжлийн лавлах батлах зэрэг үйл ажиллагааны хамрах хүрээ нэмэгдсэн.

МБС-ын сургалтын агуулга, стандарт

МБС-ын агуулга нь стандартай байна гэж хуулчилсны дагуу мэргэжлийн анхан, дунд шатны сургалт нь үйлдвэр аж ахуйн газар, байгууллагатай хамтран ажил олгогч, хэрэглэгчдийн хэрэгцээ шаардлагад нийцсэн мэргэжилтэн бэлтгэх зорилгоор ажил мэргэжлийн дүн шинжилгээ хийх, сургалтын агуулгыг тодорхойлох, дадлагын сургалтын орчин нөхцөлийг сайжруулах, төгсөгчдийг мэргэжил эзэмшилтийн түвшинг шалган баталгаажуулах зорилгоор БСШУЯ-ны Мэргэжил арга зүйн үндэсний төв “МБС-ын загвар стандарт MNS-53-70”-ыг боловсруулан Стандарт хэмжил зүйн үндэсний төв 2004 онд баталгаажуулсан.

Тус загвар стандартыг чадамжид суурилсан сургалтыг нэвтрүүлэх зорилгоор Стандарт хэмжил зүйн газраас MNS 6541-2015 “Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий шаардлага” загвар стандартыг шинэчлэн баталсан.

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/197 тоот тушаалаар загвар стандартын дагуу чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрөөр мэргэжлийн боловсрол, сургалтыг зохион байгуулж байна.

МБС-ын байгууллагаар бэлтгэж байгаа мэргэжлийн чиглэл индексийг БСШУС-ын сайдын 2016 оны А/150 тоот тушаалаар батлан сургалтын үйл ажиллагаанд нэвтрүүлж байна.

“Үнэлгээ, мэдээллийн болон бүсийн арга зүйн төв”-ийг 2016 онд байгуулан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагыг аттестатчилах, багшид мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах, мэргэжлийн болон техникийн боловсрол сургалтын агуулгыг тогтоох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлах, дадлагын сургалтын үйл ажиллагааг зохицуулах баримт бичгийг батлах, мэргэжлийн ур чадварыг үнэлэх, шалгах, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах ажлыг эрхлэх болгов.

Мөн мэргэжлийн боловсрол, сургалтын талаархи статистик болон бусад мэдээллийн нэгдсэн тогтолцоо, сан бүрдүүлэх, хөтлөх, мэргэжлийн сургалтын сурах бичиг, хичээлийн хэрэглэгдэхүүнээр хангах ажлыг зохион байгуулах, мэргэжлийн байгууллага, нийгэмлэг, холбоодын оролцоотойгоор ажил,

мэргэжил, ур чадварын стандарт боловсруулах, модулийн сан, тестийн сан бүрдүүлэх, чадамжид суурилсан сургалтад хамрагдсан иргэнд чадамжийн гэрчилгээ, мэргэжлийн болон техникийн боловсролын хөтөлбөрийн шаардлагыг хангасан иргэдэд мэргэжлийн зэрэг олгох ажлыг зохион байгуулах болов.

Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын суралцагч үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагад дадлагын ажил хийхдээ үндсэн болон дагалдангийн орон тоон дээр ажилласан бол хөдөлмөрийн хөлс авах, хөнгөлөлт эдлэх, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг дээд үнэлгээтэй төгсөгч нь шаталсан сургалттай техникийн боловсролын сургалтын байгууллагын дараагийн шатны сургалтад үргэлжлүүлэн суралцуулахаар заасан.

1995 оноос эхлэн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллага нь өдрийн, оройн, хосмог сургалтыг дагнасан буюу шаталсан хэлбэрээр зохион байгуулж эхэлсэн.

Шаталсан сургалтын бүтэц бий болсноор инженер, техникийн ажилтан бэлтгэх сургалтын хугацааг МСҮТ-д 2,5-3 жил, коллежид 3 жил, их, дээд сургуульд 4 жил нийт 10 жил сурдаг хугацааг богиносгон Мэргэжлийн боловсрол эзэмшихэд 2,5 жил, шатлан дипломын боловсрол эзэмшихэд 1,5 жил, баклавын зэрэг эзэмшихэд 2,5-3 жил ($2.5+1.5+3=7$) болж суралцах хугацааг 3 жилээр хэмнэсэн төдийгүй, агуулгын давхардлыг арилгаж залгамж чанарыг хангах, зардал хэмнэж хүмүүсийн амьжиргаанд бодитой хувь нэмэр болсон байна.

Тус туршилтын үр дүнд Дээд боловсролын тухай хуулинд 2016 оны нэмэлт өөрчлөлтөөр⁷⁹ техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт өмнө эзэмшсэн багц цагийг дүйцүүлэн элсүүлэн суралцуулах болов.

Ийнхүү шатлан суралцах хууль эрх зүйн орчин бүрдсэнээр залуучууд болон насанд хүрэгчдэд ажил мэргэжлийн карьер өсгөх, насан туршийн тасралтгүй боловсрол эзэмших бололцоог нээгдсэнээр МБС-ын байгууллагад элсэх элсэлт, төгсөлтийн чанар, мэргэжлийн дагуу ажил хөдөлмөр эрхлэх боломж өсөж, үйлдвэрлэлд хэрэглээний инженер, техникийн ажилчдыг бэлтгэн нийлүүлэх гол хөшүүрэг болж байна. Энэхүү оюутан сурагч, насанд хүрэгчид шатлан суралцах боломжтой болсоноор МБС-ын байгууллагаар эзэмшсэн мэргэжлийн үнэ цэнийг өсгөх чухал хүчин зүйл билээ.


⁷⁹ “Төрийн мэдээлэл” УБ, 2016 он

МБС-ын байгууллагаар эзэмшсэн техникийн боловсролын хөтөлбөрийг багц цагт дүйцүүлэн тооцох болсоноор хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх, насан туршийн сургалтаар гадаад, дотоодод бие дааж эзэмшсэн мэргэжлийн ур чадварыг хүлээн зөвшөөрч, баталгаажуулалт хийх болсон нь хүний нөөцийг хөгжүүлэх томоохон дэвшил болсон.

Мэргэжлийн боловсрол сургалтын тогтолцоог зах зээлийн нөхцөлд хамтран ажиллах механизм, хариуцлагын тогтолцоог бий болгох, салбарын бодого, хөгжлийг хангаж чадахуйц сургуулийн хэв шинж бүрдэж байна.

Мэргэжлийн боловсролын сургалтын хэв шинжид мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төв, техникийн боловсролын сургалтын байгууллагыг политехник коллеж, үйлдвэрлэлийн харьяалалтай сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн сургалтын төв, хөдөлмөр эрхлэлтийн боловсролын төв, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын байгууллага зэрэг хэв шинжтэй, бүрэлдэхүүндээ, эсхүл харьяалалдаа мэргэжлийн зөвлөгөө өгөх, үйлдвэрлэл-үйлчилгээ эрхлэх нэгж, бизнес инкубатор, туслах аж ахуй эрхлэх болсон.

Зураг 11. Мэргэжлийн боловсрол, сургалтын хэв шинж



Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллага өөрийн үйл ажиллагаанаас орлого олох, зарцуулах эрхтэй болсноор үйлдвэр сургалтын дадлагыг үйлдвэртэй хослуулах, багш, суралцагч нарыг урамшуулах, сургуулийн материаллаг бааз, техник тоног төхөөрөмжийг шинэчлэх зэрэг асуудлыг өөрсдөө шийдвэрлэх боломжийг бүрдүүлж өгсөн байна.

Мөн сургуулийг санхүүгийн талаар дэмжих, сургалтын орчныг сайжруулах, тоног төхөөрөмжийг шинэчлэх, мэргэжлийн багш нарыг шинэ техник технологи, хөдөлмөр зохион байгуулалтын арга барил, шинэ норм норматив, стандартуудтай танилцуулах боломж олгож сургалт мэргэжил эзэмшүүлэлтийн

чанарыг дээшлүүлэхэд бодит туслалцаа үзүүлэн сургууль аж ахуйн байгууллагын хамтын үйл ажиллагааг нягтруулах хамтын ажиллагаа бүрдсэн.

Дээд боловсролын хөгжлийн өнөөгийн байдал, хөгжил

Өнөөгийн байдлаар манай улсын дээд боловсролын харилцаанд 2002 онд батлагдсан Дээд боловсролын тухай хууль хүчин төгөлдөр үйлчилж байна. Уг хуульд 2006, 2015, 2016 онуудад нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна.

Эдгээрээс томоохон өөрчлөлт нь төрийн болон төрийн бус өмчийн дээд сургуулийн харьяа сургууль байгуулахтай холбоотой зохицуулалт оруулж, дээд сургууль нь шинжлэх ухааны тодорхой чиглэлээр судалгаа, шинжилгээний ажил явуулж дипломын болон бакалаврын сургалт эрхлэх эрх бүхий сургалт-эрдэм шинжилгээний байгууллага болохыг хуульчилж өгчээ.

Мөн дээд сургууль нь магистрын сургалт эрхэлж болохоор заасан. Мөн 2016 оны нэмэлт, өөрчлөлтөөр техникийн боловсролын хөтөлбөрийн агуулга, багц цагийг дүйцүүлэн тооцох замаар техникийн боловсролыг албан сургалтаар эзэмшсэн, элсэлтийн ерөнхий шалгалтад орсон төгсөгчийг дээд боловсролын бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулж болох бөгөөд багц цагийг дүйцүүлэн бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах журмыг мэргэжлийн боловсрол, сургалтын болон боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батлахаар өөрчилжээ.

2016 онд орсон хоёр дахь нэмэлт өөрчлөлтөөр төрийн болон төрийн бус өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын удирдах зөвлөлийг байгуулах, захирлыг сонгох, дээд боловсрол олгох байгууллагыг татан буулгах зэргийг зохицуулсан. Түүнээс гадна дараах өөрчлөлтүүдийг оруулжээ. Үүнд: Дээд боловсролын тухай хуулийн 4.5-д “Дээд боловсролын зэрэг олгодог онолын мэдлэг, ур чадвар, дадал бүхий үйлдвэрийн инженер, технологчийг бэлтгэх технологийн коллеж” ..-ийн тухай заасан.

Хуулийн 8.11-д “Дээд боловсролын сургалтын байгууллага нь боловсролын магадлан итгэмжлэл хийх эрх бүхий байгууллагаар байгууллагын магадлан итгэмжлэлийг заавал хийлгэнэ” гэж тусгасан. Өмнө нь сайн дурын үндсэн дээр магадлан итгэмжлэл хийгддэг байсан. Мөн 12.2.-т “Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их, дээд сургууль нь өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах

төвийг дангаар болон үйлдвэрлэлийн кластерийн тогтолцоогоор байгуулан ажиллуулж болно” гэсэн заалт шинээр нэмэгдсэн.

“Ажил олгогчдын захиалга, санхүүжилтээр оюутан сургах, сургалт судалгаа, шинжилгээний ажлыг дэмжих сан, Тэтгэлгийн сан, Эрсдэлийн сан, Хөрөнгө оруулалтын сан, Тусгай зориулалтын сангуудыг ажиллуулах болон гарааны компани байгуулах зэрэг зүйл заалт нэмж оруулсан нь дээд боловсролын байгууллагын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгох эрх зүйн орчин бүрдсэн гэж болно. Мөн дээд боловсролыг улс төрийн нөлөөнөөс ангид байлгаж, удирдлага, зохион байгуулалт, менежментийг олон нийтийн оролцоонд суурилсан, ардчилсан, хараат бус, нээлттэй зарчимд тулгуурласан байх зохицуулалтыг тусгасан байна⁸⁰.

Засгийн газар өөрийн үйл ажиллагааны хөтөлбөртөө дээд боловсролын талаар ямар арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр тусгаж, түүний дагуу ямар ажил гүйцэтгэж ирсэн тухай тодруулах нь зүйтэй. Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “чанаргүй их, дээд сургуулиудыг цөөлж сургалт, судалгаа, үйлдвэрлэл хосолсон, зах зээлд эрэлт хэрэгцээтэй боловсон хүчин бэлтгэдэг сургалтын системд шилжүүлж, дэргэдээ эрдэм шинжилгээ, үйлдвэрлэл, туршилтын инкубатор байгуулан, өндөр технологийн компанийг бойжуулж, бүтээлээ зах зээлд нэвтрүүлэхийг төрөөс дэмжих” гэж заасан.

Энэ хүрээнд 2016 онд Боловсролын тухай багц хууль, түүний дотор Дээд боловсролын тухай хуульд томоохон нэмэлт өөрчлөлт оруулж “Оюуны болон технологийн нөөцийг ашиглах, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын ололтыг үйлдвэрлэл, үйлчилгээнд нэвтрүүлэх зорилгоор их, дээд сургууль нь өөрийн үндсэн бүтцэд харьяалагдах сургалт-судалгааны бизнес-инкубатор, технологи дамжуулах төвийг дангаар болон үйлдвэрлэлийн кластерийн тогтолцоогоор байгуулан ажиллуулж болохоор болсон юм.

Их сургууль харьяалалдаа дээд сургууль, коллеж, технологийн коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, гарааны компани, ахлах сургуультай байж болохоор; багшийн эрх үүрэгт дангаараа болон их сургууль, дээд сургууль, эрдэмтдийн баг, хуулийн этгээдтэй хамтран ажиллах болон гарааны компани байгуулах боломжийг хуульчилсан.

Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.2-т “Төрийн өмчийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг хангаж, дээд боловсролд

⁸⁰ www.legalinfo.mn

хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг нэвтрүүлж, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлнэ”, 3.2.18 “Төрийн өмчит их, дээд сургууль, коллежийг хувьчлахгүй.

Дээд боловсролын эрх зүйн орчинг боловсронгуй болгож, төрийн их, дээд сургуулийн бие даасан байдлыг нь хангах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, стандартад суурилсан чанарын хяналтын бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлэх, судалгаанд суурилсан их сургуулийг хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ”, 3.2.19 –д “Эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийг хөгжүүлэхэд төрөөс зарцуулах санхүүжилтийг нэмэгдүүлнэ” гэж тусгасан.

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дээд боловсролтой холбогдох хэсгүүдээс “...хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээг баримжаалсан мэргэжилтэн бэлтгэх, ...” гэсэнтэй адил агуулга бүхий заалт өмнөх буюу 2012-2016 оны Засгийн газрын мөрийн хөтөлбөрт ч тусгагдан тодорхой ажлууд хийгдэж ирсэн.

Статистикийн мэдээгээр манай орны хүн амын тоо 2015 оны жилийн эцсийн байдлаар 3057.8 мян. хүнд хүрчээ. Эдийн засгийн идэвхтэй хүн ам, нийт хүн амын 40.7%(1243.9 мян.)–ийг, ажиллагчид 1151.2 мян. хүн байгаа нь хөдөлмөрийн насны нийт хүн амын 92.5%-ийг тус тус эзэлж байгаа юм. Хүн амын бичиг үсэг тайлагдалтын түвшин 98.4% байгаа нь олон улсын холбогдох зарим байгууллага, тухайлбал “ЮНЕСКО”-ийн үнэлгээгээр өндөр үзүүлэлтэд тооцогддог (Дэлхийн дундаж 86.1).⁸¹

Хүн амын боловсролд хамрагдалт 1000 хүнд 285.5 хүн байгаа ба тэр дундаа дээд боловсролтой хүмүүс 54.2 хүн ногдож байна. Хүний хөгжлийн индекс 2014 онд 0.727 болсноор Монгол улс хүний хөгжлийн түвшин өндөртэй орнуудын ангилалд шилжиж, дэлхийн 188 орноос 90-р байранд орсон ба сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байна (2000 онд 0.589, 2005 онд 0.649, 2010 онд 0.695). Суралцагчдын тоо 740.4 мян. хүн (нийт хүн амын 24.2%), тэр дундаа их дээд сургуульд 162.6 мян. оюутан суралцаж байгаа нь 15-34 насны залуучууд (1084.9 мян. хүн)-ын 15.0%-ийг эзэлж байна. Инженерийн чиглэлээр суралцагчид тэдний 21.6% (35.1 мян. хүн)–ийг эзэлж байна.тү

⁸¹ Монгол улсын хөгжлийн урт хугацааны бодлого (төсөл) 2015-2040, Үндэсний хөгжлийн хүрээлэн, УБ., 2015

Дээд боловсролын салбарт 2017 оны байдлаар 95 их, дээд сургууль, коллеж үйл ажиллагаа явуулж байгаа ба 2006 оны түвшнээс 1.8 дахин буурчээ. Түүнчлэн 2016 онд төрийн өмчийн 17 их, дээд сургууль, коллеж бүртгэлтэй байна. Үүнийг 2006 оны түвшинтэй харьцуулахад 2.8 дахин буурсан байна. Эдгээр нь төрийн өмчийн сургуулиудын тооноос менежментийн хувьчлалд орсон сургуулиудыг хасаж төрийн бус өмчийн сургуульд оруулсан, мөн Монгол улсын ЗГ-ын 2010 оны 1-р сарын 20-ны өдрийн 15-р тогтоолоор төрийн өмчийн 42 сургуулийг 16 болгон өөрчлөн зохион байгуулсан зэрэгтэй холбоотой юм.

2017 оны байдлаар нийт их, дээд сургуулиудын 77.9 хувь нь төрийн бус өмчийн их, дээд сургууль байгаа боловч нийт суралцагчдын 58.4 хувь нь төрийн өмчийн их, дээд сургууль, коллежид суралцаж байна. Их, дээд сургуулиудын 69.0 хувь нь магадлан итгэмжлэгдэж, тэнд нийт суралцагчдын 97.2 хувь нь суралцаж байна. Нийт суралцагчдын 20 орчим хувь (сүүлийн 10 жилийн дунджаар) нь төгсөж, тэдний 36.7 хувь (мөн 10 жилийн дундаж) нь төгсөөд ажлын байртай болсон гэсэн статистик байна.

2017 оны байдлаар төрийн өмчийн 17 их, дээд сургууль үйл ажиллагаа явуулж байгаа ба тэдгээр сургуулиудад ажиллаж буй профессор, багш, судлаачид нийт багш, судлаачдын 64.2 хувийг, нийт ажиллагчдын 65.0 хувийг тус тус эзэлж байна. Дээд боловсролын салбарт нийт 13000 орчим ажиллагчид ажиллаж байгаа ба 55.3 хувь (7042) нь профессор, багш, судлаачид (эрдэм шинжилгээний ажилтан) байна.

Дээд боловсролын салбарт ABET буюу АНУ-ын Инженер, технологийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр бакалаврын 3 хөтөлбөр, ASIIN буюу ХБНГУ-ын Инженер, мэдээллийн технологи, математик, байгалийн шинжлэх ухааны хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр бакалаврын 9 хөтөлбөр, магистрын 1 хөтөлбөр, ACBSP буюу АНУ-ын Бизнесийн сургууль, хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн зөвлөлөөр бакалаврын 74 хөтөлбөр, магистрын 12 нийт 99 хөтөлбөр олон улсад магадлан итгэмжлэгдээд байна⁸².

Хүснэгт 27. Монгол улсын дээд боловсролын салбарын зарим үзүүлэлт, 2016

№	Үзүүлэлт	Сургуулийн ангилал				Бүгд
		Их сургууль	Дээд сургууль	Коллеж	Гадаадын их сургуулийн салбар	
1.	Дээд боловсролын сургалтын байгууллагын тоо, эзлэх хувь	31 (32.6%)	57 (60.0%)	3 (3.2%)	4 (4.2%)	95 (100.0%)

⁸² БМИУЗ www.accomon.mn

Үүнээс:	Төрийн өмчийн сургууль	13	3	1	-	17
	Төрийн бус өмчийн сургууль	18	54	2	-	74
	Гадаадын их сургуулийн салбар	-	-	-	4	4
2. Суралцагчдын тоо, эзлэх хувь		133,187 (84.8%)	23,293 (14.8%)	393 (0.3%)	265 (0.2%)	157,138 (100.0%)
Үүнээс:	Төрийн өмчийн сургуульд суралцагчдын тоо, хувь	89,787	1,798	213	-	91,798 (58.4%)
	Төрийн бус өмчийн сургуульд суралцагчдын тоо, хувь	43,400	21,495	180	-	65,075 (41.4%)
	Гадаадын их сургуулийн салбарт суралцагчдын тоо, хувь	-	-	-	265	265 (0.2%)
3. Үндсэн багшийн тоо		5,606 (81.0%)	1,222 (17.7%)	70 (1.0%)	19 (0.3%)	6,917 (100.0%)
Үүнээс:	Төрийн өмчийн сургууль	4,283	114	47	-	4,444 (64.2%)
	Төрийн бус өмчийн сургууль	1,323	1,108	23	-	2,454 (35.5%)
	Гадаадын их сургуулийн салбар	-	-	-	19	19 (0.3%)
4. Нийт ажиллагчдын тоо		10,216 (80.2%)	2,303 (18.1%)	122 (1.0%)	99 (0.8%)	12,740 (100.0%)
Үүнээс:	Төрийн өмчийн сургууль	7,980	215	86	-	8,281(65.0%)
	Төрийн бус өмчийн сургууль	2,236	2,088	36	-	4,360 (34.2%)
	Гадаадын их сургуулийн салбар	-	-	-	99	99 (0.8%)

Эх сурвалж: Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистик, БСШУСЯ (<http://www.mecss.gov.mn/HigherSta1617>)

Хүснэгт 28. Их сургуулийн нийт ажиллагчдын тоо, 2016

№	Үзүүлэлт	Ажиллагчдын тоо	Үндсэн багш	Эрдэм шинжилгээний ажилтан	
1	Төрийн өмчийн сургууль	Тоо	8,281	4,444	105
		Эзлэх хувь	65.0	64.2	84.0
			4,549 (64.6%)		
2	Төрийн бус өмчийн сургууль	Тоо	4,360	2,454	20
		Эзлэх хувь	34.2	35.5	16.0
3	Гадаадын их сургуулийн салбар	Тоо	99	19	1
		Эзлэх хувь	0.8	0.3	0.8
Нийт дүн		12,740	6,917	125	
Эзлэх хувь			54.3	1.0	


Эх сурвалж: Дээд боловсролын салбарын 2016-2017 оны хичээлийн жилийн статистик, БСШУСЯ (<http://www.mecss.gov.mn/HigherSta1617>)

Сургалтын байгууллагын орлогын бүтэц

Төрийн өмчийн их, дээд сургуулиудын орлогын 70-85 хувийг сургалтын төлбөр, 30-15 хүртэл хувийг бусад эх үүсвэрээс бүрдүүлж байна. Төрийн өмчийн сургалтын байгууллагууд үндсэн үйл ажиллагаанаас нийт орлогын 70-85 хувийг,

төрөөс авах тогтмол зардлын санхүүжилт 5-6 хувийг тус тус бүрдүүлж байгаа нь сургалтын их сургуулийн хэмжээнд байгааг харуулж байна. Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл, инновацийн үйл ажиллагаанаас олох орлого маш бага хувийг эзэлж байгааг өөрчлөх, судалгаанд суурилсан их сургуулийн хөгжлийн бодлого, үзэл баримтлалд тулгуурлан улсын их сургуулиудыг хөгжүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

Зураг 12. Төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын орлогын бүтэц



Төрийн бус өмчийн их, дээд сургуулиудын орлогын 96.0 хувийг үндсэн үйл ажиллагааны орлого буюу сургалтын төлбөр, үлдсэн хувийг төрийн сан болон төслийн санхүүжилт, дотуур байр, түрээсийн орлого бүрдүүлж байна.

Ажиллах хүчний боловсролын түвшин⁸³

2013 оны АХС-д хамрагдсан 16-54 насны иргэдийн суурьшлыг тэдний боловсролоор харьцуулбал боловсролын түвшний эрс ялгаа ажиглагдаж байна. Зургаас харахад, нийслэлд амьдарч буй иргэдийн 34% нь бакалавраас дээш боловсролтой бол хөдөөд энэ хувь ердөө 5% байна. Харин хөдөөгийн иргэдийн 62% бүрэн дундаас доош боловсролтой байхад нийслэлд энэ тоо 10% байна.

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн байдал⁸⁴

Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг цуглуулахад чиглэгдсэн. Судалгааны дүнгээр нийт төгсөгчдийн 60.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байгаагийн 45.6 хувь нь эрэгтэйчүүд, 54.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Сургуулийн төрлөөр нь авч үзвэл ИДС төгсөгчдийн 68.4 хувь нь, МБСБ төгсөгчдийн 49.0 хувь нь тус тус хөдөлмөр эрхэлж байна.

Төгсөгчдийн 10.1 хувь нь төгсөхөөсөө өмнө ажилд орсон байсан. Харин 25.7 хувь нь төгссөнөөсөө хойш 3 хүртэл сард, 12.8 хувь нь 4-6 сарын дотор, 22.1 хувь нь 7-12 сарын дотор, 28.9 хувь нь 13 ба түүнээс дээш сарын дараа ажилд орсон байна. МБСБ төгсөгчдийн 40.9 хувь нь 13 ба түүнээс дээш сарыг ажлын байр

⁸³ БСШУСЯ, АХБ, АЙРИМ “Сургалтын үйл ажиллагааг хөдөлмөрийн зах зээлийн судалгаатай уялдуулах гарын авлага” УБ 2016.

⁸⁴ ХНХЯ, ХНХСИ “Төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлтийн судалгаа-2017”

олоход зарцуулжээ. Энэ хугацааг богиносгох, хөдөлмөрт бэлтгэх, ажилд ороход чиглүүлэх, сургалтад хамруулах, идэвхжүүлэх шаардлагатай байна.

Хүснэгт 29. Хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн ажилд ороход зарцуулсан хугацаа, сургуулийн төрлөөр

Сургуулийн төрөл	Төгсөхөөс өмнө	3-аас доош сар	4-6 сар	7-12 сар	13 сараас дээш
ИДС	9.4	28.5	14.0	24.5	23.5
МБСБ	12.7	19.6	10.0	16.8	40.9
Бүгд	10.4	25.7	12.8	22.1	28.9

2015-2016 оны хичээлийн жилд төгссөн нийт төгсөгчдийн 68.4 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Хөдөлмөр эрхэлж буй эдгээр төгсөгчдийн 69.6 хувь нь мэргэжлээрээ хөдөлмөр эрхэлж байна. Харин хөдөлмөр эрхэлж буй ИДС төгсөгчдийн 9.8 хувь нь өөрийн эзэмшсэн боловсролын түвшнээс доогуур боловсрол, ур чадвар шаардсан ажлын байранд буюу худалдагч, касс, зөөгч, бармен, үйлчлэгч, үсчин, гоо сайханчаар ажиллаж байна. МБСБ төгсөгчдийн 48.9 хувь нь хөдөлмөр эрхэлж байна. Эдгээр хөдөлмөр эрхэлж буй төгсөгчдийн 53.8 хувь нь мэргэжлээрээ ажилладаг байна.

ИДС төгсөгчдийн хувьд барилга архитектурын мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт хамгийн өндөр буюу 83.2 хувь байгаа бол компьютер, анагаах ухаан, физик, хими, биологи, газар зүй, математик статистик, нийгэм, эдийн засаг, тээвэр, багш боловсрол судлал зэрэг мэргэжлийн чиглэлээр төгсөгчдийн хөдөлмөр эрхлэлт 70.9-76.5 хувьтай байна. Харин хамгийн бага буюу 50.0 хувь нь хөдөлмөр эрхэлж буй нь нийгмийн халамж, хангамж, биеийн тамир, спортын мэргэжлийн чиглэлээр төгсөгчид байна.

Үйл ажиллагаа явуулж буй их, дээд сургууль, коллежийн тоо 2004/2005 оны хичээлийн жилд хамгийн олон буюу 183 байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 96 болж, 2 дахин буурсан байна. Нийт сургалтын байгууллагын дийлэнх хувийг төрийн бус өмчийн сургууль эзэлж байгаа бөгөөд 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад төрийн бус өмчийн сургууль 4.7 пунктээр өссөн бол төрийн өмчийн сургууль 3.9 пунктээр буурсан байна. Их, дээд сургууль, коллежийн 76.6 хувь нь 2017/2018 оны хичээлийн жилд магадлан итгэмжлэгдсэн байна.

Их, дээд сургууль, коллежид 2001/2002 оны хичээлийн жилд нийт 90.6 мянган суралцагч байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 155.2 мянга болж, 1.7 дахин өссөн ч 10 жилийн өмнөх үетэй харьцуулахад 2.2 хувиар буурсан байна. Нийт суралцагчдыг боловсролын зэргээр авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн

жилд нийт суралцагчдын 130.9 мянга (83.0%) нь бакалавр, 22.5 мянга (14.3%) нь магистр, 4.2 мянга (2.7%) нь докторын зэрэг эзэмшихээр суралцаж байна.

Их, дээд сургууль, коллежид суралцагчдын 146.0 мянга (92.6%) нь Улаанбаатар хотод, 11.6 мянга (7.4%) нь хөдөө, орон нутагт суралцаж байна. Монгол Улсын хүн амын хэтийн шинэчилсэн тооцоог ашиглаж 18-24 насны хүн амд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцаж буй тухайн насны суралцагчдын өсөлтийг түүхэн дундаж утгад үндэслэн тогтмол гэж таамаглавал 2020 онд бакалаврын зэргийн боловсрол олгох ангид суралцах суралцагчдын тоо энэ хичээлийн жилээс 4.0 хувиар буурах бол 2045 онд 64.0 хувиар өсөх магадлалтай байна⁸⁵.

Сүүлийн 17 жилийн турш худалдаа, бизнесийн чиглэлээр суралцаж буй оюутнуудын тоо бусад мэргэжлийн чиглэлүүдээс өндөр хэвээр байна. Тодруулбал, нийт суралцагчдын 16.5-24.3 хувь нь энэ чиглэлээр суралцаж байна. Харин нийтийн мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн оюутан суралцах хандлагатай байна.

Өндөр өсөлт, бууралттай чиглэлүүдийг авч үзвэл, сүүлийн 17 жилийн хугацаанд архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр суралцагчдын тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад өндөр өсөлттэй байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 294 оюутан суралцаж байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 6.1 мянга болж, 20.7 дахин нэмэгджээ. Харин нийгмийн шинжлэлийн чиглэлээр суралцагчдын тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад нэлээд буурсан байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 7.8 мянган оюутан суралцаж байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 5.5 мянга болж, 30.0 хувиар буурчээ.

Монгол Улсад суралцаж буй гадаад оюутнуудын тоо сүүлийн жилүүдэд өсөх хандлагатай байгаагийн зэрэгцээ олон улсад өрсөлдөхүйц боловсон хүчин бэлдэхийн тулд их, дээд сургууль, коллежийн сургалтын хөтөлбөрийн тодорхой хэсгийг англи хэлээр заах шаардлага бий болж байна.

Дээд боловсролын сургалтын байгууллагын үндсэн багшийн тоо 2001/2002 оны хичээлийн жилтэй харьцуулахад 20.0 орчим хувиар өссөн хэдий ч нэг багшид ногдох суралцагчдын тоо буурахгүй өссөөр байгаа нь нийт суралцагчдын тооны өсөлттэй уялдаатай юм.

⁸⁵ ҮСГ мэдээ

Нийт төгсөгчдийг боловсролын зэргээр авч үзвэл, 2017/2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 25.2 мянга (86.3%) нь бакалавр, 3.9 мянга (13.3%) нь магистр, 131 (0.4%) нь докторын зэргээр суралцаж төгссөн байна.

Сүүлийн 17 жилийн турш худалдаа, бизнесийн чиглэлээр суралцаж төгссөн оюутны тоо бусад мэргэжлийн чиглэлүүдээс өндөр хэвээр байна. Тодруулбал, нийт суралцагчдын 21.4-28.7 хувь нь энэ чиглэлээр төгссөн байна. Харин нийтийн мэдээлэл, сэтгүүл зүйн чиглэлээр бусад мэргэжлийн чиглэлүүдтэй харьцуулахад харьцангуй цөөн оюутан төгссөн байна.

Өндөр өсөлт, бууралттай чиглэлүүдийг авч үзвэл, сүүлийн 17 жилийн хугацаанд архитектур, хот төлөвлөлтийн чиглэлээр төгссөн оюутны тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад өндөр өсөлттэй байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 38 оюутан төгсөж байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 1.7 мянга болж, 43.6 дахин нэмэгджээ. Харин нийгмийн шинжлэлийн чиглэлээр төгссөн оюутны тоо бусад чиглэлүүдтэй харьцуулахад нэлээд өндөр дүнгээр буурсан байна. Тодруулбал, 2001/2002 оны хичээлийн жилд энэ чиглэлээр 1.7 мянган оюутан төгсөж байсан бол 2017/2018 оны хичээлийн жилд 875 болж, 48.4 хувиар буурчээ.

Мэргэжлийн чиглэлүүд дэх суралцагч болон төгсөгчдийн тооны өндөр дүнгээрх өөрчлөлт нь мэргэжлийн чиглэл хооронд шилжин суралцаж буй төлөв байдалтай холбоотой. О 2017/2018 оны хичээлийн жилд нийт төгсөгчдийн 10.0 мянга (34.4%) нь ажлын байртай болсон нь хөдөлмөрийн зах зээлийн тэнцвэрийг хангах, энэ чиглэлийн төрийн бодлого, хөтөлбөр шаардлагатай байгааг харуулж байна.

Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгааны үр дүнгээс харвал, сүүлийн 6 жилийн байдлаар өрхүүд гишүүдийнхээ боловсролд нийт мөнгөн орлогынхоо 2.3-3.8 хувийг зарцуулсан нь тухайн өрхийн хүнсний бус бараа, үйлчилгээний зарлагын 3.3-5.0 хувийг тус тус эзэлж байна. Боловсролын чанараар тэргүүлэх улс, орнуудтай харьцуулахад Монгол Улсын нэг багшид ногдох суралцагчдын тоо өндөр, харин 25-64 насны хүн амд дээд боловсрол эзэмшихээр суралцаж буй энэ насны суралцагчдын эзлэх хувь бага байна. Олон улс дахь мэргэжлийн тэргүүлэх чиглэл нь санхүү, бизнесийн удирлага байгаа нь Монгол Улсад мөн адил тэргүүлж байна.

Нийт суралцагчдын тооны өөрчлөлтөд сургалтын дундаж төлбөр сөрөг харин дотоодын нийт бүтээгдэхүүн, их, дээд сургууль, коллежийн тоо болон нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ эерэг нөлөөтэй байна. Тодруулбал:

Их, дээд сургуулийн төлбөрийн дундаж хэмжээ 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.35%-иар буурах хандлагатай буюу дээрх 2 хүчин зүйл хоорондоо сөрөг хамааралтай байна. Харин ДНБ (2010 оны зэрэгцүүлэх үнээр) 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.89%-иар, их, дээд сургууль, коллежийн тоо 1%-иар өсөхөд тайлант оны нийт суралцагчдын тоо дунджаар 0.54%-иар өсөх хандлагатай байна. Нэг өрхийн сарын дундаж мөнгөн орлогын хэмжээ 1%-иар нэмэгдэхэд тухайн хичээлийн жилд дээд боловсрол эзэмших суралцагчдын тоо дунджаар 0.4%-иар нэмэгдэх хандлагатай байна.

Дээд боловсролын шинэчлэлийн зураглал /Roadmap/ 2010 – 2021

Дээд боловсролын өнөөгийн байдал

Дээд боловсролын хамран сургалтын хэмжээ 54.4%-д хүрч хөгжилтэй орнуудын түвшнээс давж гарсан ч салбарын гадаад үр ашиг хангалтгүй гэсэн нийгмийн үнэлэмж түгээмэл байна.

2004-2009 оны дунджаар дээд боловсролын салбарын төгсөгчдийн ажил эрхлэлт дөнгөж 35%-тай байна.

Улс орны нийгэм, эдийн засгийн байдал, эцэг эхчүүдийн хандлага зэргээс шалтгаалан 1990-ээд оноос эхлэн эрэгтэй хүүхдүүдийг сургууль завсардуулах хандлага их байсаар ирсэн. Үүний нөлөө их, дээд сургуулиудад суралцаж буй оюутнуудын хүйсийн харьцаанд хүчтэй нөлөөлсөн байдаг. 2000 онд их, дээд сургуулиудад суралцаж буй эмэгтэй оюутны тоог эрэгтэй оюутны тоонд харьцуулсан харьцаа 1.72 байсан бол энэ харьцаа аажим боловч тогтмол буурсаар 2009-2010 оны байдлаар 1.54 болжээ. Цаашид энэ харьцаа улам буурах хандлагатай байна.

Хүртээмж:

1. Дээд боловсролын хамран сургалт нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээ, үндэсний хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдахгүй байна.
2. Байгалийн шинжлэх ухаан, хөдөө аж ахуй, инженер техник, багшийн чиглэлийн мэргэжилтэн дутагдалтай байна.
3. Дээд боловсролын болон мэргэжлийн сургалтын байгууллагад суралцагчдын тоон харьцаа зохистой түвшинд биш байна.
4. Магистр, докторын сургалтад хамрагдаж буй оюутны эзлэх хувь доогуур байна.
5. Хөдөө орон нутагт дээд боловсрол эзэмших бололцоо тааруу байна. Улаанбатаар хотод суралцаж байгаа оюутнуудын 52% нь хөдөө орон нутгаас суралцагчид байна.

Чанар, нийц:

6. Жижиг сургуулиудын тоо хэт олширч, 300-с цөөн оюутантай сургуулийн тоо нийт сургуулийн 30%-д хүрээд байна. Эдгээр сургуулиудад нийт оюутнуудын 11% л суралцаж байна
7. Хичээлийн байр, сургуулийн дэд бүтэц, судалгааны лаборатори, сургалтын хэрэглэгдэхүүн, мэдээлэл харилцааны технологи, номын санд хөрөнгө оруулалт дутагдалтай байна.
8. Дээд сургуулиудын сургалт, судалгааны ажлын стандартыг шинэчлэх шаардлагатай, чанарын баталгаажуулалтын систем үр дүнтэй ажиллаж чадахгүй байна.
9. Багш нарын хангамж, тэдний мэргэжлийн чадвар хангалтгүй байна.
10. Төгсөгчдийн мэргэжлийн түвшин, ур чадвар хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахгүй байна.
11. Их, дээд сургуулиудын эрдэм шинжилгээний ажлын чадавх сул, олон улсын хэмжээнд өрсөлдөх чадваргүй байна. Өнөөгийн байдлаар эрдэм шинжилгээний ажилд дээд боловсролын салбарын төсвийн дөнгөж 1.5% зарцуулагдаж байгаа ба энэ үзүүлэлт олон улсын түвшинд 7-10% байна. Магистр болон докторын түвшний сургалтын чанар олон улсын түвшинд хүрэхгүй байна.

Менежмент:

12. Төрийн сургалтын сангийн үйл ажиллагааг боловсронгуй болгон, зээлийн эргэн төлөлтийг сайжруулах шаардлагатай.
13. Дээд боловсролын салбарын эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна.

- 14.Авьяс, чадвартай оюутныг дэмжсэн засгийн газрын хэмжээний оюутны тэтгэлгийн тогтолцоо бүрдээгүй.
 15.Дээд боловсролын салбарын санхүүжилтын тогтолцоог шинэчлэх шаардлагатай.
 16.Дээд боловсролын болон үйлдвэрлэл, бизнесийн байгууллагуудын хоорондох түншлэл хангалтгүй байна.
 17.Дээд сургуулиудын багш нарын цалин бага, хөдөлмөрийн зах зээл дээрх үнэлэмж доогуур байна.
 18.Дээд боловсролын сургалтын байгууллагуудын удирдлагын арга барил, менежментийн ур чадвар дутагдалтай байна.

Шинэчлэлийн зорилго, чиглэлүүд

Элсэлтийн ба нийцийн шинэчлэл	Сургалтын агуулга, стандартын шинэчлэл	Их, дээд сургуулийн засаглал, удирдлагын шинэчлэл	Дээд боловсролын санхүүжилтийн шинэчлэл	Дээд боловсролын эрх зүйн орчны шинэчлэл	Сургалтын орчны шинэчлэл	Хүний нөөц, багшийн хөгжлийн шинэчлэл
<p>1.Элсэлтийн шударга тогтолцоог нэвтрүүлнэ. 2.Дээд боловсролын хамран сургалтыг (Gross Enrolment Ratio) дэлхийн стандартын түвшинд ойртуулна. 3.Элсэлтийг мэргэжлийн бүх салбаруудаар жигдрүүлэх</p>	<p>1.Сургалтын агуулгын стандартыг (curriculum standards) олон улсын жишгээр нарийвчлан боловсруулж мөрдүүлнэ. 2.Зайн, цахим сургалтын шинэ хэлбэрүүдийг өргөжүүлнэ. 3.Мэргэжлийн сургалтанд дадлагын хэсгийн ач холбогдлыг нэмэгдүүлэх</p>	<p>1. Их, дээд сургуулиудын биеэ даасан байдлыг бэхжүүлнэ. 2. Их сургуулийн стратегийн түншлэлийг өргөжүүлнэ. 3. Хариуцлагын тогтолцоог тогтоож бэхжүүлнэ. 4. Их сургуулиудын хоорондох</p>	<p>1. Их, дээд сургуулийн орлогын эх үүсвэрүүдийг өргөтгөнө. 2. Төрөөс их сургуулиудад үзүүлэх санхүүгийн дэмжлэгийг тэдний үйл ажиллагааны үр дүнтэй холбосон механизмыг бий болгож хэрэгжүүлнэ. 3. Хувийн хэвшлийн</p>	<p>Их сургуулийн статусийн тухай хуулийг боловсруулан гаргана.</p>	<p>1. Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлнэ. 2. Их, дээд сургуулийн номын сан, мэдээллийн сүлжээг шинэчлэн сайжруулна.</p>	<p>1.Их, дээд сургуулийн багш, судлаачдын чадавхийг дээшлүүлнэ.</p>

	4.Магадлан итгэмжлэлийн механизмыг өргөнөөр нэвтрүүлнэ.	өрсөлдөөнийг идэвхжүүлнэ. 5. Их сургуулийн удирдах зөвлөлийн бүтцийг боловсронгуй болгоно.	байгуулагуудаас дээд боловсролд хандив оруулах урамшлын системийг бүрэлдүүлнэ. 4. Дээд боловсролын санхүүжилтийн шинэ хэлбэрүүдийг бий болгоно. 5. Сургалтын төрийн сангийн дэмжлэгийг сургалтын амжилтыг дэмжихэд чиглүүлнэ.			
--	---	---	---	--	--	--

Дээд боловсролын өнөөгийн байдалд судалгаа, үнэлгээ хийнэ / 2010/

1.	2.	3.	4.	5.	6.	7.
1.Хөдөлмөрийн зах зээлийн эрэлтийн судалгаа хийж, үнэлэлт өгнө.	1. Их, дээд сургууль, коллежийн бакалаврын сургалтын хөтөлбөр, стандартад үнэлгээ хийнэ. 2. Их, дээд сургуулийн	1.Дээд боловсролын засаглалын эрх зүйн орчинд үнэлгээ хийнэ.	1.Их, дээд сургуулийн эдийн засаг санхүүжилтийн байдалд үнэлгээ хийнэ. 2.СТС-ийн тогтолцоонд үнэлгээ хийнэ.	1.Дээд боловсролын эрх зүйн орчинд үнэлгээ хийнэ.	1.Дээд боловсролын сургалтын орчинд үнэлгээ хийнэ. 2.Дээд боловсролын сургалтын байгууллагын мэдээллийн	1.Их, дээд сургууль, коллежийн хүний нөөцийн чадавхын үнэлгээ хийнэ. 2.Их, дээд сургууль, коллежийн төлөвлөлт, удирдлагын менежментийн чадавхын үнэлгээ хийнэ.

	<p>магистр, докторын сургалтын хөтөлбөр, стандартад үнэлгээ хийнэ.</p> <p>3. Их, дээд сургуулийн судалгаа шинжилгээний чадавхын үнэлгээ хийнэ.</p> <p>4. Их, дээд сургууль, коллежийн багц цагийн тогтолцооны хэрэгжилтийн байдалд үнэлгээ шинжилгээ хийнэ.</p> <p>5. Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын байдалд үнэлгээ шинжилгээ хийнэ.</p>				<p>технологийн хөгжлийн явцад үнэлгээ хийнэ.</p> <p>3.Дээд боловсролын сургалтын байгууллагын номын сангийн хөгжлийн байдалд үнэлгээ хийнэ.</p>	
Дээд боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлнэ /2010-2021/						
1.	2.	3.	4.	5.	6.	7.
1.Их, дээд сургуулиудын элсэлтийн шалгалтын журмыг өөрчилнө.	1. Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг өргөжүүлнэ. /2010-2021/	1.Төрийн өмчийн сургуулиудад бүтцийн өөрчлөлт хийнэ. /2010-2011/	1.Сургалтын төрийн сангийн дэмжлэгийг сурлагын амжилтыг дэмжихэд зориулна. /2010/	1.Боловсролын тухай, Дээд боловсролын тухай	1.Их сургуулиудыг хотхоноор хөгжүүлэх чиглэлийг батлуулж, ашиглалтын өмнөх	1. Их, дээд сургуулийн багшийг чадавхжуулах хөтөлбөр боловсруулна.Үүнд: а. Дотоодын ёургалт

<p>төвлөрсөн байдлаар авдаг болно. Үүнд, шалгалтын нэгдсэн асуултуудыг боловсруулж, урьдчилж хэвлэнэ. Тухайн жилүүдэд шалгалтын асуултуудыг компьютерээр сонгох механизм боловсруулж нэвтрүүлнэ. /2011/</p> <p>2.Өндөр хөгжилтэй оронд суралцагчдыг сонгон шалгаруулах шинэчилсэн журмыг боловсруулна. /2010/</p> <p>3.Магистрантур, докторантурт иргэдийн суралцах</p>	<p>2.Сургалтын хөтөлбөрийг олон улсын жишигт нийцүүлж, баталгаажуулах арга хэмжээ авна. /2010-2021/</p> <p>3.Дээд боловсролын чанарыг дээшлүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлж, дэлхийн шилдэг сургуулийн багш нараас урьж ажиллуулна. /2010-2021/</p> <p>4.Гадаадын чанартай сургуультай хамтарсан “ХОС - ХӨТӨЛБӨР”-үүдийг төрөөс дэмжлэг үзүүлнэ. /2011-2021/</p> <p>5.Их, дээд сургууль, коллежийг аттестатчилах журмыг шинэчилж боловсруулна. /2010/</p>	<p>2.Дээд боловсролын сургалтын байгууллага, хөтөлбөрийн рейтингийг тогтоох тогтолцоог бүрдүүлнэ. /2011/</p> <p>3.Дээд боловсролын сургалтын байгууллагын Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрмийг боловсруулна. /2011-2012/</p> <p>4.Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрийн аттестатчилах журмыг боловсруулна. /2010/</p> <p>6. Их сургуулиудыг</p>	<p>2.Сургалтын төрийн сангийн гадаад сургалтын санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгоно. /2010/</p> <p>3.Чанарын шаардлага хангасан цөөн сургуулийг тусгайлан санхүүжүүлж, хөрөнгө оруулалт хийнэ.Төрийн дэмжлэгийг төгсөгчдийн ажлын байртай болсонтой холбоно. /2011-2012/</p> <p>4.Их, дээд сургуульд бизнесийн орчин бүрдүүлнэ. /2010-2021/</p> <p>5.Төрийн өмчийн их, дээд сургуульд бизнес инкубаторуудыг байгуулж хөгжүүлнэ. /2010-2015/</p>	<p>хуулинд нэмэлт, өөрчлөлтийг оруулна. холбогдох өөрчлөлтийг оруулна. /2010-2011/</p> <p>2.Сургалтын төрийн сангийн холбогдох журмуудыг шинэчилнэ. /2010/</p> <p>3.Хувийн хэвшлийн их, дээд сургуулиудыг нийлэх, нэгдэх хууль, эрх зүйн орчинг бүрдүүлнэ. /2010-2011/</p> <p>4.Монгол Улсын дээд боловсролын гадаад харилцааг хөгжүүлэх чиглэлийг боловсруулна. /2011/</p>	<p>захиргааг байгуулна. /2010/</p> <p>2.Их сургуулиудын хотхоны бүтээн байгуулалтын ажлыг эхлүүлнэ. /2010-2021/</p> <p>3.Дээд боловсролын бүх сургуулийг мэдээллийн нэгдсэн сүлжээгээр холбон ашиглалт, шугамын түрээс, үйлчилгээний зардлыг төрөөс хариуцах арга хэмжээ үе шаттай хэрэгжүүлнэ. /2011-2012/</p> <p>3.Оюутны байр-20000 төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. /2010-2015/</p> <p>4.Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн хичээлийн байр, дотуур байрыг ээлж дараатай засварлана.</p>	<p>b. Гадаадын мастер, докторын сургалт</p> <p>c. Зайн сургалт \гадаадын их дээд сургуулийн\ /2010-2015/</p> <p>2.Багш нарыг жил бүр үнэлэх системийг нэвтрүүлж, үр дүнд тулгуурласанцалингийн тогтолцоог бий болгоно. /2011-2015/</p> <p>3.Их, дээд сургууль, зколлежид багш нарыг сонгон шалгаруулж өрсөлдөөнөөр авдаг болно. /2011-2021/</p> <p>4.Багш нарыгн сургалтын арга барилыг сайжруулахад дэмжлэг үзүүлдэг төвийг их, дээд сургуулийн консорциумын дэргэд бий болгож төрөөс дэмжинэ. /2011-2021/.</p> <p>5.Нэг багшид ногдох оюутны тоог бууруулах арга хэмжээ авна.</p>
---	---	--	--	---	---	---

<p>боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авна. /2011/ 4.Зайн сургалт, Е-сургалтаар иргэдийн боловсрол эзэмших боломжийг өргөжүүлнэ. /2010-2021/ 5.Гадаадын иргэдийг тэр дундаа монгол туургатан оюутнуудыг Монгол улсын их дээд сургуулиудад суралцахыг дэмжинэ. /2010-2021/</p>	<p>6.Их, дээд, сургууль, коллежийг аттестатчилна. /2010-2021/ 7.Магистр, докторын сургалт/инновацийн хөтөлбөр/ төсөл боловсруулж хэрэгжүүлнэ. /2011-2015/ 8.Төрийн бус өмчийн коллеж статусаа өөрчилж мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага болох санаачлагыг төрөөс дэмжинэ. /2011-2015/ 9.Бакалаврын сургалтын агуулгыг ерөнхий боловсролын 12 жилийн сургалтын агуулгатай уялдуулж сургалтын залгамж холбоог бүрдүүлнэ. /2011-2015/ 10.Сургууль хооронд багц цаг /кредит / шилжүүлэх журам боловсруулж мөрдүүлнэ.</p>	<p>сургалт, судалгааны чиглэлээр ангилж хөгжүүлнэ. /2010-2021/</p>	<p>6.Хувийн хэвшлээс дээд боловсролыг санхүүжүүлэх сонирхлыг дэмжих механизмыг бүрдүүлнэ. /2011/ 7.Уул , уурхайн стратегийн ордуудаас дээд боловсролыг дэмжих санг бүрдүүлж, сангийн хадгаламжийн хүүгийн орлогоос дээд боловсролыг санхүүжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлнэ. /2011/ 8.Нээлттэй, ил тод, өрсөлдөөнд суурилсан судалгааны тэтгэлгийн тогтолцоог бий болгох /2011/ 9.Дээд боловсролын байгууллагын сургалтын</p>	<p>5.Их сургуулийн тухай хуулийг боловсруулна. /2011/ 6.. Их, дээд сургуулийн сургалт, эрдэм шинжилгээний ажилд баримтлах ёс зүйн дүрмийг боловсруулж мөрдүүлэх /2011/</p>	<p>/2011-2021/ 6. Төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийг лабораторийн болон сургалтын, дотуур байрны тоног төхөөрөмжөөр хангана. /2011-2021/</p>	<p>/2011-2021/</p>
--	---	--	--	--	--	--------------------

	<p>/2010-2011/ 11.Магистр, докторын сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийг өргөжүүлнэ. /2011-2021/ 12.Магистр, доктор оюутнуудад зориулсан тэтгэлгийн тогтолцоо бий болгоно. /2011/ 13.Дээд боловсролын сургалтын байгууллагуудын эрдэм шинжилгээний ажлын стандартыг боловсруулж, хэрэгжүүлнэ. /2011-2012/</p>		<p>хөтөлбөрийг оновчтой болгох, курс, мэргэжлийн давхардалыг арилгаж, эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлж, урсгал зардлыг багасгах /2011-2012/</p>			
Хүрэх үр дүн 2021						
<ol style="list-style-type: none"> 1. Монголын дээд боловсролын өрсөлдөх чадвар, чанар дээшилсэн байна. 2. Дээд боловсролын хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлж, сургалтын орчинг сайжруулж, чанарын баталгаажуулалтын тогтолцоог бий болгосноор иргэд чанартай дээд боловсрол эзэмших боломж бүрдэнэ. 3. Мэргэжилтэй боловсон хүчний чадавх бэхжиж үндэсний эдийн засгийн өсөлтөд өгөөжөө өгнө. 4. Дээд боловсрол хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдана. 5. Дээд боловсролын байгууллагуудын сургалт, судалгааны ажилд чанарын ахиц дэвшил гарна. 						

Бодлогын зорилго, хүрэх түвшин

Монгол Улсын дээд боловсролын чанарын шинэчлэл нь үндэсний болон байгууллагын түвшинд удирдлага, сургалт, судалгааны ажлын агуулга, зохион байгуулалт, оюутан багшид үзүүлэх үйлчилгээ, үйл ажиллагааны хяналт үнэлгээ, санхүү, хөрөнгө оруулалтын бодлогыг хамарсан цогц үйл ажиллагаа болно. Үүний дүнд монголын дээд боловсролыг олон улсын нийтлэг жишигт нийцсэн, бие даасан хараат бус бөгөөд хариуцлагатай судалгаа сургалтын нэгдсэн тогтолцоо болгон хөгжүүлж, нийгэм, эдийн засгийн хөгжил, иргэдийн сонирхол хэрэгцээнд үйлчлэх чадамжийг сайжруулна. Тухайлбал:

- Дээд боловсролын хөгжлийн баталгааг хангах эрх зүй, санхүү, хөрөнгө оруулалтын зохистой орчин бүрдүүлнэ.
- Дээд боловсролын байгууллагын удирдлага, менежментийг үр нөлөөтэй, ил тод, нээлттэй, шударга, хараат бус болгоно.
- Суралцагчид нь бие даан хөгжих, ажил үүрэг хариуцан мэргэжлийн түвшинд гүйцэтгэх, багаар хамтран ажиллах бэлтгэлтэй болгон төлөвшүүлэхэд чиглэсэн, тэдний эрх ашиг, сонирхлыг хүндэтгэх хандлагыг байгууллагын бүх түвшинд төлөвшүүлнэ.
- Их сургуулийн судалгааны чадавхыг сайжруулж, эдийн засаг, нийгмийн хөгжилд хувь нэмэр оруулах шинэ мэдлэг, технологийн шийдлийг тасралтгүй боловсруулах эдийн засаг, хүний болон хөрөнгө нөөцийн баталгааг хангана.
- Профессор багш нар үр бүтээлтэй, мэргэжлийн ёсзүйтэй ажиллах нөхцөлийг бүрдүүлсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ.
- Дээд боловсролын байгууллагын үйл ажиллагааны чанарыг тасралтгүй сайжруулах, баталгаажуулах үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлнэ.

Дээд боловсролын өнөөгийн байдал

Одоогийн байдлаар 101 их, дээд сургууль, коллежид нийт 172,798 оюутан (төрийн өмчийн 15 сургуульд 104,101 оюутан, төрийн бус өмчийн 86 сургуульд 68,697 оюутан) суралцаж байгаа нь 18-23 насны хүн амын 60 гаруй хувьтай тэнцүү байна. Ерөнхий боловсролын сургуулийг төгсгөгчдийн 90 орчим хувь нь дээд боловсролын хөтөлбөрт элсч байна.

Манай дээд боловсролын салбарт 2007-2011 онд Дэлхийн банк, Азийн хөгжлийн банктэй хамтран ажилласан олон улсын болон үндэсний зөвлөх багийн эрдэмтэн судлаачдын тайланд хөдөлмөрийн зах зээлийн эргэх холбоо, дээд боловсролтой иргэдийн ажил эрхлэлт, их сургууль-үйлдвэрлэлийн хамтын ажиллагаа

хангалтгүй, санхүүгийн болон хүний нөөцийн чадамждорой, оролцогч талууд мэдээлэл хуваалцах, хамтран ажиллах соёл хөгжөөгүй гэж дүгнэжээ. Энэ нь дээд боловсролын системийг бүхэлд нь шинэчлэх шаардлагатайг нотолж байна.

Өнөөдөр дэлхийн улс орнууд хөгжлийн аль түвшинд хүрснээс үл хамааран боловсролын, түүний дотор дээд боловсролын салбарын хөгжлийн стратегийг шинэчлэн хэрэгжүүлж байна. Ийнхүү шинэчлэл хийж буй бусад орны практикаас үзэхэд глобальчлагдсан ертөнц дэх хөгжлийн стратегид баримжаалж, үр дүнг урамшуулсан эрх зүй, санхүү, хөрөнгө оруулалтын арга механизмыг цогцоор хамарсан (holistic) хандлагатай байна. Энэ бүхэнд үндэслэн дээд боловсролд чанарын шинэчлэл хийх бодлогын чиглэлийг дараах байдлаар тодорхойлж байна. Үүнд:

Шинэчлэл хийх үндэслэл, чиглэлүүд

1/ Дээд боловсролын хуулийн өнөөгийн орчин хөгжлийг боогдуулж байна.

- Дээд боловсролын удирдлагад төрийн оролцоо, зохицуулалт зохистой бус, хуулийн зарим заалт эрдмийн байгууллагын үндсэн зарчимтай зөрчилдсөн, үүрэг хариуцлагын шүтэлцээ алдагдсан.
- Хөгжлийн бодлого тодорхойлоход холбогдох талуудын оролцоог тэгш хангах, үүний үндсэн дээр хэрэгжүүлэх шатанд хамтын ажиллагааг идэвхжүүлэх механизм төлөвшөөгүй.
- Иймээс хөгжлийг дэмжих чиглэлээр хуулийн өөрчлөлт, зохицуулалтыг шинэчлэн баталгаажуулж хэрэгжүүлнэ.
- Боловсролын тухай болон бусад холбогдох хуульд удирдлагын төвлөрлийг задалж, шат шатанд ажлын үр дүнг хариуцах хариуцлагыг тодотгосон нэмэлт өөрчлөлтийг дараах зорилгоор оруулна:
- дээд боловсролын байгууллагын бие даасан, хараат бус байдал, академик эрх чөлөөг бэхжүүлэн, үйл ажиллагааныхаа үр дүнг хариуцах хариуцлагыг сайжруулах
- чанарын төлөөх эрүүл өрсөлдөөнийг дэмжих
- ашгийн төлөө бус боловсролын байгууллагад өмчийн хэлбэр харгалзалгүйгээр хөрөнгө оруулалт хийх, төсвөөс санхүүжүүлэх баталгааг хангах
- эрдмийн чөлөөт эрэл хайгуул, шүүмжит сэтгэлгээ, инноваци, бүтээлч хандлагыг хөхиүлэн дэмжих

- судалгааны их сургуулийн эрх зүйн үндсийг бүрдүүлэх
- дээд боловсролын хөгжлийг тодорхойлох хараат бус үндэсний зөвлөл/хорооны эрх зүйн байдлыг баталгаажуулах

2/ Сургуулийн засаглал, менежментийн тогтолцоо нь төр, үүсгэн байгуулагч, хөрөнгө оруулагчдаас хараат байна.

- Дээд боловсролын байгууллага нь үүсгэн байгуулагчаас хамааралтай,
- Удирдах зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл давамгайлж, түүний хүсэл зоригт үйлчлэх хэрэгсэл болсон
- захирлыг үүсгэн байгуулагч шууд томилж, сургуулийн үйл ажиллагаатай холбогдсон үндсэн шийдвэрийг сургуулийн гадна талын этгээд гаргаж байхаар зохицуулсан нь эцсийн үр дүнг хариуцах эзнийг тодорхойгүй болгож байна.

Үндсэн үйл ажиллагааны үр дүнг бүрэн хариуцах, сургуулийн хөгжлийг дэмжихэд үйлчилдэг засаглал, менежментийн үр нөлөөтэй тогтолцоо бүрдүүлнэ.

- Улс төрийн шийдвэр гаргагчид, хөрөнгө оруулагчдаас хамааралтай байдлыг өөрчилж, Удирдах зөвлөлд эрх ашгийн тэнцвэрийг илэрхийлэх, сургуулийн бие даасан байдлыг хангах менежментийг төлөвшүүлнэ.
- Сургуулийн хөгжлийн бодлогыг тодорхойлох, түүний хэрэгжилтэд хувь нэмэр оруулах чадвартай, хүсэл эрмэлзэлтэй хэрэглэгчдийн төлөөлөл Удирдах зөвлөлд түлхүү ажиллах нөхцөлийг хангана.
- Сургуулийн захирлыг сонгох, томилоход Удирдах зөвлөл, эрдмийн зөвлөл, хамт олон, оюутны саналыг тусган чөлөөт сонгон шалгаруулалт хийх зарчмыг хэвшүүлнэ.
- Сургалтын байгууллагын Эрдмийн зөвлөлийн чиг үүргийг олон улсын тэргүүлэх сургуулийн өөрийн удирдлагын дүйцэх байгууллагын чиг үүрэгтэй нийцүүлж, байгууллагын удирдлагад эрдмийн хамт олны оролцоог хангана.

3/ Дээд боловсролын салбарын хөгжлийн судалгаа сул байна.

- Монголын дээд боловсролын салбарын судалгаа нь олон улсын байгууллагын төслийн санхүүжилтээс хамааралтай, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын арга зүй, мэдээллийн сан сул дорой, хөгжлийн бодлогын үндэслэл болгох үр дүн хомс байна.
- Дээд боловсрол судлалыг хөгжүүлэн, төлөвлөлт, хөрөнгө оруулалтыг судалгаанд үндэслэн хэрэгжүүлж байх нөхцөл бүрдүүлнэ.

- Боловсролын хүрээлэнд дээд боловсролын судалгаа хариуцсан нэгж бий болгохын хамт бусад байгууллагад болон бие даан судалгаа хийх, харилцан мэдээлэл солилцох ажлын төрөл хэлбэр, хүрээг өргөтгөнө.
- Дээд боловсролын хөгжлийн асуудлаар хийж буй судалгааны ажлын явц, үр дүнг хэлэлцэх, бодлогын шийдвэрийн үндэслэл болгох бүтэц тогтолцоо байгуулж ажиллуулна.

4/ ДББ-ын үйл ажиллагааг бодитой үнэлэх оновчтой шалгуур тогтоогүй, удирдлага нь санхүү, хөрөнгө нөөцөө үр ашигтай удирдах стратегийн алсын хараа, чадавх болон урамшууллын механизм бүрдээгүй.

- Академик ёсзүй, үнэт зүйлсэд суурилсан хэм хэмжээг сургууль бие даан нэвтрүүлж хэвшүүлэх, хариуцлагын механизмд захирагддаг болгоно.
- Гүйцэтгэлийн үнэлгээний дүн, төгсөгчдийн мэргэжлийн бэлтгэл, ахиц дэвшлийгтооцож үр дүнд суурилсан, 3 жилийн циклтэй санхүүжилт олгох хөтөлбөр хэрэгжүүлнэ.
- Сургууль нөөц боломжоо зохистой хуваарилан зарцуулж, эрс хурдтай өөрчлөгдөж буй глобал зах зээлийн эрэлтэд шуурхай хариу үзүүлдэг чадвартай болгоно.
- Үйл ажиллагааны үнэлгээ, санхүүгийн бүртгэл мэдээллийн шуурхай, оновчтой байдлыг хангахад мэдээллийн технологийг үр дүнтэй ашиглана.
- Дээд боловсролын байгууллагад нягтлан бодох бүртгэл, санхүүгийн хяналтын дэвшилтэт технологийг нэвтрүүлж ил, тод нээлттэй байдлыг бий болгоно.
- Инновацийн судалгаа, технологи боловсруулах чадварыг сайжруулахад чиглүүлэн оюуны өмчийн хамгааллыг зохистой болгож, оюуны бүтээлийг эдийн засгийн эргэлтэд оруулна.

5/ Боловсролын чанарыг үнэлэх, баталгаажуулах тогтолцоо үр нөлөө муутай байна.

- БМИҮЗ-ийн одоогийн үйл ажиллагаанд ашиг сонирхлын зөрчилтэй талуудын оролцоо, нөлөө их байна.
- Магадлан итгэмжлэх байгууллагын статусыг тодорхой болгож, хөндлөнгийн үнэлгээ хийх чадамжтай төрийн бус байгууллагын хэлбэрээр бие даан ажиллах эрх зүйн орчинг бүрдүүлнэ.
- Олон улсын хамгийн сүүлийн үеийн стандартыг нэвтрүүлж, үндэсний болон олон улсын түвшний шинжээч бэлтгэх сургалтын модуль бий болгон, тэднийг гадаадад мэргэжил дээшлүүлнэ

- Дээд боловсролын байгууллагын үндэсний зэрэглэл тогтоох үнэлгээ хийх ажлыг эхлүүлнэ.

6/ Олон улсын түвшинд хүрсэн боловсролын чанарын баталгааг бий болгох, хөгжүүлэхэд тухайлан чиглэсэн нэгдсэн бодлого, дэмжлэгийн механизм тогтоогүй.

- ДББ-ыг сургалтын төвлөрсөн хөтөлбөрт суурилан хөгжих тогтолцоог дэмжих замаар тэргүүлэн хөгжүүлэх стратегийн ач холбогдолтой 10 хөтөлбөрт олон улсын магадлан итгэмжлэл авахад дэмжлэг үзүүлнэ.
- Олон улсын магадлан итгэмжлэлийн шаардлагад хүргэх зорилгоор цахим мэдээллийн эх үүсвэр, сургалтынхэрэглэгдэхүүн, тоног төхөөрөмж авах, багш нарыг сургах зэрэгт өрсөлдөөнт санхүүжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ.
- удирдлагын мэдээллийн систем (UNIMIS)-ийг нийт их, дээд сургуульд нэвтрүүлнэ.

7/ Кредитийн систем бүрэн утгаараа хэрэгжээгүй, сургууль хооронд харилцан жиших, шилжүүлэхэд бэрхшээлтэй.

- Суралцагчид хичээл сонгохболомжийг хангасан кредит шилжүүлэх, харилцан хүлээн зөвшөөрөх тогтолцоо бүрдүүлнэ.
- Оюутнууд суралцах үедээ хөгжих, дадлагажих, ирээдүйн карьераа төлөвлөх, баримжаа авах үйлчилгээ, дэмжлэг дутмаг.
- Оюутанд зориулсан үйлчилгээний цогц систем байгуулж, тэдний судалгааны ажилд оролцох, хөдөлмөр эрхлэх, дадлагажих, сонирхлын клуб, хамтлагт нэгдэх боломжийг нэмэгдүүлнэ.

8/ Оюутанд зориулсан монгол хэл дээрх ном, мэдээлэл дутмаг.

- Мэргэжил бүрээр шаардлагатай ном, сурах бичгийн жагсаалтыг гаргаж сурах бичиг, сургалтын материал зохиох, орчуулах, хэвлэхэд дэмжлэг үзүүлнэ.
- номын сангийн олон улсын сүлжээнд нэгдэж, электрон болон дижитал номын санг нийт суралцагч, багш нарт хүртээлтэй хэлбэрээр байгуулна.
- ДББ-ын багш нар хичээл заах үндсэн үүрэгтэйн зэрэгцээ хөдөлмөрийн үнэлэмж бага байгаагаас олон газар цагаар хичээл заах нь нийтлэг болж, оюутан суралцагчидтай ажиллах, тэднийг хөгжүүлэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх нь орхигдсон байна.

- ДББ-ын багшийн хичээл заах, судалгаа хийх, нийгмийн үйлчилгээ үзүүлэх чиг үүргээ бүрэн хэрэгжүүлэх, суралцагчдыг хөгжүүлэх, нийгэмшүүлэхэд төвлөрч ажиллах урамшуулал, дэмжлэгийн механизм бүрдүүлнэ.
- Профессор багш нь оюутанд судалгааны арга барил эзэмшүүлэх, бүтээлч эрэл хайгуул хийхэд үлгэрлэн дагуулж, тэдний шүүмжит сэтгэлгээг хөгжүүлэхэд тусалдаг, оюутан хичээл зүтгэлтэй суралцах сонирхол, хандлагыг төлөвшүүлэхэд чиглэсэн сайн туршлагыг бий болгох, түгээн дэлгэрүүлэх тогтолцоо бүрдүүлнэ.

9/ Дээд боловсрол үндсэндээ сургалтын төлбөрөөс санхүүжиж байна. ДББ-ууд нь үйл ажиллагаагаа явуулахад хүрэлцэхүйц орлого бүрдүүлэхийн тулд төлбөр хийхийг зөвшөөрсөн оюутныг олноор нь элсүүлж байна. Төрийн бус өмчийн сургуулиуд санхүүжилтийнхээ бараг 90%-ийг, төрийн өмчийн сургуулиуд санхүүжилтийнхээ 80%-ийг сургалтын төлбөрөөс бүрдүүлж байна.

- ДББ-ын санхүүжилтийг олон эх үүсвэртэй болгоно.
- Дээд боловсролын үйл ажиллагааг хөрөнгө, санхүүгээр дэмжсэн ажил олгогч, хөрөнгө оруулагчдыг татвараас хөнгөлөх, чөлөөлөх нөхцөл бүрдүүлнэ.
- Сургалтын байгууллага бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, өөрсдийн боловсролын технологийн шийдэлд үндэслэн стартап компани байгуулах, патент лицензээ борлуулах, хамтран эзэмших замаар санхүүжилтээ нэмэгдүүлэх боломжийг хуулиар нээлттэй болгоно.
- Дээд боловсролыг дэмжих санг байгуулж хөрөнгийн эх үүсвэрийг баталгаажуулж, үр дүнг дэмжих нөхцөл бүрдүүлнэ.
- Их сургуулийн судалгааны ажлыг дэмжсэн төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж, судалгааны ажлын үр дүнг худалдах, орлого нэмэгдүүлэх эх үүсвэр болгон ашиглах нөхцөл бүрдүүлнэ.
- Нэг оюутанд ногдох жилийн дундаж зардал 3.0 сая төгрөг. Нийт оюутан суралцагчид, тэдний эцэг эх 4 жилд нийт 2 их наяд 73 тэрбум 576 сая төгрөгийг суралцахтай холбогдсон зардалд төлж байна.
- ДББ-ын санхүүжилтийг олон эхүүсвэртэй болгосноор үйл ажиллагааны чанарт тогтвортой ахиц гаргах, оюутан суралцагчдын нийгэм ахуйн хэрэгцээг хангах боломжийг нэмэгдүүлнэ.
- чадавхжуулж, бүртгэл, хяналтын системийг нэвтрүүлэн, чанарын ахиц дэвшлийг дэмжих байгууллага болгоно.

- Сургалтын төрийн сангийн хөрөнгө нь эхний ээлжинд орлого багатай өрхийн суралцагчийн суралцах тэгш эрхийг хангах зориулалттай атал энэ ангилалд хамааралгүй хэсэгт илүүтэй хуваарилагдах болсон.
- Сургалтын төрийн сангийн үйлчилгээний зорилтот хэсгийг зөв тогтоож, тэдэнд дэмжлэг хүргэх механизмыг шинэчлэн, нийгэм, эдийн засгийн хөгжилд нэн эрэлттэй чиглэлийн мэргэжлээр суралцагчдыг дэмжих зохицуулалттай болгоно.
- Сургалтын төрийн сангийн үйл ажиллагааг өргөжүүлнэ.

10/ Их сургуулийг хотхоноор хөгжүүлэх чиглэл засгийн газрын 2010 оны 149 дүгээр тогтоолоор батлагдсан ч ахиц дэвшил тодорхойгүй.

- Их сургуулийн хотхон байгуулах техник-эдийн засгийн үндэслэл, ерөнхий болон хэсэгчилсэн төлөвлөгөөг баталж, эхний ээлжийн барилга байгууламжийг ашиглалтад оруулна.

11/ Дээд сургууль төгсгөгчид хөдөлмөрийн зах зээлийн хэрэгцээг хангаж чадахгүй байна.

- Сургуулиуд өөрийн тогтоосон шаардлагын баримтлан элсэгчдэд ижил тэгш хандах зарчим алдагдах, хандиваар болон бусад эрх мэдэлтний чиглэл шийдвэрээр элсүүлж байгаа нь ёсзүйн буруу практикт дасах, дасгах үр дагавартай байна.
- Дээд боловсролын ерөнхий боловсролын сургууль болон хөдөлмөрийн захтай харилцах холбоог сайжруулж, хүүхэд залуучууд мэргэжлийн сонголтоо оновчтой хийхэд туслах.
- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангид кредит цагийн тогтолцоог нэвтрүүлж, мэргэжлийн чиг баримжаа олгох, төрөлжсөн сургалт явуулах замаар дээд сургуульд суралцах бэлтгэлийг сайжруулна.
- ДББ-ын үйл ажиллагаанд шударга, нээлттэй байх зарчмыг хэрэгжүүлж, оны эхний сард оюутан элсүүлэх шалгуур, 3 дугаар сард сургалтын төлбөрийн хэмжээг албан ёсоор зарлаж, нийтэд мэдээлж, элсэлтийн ажлын бүх шатанд хатуу дагаж мөрддөг болгоно.
- Оюутнууд сургуулиа төгсч, диплом авсан боловч мэргэжлийн ур чадвар, төлөвшил нь ажил олгогчдын шаардлага, зах зээлийн эрэлтэд нийцэхгүй байна.

- Элсэлтийн шалгалтаар шинжлэх ухааны мэдлэг, чадварыг үнэлэхээс гадна бие хүний хандлага төлөвшил, тухайн мэргэжлээр суралцах хүсэл, сонирхол, эх хэл эзэмшилтийн түвшин зэргийг үнэлж сонгон шалгаруулдаг болно.
- Тухайн хөтөлбөрөөр суралцагчийн эзэмшсэн байх мэдлэг, чадварын төвшин, төгсгөгчид тавих шаардлагыг тодорхой болгож, явцын болон төгсгөлтийн шалгалт, хяналт үнэлгээний системтэй болно.
- БСШУСЯ дээд боловсролын мэргэжлийн чиглэл, элсэлтийн хяналтын тоогтогтоож буй нь төдийлэн оновчтой биш, сургууль, төрийн захиргааны байгууллагын харьцаанд сөрөг үр дагавар үзүүлж байна. Иймээс элсэлтийн хяналтын тоог яамнаас тогтоодог байдлыг өөрчилж хөгжлийн чиг хандлагад суурилсан судалгаа, сургуулийнхаа чадамж, хүний нөөц, сургалтын орчин материаллаг баазад тулгуурлан элсүүлэх оюутны тоогоо тогтоохыг дэмжинэ.

Монголын боловсролын эрх зүйн шинэчлэл

1990-ээд оноос Монгол Улс нэг намын төржсөн засаглал, төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн харилцаанаас татгалзаж, парламентийн засаглалтай, олон намын тогтолцоотой, зах зээлийн эдийн засгийн харилцаа бүхий хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжих шилжилтийн үеийг эхэлүүлсэн билээ. Энэхүү улс төр, эдийн засаг, нийгмийн шинэчлэлийг хэрэгжүүлэх нэг үндсэн нөхцөл нь манай улсад эрх зүйт төрийн шинэ тогтолцоог бий болгон төлөвшүүлэх асуудал байлаа. Иймээс 1992 онд хуралдсан Монгол Улсын Их Хурлаас Монгол Улсын ардчилсан Үндсэн хуулийг баталсан билээ. Энэ Үндсэн хуульд Монгол Улсад парламентийн засаглалтай, олон хэвшил бүхий эдийн засагтай, хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлон хөгжүүлэхийг тунхаглан зарласан нь Монгол Улсыг нийгмийн шинэ харилцаанд шилжих эрх зүйн зохицуулалтыг бий болгов. Боловсрол нь аль ч улс оронд нийгмийн хамгийн том салбар болдог, өөрөөр хэлбэл, боловсролын харилцаанд оролцдоггүй иргэн, байгууллага гэж хаана ч байдаггүй.

Түүнчлэн иргэний боловсрол, соёлын түвшнээс нийгмийн хөгжил шууд хамааралтай болохыг нийгмийн хөгжлийн түүх нотлон харуулсаар байна. Иймээс аливаа нийгмийн харилцааг төгөлдөржүүлэн боловсронгуй болгоход иргэний боловсролын хүртээмж, чанар, үнэлэмжийг дээшлүүлэх нь тулгамдсан асуудлын нэг байдаг. Энэхүү тулгамдсан асуудлыг шийдвэрлэхийн тулд боловсролд эрх зүйн шинэчлэл хийх шаардлага зүй ёсоор тавигдсан юм. Үүнийг иш үндэс болгон Монгол Улсын Их Хурлаас 1991 онд Боловсролын тухай хуулийг шинэчлэн баталсан, 1995 онд Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого болон

Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай, Дээд боловсролын тухай хууль (багц хууль)-ийг тус тус баталж мөрдүүлснээс гадна эдгээр хуульд 1998, 2000, 2002, 2006 онуудад нэмэлт, өөрчлөлт орууллаа. Мөн 2002 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, 2006 онд Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, 2011 онд Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийг тус тус шинээр батлан мөрдүүллээ. 1995-2006 онд шинээр болон шинэчлэн батлан мөрдөж байгаа эдгээр хуулийг бүхэлд нь “Боловсролын тухай багц хууль” гэж нэрлэв. Энэхүү илтгэлд Монголын боловсролын эрх зүйн шинэчлэлийн мөн чанар, үр нөлөөний талаар авч үзсэн болно.

Боловсролын эрх зүйн шинэчлэлийн мөн чанар

1990-ээд оноос хойших үеийн монголын боловсролд хийгдэж байгаа эрх зүйн шинэчлэлийг дор дурдсан 6 чиглэлээр багцлан авч үзэх нь зүйтэй:

1. Боловсролын тогтолцоонд хийсэн эрх зүйн шинэчлэл

Монгол Улсад 1990-ээд оныг хүртэл боловсролын тогтолцоог цэцэрлэг, бүх шатны сургуулийн хүрээнд авч үздэг байв. Өөрөөр хэлбэл, боловсролыг өргөн утгаар нь биш зөвхөн албан ёсны боловсрол (formal education)-оор хязгаарлаж байв. Тухайлбал, Боловсролын тогтолцоог 1982 оны БНМАУ-ын ардын боловсролын хуульд “БНМАУ-ын ардын боловсролын систем нь сургуулийн өмнөх насны хүүхдийн хүмүүжил, ерөнхий дунд боловсрол, сургуулиас гадуур олгох хүмүүжил, техник-мэргэжлийн боловсрол, тусгай дунд боловсрол, Дээд боловсролоос бүрдэнэ” гэж тодорхойлсон бол 1991 оны БНМАУ-ын боловсролын тухай хуульд “БНМАУ-д боловсролын тогтолцоо нь сургуулийн өмнөх, ерөнхий болон мэргэжлийн боловсролоос бүрдэнэ.” гэсэн нь мөн л боловсролыг зөвхөн сургууль, цэцэрлэгээр хязгаарласан байна. Иймээс боловсролыг “Хүн эхийн хэвлийд бүрэлдэн бий болох үеээс эхлэн насан эцэс хүртлэх үйл явцыг хамруулах нь” боловсролын мөн чанарыг төгс илэрхийлдэг. Өөрөөр хэлбэл, “Боловсрол гэдэг нь хүн бүрэлдэн бий болох үеээс эхлээд ертөнцийн мөнх бусыг үзэх хүртлэх хугацаанд түүний албан ёс (бүх шатны сургууль, цэцэрлэгээр болон түр хугацааны сургалт)-ны болон албан ёсны бус (амьдралын уламжлалт ёс, ахуйн орчин, нөхцөл, бусад хүмүүсийн үйл ажиллагаа, туршлагаас сурсан, мэдсэн зүйл, өөрийн ажил, амьдралын явцад бий болгосон арга барил, үйл ажиллагаа, туршлага зэрэг-nonformal education) боловсролоор олж авсан мэдлэг, чадвар, туршлага, төлөвшлийн нэгдэл юм” гэж өргөн утгаар нь авч үздэг. Үүнийг

иш үндэс болгон 1995 онд баталсан Боловсролын тухай хуульд “Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх бөгөөд сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэнэ” гэж боловсролын тогтолцоог өргөн утгаар нь тодорхойлов. Ингэснээр Монгол Улсын боловсролын агуулгын тогтолцоог өргөн утгаар нь албан ба албан бус боловсролын нэгдэл байх, нарийвчилсан утгаараа сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд боловсролоос бүрдэхээр тодорхойлсон нь боловсролын эрх зүйн шинэчлэлийн нэг онцлог юм.

Түүнчлэн боловсролын эрх зүйн шинэчлэлийн дүнд боловсрол нь Монголын нийгэм, эдийн засгийн тогтолцооны нэгэн бүрэлдэхүүн хэсэг мөн боловч өөрөө агуулгын тогтолцоо, байгууллагын тогтолцоо, удирдлагын тогтолцоо гэсэн бүрэлдэхүүн хэсгүүдтэй болохыг хуульчлан тогтоолоо.

Бага, дунд боловсролын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлт (2002 он)-өөр Монгол Улсын бага, дунд боловсролын 4+4+2 гэсэн сургалтын хуучин тогтолцоог өөрчлөн бага боловсролыг 5, суурь боловсролыг 9, бүрэн дунд боловсролыг 11 жил (5+4+2)-д тус тус эзэмшүүлэхээр, түүнчлэн хүүхдийг сургуульд элсүүлэх насыг 8 байсныг 7 болгосон, Боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Дээд боловсролын сургалтын байгууллагын ангиллыг их сургууль, коллеж байсныг их сургууль, дээд сургууль, коллеж болгож, дээд боловсролын шатлалыг дипломын, бакалаврын, магистрын, докторын гэсэн зэрэглэл (degree)-тэй байхаар тодорхойлсон нь Монгол Улсын боловсролын тогтолцоог олон улсад нийцүүлэх эрх зүйн зохицуулалт болсон юм. Энэхүү өөрчлөлтийн дүнд манай улс хүүхдийг 8 настайд нь бага сургуульд элсүүлдэг байсан дэлхийн ганц улс байснаа больж 7 настай хүүхдийг элсүүлдэг болсон төдийгүй Монгол Улсын бага, дунд боловсролын баримт бичгийг бусад улс оронтой харилцан хүлээн зөвшөөрөлцөх боломжийг бүрдүүлэхэд чиглэснээрээ онцлог байлаа. Өөрөөр хэлбэл, энэхүү өөрчлөлтийг хэрэгжүүлснээр 11 жилийн дунд сургууль төгсөгчдийг гадаадын бусад орны их сургууль, дээд сургууль, коллежид шууд элсэн суралцах нөхцөл бүрдэнэ гэсэн үг юм. Энэхүү эрх зүйн шинэчлэлийн дагуу 2005-2006 оны хичээлийн жилээс ЕБС-ийг 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлж эхэлсэн боловч 2006 онд Боловсролын тухай болон Бага, дунд боловсролын тухай хуулиудад оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр бага, дунд боловсролын сургалтын тогтолцоог 6+3+3 гэсэн 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, хүүхдийг 6 наснаас нь сургуульд элсүүлэхээр тогтоосны дагуу 2008-2009 оны хичээлийн жилээс энэхүү шилжилтийг мөн

зэрэгцүүлэн хийж байна. Үүнээс үзэхэд ЕБС-ийн сургалтын тогтолцоо нь 1990 оныг хүртлэх хугацаанд харьцангуй тогтвортой байснаа түүнээс хойших жилүүдэд ерөнхий боловсролын сургуулийн бүтцийг ойр ойрхон өөрчилсөн нь сургалтын агуулгын залгамж холбоо болон түүнийг судлах логик дарааллыг алдагдуулж, хүүхдийн сургалтад муугаар нөлөөлсөн төдийгүй ард түмний ярьдагаар “Хүүхдийг туршилтын туулай болгож” байгаа хэрэг билээ.

ЕБС-ийг 11 болон 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэх тухай эрх зүйн шинэчлэл нь Монгол Улсын бага, дунд боловсролыг олон улсынхтай дүйцүүлэх, бага, дунд боловсролын баримт бичгийг харилцан хүлээн зөвшөөрөхөд чиглэсэн хэдий ч түүний эерэг болон сөрөг үр дагварыг судлан тогтоогоогүй байна.

Иймээс ерөнхий боловсролын сургуулийн бүтцийн талаар урьдчилан судалгаа, туршилт хийж, түүний шинжлэх ухааны үндэслэлийг тогтоосны дараа бүтцийн өөрчлөлтийг хийж, цаашид тогтвортой мөрдүүлэхээр эрх зүйн зохицуулалтыг бий болгох нь нийгмийн амьдралаас урган гарч байна. 1995 онд Улсын Их Хурлаас баталсан Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хуульд дээд боловсролын сургалтын байгууллагын тогтолцоонд их сургууль, дээд сургууль, коллежийг хамруулж, агуулгын хувьд ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хэсгээс бүрдэх бөгөөд багц цаг (кредит)-ийн хэмжээгээр ялгагдах боловсролын зэрэг (дипломын, бакалаврын, магистрын), эрдмийн зэрэг (Ph.D, Sc.D)-ийн гэсэн шатлалтай байхаар эрх зүйн зохицуулалтыг бий болгов. Ингэснээр Монгол Улсын дээд боловсролын тогтолцоо нь бусад орныхтой адилхан болсон юм.

2. Боловсролын агуулга, түвшин, стандартад хийсэн эрх зүйн шинэчлэл.

1991 оныг хүртлэх Боловсролын тухай хуулиудад Боловсролын агуулга, стандартыг зохицуулсан тусгай заалт байгаагүй бөгөөд СӨБ, бага, дунд, дээд боловсролын агуулга нь тус тусын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрөөр тодорхойлогдож байв. БНМАУ-ын боловсролын тухай хууль (1991он)-д боловсролын агуулга юунд чиглэгдэхийг тогтоогоогүй хэдий ч иргэд боловсролыг албан ёсны буюу албан ёсны бус арга замаар эзэмшиж болохыг хүлээн зөвшөөрч, “Албан ёсны арга замаар эзэмших боловсролын агуулгыг төрөөс тогтооно. Албан ёсны бус арга замын хувьд агуулга нь чөлөөтэй байна” гэж боловсролын агуулгыг тогтоох субъектыг тодорхойлж өгсөн байна.

Харин 1995 оны Боловсролын тухай хуульд боловсролын агуулга, стандартын тухай нэгэн бүлэг асуудлаар эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь өмнөх хуулиудаас давуутай болжээ.

Энэ хуульд Монгол Улсад анх удаа боловсролын стандартыг бий болгох эрх зүйн үндсийг тогтоосон байна. Тухайлбал, Боловсролын тухай хуульд “Боловсролын агуулга нь суралцагчдын нас, бие, сэтгэхүйн онцлог, авъяас сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэж заагаад Монгол Улсын боловсролын агуулгыг түвшнээр нь сургуулийн өмнөх болон бага, дунд, дээд гэж ангилаад түвшин бүрийн агуулга юунд чиглэгдэхийг Бага, дунд боловсролын тухай болон Дээд боловсролын тухай хуульд тодорхойлж, боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрөөр нарийвчлан тогтоохоор эрх зүйн зохицуулалтыг бий болгосон юм.

Боловсролын тухай хуулийн заалтын дагуу 1998 онд “Монгол Улсын бага, дунд боловсролын агуулгын болон үнэлгээний стандарт”-ыг шинээр батлан мөрдүүлсэн юм. Ингэснээр Монгол Улсад анх удаа бага, дунд боловсролын агуулгын үндэсний стандарттай болсон байна.

Дээд боловсролын тухай хууль (1995 он)-д “Дээд боловсролын агуулга нь нэгдмэл бөгөөд суралцагчдад шинжлэх ухаан, техник, технологи, нийгэм-хүмүүнлэгийн тодорхой чиглэлээр сургалт, эрдэм штнжилгээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хүрээнд мэргэжлийн өндөр түвшинд ажиллах мэдлэг, чадвар, дадал эзэмшүүлж, иргэний өндөр соёл төлөвшүүлэхэд чиглэгдэнэ” гэж зааснаас гадна дээд боловсролын агуулга нь ерөнхий суурь, мэргэжлийн суурь болон мэргэшүүлэх хэсгээс бүрдэхээр тодорхойлсон байна.

Түүнчлэн дээд боловсролын агуулгын багтаамжийг багц цагаар хэмжихээр тогтоосон нь дээд боловсролын агуулгад хийсэн эрх зүйн шинэчлэлийн нэгэн онцлог юм. Эдгээр эрх зүйн шинэчлэлийн дагуу сүүлийн 10 гаруй жилд дээд боловсролын сургалтын ихэнх байгууллагын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт, зохион байгуулалтад багц цагийн жиших нэгжийг хэрэглэж байгаа, дээд боловсролын ерөнхий суурь хэсгийн болон хуулийн мэргэжлийн агуулгын стандартыг боловсруулан ашиглаж байгаа боловч дээд боловсролын бусад мэргэжлийн хичээлүүдийн агуулгын болон үнэлгээний стандартыг бий болгоогүй байна. Иймээс ч манай улсын дээд боловсролын агуулгын түвшин доогуур,

мэргэжлийн сургалтын хөтөлбөрүүд нь олон улсын хэмжээнд хөрвөх чадваргүй хэвээр байна.

Докторантурт суралцагч нь 60 хүртэл багц цагийн сургалтыг дүүргэхээс гадна тухайн сэдвээр судалгааны ажил хийж, нэгэн сэдэвт эрдэм шинжилгээний бүтээл бичиж, боловсролын докторын зэрэг олгох эрдмийн зөвлөлд хамгаална. Харин эрдэм шинжилгээний ажилтны хувьд судалгаа, туршилтын ажлын цар хүрээ, онол-аргазүйн түвшин, практик ач холбогдлыг харгалзан тэдэнд бүтээлээр нь шинжлэх ухааны докторын зэрэг олгох асуудлыг Шинжлэх ухаан, технологийн тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр зохицуулдаг боллоо.

Боловсролын тухай багц хуульд оруулсан бодлогын өөрчлөлтийн нэг нь бүх шатны боловсролын агуулгад онол, дадлагын харьцааг оновчтой болгох, ялангуяа боловсролын агуулгад прагматик чиглэлийг нэмэгдүүлэх, иргэнийг нийгэм-хүмүүнлэгийн зөв төлөвшилтэй болгоход чиглэгдсэн байна. Энэ нь Боловсролын тухай хуульд “Монгол Улсын боловсролын зорилго нь иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадавхтай, хүмүүнлэг ёсыг дээдлэн сахидаг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд оршино”, “Боловсролын агуулга нь суралцагчийн нас, бие, сэтгэхүйн онцлог, авьяас сонирхол, хувийн болон нийгмийн хэрэгцээ, үндэсний өв, шинжлэх ухаан, технологийн хөгжлийн хандлагад нийцүүлэн боловсролын зорилгыг хэрэгжүүлэхэд чиглэнэ” гэж шинэчлэн тодорхойлсноор илэрч байгаа юм.

1995 оноос өнөөг хүртэл Боловсролын тухай хуульд заасны дагуу сургуулийн өмнөх, бага, дунд болон дээд боловсролын сургалтын орчны стандартыг боловсруулаагүй байгаад зохих дүгнэлт хийх болсныг харуулж байна.

3. Боловсролын удирдлага, түүний тогтолцоо, бүрэн эрхэд хийсэн эрх зүйн шинэчлэл.

1995 онд Улсын Их Хурлаас баталсан Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, Боловсролын тухай хуульд боловсролын удирдлагын төрийн бодлогын үндсийг “Боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, төрийн ивээл, зохицуулалт, төр-олон нийтийн хяналтанд байлгана” гэж гэж тодорхойлсон нь ардчилсан нийгмийн зарчимд нийцсэн шинэчлэл болов. Боловсролын тухай багц хуульд оруулсан өөрчлөлтөөр Монгол Улсын боловсролын удирдлагыг хэлбэрээр нь төр, захиргааны удирдлага, өөрийн удирдлага, мэргэжил, арга зүйн удирдлага гэж ангилснаас гадна түвшнээр нь үндэсний, орон нутгийн, байгууллагын гэж ангилсан юм.

Үндэсний хэмжээнд төр, захиргааны удирдлагыг төрийн эрх барих дээд байгууллага буюу УИХ, Төрийн захиргааны дээд байгууллага буюу Засгийн газар, Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын хяналтын Улсын алба хэрэгжүүлэх; орон нутгийн түвшинд төр, захиргааны удирдлагыг аймаг, нийслэлийн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг дарга; Боловсролын сургалтын байгууллагын түвшинд цэцэрлэг, бүх шатны сургуулийн захиргаа; үндэсний хэмжээнд мэргэжил-аргазүйн удирдлагыг эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага буюу боловсролын хүрээлэн, орон нутгийн түвшинд аймаг, нийслэлийн Боловсролын төв, сургалтын байгууллагын түвшинд заах аргын нэгдэл (тэнхим), эрдмийн зөвлөл (их, дээд сургуульд); өөрийн удирдлагыг зөвхөн сургалтын байгууллагын түвшинд бүх шатны сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөл тус тус хэрэгжүүлэх юм.

Боловсролын удирдлагын талаарх хууль тогтоох болон төрийн захиргааны дээд байгууллагын бүрэн эрхийг УИХ-ын болон Засгийн газрын тухай хуульд заасны дагуу хэрэгжүүлнэ. Боловсролын тухай багц хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын хяналтын улсын алба, Эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, орон нутгийн бүх шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын болон бүх шатны сургууль, цэцэрлэгийн захиргааны болон өөрийн удирдлагын бүрэн эрхтэй холбогдсон эрх зүйн зохицуулалтыг бүхэлд нь өөрчлөн шинэчиллээ. Тухайлбал, Боловсролын тухай хуульд зааснаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийг байгуулах, татан буулгах, захирлыг томилж, чөлөөлөх, өмчийн аль ч хэлбэрийн дээд боловсролын байгууллагад сургалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл олгох, хуульд заасан журмын дагуу үйл ажиллагааг нь зогсоох эрхтэй болжээ. Мөн хуульд зааснаар боловсролын захиргааны хяналтыг бий болгож, түүнийг боловсролын хяналтын алба, улсын байцаагч хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Боловсролын захиргааны хяналтын алба нь Боловсролын тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, бүх шатны боловсролын стандарт, сургалт-хүмүүжлийн ажилтай холбогдсон хууль, дүрэм, журмын хэрэгжилтэд мэргэжлийн хөндлөнгийн хяналт тавих бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр эрх зүй зохицуулалтыг бий болгожээ. 1990-ээд оноос хойших боловсролын удирдлагын эрх зүйн шинэчлэл нь боловсролын сургалтын байгууллагын удирдлагад төвлөрлийг сааруулах, бие даасан байдлыг дээшлүүлэх, өөрийн удирдлагыг хөгжүүлэхэд чиглэгдсэн байна. Тухайлбал, СӨБ,

бага, дунд боловсролын удирдлагыг бүхэлд нь орон нутаг (бүх шатны ИТХ, Засаг дарга)-т шилжүүлж, дээд боловсролын хувьд бие даасан байдлыг дээшлүүлэх эрх зүйн зохицуулалтыг бий болгосон байна.

4.Боловсролын байгууллага, түүний тогтолцоо, бүрэн эрхэд хийсэн эрх зүйн шинэчлэл.

Боловсролын тухай хуульд “Боловсролын зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийг боловсролын байгууллага гэнэ”, “Боловсролын нэг буюу хэд хэдэн түвшний боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг хуулийн этгээдийг боловсролын сургалтын байгууллага гэнэ” гэж тус тус тодорхойллоо. Ингэснээр боловсролын байгууллагын зааг ялгааг мэдэх, тогтолцоог зөв ойлгох, боловсролын байгууллагыг бусад байгууллага, аж ахуйн нэгжээс ялгах боломжтой болов. Монгол Улсын Үндсэн хууль (1992 он)-д өмчийн аль ч хэлбэрт үндэслэсэн сургалтын байгууллагыг ямарч байгууллага, иргэн байгуулж болохыг хүлээн зөвшөөрсөн нь боловсролын эрх зүйн шинэчлэлийн бас нэг онцлог юм.

Боловсролын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр боловсролын байгууллагын тогтолцоо нь боловсролын сургалтын байгууллага, боловсролын эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллага, боловсролын бусад байгууллагаас бүрдэж байна. Боловсролын сургалтын байгууллагад цэцэрлэг, бүх шатны сургууль; эрдэм шинжилгээ, арга зүйн байгууллагад үндэсний хэмжээнд Боловсролын хүрээлэн, орон нутагт Боловсролын газар, хэлтэс; бусад байгууллагад Боловсролын мэргэжлийн хяналтын алба, боловсролын магадлан итгэмжлэлийн байгууллага, Албан бус боловсролын үндэсний төв, Сургалтын төрийн сан, нийгэм, эдийн засаг, техник, технологи, байгаль орчин, гоо зүй, соёл, урлаг, спорт, эрүүл мэнд, гэр бүлийн болон үйлчигээний хүрээний асуудлаар тусгай хөтөлбөрийн дагуу хүүхэд, насанд хүрэгчдэд боловсрол эзэмшүүлэх, боловсрол, мэргэжлээ дээшлүүлэхэд нь туслалцаа үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллага зэрэг хуулийн этгээдүүд хамрагдах боллоо. Мөн бүх шатны сургуулийн ангилал, хэв шинжийг нарийвчлан тогтоолоо. Тухайлбал, бага, дунд боловсролын сургалтын байгууллагыг бага, дунд, ахлах сургууль гэсэн ангилалтай болгож, ердийн, мэргэжлийн, гүнзгийрүүлсэн болон тусгай сургалттай гэсэн хэв шинжтэй байхаар, дээд боловсролын сургалтын байгууллагын хувьд их сургуулийг эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн буюу эрдэм шинжилгээ-сургалтын; дээд сургуулийг сургалт-эрдэм шинжилгээний; коллежийг сургалтын буюу сургалт-үйлдвэрлэлийн хэв шинжтэй болголоо.

Боловсролын сургалтын байгууллагын удирдлагын тогтолцоо нь захиргааны удирдлага, өөрийн удирдлага, мэргэжил-аргазүйн удирдлагаас бүрдэх бөгөөд захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх субъект нь захирал (эрхлэгч), өөрийн удирдлагыг хэрэгжүүлэх субъект нь цэцэрлэг, ЕБС-д цэцэрлэг, сургуулийн зөвлөл (School council), дээд боловсролын сургалтын байгууллага, МСҮТ-д удирдах зөвлөл (School board) байхаар өөрчлөв.

Бүх шатны сургууль, цэцэрлэгийн захиргааны удирдлага буюу захирал, эрхлэгч нь үйл ажиллагаагаа хууль тогтоомжид нийцүүлэх, сурацагчдын эрх ашгийг хамгаалах, сургалт-хүмүүжлийн ажилд дэвшилтэд арга, хэлбэрийг сонгон хэрэглэх, хүний нөөцийг бүрдүүлэх, хөгжүүлэхэд чиглэгдсэн бүрэн эрхийг хэрэгжүүлэх боллоо. Сургууль, цэцэрлэгийн зөвлөл нь зөвхөн тухайн сургууль, цэцэрлэгийн багш, ажилтан, сурагч, эцэг, эхийн болон бусад байгууллагын төлөөлөл бүхий тус тусын хурлаас сонгосон 9-11 хүний бүрэлдэхүүнтэй байх, зөвлөлд үүсгэн байгуулагчийн төлөөлөл заавал байх шаардлагагүй бөгөөд хэрэв төлөөллөө оруулахыг хүсвэл нийт ажиллагчдын хурлаас сонгохоор журамлав. Харин удирдах зөвлөлийн хувьд үүсгэн байгуулагчийн төлөөлөл 51-60 хувь нь байхаар тогтоосон нь сургууль, цэцэрлэгийн удирдлагад үүсгэн байгуулагч давуу эрхтэй оролцохыг харуулж байна. Түүнчлэн Боловсролын тухай хуульд оруулсан өөрчлөлтөөр удирдах зөвлөл нь сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгчийг ажилд томилох, ажлаас чөлөөлөх шийдвэр гаргадаг, уг шийдвэрийг үүсгэн байгуулагч батламжилдаг байсныг өөрчлөн сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөл нь захирал, эрхлэгчийг томилох, чөлөөлөх талаар үүсгэн байгуулагчид санал тавьдаг болголоо.

Ингэснээр сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөл нь сургууль, цэцэрлэгийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, захирал, эрхлэгчийн үйл ажиллагаанд хяналт тавих, дэмжлэг үзүүлэх, багш, суралцагчдын эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй болж байгаа юм. Эдгээр эрх зүйн шинэчлэл нь боловсролын сургалтын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, төвлөрлийг сааруулах, өөрийн удирдлагыг хөгжүүлэхэд чиглэжээ. Ийнхүү боловсролын сургалтын байгууллагын удирдлагын төвлөрөл багасч, бие даасан байдал, бүрэн эрх нь нэмэгдсэн хэдий ч цэцэрлэг, бүх шатны сургуулийн захиргааны удирдлагыг хэрэгжүүлэх хүний нөөц (захирал, эрхлэгч)-ийг зохих түвшинд бэлтгээгүй, тэдний менежментийн чадавхи сул, сургууль, цэцэрлэгийн зөвлөл, удирдах зөвлөлүүд хуульд заасан чиг үүргээ зохих ёсоор хэрэгжүүлж чадахгүй байгаа нь боловсролын сургалтын байгууллагын захиргааны болон өөрийн удирдлагын

төлөвшил, үр нөлөөнд зарчмын өөрчлөлт гараагүй, эрх зүйн шинэчлэлийн хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

5.Боловсролын эдийн засаг, сургалтын орчны эрх зүйн шинэчлэл

Боловсролын эдийн засгийн эрх зүйн шинэчлэлийн гол агуулга нь төрийн өмчийн боловсролын сургалтын байгууллагын хувьд санхүүжилт нь тогтмол болон хувьсах зардлаас тогтох, хувьсах зардлыг цэцэрлэг, ЕБС, МСҮТ-д нэг суралцагчид ногдох хувьсах зардлын нормативээр, дээд боловсролын сургалтын байгууллагад сургалтын төлбөр (сургалтын хөтөлбөрийн зардал)-ийн хэмжээгээр тогтоохоор зааснаас гадна бага, дунд боловсрол эзэмшихэд нэг суралцагчид ногдох хувьсах зардлын норматив, дээд боловсрол эзэмшихэд нэг суралцагчид ногдох сургалтын төлбөрийн жишгийг сургуулийн байршил, хэв шинж болон мэргэжлийн төрлөөс хамааруулан Засгийн газар жил бүр шинэчлэн тогтоож байхаар заалаа. Түүнчлэн төрийн өмчийн их сургууль, дээд сургууль, коллежийн тогтмол зардлыг улсын төсвөөс, ЕБС-ийн тогтмол зардал болон дотуур байрны нийт зардал, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр цэцэрлэг, ЕБС-ийн нэг суралцагчид ногдох нормативт зардлыг улсын төсвөөс тус тус санхүүжүүлэхээр хуульчилсан юм.

Цэцэрлэгийн хувьд хүүхдийн хоолны зардлын тал хувийг эцэг, эх, асран хамгаалагч нь хариуцдаг байсныг Сургуулийн өмнөх боловсролын тухай шинэ хууль (2008 он)-д заасны дагуу өөрчлөн төр бүхэлд нь хариуцах боллоо. Ингэснээр амьжиргааны түвшнээр доогуур орлоготой өрхийн хүүхдийг СӨБ-д хамруулах боломжийг бий болголоо.

Төрийн өмчийн дээд боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь улсын төсвийн санхүүжилтээс гадна сургалтын төлбөр, эрдэм шинжилгээний төсөлт ажлын болон өөрийн үйл ажиллагааны орлого, бусад хандив, тусламжаас бүрдэнэ. Харин цэрэг, цагдаагийн дээд боловсрол эзэмшүүлэхтэй холбогдсон зардлыг төр хариуцахаар боловсролын хуульд заасан тул төрийн өмчийн цэрэг, цагдаагийн их, дээд сургуульд суралцагчдын сургалтын зардлыг улсын төсвөөс олгодог.

Төрийн бус өмчийн боловсролын сургалтын байгууллагын санхүүжилтийн эх үүсвэр нь үүсгэн байгуулагчийн хөрөнгө, нэг суралцагчид ногдох хувьсах зардлын улсын төсвөөс санхүүжүүлэх хэсэг, сургалтын төлбөр, хандив, хөнгөлөлттэй зээл, өөрийн үйл ажиллагааны орлогоос бүрдэнэ. Боловсролын сургалтын орчинд боловсролын сургалтын байгууллагын хичээлийн болон дотуур байр, бусад

барилга, байгууламж, машин, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүн, номын сан, түүний фонд, үйлдвэрлэл, үйлчилгээний болон сургалт-эрдэм шинжилгээний туршилт, дадлагын газар, эзэмшил газар, мал зэрэг өмчллийн зүйлс багтдаг.

Боловсролын сургалтын байгууллагын барилга, байгууламж, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, бусад өмчллийн зүйлс нь багш, ажиллагчид, суралцагчийн сургалтын үйл ажиллагаа, хөдөлмөрийн онцлогт тохирсон, эрүүл ахуй, аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх, сургалтын орчныг бүрдүүлэх үүргийг үүсгэн байгуулагч хариуцах, сургалтын байгууллагын барилга, байгууламжийг зориулалтын дагуу ашиглахыг хуульчлан заасныг боловсролын харилцаанд оролцогч бүр мөрдөх үүрэг хүлээдэг.

6. Боловсролын харилцаанд оролцогчдын эрх, үүрэг, нийгмийн баталгааны эрх зүйн шинэчлэл

Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар Монгол улсын иргэд сурч боловсрох эрх эдэлдэг. Боловсролын тухай, Бага, дунд боловсролын тухай, Дээд тухай, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууиудад багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн эрх, үүргийг тусайлан авч үзэж, эрх зүйн зохицуулалтыг бий бологосон юм. Боловсролын хууль (1991 он)-д иргэд нь бүх шатны сургууль, дамжаанд төлбөргүй буюу төлбөртэй сурч боловсрох үндсэн эрхтэй бөгөөд 17 хүртэл насандаа суурь боловсрол заавал эзэмших үүрэгтэйгээс гадна суралцагчид нь суралцах нөхцөл бололцоогоор хангуулах, сургалтын төлөвлөгөөнд заавал судлахаар тусгагдаагүй хичээлээс сонгон судлах, сургуулийн зөвлөлд сонгогдох, суралцах хугацаа, боломжийнхоо талаар санал тавьж шийдвэрлүүлэх, анги, дамжаа алгасах, сурч боловсрох хэлбэрээ сонгох эрх эдлэхээс гадна сургалтын төлөвлөгөөг хугацаанд нь биелүүлж, хичээлийн хөтөлбөрийг бүрэн эзэмших үүрэг хүлээх болсон байна. Ингэснээр суралцагчид нь өнөөг хүртэл зөвхөн сургалтын үйл ажиллагаатай холбогдсон үүрэг хүлээдэг байсан бол энэ хууль гарснаар үүрэг хүлээхээс гадна зохих эрх эдлэх болсон байна. Түүнчлэн энэ хуульд насанд хүрээгүй суралцагчийн эцэг, эх буюу асран хамгаалагчийн эрх, үүргийг анх удаа хуулийн түвшинд тогтоосон байна.

Хуульд зааснаар эцэг, эх буюу асран хамгаалагч нь “Хүүхдээ 6-8 насанд нь ямар сургуульд, ямар хэлбэрээр суралцахыг сонгож шийдвэрлэх, боловсролын байгууллага, багшийн үйл ажиллагаатайжж холбогдсон санал гаргах, хүүхдийнхээ мэдлэг, чадвар, авъяас, бие сэтгэхүйн талаар сургууль, багшаас

гаргасан тодорхойлолттой танилцах “эрх эдэлж,”...багштай хамтран ажиллах, ажил, мэргэжлээ зөв сонгоход туслах, ...сургууль, багшаас тавьсан сурган хүмүүжүүлэх шаардлагыг биелүүлэх, сурган хүмүүжүүлэх үйл ажиллагааны арга барил эзэмших” үүрэг хүлээх болсон байна.

Багшийн хувьд сургалт явуулах нөхцөл, бололцоогоор хангуулах, багшийн мэргэжлийн болон эрдмийн цол хүртэх эрхтэйгээс гадна багшийн ёс зүй, нэр төрийг эрхэмлэн шавь нараа үлгэрлэн дагуулах үүрэгтэй болжээ. Ингэснээр багшийн эрхийг нэмэгдүүлснээс гадна тэдэнд нийгмийн зүгээс тавих шаардлагыг өндөржүүлэх эрх зүйн үндсийг тогтоосон байна.

Монгол Улсын Үндсэн Хуульд “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно...” гэж заасан нь сургуулийн өмнөх болон бага, суурь, бүрэн дунд боловсролыг иргэн үнэ төлбөргүй эзэмших нийгмийн баталгаагаар хангагдаж, харин дээд боловсролыг төлбөртэй буюу төлбөргүйгээр эзэмших эрх зүйн зохицуулалтыг бий болголоо. Түүнчлэн ЕБС, МСҮТ (анхан шатны)-ийн дотуур байранд төлбөргүй суралцах, дээд боловсролын хувьд өнчин, амьжиргааны түвшин нэн доогуур өрхийн, хөгжлийн бэрхшээлтэй суралцагч, Төрийн албан хаагчийн нэг хүүхдийн сургалтын төлбөрийг төр хариуцахаас гадна нийтийн тээврээр хөнгөлөлттэй зөрчих, суралцагчийн онцгой авьяас, чадварыг урамшуулан дэмжих, хөнгөлөлттэй нөхцөлөөр зээл олгохтой холбогдсон нийгмийн баталгаа эдэлж байлаа. 2011 онд баталсан Дээд боловсролын санхүүжилт, суралцагчын нийгмийн баталгааны тухай хуулиар суралцагчдын сурлагын амжилтыг харгалзан төрөөс сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэх, бакалавр, магистрын сургалтад өдрөөр сурацагчид тэтгэлэг олгодог боллоо. Сурлага, спорт, урлагийн онцгой амжилт гаргасан суралцагчид Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Ерөнхий сайдын нэрэмжит тэтгэлэг олгохоор тогтоосон нь суралцагчдын авьяас чадварыг төрөөс хөхиүлэн дэмжиж байгаагийн нэгэн илэрхийлэл болжээ. Боловсролын энэхүү нийгмийн баталгаа нь өмчийн хэлбэр харгалзахгүй адил тэгш байна.

Боловсролын тухай хуульд зааснаар бүх шатны сургууль, цэцэрлэгийн багшид сурган хүмүүжүүлэх ажлын онцлогийг харгалзан 33 өдрийн нэмэгдэл амралт олгохоос гадна бүх шатны сургууль, цэцэрлэгийн захирал, эрхлэгч, орлогч захирал, хичээлийн эрхлэгч (сургалтын менежер), хичээлийн зохицуулагч, нийгмийн ажилтан, арга зүйч, дадлагын болон байрын багш, цэцэрлэгийн туслах багшид ажлын 15 өдрийн нэмэгдэл амралт эдэлдэг боллоо. Мөн 25 ба түүнээс дээш жил ажилласан бүх шатны сургууль, цэцэрлэгийн багш, захирал, эрхлэгчид

тэтгэвэрт гарахад нь 12 сарын үндсэн цалинтай тэнцэх мөнгөн тэтгэмж олгодог, хөдөөгийн сум, баг, хорооны сургууль, цэцэрлэгт ажиллаж байгаа байгууллагаас нь нэг удаа олгодог байсан бол энэ хуульд багш, захирал, эрхлэгчээс гадна дээрх ажлын 15 өдрийн амралт эдэлдэг албан тушаалтанд тэтгэвэрт гарахад нь уг буцалтгүй тэтгэмжийг олгохоор нэмэлт орууллаа. Мөн боловсролын салбарт ажилладаг багш, бусад ажиллагчид нь Хөдөлмөрийн тухай хууль, Тэтгэвэр, тэтгэмж, нийгмийн хамгааллын тухай хуулиуд болон бусад хууль тогтоомжид заасан нийгмийн баталгаанд нэгэн адил хамарагдаж байна.

Боловсролын эрх зүйн шинэчлэлд хийсэн судалгаанаас үндэслэн дор дурдсан дүгнэлт хийж болох юм:

1. 1990-ээд оноос хойш Боловсролын төрийн бодлого, эрх зүйн зохицуулалтыг бий болгож, жилээс жилд боловсронгуй болгож байгаа хэдий ч бодлогын залгамж холбоо алдагддаг, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, орчин, нөхцөлийг зохих түвшинд бий болгоогүй, биелэлтийн байдлыг бодитойгоор үнэлж, дүгнээгүйгээс хэрэгжилт нь хангалттай биш байна.
2. Бага, дунд боловсролын агуулга, бүтцийг олон улсын жишигт нийцүүлэн ЕБС-ийн 4+4+2 гэсэн бүтцийг өөрчлөн 5+4+2 гэсэн бүтцэд шилжүүлж, сургуульд элсэх насыг 8 байсныг 7 болгосон, улмаар 6 настай хүүхдийг сургуульд элсүүлэх, бага, дунд боловсролын сургалтын тогтолцоог 6+3+3 болгох эрх зүйн зохицуулалтыг бий болгосон нь Монгол Улсын бага, суурь, бүрэн дунд боловсролыг олон улсынхтай дүйцүүлэхэд зарчмын шинэчлэл болж байгаа ч энэхүү өөрчлөлтийг нарийн судалгаа, тооцоонд тулгуурлаагүй, нэг шилжилтийг дуусгаагүйгээр нөгөөг эхлүүлсэн нь багш, суралцагч болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад бэрхшээл учруулж байна.
3. Боловсролын үйлчилгээний чанар өнөөгийн нийгмийн эрэлт, нийлүүлэлтийн шаардлагыг төдийлөн хангахгүй байна. Дээд боловсролын нийгмийн үнэлэмж буурсаар байна. Энэ нь боловсролын үйлчилгээний чанарт шууд нөлөөлдөг үндсэн үзүүлэлт болох сургалтын агуулга, стандарт бүрэн шинэчлэгдээгүй, сургалтын арга зүй, үнэлгээний механизм боловсронгуй биш, хичээлийн болон дотуур байрын хангамж, хүрэлцээ, ахуйн нөхцөл, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, сурах бичгийн хангамж дутмаг, багшийн болон сургуулийн удирдах ажилтны чадавх шаардлагын түвшинд хүрээгүйтэй холбоотой байна.
4. Аль ч шатны сургууль нь суралцагчдын сэтгэл хангуулан суралцах, хөгжих, сургалт-судалгаа, соёл-хүмүүжлийн болон нийгэм-сэтгэл зүйн орчинг бүрдүүлж чадаагүй байна.

5. ЕБС-ийн ахлах ангиас эхлээд их, дээд сургууль, коллежийн оюутан, магистрант, докторантын 60-80 хувь нь эмэгтэйчүүд байгаа нь боловсролын хүйсийн тэнцвэрт байдал алдагдаж эхэлснийг харуулж байна.
6. Дээд боловсролыг хөгжүүлэх бодлого оновчтой биш, дээд боловсролын сургалтын байгууллагад тавих шаардлагыг нарийн баримтлаагүй, аттестатчилал, магадлан итгэмжлэлийг зохих ёсоор нь явуулаагүй, төрийн болон төр-олон нийтийн хяналт, үнэлгээг зохих түвшинд хийгээгүй зэргээс дээд боловсролын үнэлэмж, чанар, өрсөлдөх чадвар доогуур хэвээр байна.

Боловсролын магадлан итгэмжлэл

Монгол Улс ардчилал, зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн 30 шахам жилийн хугацаанд монголын боловсрол өмчийн олон хэлбэрт суурилан хөгжиж, хөрөнгө оруулалт хэд дахин нэмэгдэж дээд болон мэргэжлийн салбарт бодит хэрэгцээнээсээ давсан материаллаг баазыг бий болгосон. Гэвч сургалтын байгууллага бүр иргэдэд хүсэн хүлээсэн боловсролыг олгож чадахгүй байгаагаас олон нийт сайшаан магтахаас илүү шүүмжлэн хэлэлцэх давамгайлах хандлагатай байна. Асуудлын гол нь чанар байна. Чанар нь үргэлж хувьсан өөрчлөгдөж байдаг процесс юм.

Дэлхийн бүх улс орнуудад өндөр мэдлэг, ур чадвартай мэргэжлийн дээд боловсролтой хүмүүс хөгжлийн хурдыг тодорхойлж байдаг. БМИҮЗ сургалтын байгууллага, хөтөлбөрүүдээ олон улсын жишигт нийцүүлэх, дэлхийн иргэн хүнийг бэлтгэхэд өөрийн хувь нэмрээ оруулахыг зорин ажиллаж байна.

Магадлан итгэмжлэх үйл ажиллагаа нь боловсролын байгууллагын магадлан итгэмжлэл, боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөрийн магадлан итгэмжлэл, шинээр нээх сургалтын хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэл гэсэн үндсэн 3 хэлбэрээр явагддаг.

Байгууллагын магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын байгууллага Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын зэрэг олгох сургалтын хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.

Урьдчилсан магадлан итгэмжлэл нь тухайн боловсролын байгууллагын шинээр нээх сургалтын хөтөлбөр Боловсролын магадлан итгэмжлэх үндэсний зөвлөлөөс тогтоосон шалгуур, шаардлага (стандарт)-ыг хангаж буй эсэхэд эрх бүхий хөндлөнгийн этгээд хараат бус үнэлгээ хийж, чанарыг баталгаажуулж, дүгнэлт гаргах үйл ажиллагаа юм.

2000-2004 онд их, дээд сургууль, коллежийн тоо хамгийн оргил үедээ 185 хүрч байсан бол 2008-2010 онд 113 болтлоо, 2017-2018 оны хичээлийн жилд 96 болж буурсан. Үүнтэй холбоотойгоор магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын тоо буурч байсан боловч нийт сургуулиудын дунд магадлан итгэмжлэгдсэн сургуулиудын эзлэх хувь 67-98% болтлоо өсөж байв

Зураг 13. Дээд боловсролын салбарын өсөлт ба магадлан итгэмжлэлийн явц



2018 оны байдлаар Монгол улсад үйл ажиллагаа эрхэлж буй төрийн өмчийн 18 сургууль, төрийн бус өмчийн 75 сургууль, гадаадын сургуулийн салбар 3 сургууль, нийт 96 их, дээд сургууль, коллежуудаас 73 байгууллага буюу 78% нь магадлан итгэмжлэгдсэн.

Магадлан итгэмжлэгдсэн сургуулиудад нийт суралцагчдын 98% нь буюу 151 мянга гаруй оюутан суралцаж байна

2018 оны 11 дүгээр сарын байдлаар дээд боловсролын 73 сургалтын байгууллага магадлан итгэмжлэгдсэн бөгөөд үүнээс анх удаа магадлан итгэмжлэгдсэн 9 сургууль, хоёр дахь удаа магадлан итгэмжлэгдсэн 45 сургууль, гурав дахь удаа магадлан итгэмжлэгдсэн 19 сургууль байна. 2018 онд магадлан итгэмжлүүлэхээр өөрийн үнэлгээний тайлан бэлтгэж байгаа 21 сургууль байгаагаас анх удаа 1, хоёр дахь удаа 7, гурав дахь удаа 13 сургууль тус тус магадлан итгэмжлүүлэхээр бэлтгэж байна.


Хөтөлбөрийн магадлан итгэмжлэл

Хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн 78.0 хувийг төрийн өмчийн сургууль, 22.0 хувийг төрийн бус өмчийн сургууль эзэлж байна. Сургалтын хөтөлбөрийг шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, агуулга, арга зүйг сайжруулах, онол-практикийн

хичээлийн зохистой харьцааг бий болгох, үр дүнг бодитоор үнэлэхийн тулд дотоод чанарын хяналт, магадлан итгэмжлэлийн тогтолцоог боловсронгуй болгож, чанарын хяналтыг системтэйгээр хэрэгжүүлэх чиглэл барьж байна.

БМИҮЗ нь 2002 онд Боловсролын зэрэг олгох хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн журам, хөтөлбөрт тавигдах урьдчилсан шаардлагууд, баримтлах шалгуурууд, өөрийн үнэлгээ хийх чиглэлүүд, хөтөлбөрийн үнэлгээ хийх мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталж, 2003 оноос сургалтын хөтөлбөрийг магадлан итгэмжлэх ажил эхэлсэн. Өнөөдрийн байдлаар сургалтын хөтөлбөрт үнэлгээ хийх 10 мэргэжлийн зөвлөл байгуулагдан ажиллаж байна. 2004-2018 онд дээд боловсролын сургалтын байгууллагын нийт 236 хөтөлбөр магадлан итгэмжлэгдсэнээс төрийн өмчийн сургуулийн 184, төрийн бус өмчийн сургуулийн 52 хөтөлбөр байна.

Зураг 14. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрийн тоо



Зураг 15. Магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр, боловсролын зэргээр



Зураг 16. 2014-2018 онд магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөрүүдийг мэргэжлийн чиглэлээр харуулсан байдал




Урьдчилсан магадлан итгэмжлэл 2016 онд Боловсролын тухай хуулийн 21.6-д орсон нэмэлт өөрчлөлтөөр “Боловсролын сургалтын байгууллага шинэ хөтөлбөрөөр сургалт эрхлэхийн өмнө Боловсролын магадлан итгэмжлэх байгууллагаар урьдчилсан магадлан итгэмжлэл хийлгэнэ” гэж зааснаар Монгол

Улсын боловсролын салбарт шинэ хөтөлбөрийг нээхийн өмнө урьдчилсан магадлан итгэмжлэл хийх эрх зүйн орчин бүрдсэн.

БМИҮЗ-д 2017-2018 оны хичээлийн жилд 136 шинэ хөтөлбөрийн хүсэлт ирсэн бөгөөд тухайн үед Боловсролын тухай хуулийг хэрэгжүүлэх холбогдох журам хараахан батлагдаагүй тул хуулийн 21.2-т заасан тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаанд БСШУСЯ, БМИҮЗ-ийн хамтарсан ажлын хэсэг ажиллаж 36 хөтөлбөрт тусгай зөвшөөрөл олгох дүгнэлт гаргасан юм.

2017-2018 оны хичээлийн жилд 24 их, дээд сургуулиас 98 шинэ хөтөлбөрийн хүсэлт ирсэн. БМИҮЗ-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 8 дугаар тогтоолоор батлагдсан “Дээд боловсролын сургалтын байгууллагын хөтөлбөрт урьдчилсан магадлан итгэмжлэл хийх түр журам”, Хөтөлбөрийн урьдчилсан магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлагын дагуу урьдчилсан шаардлага хангасан 88 хөтөлбөрт 161 шинжээч ажиллаж, 42 хөтөлбөр “хангалттай” дүгнэлт өгсөн байна. Дээд боловсролын магадлан итгэмжлэх комиссын 2018 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн хуралдаанаар 42 хөтөлбөр дээр ажилласан шинжээчдийн дүгнэлтийг хэлэлцэж, ДБМИК дүгнэлтээ БСШУСЯ-нд хүргүүлсэн.

Зураг 17. Урьдчилсан магадлан итгэмжлэлийн хөтөлбөр, 2017-2018



итгэмжлэгдсэн их, дээд болон мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагууд чанарын баталгаажуулалтын хөндлөнгийн байгууллагаар үнэлгээ хийлгэн олон улсад хүлээн зөвшөөрөгдөж, дэлхийн боловсролын зах зээлд гарч ирсэн нь онцлох үйл явдал мөн.


Өнгөрсөн хугацаанд БМИҮЗ нь чанарын баталгаажуулалтын хамгийн том сүлжээ байгууллага болох Дээд боловсролын чанарын баталгаажуулалтын агентлагуудын олон улсын сүлжээ (INQAАНЕ)-нд жинхэнэ гишүүнээр 1999 онд элссэн бөгөөд мөн Ази, Номхон далайн бүсийн орнуудын Чанарын Сүлжээ (The Asia Pacific Quality Network) –ийн жинхэнэ гишүүнд 2005 онд, Олон улсын чанарын

групп (CIQG)-ийн гишүүн байгууллагаар 2013 онд тус тус элссэн. Мөн 2005 оны 12 дугаар сард APACC буюу Ази, Номхон далайн бүсийн Магадлан итгэмжлэл ба Батламжлалын Комисстой хамтран ажиллах санамж бичигт анх удаа гарын үсэг зурснаас хойш одоог хүртэл идэвхтэй хамтран ажиллаж, 4 мэргэжлийн боловсролын сургуулийг магадлан итгэмжлүүлээд байна.

Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагаар (APACC, ACBSP, AWEWPR, ASIIN) нийт – 15 сургуулийн 19 сургалтын хөтөлбөр магадлан итгэмжлэгдээд байна.

Төрөөс БМИҮЗ-ийг бие даасан мэргэжлийн байгууллага болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх үйлчилгээг ил тод түргэн шуурхай байлгах бодлого барьж байна. Сургалтын хөтөлбөрийн чанар, үр дүнг бодитоор үнэлэхийн тулд Боловсролын магадлан итгэмжлэлийн үндэсний зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, олон улсад болон дотоодод хүлээн зөвшөөрөгдсөн шинжээч нарыг бэлтгэх, дээд боловсролын байгууллагын дотоод чанарын баталгаажуулалтын тогтолцоог хөгжүүлэх ажлууд хийгдэж байна.

Зураг 18. Олон улсад магадлан итгэмжлэгдсэн хөтөлбөр



Цаашид боловсролын чанар, баталгаажуулалтыг хөгжүүлэхийн тулд БМИҮЗ-ээс “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал”-д тусгагдсан урт хугацааны хөгжлийн зорилтуудыг баримтлахын зэрэгцээ богино, дунд хугацаанд дараах чиглэлүүдийг баримтлан ажиллахаар төлөвлөж байна. Үүнд:

Улсын их хурал 1995 онд боловсролын багц хуулийг шинээр батлахдаа “Боловсролын магадлан итгэмжлэх байгууллага нь бага, дунд дээд боловсролын сургалтын байгууллагын сургалт, эрдэм шинжилгээний ажилд магадлан шинжилгээ хийж, сургалтыг эрхлэх шаардлага хангаж байгаа эсэх талаар шийдвэр гаргах эрхтэй...байгууллага байна” гэж хуульчилж байсан. Иймд магадлан итгэмжлэл бага, дунд дээд боловсролын сургалтын байгууллагын хүрээнд өргөжих болно.

Магадлан итгэмжлэлийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг эхний шатанд Ази-Номхон далайн орнуудын нийтлэг стандартад нийцүүлэн, их, дээд сургууль, мэргэжлийн сургууль, мэргэжлийн боловсролын сургалтын байгууллага гэсэн ангиллаар, сургалтын хөтөлбөрт тавигдах шаардлага, шалгуурыг мэргэжлийн чиглэл бүрээр ялгавартай боловсруулан үндэсний стандарт болгон баталгаажуулан хэрэгжүүлэх, тасралтгүй сайжруулах хэрэгцээ амьдралаас урган гарч байна.

Олон улсын магадлан итгэмжлэлийн байгууллагуудаас хамгийн найдвартай, чанартайг нь сонгон хамтран ажиллаж, монголын боловсролын чанарыг дээшлүүлж, олон улсад хөрвөх чадварыг нь нэмэгдүүлэх хүчин зүйл, хүчирхэг хөшүүрэг болгох нь онцгой чухал байна.

Хамгийн өндөр тавьдаг хэрэглэгчийн хэрэгцээг нээлттэй хангаж, боловсролын глобал зах зээлийн өрсөлдөөнийг даван гарч, тасралтгүй хөгжих нь боловсролын байгууллагуудын эрхэм зорилго юм. Дээд болон мэргэжлийн боловсролын салбарт хөндлөнгийн үнэлгээ, чанарын баталгаажуулалт зонхилж байгааг анхаарч сургалтын байгууллага бүр чанарын дотоод хяналт, үнэлгээний системийг бүрдүүлэн хоёр талаас тэгш оролцоотой хамтран ажиллах шаардлагатай байна.

Боловсролын салбарт шинжлэх ухаанд суурилсан шинэчлэлт, өөрчлөлт тасралтгүй явагдаж байх нь зүй тогтол юм. Өдөр тутам шинэ ойлголт, арга ажиллагаа, технологийг эзэмшин нэвтрүүлж байж хүсэн хүлээсэн үр дүнд хүргэхийг зорин ажиллаж байна.

Даяаршилд боловсролын орон зай хил хязгааргүй, улам бүр үндэстэн дамнасан шинжтэй болж байна. Хил хязгааргүй боломж нь бас хил хязгааргүй асуудлыг дагуулж байна. Асуудлыг хил хязгаарт үл баригдан шийдвэрлэхэд магадлан итгэмжлэлийн үүрэг, үндэстний хэмжээнд төдийгүй олон улсын түвшинд улам бүр өсөн нэмэгдэж байна.

Сурах бичиг

Монгол үндэснийхээ боловсрол, сургалтын түүхэн өв, туршлагыг нухацтай судлах, ашиглах, хэрэглэх үндсэн дээр өнөөгийн боловсрол, сургалтын чанарыг сайжруулах нь бас нэг чухал арга зам юм. Үүнийг харгалзан бид орчин үеийн Монголын боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх ухааны түүхэнд харьцангуй бага судлагдсан ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний шинэхэн өв уламжлал хийгээд хөгжлийн замнал, хандлагыг баримт бичгийн болон систем шинжилгээ, түүхэн зүйн аргаар судалсан юм.

XXI зууны суралцагчийн хувийн болон нийгмийн хэрэгцээ нь тасралтгүй суралцах, тэгэхдээ суралцаж сурах, сурах арга барил эзэмших, үүнийхээ үр дүнд өөрийн хөгжил, төлөвшлийг хангахад оршдог. Энэ хэрэгцээг нь хангахад сургалтын олон төрөл хэрэглэгдэхүүн, түүний дотор сурах, сургах үйлийн тогтолцооны загвар, удирдамж болох сурах бичиг чухал байр эзэлнэ. Сурах бичиг бол суралцагчийн сурах, судлан шинжлэх, асуудал шийдвэрлэх, гэгээрэх, төлөвших үйлийн хөтөч хэрэглэгдэхүүн юм. Нөгөө талаар сурах бичиг нь тухайн улс үндэстний хөгжлийн түвшний илэрхийлэл, оюуны баялаг, боловсролын өрсөлдөх чадвар, соёлын нэгэн чухал үзүүлэлт болдог. Иймээс сурах бичгийг шинжлэх ухаан, боловсрол, сургалтын тодорхой бодлого, үндэслэлтэй зохиох, хяналт шинжилгээ хийх, бодитой үнэлэх шаардлагатай байгаа юм. Түүнчлэн сурах бичиг нь үндэсний баялаг, оюуны бүтээл, сургалтын чухал хэрэглүүр болохын зэрэгцээ санхүү хөрөнгө ихээхэн шаарддагийн хувьд ч чанартай, тогтвортой байлгах, залгамж холбоотойгоор хэрэглэх, цаашид улам боловсронгуй болгоход ч сурах бичгийн цогц судалгаа зайлшгүй хэрэгтэй байгаа билээ.

Ийм учраас бид ялангуяа, Монгол улсын ардчилсан Үндсэн хууль батлагдсан 1992 оноос 2017 он хүртэлх 25 жилд Монголын боловсролын сургалтын чухал хэрэглэгдэхүүн үндэсний сурах бичгийн байдал, хөгжил ямар байв?, ололт амжилт, бэрхшээл, сургамж юу байв? гэдэгт дүн шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгөх нь боловсрол, сургалтын ойрын болон ирээдүйн хөгжилд чухал ач холбогдолтой юм.

Сурах бичиг нь ЕБС-ийн хичээл, сургалтын үндсэн хэрэглэгдэхүүний нэг учир төр засгаас анхаарч, түүнийг нийгмийн өөрчлөлт, боловсролын хөгжлийн дагуу байнга боловсронгуй болгож, бас шинэчлэн сайжруулсаар ирсэн. Судлаачид сурах бичгийг олон янзаар тодорхойлсон байдаг. “Сурах бичиг нь боловсролын стандарт ба киррикулимийг хэрэгжүүлэх зориулалттай суралцахуй ба

багшлахуйн нэгдлийг хангахад шаардлагатай онол, арга зүйн үндэс бүхий дидактик шийдлийг цогцоор хэлбэржүүлсэн сургалтын үндсэн хэрэглэгдэхүүн юм.⁸⁶” гэж Бага, дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага буюу стандартад тодорхойлсон байна.

Монголын орчин цагийн сургуулийн сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүн ялангуяа, ерөнхий боловсролын сурах бичгийн хөгжлийн түүхэн байдалд тойм шинжилгээ хийхэд, тухайлбал, 1921-1926 онд ”Ертөнцийн байдал”, “Монгол үсгийн цагаан толгой”, “Балар цагийн түүх” зэрэг сурах бичгийн шинжтэй ном, гарын авлагуудыг зохион хэрэглэж байсан ба мөн 1949 онд үндэсний монгол бичгээр хэвлэгдсэн сурах бичгийг кирилл бичигт хөрвүүлэн, ЗХУ-д хэвлэж ашиглаж байсан бөгөөд 1950-аад оноос эхлэн ЗХУ-ын ерөнхий боловсролын сургуулийн математик, физик, хими, ургамал судлал, амьтан судлал, түүх, газарзүйн сурах бичгүүдийг орчуулан хэрэглэсэн, 1960-аад оны эхнээс бага, дунд сургуулийн сурах бичгийг өөрсдөө бие даан зохиох болж, улмаар 1970-аад оноос ерөнхий боловсролын бүх сурах бичиг үндэсний зохиогчтой болсон нь манай улсын боловсрол, сургалтын хөгжилд гарсан томоохон ололтын нэг юм.

1950-аад оноос эхлэн ЗХУ-ын ерөнхий боловсролын сургуулийн математик, физик, хими, ургамал судлал, амьтан судлал, түүх, газарзүйн сурах бичгүүдийг орчуулан хэрэглэж эхэлсэн нь сурагчдад тухайн шинжлэх ухааны агуулгыг эх хэлээрээ судлах боломжийг олгохын зэрэгцээ ерөнхий боловсролын түвшин бүрийн агуулга, арга зүйн хүрээг тодорхойлоход тус дөхөм болжээ. Гэсэн хэдий ч үндэсний зохиогчдын зохиосон сурах бичигт Оросын холбооны улсын (хуучнаар ЗХУ) ЕБС-ийн сурах бичгийн агуулга, зохиомжийг хуулбарлах, Монголын нам, төрийн тухайн цаг үеийн бодлого, шийдвэрийг тусгах хандлага давамгайлж байжээ. Ийм учраас үндэсний зохиогчид өөрийн улс орны онцлог, байгаль цаг уурын нөхцөл, хүмүүсийн ажил, хөдөлмөрийн хуваарилалт, зан заншил, түүх, соёлын үнэт зүйлсийг тусгаж, сурах бичгийн агуулгыг сайжруулах талаар санал бодлоо дэвшүүлж байсан байна.

1990-ээд оноос эхлэн нийгмийн өөрчлөлттэй холбоотойгоор сурах бичигт дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлагыг баримжаалан үндэсний түүх, соёлын үнэт зүйлсийг тусгах, түүнийг сурагчдын хэрэгцээ, сонирхолд нийцүүлэн зохиох зайлшгүй шаардлага тулгарч байв. Нийгмийн тогтолцооны өөрчлөлт, шилжилттэй холбоотойгоор сурах бичиг зохиох үзэл баримтлал, хандлага,

⁸⁶ Бага дунд боловсролын хэвлэмэл сурах бичигт тавих шаардлага. MNS 5418:2008

үнэлэмж өөр болсон хийгээд зах зээлийн эдийн засагт шилжиж буй шилжилтийн үед хэвлэх цаас, бусад бараа материалын хомсдол, үнийн өсөлт зэргээс үүдэн ЕБС-ийн сурах бичгийг шинэчлэх ажил зогсонги байдалд орж, сурагчдыг сурах бичгээр хангаж чадахгүйд хүрч байжээ. 1994 онд С.Шарав нарын зохиосон нэгдүгээр ангийн “Цагаан толгой”, 1998 онд О.Пүрэв нарын зохиосон IX-X ангийн Нийгмийн тухай мэдлэг гэх мэт цөөн тооны сурах бичиг зохион, хэвлэж хэрэглэж байв.

1992 оноос хойш ерөнхий боловсролын сурах бичгийн зохиолт, түүний агуулга, арга зүй болон хуваарилалт, түгээлт, хангалт, хүртээмжийн байдалд гарсан өөрчлөлт, хөгжил, бас бэрхшээлийг Монгол улсын засгийн газруудын чиг үүргийн хамрах хүрээ болон бодлого, үйл ажиллагааны өөрчлөлтөөр нь голлох шалгуур болгон дараах 6 үе шатанд хуваан үзэж болохоор байна. Үүнд:

1. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагааны бэрхшээл ба шилжилтийн эхлэл (1992-1996 он)
2. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагааг шинээр дэвшүүлж, хэрэгжүүлж эхэлсэн үе (1996-2000 он)
3. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагаа тогтворжиж эхэлсэн үе (2000-2004 он)
4. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагаанд стандарт хэрэгжиж, хувилбарт сурах бичигтэй болсон үе (2004-2008 он)
5. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагаанд төрийн тодорхой зохицуулалт хэрэгжсэн үе (2008-2012 он)
6. Сурах бичгийн бодлого, үйл ажиллагаа суралцахууд баримжаалан хөгжсөн үе (2012-2016 оныг дуустал) хэмээн ангилж болно.

Ерөнхий боловсролын сургуулийн бүх хичээлийн агуулгыг 1991-1995 онд өөрчлөх, шинэчлэхэд дор дурдсан зарчимд тулгуурласан байна. Үүнд:

- Үндэсний соёл, зан заншил, оюуны өв уламжлалын тулгамдсан асуудлыг тусгахын хамт хүн төрөлхтний соёлын ололтод тулгуурлан баяжуулах,
- Улс төржсөн, үзэл сурталжсан байдлаас ангижруулах,
- Шинжлэх ухаан, техник, технологийн шинэ ололт, байгаль, эдийн засаг, экологийн орчин үеийн асуудлуудыг бүтээлчээр тусгах,
- Боловсрол эзэмшихэд нэн шаардлагатай шинжлэх ухааны тулгуур онол, хууль, ухагдахуун, таамаглал, төсөөлөл, баримтыг сонгон судлуулах,

- Мэдлэг, чадвараа амьдралд хэрэглэх дадал эзэмшүүлэх асуудлыг хүчтэй болгох замаар хичээлүүдийн онолын болон хэрэглээний чиглэлийг зохистой хослуулах,
- Сурагчдын нас, бие, сэтгэхүйн онцлогт тохируулан интеграцичлах болон төрөлжүүлэх зарчмыг зохистой хослуулах,
- Шинжлэх ухааны танин мэдэхүйн арга судлалд тулгуурласан сургалтын арга технологийг нэвтрүүлэх,
- Сургалтыг Монгол бичгээр явуулах арга технологийг боловсруулан хэрэгжүүлэх,
- Мэдээллийн техник, сургалтын хэрэглэгдэхүүнийг өргөн ашиглах зэрэг болно.

Ерөнхий боловсролын хичээлүүдийн агуулгыг тодорхойлоход баримталсан эдгээр нийтлэг зарчмуудыг тухайн үеийн сурах бичгүүдийн агуулга, арга зүйд мөн нэгэн адил мөрдсөн байна. 1994 оноос Дани улсын засгийн газрын тусламжийн хүрээг өргөтгөх "Сурах бичиг, хэвлэх, цаас, хэвлэлийн тоног төхөөрөмжөөр хангах" асуудлыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

1996 онд УИХ-аас баталсан "Монгол улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр"-т Боловсролын стандартад тохирсон олон хувилбартай сурах бичгээр хангах оновчтой тогтолцоог бий болгоно. Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг шинэчлэнэ. Нийгмийн ухааны сургалтын агуулгыг хүмүүнлэг, ардчилсан нийгмийн иргэн төлөвшүүлэх хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн үзэл суртлын аливаа нөлөөллөөс ангижруулан шинэчилж, суралцагчдад чөлөөтэй сонголт хийх боломжийг хангана. 1998 он гэхэд ерөнхий боловсролын сургуульд хэрэглэж байгаа нийгмийн ухааны хичээлийн найман төрлийн сурах бичгийг 2-3 хувилбартайгаар шинэчлэн зохиож хэвлүүлнэ. Сурах бичгийг шинээр зохиох, хэвлүүлэх, түгээх арга механизмыг боловсронгуй болгоно" хэмээн заасан байна.

2002 онд УИХ-аас шинэчлэн найруулсан Боловсролын багц хуульд ерөнхий боловсролын бүтцийг дэлхийн улс орны ерөнхий боловсролын сургуулийн бүтцэд нийцүүлэх эхлэлийг тавих зорилгоор 11 жилийн сургалтын тогтолцоонд шилжүүлэхээр заасан.

2006 оны Боловсролын багц хуульд ерөнхий боловсролын сургалтыг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх, түүний бэлтгэлийг хангах үүднээс суралцагчдын нас, сурах орчин, нөхцөл, сурах бичгийг ерөнхий боловсролын шинэ стандарттай уялдуулахаар заасан байна. Ерөнхий боловсролын сургуулийн 11 жилийн сургалтын төлөвлөгөөг 2005-2006 оны хичээлийн жилээс хэрэгжүүлж, бага болон

ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд өөрчлөлт оруулсан байна. Боловсролын хөгжлийн хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнд “Сурах бичиг зохиох, хэвлэх, түгээх шинэ арга технолог”-ийг бий болгосны зэрэгцээ дээд сургуулиудын номын санг мэдээллийн орчин үеийн төв болгон шинэчлэжээ. Мөн ЕБС-ийн 40 шахам, дээд боловсролын 70 гаруй сурах бичгийг шинээр хэвлэсэн байна. 2007-2008 оны хичээлийн жилээс эхлэн БСШУЯ ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийн талаар баримтлах бодлого, стандартыг боловсронгуй болгох, сурах бичгийг шинэчлэх ажлыг үргэлжлүүлэн, түүний хүрэлцээ, хангамжийг сайжруулах тухай шийдвэр гаргасан.

Хэвлэмэл сурах бичигт тавигдах стандартыг Стандартчилал, Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2008 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн 06 тоот тогтоолоор батлажээ. Энэхүү стандартад бага, дунд боловсролыг албан, албан бус арга замаар эзэмшигчдэд хэрэглэх сурагчийн хэвлэмэл сурах бичгийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, хэвлэлийн эхэд ба бэлэн болсон сурах бичигт үнэлгээ өгөх үйл ажиллагаа явуулахад баримтлах нийтлэг болон тусгай шаардлагуудыг тодорхойлсон байна. Стандартыг сурах бичгийн үндсэн хэрэглэгчид, судлаач, зохиогч, шинжээч, бодлого боловсруулагч, шийдвэр гаргагч, ном, хэвлэлийн салбарын ажилтан, хэвлэлийн газар, хэвлэх үйлдвэрийн мэргэжлийн хүмүүст зориулсан байна. Уг стандартад сурах бичиг, дэвтэр, атлас, хэвлэмэл дидактик материал, сурах бичиг дэх хавчуулга хуудсууд зэрэг хамаарна гэж тодорхойлсон байна. Энэхүү стандарт хэрэгжсэн нь сурах бичгийн чанарыг сайжруулахад том алхам болжээ. Сурах бичиг, сургалтын материал, мэргэжлийн мэдээллийн хүртээмж, чанар, электрон эх сурвалжийн хүртээмжийг нэмэгдүүлэв. 2009 оноос ерөнхий боловсролын сурах бичиг зохиох баг шалгаруулах, зохиолгох ажлыг БСШУЯ, түүний харьяа Боловсролын хүрээлэн хариуцах болов. Энэ оноос эхлэн бага ангийн сурах бичгийг төрөөс 100 хувь үнэ төлбөргүйгээр номын сангаар дамжуулан хангав. Дунд болон ахлах ангийн сурах бичгийн 40 хүртэл хувийг төрөөс үнэ төлбөргүйгээр хангаж, ЕБС-д хэрэглэх шинэ сурах бичгийн эхийг электрон хэлбэрээр Вэб сайтад байрлуулсан байна.

Сургуулийн номын сангаар дамжуулан сурагчдад үнэгүй хэрэглүүлэх дээрх бүх сурах бичгийн хуваарилалт, түгээлт, ашиглалтад тогтмол хяналт шинжилгээ хийх, бага ангийн сурагч бүр хичээл бүрээр сурах бичигтэй байх, дунд, ахлах ангийн сурагчдыг өрхийн амьжиргааны түвшнээс хамааруулан үнэгүй хэрэглэх сурах бичгээр хангах, эрэлтэд нь нийцсэн сурах бичиг худалдан авах боломжийг бүрдүүлэх бодлогыг амьдралд хэрэгжүүлэх арга механизмыг бий болгожээ.

2004 онд сурах бичигт тавих шаардлагыг анх удаа стандартчилсан байна. Стандартчилал, Хэмжил зүйн Үндэсний Зөвлөлийн баталсан “Бага дунд боловсролын сурах бичигт тавих шаардлага MNS 5418:2004”-аар ЕБС-ийн сурагчдын хэрэглэх хэвлэмэл сурах бичгийг зохиох, хэвлэлийн эх бэлтгэх, хэвлэх, бэлэн болсон сурах бичигт үнэлгээ өгөхөд баримтлах нийтлэг болон тусгай шаардлагуудыг тогтоосон. Стандарт шаардлага нь сурах бичгийн чанарыг үнэлэх үндсэн хэмжүүрийг тогтоосноороо онцлогтой. Нэгэнт сурах бичгийн стандарт батлагдан гарсан тул 2004 оноос эхлэн хэвлэлийн газар “төв”-тэй сурах бичгийн бодлого хэрэгжиж эхэлсэн бөгөөд сурах бичгийн эх зохиох, хэвлэх, түгээх ажлуудыг хэвлэлийн газрууд эрхлэх болсон. Хэвлэлийн газрууд зохиогчийн баг бүрдүүлж, сурах бичгээ зохиож, сонгон шалгаруулалтад оролцох эрх зүйн зохицуулалт хийгдсэн юм. Шалгарсан сурах бичигт хэвлэх эрх олгосноор нэг ангийн 2-3 хувилбартай сурах бичгээс багш, сурагч сонголт хийж, сонгосон сурах бичгийг хэвлэн, түгээх болсон. Гэсэн ч Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хэвлэлийн ХХК буюу газруудын тухайн хүрээний үйл ажиллагааны аль алины төлөвшил, соёлын дутагдал, хомсдлоос үүдэлтэйгээр энэ үед сурах бичгийн агуулгын бодлого алдагдах, цаг хугацаандаа сурагчдын гарт очихгүй байх, үнэ өсөх, үнийн бодлого алдагдах, хангалт хүртээмж буурах, түүнийг хянаж чадахгүй болох зэрэг сөрөг үр дагаврууд үүсэн гарч байв. Эдгээр сөрөг үр дагавар, үзэгдлүүдийг арилгаж, сурах бичгийн чанарыг сайжруулах, үнийг тогтворжуулах, хангалт, хүртээмжийг нэмэгдүүлэх талаар төрөөс зохицуулалт хийх зайлшгүй шаардлага тулгарав.

Энэ үүднээс Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичиг зохиох, хэвлүүлэх, түгээх журмыг БСШУ-ны сайдын 2009 оны 131 дугаар тушаалаар баталсан нь бодлогын шинжтэй эрх зүйн зохицуулалт байв. Уг тушаалаар дараах зүйлүүдийг зохицуулсан байна. Үүнд:

- 2009-2010 оны хичээлийн жилээс эхлэн ЕБС-ийн сурах бичиг зохиох, хэвлэх, нийлүүлэх үйл ажиллагаанд бодлого, эрх зүйн энэхүү баримт бичгийг тогтвортой мөрдөх
- Ерөнхий боловсролын сургалтад ашиглах сурах бичиг нь хувилбаргүй, улсын хэмжээнд нэг сурах бичгийг ашиглах
- Сурах бичгийн агуулга, зохиогчийн эрх, хэвлэн нийтлэлийн бусад эрхийг төр эзэмших

- Сурах бичгийн түрээсийн болон хуримтлалын оновчтой тогтолцоог бий болгох
- Төрөөс хангах сурах бичгийг зорилтот бүлэгт чиглүүлэх зэрэг болно.

Уг журмын дагуу сурах бичгийн эх зохиох, хянах, хэвлэх, түгээх ажлыг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохицуулах болов. Улмаар сурах бичгийн зохиогчдыг шалгаруулах урилгыг олон нийтэд нээлттэй зарлах, шалгаруулалтаар сонгох, эх зохиох, хянах, хэвлэхэд бэлэн болох бүхий л үйл ажиллагааг Боловсролын хүрээлэн мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж ажиллах болсон байна. Тухайлбал, БСШУ-ны сайдын 2009 оны 131-р тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн сурах бичгийг зохиох, хэвлүүлэх, түгээх журам”-ын 2.2-ыг үндэслэн сурах бичгийн зохиогчийн багийг дараах шаардлагын дагуу шалгаруулж байна. Үүнд:

- Зохиогчийн багийн гишүүдийн анкет
- Боловсролын болон мэргэжлийн зэргийг гэрчлэх баримт бичиг (Нотариатаар баталгаажуулсан байх)
- Тухайн боловсролын болон ЕБС-ийн сурах бичиг, сургалтын чиглэлээр гаргасан бүтээлийн жагсаалт (сүүлийн 5 жилээр)
- Зохиогчийн багийн ахлагчийн захидал (Захидалд багийн гишүүдийн ажлын чиг үүргийг тодорхойлон, сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээ, зохиомжийн шинэлэг санааг тусгасан байх)
- Зохиох сурах бичгийн тодорхой нэг сэдвийн боловсруулалт (2-4 нүүр байх)
- Зохиогчийн баг 5-аас доошгүй гишүүнтэй байх бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
 - Тухайн боловсролын болон тухайн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн гишүүнтэй байх;
 - Тухайн боловсролын агуулга, арга зүй, дидактикаар мэргэшсэн гишүүнтэй байх;
- Сурах бичгийг сургалтын практикт ашигладаг гишүүнтэй байх; зэрэг болно.

Ингэснээр ЕБС-ийн бүх сурагч нэг ижил төвшний сурах бичиг хэрэглэж эхэлсэн бөгөөд сурах бичгийн агуулгын ялгаатай байдал арилж, сурах бичиг цаг хугацаандаа хэрэглэгчдэд хүрэх боломж бүрджээ. Мөн сурах бичгийн үнэ буурч, үнэд хяналт тавих боломжтой болсон бөгөөд хангалт, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дорвитой ахиц гарсан аж. Тухайлбал:

2008-2014 онд ерөнхий боловсрол 12 жилийн тогтолцоонд шилжиж, 6 настай хүүхэд нэгдүгээр ангид элсэн суралцах болсонтой холбоотойгоор сургалтын хөтөлбөрт агуулгын шилжилт, арга зүй, үнэлгээний сайжруулалт хийх хэрэгцээ,

шаардлагын дагуу сурах бичгийн шинэчлэл хийгдсэн байна. 12 жилийн үндэсний хөтөлбөрийн I-XII ангийн сурах бичгийг тодорхой графикийн⁸⁷ дагуу шинэчлэн, хэвлэв. Тухайн хичээлийн жил эхлэхээс өмнө шинээр хэвлэгдсэн сурах бичгийг хугацаанд нь түгээдэг болсон байна.

- Сурах бичгүүдийг БШУЯ-ны цахим хуудсанд байршуулж эхэлсэн.
- 2013 оноос эхлэн сурах бичгийг багшийн номтой хамтад нь зохиож, хэрэглэх болсон.
- Англи хэл, хөгжмийн сурах бичгийн нэмэлт хэрэглэгдэхүүн болох CD-г хамтад нь хэвлэдэг болов.
- БШУ-ны сайдын 2013 оны А/155 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтаар баталсан “Бага, дунд боловсролын шинэчлэлийн ерөнхий зураглал”-ын дагуу 2014 оноос эхлэн сургалтын цөм хөтөлбөрийн үзэл санаа, агуулга, арга зүй, үнэлгээг хэрэгжүүлэхээр сурах бичгийн шинэчлэл хийгдсэн байна.
- 2017-2018 оны хичээлийн жилийн байдлаар I-V ангид 6-9 хичээлийн 33 сурах бичиг, VI-IX ангид 12-17 хичээлийн 55 сурах бичиг, X-XI ангид 15 хичээлийн 25 сурах бичиг шинээр зохиож, хэрэглэж байна. Үүний зэрэгцээ VI-IX ангид 12 жилийн үндэсний хөтөлбөрийн дагуу зохиосон 7 сурах бичиг, X-XI ангид 5 сурах бичиг, XII ангид 10 сурах бичиг хэрэглэж байна.
- Тусгай хэрэгцээт бага боловсролын монгол хэл, математикийн сурах бичгийг зохиож, хэвлэснээр хөгжлийн бэрхшээлтэй суралцагчдын онцлог, тэдний хэрэгцээнд нийцсэн сурах бичгээр хангах боломжтой болсон.
- Үндэстний цөөнх (казах хүүхэд)-ийн боловсролын үйлчилгээний чанарыг сайжруулах, тэдний сурч боловсрох эрхийг хангах зорилгоор Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн сурагчид эх хэл, уран зохиолоос бусад хичээлээр Казакстан улсын сурах бичиг хэрэглэж ирсэн уламжлалаас татгалзаж манай улсад зохиож, хэвлэсэн сурах бичгийг ашиглах бодлогын дагуу VI-VIII ангийн “Казах хэл, уран зохиол” сурах бичгийг зохион хэвлүүлж, сургалтад хэрэглэж байна.
- Бага ангийн сурах бичгүүдийг казак, тува хэл дээр орчуулан хэрэглэж байна.
- Гадаадад суугаа монгол иргэдийн хүүхдүүдэд зориулсан монгол хэлний цахим сурах бичиг, багшийн гарын авлагыг боловсруулж байна.

ЕБС-ийн анги бүрийн бүх судлагдахууны сурах бичгийг зохиож, хэвлэхэд 5-7 жил зарцуулдаг. Мөн тухайн жилд суралцах сурагчдын тооны өсөлт, сурах бичгийн элэгдэл, хорогдол зэргийг тооцон нөхөн хангалтаар нэмж хэвлэдэг. Энэ нь олон

⁸⁷ БСШУ-ны сайдын 2007 оны 461 дүгээр тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн сурах бичиг шинэчлэлийн график”

нийтийн зүгээс сурах бичгийг жил болгон хэвлэж, улсын хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байна гэх шүүмжлэлтэй тулгардаг байна. Мөн сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичиг зохиох ажлыг зэрэгцүүлэн хийж байсан нь хүний нөөц, цаг хугацаа, санхүү хөрөнгийн хязгаарлагдмал байдал үүсгэж, улмаар сурах бичиг цаг хугацаандаа сурагчдын гарт очихгүй байх бэрхшээл гарч байжээ.

Сурах бичигт боловсролын түвшний анги бүрийн сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүй, үнэлгээний үзэл санааг сурагчдын нас, бие, сэтгэхүй, танин мэдэхүйн онцлогт тохируулан боловсруулахад анхаарч байна. Сүүлийн жилүүдэд сурах бичиг нь зөвхөн мэдээллийн үндсэн эх сурвалж байдгаа больж, суралцагч төвтэй сургалтад суралцагч өөрөө мэдлэг бүтээх, суралцахуйг хөтлөх, хөгжүүлэх хэрэгсэл болж байна.

Энэ утгаараа сурах бичгийн арга зүйн шийдэл, дасгал, даалгаврын тавил, зураг дүрслэлийн зохиомж зэргийг тасралтгүй сайжруулсаар иржээ. Тухайлбал, 2006 онд хэвлэгдсэн ЕБС-ийн IV ангийн нийгмийн ухааны хичээлийн сурах бичигт “Би хэний удам бэ?” сэдвийг Чингис хааны удам, есөн үеийн нэршлийн талаарх мэдээллийг уншаад, түүний дагуу асуултад хариулахаар даалгаврыг боловсруулсан байдаг бол одоо хэрэглэж буй сурах бичигт сурагч өөрийгөө танин мэдэх, ойлгох, үнэлэх суралцахуйн зорилтын хүрээнд “Би гэр бүлийн гишүүн” сэдвийг нэгэн сурагчийн тухай тохиолдол уншаад, өөрийн уг, удмын талаар эргэцүүлэн бодож ярилцах, өөрийн гурван үеийн угийн бичгийг зураглах даалгавар гүйцэтгэхээр боловсруулсан нь сурагч өөрөө хийж гүйцэтгэх үйлийн явцад суралцах, хөгжих арга зүйн шийдлээр боловсруулсан онцлогтой байна.

Сурах бичигт тавигдах стандарт шаардлагыг 2008 онд шинэчилэн баталсан бөгөөд уг шаардлагын дагуу эх хянах шалгуурыг агуулга, арга зүй, үнэлгээ, дизайн, хэл найруулга гэсэн бүтэцтэйгээр боловсруулж хэрэглэж байна. Үүнийг сурах бичгийн эхийг хянах шалгуур хуудас болгон ашигладаг.

Сурах бичиг зохиох багийг нээлттэй шалгаруулалтаар сонгодог бөгөөд баг тухайн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшсэн, заах арга зүйн чиглэлээр мэргэшсэн, сурах бичгийг ЕБС-д практикт хэрэглэдэг гишүүдтэй байхыг шаарддаг. Өнөөдрийн байдлаар сурах бичиг зохиогчдын багийн гишүүдийн 29 хувийг ЕБС-ийн багш, 33 хувийг их, дээд сургуулийн багш, үлдсэн 38 хувийг бусад мэргэжлийн байгууллага (БХ, БМДИ, НБГ, БҮТ, бусад хүрээлэн, ТББ)-ын төлөөлөл бүрдүүлж байна.

Гэвч сурах бичигт салаа утгатай агуулга хийгээд арга зүйн шийдэл нь дутмаг, оновчгүй, ойлгомжгүй, хариу нь тодорхой бус дасгал даалгавар, найруулгын болон зөв бичих дүрмийн алдаа гарах зэрэг дутагдлууд оршсоор байна. Одоо хэрэглэж буй сурах бичигт тавих шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсронгуй болгох хэрэгтэй байна.

Одоогийн байдлаар тусгай хэрэгцээт боловсролын сурах бичигт тавих тусгай шаардлага, шалгуур байхгүй байна. Сурах бичгийн агуулга, арга зүй, үнэлгээ, даалгавар, дизайн зохиомж, багтаамж нь сургалтын хөтөлбөр, сурагчийн хэрэгцээ, сонирхол, ачаалал, сурах арга барил эзэмших, тэдний бүтээлч сэтгэлгээ, асуудал шийдвэрлэх чадварыг хөгжүүлэхэд нийцэх нийцэл болон хангалт, хүртээмжийн талаар цогц судалгаа шинжилгээ хийх шаардлагатай байна.

Сурах бичгийг хүүхдийн нүдний хараа, нас, бие, хөгжлийн онцлогийг тооцсон олон улсын стандартын дагуу хэвлэхэд онцгой анхаарч, шинэчилсэн технологиор хэвлэж байна. Өөрөөр хэлбэл, цаас, өнгө будгийн чанарт шаардлага тавьж, шилийг нь оёх, хавтсыг нь бүрэх технологийг нэвтрүүлснээр сурагчдын сурах бичгийн хэвлэлийн чанар сайжирсан. Мөн хэвлэлийн газрын техник, технологийн хүчин чадал сайжирч, сурах бичгийг өөрийн орондоо хэвлэх бүрэн боломжтой болсон нь чухал ололт юм.

Сурах бичгийн жингийн асуудал нэлээд анхаарал татаж байна. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурагчийн үүрч буй цүнхний жин хэт их байгааг шүүмжилж, түүнийг сурах бичгийн жинтэй холбож байна. Боловсролын хүрээлэнгээс хийсэн судалгаагаар сурах бичиг нь сурагчдын хичээлийн хэрэгслийн нийт жингийн 30-40 хувийг эзэлж байгаа нь илэрчээ. Хүүхдийн үүрч яваа бүх ачааны жин хэд байх ёстой, одоо хэд байгааг судлаж тогтоох шаардлагатай байна. Бага ангийн сурах бичгийн жин, сурагчийн өдөрт хэрэглэх сурах бичгийн жингийн дунджийг тооцоолж, дараах хүснэгт⁸⁸-эд үзүүлэв.

Хүснэгт 30. I-V ангид хэрэглэх багц сурах бичгийн жин (граммаар)

<i>Анги</i>	<i>I анги</i>	<i>II анги</i>	<i>III анги</i>	<i>IV анги</i>	<i>V анги</i>
Нэг ангид хэрэглэж буй нийт сурах бичгийн тоо/нийт жин	6/ 1350 г	6/ 1350 г	6/ 1350 г	7/ 1515 г	8/ 1800 г
Сурагчийн нэг өдөр хэрэглэх сурах бичгийн дундаж жин (Сурагчдын хичээлийн хуваарийг үндэслэв.)	1015 г	1015 г	1015 г	1040 г	1145 г
Сурагчдын цүнхний нийт жин (хичээлийн хэрэгслийн хамт)	3150 г	3070 г	3210 г	3130 г	3770 г

⁸⁸ Н. Хулан нар. Ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдын цүнхний жин. Боловсрол судлал сэтгүүл. 2017/10 (138)

Өмнөх жилүүдэд сурах бичгийг эцэг эхчүүд худалдан авдаг байсан бол 1994 оноос эхлэн сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичгийг үнэ төлбөргүй ашиглах “Сурах бичгийн сан”-г байгуулж, түүгээр дамжуулан сурах бичгийн хангалт хийгдэж иржээ.

Харин 2002 оноос сурах бичиг хэрэглэсний хураамж болох 150 төгрөг төлж сургуулийн номын сангаар дамжуулан ашигладаг болсон байна. 2005 онд сурах бичгийг эрхийн бичгээр авах түр журам гарч нэн ядуу өрхийн хүүхэд, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн бүтэн ба хагас өнчин хүүхэд эрхийн бичгээр сурах бичиг авах, энэхүү эрхийн бичигт хамрагдаагүй сурагчид сурах бичгийг худалдан авах журамд шилжсэн нь:

- Сурах бичгийг “номын сан”-аар дамжуулан хэрэглэж байсан сурагч, эцэг эх худалдан авахаас татгалзах
- Авсан номынхоо мөнгийг тушаахгүй байх зэргээр сургуулийн номын санчид хүндрэл учруулж байв.

2006 онд ЕБС-ийн сурагчдын дөрөвний нэг нь сурах бичгийг үнэгүй авч хэрэглэх журамд хамрагдаж байжээ.⁸⁹

2009 оноос Засгийн газрын шийдвэрээр ЕБС-ийн бага ангийн сурагчдын 100 хувь, дунд, ахлах ангийн сурагчдын 40 хувийг сургуулийн номын сангаар дамжуулан сурах бичгээр үнэ төлбөргүй хангах ажлыг зохион байгуулж эхэлсэн.

Ингэснээр бага ангийн бүх хүүхэд, дунд, ахлах ангийн бүтэн өнчин, хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой өрхийн болон 3 буюу түүнээс дээш тооны хүүхэд нь ЕБС-д суралцдаг өрхийн хүүхдийн сурах бичгийг төрөөс үнэ төлбөргүй хангах тогтолцоо бий болсон. Үүний зэрэгцээ 2011 оноос ЕБС-ийн сурагчид хичээлийн жилийн эхэнд шаардлагатай багц сурах бичгийг сургуулийн номын сангаар дамжуулан түрээсээр авч ашиглаад, хичээлийн жилийн төгсгөлд буцаан хүлээлгэж өгөх түрээсийн тогтолцоо, эргэлтийн сан хэрэгжиж эхэлсэн нь сурагчдад сурах бичгийг 2 дахин бага үнээр хэрэглэх боломж олгосон байна.

Түрээсийн тогтолцоо нь сурах бичгийн хүртээмжийг сүүлийн 5 жилийн дунджаар авч үзэхэд 45 хүртэлх хувь нэмэгдүүлж байсан нь “сурах бичиггүйгээс хичээлд оролцдоггүй, гэрийн даалгавар хийдэггүй байдлыг багасгаж, сургалтын үр дүнд ахиц гарсан гэж багш нар үзсэн”⁹⁰ бөгөөд эцэг, эхэд ч сурах бичгийг нэг дороос

⁸⁹ Г. Содномваанчиг. Монголын бага, дунд боловсролын сургалтын агуулгын хөгжлийн түүхэн тойм. Улаанбаатар хот. 2008 он.

⁹⁰ Боловсролын хүрээлэнгийн СБСОСС-ын 2013 оны ажлын тайлан

түрээслэн авах, санхүүгийн хувьд ч хөнгөлөлт, дэмжлэг болж байлаа. Тухайлбал, 2014 онд дунд, ахлах ангийн сурагчдын 85 хүртэлх хувь сурах бичгээр хангагдсан байна.

Хүснэгт 31. ЕБС-ийн анги бүрийн бүх хичээлийн сурах бичгийн үнийн дундаж

Анги	VI	VII	VIII	IX	X	XI	XII
Нийт сурах бичгийн тоо	12	15	17	15	15	13	10
Багцын үнэ	32550	36600	39450	36700	45200	44600	28400
Дундаж	37600 төгрөг						

Сурагч нэг хичээлийн жилийн туршид хэрэглэх бүх сурах бичгийг дунджаар 37600 төгрөгөөр худалдан авч байна. Нэг сурах бичгийн доод үнэ 1200, дээд үнэ 5200, дундаж үнэ 2700 төгрөгийн үнэтэй байна. Эцэг эхийн худалдан авах чадвар тааруу, худалдаа борлуулалтын сүлжээ байхгүй, сурах бичгийн олдоц муу, нэг ангийн бүх сурах бичгийг нэг дороос авах зохицуулалт байхгүй, дамлан зарах явдал зогсохгүй байгаа зэрэг нь сурах бичгийн түгээлт, хүртээмжид хүндрэл учруулж байна. Мөн цаг хугацаандаа хэрэглэгчдийн гарт очихгүй байх зэрэг дутагдал гарсаар байна.

Монгол улсын боловсрол, шинжлэх ухааны сайдын А/ 240 тушаалаар 2014-2015 оны хичээлийн жилээс бага боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2015-2016 оны хичээлийн жилээс суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг, 2015-2016 оны хичээлийн жилээс бүрэн дунд боловсролын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэсэн билээ.

2000 оноос сурах бичгийн чиглэлээр хэд хэдэн судалгаа, шинжилгээний ажлууд хийгдсэн байна. Тухайлбал: “XXI зууны Монголын түүх, нийгмийн ухааны боловсролын онол ба методологи” (Пүрэв, 2003) нэг сэдэвт бүтээлд түүх, нийгмийн ухааны боловсролын сурах бичгүүдийг зохиох үндсэн зарчмуудыг тодорхойлсон нь түүх, нийгмийн ухааны сурах бичиг судлалын цаашдын хөгжилд онолын үндэслэгээ болжээ.

“Гадаад хэлний сурах бичгийг сургалтын удирдлагын үүднээс шинжлэх асуудалд” (Туяа, 2004) бүтээлд гадаад хэлний 33 сурах бичигт шинжилгээ хийж, сурах бичгийн үндсэн 8 параметрын дагуу 24 бүлэг, 123 шалгуурыг боловсруулж, улмаар сурах бичигт чанарын шинжилгээ хийх шалгуурын системийг тодорхойлсон байна⁹¹.

“Нийгмийн ухааны сурах бичгийн агуулга, аргазүйн уламжлал, шинэчлэлийн залгамж холбоо” (Дэлгэрсайхан, 2013) бүтээлд бага боловсролын нийгмийн

⁹¹ Туяа Л. Гадаад хэлний сурах бичгийн шинжилгээний аргазүйн зарим асуудал. УБ, 2005

ухааны сурах бичигт тавигдах тусгай шаардлага, шалгуур, үзүүлэлт, зөвлөмжийг судлан боловсруулсан нь суурь болон бүрэн дунд боловсролын сурах бичигт тавигдах тусгай шаардлагыг судлагдахуунаар боловсруулахад тодорхой чиглэл баримжаа болох онол, аргазүйн ач холбогдолтой судалгаа болсон байна. “Франц хэлний анхан шатны сургалтын сурах бичиг зохиож, туршсан үр дүн “(ЕБС-ийн VI-VII ангийн жишээгээр) (Золзаяа, 2009) бүтээлд сурах бичигт тусгасан агуулгын хүрээгээр сурагчдын мэдлэг, чадварыг шалгаж үнэлэн дүгнэх тестийн даалгавруудыг боловсруулан, түүний найдвар, тохироцыг шалгасан байна.

“Электрон сурах бичиг бүтээх аргазүйн хувилбар боловсруулж, хэрэгжүүлсэн туршилт, үр дүн” (Цэдэвсүрэн, 2009) бүтээлд электрон сурах бичгийн онцлогийг тодорхойлж, электрон сурах бичигт үнэлгээ хийх арга зүйн хувилбар боловсруулж турших асуудлуудыг судлаж, үр дүнг тооцсон байна. “Англи хэлний сурах бичгийн шинжилгээ, үнэлгээний арга зүйн хувилбар боловсруулах судалгаа” (Амаржаргал, 2013) бүтээлд гадаад хэлний сурах бичигт шинжилгээ хийх шалгуур үзүүлэлтийг боловсруулсан байна.

БШУЯ-аас 2012 онд (БШУ-ны сайдын 2012 оны 12 дугаар сарын 12-ны А 179 тоот тушаалаар) Боловсролын хүрээлэнгийн статус, үйл ажиллагааг өргөтгөж, Сурах бичиг, сургалтын орчны сектор бий болгосон нь сурах бичиг судлалд цоо шинэ түлхэц болов.

Багш боловсролын хөгжлийн байдал

2012 оноос өнөөдрийг хүртэл:

2012 оноос Монгол Улсын Засгийн газрын мөрийн хөтөлбөрт “... институтцэд суурилсан багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бий болгон төлөвшүүлэх, зорилт дэвшүүлсэн. 2012 онд Засгийн газрын 180-р тогтоолоор “Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт” байгуулж, дүрмийг нь баталсан. “Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм”-д зааснаар “Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг боловсролын хөгжлийн бодлого болон нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлан, орчин үеийн мэдээлэл харилцааны технологид суурилж, олон улсын стандартад нийцүүлэн зохион байгуулж, багшаар дамжуулан боловсролын салбарыг хөгжүүлэх” гэсэн эрхэм зорилготой ажиллаж байна.

Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын баталсан дүрмийн хүрээнд дараах үйл ажиллагааг зохион байгуулж байна. Үүнд:

- Багшийн мэргэжил дээшлүүлэх үндсэн, төрөлжсөн, захиалгат сургалт зохион байгуулах
- Багшид мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх
- Багшийн хөгжлийг дэмжих үйл ажиллагаа зохион байгуулах
- Багшийн мэргэжил дээшлүүлэх нөхцөл байдал, хөгжлийн хандлага, эрэлт нийлүүлэлтийн уялдаа, хэрэгжүүлж буй үйл ажиллагааны чиглэлээр судалгаа хийх

Тус институт нь үйл ажиллагаагаа бага дунд боловсролын шинэчлэлийн бодлогыг багш, удирдах ажилтнуудад хүргэх, үзэл санааг түгээн дэлгэрүүлэх, сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтаар эхэлсэн бөгөөд өнгөрсөн хугацаанд нийслэл хот, 21 аймгийн 98,500 (давхардсан тоогоор) орчим багш, удирдах ажилтанд үндсэн, төрөлжсөн, захиалгат сургалт, зөвлөн туслах болон бусад олон талт үйл ажиллагаагааны хэлбэрээр хүрч ажиллажээ.

Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж буй асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг сонгон багшийг ажлын байранд тасралтгүй хөгжихөд дэмжлэг үзүүлэх үүднээс Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2012 оны А/136 дугаар тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөрийг баталж, үндэсний хэмжээнд хэрэгжилтийг ханган ажиллахыг Багшийн мэргэжил дээшлүүлэх институтэд үүрэг болгосон байдаг.

Тус институт нь бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлогыг багш, удирдах ажилтан нарт хүргэх, гол үзэл санааг түгээн дэлгэрүүлэх сургалтаар үйл ажиллагаагаа эхэлсэн бөгөөд 2013 онд нийслэл хот, 21 аймгийн 3000 гаруй багш, удирдах ажилтанд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого-чиглэл, зорилтыг танилцуулах сургалт-хэлэлцүүлгийг зохион байгуулжээ. Монгол Улсын Засгийн газрын 2012-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрийн “Эрдэм боловсролтой монгол хүн” 3 бүлэгт туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/136 тоот тушаалаар “Багшийн хөгжил” хөтөлбөр батлуулан үйл ажиллагааныхаа салшгүй нэг хэсэг болгон хэрэгжүүлжээ. “Багшийн хөгжил” хөтөлбөр нь хүүхэд бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж байгаа асуудлыг судлан илрүүлэх, шийдвэрлэх арга замыг сонгон ажлын байрандаа тасралтгүй хөгжих таатай нөхцөл бүрдүүлэх...” зорилготой хөтөлбөр бөгөөд амжилттай хэрэгжүүлэхэд мэргэжлийн байгууллага болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажилласан

байна. Энэ хөтөлбөрийг 2012-2016 онд дараах 3 үе шаттай хэрэгжүүлэхээр төлөвлөжээ.

1. 2012-2014 он: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэхэд чиглэсэн багшлах арга зүйд тулгамдаж байгаа асуудлыг судлан илрүүлж, шийдвэрлэх арга замыг тодорхойлох
2. 2014-2016 он: Хүүхэд нэг бүрийг хөгжүүлжх багшийн мэргэжил, ур чадвар, хандлага төлөвих үе шат
3. 2016-2016 он: Багш өөрийгөө хөгжүүлэх, мэргэших, ур чадвараа сайжруулснаар боловсролын чанарт эерэг өөрчлөлт гарах үе шат

“Багшийн хөгжил” хөтөлбөрийг хэрэгжүүлэх үе шатуудаас харахад багшийн мэргэжлийн ур чадвар (professional skills) нь тун ч богино хугцаанд төлөвшдөг гэж бодсон “гэнэн” ойлголттойгоор асуудалд хандсаныг харуулж байна (Монгол улсад тогтвортой хөгжлийн боловсрол, тогтвортой хөгжил, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн орчин, хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа, УБ, 2016, 145-р тал).

2008-2010 онд боловсролын стандарт, сургалтын үндэсний хөтөлбөр, сурах бичгийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан багшийн мэргэжл, мэргэжлийн ур чадвар, ажил үүрэгтэй холбоотой шинэчилсэн багц 2012-2016 онд журмуудыг Засгийн газрын шинэчлэлийн бодлогын хүрээнд “Хүүхэд бүрийг хөгжүүлэх зорилтын дагуу өөрчилсөн байна. Үүнд:

- ЕБС, цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм, 2017 оны ... -р тушаал
- Ажлын байрны үлгэрчилсэн тодорхойлолт, 2007 оны 354, 179-р тушаал
- “Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам, 2013 оны А/287-р тушаал
- Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам, 2013 оны А/305-р тушаал
- ЕБС-ийн ажлыг төлөвлөх, үнэлэх, дүгнэх чиглэл 2014 оны А/293-р тушаал

Эдгээр журамд 2008 оны багц журамд чухалчилсан суурь шийдлүүдийг үндсэндээ хадгалсан боловч цаашид шийдвэрлэх шаардлагатай асуудал бий болгосныг онцлон тэмдэглжээ. Тухайлбал:


- Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журмуудыг нэг журмаар зохицуулдаг болсон

- Багшлах эрхийн хамгийн гол шалгуур болох багш нь залшгүй багш боловсролын бакалаварын зэрэгтэй байх шаардлагыг бүлгэрүүлж, заах арга зүйн хөрвөх сургалтад” хамрагдсан л бол хэн ч багшлах эрхтэй байж болгохоор болгосон
- Багшлах эрх олгох болон мэргэжлийн зэрэг олгох нийтлэг шалгуурын эхний нэгээс бусад мөн хасах шалгуурыг ижил болгосон. Өөрөөр хэлбэл багшийн хөгжлийн эрх олгох, мэргэжлийн зэрэг олгох хоёр ялгаатай үе шатыг адилтган авч үзсэн.
- Багшлах эрхийг зөвхөн сургалттай холбож, багшийн ажлын байранд тавигдах шаардлагуудыг тооцохгүй болгосон.
- Багшлах эрх “нээгдэх”, “сунгагдах”, мэргэжлийн зэргийг “хамгаалах” гэсэн шинэ харилцаануудыг оруулсан боловч тэдгээрийг хэрхэн зохицуулахыг журамлаагүй.
- Мэргэжлийн заах аргач, тэргүүлэх зэргийн зарим тусгай шалгуур нь хэмжигдэх үзүүлэлтгүй болсон.
- Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох ба хасахад тавигдах шалгуурыг хангасан, хангаагүйн нотолгоог ямар баримт материалыг үндэслэн хэрхэн баталгаажуулах гаргахыг журамлаагүй тул тухайн асуудлыг шийдвэрлэх эрх бүхий субъект нь ирсэн хүсэлтийг хүлээн аваад хэрхэн үнэлгээ, дүгнэлт, шийдвэр гаргах нь тодорхойгүй болсон.
- Багшлах эрх, мэргэжлийн зэргийн үнэмлэхийн тусгай код бүхий нэгдсэн загварыг баталдаггүй болсон. “Монгол улсын тогтвортой хөгжлийн боловсрол, ногоон хөгжлийн бодлого, эрх зүйн хэрэгжилт болон хэтийн төлөвийн суурь судалгаа” номд тус судалгааны хүрээнд хуучин болон шинэ багц журмуудыг харьцуулж, гол өөрчлөлтийг дараах байдлаар тодруулжээ (УБ, 2016, 148-р тал).

2016 онд Боловсролын тухай хууль”-д “Багшийн мэргэжил дээшлүүлэх сургалт, арга зүйн байгууллага боловсролын хөгжлийн бодлого болон сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны эрэлт хэрэгцээнд тулгуурлан мэргэжлийн тасралтгүй хөгжлийг дэмжих үйлчилгээг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах, зохион байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.” гэсэн заалтыг шинээр нэмж, тус институтын чиг үүргийг хуульчилсан.

Тус институт нь 2012-2018 онд Төлөвлөлт мониторингийн алба, Байгалийн ухааны сургалтын алба, Хэл, нийгэм, хүмүүнлэгийн ухааны суралтын алба, Захиалгат сургалтын алба, СӨБ, бага боловсролын сургалтын алба, Цахим

сургалтын алба, Захиргаа аж ахуйн хэлтэс гэсэн бүтэцтэй ажиллаж байсан. 2018 онд “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль” батлагдсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд А/482 дугаар тушаалаар тус институцийн бүтэц, орон тоог шинэчилсэн байна. 2018 оноос тус институт нь Бүртгэл, төлөвлөлт, мэдээллийн алба, Сургалтын алба, Суралцагчийн хөгжлийн алба, Сургалтын байгууллагын менежментийн алба, Багшийн хөгжил сургалтын технолгийн алба, Захиргаа аж ахуйн хэлтэс гэсэн үндсэн бүтэц, зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа явуулж байна.



БМДИ нь байгууллагынхаа үндсэн чиг үүрэг, боловсролын салбарын хууль, дүрэм, журмын хүрээнд багшийн хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагааг боловсролын байгууллагын ажилтан, албан хаагчдын мэргэжлийн хөгжлийн хэрэгцээнд үндэслэн, олон улсын жишигт нийцүүлэн зохион байгуулж ирсэн.

Нэг. Багшийн хөгжлийг дэмжих-мэргэжил дээшлүүлэх сургалт

Байгуулагдсан цагаасаа хойш нийслэл хот болон 21 аймгийн 125,514 /давхардсан тоогоор/ орчим багш, удирдах ажилтанд үндсэн, төрөлжсөн, захиалгат сургалт, зөвлөн туслах болон бусад олон талт үйл ажиллагаагааны хэлбэрээр хүрч ажилласан байна.

Үндсэн сургалт

Боловсролын тухай хуулинд “Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багшийн мэргэжлийг өмчийн хэлбэр үл харгалзан улсын төсвийн хөрөнгөөр 5 жил тутам дээшлүүлнэ.”/40.8/ гэсэн заалт 2012 онд шинээр нэмэгдсэн нь багш нарын мэргэжлийн хөгжлийг дэмжсэн томоохон шийдвэр болжээ. Тус институт нь хуулийн энэхүү заалт, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 дугаар тушаалаар баталсан “СӨБ, ерөнхий боловсролын багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-ын дагуу багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулж ирсэн. Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 дугаар тушаалын дагуу “Сургуулийн өмнөх болон

бага, дунд боловсролын сургалтын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх” сургалтыг графикайн дагуу зохион байгуулж ирлээ.

2012-2016 онд эхний болон 5,10 дахь жилдээ ажиллаж буй нийт 14581 багш, ажилтныг хамрсан төвлөрсөн болон бүсчилсэн байдлаар мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг зохион байгуулжээ. Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн үзэл баримтлал, олон улсын чиг хандлагад мэргэжил дээшлүүлэх сургалт, үйл ажиллагааг ойртуулах үүднээс 2015 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтаас эхлэн танхимын өмнө болон дараа онлайн сургалтыг зохион байгуулж байгаа нь сургалтад хамрагдсан багш нар танхимын сургалтаар эзэмшсэн мэдлэг, чадвараа ажлын байранд хэрэгжүүлэх, үйл ажиллагаандаа нэвтрүүлэхэд ихээхэн үр дүнтэй ажил болсон юм.

Багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг СӨБ, бага боловсрол, монгол хэл-уран зохиол, англи хэл, орос хэл, түүх-нийгмийн ухаан, математик, физик, хими, биологи, эрүүл мэнд, газар зүй, мэдээлэл зүй, хөгжим, биеийн тамир, дизайн технологи гэсэн 15 чиглэлээр; ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтыг захирал, сургалтын менежер, нийгмийн ажилтан, эрхлэгч, арга зүйч, номын санч, дотуур байрын багш, согог зүйч, эмч гэсэн зорилтот бүлэг бүрийн ажил үүргийн чиглэлээр тус тус зохион байгуулж байна.

Үндсэн сургалтын агуулга зорилтот бүлэг бүрээр ялгаатай. Тухайлбал, эхний жилдээ ажиллаж байгаа багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын агуулга нь багш нарын ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлэхэд нь; 5 дахь жилдээ ажиллаж байгаа багш нарын сургалтын агуулга нь тэдний багшлахуйд тулгамдаж байгаа асуудлын шийдлийг хэлэлцэх, хүүхэд бүрийг хөгжүүлэх арга технологиос эзэмших, ажлын байрандаа бие даан хөгжихөд нь; 10 дахь жилийн багш нарын сургалтын агуулга нь багш нар хуримтлуулсан мэдлэг, чадвар, туршлагаа хуваалцах, зөвлөгөө өгөх, дидактикийн шинэ онол арга зүйгээс суралцахад нь тус тус дэмжлэг үзүүлэхэд чиглэдэг.

2013-2019 онд зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 29,974 багш хамрагдсанаас эхний жилдээ ажиллаж байгаа 9320, тав дахь жилдээ ажиллаж байгаа 11,816, арав дахь жилдээ ажиллаж байгаа 8538 багш хамрагджээ. Эдгээр багшийн 14,0% нь эрэгтэй багш байна. 2013-2019 онд Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш нарын тоог хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 32. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан багш нарын тоо

Он	Эхний жил	5 дахь жил	10 дахь жил	Нийт
2013	0	1073	991	2064
2014	1755	2409	1728	5892
2015	1559	1444	1158	4161
2016	1636	1538	1125	4299
2017	1809	1622	1489	4920
2018	2532	1939	1668	6139
2019	2799	1791	1379	5979
Нийт	9320	11816	8538	29974

2016-2019 онд зохион байгуулсан мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад 3148 удирдах болон бусад ажилтан хамрагдсанаас эхний жилдээ ажиллаж байгаа 1714, тав дахь жилдээ ажиллаж байгаа 925, арав дахь жилдээ ажиллаж байгаа 509 удирдах болон бусад ажилтан хамрагдсан байна. Эдгээр удирдах болон бусад ажилтны 21.0% нь эрэгтэй байна.

Хүснэгт 33. Мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдсан удирдах болон бусад ажилтны тоо

Он	Эхний жил	5 дахь жил	10 дахь жил	Нийт
2016	453	279	133	865
2017	380	180	120	680
2018	544	230	119	893
2019	337	236	137	710
Нийт	1714	925	509	3148

Үндсэн сургалтыг 2015 оноос танхимын болон цахим сургалтын хэлбэрийг хослуулан зохион байгуулж ирсэн. Цахим сургалтыг esurgalt.itpd.mn буюу “Багшийн цахим кампус”-т зохион байгуулж, онлайн курсуудыг БМДИ-ийн мэргэжлийн арга зүйчид хөтлөн, цахим сургалтын албаны арга зүйчид нэгдсэн удирдлага, техникийн зөвлөмжөөр ханган ажиллаж байна.

Зураг 19. Үндсэн сургалтын бүтэц



Багшийн цахим кампуст 2015-2018 онд 145 цахим сургалтын виртуал анги үүсгэж, 6860 суралцагч онлайн сургалтын системд бүртгэгдэж, үүнээс 10 дахь жилдээ ажиллаж багш нарын 42 анги, 5 дахь жилдээ ажиллаж буй багш нарын 45 анги, эхний жилдээ ажиллаж буй багш нарын 58 онлайн сургалтын виртуал анги үүсгэн ажиллалаа. Мөн 15 мэргэжлийн багш, 5 чиглэлийн удирдах ажилтанд зориулсан зорилтот бүлэг бүрийн онлайн сургалтын 66 хөтөлбөр боловсруулж, тэдгээрийг хэрэгжүүлэх арга зам, уншиж

судлах материал, үнэлгээний даалгавар, шалгуур, аргачлалыг боловсруулсан байна.

2019 оноос эхлэн багш, удирдах болон бусад ажилтнууд танхимын сургалтын өмнө 35 хоногийн хугацаанд 50 цагийн онлайн курсыг сонголттойгоор судалж танхимын сургалтад хамрагдаж байна. Үндсэн сургалтын танхимын өмнөх онлайн сургалтыг сонголттой болгосноор онлайн сургалтын системд 54 төрлийн агуулгаар нийт 124 онлайн сургалтын виртуал ангид 6679 хүн хамрагдсан ба нийт 124 курсд давхардсан тоогоор 34,083 багш, удирдах болон бусад ажилтан онлайн сургалтад оролцсон.

Төрөлжсөн сургалт

Төрөлжсөн сургалт нь боловсролын бодлого чиглэлийг таниулах, хэрэгжүүлэх арга зам болон мэргэжлийн тусгай дидактикийн ур чадварт суралцах, хувь хүний хөгжил, мэдлэг ур чадварыг нь дэмжих зорилготой.

2012-2013 онд Боловсролын чанарын шинэчлэлийн хүрээнд хүүхэд бүрийг хөгжүүлэх бодлогыг багш бүрд хүргэх, тэдэнд заах арга, харилцаа, хандлагаа өөрчлөхийн чухлыг “нэг бүрчлэн” мэдрүүлэх зорилгоор “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын арга зүй-технологи” сэдэвтэй гурав хоногийн сургалтыг 21 аймаг, нийслэлийн 9 дүүрэгт зохион байгуулж, 23,871 багш, ажилтныг хамруулжээ. Энэ сургалт нь хүүхдийн сурахад тохиолддог саад бэрхшээлийн илрэх байдал, тэдгээрийг даван туулах арга зүйд багш нарын анхаарлыг хандуулсан, сургалтын арга барилаа өөрчлөх сэдэл бий болгожээ.

Боловсролын чанарын шинэчлэлийн ажлын хүрээнд сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын хөтөлбөрийн шинэчлэлийн ажил байлаа. Энэхүү ажлын хүрээнд багшийн мэргэжил дээшлүүлэх институт БСШУЯ, харьяа үндэсний хэмжээний мэргэжил арга зүйн байгууллага, орон нутгийн боловсролын соёлын газар, хэлтэс, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтан, бусад төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран сургалтын цөм хөтөлбөрийн агуулга, арга зүйг түгээн дэлгэрүүлэх сургалтууыг зохион байгуулж иржээ. Тухайлбал, 2014-2018 онд ерөнхий боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр, тухайлбал, 2014 онд бага боловсрол, 2015 онд суурь боловсрол, 2016-2018 онд бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулж, 58,671 (давхардсан тоогоор) багш, удирдах ажилтныг хамруулжээ. Түүнчлэн, аймаг, нийслэлийн Боловсролын газрын мэргэжилтэн, лаборатори

сургуулийн удирдах ажилтны сургалтад 1205, лаборатори сургуулийн хөтөлбөр хэрэгжүүлэх арга зүйн сургалтад 4324 багш, ажилтныг хамруулж, БСШУЯ, Боловсролын хүрээлэнтэй хамтран 220 сургуулийн хөтөлбөрийн хэрэгжилтэд мониторинг хийж, зөвлөн тусалсан байна. Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын байгууллагын багш удирдах ажилтнуудад боловсролын бодлого шийдвэрийг танилцуулах, хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилготой төрөлжсөн сургалтуудад 78,787 (давхардсан тоогоор) багш, удирдах ажилтан хамрагдсан байна. Үүнээс 2018 онд 2299 багш удирдах болон бусад ажилтанг оролцуулан зохион байгууллаа. Тухайлбал:

- Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Сургуулийн менежмент, багшийн хөгжил бүрэн дунд боловсролын сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга зүй-III" сургалтад нийт 315 хүн;
- Харааны, сонсголын, оюун ухааны бэрхшээлтэй хүүхдийн тусгай сургуулиудын багш, удирдах ажилтнуудад тусгай боловсролын бодлого, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх хүрээнд мэргэжил дээшлүүлэх сургалтыг 393 багш, удирдах болон бусад ажилтан;
- Монгол улс 2021 онд (PISA)-ийн сурлагын амжилтын судалгаанд хамрагдах бэлтгэл ажлын хүрээнд сургагч багш бэлтгэх сургалтад 60 багш;
- 2018-2019 оны хичээлийн жилээс ЕБС-ийн 4-12 дугаар ангид эрүүл мэндийн хичээл орох болсонтой холбогдуулан "Эрүүл мэндийн боловсролын сургагч багш бэлтгэх" сургалтад 92 оролцогч;
- ТХБ-ыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр, үйл ажиллагаанд интергацчилах зорилгоор "Тогтвортой хөгжлийн боловсрол-сургуулийн менежмент" сургалтыг орон нутгийн БСУГ-ын дарга, ахлах мэргэжилтэн захирлуудыг оролцуулан 93 сургагч багш;
- Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр түүх, нийгмийн ухааны багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалт болон аймаг, нийслэлийн ТНУ-ны сургалт хариуцсан 353 багш, 37 мэргэжилтэнд үзүүлэх хичээл зааж, хэлэлцүүлэг;
- Цахим орчин дахь аюулгүй байдал, зохистой хэрэглээ, "Хүүхдийн нийгэм сэтгэл зүйн байдлыг үнэлэх, оношлох, өсвөр үеийнхэнд сэтгэл зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлэх аргачлалд суралцах" агуулгын хүрээнд 125 нийгмийн ажилтан, 68 дотуур байрын багш;

- Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банктай хамтран хэрэгжүүлж буй “Баруун бүсийн сургуулийн бага ангийн сурагчдын дотуур байрны нөхцөлийг сайжруулах” төслийн хүрээнд хүүхдийн эрх, хамгаалал, асрамж, халамж, эцэг эх, сургууль, олон нийтийн хамтын ажиллагааг сайжруулах зорилготой сургалтад ЕБС-ийн дотуур байрны багш, жижүүр нийт 308 хүн;
- JICA олон улсын байгууллага-PROCESS төсөл, БМДИ, БҮТ, БХ зэрэг мэргэжлийн байгууллагуудын хамтран боловсруулж, БСШУС-ын сайдын А/549 тушаалаар батлагдсан “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг танилцуулан, сургуулийн менежментийг хөтөлбөрийн менежментийн циклтэй уялдуулан хэрэгжүүлэх арга зүйн дэмжлэг үзүүлэх зорилгоор “ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал, сургуулийн менежмент” сэдэвт сургалтыг 496 хүнд тус тус зохион байгуулав.

Монгол улсад боловсролын тогтолцооны шинэчлэлийг даган ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөр хэд хэдэн удаа өөрчлөгдсөн байна. Манай улсад хэрэгжсэн сургалтын хөтөлбөрүүдэд хийсэн SWOT шинжилгээний үр дүнд тулгуурлан сургалтын хөтөлбөрийг төлөвлөх, боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, сайжруулах цогц үйл ажиллагааг тогтвортой хэрэгжүүлэх зорилгоор “Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох аргачлал”-ыг 2018 оны 08 дугаар сарын 30-ны өдөр Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын А/549 дугаар тушаалаар батлан хэрэгжүүлж байгаа билээ. Энэ ажилтай холбоотойгоор 2019 онд “Сургалтын хөтөлбөр, суралцахуйн удирдамж, зөвлөмжийг сайжруулсан үр дүнг танилцуулах, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий сургалтыг нийт нийслэл хот, 21 аймгийн багш, удирдах ажилтан болон орон нутгийн боловсролын удирдах байгууллагын мэргэжилтэн нийт 40,872 хүнд зохион байгуулсан.

Эдгээрээс гадна Багшийн мэргэжил дээшлүүлэх институт нь 2015-2019 онд НҮБ-ийн Хүн амын сан, Хүүхдийн сан, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банк, Германы хамтын ажиллагааны нийгэмлэг, Швейцарын хөгжлийн хамтын ажиллагааны нийгэмлэг, Японы хүүхдийг ивээх сан зэрэгтэй байгууллага, төсөл хөтөлбөрүүдтэй хамтран төрөлжсөн сургалтууд зохион байгуулж, 68,289 (давхардсан тоогоор) багш, ажилтныг хамруулсан байна.

Захиалгат сургалт-зөвлөн туслах ажил

Орон нутаг, сургуулийн захиалгаар зөвлөн туслах үйл ажиллагаанаас гадна багшийн тасралтгүй хөгжлийг дэмжих олон талт үйл ажиллагаануудыг багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн дүрэм, бусад эрх зүйн баримт бичгүүдэд үндэслэн зохион байгуулж байна. 2013-2019 онд орон нутаг, сургуулийн захиалгаар 390 гаруй удаагийн сургалт зохион байгуулж, 18,200 багш, удирдах ажилтан хамрагдсан байна. Харин зөвлөн туслах үйлчилгээнд 7259 багш хамрагджээ. 2013-2019 онд нийт тус байгууллагаас нийслэл хот, 21 аймгийн СӨББ, ЕБС-д давхардсан тоогоор 390 гаруй удаагийн сургалтаар 18,200-аад багш ажилтан, иргэдэд хүрч ажилласан байна.

Боловсролын байгууллагын багш, ажилтнуудын ажлын байрандаа мэргэжил дээшлүүлэх хүсэлт, хэрэгцээнд үндэслэн захиалгат сургалт, зөвлөн туслах үйл ажиллагааг зохион байгуулж, 14,330 багш ажилтанд арга зүйн дэмжлэг үзүүлснээс 2018 онд нийслэлийн төрийн өмчийн 136 сургуулийн 7173 багш, ажилтанд “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлэх бэлтгэх хангах, “Багшийн хөгжлийн хөтөлбөр” боловсруулахад тусгах санал авах, мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтын бүртгэл, зохион байгуулалтын талаарх мэдээлэл хүргэх, сургуулийн дотоод орчны өөрийн үнэлгээ, гадаад орчны хөндлөнгийн үнэлгээг хийж, багшийн ажлын төлөвлөлтийг оновчтой хийх, багшийн хөгжлийн дэвтэр ашиглах зөвлөмж өгөх зэргээр хамтран ажиллахын зэрэгцээ “Эерэг бол Гоё” аяны хүрээнд сургууль, багш нарын сайн туршлага 88, эерэг мэдээ, мэдээлэл боловсруулан байгууллагын цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэж ажиллалаа

Сонголтот сургалт

2018 онд энэхүү сургалтыг анх зохион байгуулсан. Багшийн мэргэжил дээшлүүлэх институтийн захирлын 2019 оны 01 сарын 02-ны өдрийн А/02 тоот тушаалаар “Багшийн хөгжлийг дэмжих сонголтот сургалт зохион байгуулах журам” батлагдсаны дагуу нийт 46 хөтөлбөрөөр тус бүр 24 цаг (1 кредит) үнэ төлбөргүйгээр 980 багшийг хамруулж, 894 багшид “Батламж” олгосон. Оролцогчдын сонгосон агуулга хөтөлбөрийг чиглэлээр нь ангилж үзвэл: “Сургалт хөгжил-38%”, “Хүүхдийн хөгжил-23%”, “Багшийн хөгжил-19%”, “Мэдээлэл харилцааны технологи-15%”, “Удирдлагын менежмент, хөгжил-5%” тус тус агуулга бүхий хөтөлбөрийг өөрийн хэрэгцээ, сонирхолд үндэслэн сонгож суралцсан байна. БМДИ-ээс 2018-2019 оны хичээлийн жилд багш, ажилтны эрэлт

хэрэгцээнд үндэслэн сургалтын хөтөлбөрөө чөлөөтэй сонгох боломжтой, ажлын дараах сургалт- үйлчилгээний хэлбэрийг шинээр бий болгон хэрэгжүүлсэн нь ихээхэн үр дүнтэй үйл ажиллагаа болсоныг оролцогчид онцолсон байна.

Хоёр. Багшийн хөгжлийг дэмжсэн үйл ажиллагаа

2012 он хүртэл БСШУСЯ хариуцан зохион байгуулж ирсэн багшийн хөгжлийг дэмжсэн Оны тэргүүний багш шалгаруулах, зөвлөх багш мэргэжлийн зэрэг олгох, төрөлжсөн сургалтын хөтөлбөрийг магадлан дүгнэлт гаргах зэрэг үйл ажиллагааг БМДИ-д эрх шилжүүлсэн.

Төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/287 тушаалаар батлагдсан “Сургуулийн өмнөх болон бага дунд боловсролын сургалтын байгууллагын багш ажилтны мэргэжил дээшлүүлэх журам”-д заасны дагуу төрөлжсөн сургалтын хөтөлбөрт магадлан шинжилгээ хийх ажлыг графикийн дагуу гүйцэтгэж байна. 2014-2019 онд давхардсан тоогоор 495 хөтөлбөрт дүгнэлт гаргаж, 339 хөтөлбөрт төрөлжсөн сургалт явуулах эрх олгожээ. Эдгээр хөтөлбөрийн 50 хувь нь бүх мэргэжлийн багш нарт, 22 хувь нь бага боловсрол, 15 хувь нь цэцэрлэгийн багш нарт зориулагдсан байна.

Зөвлөх багш мэргэжлийн зэргийн дүгнэлт гаргах. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/305 тушаалаар батлагдсан “Багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох хасах журмыг хэрэгжүүлж, СӨБ, ерөнхий боловсролын сургуулийн багш, удирдах ажилтанд мэргэжлийн “Зөвлөх багш” зэрэг олгох үйл ажиллагааг зохион байгуулж байна. 2013-2018 онд “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгуулах хүсэлт гаргасан 600 орчим багшийн материалыг хүлээн авч, 350 багшид “Зөвлөх багш” мэргэжлийн зэрэг олгох дүгнэлт гаргаж БСШУСЯ-д уламжилсан нь сайдын тушаалаар баталгаажсан байна. 2016 оноос зөвлөх багш багш нарын сайн туршлага, бүтээлч арга зүй, технологийн талаар мэдээлэл солилцох уулзалт-зөвлөгөөнийг зохион байгуулж тэдэнд үүрэг хариуцлагаа ухамсарлах, хамтын ажиллагаагаа бэхжүүлэх, өөрийгөө хөгжүүлэн, үндэсний түвшинд манлайлан ажиллах талаар хэлэлцүүлэг өрнүүлж, бүтээлч туршлагыг нийтийн хүртээл болгон ажиллаж байна.

Багшлаар ажиллах, багшлах эрх олгох, сунгах. Бага, дунд боловсролын тухай хууль /21.2/, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль /12.2/-д “Багш нь багшлах эрхтэй байна” гэсэн заалт бий. Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/305-р тушаалаар батлагдсан журмыг хэрэгжүүлж, 2014-2018 онд

сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагад ажиллах багш нарт багшлах эрх олгох, сунгах үйл ажиллагааг БМДИ зохион байгуулж ирсэн. Энэ үйл ажиллагааг дараах гурван үе шатаар зохион байгуулж ирсэн.

1. *Эхний нэг жил ажиллах эрх олгох шалгалт.* Их дээд сургуулийг багш мэргэжлээр төгссөн иргэн эхний нэг жил ажиллах эрхийн шалгалтад орж тэнцсэнээр ЕБС, цэцэрлэгт нэг жил ажиллах эрх ннээгдэнэ. Тус шалгалтыг жилд улсын хэмжээнд 2 удаа онлайн хэлбэрээр зохион байгууж байсан.
2. *Багшлах эрх олгох.* Сургалтын байгууллагад эхний жилдээ ажиллаж буй багш нарын мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдан багшлах эрх олгуулах хүсэлт гаргаж, зохих шаардлага хангавал багшлах эрхийг 5 жилийн хугацаатай олгоно.
3. *Багшлах эрх сунгах.* Сургалтын байгууллаад 5 болон 10 дахь жилдээ ажиллаж буй багш нь мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтад хамрагдаж зохих шаардлагыг хангаснаар багшлах эрхийг сунгуулна. 5 дахь жилдээ ажиллаж байгаа багшийн багшлах эрх таван жилээр сунгагдах бол 10 жилдээ ажиллаж буй багш нарынх хугацаагүйгээр сунгагдана.

БМДИ нь 2014-2018 онд 14,986 хүнд сургалтын байгууллагад эхлэн ажиллах эрх, эхний жилдээ ажиллаж байгаа 10,551 хүнд багшлах эрх олгосон бол 5 ба 10 дахь жилдээ ажиллаж байгаа 13,600 багшийн багшлах эрхийг сунгасан байна. 2018 онд “Багшийн хөгжлийг дэмжих тухай” шинэ хууль батлагдаж “Багш мэргэжлээр дээд боловсрол эзэмшсэн төгсөгч нь багшлах эрхтэй байх” гэж хуульчилснаар энэ үйл ажиллагаа зогсоод байгаа аж.

“Оны тэргүүн”-ий багш шалгаруулах. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2007 оны 440-р тушаалаар батлагдсан “Улс, аймаг, нийслэлийн Оны тэргүүний багш шалгаруулах болзол, түүнийг дүгнэх аргачлал”-ын дагуу 2013-2019 онд “Оны тэргүүний багшийн болзол хангасан 21 багшийг шалгаруулжээ. БМДИ-ийн захирлын тушаалаар тусгай ажлын хэсэг байгуулан аймаг, нийслэлийн боловсролын газруудаас ирүүлсэн багш нарын материалд “Оны тэргүүний багш шалгаруулах” болзол, аргачлалын дагуу үнэлгээ, дүгнэлт хийдэг.

Судалгаа, шинжилгээний ажил. Хичээлийн судалгааны арга зүй нь бага, дунд боловсролын чанарын шинэчлэлийн бодлого, 2012-2016 онд хэрэгжих “Багшийн хөгжил” хөтөлбөрт дэвшүүлсэн “Хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх арга барилтай багшийг төлөвшүүлэх” зорилтыг хэрэгжүүлэх гол арга замын нэг гэж үзэж БМДИ, Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран 2013 онд анхдугаар,

2014-2019 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн баглах арга зүй” онол практикийн бага хурлыг уламжлал болгон зохион байгуулж ирлээ. Энэхүү хурал нь багш ажлын байрандаа хамтдаа тасралтгүй хөгжих хэрэгцээ, сургуульд суурилсан багшийн мэргэжлийн хөгжлийг дэмжих бодлого, үзэл баримтлалтай нягт уялдсан төдийгүй багш нар бүтэн жилийн турш бэлтгэн, өөрийн арга туршлагаа бусадтай хуваалцах боломж олгосон томоохон цар хүрээ бүхий хурал болоод байна. Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран “Хүүхдийн хөгжлийн дэмжсэн багшлах арга зүй” онол практикийн бага хурлыг 2012 оноос эхлэн долоон удаа зохион байгуулж байна. Энэхүү хурлын эхний шатанд жил бүр 100-125 илтгэл багш нар ирүүлдэгээс 45-50 илтгэл дараагийн шатанд хэлэлцэгдэж үр нөлөөтэй 3-4 илтгэлийг БНСУ, Япон, ОХУ-д сургалт туршлага судлах үйл ажиллагаанд харагдах эрхээр урамшуулж нийт 20 гаруй багшийг оролцуулсан байна.

Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах шинэлэг арга зүй, туршлага хуваалцах, түгээн дэлгэрүүлэх, хөгжүүлэх зорилгоор 2013 оноос Монголын хичээлийн судалгааны нийгэмлэгтэй хамтран жил бүр уламжлал болгон зохион байгуулж байгаа ба 2018 онд “Хүүхдийн хөгжлийг дэмжсэн багшлах арга зүй” онол практикийн V бага хурлыг дөрвөн салбар хуралдаанаар зохион байгуулж 170 гаруй хүн оролцож, хичээлийн судалгааны үндэсний эксперт, зөвлөхүүд 54 илтгэлийг сонгон хэлэлцсэн байна. Хурлаас багшлахуйн бүтээлч арга туршлага бүхий үр нөлөөтэй дөрвөн илтгэлийг сонгон шалгаруулж, илтгэгч нарыг Япон, Солонгос, ОХУ зэрэг улсад туршлага судлах сургалтад хамрагдах эхийн бичгээр урамшуулж иржээ. Энэ чиглэлээр БМДИ нь бусад мэргэжлийн байгууллагатай дараах чиглэлээр хамтран ажиллаж байна. Үүнд:

- Боловсролын Хүрээлэн, Боловсролын Үнэлгээний Төв, МУИС, МУБИС-тай хамтран зохион байгуулсан “Боловсролын нийгэм зүйн тулгамдсан асуудал, шийдэл, арга зам” сэдэвт эрдэм шинжилгээний IV бага хуралд 100 гаруй судлаачид илтгэлээ хэлэлцүүлсэн ба хурлын эмхэтгэл, зөвлөмж гаргалаа.
- 2015-2018 онд ЦХА-ын дэмжлэгтэйгээр хэрэгжсэн “Тогтвортой хөгжлийн боловсролын төсөл”тэй хамтран “Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт ТХБ-н үзэл санааг нэвтрүүлэх замаар багшийн мэргэжил дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлэх” ерөнхий зорилгын хүрээнд судалгаа хийсэн.

- “Багш мэргэжлийн тасралтгүй хөгжлийн хэрэгцээг тогтоох зорилгоор үндэсний хэмжээнд онлайн судалгаа явуулж, ойрын жилүүдэд мэргэжил дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт тусгах шаардлагатай агуулга, арга зүйг тодорхойлж хөтөлбөрөө сайжруулж байна.
- “Багш, удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх 5 дахь жилдээ ажиллаж буй багш нарын үндсэн сургалтын хөтөлбөрт ТХБ-н үзэл санаа, агуулга арга зүй туссан байдалд үнэлгээ хийж, эхний болон 5,10 жилийн үндсэн сургалтад ТХБ-ын бие даасан дэд модулиуд тусгагдсан хэрэгжиж байгаа бөгөөд тус институтийн арга зүйчид ЕБС-ийн сургалтад ТХБ-ыг интеграцчилах арга зүйг боловсруулан туршсан.
- Багшийн мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагаанд мөрдөгдөж буй бодлогын баримт бичгүүдийн харьцуулсан судалгаа хийж, эрх зүйн орчныг сайжруулах зөвлөмж-чиглэлийг гаргасан.
- ЕБС-ийн багш нарт зориулан Монгол улсын ТХ, ТХБ-ын хөгжлийн стратегиудын интеграц, ЕБС-ийн сургалт, үйл ажиллагаанд ТХБ-ыг интеграцчилах үндсэн чиглэл, багшийн цогц чадамж, ТХБ-ыг ЕБС-ийн сургалт үйл ажиллагаанд интеграцчилах агуулга, арга зүйн хүрээ зэргийг багтаасан, бага, суурь, бүрэн дунд боловсролын түвшин бүрээр сургалтын хөтөлбөрт ТХБ-ыг интеграцчилах боломжийг жишиг болгон үзүүлсэн 89 хэвлэлийн хуудас бүхий “Тогтвортой хөгжлийн боловсролыг ерөнхий боловсролын сургуулийн сургалт, сургалтыг дэмжих үйл ажиллагаанд интеграцчилах арга зүй” гарын авлагыг 45 хүний бүрэлдэхүүнтэй 7 дэд баг боловсруулан Швейцарийн хөгжлийн агентлаг, ТХБ-ын санхүүгийн дэмжлэгтэйгээр хэвлүүлэн, монгол улсын ЕБС-иудад түгээсэн. Мөн СӨБ, ЕБС-д 1, 5, 10 дахь жилдээ ажиллаж буй багш нарт зориулсан үндсэн сургалтын гарын авлага 7800 хувь, дотуур байрын багш нарт зориулж мэргэжил арга зүйн хөтөч болгон ашиглаж болох гарын авлага; ЕБС-ийн багш нарт зориулж “Багш хөгжлийн дэвтэр” 30,000 хувь гарын авлага зөвлөмж боловсруулан хүргэлээ.

БМДИ нь 2012-2019 онд дараах улс орнуудын ижил төстэй үйл ажиллагаа эрхэлдэг мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Үүнд:

- 2012 оноос БНСУ-ын Боловсролын яамны санхүүжилтээр, Монгол улсын БСШУСЯ, БМДИ, БНСУ-ын ЮНЕСКО-АПСЕЮ (Ази-Номхон далайн бүсийн олон улсын ойлголцлын боловсролын төв) байгууллагуудын хамтын ажиллагаа, оролцоотойгоор “Монгол-Солонгос багш солилцооны хөтөлбөр”-ийг амжилттай хэрэгжүүлж байна. 2012-2019 онд тус хөтөлбөрт Монгол улсаас 172, Солонгос улсаас 148 багш хамрагдаж арга зүй, туршлагаа хуваалцсан байна.
- 2013 оноос ОХУ-ын Эрхүүгийн их сургуультай гэрээтэй ажиллаж орос хэлний багш нарын мэргэжил дээшлүүлэх сургалтад тус сургуулийн мэргэжилтэн багш ирж хичээл зааж ирсэн. Мөн 2013-2018 онд ерөнхий боловсролын сургуулийн орос хэлний багш нарыг 7 хоногийн хугацаат зуны сургалтад хамруулж, тухайн хэлний орчинд харилцах боломж олгоход анхаарч ажиллаж байна. Тус сургалтад нийт ... орчим багш хамрагдаад байна.
- 2015-2017 онд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Ажил мэргэжлийн дээд сургуультай хамтын ажиллагааны гэрээ байгуулж БМДИ-ийн арга зүйч, ажилтан албан хаагч, орон нутгийн боловсролын байгууллагын төлөөлөл болон ЕБС-ийн МХУЗ-ын багш нийт 150 гаруй хүнийг сургалт туршлага судлах үйл ажиллагаанд хамруулсан байна. Энэ ажлын үр дүнд өнөөдөр орон нутгийн БСУГ-ууд Шилийн хотын ерөнхий боловсролын сургуулиудтай холбоо тогтоон хамтран ажиллаж байна.
- 2016 оноос Япон улсын Шизүока мужийн Боловсролын хороотой “Хамтын ажиллагааны гэрээ” байгуулж, гэрээний дагуу жил бүр БМДИ-ээс 1-2 удирдах ажилтан болон арга зүйч, Японы талаас 2 мэргэжилтэн сургалт-туршлага судлах үйл ажиллагаанд хамруулж байна.
- 2002-2015 он хүртэл БСШУСЯ, БНСУ-ны Дэжон хотын боловсролын газар хоорондын хамтын ажиллагааны хүрээнд зохион байгуулж байсан сургалтаа 2016 оноос БМДИ-д эрх шилжүүлсэн ба “Монголын багш нарын мэдээллийн технологийн сургалт” хамтран зохион байгуулж байна. Энэ сургалтад 2002 оноос өнөөдрийг хүртэл нийт 413 багш хамрагдсан байна.

Хамтын ажиллагааны талаар. БИДИ нь ижил төстэй үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд Япон, Солонгос, ОХУ, БНХАУ зрэг улстай багшлах арга зүй, багшийн мэргэжил дээшлүүлэх чиглэлээр туршлага судлах, дунд сургуулийн багш нарын хооронд багш солилцоо хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэргээр хамтран ажиллаж байна. Тухайлбал, 2012 оноос эхлэн хоёр улсын засгийн газрын хооронд хэрэгжиж буй

“Монгол-Солонгос багш солилцооны хөтөлбөр”-ийг дурдаж болох юм. 2012-2016 оны хооронд БНСУ, АПСЕЮ (Ази Номхон далайн олон улсын харилцан ойлголцлын төлөөх боловсролын төв)-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрт нийт 128 багш хамрагджээ.

Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах үйл ажиллагааны чиглэлээр. “Төрийн байгууллагын вэб сайтад тавих шаардлага” /MNS:6285:2016/-ын дагуу БМДИ-ийн албан ёсны цахим хуудсыг агуулга болон дизайны байнгын шинэчлэл хийж www.itpd.mn цахим хуудас нь үндсэн 10, дэд 33 цэстэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Тус хуудаст шинэ мэдээ, шинэ хууль, дүрэм журмыг байршуулснаас гадна мэргэжлийн байгууллага, сургууль багш нар болон иргэд ТХБ-ын 17 зорилгын хүрээнд хийгдсэн сайн туршлагаа түгээн дэлгэрүүлэх боломж бүхий динамик ажиллагаатай esd.itpd.mn дэд цахим хуудас, twitter, youtube, facebook, @ITPDMongolia фэйсбүүк хуудас зэргээс гадна нь 6 телевиз, 5 өдөр тутмын сонин, 2 FM радиотой хамтран ажиллаж, олон нийтэд мэдээллийг цаг алдалгүй шуурхай хүргэж байна. Мөн байгууллагын албан ёсны фэйсбүүк [/www.facebook.com/itpdMongolia/](http://www.facebook.com/itpdMongolia/), твиттер [/www.twitter.com/itpdMongolia/](http://www.twitter.com/itpdMongolia/) хуудсуудыг тус тус ажиллуулж байна. Байгууллагын фэйсбүүк хуудсаар [/https://www.facebook.com/itpdMongolia/](https://www.facebook.com/itpdMongolia/) өдөр бүр багш нарын асуултад хариулт өгч, мөн шинэ мэдээ мэдээлэл, фото болон видео бичлэг байршуулж байнгын үйл ажиллагааг ханган ажиллаж байна.

“Багшийн хөгжил” хөтөлбөрийг дэмжих, хөтөлбөрийн хэрэгжилт явцын талаар олон нийт болон боловсролын салбарынханд мэдээлэх, багш нарыг шинэ мэдээ мэдээллээр хангах, туршлага арга зүйг нь түгээн дэлгэрүүлэх зорилгоор 2015 оноос “Багшийн хөгжил” сэтгүүлийг эрхлэн гаргаж байна. Тус сэтгүүлийн гол зорилго нь төрөөс боловсролын талаар баримталж буй бодлого, зорилтын хэрэгжилт, үр дүн, БМДИ-ийн үйл ажиллагааны талаарх мэдээ мэдээллийг СӨБ, ЕБС-ийн багш, удирдах ба бусад ажилтнууд, олон нийтэд хүргэх зорилготой юм.

Боловсролын эдийн засаг, санхүү, хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, хууль эрх зүй, менежментийн шинэ тогтолцоо бүрдсэн нь

Тухайн цаг үеийн төвлөрсөн төлөвлөгөөт захиргаадалтын эдийн засгаас зах зээлийн харилцаанд шилжих шилжилтийн үеийн төр, засгийн бодлого, хууль эрх зүйн хүрээнд боловсролын салбарыг энэхүү харилцаанд шилжүүлэх арга хэмжээг 1991 оны боловсролын салбарыг хөгжүүлэх үзэл баримтлал болон боловсролын

тухай шинэчилсэн хуулийг хэлэлцэж батлуулсан үеэс эрэмбэ дараатай хэрэгжүүлж эхэлсэн.

Энэхүү эхний үед буюу 1990-1995 оны хугацаанд дараах хямралын үйл явц гүнзгийрсэн байсан бөгөөд дараах өвөрмөц онцлогтой орчин нөхцөл бүрдэж, зарим нэг шинэчлэлийн үйл явц эхлэж байлаа. Үүнд:

Нэгдүгээрт, хүмүүнлэг, ардчилсан нийгэм, зах зээлийн харилцаа, тэрний боловсролын салбарын онцлог харилцааны талаарх ойлголт, мэдлэг хангалтгүй зөвхөн зарим нэгэн идэвх санаачилгатай судлаач, хүмүүсийн уншиж сонсон дам, бүр тодруулвал орчуулгын мэдээллээс хэтрэхгүй байлаа.

Хоёрдугаарт, зээлийн харилцааны үеийн нийгэм, эдийн засгийн болоод боловсролын хөгжлийн цогц үндэсний бодлого, хууль эрх зүйн орчин байхгүй, боловсрол, сургууль, багш нарын үнэлэмж огцом асар ихээр унаж, зах зээлийн үед ганзгын наймаа эрхэлж, олон хувийн малтай болохыг зах зээлийн харилцаа хэмээн ойлголт өргөжиж байв.

Гуравдугаарт, орчин үеийн хэрэгцээ, шаардлагыг хангахуйц хүний нөөц болон байгууллагын менежментийн чадавх бүрдээгүй.

Дөрөвдүгээрт, төр, засгийн шинэ бодлого, хууль эрх зүйн батласан шийдвэрүүдийг бодиттой хэрэгжүүлэх санхүүжилт, төсөв, хөрөнгө оруулалтын нөөц боломж байхгүй.

Тавдугаарт, боловсролыг хямралаас гаргах гадаадын хөрөнгө оруулагч дэмжигчид байхгүй зэргээс боловсролын хямрал ихээхэн удаашрах зогсонги байдалтай байлаа.

Зургаадугаарт, энэхүү боловсролын хямрал гүнзгийрч боловсролын өөрчлөлт удааширч, багш, ажиллагчдын цалинг тавьж чадахгүй, сургууль завсардалт ихтэй, хичээлийн болон дотуур байр нь эвдэрч, цахилгаан, дулаан байхгүй багш, сурагчид нь гадуур хувцастайгаа даарч бээрсэн зэрэг шалтгаануудаас үүдэн багш, боловсролын ажилтнууд хот хөдөөгүй ажил хаялт жагсаал цуглаан хийсэн маш хэцүүхэн цаг үе байлаа.

Эдүгээ дэлхийн хүн төрөлхтөн маш сонирхолтой бөгөөд асар хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй цаг үед амьдарч байна. Хүмүүсийн амьдралын хэв маяг, улс орны хөгжлийн чиг андлага, салбар, байгууллага хоорондын зах зээлийн төлөөх ширүүн өрсөлдөөн, мэдээллийн асар хурдтай шинэчлэлт гээд урьд өмнө нь монголчууд бид нэлээд амгалан тайвнаар хүлээн авч алгуурхнаар хувьсан

өөрчлөн хэвшлээ болгодог байсан арга барил бараг түүхийн хуудаснаа үүлдэхээр хуучирч байна.

Дэлхийн хүн ард даяарчлалын хөгжлийн үзэл санаа, харилцан ойлголцож, ижилсэх, хамтран ажиллах, хязгаарлагдмал нөөц боломжоо чиг зорилготой ашиглах нэгдмэл сонирхолтой болж байгаа нь илүүү ихээр мэдрэгдэх боллоо.

Одоогийн нөхцөлд орчин үеийн мэдээлэл, холбооны технологи, компьютерын сүлжээг дээд зэргээр ашиглах, дэлхий нийтийн харилцааны түгээмэл хэрэгсэл болсон англи хэлийг эзэмшиж хэрэглээ болгох, зах зээлийн эрэлт хэрэгцээг соргог мэдэрч аливаа өрсөлдөөнд ялах мэдлэг, чадварын бэлтгэлтэй байх гээд шинэ ойлголт бий болсоор байна. Харин монголчууд бид асар хурдацтай өөрчлөгдөж буй дэлхий ертөнцөд амьдарч, ажиллах боловсрол, мэдлэг, чадварыг эзэмшиж чадсан уу, манай сургууль, байгууллага, багш нар, цаашилбал сургалтын агуулга, технологи, орчин, шинэ хэрэгцээ, шаардлагыг хангаж чадсан уу, боловсролыг шинэчлэж өөрчлөх хангалттай санхүүжилт, хөрөнгө оруулалт байна уу гэсэн олон асуудал шил шилээ даран гарч ирж байгаад зохих хариу өгөхөд оршиж байгаа юм.

Хэрвээ боловсролын салбарт мэдээлэл, холбооны технологийг хөгжүүлэе, англи хэлийг суръя, интернэтэд холбоё гэж 1990-1995 оны боловсролын амьдралын хүнд бэрх, хямралын нөхцөлд ярьсан бол хүн бүхэн гайхаж, цалин мөнгө бага, түүнийгээ цагт нь тавьж чадахгүй, сургууль завсардалтыг зогсоож, зах зээл, ганзагын наймаа хөөсөн багшаа буцааж сургуульд нь авч ажиллуулах боломжгүй, олон цагаар цахилгаан тасарч зарим хөдөөд цахилгааны бараа сураг ч гараагүй байсан үе юм. 1993, 94 онд Монгол Улсын боловсролын тогтолцоо гадаад улс орнуудад нээлтэй болж байсан тэрхүү тааламжтай цаг үе, нөхцөлд дэлхийн санхүүгийн томоохон байгууллагын нэгэн Азийн Хөгжлийн Банк нь манай орны боловсролын бодит хэрэгцээ, шаардлагыг маш соргоогоор урьдчилан мэдэрч "Боловсрол, хүний хүчин зүйлийн сектор судалгаа, мастер төлөвлөгөөг боловсруулахад зоригтойгоор анхны хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсын боловсролын орчин үеийн хөгжилд маш чухал түүхэн үүрэг роль гүйцэтгэсэн байна.

Энэхүү мастер төлөвлөгөөнд боловсролын чанар, үр ашиг, хүртээмжийг сайжруулах, менежментийн чадавхийг дээшлүүлэх, хүний нөөцийн чанар, хөгжлийг хангах, дээд боловсролын магадлан итгэмжлэлийг хөгжүүлж, мэдээллийн академик электрон сүлжээг байгуулах, сурах бичгийн чанар, агуулгыг

сайжруулах зэрэг олон чухал зорилтуудыг тусгаж байсан нь өнөөдөр бүгд бодит биелэлээ олж Монгол Улсын боловсролыг дэлхий дахины орчин үеийн хөгжлийн түвшинд ойртуулахад тус дэм болж чадсан байна.

Мастер төлөвлөгөөнд л тусгачихвал бүх юм зүгээр л илбэтэй юм шиг бүтчихнэ гэж бодох боломжгүй. Төлөвлөсөн зорилтууд мөнгө хөрөнгөгүй л бол үнэхээр цаасан дээр бичсэн хоосон лоозон, мөрөөдөл болох нь гарцаагүй. Тэгвэл хэн мөнгө, хөрөнгө өгч тэр зүйлийг бодит биелэл болгож чадсан юм бол гэсэн асуулт зүй ёсоор тавигдана. Үүнд боловсрол судлаачид оновчтой зөв хариулт өгөх учиртай. Мастер төлөвлөгөө нь байгаад хөрөнгө оруулалт, мөнгө санхүүжилт байхаар шинэ шинэ үйл ажиллагаа, үүр дүнгүүд ар араасаа шил шилээ дараад бий болно гэж бодвол бас бүтэшгүй.

Түүнийг зориулалтын дагуу цаг хугацаанд нь бодит баялаг, бүтээл болгож байдаг мэргэшсэн ажилтан, баг, хамтлаг, хүмүүсгүйгээр энэ бүтэхгүй. Ийм учраас гадаадын зээл, тусламжийг монголчууд өөрсдийн оюун ухааны чадавх, туршлагаар бие даан хэрэгжүүлдэг үндэсний төслийн баг манай орны хувьд цоо шинээр бүрэлдэж, монголчууд өөрсдийн мэдлэг, чадвар, оюун ухаандаа итгэж, хамтран ажиллаж, бие биеэ харилцан ойлгох, чадварт энэ төслийн хугацаанд бас амжилттай суралцсан.

Өнгөрсөн 1992-2017 оны 25 жилийн хугацаанд олон улсын байгууллага, хандивлагч орнууд манай орны улс төр, нийгмийн хөгжил, өөрчлөлт шинэчлэлийг ихээхэн анхааралтай харж, тусалж, дэмжлэг үзүүлж ирлээ. 1993-1994 онд Азийн Хөгжлийн Банкнаас Монгол Улсын Боловсрол, хүний хүчин зүйлийн секторын судалгаа, Мастер төлөвлөгөөг анх удаа боловсруулах ажлыг санхүүжүүлж дэмжсэн нь өнөөгийн орчин үеийн боловсролын шинэ тогтолцоог бүрдүүлэхэд цогц бодлого, онол арга зүй болоод практик амьдралын маш чухал алсын хараатай зөв хөрөнгө оруулалт болсон юм.

Мөн тэр үед ЮНЕСКО-гийн тусламжтайгаар "Говийн эмэгтэйчүүдийн боловсролыг дэмжих төсөл", мөн ДАНИДА-гийн дэмжлэгтэйгээр "Бага, дунд боловсролыг дэмжих төсөл" гээд Монгол орны боловсролыг хөгжүүлэх гадаадын хөрөнгө оруулалт орж ирэх үүүд хаалгыг нээсэн анхны чухал алхмууд хийгдсэн. 1990 оны эхээр манай орны боловсролын хөгжилд нэлээд дэмжлэг үзүүлж байсан хуучнаар ЗХУ тэргүүтэй социалист хамтын нөхөрлөлийн орнуудын дэмжлэг тусалцаа бүрмөсөн зогсноор олон улсын гадаад хамтын ажиллагааны бас зогссон цаг үе байлаа.

Харин 2000 оны эхний үеэс боловсролын салбарын гадаад хамтын ажиллагааны хүрээ тэлж хандивлагч олон улсын байгууллага, орны тоо нэмэгдэж, хамтын үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтын хүрээгээ улам бүр тэлж эхэлсэн байна. Энэ нь манай орны боловсролын хөгжлийг эрчимжүүлэх, олон улсын хөгжлийн түвшинд ойртуулах, монголчуудын сайн хөдөлмөрлөж, сайхан амьдрах боломжийг улам бүр нэмэгдүүлж байна.

Олон Улсын байгууллага, гадаад улс орны тусламжтай хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрүүд нь зориулалт, цаг хугацаа, хамрах хүрээ, санхүүжилтийн хэмжээ, эх үүсвэрээрээ өөр хоорондоо ялгаатай боловч эцсийн дүндээ Монгол орны боловсролын хөгжил, шинэчлэлийг дэмжих, монголчуудын ажиллаж, амьдрах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд зориулагдаж байгаа юм. 1993-1994 онд Азийн Хөгжлийн Банкны техникийн туслалцаатайгаар “Боловсрол, хүний хүчин зүйлийн Сектор Судлагаа болон Мастер Төлөвлөгөө”-г олон улсын нэр хүндэттэй их сургууль, судлагааны байгууллагын, тухайлвал, АНУ, Австрали, Хонг Конг, Энэтхэг, Японы зэрэг орны эрдэмтэн, судлаачтай хамтран боловсруулав. Энэхүү сектор судлагаа, мастер төлөвлөгөө нь зөвхөн боловсролын салбарт төдийгүй манай орны нийгэм, эдийн засгийн хүрээнд анх удаа олон улсын түвшинд орчин үеийн шинэлэг арга зүй, технологээр хийгдсэн юм.

Эдүгээ тодорхой салбар, орон нутгийн захиргаа, сургууль, байгууллага, бизнесийн секторынхон бүгд л сектор судлагаа, хөгжлийн стратеги мастер төлөвлөгөөгөө боловсруулан хэрэгжүүлж хэвшээд байна. Энэ нь боловсролын гадаад нээлттэй бодлого, хөрөнгө оруулалтын эхний үр дүн, нөлөө байлаа.

Боловсролын яаманд 1992-1997 онд 1,7 сая ам. долларын санхүүжилттэй Дани улсын ДАНИДА байгууллагын санхүүжүүлэлт, ЮНЕСКО-гийн дэмжлэгтэй “Монголын говийн малчин эмэгтэйчүүдийн сурах хэрэгцээг хангах албан бус боловсрол төсөл”, мөн ДАНИДА-гийн тусламжтайгаар “Монголын бага, дунд боловсролын хөгжлийг дэмжих төсөл” 1993-1997 онд 5,4 сая ам. долларын санхүүжилттэй тус тус хэрэгжив.

1994-1997 онд ЮНИСЕФ-ийн “Сургууль завсардсан хүүхдэд албан бус аргаар боловсрол нөхөн олгох” 120 мянган ам .долларын санхүүжилтэй төсөл, 1993-1994 онд Боловсролын яам, Боловсролын Хөгжлийн хүрээлэн ЮНЕСКО-той хамтран “Боловсролын удирдах ажилтны чадавхыг дээшлүүлэх” чиглэлээр төслийг хэрэгжүүлсэн зэрэг нь манай боловсролын салбарт хэрэгжсэн гадаадын томоохон төслүүдийн эхлэл болсон.

1997 оноос Соросын Нээлтэй Нийгэмлэгийн Сангийн дэмжлэгтэйгээр боловсролын салбарт сургуулийн өмнөх боловсролын алхам алхмаар төсөл, нээлттэй сургууль, дээд боловсролыг дэмжих хөтөлбөр, гадаадын тэтгэлэгт сургалт, багш хөтөлбөр, мэтгэлцээн хөтөлбөр гээд маш олон чиглэлээр төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн бөгөөд одоо ч зарим нэгэн нь амжилттай хэрэгжиж байна.

Дээрх боловсролын салбарт оруулсан гадаадын томоохон хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөрт Азийн Хөгжлийн Банк, ЮНЕСКО, ЮНИСЕФ, ДАНИДА, Австралийн Олон Улсын Хөгжлийн Сан, Соросын Нээлтэй Нийгэмлэгийн Хүрээлэн гээд олон улсын байгууллагууд, АНУ, Япон, Англи, Австрали, Дани, Швед, Норвеги, Тайланд гээд дэлхийн томоохон их, дээд сургуулийн эрдэмтэн судлаач, мэргэжилтнүүд зөвлөх судлаач, мэргэжилтнээр ажилласан нь манай орны боловсролын дэлхий дахинд хамтын үйл ажиллагааны нээлттэй бодлого боловсруулж, хэрэгжүүлэхэд маш их дэм туслалцаа болсон гэдгийг энд онцлон тэмдэглэх хэрэгтэй.

1993, 1994 онд боловсролын тогтолцоо гадаад улс орнуудад нээлтэй болж байсан тэрхүү тааламжтай цаг үе, нөхцөлд дэлхийн санхүүгийн томоохон байгууллагын нэг Азийн Хөгжлийн Банк нь манай орны боловсролын салбарын хүндрэл, бэрхшээл бодит хэрэгцээ, шаардлагыг маш соргогоор мэдэрч "Боловсрол, хүний хүчин зүйлийн сектор судалгаа, мастер төлөвлөгөө"-г боловсруулахад анхны хөрөнгө оруулалт хийсэн нь Монгол Улсын боловсролын цаашдын урт хугацааны хөгжилд маш чухал түүхэн үүрэг гүйцэтгэсэн юм.

Энэхүү анхны мастер төлөвлөгөөнд боловсролын чанар, үр ашиг, хүртээмжийг сайжруулах, менежментийн чадавхийг дээшлүүлэх, сургалтын агуулга, стандартыг боловсронгуй болгох, хүний нөөцийн чанар, хөгжлийг хангах, дээд боловсролын магадлан итгэмжлэлийг хөгжүүлж, мэдээллийн академик электрон сүлжээг байгуулах, сурах бичгийн чанар, агуулгыг сайжруулах, дэд бүтцийг хөгжүүлж, техникийн шинэчлэл хийх зэрэг олон чухал зорилтуудыг тусгаж байсан нь өнөөдөр бүгд бодит биеллээ олж Монгол Улсын боловсролыг дэлхий дахины орчин үеийн хөгжлийн түвшинд ойртуулахад бодиттой тус дэм болж чадсан юм.

Түүнээс хойш 2000 онд Монгол Улсын Боловсролыг 2000-2005 онд хөгжүүлэх Стратеги Төлөвлөгөө, 2006 онд Боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Мастер төлөвлөгөөг тус тус Азийн Хөгжлийн Банк, бусад олон улсын байгууллагын санхүүжилтын дэмжлэгтэйгээр боловсруулж Монгол Улсын Засгийн Газраар

батлуулан амжилттай хэрэгжүүлсэн. Тэдгээрт туссан олон арга хэмжээг бүтээлчээр хэрэгжүүлэхэд Азийн Хөгжлийн Банкны “Боловсролын Хөгжлийн Хөтөлбөр”-ийг 1996 оноос тодорхой чиглэсэн зорилготой олон талт бодлогын, оюуны болон капиталын хөрөнгө оруулалтыг шат дараалалтай хийж багагүй амжилт, үр дүнд хүрсэн байна.

Тэдгээр хөрөнгө оруулалтыг зориулалтын дагуу цаг хугацаанд нь чанар, үр ашигтай зарцуулж, түүнийг бодит баялаг, бүтээл, мэдлэг, чадвар болгож байдаг төслийн мэргэшсэн ажилтан, баг, хамтлагууд хөдөө орон нутаг, сургууль, байгууллагад бий болж төлөвшиж байгаа нь боловсролын салбарын хүний нөөцийг чанаржуулж, хөгжүүлэхэд нэн чухал ач холбогдолтой болсон.

Өөрөөр хэлбэл боловсролын салбар дахь гадаадын зээл, тусламжийн хөтөлбөр, төслийг монголчууд өөрсдийн хамтын оюун ухаан, хүч чармайлт, туршлагаар бие даан хэрэгжүүлдэг үндэсний төслийн баг манай салбарын хувьд цоо шинээр бүрэлдэж, монголчууд бид өөрсдийн мэдлэг, чадвар, оюун ухаандаа итгэж, хамтран ажиллаж, бие биеэ харилцан ойлгох мэдлэг, чадварт энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаанд бас амжилттай суралцсаар байна.

Энэхүү гадаад хамтын ажиллаганы төслүүдийн хүрээнд олж авсан шинэ мэдлэг, чадвар, туршлага нь боловсролын салбарын хөгжил, шинэчлэлийг эрчимжүүлэх, боловсролын үйлчилгээний хүртээмж, чанар, үр ашгийг дээшлүүлэх өргөн нөхцөл, боломжийг бий болгосон.

Боловсролын салбарын шинэчлэл, өөрчлөлтийг дэмжих зорилгоор Азийн Хөгжлийн Банкны туслалцаатай 1997-2002, 2003-2007, 2008-2012 онд хэрэгжүүлсэн “Боловсролын Хөгжлийн Хөтөлбөр”- 1, 2, 3 дугаар шатны төслүүдийн үндсэн зорилт нь боловсролын хөгжил, шинэчлэлийн бодлого, стратеги, Мастер төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжүүлэх, менежментийн чадавхийг дээшлүүлэх, бүх шатны боловсролын сургалтын агуулга, стандарт, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг шинэчлэх, боловсролын салбарын хүний нөөцийн хөгжил, мэдээлэл холбооны технологи болон англи хэлний сургалтыг дэмжих, сургууль, цэцэрлэгийн таатай орчин бүрдүүлэх, дэд бүтцийг хөгжүүлэх замаар боловсролын чанар, үр ашиг, хүртээмжийг дээшлүүлж, тэдгээрийг боловсролын орчин үеийн шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэн шинэчлэн, боловсронгуй болгох зэрэг тэргүүлэх ач холбогдол бүхий цогц асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэж байв.

Дэвшүүлсэн зорилтын хүрээнд юуны өмнө боловсролын ажил, үйлчилгээг сурагч, оюутан, иргэдэд илүү чанартай, тогтвортой хүргэх, сургалтын байгууллагын зохистой бүтэц, хэв шинж, байршил, оновчтой орон тоог бий болгохыг зорьсон бөгөөд энэ чиглэлээр нэлээд бодитой алхмуудыг хийж эдүгээ эхний тодорхой үр дүнгүүд гарсан. Тухайлбал, сургуулийн байр байшин, идэвхгүй үйл ажиллагааг санхүүжүүлэх



бус харин хүмүүсийн боловсрол эзэмших, боловсролын хүртээмжтэй, чанар үр ашигтай үйлчилгээ авах, сургалтын ажлыг илүү үр өгөөжтэй явуулах, тийм сонирхол төрөхүйц нөхцөл бололцоог бий болгох, зохимжтой уян хатан тогтолцоо бүрдүүлэх чиглэлээр бүтцийн өөрчлөлт хийж, үр ашиг багатай үрэлгэн зардлыг багасган, нийгмийн идэвхтэй оролцоо бүхий үйл ажиллагааг дэмжин, урамшуулж бодлогын, оюуны болон капиталын хөрөнгө оруулалт хийсэн.

“Боловсролын Салбарын Хөгжлийн Хөтөлбөр”-ийг хэрэгжүүлж буй энэхүү хугацаанд XXI зууны боловсролын эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцэхүйц хэд хэдэн агуулгын болоод тогтолцооны шинжтэй эерэг өөрчлөлтүүдийг хийлээ.

Ерөнхий боловсролын сургуулиас их, дээд сургууль, аймаг, нийслэлийн



боловсрол, соёлын төвөөс Боловсролын яам хүртэл боловсролын удирдлагын компьютерын мэдээллийн цогц сүлжээ манай оронд анх удаагаа бий болсон явдал чухал ач холбогдолтой. 400 орчим ЕБС болон боловсролын байгууллагуудад компьютерын

лаборатори, 110 гаруй сургуульд мэдээлэл харилцааны технологийн төв, боловсрол, шинжлэх ухаан, соёлын “Эрдэмнет” компьютерын сүлжээ, МУБИС-ийн МХТС-ийн техникийн шинэчлэл, номын санг байгуулахад хөрөнгө оруулалт хийв. Ингэснээр мэдээллийн технологийн шинэ зуунд манай оюутан, сурагч, багш нар өөрийн орны төдийгүй дэлхий дахины шинэ мэдээллүүдийг цаг тухайд нь авах, мэдээллээ солилцох өргөн таатай боломж нээгдлээ.

Дорнод, Дорноговь, Баянхонгор, Завхан, Ховд, Хөвсгөл аймгийн мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийг улсын хэмжээнд загвар сургууль болгон сонгон авч 5 тэрбум төгрөгийн иж бүрэн хөрөнгө оруулалт хийсэн нь мэргэжлийн болон техникийн боловсролын салбарын чанар, үр ашгийг дээшлүүлэх тал дээр шинэлэг алхам болсон юм.



Боловсролын салбарын хүний нөөцийн хөгжил, чанарыг дэмжих зорилго бүхий өөрийн орны эрдэмтэн багш нараас бүрдсэн үндэсний, орон нутгийн, сургуулийн сургагч багш нарын бүхэл бүтэн баг хамтлагууд бий болж, дипломын дараах сургалт явуулах таатай орчин, сургалтын агуулга, технологийн дэвшилтэт тогтолцоо бүрдэв. 45000 гаруй багшид боловсролын удирдах ажилтны мэргэжлийг дотоодод нь, 200 гаруй эрдэмтэн багшийг АНУ, Канад, Франц, Англи, БНСУ, Герман, Австрали, Тайланд, Сингапур, Хонг Конг, Филиппин зэрэг орны их сургуулиудад явуулж мэргэжил дээшлүүлсэн нь багшаар дамжуулж оюутан, сурагч, сургууль, боловсрол цаашилбал Монгол улсын хөгжил ирээдүйд оюуны дорвитой хөрөнгө оруулалт хийсэн гэсэн үг.

Дээд боловсролын магадлан итгэмжлэлийн тогтолцоог бүрдүүлж, 15 экспертийг Филиппины Манила хотод, дотооддоо 500 гаруй хүнийг сургалтад хамруулж,



магадлан итгэмжлэлийн ажлын албыг шинээр бий болгоход хөрөнгө оруулав. Боловсролын салбарт сүүлийн үед хийгдээгүй сургалтын техникийн шинэчлэлт хийлээ. Тухайлбал, 330 ЕБС-ийг хими, физик, биологийн 990 кабинет, бүх аймаг, хотын БСТ-үүдийг сургалтын тоног

төхөөрөмжөөр тоноглож, мөн УБИС, МУИС, ХоБДС-ийн хими, физик, биологийн хичээлийн лабораторийн багаж, техник хэрэгслийг шинэчилсэн. 310 гаруй Ерөнхий боловсролын сургуулийн, 500 гаруй хичээлийн болон дотуур байр, уурын зуух, гал тогоо, биен тамирын заал зэрэг барилга байгууламжийг засварлан, тохижуулж сургалтын таатай орчинг бүрдүүлэв.

Биеийн тамирын тоног төхөөрөмжийг 80 ЕБС-д, фермер, барилга, цахилгаан, нийтийн хоол, оёдол, үсчин гоо сайхан зэрэг мэргэжлийн баримжаа олгох боловсролын тоног төхөөрөмжийг 175 ЕБС-д, 6 настай хүүхдийн ангийн тавилга, тоног төхөөрөмжийг 100 ЕБС-д нийлүүлэв. 250 хүүхдийн цэцэрлэг-бага

сургуулийн цогцолборын барилгыг Дорнод, Төв, Өвөрхангай, Увс, Говь-Алтай, Архангай аймагт шинээр барьж, ашиглалтад авсан нь манай боловсролын салбарт хийгдсэн нэн шинэ алхмуудын нэгэн боллоо.



Сурах бичиг, сургалтын материал зохиох, хэвлэх, түгээх шинэ арга технологи бий болсны сацуу дээд сургуулиудын номын санг мэдээллийн орчин үеийн төв болгож шинэчлэв. ЕБС-ийн 120-оод, дээд боловсролын 170 гаруй сурах бичгийг шинээр хэвлэв. Их

дээд сургуулиудын номын санг баяжуулахад 300 гаруй сая төгрөг зарцуулж, тэдгээрийг төрөлжсөн мэдээллийн төв болгон өөрчилж электрон сүлжээнд холбосон. Номын санчдыг Манила, Тайланд болон өөрийн оронд урт, богино хугацаагаар сургав. Ерөнхий боловсролын 122 сургуульд цахим номын сангийн иж бүрэн хөрөнгө оруулалт хийж, номын санч, мэдээлэл зүйн багш нарыг сургалтад хамруулсан төдийгүй 33 ерөнхий боловсролын сургуульд багшийн хөгжлийн төв нийлүүлэв.

Азийн Хөгжлийн Банкны энэхүү төслийг амжилттай хэрэгжүүлсний эерэг үр дагавар нь хөдөөгийн жирийн сургуулийн багш, захирал, сурагч цаашилбал Засаг дарга, эцэг, эхээс авахуулаад яамны мэргэжилтэн, сайдаа хүртэл, бүр цаашилбал төр, засгийн удирдлага хүртлэх гадаадын зээл, тусламжийн төслийг зориулалтын дагуу ашиглах мэдлэг, чадвар эзэмшиж, туршлагажиж байгаад оршино. Төслийн менежментийн дээд сургуульд таван жил суралцаж төгссөнтэй адил ихээхэн зүйлсийг төслийн ажилтан, төслийг хэрэгжүүлэгчид сурч, хийж бүтээдэг боллоо.

Боловсролын салбарын зээлийн төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг Азийн Хөгжлийн Банк, Монгол Улсын Засгийн газар, сургууль, багш нар анхааран, ихээхэн ажиглаж, дор бүрнээ үнэлж, дүгнэж байлаа. Ялангуяа Азийн Хөгжлийн Банк ихээхэн анхаарч, хөтөлбөрийн хэрэгжилтийг дэмжиж байсны үр дүнд тус банкны гишүүн орнуудын боловсролын төслүүдээс хамгийн амжилттай хэрэгжиж буй төсөл гэсэн үнэлгээг өгч, тусгай дипломоор шагнасан.

Азийн Хөгжлийн Банкны боловсролын салбарын анхны томоохон хөрөнгө оруулалтын төслийн үр дүн, туршлагад түшиглэн Нордикийн Хөгжлийн Сан,

Дэлхийн Банк, Японы Ядуурлыг Бууруулах Сан, ЖАЙКА зэрэг байгууллага олон төслийг хэрэгжүүлсэн.

Төслүүдийн үр дүнг зөвхөн АХБ-наас хөрөнгө авч барилга байгууламж засварласан, компьютер, байгалийн ухааны лаборатори, цахим номын сан, багшийн хөгжлийн төв нийлүүлсэн гэдгээр үнэлж болохгүй. Зөвхөн АХБ-ны туслалцаатай хэрэгжсэн” Боловсролын Салбарын Хөгжлийн Хөтөлбөр- 1,2,3” нь гэхэд зөвхөн боловсролын шинэчлэлийг дэмжээд зогсоогүй манай орны олон зуун барилгын компани, барилгын материалын үйлдвэрлэл, худалдаа, хангамжийн байгууллагын үйл ажиллагааг дэмжих, тэднийг шинэ арга технологи, бараа, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, мониторинг-үнэлгээ, хариуцлагын шинэ технологид суралцахад нь ихээхэн бодлогын, оюуны хөрөнгө оруулалт хийсэн юм. Мөн давхардсан тоогоор 380 гаруй сургуулийн барилгын их засварыг хийсэн 380 гаруй компанийн (ойролцоогоор 1 компани 100-300 ажиллагчидтай гэвэл) дунджаар 38-114 гаруй мянган барилгачин, 1 барилгачны ам бүл 5 хүн гэвэл 150,000-570,000 гаруй монголчуудын цалин хөлс, нийгмийн асуудлыг шийдвэрлэсэн хэмээн үзэж болно.

Сургалтын орчны өнөөгийн байдал

Сургуулийн гадаад орчин

ЕБС-ийн стандарт боловсруулах нь өнөөгийн бодлого боловсруулагч, судлаачид, багш, сургуулийн удирдлагуудын өмнө тулгамдаж буй чухал асуудал болж байна. Энэхүү судалгаанд сургалтын орчныг “материаллаг буюу биет” орчны хүрээнд авч үзсэн бөгөөд сургуулийн гадаад орчин болох сургуулийн барилга байгууламж, тохижилт, эдэлбэр газар, түүний эрүүл ахуй, аюулгүйн нөхцөл, үйлчилгээний орчин (гадаад орчин), анги танхим, тавилга, тоног төхөөрөмж, боловсролын үйлчилгээ (дотоод орчин) гэсэн үндсэн 2 чиглэлээр сургалтын орчны өнөөгийн байдлыг тодруулахыг зорив. Үүнд нийт 44 (хотын 27, хөдөөгийн 17) сургуулийг түүвэрлэн авсан мэдээллийн үр дүнд тулгуурласан болно.

Судалгаанд хамрагдсан ЕБС-ийн талаарх ерөнхий мэдээлэл

Судалгаанд хөдөөгийн 3 бага, 10 бүрэн дунд, 5 цогцолбор сургууль, хотын 1 бүрэн бус дунд, 17 бүрэн дунд, 5 цогцолбор сургууль тус тус хамрагдсанаас дотуур байртай 8 сургууль байна. Эдгээр сургууль нь гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтын хэв шинжтэй ажээ. Барилгын норм ба дүрэм БНБД-II-66-88-д зааснаар ЕБС-ийн хүчин чадлыг тооцохдоо 33-44 анги танхимтай, 1 ангид 30-35 сурагч (хот, хөдөөд ялгаатай)-тай байхаар төлөвлөдөг байна. Судалгааны

дүнгээс үзвэл сургуулиудын 9 хувь нь 1 ээлжээр, 73 хувь нь 2 ээлжээр (үүнээс 59.3 хувь нь хот), 16 хувь нь 3 ээлжээр (үүнээс 100 хувь хот), 2 хувь нь холимог буюу 2.5 ээлжээр хичээллэдэг байна. Энэ тоон үзүүлэлт нь хотын сургуулиудын ачаалал хөдөөгийнхөөс их байгааг харуулж байна.


2010-2011 оны хичээлийн жилийн эхний үеийн статистикт 1 багшид ногдох хүүхдийн тооны улсын дундаж үзүүлэлт ЕБС-д 19.4, бага ангид 29.3 байна⁹² гэсэн үзүүлэлттэй байгаа ба судалгаанд хамрагдсан сургуулиудын дүнг дээрх үзүүлэлттэй харьцуулбал улсын дундажтай ойролцоо (20.3) боловч 1 багшид ногдох хүүхдийн тоо нийт бага ангид (34.3) 17 хувиар илүү, ахлах ангид (8.8) 55 хувиар дутуу байна. Эндээс бага ангийн багшийн ачаалал бусад ангиас их байгаа нь бага боловсролын түвшинд багш, сурагчийн сургах, сурах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх талтай.

Сургуулийн барилга байгууламжийн насжилт ба засвар

Юуны өмнө сургуулийн ашиглалтад орсон оныг сүүлийн 10 жилд барилгын их засварт хамруулсан байдалтай харьцуулан авч үзье (Зураг 20).

Нийт сургуулийн 55.5 хувь нь 30-50 жилийн настай (1960-1980), 27.5 хувь нь 10-30 жилийн настай (1980-2000) барилгууд байна. Сүүлийн 10 жилд барилга байгууламжид хийсэн засварын талаарх судалгаанд 40 сургууль (эдгээрийн 8 нь стандартын бус барилгад хичээллэж байна) 64 удаагийн их ба урсгал засвар хийснээс 12 сургууль нь их засвар хийжээ. 1940-1960 оны барилгад нийт их засварын 28.5 хувь, 1960-1980 оны барилгад 42.8 хувь, 1980-2000 оны барилгад 10 хувь, 2000 оноос хойших барилгад 25 хувь хөрөнгө оруулж, доод тал нь 1.1 тэрбум гаруй төгрөг зарцуулсан байна. Эндээс, барилган насжилт их байх тутам (ялангуяа, 30-аас дээш жилийн насжилттай) чанар нь муудаж, тэр хэмжээгээр хөрөнгө оруулалт их шаардах төлөв харагдаж байна.

Зураг 20. Барилга байгууламжийн насжилт



⁹² 2010-2011 оны Монгол Улсын статистик мэдээ

Сурагчдын дотуур байр: Судалгаанд хөдөөгийн 6, хотын 2 сургууль (үүнд: 1 нь бүрэн бус дунд, 5 нь бүрэн дунд, 2 нь цогцолбор сургууль) дотуур байртай байгаагаас нийт сурагчдын 9-24 хүртэлх хувийг хамруулж байна. Дотуур байранд амьдарч байгаа сурагчдын 23.5 хувь нь бага, 43.3 хувь нь дунд, 33 хувь нь ахлах ангийн сурагчид байгаагаас эмэгтэй 46-66 хувь байна. Дотуур байртай сургуулиудын тавилга, зөөлөн эдлэлийн хүрэлцээ, хангамжийн хувьд “хүүхэд бүрд хүрэлцээтэй” гэж 28.6 хувь, “зарим тавилга хүрэлцээгүй” гэж 57.1 хувь, “зөөлөн эдлэл, тавилгын аль аль нь хүрэлцээгүй” гэж 14.3 хувь нь хариулжээ. Мөн дотуур байрны халуун усны өрөөний эрүүл, аюулгүй байдлыг хангасан эсэх тал дээр эдгээр сургуулийн 57.1 хувь нь “охид хөвгүүдээр тусгаарлагдсан, халуун хүйтэн устай, гэрэлтүүлэх сайтай” гэж хариулсан бол үлдсэн хувь нь “зарим нөхцөлийг хангасан” гэжээ. Энэ байдлаас үзэхэд сурагчдын дотуур байрны үйлчилгээ, хангамжид цаашид анхаарч, төсөв хөрөнгийг аль ч түвшинд шийдэж байх зайлшгүй шаардлага урган гарч байна. Энэ нь сурагчдын эрүүл, аюулгүй, тохь тухтай сурч, амьдрах нөхцөлийг хангах маш чухал үзүүлэлт болно.

Сургуулийн эдэлбэр газрын тохижилт, аюулгүй байдал

БТХ-ийн 42.6-д “Боловсролын сургалтын байгууллага нь барилга, хот төлөвлөлтийн норм, нормативыг баримтлан тогтоосон, сургалтад зориулсан эзэмшил газартай байна” гэсэн заалтын дагуу судалгаанд хамрагдсан бүх сургууль “эдэлбэр газрын гэрчилгээтэй” гэж хариулсан байна. Барилгын норм ба дүрэм БНБДII-66-88-д заасны дагуу “сургуулийн эдэлбэр газар $15521.88 \pm 1780.8 \text{ м}^2$ байна” гэсэн үзүүлэлттэй судалгаанд хамрагдсан сургуулиудын эдэлбэр газрыг харьцуулбал $1369 \text{ м}^2 \div 6875 \text{ м}^2$ байна. Энэ нь барилгын норм дүрэмд заасан эдэлбэр газрын дундаж үзүүлэлтээс доогуур үзүүлэлт юм.

ЕБС-ийн эдэлбэр газрын орчны тохижилт, аюулгүй байдал нь сурагчдын сурах болон эрүүл орчинд амьдрах нөхцлийн нэг юм. Энэ үүднээс “сургуулийн ойр орчимд автомашины граж, согтууруулах ундаа болон тамхиар үйлчилдэг байгууллага бий эсэх, гаднах орчинд хамгаалалт, хашаа бий эсэх, хөгжлийн бэрхшээлтэй сурагчдад үйлчлэх боломжийг хэр хангасан эсэх” талаар ажиглалт хийхэд сургуулийн ойр орчим (50м газар) согтууруулах ундаа, тамхиар үйлчилдэг цэг байдаггүй гэж 22.7 хувь, ХБХ-д үйлчлэх боломжийг хангасан гэж 18 хувь байгаа нь хүүхдийн аюулгүй, эрүүл сурах орчин нөхцөлд сул анхаардгийг харуулж байна.

ЕБС-ийн эдэлбэр газрын талбайн цэцэрлэгжүүлэлт, гэрэлтүүлгийг авч үзвэл “Сургууль орчмын цэцэрлэгжүүлэлттэй” 41 сургуулиас 29.9 хувь, “гэрэлтүүлэгтэй” 30 сургуулиас 21.2 хувь нь тус тус “хангалттай” гэжээ.

Сургуулийн биеийн тамирын талбай, түүний ашиглалт

ЕБС-ийн биеийн тамирын талбайн хэмжээ нь БНБД II-65-79 шаардлагад заасанчлан сургуулийн бүтцээс хамаарч $7450\text{м}^2 \div 10170\text{м}^2$ байх ёстой ажээ. Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд биеийн тамирын талбайн хэмжээгээр дээрх шаардлагыг хангасан ердөө 2 сургууль (8000м^2 ба 10800м^2) байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Биеийн тамирын талбайг зориулалтын хувьд “хичээлийн үндсэн үйл ажиллагаанаас гадна секц, дугуйлан, спортын уралдаан тэмцээн зохион байгуулах буюу сургалтын зорилгоор” 67.9 хувь, “олон нийтийн үйл ажиллагаа урлагийн тоглолт уралдаан тэмцээн явуулах зорилгоор” 7.14 хувь, “сургалтын үйл ажиллагаа, уралдаан тэмцээн олон нийтийн үйл ажиллагаа зэрэг бүхий л үйл ажиллагааны зорилгоор” 21.43 хувь тус тус ашигладаг байна.

Барилга байгууламжийн эрүүл ахуйн нөхцөл

Халаалтын систем: Сургалт-хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм ба дүрэм (БНБД-II-66-88)-д заасны дагуу хүйтний улиралд сургууль, хичээлийн анги танхимын тасалгаа нь (биеийн тамирын заал 18 хэм, эмчийн өрөөнд 20 хэм) жигд 18 хэм байх ёстой ажээ. Энэхүү нөхцлийн биелэлтийг судалж үзэхэд судалгаанд хамрагдсан сургуулиудын 70.4 хувь нь төвийн системд холбогдсон, 9.1 хувь нь байгууллага дундын бойлертой, 18.2 хувь нь ердийн болон нам даралтын уурын зуухтай байна. Хотын 8, хөдөөгийн 17 сургууль дулааны төвлөрсөн системд холбогдоогүй байна.

Усан хангамж: Судалгаанд хамрагдсан нийт сургуулийн 88.6 хувь, үүнээс хотын сургуулийн 96.3 хувь, хөдөө орон нутгийн сургуулийн 76.5 хувь нь төвлөрсөн хангамжийн эх үүсвэртэй бол үлдсэн хувь нь төвлөрсөн бус (зөөврийн) ус хангамжийн эх үүсвэртэй байна. Төвлөрсөн бус усан хангамжийн эх үүсвэртэй сургуулийн 40 хувь нь гүний худгийн усыг унд ахуйн хэрэгцээндээ ашиглаж байна.

Нийт сургуулийн 79.4 хувь нь ариутгах татуургын сүлжээнд холбогдсон, үлдсэн хувь нь холбогдоогүй байна. Ариутгах татуургын сүлжээнд холбогдоогүй сургуулиуд нь бүгд хөдөө орон нутгийнх бөгөөд энгийн бие засах газрыг ашиглаж байна. Сургуулийн ариун цэврийн тоног төхөөрөмжийн ашиглалтыг татуургын сүлжээнд холбогдсон сургуулиудын хувьд авч үзвэл ердөө 18 хувь нь “20 эмэгтэй, 30 эрэгтэй сурагч тутамд 1 суултуур байх” гэсэн шаардлагыг хангасан гэж үзэж

болохоор байна. Иймд ариутгах татуургын сүлжээнд холбогдсон дийлэнх сургуульд энэхүү шаардлагын хэрэгжилт маш хангалтгүй байна. Ариун цэврийн өрөөг 6 настнуудад зориулж бусад ангиудаас тусгаарласан эсэх тал дээр нийт сургуулиудын 72.7 хувь нь “тийм” гэж хариулсан.

Боловсролын үйлчилгээний орчин


ЕБС-ийн үйл ажиллагааны үндсэн чиглэл нь сургалт мөн. Үүнээс гадна, багш сурагчдын ажиллах, суралцах, хүмүүжих зэрэг бусад үйл ажиллагаа явуулах боловсролын үйлчилгээний орчин бүрдүүлсэн байх нь чухал юм. Бид энэхүү судалгаагаар “боловсролын үйлчилгээний орчин” гэдэгт багш, удирдах ажилтны ажлын байрны хүрэлцээ хангамж, сурагчдын “хүүхэд хөгжил төв”, номын сан, интернэтийн үйлчилгээ, урлагийн заал, дотуур байрны хүрэлцээ хангамж, багш сурагчдад зориулсан цайны газар, эрүүл мэндийн үйлчилгээ зэргийг авч үзэв.

Багш, удирдах ажилтны ажлын нөхцөл

Судалгааны дүнгээс авч үзвэл 1 сургалтын менежерт дунджаар 36.6 багш (хотод 42.5, хөдөөд 27.6), багш нарын 1 өрөөнд 74.6 багш (хотод 88, хөдөөд 55) тус тус ногдож байна. Үүнээс үзэхэд “Багшийн хөгжлийн 1 танхимд 10-30 багш 1-2 ээлжээр ажиллана” гэсэн БСШУ-ны сайдын 114-р тушаалын заалт хот, хөдөөгийн судалгаанд хамрагдсан сургуулиудад хэрэгжихгүй байна. Өөрөөр хэлбэл, багшийн ажлын байрны тодорхойлолтод заагдсан чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, багш ажлын байрандаа мэргэжил, боловсролоо дээшлүүлэх, ээлжит хичээлдээ хамтран бэлтгэхэд шаардлагатай материаллаг болон технологийн орчныг танхимд бүрдүүлсэн байх шаардлага хангагдахгүй байна. Багш нарын өрөөнд ногдох багшийн тоогоор судалгаанд хамрагдсан сургуулиудаас хотын сургуулиуд дунджаас доогуур байгаа нь харьцангуй сайн үзүүлэлт гэж үзэх үндэстэй.

Сурагчдад үйлчлэх үйлчилгээ: Энд “Хүүхэд хөгжлийн төв”, “Урлагийн заал”, “Номын сан”, “Эмчийн өрөө”, “Интернэтийн үйлчилгээ”-тэй эсэхийг хот, хөдөөгийн сургуулиар авч үзэв (Зураг 21).

Зураг 21. Сурагчдад үйлчлэх үйлчилгээ



Судалгаанд хамрагдсан сургуулиудын 47.7 хувь нь хүүхэд хөгжлийн төвтэй, 56.8 хувь нь интернэтийн сүлжээнд холбогдсон, 61.4 хувь нь номын сантай, 63.6 хувь нь урлагийн заалтай, 70.4 хувь нь эмчийн өрөө (эрүүл мэндийн үйлчилгээ)-тэй байна. Номын сан, мэдээллийн төвтэй сургуулиудын хувьд уншлагын танхимын суудлын тоог авч үзье (хүснэгт 34).

Судалгаанд хамрагдсан номын сантай сургуулиудын номын фондод эзлэх сурах бичгийн тоог авч үзэхэд 50-70 хувь, 70-95 хувь сурах бичгээр хангагдсан сургуулиуд харьцангуй ойролцоо хувьтай байна. Харин номын фондын 95 хувь нь сурах бичгээр хангагдсан 1 сургууль байна.

Хүснэгт 34. Суудлын тоо

	Нийт, үүнээс хот, хөдөө (тоо/хувь)		
15 хүртэлх суудалтай	5 (16.1 хувь)	3	2
15-30 хүүхдийн суудалтай	19 (61.3 хувь)	8	11
30-50 хүүхдийн суудалтай	7 (22.6 хувь)	6	1

Номын фондын 30 хүртэл хувь нь сурах бичгээр хангагдсан сургуулиудын сурагчдын 61.3 хувь, 30-50 хүртэл хувь нь сурах бичигтэй сургуулиудын сурагчдын 30 орчим хувь нь “гэрээр ном авч уншдаг” байгааг тооцвол номын фондод сурах бичгээс бусад номын эзлэх хувь өндөртэй сургуулиудад хамаарч байна. Эндээс үзвэл багш сурагчдын бие даан хөгжих, даалгаврын санг баяжуулах болон бусад хичээл – сургалтын үйл ажиллагааг дэмжихэд чиглэсэн сүүлийн үеийн шинжлэх ухааны танин мэдэхүй, утга уран зохиолын болон бусад ном, гарын авлагаар номын фондыг арвижуулах шаардлагатай.

Компьютерын танхим: БСШУ-ны сайдын 2006 оны 413-р тушаалаар батлагдсан “ЕБС-ийн компьютерын танхимд тавигдах үлгэрчилсэн шаардлага”-ын 3.1-д “...доод тал нь сургалтын 12 компьютер, багшийн 1 компьютертэй байх”-аар заажээ. Энэхүү заалтын хэрэгжилтийг судалж үзвэл судалгаанд хамрагдсан сургуулиудын 91 хувь нь дээрх шаардлагыг хангаж байна. Харин 1 компьютерт

ногдох сурагчдын тоог авч үзвэл хамгийн багадаа 2.75 сурагч ногдож байгаа ганц л сургууль байгаа нь компьютерын хүрэлцээ хангамж хангалтгүй байгааг харуулж байна.

Биеийн тамирын заал: Биеийн тамирын заалны 60.9 хувь нь стандарт хэмжээ (БНБДИI-66-88-д зааснаар 9x18x6, 12x24x6, 18x30x6) – тэй, 39 хувь нь стандарт бус хэмжээ (6x21x4, 7x22)-тэй байна. Стандарт бус хэмжээтэй заалтай сургуулиудын хувьд спорт хорооны заал, хурлын заал ашиглан хичээл ордог байна. Сургуулиудын биеийн тамирын зааланд хувцас солих өрөөтэй эсэхийг судлан үзэхэд 45 хувь нь “тийм”, 55 хувь нь “үгүй” гэжээ. Суралцагчдын нас сэтгэхүй, биеийн ерөнхий онцлогоос хамааран биеийн тамирын зааланд сурагчдыг бага, дунд ахлах ангиар хичээллүүлэх шаардлага тавьдаг. “Бага ангийн сурагчид дунд, ахлах ангийнхантай хамт биеийн тамирын хичээл ордог” гэж сургуулиудын 47.5 хувь, “ордоггүй” 52.5 хувь нь хариулснаас үзэхэд бага ангийнхныг ялангуяа, 1-р ангийнхныг дунд, ахлах ангийнхантай хамт хичээллүүлж байгаа сургууль багагүй хувьтай байна.

Норм дүрэмд зааснаар биеийн тамирын заалны дулаан 18 ± 2 хэм байх ёстой. Биеийн тамирын заалны дулааны хэмийг ажиглалтын үеийнхээр (5 сар) авч үзэхэд 57 хувь нь “хэвийн”, 39 хувь нь “хүйтэн”, 4 хувь нь “бөгчим халуун” байсан бол гэрэлтүүлэг нь (40 сургуулийн хувьд) 70 хувь нь “тод буюу хангалттай”, 20 хувь нь “бүүдгэр”, 10 хувь нь “хангалтгүй” байна.

Биеийн тамирын зааланд 1 цагт хичээллэгчдийн тоог авч үзэхэд сургуулиудын 67.5 хувь нь 70-аас бага, 32.5 хувь нь 70-аас их сурагч хичээллэдэг байна. Үүнийг тодруулан авч үзэхэд заримдаа 3 анги хамт орох тохиолдол байхаас гадна 80-аас дээш сурагч хичээллэдэг сургууль 32.5 хувийг эзэлж байна. Эдгээр сургууль (32.5 хувь бүхий) – ийн 70 орчим хувь нь 2 ээлжтэй (3 ээлжтэй 1 сургууль байна) хотын сургууль байсан ба сургуулийн хүүхдийн ачаалал их байгаатай холбон үзэж байна.

Биеийн тамирын хичээлийг стандартын дагуу амжилттай зохион явуулах, суралцагчдын бие бялдрыг хөгжүүлэхэд хичээлийн хэрэглэгдэхүүн чухал үүрэгтэй. Нийт сургуулийн 68.2 хувь нь гимнастикийн савлуур, гүйлтийн зам, сагсан бөмбөг, гар бөмбөг, хөл бөмбөг “хүрэлцээтэй” гэж хариулсан бол 26.8 хувь нь “үгүй”, 4.6 хувь нь “дунд зэрэг” гэж хариулсан байна.

Дүгнэлт

1. Багш, сурагчийн харьцааны хувьд 2010-2011 оны хичээлийн жилийн эхний үеийн статистиктай харьцуулбал, улсын дундажтай ойролцоо (20.3), бага ангийн багшийн ачаалал дунд ба ахлах ангиас 13.4-15.7-оор их байгаа нь бага боловсролын түвшинд багш, сурагчийн сургах, сурах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх талтай.
2. Нийт сургуулийн 83 хувь нь 10-50 жилийн насжилттай, 17 хувь нь 50-70 жилийн насжилттай байгаа ба барилгын насжилт өндөр байх тутам чанар нь муудаж, засварт хөрөнгө их зарцуулагдахаар дүр зураг байна.
3. Сурагчдын дотуур байрны үйлчилгээ, хангамжийн шаардлагыг сургуулиудын 28.6 хувь хангаж байна.
4. Сургуулийн эдэлбэр газрыг зориулалтын дагуу ашиглана гэсэн заалт хэрэгжихгүй байна. Судалгаанд хамрагдсан сургуулиудын хувьд биеийн тамирын талбайн нормт хэмжээг хангасан ердөө 2 сургууль (8000м² ба 10800м²) байна.
5. Сургуулийн эрүүл ахуйн нөхцлийн хувьд дулааны эх үүсвэрийг бүрэн хангасан, цэвэр усыг төвлөрсөн усан хангамжийн эх үүсвэрээр хангасан, ариутгах татуургын сүлжээнд холбогдсон тус тус 88.6 хувьтай байна. Ариутгах татуургын сүлжээнд холбогдсон сургуулиудын ердөө 20 хүрэхгүй хувь нь 20 эмэгтэй, 30 эрэгтэй сурагч тутамд 1 суултуур байх шаардлагыг хангажээ.
6. Багшийн ажлын байрны тодорхойлолтод заасан чиг үүрэг, үйл ажиллагааг хэрэгжүүлэх, багш ажлын байрандаа мэргэжил, боловсролоо дээшлүүлэх, ээлжит хичээлдээ хамтран бэлтгэхэд шаардлагатай материаллаг болон технологийн орчныг танхимд бүрдүүлсэн байх шаардлага хангагдахгүй байна (1 танхимд 74.6 багш).
7. Нийт сургуулийн 47.7 хувь нь хүүхэд хөгжүүлэх төвтэй, 56.8 хувь нь интернэтийн сүлжээнд холбогдсон, 70.4 хувь нь эмчийн өрөөтэй, 63.6 хувь нь урлагийн заалтай байна.
8. Компьютерын танхимд “сургалтын 12 компьютер, багшийн 1 компьютертэй байх” шаардлагыг сургуулиудын 91 хувь нь хангаж байгаа ч 1 компьютерт ногдох сурагчдын тоог авч үзвэл хамгийн багадаа 2.75 сурагч ногдож байгаа нь компьютерын хэрэглээний хугацаа дууссан, хүчин чадал нь хүрэлцэхгүй компьютер их байгааг харуулж байна.
9. Биеийн тамирын заалны хүрэлцээ, үйлчилгээ дундаж хэмжээнд байна гэж үзлээ.

2. Анги танхимын орчин

“Сургалтын орчны өнөөгийн байдал” судалгаанд хамрагдсан сургуулиудын 200 анги танхимд хэмжилт, ажиглалт хийж, Барилгын норм ба дүрэм (БНБДИ-66-88), 6-17 насны хүүхдийн өсөлт хөгжлийн судалгаа (Д.Ганбат нарын), ЕБС-ийн орчны эрүүл ахуйн үнэлгээ (НЭМ-ийн хүрээлэн, ЭМЯ, 2008), ОХУ-ын Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын орчинд тавигдах эрүүл ахуйн шаардлагууд (СанПиН 2.4.21178-02) зэрэг баримт бичиг, судалгааны үр дүнтэй харьцуулан анги танхим, сандал ширээ, самбарын зохист хэмжээ; өнгө, гэрэлтүүлэг, дулаан, агааржуулалт зэрэг эрүү ахуйн нөхцлүүдийг судалсан үр дүнг танилцуулж байна.

а. Анги танхимын ерөнхий үзүүлэлтүүд

Анги танхимын хэмжээ: Сургуулиудын анги танхимын хэмжээ нь тухайн сургууль хэдэн онд, ямар стандартаар, хэдэн хүүхдийн хүчин чадалтай байхаар төлөвлөгдсөнөөс хамаарч янз бүр байна. Барилгын норм ба дүрэм (БНБДИ-65-79)-д ердийн хичээллэх ангийн талбайн хэмжээ 48-50 ам.м, кабинет лабораторийн зориулалттай танхимын талбай 66-72 ам.м, Сургалт – хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм ба дүрэм (БНБДИ-66-88)-д ердийн хичээллэх ангийн талбайр 50-60 ам.м, кабинетийн зориулалттай ангийн талбай хичээлийн чиглэлээс хамаарч 60-70 ам.м байхаар тусгажээ. Судалгааны явцад хэмжилт хийсэн анги танхимуудын 47 хувь нь “Сургалт – хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм ба дүрэм (БНБДИ-66-88)-д заасан хэмжээнд нийцэж байсан (хотод 18.6 хувь, орон нутагт 37.5 хувь) бол үлдсэн 53 хувь нь дээрх нормт хэмжээнээс зөрүүтэй байв. Үүнийг хот, хөдөөгөөр авч үзвэл хот 81.5 хувь, орон нутгийн сургуулийн 62.5 хувь нь анги танхимын зохист хэмжээнээс их эсвэл бага байна.

Ангид байрлуулах сандал, ширээний хэмжээ (урт, өргөн), хананаас ширээ хүртэлх 4 талын зайг тооцвол ангийн урт, өргөний дундаж хэмжээ 6х8 ам.м байна. Судалгаанд хамрагдсан ангиудын уртын хамгийн их хэмжээ 13м, хамгийн бага нь 3.7м; өргөний хамгийн их хэмжээ 9.2м, хамгийн бага нь 2.4м байгаагаас үзэхэд сурагчид харилцан адилгүй талбай, хэмжээтэй ангид хичээллэж байна.

Хүснэгт 35. Анги танхимын талбай

д/д		Анги танхимын урт ≈8м	Ялгаа	Анги танхимын өргөн ≈6м	Ялгаа	Талбай 55-60м ²	Эзлэх хувь
1.	а. Хамгийн их	13м	+5 м	4.2 м	-1.8 м	54.6 м ²	2
	б. Хамгийн бага	3.7 м	-4.3 м	3.7 м	2.3 м	13.69 м ²	

2.	а. Хэт нарийн	13 м	+5 м	4.2 м	-1.8 м	54.6 м ²	8.5
	б. Хэт өргөн	11 м	+3	7 м	+1	77 м ²	

Дээрх хүснэгтээс харахад эхний тохиолдлын хувьд судалгаанд хамруулсан анги танхимууд нь талбайн зохист хэмжээг хангаж байгаа ч гэсэн хэт нарийн урт, эсвэл хэт өргөн богино ангиудад (нийт судалгаанд хамрагдсан ангийн 13.5 хувь) сурагчид хичээллэж байна. Эхний ангийн хувьд самбар дээрх бичээс харагдахгүй байх, багшийн яриа бүдэг сонсогдох гэх мэт хүндрэл учрах бол 2 дахь тохиолдлын хувьд захын ширээний сурагчдад самбар дээрх гэрлийн ойлт 30⁰-аас бага болж, бичигдсэн зүйлс харагдахгүй байх (харааны гажиг үүсэх), нэг зүг рүү удаан харж суух (хүзүү, нуруу нугалмайн хөгжилд сөргөөр нөлөөлөх) зэргээр сурагчдын эрүүл, тохь тухтай орчинд сурах эрхийг хязгаарлаж байна.

Анги танхимын хана, шалны өнгө

Анги танхимын ханын өнгөний сонголт нь байгалийн гэрлийн тусгалын коэффициентийг зохицуулах, анги танхимд тусах гэрэлтүүлгийн хэмжээг дээд зэргээр ашиглах, мөн ангийг адил хэмжээнд гэрэлтүүлэхэд дэмжлэг болно. ОХУ-ын Ерөнхий боловсролын сургуулиудын сургалтын орчинд тавигдах эрүүл ахуйн шаардлагууд (СанПиН 2.4.2.1178-02)-ын 2.1.6-д “Анги танхимын ханын өнгө нь хурц шар, ногоон, цэнхэр өнгөтэй байх нь тохиромжтой” гэжээ. Судалгаанд хамрагдсан ангиудын 90 гаруй хувийн хана нь шар, ногоон цэнхэр өнгөтэй байгаа нь дээрх шаардлагад нийцэж байна. Хөдөө орон нутгийн сургуулиуд ихэвчлэн бор болон ногоон өнгийн ханатай байгаа бол хотын сургуулиудын хана голдуу цайвар ногоон, цэнхэр өнгөтэй байна.

Ангийн шалны өнгөний сонголт нь шар, цайвар, шаравтар, бор, боровтор өнгө 92.7 хувь, ногоон, ногоон эрээн, цайвар, цагаан өнгө үлдсэн хувийг эзэлж байна.

Гэрэлтүүлэг, дулаан, агааржуулалт

Байгалийн гэрэлтүүлэг ихэвчлэн зүүн талаас байгаа нь БНБДИ-66-88-ын заалттай тохирч байгаа бөгөөд “бусад” гэдэгт ихэвчлэн баруун талаас болон ар талаас, зарим тохиолдолд 2 талаас (баруун ба зүүн зүгээс) байгалийн гэрэлтүүлэгтэй байна.

Анги танхимын 7 хувь нь компьютерын кабинетын тохижилттой байгаа бөгөөд эдгээрийн 35 хувь нь зүүнээс бус сурагчдын араас байгалийн гэрэлтүүлэгтэй байгаа нь компьютерын дэлгэцэнд гэрэл ойх, сурагчдын хараанд сөргөөр нөлөөлөх талтай.

Зохиомол гэрэлтүүлгийн хувьд анги танхимын ихэнх нь тод гэрэлтүүлэгтэй байгаа хэдий ч 23.5 хувь нь бүүдгэр болон хангалтгүй гэрэлтүүлэгтэй байв. Гэрэлтүүлэг

хангалтгүй ангид хичээллэх нь хүүхдийн хараа муудах эмгэг үүсгэдэг болохыг зарим судлаачид (О.Н.Савельев, 1989, В.В.Коваленко, 1970) тогтоосон байдаг бөгөөд ийм сөрөг нөлөө үзүүлж болзошгүй байгааг⁹³ дээрх судалгааны дүн харуулж байна.


Эрүүл ахуйн нормд заасны дагуу анги танхимын агаарын хэвийн хэм 18 ± 2 байх ёстой ба судалгааны дүнг үүнтэй харьцуулбал, нийт ангийн 77.5 хувь, хотын 79.8 хувь, орон нутгийн 74.1 хувь нь хэвийн, харин нийт анги танхимын 15 хувь, хотын 16 хувь, орон нутгийн 13.6 хувь нь нормоос бага (16 хэмээс бага) гарсныг судалгаа авах үед төвлөрсөн системийн халаалт зогссонтой холбон тайлбарлаж байна.

Агааржуулалтын хувьд ажиглалт хийсэн нийт анги танхимын 64.1 хувь нь хэвийн буюу хичээл хооронд салхивч нээж, агаар оруулдаг бол 31.3 хувь нь хэт хуурай эсвэл чийгтэй, таагүй үнэртэй байна. Агааржуулалтыг хот ба хөдөөгөөр авч үзвэл хотод 65.7 хувь, хөдөө орон нутагт 69.5 хувь нь “хэвийн”, харин “хуурай”, “бөгчим” агааржуулалттай анги танхим нь 3 ээлжтэй сургуулиудад хамаарагдаж байна.

Кабинет, түүний ашиглалт

Судалгаанд хамрагдсан сургуулиудын 156 кабинетийг хичээлээс хамааруулан дараах зурагт харуулав.

Зураг 22. Кабинетийн зориулалт



Зургаас харахад судалгаанд хамрагдсан ангиудын хувьд 38.5 хувь нь математик, монгол хэл болон гадаад хэлний хичээлээр кабинетийн гэрчилгээ авсан байна. Ажиглалт хийсэн кабинетийн 21.4 хувьд 5-11-р ангиуд хичээллэдэг ба кабинетийн системээр хичээллэх явцад хүүхэд хүссэн хүсээгүй тохирохгүй ширээнд сууж байна. Ердийн сургалттай ангид сурагчдын нуруу нугалмын гажиг 11 хувиас хэтрэхгүй байхад кабинетийн системээр хичээллэгчдийн дунд 22.8 хувь байжээ⁹⁴.

⁹³ЕБС-ийн орчны эрүүл ахуйн үнэлгээ., НЭМ-ийн хүрээлэн, ЭМЯ, 2008
⁹⁴ ЕБС-ийн орчны эрүүл ахуйн үнэлгээ., НЭМ-ийн хүрээлэн, ЭМЯ., 2008

Хүснэгт 36. Кабинетийн талбай

Кабинет	Бодит хэмжээ (м ²)	Нормт хэмжээ (м ²)	Хангалт
Математик, монгол хэл, уран зохиол, газар зүй, дуу хөгжим	23.4 – 65.4 ам.м	50-66 ам.м	27.2 хувь
Гадаад хэл	18.7 – 64.8 ам.м	32-50 ам.м	57.1 хувь
Байгалийн ухаан	41.4-69 ам.м	66 ам.м	5.3 хувь
Техник технологи	36-65.9 ам.м	66 ам.м	24 хувь

Дээрх хүснэгтээс харахад Барилгын норм ба дүрмийн 3.10-т заасан кабинетийн талбайн нормт хэмжээг сайн хангахгүй байна. Бид судалгаанд хамрагдсан математик, монгол хэлний хичээлийн кабинет бүрийн талбайн хэмжээг норм, дүрэмд заасан хэмжээ (50-66м²)-тэй харьцуулан авч үзэв. Монгол хэлний кабинетийн 21.5 хувь, математикийн кабинетийн 40 хувь нь сургалтын кабинетийн талбайн нормт хэмжээтэй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Кабинетаар хичээллэж буй анги танхимд хийсэн ажиглалт судалгаанаас үзэхэд:

- Сурагчид хамтран ажиллаж туршилт, ажиглалт, тооцоо судалгаа, нээлт хийх, мэдлэг бүтээх орчин бүрдүүлсэн байх (2.1.4),
- Сургалтын хэрэглэгдэхүүнийг тогтмол, үр өгөөжтэй хэрэглэж тооцоо судалгааг хийсэн байх (2.1.6),
- Кабинетийн хананд байрлуулсан үзүүлэх материалууд, мэдээллийн самбарууд нь үзэгдэхүйц том үсгээр бичигдсэн, харааны түвшинд тохирсон байх (2.2.6) гэсэн “Кабинетийн гэрчилгээ олгох заавар”-т заасан шаардлагууд хангалтгүй түвшинд (7.5 хувь) байгааг дурдах хэрэгтэй.

Нэг хүүхдэд ногдох талбайн хэмжээг нормтой харьцуулахад⁹⁵ нийт сургуулийн 32.5 хувь, хотын сургуулийн 34.4 хувь, орон нутгийн сургуулийн 29.4 хувь нь нормт хэмжээнээс бага байна.

Бүлэг дүүргэлт (бага, дунд, ахлах ангиар)

Судалгаанд хамрагдсан ангиудын 29 хувь нь бага анги байна. Бүлэг дүүргэлт 25-32, хөдөө орон нутагт дунджаар 31.2 (19-40) байгаа бол хотод 35.8 (10-51), хамгийн ихдээ 51 сурагчтай анги байгаагийн зэрэгцээ 36 болон түүнээс дээш сурагчтай анги 22.7 хувийг эзэлж байна. Судалгаанд хамрагдсан ангиудын 53.4 хувь нь 1 дүгээр анги байна.

Судалгаанд хотын сургуулиудын 39, хөдөөгийн сургуулиудын 24 дунд анги хамрагдсанаас 7-9 дүгээр ангийн бүлэг дүүргэлт дунджаар 29-30, хамгийн багадаа 12, ихдээ 46 байна.

⁹⁵ Нэг хүүхдэд ногдох талбайн дундаж хэмжээ 1.5м² байна гэж барилгын норм дүрэмд заасан байдаг.

Ахлах ангийн 56 анги танхимд ажиглалт хийснээс бүлэг дүүргэлт дунджаар 27.9, хамгийн багадаа 12, дээд тал нь 46 байна. Судалгаанд хамрагдсан ангиудын сурагчдын тооны дундаж нь 29, хүйсийн харьцаа хотод 13:16 (охид), хөдөө орон нутагт 13:15 (охид) байна. Эндээс үзвэл бүлэг дүүргэлт ба хүйсийн харьцаа хот, хөдөөд ойролцоо байна. Энэ үзүүлэлт нь анги ахих тутам тогтвортой байв. Судалгаанд хамрагдсан ангиудын 34.5 хувь нь бүлэг дүүргэлт дунджаар 30 байх ёстой (БНБД 31-03-03-ын 2.7) гэсэн эрүүл ахуйн нормоос хэтэрчээ.

Самбар

Самбарын хэмжээ нь 100-420 см урттай, 90-150 см өргөнтэй, шалнаас 40-110 см өндөрт байгаа (хүснэгт 3) нь БНБД-3-11-д заасан самбарын уртын хэмжээ 3-4.5м байна гэсэн үзүүлэлтэд хүрэхгүй байна.

Хүснэгт 37. Самбарын хэмжээ (см)

	Урт	Өргөн	Шалнаас дээш
Хэмжээ	100-420	90-150	40-110
Хот	150-420	95-150	52-110
Хөдөө	100-369	90-150	40-110

Самбарын байршил буюу шалнаас самбарын доод ирмэг хүртэлх зайг үзвэл 40-110 см байна. Самбарын доод ирмэг шалнаас 47-69 см-ээс доошгүй өндөртэй байх шаардлагыг судалгаанд хамрагдсан ангиудын 7 хувь нь хангаж байна.

Самбарын доод ирмэгээс шал хүртэлх зохист хэмжээг дараах хүснэгтэд харуулав:

Хүснэгт 38. Шалнаас самбарын доод ирмэг хүртэлх зай (см)

Анги	Нас	Зохист хэмжээ (см)
Ахлах	17	69
	16	
Дунд	15	64
	14	
Бага	13	61
	12	
	11	56
	10	
Бага	9	51.6
	8	
	7	47
6		


Самбарын өнгө

Самбарын зохист өнгөний сонголтын талаар судалгаанд авч үзсэн стандартууд, норм дүрэмд тодорхой тусгаагүй байна. Иймд бид уг судалгаанд ОХУ-ын Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын орчинд тавигдах эрүүл ахуйн шаардлагууд

(СанПиН 2.4.2.1178-02)-ын 2.6.1-д “Ангийн самбар хар ногоон, хар хүрэн байна” гэсэн заалтыг үндэслэн судалгааны боловсруулалтыг хийв.

Судалгаанд хамрагдсан ангиудын 55.5 хувь нь ногоон болон хар ногоон өнгийн самбар ашиглаж байна. Орон нутгийн сургуулиуд бусад өнгө буюу цагаан, хар, хар саарал, ягаан гэх мэт төрөл бүрийн өнгөтэй самбар ашиглаж байна.


Зураг 23. Самбарын өнгө



Ажиглалт судалгаанд хамрагдсан ангиудын 66.5 хувь нь ногоон, хар ногоон, хүрэн, бор хүрэн өнгөтэй самбар байгаа нь өнгөнд тавигддаг нийтлэг шаардлагад нийцэж байна.

Ширээ, сандлын хэмжээ

Сурагчдын ширээ, сандлын зохист хэмжээг гаргахын тулд 6-17 насны хүүхдийн өсөлт хөгжлийн дундаж хэмээг 2003 онд судалж гаргасан Английн эрдэмтэн Ж.Дрейфусын судалгааг ашиглав. Эрдэмтний үзсэнээр, аль ч насны хүүхдийн суух байрлалд тохирсон сандал ширээний зохист хэмжээ нь дараах зурагт үзүүлснээр байх ёстой ажээ.



Хэдийгээр сүүлийн жилүүдэд хүүхдийн өсөлт хөгжлийн акселераци явагдаж байгаа ч Монгол улсын хэмжээнд хийгдсэн хүүхдийн өсөлт хөгжлийн судалгааны үр дүнг дээрх судалгаатай харьцуулан үзвэл 2008 онд хийсэн Д.Ганбат нарын судалгаатай тохирч байгаа юм. Ж.Дрейфусын судалгааг ашиглан Монгол хүүхдийн өсөлт хөгжилд тохирох сандал, ширээний зохист хэмжээг хүснэгт 38-д тооцоолон гаргав.

Ажиглалт судалгаа хийсэн анги танхимд буй ширээний хэмжээ нь 37-180 см урт, 34-120 см өргөн, 40-100 см өндөр, харин сандлын хэмжээг авч үзвэл 26-175 см урт, 13-55 см өргөн, 30-90 см өндөртэй байна. Ширээний өндөр 47-69 см байх шаардлагыг судалгаанд хамрагдсан сургуулиудын 27.5 хувь, сандлын өндөр 28-43 см байхыг 66 хувь нь хангаж байна. Ялангуяа, бага ангийн сурагчид тохирохгүй ширээ, сандалд сууснаас тэдний

өсөлт, биеийн галбирт нөлөөлөх, бусад өвчин эмгэг үүсэх зэрэг сөрөг нөлөөтэй. В.П.Неделью (Киев, 1970)-ийн тогтоосноор “бага ангийн сурагчдын 18.9 хувь нь нуруу нугалмайн хэв гажсан, энэ байдал анги ахих тутам өсч байгаа нь ажиглагдсан бөгөөд 1 дүгээр ангийн сурагчдын 15.3 хувийн нуруу нугалмайн хэв гажсан байсан бол 4 дүгээр ангид 21 хувь болж өсчээ⁹⁶.

Хүснэгт 39. Сандал, ширээний зохист хэмжээ (хөвгүүд/охид)

Нас	Хүүхдийн өндөр (см)	Сандлын өндөр (см)	Ширээний өндөр (см)
17	173.2	43.18	68.6
	161.5	40.64	
16	170.9	43.18	
	161.3	39.37	
15	166.6	40.64	63.5
	160.5	39.37	
14	160.0	40.64	
	158.2	38.1	
13	153.7	39.37	61
	153.9	38.1	
12	147.8	36.83	
	149.9	37.34	
11	142.7	35.56	55.9
	143.5	36.57	
10	137.9	35.56	
	137.7	33.02	
9	133.1	33.78	51.6
	132.1	33.02	
8	128.0	33.02	
	127.0	31.75	
7	122.4	30.48	47
	121.7	29.21	
6	117.1	29.46	
	116.3	27.94	

Ширээний хэмжээ (ангиар)

Ширээний хэмжээг бага, дунд ба ахлах ангиудаар авч үзье. Бага ангийн хувьд сурагчдын 33.3 хувь нь нэг сурагчийн суух зориулалттай ширээнд хичээллэж байна. Ажиглалт судалгаанд хамрагдсан ангиудын 94.6 хувь нь 57 см-ээс дээш өндөртэй ширээтэй байгаа нь сурагчийн ширээний өндөр 47-55 см байх ёстой гэсэн зохист хэмжээнээс илүү байна. Зөвхөн 5.4 хувь нь л зохист хэмжээг хангаж байна. Дунд ангийн 61 анги танхимд ажиглалт хийснээс хотын 38, хөдөөгийн 23 байгаагаас ширээний урт нь 60-180 см, өргөн нь 40-90 см, өндөр нь 55-93 см байгаа бөгөөд сурагчдын 3.2 хувь нь нэг сурагчийн суух зориулалттай ширээнд

⁹⁶ Цэрэнжигмэд Г. “Бага ангийн сурагчдын эрүүл ахуйн мэдлэг, дадлыг тэдний өвчлөл, сургалтын орчинтой холбож судалсан нь”, УБ 1997 он

хичээллэж байна. Дунд ангийн ширээний өндөр 60-64 см байх шаардлагыг зөвхөн 3.3 хувь хангажээ.

Ахлах ангийн 56 анги танхимд ажиглалт хийснээс хотын 21, хөдөөгийн 36 анги хамрагджээ. 91.1 хувь нь хосоороо суух зориулалттай ширээнд хичээллэж байгаа бөгөөд ахлах ангийн ширээний өндөр 64-68.6 см байна гэсэн үзүүлэлттэй харьцуулахад 6.2-10.8 см-ээр илүү байгаа нь тухайн насны сурагчдын хувьд тохиромжгүй хэмжээ юм. Энэ шаардлагыг судалгаанд хамрагдсан ангиудын 9 хувь нь л хангаж байна.

Сандлын хэмжээ

Судалгаанд хамрагдсан ангиудын сандлын зориулалт нь 1 сурагчийн ба хосоор суух (вандан сандал) гэсэн 2 янз байна. Нийт ангийн 22.5 хувь нь сурагчид ганцаар суух сандалтай бол 75 хувь нь хосоороо суух зориулалттай вандан сандалтай байна. Гэтэл гадаад улс орнуудын сургалтын орчны стандартад вандан сандал хэрэглэхийг хориглодог.

Бага ангийн сурагчид 30-120 см урт, 13-47 см өргөн, 30-50 см өндөртэй сандалтай байна. Бага ангийн сандлын өндөр 28-35.5 см байна гэж заасан хэмжээнээс 2-14.5 см-ээр өндөр байгаа ба 37.5 хувь нь зохист хэмжээг хангаж байна.

Дунд ангийн сандал 30-120 см урт, 13-55 см өргөн, 33-55 см өндөртэй байна. 35.5-40.2 см өндөртэй байх шаардлагыг 60.6 хувь нь хангахгүй буюу зохист хэмжээнээс 1-15 см-ээр өндөр байна.

Судалгаанд хамрагдсан ахлах ангийн сурагчид 30-175 см урт, 14-46 см өргөн, 34-90 см өндөртэй сандалтай байна. Тухайн насны хүүхдүүд 39.4-43.2 см өндөртэй сандал хэрэглэх шаардлагыг 44.6 хувь нь хангаж байна. Судалгааны мэдээллээс үзэхэд ахлах ангид 39.4 см байх минимум хэмжээнээс намхан, эсвэл 43.2 см байх максимум хэмжээнээс өндөр сандалтай анги 55.4 хувь байгаа нь тухайн насны хүүхдийн ашиглах сандлын зохист хэмжээнээс хол зөрүүтэй байна.

Ширээ сандлын байршил, эгнээ хоорондын зай

Судалгаанд хамрагдсан ангиудын 87.5 хувь нь ширээ сандлыг уламжлалт буюу 3 эгнээгээр байршуулсан байна. “Барилгын норм ба дүрэм” (БНБД II-65-79)-ийн 3.11-д зааснаар анги танхимд ширээ сандлыг 3 эгнээгээр байрлуулсан тохиолдолд ширээнүүдийн эгнээ хоорондын зай 50-60 см байх шаардлагыг судалгааны явцад ажиглалт хийсэн анги танхимын 51 хувь нь хангаж байгаа бол 15 хувь нь хэт ойр, 30 хувь нь хэт хол байна. Хөдөө орон нутагт эгнээ хоорондын зай 39.5 хувь нь хэвийн, 8.6 хувь нь хэт ойр, 46.9 хувь нь хэт хол байгаа бол хотод

19.3 хувь нь ойр, 58.8 хувь нь хэвийн, 18.4 хувь нь хэт хол байгаа үзүүлэлт гарч байна.

Дүгнэлт

- Судалгаанд нийт 200 анги танхимуудад хэмжилт хийснээс 47 хувь нь Сургалт – хүмүүжлийн байгууллагын барилга төлөвлөлтийн норм ба дүрэм (БНБДИ-66-88)-д заасан 50-66 м² байна гэсэн хэмжээнд нийцэж байна. Нийт ангиудын 90 гаруй хувь нь шар, ногоон, цэнхэр өнгөтэй ханатай байгаа нь шаардлагад нийцэж байна.
- Анги танхимын гэрэлтүүлгийн хувьд нийт ангийн байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг нь БНБДИ-66-88-ын заалттай тохирч байна.
- Дулаан хангамж хэвийн анги 77.5 хувь, дулааны норм буюу 16 хэмээс бага анги 15 хувь байгаа нь судалгаа авах үед төвлөрсөн системийн халаалт зогссон үетэй давхацсантай холбоотой.
- Кабинетийн системээр хичээллэж буй анги танхимд хийсэн ажиглалт судалгаанаас үзэхэд “Кабинетийн гэрчилгээ олгох заавар”-т заасан 2.1.4, 2.1.6, 2.2.6 шаардлагууд тэр бүр биелэхгүй байна.
- Бүлэг дүүргэлтийн хувьд бага ангид 25-32, дунд ангид 29-30, ахлах ангид 27.9 байгаа нь 2010 оны улсын статистиктай харьцуулбал ойролцоо байна. Сурагчдын жөндөрийн харьцаа дунджаар 14:15, анги төгсөх тутам тогтвортой байна.
- Самбарын доод ирмэг шалнаас 47-69 см-тэй байх шаардлагад судалгаанд хамрагдсан ангиудын 7 хувь хамрагдаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.
- Ажиглалт судалгаанд хамрагдсан ангиудын 66.5 хувь нь ногоон, хар ногоон, хүрэн, бор хүрэн өнгийн самбартай байгаа нь самбарын өнгөнд тавигддаг нийтлэг шаардлагад нийцэж байна.
- Ширээний өндөр 47-68.6 см байх шаардлагыг судалгаанд хамрагдсан сургуулиудын 27.5 хувь, сандлын өндөр 28-43 см байх шаардлагыг 66 хувь нь хангаж байна. Ялангуяа, бага ангийн сурагчид тохирохгүй ширээ, сандалд сууснаар тэдний өсөлт, биеийн галбирт сөргөөр нөлөөлөх, бусад өвчин үүсэх орчин бүрдсэнийг анхаарах шаардлагатай.
- Сандлын өндрийн зохист хэмжээг бага ангийн 37.5 хувь, дунд ангийн 39.4 хувь, ахлах ангийн 44.6 хувь тус тус хангаж байна. Судалгаанд хамрагдсан аль ч ангийн сурагчдын талаас илүү хувь нь тохирохгүй сандалд сууж байна.

- Ширээ сандлын хоорондох зохистой хэмжээг хангаж байгаа анги 51 хувь байгаа нь хангалтгүй үзүүлэлт болно.

3. Сурагчдын сурлагын амжилт ба сургуулийн уур амьсгалын зарим хүчин зүйлийн хоорондын хамаарал

Сургуулийн эрхэм зорилго нь сурагчдын сайн сайхан байх, сургуульдаа дуртай байх нөхцөлийг хангах, улмаар тэдний хичээл, сурлагадаа амжилт гаргахад нь туслан дэмжихэд чиглэх ёстой. Бид энэхүү өгүүлэлд сурагчдын сурлагын амжилтад нөлөөлдөг олон хүчин зүйлийн дотроос сургуулийн уур амьсгал буюу “зөөлөн” орчны нөлөөлөл бий эсэхийг тодруулахыг зорив. Ингэхдээ Боловсролын хүрээлэнгээс 2013-2014 онд хийгдсэн бага боловсролын сургалтын үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх туршилт судалгааны мэдээлэлд боловсруулалт хийж, Бага ангийн сурагчдын сурлагын амжилт (сорилын оноо)-д гэр бүлийн уур амьсгал, эцэг эхийн оролцоо, багшийн харилцаа, үе тэнгийнхний хандлага зэрэг сургуулийн уур амьсгалыг тодорхойлох зарим хүчин зүйлс шууд хамааралтай байна гэж үзэв.

Сургалтын орчин: Утга ба хамаарал

Сургалтын орчин ба сурлагын амжилт хоорондын хамаарал

Сурах ба сургах орчинд нөлөөлөх олон хүчин зүйлүүдийн нэг нь сургалтын орчин юм. Сурах ба сургах үйл ажиллагааны материаллаг ба материаллаг бус орчны нэгдлийг сургалтын орчин гэх ба материаллаг орчныг *хатуу* (hard), материаллаг бус орчныг *зөөлөн* (soft) орчин гэж тодорхойлж болно. Материаллаг бус буюу зөөлөн орчин нь сургуулийн уур амьсгал бөгөөд үүнийг сэтгэл зүй, нийгэм, соёлын орчин гэж ойлгож байна. Энэхүү “хатуу” ба “зөөлөн” шинж чанарын орчин нь хоёулаа сурлагын амжилтанд нөлөөлж байгааг олон олон судалгаа харуулж ирсэн байна.

Материаллаг орчин нь ерөөсөө сурагчдын сургуульд явах, сурах, улмаар амжилттай сурахад нөлөөлөх чухал хүчин зүйл байсаар ирсэн. Ялангуяа агаарын хэм, чанар, гэрэлтүүлэг, дуу чимээ зохистой хэмжээндээ байхгүй байх нь (Higgins. 2005, p.36) сурагчдын анхаарал төвлөрөх, сэтгэл тайван, сайн сайхан байх, хичээл сургуульдаа дуртай явах зэрэгт болон эцсийн эцэст суралцагчийн амжилт гаргахад хортой нөлөөтэй (Beunon 1997, p.22). Мөн самбар шохой, суух, бичихэд тухтай ширээ сандал, цүнх, ном дэвтэр зэрэг юмс, эд зүйлээ хийх сав шүүгээ, үзүүлэн таниулах хэрэглэгдэхүүн гэх мэт энгийн зүйлүүд нь сурлагын амжилтанд нөлөөлдөг суурь хүчин зүйлүүд байсаар ирсэн (Beunon 1997, p.21). Материаллаг

орчны энэхүү хамгийн бага, наад захын шаардлагууд хангагдсан ч сургалтын үйл явцад үзүүлэх нөлөө нь хялбар харагдахгүй, учир шалтгааны холбоо хамаарал нь улам бүр төвөгтэй болж ирсэн байдаг. Харьцуулах боломжтой орчинд, тохь тухтай, өнгө үзэмж сайтай сургуульд сурагчдын сурлагын амжилтын түвшин нь ядуувтар байшин барилгатай сургуулийн сурагчдынхаас илүү байсан тохиолдлууд АНУ-д ажиглагдсан байна (Веупон 1997, р.22).

Материаллаг бус орчны нөлөө сурах ба сургах үйл ажиллагаанд нэн чухал болох нь тодорхой болж хүлээн зөвшөөрөгдөөд байна. Энэхүү зөөлөн орчин гэдгийг сэтгэл зүй, нийгэм болон соёл гэсэн ухагдахууны талаас нь авч үздэг бөгөөд үүнийг сургуулийн “уур амьсгал” гэж нэрлэж болох юм. Хэдийгээр сургуулийн уур амьсгал тухайн үндэсний болон орон нутгийн онцлог нөхцөл байдлаас ихээр хамаарах боловч дараах хүчин зүйлүүдийг цаашдын хөгжилд хэлэлцэн авч үзэх нь чухал юм. АНУ дахь “Сургуулийн Уур амьсгалын Зөвлөл” (2007)-өөс сургуулийн уур амьсгал гэдгийг дараах байдлаар тодорхойлсон байна: “Сургуулийн уур амьсгал нь сургуулийн амьдрал дахь хүмүүсийн үйл ажиллагааны загвар, хэв маяг дээр суурилдаг ба энэ нь норм хэм хэмжээ, зорилго, үнэт зүйлс, хүмүүсийн хоорондын харилцаа, сурах ба сургах үйл ажиллагаа, байгууллагын бүтэц зэрэгт тусгалаа олсон байна”.

Америк болон Британы сургуулийн нөхцөлд бие махбодын, нийгэм сэтгэл зүйн аюулгүй байдал, харилцааны асуудал болон нийгмийн дэмжлэг нь сургалтын орчны хамгийн чухал талбар байдаг байна (Нийгэм, Сэтгэл зүйн Боловсролын төв. 2010, х.1).

“Сургуулийн уур амьсгал” ойлголтыг тодотгох нь

Сургуулийн уур амьсгал нь сургалтын орчны амин чухал, салшгүй хэсэг болохын хувьд сурагчдын сурлагын амжилтанд нөлөөлдөг хүчин зүйлийн нэг гэдгийг хүлээн зөвшөөрөхөөс өөр аргагүй юм. Сургуулийн уур амьсгал гэдэгт *нийгэм сэтгэл зүйн аюулгүй байдал, хүмүүсийн хоорондын харилцаа, засаглал болон удирдлагын нээлттэй зарчмууд, багш сурагчдын сургах ба сурах үйлийн илрэл* зэрэг материаллаг бус ойлголтуудыг багтаана.

Сургуулийн тогтсон соёл, ёс заншил, хамтаараа эрхэмлэх үнэт зүйлс, эрхэм зорилго, алсын хараа болон сурах, сургахуйн эерэг орчин нь сургууль хөгжүүлэх төлөвлөгөө, хүний нөөцийн зохистой хуваарилалт, нийгмийн тэгш оролцоо, багийн ба хамтын үйл ажиллагаа, хувь хүний хөгжил дэвшил, шударга ёс, мэдээллийн болон санхүүгийн нээлттэй, ил тод байдлаар илэрдэг. Эдгээрийг

сургуулийн уур амьсгалыг тодорхойлох нийгэм сэтгэл зүйн ерөнхий үзүүлэлтүүд ч гэж ойлгож болох ба нөгөө талаар тухайн сургуулийн бусдаас ялгарах нийтлэг хэв шинж болдог байна. Иймээс сургуулийн уур амьсгалын талаарх эдгээр ойлголтуудыг материаллаг орчинтой адил хатуу чанд стандартчилж болохгүй ч олон тооны судалгааны ажлуудад тэдгээрийн зохистой хэр хэмжээ хэрхэн чухал болох талаар дүгнэн харуулсан байдаг.⁹⁷ Тухайлбал, “Сургуулийн уур амьсгал нь сурагчдын сурлагын амжилтанд болон тэдний сайн сайханд нөлөөлөөд зогсохгүй хувь хүний болон ниймийн хөгжилд нөлөөлдөг (OECD 2009, р.4)”, “Америк болон Британы сургуулийн нөхцөлд аюулгүй байдлын хэм хэмжээ, дүрэм журам, бие махбодын болон нийгэм сэтгэл зүйн аюулгүй байдал ба харилцааны асуудал болох хүүхдүүд ба томчуудад үзүүлэх нийгмийн дэмжлэг туслалцаа нь хамгийн чухал талбар байдаг байна (Нийгэм, Сэтгэл зүйн Боловсролын төв. 2010, х.1)” гэсэн судалгааны дүгнэлтүүд гарчээ.

Сургуулийн уур амьсгалын чухлыг судалгаануудад нэлээд онцлон тэмдэглэсэн байдаг ч энэ талаар боловсролын бодлогод сайн тусгаж чадаагүй байдаг ажээ. АНУ-д “Сургуулийн уур амьсгалын Зөвлөл”-ийн (2007, х.8) үзэж байгаагаар сурагчдын сурлагын амжилтыг тайлбарлахад сургуулийн уур амьсгал гэх хүчин зүйлийг хайхардаггүй, авч үздэггүй нийтлэг үзэгдэл байна гэжээ.

Манай улсын хувьд энэхүү ойлголттой хамаарал бүхий зарим заалтуудыг Боловсролын багц хууль, Хүүхдэд Ээлтэй Сургуулийн бодлого (2004), “Боловсрол” Үндэсний хөтөлбөр (2009), Ерөнхий боловсролын сургуулийн үлгэрчилсэн дүрэм (2010), Ерөнхий боловсролын сургууль болон цэцэрлэгийн багшийн ёс зүйн дүрэм (2007) зэрэг янз бүрийн түвшний эрх зүйн баримт бичгүүдэд тусгаж, зохицуулсаар байна.


Сурлагын амжилт ба нийгэм-сэтгэл зүйн орчны хамаарал

Сурагчдын хичээлд оролцох оролцоо vs Сурлагын амжилт: Бага боловсролын чанарын шинэчлэлийн туршилтад хамрагдсан сурагчдын хичээлд оролцох оролцоо нь тэдний сурах хүсэл эрмэлзэл, сургууль, багш, найз нөхөддөө итгэх итгэл, өөрийгөө үнэлэх үнэлэмжийн илэрхийлэл болж сурлагын амжилт гаргахад чухал нөлөөтэй хүчин зүйл гэж үзэн Боловсролын хүрээлэнгийн судлаачид хичээлийн ажиглалт хийх замаар тэмдэглэл хөтөлж, судалгааг явуулав. Ингэхдээ ажигласан сурагчдын тухайн өдрийн хичээлийн даалгавар гүйцэтгэл, идэвх оролцоо (хичээл дээр гар өргөх, асуултад хариулах гэх мэт үйлийн тоо) ямар

⁹⁷ Илүү дэлгэрэнгүй мэдээллийг АХБ-ны “Санхүүгийн хямралын үед боловсролын үйлчилгээг нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүргэх нь” төслийн “Сургалтын орчин” гэсэн бүрэлдэхүүн хэсгийн “Олон улсын харьцуулсан тайлан”-аас (2013) харна уу.

байгааг хэмжээсжүүлсэн⁹⁸ бөгөөд улмаар тэдний хичээлд оролцох оролцоонд анги зохион байгуулалтын хэлбэр нөлөөтэй болохыг тодруулав (Зураг 23).


Зураг 24. Сурагчдын оролцоо ба анги зохион байгуулалтын хэлбэр



Зургаас харахад хичээлийг баг, хэсгээр зохион байгуулах нь сурагчдын хичээлд оролцох оролцоог нэмэгдүүлдэг гэсэн дүгнэлтэд хүрч болохоор байна.


Судалгаанд хамрагдсан сурагчдын оролцоо 2 дугаар шатны судалгаанд 1 дүгээр шатны судалгаанаас 0.28-аар ахисан байна (Зураг 25).

Зураг 25. Сурагчдын идэвх, оролцоонд гарсан өөрчлөлт



Анги зохион байгуулалтын хэлбэр сурагчдын идэвх оролцоонд нөлөөтэй байсан бол сурагчдын амжилт (сорилын оноо)-д ямар нөлөө үзүүлж байгааг харъя (Зураг 26).

Зураг 26. Анги зохион байгуулалт ба сурлагын амжилтын хамаарал



Зургаас харахад ангийг П үсгэн хэлбэрээр зохион байгуулахад сурагчдын сорилын оноо хамгийн өндөр, удаах нь багийн зохион байгуулалтын хэлбэрээр хичээллэсэн сурагчдын үзүүлэлт өндөр байна. Боловсруулалтын үр

дүнгээс харахад $p\text{-value}$ ⁹⁹ 0.05-аас бага байгаа нь анги зохион байгуулалт сорилын оноо хооронд ач холбогдлын түвшинд ялгаа байгааг харуулж байна.


Сурагчдын стрессийн түвшин: Сурагчдын хичээлд оролцох идэвх оролцоо 2 шатны судалгааны харьцуулалтаар сайжирсан, эерэг үзүүлэлттэй гарсан тул сэтгэлзүйн сорилоор тэдний стрессийн түвшинд эерэг өөрчлөлт гарсан байх ёстой гэсэн таамаглал дэвшүүлж гарааны судалгааны сэтгэлзүйн сорилоор

⁹⁸ Хэрэв сурагч тухайн өдрийн хичээлийн турш 1-3 удаа гар өргөсөн бол 1; 4-6 удаа өргөсөн бол 2; 7-9 удаа өргөсөн бол 3; 10-12 удаа өргөсөн бол 4; 13-аас дээш удаа өргөсөн бол 5 гэх байдлаар ангилж, кодолсон болно.

⁹⁹ $p\text{-value}$ - ач холбогдлын түвшинг илэрхийлдэг ба 0.05-аас бага байх тохиолдолд хамаарлыг ач холбогдолтой гэж үздэг.

сурагчдын CO¹⁰⁰ буюу сэтгэц мэдрэлийн байдлыг илтгэсэн үзүүлэлт үр дүнгийн судалгаагаар хэрхэн өөрчлөгдсөнийг авч үзэв.

Зураг 27. Сурагчдын стрессийн өөрчлөлт



Дээрх зургаас харахад судалгаанд хамрагдсан сурагчдын хувьд стрессийн түвшин судалгааны хооронд эрс өөрчлөгдсөж, (4-р ангиас бусад ангийн сурагчдын хувьд) өсөх хандлагатай болсон нь сөрөг үзүүлэлт болох талтай бөгөөд сурагчдын стрессийн түвшин яагаад өссөн нь сонирхол татсан үр дүн болж байна. Иймээс бид асуудлыг тодруулахын тулд сурагчдын гэр бүлийн уур амьсгал, эцэг эхийн оролцоо, багшийн харилцаа, үе тэнгийнхний хандлага зэрэг үзүүлэлт нь сорилын оноотой ямар хамааралтай байгааг нарийвчлан авч үзлээ.


Гэр бүлийн уур амьсгал vs Сурлагын амжилт: Хүүхдийн сурлагын амжилт, хүмүүжил төлөвшилд хамгийн чухал нөлөө үзүүлдэг хүчин зүйл бол гэр бүлийн орчин нөхцөл юм. Судалгаанд хамрагдсан эцэг эхчүүдээс өгсөн хүүхдийн сурлагын амжилтад гэр бүлийн орчин хэр хэмжээгээр нөлөөлж буй талаарх мэдээлэлд үндэслэн шинжилгээ хийж үзэхэд, хэдийгээр ач холбогдлын түвшинд ялгаатай биш ч гэсэн ар гэрийн таагүй уур амьсгалын нөлөө ихтэй сурагчид гэр бүлд нь иймэрхүү нөлөө бага зэрэг, эсвэл огт байдаггүй гэж хариулсан хүүхдүүдтэй харьцуулахад даалгаврын сорил дээр бага оноо авсан байна. Судалгааны энэ үр дүнг сурагчдаас авсан асуулгын дүн ч баталж байна. Тэднээс гэрийн ажил хэр хийдэг вэ гэсэн асуулт асуусан ба “байнга хийдэг” гэж хариулсан хүүхэд “ихэнхдээ”, “заримдаа”, “үгүй” гэсэн хариулт сонгосон сурагчдаас доогуур буюу хамгийн бага оноо авчээ.

Эцэг эхийн оролцоо vs Сурлагын амжилт Сургуулиас зохиогдсон ажилд эцэг эхчүүд идэвхтэй оролцдог эсэх нь сурагчдын амжилтад хэрхэн нөлөөлдгийг сонирхож үзэв. Эцэг эх нь сургуулийн ажилд ихээр оролцдог хүүхдүүд даалгаврын сорилд харьцангуй өндөр оноо авсан байна (График 5). Сургуулиас

¹⁰⁰ CO үзүүлэлт бага байвал эерэг үзүүлэлт гэж үзнэ.


зохион байгуулагдаж буй ажилд идэвхтэй оролцож байгаа нь хүүхдийнхээ сурлага, хүмүүжилд анхаарч, санаа тавьж буйн нэг илрэл юм.

Зураг 28. Эцэг эхийн оролцоо ба сурлагын амжилтын хамаарал




Багшийн дарамт шахалт vs Сурлагын амжилт: Багшаас сурагчид үзүүлж буй дарамтыг эцэг эхчүүдээс авсан мэдээлэлд үндэслэн тодорхойлохыг хичээв (Зураг 28). Багшийн дарамт их байхад сурагчдын даалгаврын сорилын оноо бага байгаа нь харагдаж байна. Багшийн дарамт, сурагчдын сурлагын амжилт буурахад нөлөөлж байгаа ба үзүүлэлт нь ач холбогдлын түвшинд хамааралтай байгаа юм.

Зураг 29. Багшийн дарамт шахалт ба сурлагын амжилтын хамаарал



Үе тэнгийнхний харилцаа vs Сурлагын амжилт: Сургуулийн орчин, тэр дундаа үе тэнгийнхэн болон найз нөхдийн харилцаа, хандлага нь сурагчдын амжилтад нөлөөлөх гол хүчин зүйлсийн нэг байдаг. Судалгаанд хамрагдсан сурагчдын даалгаврын сорилын оноог үе тэнгийнхний харилцааны дарамттай хамааруулж үзэхэд энэ нөлөө их байх тусам сурагчдын даалгаврын сорилын оноо бага байсан ба энэ нь ач холбогдлын түвшинд хамааралтай байв (Зураг 29).

Зураг 30. Үе тэнгийнхний харилцааны дарамт ба сурлагын амжилтын хамаарал



Судалгаанаас дараах дүгнэлт гарсан байна. Үүнд:

- Онолын судалгааны түвшнээс авч үзэхэд сурагчдын сурлагын амжилтад “хатуу” ба “зөөлөн” шинж чанарын орчин хоёулаа нөлөөлдөг болохыг харж болох бөгөөд ялангуяа, сургуулийн уур амьсгал (өөрөөр хэлбэл, зөөлөн орчин)-ын нөлөөлөл бий гэдгийг хүлээн зөвшөөрдөг хэдий ч боловсролын бодлогод төдийлөн тусгаж чаддаггүй байна.
- Бага боловсролын үндэсний шинэчилсэн хөтөлбөрийн туршилтын судалгааны дүнгээс авч үзэхэд хичээл, сургалтыг зохион байгуулахдаа сурагчдыг баг, бүлэг, хэсгийн хэлбэрээр буюу оролцоог тэгш хангасан анги зохион байгуулалт нь тэдний сурах идэвх сонирхлыг нэмэгдүүлж, тэр хэрээр амжилт гаргахад эерэг нөлөөтэй байна.
- Бага ангийн сурагчдын стрессийн түвшин 2 шатны судалгааны хооронд ихэнх ангиудад нэмэгдсэн байсныг гэр бүлийн таагүй уур амьсгал, эцэг эхийн сул оролцоо, багшийн сөрөг харилцаа, үе тэнгийнхний дарамт шахалт зэрэг нийгэм-орчны сөрөг хүчин зүйлтэй холбоотой гэж үзэв.
- Бага ангийн сурагчдын сурлагын амжилт (сорилын оноо)-д дээр дурдсан хүчин зүйлс (өөрөөр, зөөлөн орчны нөлөө) шууд хамааралтай байна гэж үзэх хангалттай нотолгоо олдсон болно. Тодруулбал, сурагчдын сорилын оноо нь гэр бүл, эцэг эх, багш, найз нөхдийн харилцааны эерэг нөлөөлөлд өндөр, харин сөрөг нөлөөлөлд хамгийн бага утгатай гарсан байна.

Монголын боловсролд хэрэгжүүлсэн гадаадын хөрөнгө оруулалттай төсөл, хөтөлбөрүүд

Төслүүдийн үр дүнд монголчууд зөвхөн өөрсдөдөө төдийгүй гадаадын бусад улс орнуудад боловсролын бодлогын, оюуны хөрөнгө оруулалт хийж, боловсролоо экспортлох чадвар бүхий баг, хамтлаг бүрдэж, оюун ухааны хөрөнгө оруулагч хандивлагч орон болох бололцоо, нөхцөл бий болж байна гэдэг өөдрөг үзлээр төсөл, хөтөлбөрийн үр дүнг үнэлэх шаардлагатай.

Манай оронд 1990-2000-аад онд хэрэгжсэн төслийн хүрээнд цоо шинээр бий болсон цогцолбор, сум дундын бүсийн төв сургуулиудын бүтэц, хэв шинжийг хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнууд төдийгүй дэлхийн хөгжилтэй Япон, АНУ, Тайланд зэрэг орнууд ихээр байгааг олон улсын судлаачид сайшаан тэмдэглэж байсан.

Боловсролын салбарт кластерээр хөгжих шинэ дэлхий дахины хэмжээний загварыг боловсролын бүсийн сургуулиуд, цогцолбор сургуулийн шинэ бүтэц,

хэлбэрийг бий болгосон нь маш чухал боловсролын брэнд болсон хэмээн үздэг. Онол-арга зүйг монголын боловсрол судлачид, эдийн засагчид бүхэн боловсруулсан нь цаашид боловсролд оруулах бодлогын болоод оюуны шинэ хөрөнгө оруулалтыг бий болгосонтой адил юм.

Олон улсын хурал, цуглаан дээр монголын боловсролд олсон ололт амжилтыг сайшаан дэмжиж, урамшуулж байсанд монголчууд бид баярлаж бахархахын сацуу бий болсон ололт, амжилт, туршлагаа улам баталгаажуулж, сайжруулах, гадаад, дотоодод сурталчилж, ойлгуулах шаардлагатай байгаа юм.

Эдүгээ манай орны 50 гаруй цогцолбор сургуульд таван сурагчийн нэг, таван багшийн нэг нь тус тус сурч, ажиллаж байна

Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаар дамжин хүн бүхний сэтгэлгээ, хандлага, арга барилд шинэ өөрчлөлт гарсан нь чухал үр дүн юм. Аливаа төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүн бол олон хүний хамтын оюун ухаан, хүч хөдөлмөрөөс хамаарч байдаг.

1997-2012 онд хэрэгжүүлсэн хамгийн томоохон хандивлагч Азийн Хөгжлийн Банкны "Боловсролын Хөгжлийн Хөтөлбөр" нь бусад гадаадын олон улсын байгууллагын төслүүдээс ялгагдах гол онцлогийг дараах байдлаар дурьдаж болно.

Нэгдүгээрт, энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлэх техникийн туслалцаа, бодлогын, оюуны, капиталын хөрөнгө оруулалт нь өөр хоорондоо логик залгамж холбоотой. 1997-2012 он (төсөл бүр 5 жилийн) буюу 15 жилд нийт 52 гаруй сая ам.долларын өртөгтэй хөнгөлөлттэй зээлийн цогц хөрөнгө оруулалт хийсэн юм. Урьд өмнө, эдүгээ ч боловсролын салбарт хэрэгжиж буй гадаадын бусад төсөл нь төрөлжиж дагнасан богино хугацааны, ихэнхдээ техникийн туслалцаа, буцалтгүй тусламжийн хэлбэртэй байдаг. Бага хөрөнгөөр хичнээн олон асуудлыг шийдвэрлэж, шинэ зүйлийг бүтээж болдгийг дээр дурдсан энэхүү багц төслийн үр дүн маш тодорхой харуулж байна. Эдүгээ 4-30 тэрбум төгрөгөөр 1 эмнэлэгийн барилгыг барих, 4 - 6 тэрбум төгрөгөөр 1 сургуулийн хичээлийн барилгыг шинээр барьж байгааг харьцуулан үзэж болно.

Хоёрдугаарт, АХБ-ны зээлийн БХХ-ийн өдөр тутмын үйл ажиллагаа, санхүүжилт, хяналт үнэлгээний болоод удирдлага, зохион байгуулалт, зохицуулалтын ажлыг дотоодын төсөл хэрэгжүүлэх алба, үндэсний зохицуулагчид бие даан өөрсдөө хийдэг бол бусад техникийн туслалцааны төслийн үйл ажиллагааг гадаадын санхүүжүүлэгч байгууллага, гадаадын зөвлөхүүд голчлон эрхлэн явуулдаг.

Гуравдугаарт, БХХ нь бага, дунд, дээд боловсролын хүрээнд Монгол орны бүх аймаг, нийслэл, сум, дүүргийн нийт сургууль, багш, ажилтан, сурагчдад хүрч байдаг бол бусад төслүүд нь тодорхой салбар, хэсэг сонирхлын бүлгийг хамардаг.

Дөрөвдүгээрт, БХХ нь сургуулийн барилгын засвараас авахуулаад менежментийн чадавхийг дээшлүүлэх, сургалтын агуулга, технологи, сурах бичиг, номын санг шинэчлэх, сургагч багшийг бэлтгэх замаар багшийн мэргэжлийг дээшлүүлэх, компьютерын сүлжээ, мэдээлэл холбооны технологийг хөгжүүлэх, сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангадаг.



Тавдугаарт, энэхүү төслийг удирдаж хэрэгжүүлэх хамтын менежментийн олсон туршлага дээр тулгуурлаж тэдний удирдлага дор АХБ-ны төдийгүй Нордикийн Хөгжлийн Сан, Дэлхийн Банк, ЖАЙКА-гийн хөрөнгө оруулалтын олон төслүүд маш амжилттай хэрэгжиж байгаа

бөгөөд Боловсролын Хөгжлийн Хөтөлбөрийн удирдлага дор 2007-2013 онд хэрэгжсэн Дэлхийн Банкны дэмжлэгтэй хэрэгжсэн “ Үр Дүнд Түргэн Хүрэх Санаачлагын Түншлэл” төслийн хэрэгжилтийн явц нь 2009 онд дэлхийн 70 гаруй улс орноос хамгийн сайн хэрэгжсэн 5 төслийн нэг нь болж, Зүүн Өмнөд Азийн 6 орны боловсролын төлөөлөгчид монголын туршлагаас судалж, өндрөөр үнэлсэн гээд боловсролын амьдралын олон талт үйл ажиллагааг цогцоор хамарч байдгаараа онцлогтой.

Мөн энэхүү дээрх төслийн үргэлжлэл болж 2009-2014онд Азийн Хөгжлийн Банкны тусламжтай “Боловсролын Салбарын Шинэчлэл” MON-0125, “Боловсролын салбар дахь хямралыг сааруулах төсөл” MON-0158, “Дээд Боловсролын шинэчлэлийн Төсөл” MON, Японы Ядуурлыг Бууруулах Сангийн тусламжтай “Хөдөөгийн, нүүдэлчин болон шилжин



суурьшигчдийн хүүхдэд сургуулийн өмнөх боловсрол олгох” төсөл тус тус амжилттай хэрэгжиж дууссан.

Түүнчлэн 2000 оноос боловсролын салбарт Английн болон Японы Хүүхдийг Ивээх Сан, Дэлхийн Зөн, Соросын Нээлтэй Нийгмийн Хүрээлэн, Швейцарийн Хөгжлийн Сан, ТАСИС, ТЕМПУС, КОЙКА, GTZ, АДРА SIDA гээд олон улсын байгууллагууд бага, дунд хэмжээний санхүүжилттэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүллээ.

Судалгаанаас үзэхэд дээрх олон улсын хандивлагчдаас ЮНЕСКО, ЮНИСЕФ, Хүүхдийг ивээх сан зэрэг байгууллагууд хамгийн олон чиглэл, нэр төрлийн дунджаар 10,000-300,000 ам.долларын бага оврын санхүүжилтэй төслийг, харин Соросын Сангийн Нээлтэй Нийгмийн Хүрээлэн, Дэлхийн зөн нь дунджаар 30,000-500,000 ам.долларын хэмжээтэй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн байна.

Монгол улсын боловсролын салбарт, ялангуяа сургуулийн өмнөх боловсрол, Бага, дунд боловсролын салбарт ЕБС, цэцэрлэгийн бүтэц, хэв шинж, зохион байгуулалтыг оновчтой болгох, сургалтын орчинг сайжруулах, удирдах ажилтан, багшлах боловсон хүчний боловсрол, мэргэжлийг дээшлүүлэх, ингэснээр боловсролын чанар, үр өгөөжийг сайжруулах зорилгоор 1990-ээд оноос олон хөтөлбөр, төсөл хэрэгжиж эхэлсэн юм.

Өнгөрсөн хугацаанд боловсролын салбарт “Бүх нийтийн суурь боловсролын үндэсний хөтөлбөр” (1995-2000), “Албан бус боловсролын үндэсний хөтөлбөр” (1997-2004), “Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр” (1995-2000) зэрэг үндэсний хэмжээний хөтөлбөрүүд хэрэгжиж ирсэн бөгөөд эдгээрт иргэд, хүүхэд багачуудад боловсрол олгох, тэдний боловсролын түвшинг ахиулах, аймаг, сумдын сургууль, цэцэрлэгийг бэхжүүлэх, боловсролын хүртээмж, чанарыг сайжруулах асуудал чухал байр эзэлж байлаа. Түүнчлэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэхэд зарцуулсан дотоодын санхүүжилт болон гадаадын хандивлагчдын зээл тусламжаар хэрэгжсэн үйл ажиллагааны дийлэнх нь хөдөө орон нутгийн боловсролыг хөгжүүлэхэд чиглэсэн байна.

1996-2001 онд хэрэгжсэн “Сургуулийн өмнөх боловсролыг бэхжүүлэх нь” төслийн хүрээнд аймаг, сумдын цэцэрлэгүүдийн материаллаг нөхцөлийг сайжруулах, хамрах хүрээг өргөжүүлэх, сургуулийн өмнөх боловсролд ажиллагчдын мэргэжлийн чадавхыг сайжруулах зэрэг ажлууд хийгдэв. НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар, Английн Хүүхдийг ивээх сан, Монголын Нээлтэй Нийгэм

Хүрээлэн (СОРОС-ын сан)-гээс олгосон буцалтгүй тусламж бодитой дэмжлэг туслалцаа үзүүлснийг тэмдэглэж байна.

Монгол улсын Засгийн газраас ЮНЕСКО-той хамтран хэрэгжүүлсэн албан бус боловсролын зайны сургалтын “Сурч амьдаръя” төсөл 1997-2002 онд хэрэгжиж дууслаа. 1.1 сая ам долларын санхүүжилттэй энэхүү төслийг Данийн Засгийн газрын ДАНИДА-аас санхүүжүүлсэн бөгөөд төслийн хүрээнд хийгдсэн өрхийн сургалтад 355 сум хорооны 40 гаруй мянган хүн хамрагджээ. Энэхүү зайны сургалтад хамрагдсан иргэд боловсролоо дээшлүүлээд зогсохгүй, амьдрах арга ухаанд суралцан өрхийн орлогоо нэмэгдүүлж чадсанд уг төслийн ач холбогдол оршиж байна.

Хүснэгт 40. Төслүүдийн санхүүжилтийн хэмжээ

	<i>Төслийн нэр</i>	<i>Он</i>	<i>Санхүүжилтийн хэмжээ</i>
2766	Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	2012-2016	20.0
3243	Хөдөлмөр эрхлэлтийн ур чадвар төсөл	2014-2018	25.0
3594	Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл	2018-2022	50.0
Нийт			137.5

НҮБ-ын хүүхдийн сангийн “Бага сургуулийн багш нарын мэргэжлийг дээшлүүлэх зайны сургалт” (1994-2006) төслийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд уг төслөөр багш нарт зориулсан радио, телевизийн хичээл явуулах, хөдөөгийн сургуулийн багш нарыг сургалт, семинарт хамруулах, гарын авлага, сургалтын материалаар хангах, 6 настай хүүхдийг сургах туршилтын ажлыг хийжээ.

НҮБ-ын Хүүхдийн сан “Бага боловсрол, олон нийтийн оролцоо” (1994-2006), “Хөдөөгийн сургуулийн хөгжил” (2001-2003, Данида) зэрэг төслүүд нь хөдөөгийн сургуулийг бэхжүүлэх, сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгох, хүүхдэд ээлтэй сургууль бий болоход зохих хувь нэмрээ оруулав.

МННХ (СОРОС-ын сан)-ийн “Алхам алхмаар” (1998-2001) хөтөлбөрийн дагуу Улаанбаатар хотын 19, аймаг үбүрт 1-2, нийт 45 цэцэрлэгт сургалтын үүлгэр жишээ орчин бүрдүүлсэн нь цэцэрлэгүүдийн сургалтын орчныг сайжруулахад ихээхэн түлхэц үүзүүлэв.

Тус хөтөлбөрийн хүрээнд “Бага насны хүүхдийн хөгжил” (3-5 нас, 6-7 нас, 8-10 нас), “Бага насны хүүхдийг хөгжүүлэх нь”, “Бага насны хүүхдийг хөгжүүлэх сургалтын төлөвлөгөө”, “Тусгай хэрэгцээт боловсрол шаардлагатай хүүхдийг хөгжүүлэх нь”, “Хүүхдийн хөгжилд эцэг эхийн үүрэг” зэрэг номыг хэвлэн

гаргасан нь багш, эцэг эхийн хүүхэдтэй ажиллах арга барилд суралцахад чухал нөлөө үзүүлсэн юм.

Түүнчлэн НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн газар, Английн Хүүхдийг Ивээх сан, Английн түншлэлийн хөтөлбөрөөс аймаг, нийслэлийн 527 цэцэрлэгт 1 сая 58 мянган ам.доллар (буцалтгүй тусламж)-ын санхүүжилттэй “СӨБ-ыг бэхжүүлэх нь” төсөл амжилттай хэрэгжлээ.

“Сургууль-2001” хөтөлбөрт төв, орон нутгийн ерөнхий боловсролын болон багш бэлтгэдэг их, дээд сургууль, коллежийн 72 сургууль хамрагдсан байна. Тус хөтөлбөр нь боловсролын стандарт, сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, төвлөрлийг сааруулах зорилгоор сургуулийн шинэчлэлийг дэмжих үйл ажиллагааг хамтын ажиллагааны сургуулиудаараа дамжуулан хэрэгжүүлсэн юм.

Хөтөлбөрт хамрагдсан хот, хөдөөгийн 72 сургууль нь боловсролын шинэчлэлийг хэрэгжүүлэхэд хамтран ажиллаж нэг хамт олон болон ажилласнаар нэгдсэн сүлжээ бий болов. 150 шахам багшийг сургалтын хөтөлбөр, сургалтын болон үнэлгээний шинэлэг аргуудад сургаж үндэсний сургагч багшийг бэлтгэв.

Хамтын ажиллагааны сургуулиудыг түшиглэн байгуулсан мэдээллийн төвүүд нь багш, сурагчид, иргэдэд шинэ мэдээлэл өгөх, сургалтын төрөл бүрийн материал, гарын авлага ашиглах, харилцан туршлага солилцох газар болж чаджээ.

“Сургууль-2001” сонин гаргаж байгаа нь боловсролын амьдрал дахь өөрчлөлт шинэчлэлийг тусгах, мэдээлэх хэрэгсэл болж байна. Багш бэлтгэх тогтолцоог боловсронгуй болгох үүднээс УБИС дээр “Шинэ зам” төсөл хэрэгжижээ. Төсөл хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэл хүрээ нь ийнхүү олон янз төрөл байдаг нь түүнийг хэрэгжүүлэгчдээс маш их мэдлэг чадвар, туршлага, хүмүүстэй харьцах эв дүй, тэвчээр, үнэнч шударга, хөдөлмөрч зан чанарыг шаардаж байдаг учраас хөтөлбөр, төсөл хэрэгжүүлсэн бүх түвшинд ажилласан хүмүүсийг энэ чиглэлээр орчин үеийн түвшинд бэлтгэж өгснөөрөө маш чухал ач холбогдолтой хэмээн үзэж байна.

Азийн Хөгжлийн Банкны “Боловсролын Салбарын Хөгжлийн Төсөл”-ийн 1997-2002, 2003-2007, 2007-2012 онд хэрэгжсэн нэг, хоёр, гуравдугаар шатны эцсийн үр дүн, өгөөжийг Азийн Хөгжлийн Банкнаас “онц сайн” хэмээн үнэлсэн нь Монголын боловсролын салбарын хямрал, хүндрэл, бэрхшээлийг даван туулж, XXI зууны шинэ хөгжлийн суурийг тавих ажлыг эрчимжүүлэхэд уг хөрөнгө оруулалтын оруулсан бодит үр дүнг тодорхой харуулж байна.

Хүснэгт 41. Боловсролын салбарын хөнгөлөлттэй зээлийн төслүүд

	<i>Төслийн нэр</i>	<i>Он</i>	<i>Санхүүжилт /\$ сая /</i>
1507	Боловсролын салбарын хөгжлийн бодлогын хөтөлбөр	1997-2002	6.5
1508	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын төсөл	1997-2002	9.0
1908	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын II төсөл	2003-2007	14.0
2238	Боловсролын салбарын хөрөнгө оруулалтын III төсөл	2008-2012	13.0
2766	Дээд боловсролын шинэчлэлийн төсөл	2012-2016	20.0

*Asian Development Fund (concessional loan)

** ADB's ordinary capital resources

Гадаадын зээл, буцалтгүй тусламжаар санхүүжиж буй зарим төсөл

Боловсролын салбарт 1992-2017 онд хийгдсэн олон улсын хандивлагчдын хөрөнгө оруулалт, тэдгээрийн гарсан үр дүнгийн олон арван сургамжид тулгуурлан цаашид монголчууд бид боловсролын салбарын чанар, үр ашгийг дээшлүүлэх, насан туршийн суралцахуйн үзэл баримтлалд тулгуурласан чанартай, хүртээмжтэй боловсролыг нийт хүүхэд багачууд, иргэдээ тэгш эзэмшүүлж баймааж нь эрс дээшлүүлж сайжруулж чадна. Ийм нөөц боломж монгол улсын боловсролын салбар, иргэн бүрт байгааг мартаж болохгүй.

Тийм ч учраас боловсролын хөгжлийн өнгөрсөн цаг үедээ буюу 1992-2017 оны үеийн 25 жилийн боловсролын салбарын хөгжил, дэвшил түүний дотор боловсролын эдийн засаг, санхүүжилт, хөрөнгө оруулалтын бодлого, стратеги, хууль эрх зүйн тогтолцоо, түүний ололт амжилт, үр ашиг, өгөөж, сургамжид нягт нямбай дүн шинжилгээ хийж, цаашид хөгжих эдийн засаг, санхүүгийн шинэ бодлого, орчныг тодорхойлох нь чухал юм.

Нийгмийн тэргүүлэх салбар болсон боловсролын салбарыг хөгжүүлэхэд Монгол Улсын Засгийн Газраас гадаад, дотоодын хөрөнгө оруулалтын хэмжээг нэмэгдүүлэхийн сацуу тэдгээрийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлэх, төсөл хөтөлбөрүүдийг өөр хооронд нь уялдуулж зохицуулах, үүр дүнг нь тооцох цогц бодлогыг боловсруулан, хэрэгжүүлэх ажлыг улам боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Өнгөрсөн 1992-2017 онд хэрэгжсэн боловсролын төсөл, хөтөлбөр дотроос Азийн Хөгжлийн Банкны тусалцаатай 1997-2012 онд хэрэгжүүлсэн буй "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр I,II,III " нь манай салбарт төдийгүй нийгмийн салбарт хэрэгжсэн хамгийн анхны томоохон зээлийн хөрөнгө оруулалт болсон юм.

Энэхүү "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн эцсийн үр дүн нь 1997-2012 оны боловсрол, сургуулийн хөгжлийн төрх байдал, бүтэц, хэв шинж, багш нарын идэвхи санаачлага, мэргэжлийн ур чадвар, сургалтын техник хэрэгсэлийн хангамж, орчин үеийн мэдээллийн технологи, компьютерын сүлжээ, шинэ сурах бичиг, номын сангийн хөгжлийн түвшинг эрчимтэй дээшлүүлснээр тодорхойлогдож байгаа юм.

Зээлийн хөрөнгөөр санхүүжиж байгаа хөрөнгө оруулалт гэдэг нь монголчууд биднээс илүү их хариуцлага, анхаарал, эцсийн үр дүнг шаардсан маш эмзэг нарийн цогц хамтын бүтээл болох нь хөтөлбөрийг хэрэгжүүлсэн өнгөрсөн хугацаанд маш тодорхой харагдсан. Энэ цаг үед гадаадын зээлийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх менежментийн чадавхи цоо шинээр бүрдэж, дотоодын мэргэшсэн ажилтан, зөвлөхүүд шинээр бэлтгэгдсэн нь маш чухал ач холбогдолтой.



Төсөл хэрэгжиж эхэлж байсан анхны үед монголын ирээдүйн иргэд зээлийн хөрөнгө оруулалтыг хэдэн жилийн дараа эргүүлж төлнө гэдэг утгаар нийгмийн сэтгэл зүй энэ зүгт илүү хандаж байсан. Энэ бүхнийг Азийн Хөгжлийн Банк,

Монгол улсын төр засгийн газар соргог мэдэрч, түүнийг хамгийн үр өгөөжтэй хэрэгжүүлэх бүхий л боломж, нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч ажилласан.

Тухайн үед БСШУЯ-ны зүгээс гадаадын хөрөнгө оруулалтыг хамгийн үр ашигтай, чиглэсэн зорилготой зарцуулж, ашиглах талаар идэвхи чармайлт гарган, удирдлага, зохион байгуулалтаар бүрэн хангаж ажиллаж байлаа. Энэхүү удирдлага, зохион байгуулалтыг хангах үүднээс Азийн хөгжлийн банкны санаачлагаар Монгол дахь боловсролын хандивлагч олон улсын байгууллагуудын зохицуулах механизм гэдэг зохицуулах зөвлөлийг байгуулж ажилласан нь хамгийн чухал ач холбогдолтой болсон. Одоо ч гэсэн энэхүү хандивлагчдын хамтын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах механизмын түүхэн туршлага ач холбогдлоо алдаагүй харин ч илт үгүйлэгдэж байна.

Энэ бүхний эцэст Монгол орны боловсролын хөгжил, дэвшил хурдассан, боловсролын чанар хүртээмж сайжирснаар монголчуудын сайхан амьдрах нөхцөл, боломж бүрдэж эхэлснийг судлаачийн хувьд онцлон тэмдэглэж байна.

1992-2017 онд гадаадын олон улсын байгууллагын хөрөнгө оруулалтын дэмжлэгтэй туслалцаатай хэрэгжиж буй энэхүү хөтөлбөр нь 1990 оноос бий болсон боловсролын гүнзгий хямралыг амжилттай даван туулж шинэ XXI зуунд Монгол орны боловсролыг хөгжүүлэх суурь бүхий шатны бэлтгэлийг үндсэнд нь хангахад бодитой хувь нэмэр оруулсан байна хэмээн дүгнэж байна.

Манай төслийн хүрээнд цоо шинээр бий болсон цогцолбор, сум дундын бүсийн төв сургуулиудын бүтэц, хэв шинжийг хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд багтаж байсан улс орнууд төдийгүй дэлхийн хөгжилтэй Япон, АНУ, Тайланд зэрэг орнууд ихээр сонирхож өөрийн онцлогтоо тохируулан ашиглаж байгаа нь үүнийг бас гэрчилж байна. Шууд тэмдэглэж хэлэхэд өнөөгийн боловсролын хөгжил удаашрч илүү их хямрал нүүрэлж, ихээхэн цаг алдаж нэлээд хохирол амсах байсан. Азийн хөгжлийн банкаас 60 гаруй орны боловсролд хэрэгжүүлсэн хөтөлбөр, төслөөс хамгийн сайн хэрэгжсэн төсөл хэмээн “Боловсролын салбарын хөгжлийн төсөл”-ийг 2002 онд АХБ-ны хүндэт дипломоор шагнаж, мөн АХБ-ны дэмжлэгтэй хэрэгжүүлсэн “ Санхүүгийн хямралын үеийн боловсролыг дэмжих төсөл” нь мөн амжилттай хэрэгжиж гишүүн орнууддаа туршлагаа түгээх эрхийг авсан байна.

Дэлхий банк, Бүх нийтийн боловсролыг дэмжих Каталитик сангийн 29.4 сая ам долларын дэмжлэгтэй хэрэгжсэн “ Үр дүнд түргэн хүрэх төсөл”-ийн хэрэгжилт нь энэхүү төсөл хэрэгжсэн 75 орны хамгийн сайн хэрэгжиж буй 5 орны нэгээр шалгарч Монгол Улс энэхүү том хандивлагч байгууллагын Удирдах зөвлөлийн

гишүүнээр сонгогдож Ази, Номхон далайн 6 орны орлогч сайд, удирдлагууд монгол оронд ирж манай туршлагыг судалсан нь бид зөвхөн төсөл хэрэгжүүлэгч байснаа одоо гадаадынханд бодлогын, оюуны хөрөнгө оруулагч болж, боловсролоо экспортлох цаг нь болсныг харуулж байна.

Цаашид боловсролын салбарт олон улсын хандивлагч байгууллага, орнуудын хэрэгжүүлсэн боловсролын хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн ололт амжилт, сайн туршлагыг улам баталгаажуулж, сайжруулан үргэлжүүлэн илүү шинэлэг агуулгаар баяжуулан хэрэгжүүлэх, үр дүнг нь гадаад, дотоодод өргөнөөр сурталчилж, ойлгуулж, нийтийн хүртээл болгон өдөр тумын боловсролын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх шаардлагатай байна. Түүнчлэн дутуу дулимаг хийж, алдаа бэрхшээл учруулсан асуудал, арга хэмжээ, үйл ажиллагааг дахин эргэн харж, үнэлэлт дүгнэлт өгч засч залруулах нь чухал.

Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр, төслүүдийн хөрөнгө оруулалтаар дамжин багш, суралцагчид, удирдах ажилтан, иргэд, олон нийтийн сэтгэлгээ, хандлага, арга барилд шинэлэг өөрчлөлтүүд байнга гарч байдгийг онцгой анхаарч түүнийг боловсролын шинэчлэл, хөгжлийг хурдасгах бүтээлч хөшүүрэг болгох менежментийг бий болгох хэрэгтэй.

Сурах бичгийн хөгжлийг хангаж, цаашид шийдвэрлэх асуудлууд

Сурах бичгийн чанарыг сайжруулахад дараах шийдлүүдийг хийх, хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

- Боловсролын хүрээлэн хэрэглэж буй сурах бичигт судалгаа, үнэлгээ хийх
- Судалгааны үндэслэлтэйгээр сурах бичгийг сайжруулах төлөвлөлт хийх
- Цаг хугацааны бодитой төлөвлөлт хийх
- Сурах бичгийн зохиогч, редакторыг чадваржуулахад анхаарч, сургалт, уулзалт зохион байгуулах
- Сурах бичгийг зохиох, хэвлэх, түгээхтэй холбоотой эрх зүйн бодлого, зохицуулалтын дүрэм журмыг боловсронгуй болгох
- Сурах бичигт тавих нийтлэг болон тусгай шаардлага, шалгуурыг боловсронгуй болгох
- Судлагдахууны онцлогийг тусгасан сурах бичгийн шаардлага, шалгуур үзүүлэлтийг боловсруулах
- Тусгай хэрэгцээт боловсролын сурах бичигт тавих тусгай шаардлага, шалгуурыг боловсруулах, түүний дагуу үнэлгээ, судалгаа хийх

- Сурах бичгийн чанарыг сайжруулахад мэргэжлийн байгууллага, хүмүүс (Их, дээд сургууль, ЕБС, БМДИ, БҮТ, Түүхийн хүрээлэн, Хэл уран зохиолын хүрээлэн, бусад хүрээлэн, Төрийн хэлний үндэсний зөвлөл, ТББ, иргэн)-ийн оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн зохицуулалт хийх, хамтарч ажиллах
- Багш нар сурах бичгийн чанар болон сурагчдын хэрэгцээ, шаардлагад хэр нийцэж буй талаар тодорхой саналаа холбогдох байгууллага (аймаг нийслэлийн БСУГ, Боловсролын хэлтэс)-д хүргүүлэх
- Дээрх саналыг аймаг, нийслэлийн БСУГ, Боловсролын хэлтэс, багш нараас авч нэгтгэн, Боловсролын хүрээлэнд хүргүүлэх
- Сурах бичгийн эх бэлтгэл, хэвлэлийн чанарт тавих хяналтыг сайжруулах
- Сурах бичгийн хангалт, хүртээмжийг нэмэгдүүлэхэд дараах шийдлийг хийх хэрэгтэй гэж үзэж байна. Үүнд:
- Эцэг эх, сурагчид оршин суугаа газраасаа, нэг цэгээс хэрэгцээт бүх сурах бичгээ бодит үнээр худалдан авах боломжийг бий болгох
- Сургуулийн удирдлага, багш, номын санч төрөөс хангаж буй сурах бичгийг зорилтот бүлэгт нь зориулах, худалдаж буй сурах бичгийн талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэх, сурах бичгийн хангалтыг нэмэгдүүлэхэд анхаарч эцэг эхтэй хамтарч ажиллах, сурах бичгээ татаж авах, сурагчдад олгох, буцааж авах ажлыг бэрхшээл, чирэгдэлгүй болгоход анхаарч ажиллах

Аймгийн БСУГ, нийслэл, дүүргийн Боловсролын хэлтэс шинээр нийлүүлсэн сурах бичгийг сургуулиудад үнэн зөв хуваарилах, тооцоо хийх, худалдаж буй сурах бичгийн талаарх мэдээллийг сургуулиудад цаг хугацаанд нь хүргэх, орон нутагт сурах бичиг худалдаж буй байдалд хяналт тавих, сурах бичгийг хэвлэсэн хэвлэлийн газартай хууль, эрх зүйн хүрээнд хамтран ажиллах, сурах бичгийн нэгдсэн худалдаа зохион байгуулах, сурах бичгийн хангалтын талаар судалгаа хийх, хангалтыг нэмэгдүүлэх талаар санаачилга гарган тодорхой ажил зохион байгуулах

- Төрийн зүгээс сурах бичиг хэвлэх, түгээх, худалдан борлуулах харилцааг зохицуулах эрх зүйн зохицуулалт, орчинг боловсронгуй болгох, түрээсийн тогтолцоо буюу эргэлтийн санг үргэлжлүүлэн ажиллуулах, сурах бичгийг цахим хэлбэрт шилжүүлж үнэ төлбөргүй ашиглах боломж бий болгох, сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг МХХТ-ийн төрөл бүрийн хэрэгслээр ашиглах программ хангамжийг хөгжүүлэх, цахим сурах бичиг, нээлттэй хэрэглэгдэхүүн боловсруулах, хөгжүүлэх, хангамжийг нэмэгдүүлэхтэй холбоотой арга хэмжээг авч хэрэгжүүлэх зэрэг болно.

Монгол улс 2004 оноос сурах бичгийн стандарттай болсон нь сурах бичгийг үндэсний хэмжээнд сайжруулах, чанарыг нь хэмжих, үнэлгээ өгөхөд чухал ач холбогдолтой шийдэл болсон бөгөөд сурах бичгийн талаар тусгайлсан судалгаа хийгдэж, диссертациуд бичигдсэн нь сурах бичиг судлалд тодорхой хувь нэмэр оруулах үе эхэлсэн гэж дүгнэж байна.

Монголын боловсролын судалгааны үндэсний төв байгууллага Боловсролын хүрээлэнд Сурах бичгийн судалгааны секторыг БШУ-ны Сайдын тушаалаар (2012 он) байгуулсан нь сурах бичгийн шинжлэх ухааны үндэслэл, аргазүйг судлах, боловсруулах, чанар, үнэлгээг сайжруулахад том түлхэц болсон байна.

Судалгааны нэгж болгон, 2009-2013 онуудад үндэсний хэмжээнд зохиогдож, хэвлэгдэж, практикт нэвтэрсэн суурь боловсролын буюу 7,8-р ангийн математик, монгол хэл, байгаль, нийгэм- хүмүүнлэг, мэдээлэл технологийн чиглэлийн сурах бичгүүдийн бүтэц, агуулга аргазүйд дүн шинжилгээ хийж үзэхэд, эдгээр сурах бичгүүд нь суралцахуйд чиглэсэн үнэт зүйл, шийдэлтэй болох нь харагдаж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ. ТУРШЛАГААС АВАХ СУРГАМЖ

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр, агуулгын хөгжлийн сургамж, асуудал

- Сургалтын хөтөлбөрт Монгол хүний үнэт зүйлийг эрхэмлэж, суралцагчийн суралцахуйг дэмжсэн, суралцагчийн бүх талын оролцоог тооцсон, эрх, эрх чөлөө, сонголтыг нь хүндэтгэсэн зэрэг үнэт зүйлүүдийг тодорхой тусгаж, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, улмаар харьцангуй нээлттэй хөтөлбөрүүдэд шилжих
- Хөтөлбөр нь суралцагчийн хувийн болон нийгмийн хэрэгцээ, сонирхол, мэргэжил сонголт, алба ахихуйд нийцсэн байх
- Юунд суралцуулахыг чухалчлахаасаа илүү яаж суралцах буюу сурах хэв маяг, арга барил, ялангуяа, шинжлэн судлах арга барилд суралцахуйг бүхэлд нь дэмжих
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн (гадаадын улсуудын сургалтын хөтөлбөрийг хуулбарлах бус) үйлийн, сэтгэл зүйн, материаллаг гэх мэт иж бүрэн орчинг бүрдүүлэн хөгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн чанарын үнэлгээг хэрэгжүүлэх механизмыг төгөлдөржүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн үр дүн болох суралцагч нэг бүрийн сурлагын чанарт онцгой анхаарч (ЕБС-ийн сургалтын чанар мэдэгдэхүйц унаж байгаа тухай судалгааны дүгнэлтийг дээр дурдсан), явцын болон үр дүнгийн үнэлгээний арга, аргачлалыг хөгжүүлэх
- БСШУСЯ-ны хувьд хийж болох нэг сонголт бол хөтөлбөрийн үнэлгээний хүрээг дахин хянан үзэж, сайжруулах, үнэлгээ (ялангуяа явцын үнэлгээ)-ний чиглэлээр мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, явцын болон өөрийн үнэлгээний гарын авлага, материалыг боловсруулж, түгээх
- Цаашид сургалтын хөтөлбөр-стандарт (curriculum-standart) бий болгох шинжлэх ухаан, философийн үндэслэгээг нухацтай тодруулж байж, үндэсний түвшний шийдвэр гаргах
- Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэхдээ, суралцахуй ба багшлахуйн философийг тэнцвэртэй харгалзахын сацуу суралцагч төвт сургалтын философи баримтлалуудыг өөриймшүүлж, тууштай мөрдөх

- Бид боловсролын философийн орчин үеийн урсгал, чиглэлийн үнэт зүйлс, Монголын ерөнхий боловсролд хэрэгжиж ирсэн сургалтын хөтөлбөрүүдийн зорилго, бүтэц, агуулгыг нь олон улсын чиг хандлагатай харьцуулан судалж, мөн манайд энэ талаар хийгдсэн хэд хэдэн судалгааны үр дүнг авч үзсэн болно. Монголын ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөр нь өөрийн улсын боловсролын төв байгууллагын оролцоо, эрдэмтэд, багш нарын судалгаа, туршлага, гадаадын хөгжингүй улсуудын хөтөлбөр судлалын судалгааны зарим ололтод тулгуурлан хөгжиж, Эх орны ерөнхий боловсролын хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан нь судалгаагаар харагдлаа. Манай улсад сургалтын хөтөлбөр ялангуяа, ЕБС-ийн сургалтын хөтөлбөрийн талаар Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны болон эрдэм шинжилгээ, аргазүйн байгууллагаас хөтөлбөр судлалын шинжлэх ухааны үндэстэй судалгаа, боловсруулалт, хэрэгжүүлэлтийг залгамж чанартай, тогтвортой хийхэд дутагдал байна. Бүх шатны боловсролын сургалтын хөтөлбөрүүдийг цаашид шинжлэх ухааны үндэстэй боловсруулах, хэрэгжүүлэх, үнэлэх, эдгээрийг бодлогын хувьд залгамж чанартай болгох шаардлагатай байна. Үүнд:

- Бүх түвшний боловсролын агуулгыг босоо, хэвтээ түвшинд нь интеграцчлах, уялдааг нь сайжруулах явдал тулгамдаж байна. Гадаад хэлний сургалт, байгалийн ухааны боловсролын агуулгын төлөвлөлт, монгол хэл, монгол бичгийн сургалтын агуулга, аргазүйд шийдвэрлэх асуудлууд цөөнгүй байна. Гадаад хэл, мэдээллийн технологийн сургалтыг эрчимжүүлэх, түүнийг үзэх анги, сургалтын цагийг оновчтой тогтоох, сурах бичиг, гарын авлага болон өндөр мэргэжлийн багш бэлтгэх нь чухал байна. (Бэгз, 2011)
- Стандарт, хөтөлбөрийг турших бэлтгэлийг хангах, сургууль, бүс нутгийг оновчтой сонгох, туршилтын ажлыг удирдахад төрийн удирдах болон эрдэм шинжилгээний байгууллага, орон нутгийн засаг захиргааны туслалцаанаас гадна иргэдийн оролцоо их чухлыг анхаарах.
- Сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ олон улсын боловсролын хөгжлийн чиг хандлага, Монгол орны иргэдийн боловсролын ирээдүйн хэрэгцээг сайн судлах.

- Сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэхдээ: а) мэдлэгийн баримжаатай сургалтыг чадварт суурилсан сургалтаар солих, б) багш төвтэй сургалтыг суралцагч төвтэй сургалттай хослуулах, в) сургалтын агуулгыг орон нутаг, сургуулийн түвшинд сонголттой болгох, г) өнгөрсөн үеийн туршлага өвлүүлэхэд чиглэсэн сургалтыг ирээдүйд чиглэсэн туршилт явуулах сургалтаар солих (Бэгз, 2011)

Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний талаар практикийн хувьд (багш нараас гаргасан саналын үндсэн дээр) авах сургамж, шийдэх зарим асуудал:

- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг сургуулийн байршил, онцлогтой уялдуулах
- Ахлах ангийн хичээлийг сонголттой хөтөлбөрөөр хичээллэх нь хүүхдийн сонирхол хэрэгцээнд нийцэж байгаа боловч, багшийн илүүдэл, дутагдал үүсээд байгааг тооцож, хөрвөх чадвартай багшийг бэлтгэхэд анхаарах
- Хүүхдийн ачааллыг бууруулахын тулд хөтөлбөрүүдэд тусгах цөм агуулга, арга зүйг тогтоож хичээл судлагдахууныг багцлах
- Сургалтыг дэмжих үйл ажиллагаанд эрүүл мэнд, иргэний боловсрол, аюулгүй байдал зэрэг хичээл агуулгыг оруулж тодорхой стандарт, хөтөлбөртэй болгох
- Бага ангийн монгол хэл, математикийн хичээлийн хөтөлбөрийн агуулгыг дахин сайжруулах
- Сургалтын хөтөлбөрийг үнэлэх судалгааг тогтмолжуулан түүний өөрчлөлт, хөгжүүлэлтийг эрдэм шинжилгээний үндэслэлтэй тодорхойлдог болох
- Сургалтын хөтөлбөр боловсруулахад мэргэжлийн багш нараас санал авах
- ОУ-ын сургалтын хөтөлбөр, цөм хөтөлбөр гэсэн 2 хөтөлбөр үндэсний хэмжээнд зэрэгцэн хэрэгжиж байгаа нь оновчтой эсэхийг судлах
- Ахлах ангид ордог заавал судлах хичээлийн тоог цөөрүүлж, сонгон судлах хичээлийг нэмэгдүүлэх
- Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд ойр ойрхон өөрчлөлт орж байгааг тогтвортой болгох, 10-р ангиас 4 хичээлийг, 4 цагаар судлах боломжтойг сургалтын төлөвлөгөөнд тусгах
- Суурь боловсролд олон хичээл орж байгааг анхаарч, хичээлийн тоог цөөрүүлэх, эсвэл хүүхдийн сонирхолд үндэслэн зарим хичээлийг сонгон судлах боломжийг бүрдүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн цахим санг аймаг, дүүрэг бүрээр бий болгох
- Гүнзгийрүүлэн судлах хөтөлбөр ямар түвшинд хүрэх, үүнтэй уялдуулан сурах бичгийн агуулгыг өргөсгөх

- Хөтөлбөрийн хэрэгжилтийг улс төр, эдийн засгийн нөлөөллөөс ангид байлгах, хөтөлбөрийг тогтвортой байлгах үүднээс хөтөлбөрийн циклийн хугацаа 8-с дээш жил байх, энэ хугацаанд хөтөлбөрөө сайжруулан гаргаж, хэвлэн түгээдэг байх.
- Нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр шаардлагынхаа хувьд ялгаатай, үнэлгээтэйгээ холбоотой гэдгийг ойлгож хэрэглэдэг болоход анхаарах
- Зарим сургалтын хөтөлбөрийн агуулга, арга зүйг сайжруулах. Жишээ нь: түүхийн хичээлд монголын түүх, дэлхийн түүх холилдон орж байгааг анхаарах
- 7 хоногт 1 цагаар ордог хичээл нь өдөр бүр шинэ сэдэв үзээд бататгах цаг байхгүй байгааг анхаарах
- Хөдөө орон нутагт гадаад хэл, мэдээллийн технологийн хичээлийг группээр хичээллэх орчинг бүрдүүлэх
- 12-р ангид заавал судлах хичээлийн цаг олон байх шаардлагагүй харин сонгон судлах хичээлийн цагийг нэмэх
- Бага ангийн монгол хэлний сургалтын хөтөлбөрийн агуулгад хэл зүйн чадвар бага байгаа нь дунд ангидаа зөв бичих чадвар сул сурагчид орж ирэх үндэслэл болж байна. Мөн дунд, ахлах ангийн монгол хэлний хичээлийн агуулга хүнддэж байгааг анхаарах
- Түүх, нийгмийн ухааны хичээлийн цагийг багасгасан нь монгол өв соёл, уламжлал алдагдахад хүргэж байна. Иймд эдгээр хичээлийн цагийг нэмэх
- STEM сургалтын цагийг хичээлийн хөтөлбөрт тусгаж, цалин хөлстэй болгох
- Бага-Суурь-БДБ-ын хөтөлбөрийн залгамж холбоог анхаарах (бага нь суурийнхаа, суурь нь БДБ-ынхаа суурь болж байгаа эсэхийг нягталж үзэх)
- Хөтөлбөр боловсруулахад агуулга хөнгөдөх, хүнддэх асуудал байгаа нь хөтөлбөрийн хэрэгжилтэд нөлөөлж буйг анхаарах /бага анги, англи хэл гэх мэт
- 2004 оны стандартад 2990 гаруй чадварыг эзэмшлээ гээд дүн гаргаж байсан. Энэ болж байна уу. Боловсролын стандартаа эргэн харах хэрэгтэй. Боловсролд багшийн хөгжлийн, сургалтын орчны, агуулгын, үнэлгээний гэх мэт ямар стандарт мөрдөхийг тодорхой болгох.
- Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг 10 жил тодорхой мөрдөх (багш нар ойлгож мэдрээд, хэрэгжүүлээд эхлэхээр өөрчлөгдөөд байж болохгүй)
- багш нарт сургалтын хөтөлбөрийг ойлгуулах сургалтыг үе шаттайгаар зохион байгуулах
- Сургууль өөрийн онцлогт тохирсон сургуулийн хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэхэд хяналт тавих, ямар зохицуулалт байхыг тодорхой болгох

- Ахлах ангийн сонгон судлах хичээл сурагчийн сонголтыг хүндэтгэхгүй байна. Сонголт хийх эрхийг нь бүрэн олгохын тулд бүлэг дүүргэлтийн тоог эргэн харж зохицуулах
- Зарим онцлогтой хичээлийн сонгон судлах хичээлийг амьдралд нийцүүлэх (технологи, мэдээллийн технологи)
- Амьдрах чадварт суралцах хичээлийн чанарт анхаарах
- Зарим хичээлд агуулга их хүндэрч байна. Хичээлийн залгамж холбоог сайжруулах, агуулгын зөрүүг арилгах, 1, 2 цаг ордог хичээлийн цагийг нэмэгдүүлэх
- Агуулга тогтвортой байх, залгамж холбоог тодорхой болгох багцалж өгөх тал дээр анхаарах
- Хөгжмийн хичээлийн сурах бичгийн чанар хангалтгүй, хөтөлбөрийг өөрчлөх, гадаадын хөгжимчдийг судалж байхаар үндэснийхээ нэг хөгжмийг тоглож сураад гардаг байхад нь анхаарах
- Хичээлүүдийн агуулгын хүрээ өргөн байна. Чадвар эзэмшүүлэх давхар агуулгыг эзэмшүүлэх талаар анхаарч, сурагчдын ачааллыг багасгах
- Хөтөлбөрийн талаар түвшин түвшиндээ нэг ойлголттой байх
- Бага ангийн математикийн хичээлийн агуулга, чадварын түвшинг судалж ачааллыг тэнцүүлэх
- Химийн хичээлийн 9 дүгээр ангийн агуулга их байна.
- Сургалтын хөтөлбөрийн шалгуурт суралцахуй, багшлахуй, хэрэглэгдэхүүн, үнэлгээний асуудлыг тусгаж боловсронгуй болгох
- Хөтөлбөрт үнэлгээ хийхдээ багшийн сайн технологи, сайн арга зүйг үнэлэх, эдгээрийг харгалзах
- Сурагчид хөтөлбөрийг хүлээж авах чадварыг судлах зэрэг болно.

Ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн талаар цаашид шийдвэрлэх асуудлууд

- Сургалтын хөтөлбөрт Монгол хүний үнэт зүйлийг эрхэмлэж, суралцагчийн суралцахуйг дэмжсэн, суралцагчийн бүх талын оролцоог тооцсон, хувийн эрх, эрх чөлөө, сонголтыг хүндэтгэсэн зэрэг үнэт зүйлүүдийг тодорхой тусгаж, хэрэгжилтийн үр дүнг үнэлэх, улмаар харьцангуй нээлттэй хөтөлбөрүүдэд шилжих
- Хөтөлбөр нь суралцагчийн хувийн болон нийгмийн хэрэгцээ, сонирхол, мэргэжил сонголт, алба ахихуйд нийцсэн байх

- Юунд суралцуулахыг чухалчлахаасаа илүү яаж суралцах буюу сурах хэв маяг, арга барил, ялангуяа, судлан шинжлэх арга барилд суралцахуйг бүхэлд нь дэмжих
- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн (гадаадын улсуудын сургалтын хөтөлбөрийг хуулбарлах бус) үйлийн, сэтгэлзүйн, материаллаг иж бүрэн орчинг хөгжүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн боловсруулалт, хэрэгжилтийн чанарын үнэлгээг хэрэгжүүлэх механизмыг төгөлдөржүүлэх
- Сургалтын хөтөлбөрийн үр дүн болох суралцагч нэг бүрийн сурлагын чанарт онцгой анхаарч (ЕБС-ийн сургалтын чанар мэдэгдэхүйц унаж байгаа гэсэн дүгнэлт бий), үр дүнгийн болон явцын үнэлгээний арга, чадавхийг цогц хөгжүүлэх
- БСШУСЯ-ны хувьд хийж болох нэг сонголт бол хөтөлбөрийн үнэлгээний хүрээг дахин хянан үзэж, сайжруулах, үнэлгээ (ялангуяа явцын үнэлгээ)-ний чиглэлээр мэргэжил дээшлүүлэх үйл ажиллагааг тасралтгүй сайжруулах, явцын болон өөрийн үнэлгээний гарын авлага, материалыг боловсруулж, түгээх
- Цаашид сургалтын хөтөлбөр-стандарт (curriculum-standart) бий болгох шинжлэх ухаан, философийн үндэслэгээг нухацтай тодруулж байж, үндэсний түвшний шийдвэр гаргах
- Сургалтын хөтөлбөрийг хөгжүүлэхдээ, суралцахуй ба багшлахуйн философийг тэнцвэртэй харгалзахын сацуу суралцагч төвт сургалтын философи баримтлалуудыг өөриймшүүлж, тууштай мөрдөх

Монголын боловсрол судлалын хөгжлийн цаашидын хандлага, шаардлага

Манай орны боловсрол судлалын сүүлийн 25 жилийн хөгжилд олсон ололт багагүй байгаагийн зэрэгцээгээр бидэнд одоо, цаашид хийх ажил түүнээс ч илүү байгаа юм.

Боловсрол судлал дэлхий дахинд өнгөрсөн зууны 60-аад оноос шинжлэх ухааны бие даасан чиглэл болон шинэ хандлагаар хөгжиж байна. Дэлхийн олон оронд боловсрол судлалын хүрээлэн, их сургуулиудад боловсрол судлалын коллеж, тэнхим байгуулагдаж, боловсролын өргөн хүрээний асуудал судалдаг боллоо. АНУ зэрэг олон оронд боловсрол судлалын том холбоод ажиллаж байна. Үүнээс харахад боловсрол судлал зөвхөн энэ чиглэлийн эрдэмтдийн судалгааны хүрээ биш, харин бүх нийтийн үйлс болж байгаа байдал харагдаж байна. Учир нь боловсрол бол хүн төрөлхтний олон арав, зуу, мянган үеийнхний буй болгосон

амьдрах соёлыг дараа дараагийн үед нь өвлүүлэн дамжуулах нийгмийн институт юм. Түүний хөгжлийн асуудал үе үеийнхний анхаарал, сонирхлыг татсаар ирсний дээр шинэ XXI зууны босгон дээр боловсрол нь хүн төрөлхтний хөгжлийн үндсэн хүчин зүйл, түүний зайлшгүй шаардлагатай орчин болж гарч ирж байна¹⁰¹. Энэ үеийг шинжлэх ухааны хүрээнд мэдлэгийн нийгмийн хөгжлийн үе гэж нэрлэж тогтлоо.

Сүүлийн жилүүдийн байдлаар АНУ, Герман, БНСУ, Австрали зэрэг өндөр хөгжилтэй орнуудад багш бэлтгэх сургуулийн сургалтын агуулгын 60.0-70.0 хувь нь боловсрол судлалд суурилсан багшийн эрдмийн судлагдахуунууд болжээ. Энэ нь боловсролын онол, аргазүйн мэдлэг сайтай, багшлах өндөр ур чадвартай багш бэлтгэх үндэс болдог байна.

Боловсрол судлал нь байгаль, нийгмийн шинжлэх ухааны уулзвар дээр үүссэн хүн судлалын бүлэг шинжлэх ухааны нэг салбар болж, бие даан хөгжиж байгаа юм. Боловсрол судлалыг англи хэлт орнуудад Education Research, герман болон түүний төрөл хэлт орнуудад Pedagogika гэж нэрлэж байснаа 1962 оноос хойш Educology гэж нэрлэхээр болж тогтсон¹⁰² байдаг ч өнөө хэр Educational Sciences, Education Research, Educology гэсэн нэрүүд зэрэгцэн оршсоор байна.

Хүний амьдралын тодорхой үе шатны физиологийн суурь хэрэгцээ нь бие биеэс ялгагдах онцлог шинжүүдтэй байдаг нь мөнхүү насны боловсролын хэрэгцээ ч бие биеэс эрс ялгагдах 3 өөр үе шатанд хуваагдахад хүргэдгийг олж тогтоосноор сүүлийн үед эдгээр өөр хоорондоо ялгаатай боловсролын хэрэгцээ, түүний насны үечлэлийг тус тусдаа ялгаа бүхий агуулгатай нэр томъёогоор илэрхийлэх болов. Манай улсад тодорхой хүрээний багш, судлаачдын боловсрол судлалын шинжлэх ухааны талаарх ойлголт тааруу, түүгээр ч барахгүй боловсрол судлалын салбар шинжлэх ухаан-хүүхдийг сургаж хүмүүжүүлэх ухаан (педагогика)-ыг насан туршийн боловсролын (хүүхдийн, насанд хүрэгчдийн, өндөр настны) онол аргазүйтэй хольж будилах, түүгээр орлуулж ойлгох хуучин хандлага хэвээр байсаар байна.

Энэ нь эцэстээ боловсрол судлалыг хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухаанаар төлөөлүүлж ярьж бичихэд хүргэж байна. Иймээс багш бэлтгэх зарим их, дээд сургуулийн сургалтын төлөвлөгөөнд боловсрол судлал хичээлийн нэрээр хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухааныг заах, түүгээр ч барахгүй боловсрол

¹⁰¹ Бэгз Н. 2008. Боловсролын хөгжлийн онол, аргазүйн асуудлууд. УБ, 22-р тал.

¹⁰² Оливера Карлос . К теории сравнительной педагогики-Перспективы, No 2, 1989.

судлалыг педагогика-ийн дотор оруулж төөрөх явдал ч нэлээдгүй байсаар байгаа юм.

Сүүлийн 20-иод жилд боловсрол судлалын нэг чиглэл болох сургалт хүмүүжлийн ерөнхий онолын судалгаа, сургалтыг орхигдуулж, мэргэжлийн дидактикаар орлуулах хандлага манай зарим багш, судлаачдын дунд газар авчээ. Энэ болгоны нарийн учрыг олоогүй хүмүүсийн зүгээс боловсрол судлал гэж бий эсэх, байдаг бол энэ нь хүүхдийн сурган хүмүүжүүлэх ухаанаас юугаар ялгаатай, энэ нь багш бэлтгэх сургалтад хэрэгтэй эсэх талаар эргэлзэхэд ч хүргэж байна.

Монгол улсын боловсролын судалгааны ажлын тулгамдсан, үндсэн гол чиглэлүүдийг нарийвчлан тодорхойлж, оролцогч, сонирхогчдын бүлгүүдийн нэгдсэн зөвшилцөлд хүрч чадаагүй байна. Нэгэнт боловсрол судлалын судалгааны тэргүүлэх чиглэлүүд тодорхой болоогүй байх тул сургалт явуулж, мэргэжилтэн бэлтгэж байгаа, магистр, докторын судалгаа явуулж байгаа чиглэлүүд нь уялдаа, холбоо муутай байна. Судалгааны чиглэл, сэдвийг тогтоохдоо сургууль, тэнхим, профессорын үзэмж, сонирхлын хүрээнд, эсвэл өөрсдийн чадал боломжийн хэмжээнд тааруулах хандлага илүүтэй байна.

1958-1990-ээд онд диссертацийн түвшинд боловсролын асуудлаар хийгдсэн ажлуудыг үзвэл голдуу сургалтын агуулга, заах аргын хүрээнд, багшийн байр сууринаас хийгдсэн байгаа нь харагдаж байна. Харин суралцагч монгол хүүхдийн сурах чадварын судалгаа олигтой хийгдээгүйгээс гадаадын, тэр дундаа зөвлөлтийн эрдэмтдийн судалгааны өгөгдөхүүнийг монгол хүүхэд дээр шууд буулган хэрэглэсэн байдал нийтлэг байна.

Харин сүүлийн жилүүдэд манай нэлээд эрдэмтэн, мөн олон улсын байгууллагуудын оролцоо, дэмжлэгтэйгээр монгол хүүхдийн судалгаа овоо хийгдэх боллоо. БСШУ-ны яамны захиалгаар 2013 оноос Боловсролын хүрээлэнд хийгдэж эхэлсэн монгол хүүхэд, залуусын хөгжлийн цогц судалгаа үүний нэг тод жишээ мөн. Харин ирэх жилүүдийн боловсролын судалгаа, сургалтын бодлогыг монгол хүн судлалын суурьтайгаар хийх нь чухал гэж үзэж байна.

Яам, хүрээлэн, сургууль, тэнхим, профессорын багуудын хооронд судалгааны ажлын бодлогыг зохицуулах, зөвшилцөх, зангидах механизм хараахан төгс бүрдээгүй байсаар байна. Иймээс боловсрол судлалын үндэсний мэргэжилтэн судлаач бэлтгэх, тэднийг бодлогоор байршуулах, үр дүнтэй ашиглах,

мэргэшүүлэн сургах, шавь сургууль бий болгох асуудал нь төрийн зүгээс дэмжлэг муутай, хувь эрдэмтдийн санал, санаачлагын хэмжээнд явж ирлээ.

Боловсрол судлалын судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх асуудал огт орхигдоогүй боловч бас шаардлагын хэмээнд хүрэхгүй байна. Шинжлэх ухаан, технологийн төслийн санхүүжилтэд судалгааны тоног төхөөрөмж авах, шинэчлэх зардлыг тооцож суулгаж өгдөг боловч санхүүжилт нь тэр бүр олддоггүй, судалгааны ажлыг нэвтрүүлэх зардал огт тооцогддоггүй нь ажлын үр дүн цаасан дээр үлдэх явдлын нэг шалтгаан болсоор байна.

Монгол Улсын боловсрол судлалыг шинэ түвшинд гарган хөгжүүлэхийн тулд юуны өмнө дараах асуудлуудад анхаарлаа хандуулах шаардлагатай гэж үзэж байна.

Суралцагч оюутан, судлаачдаар өнөөгийн Монгол улсын боловсролын хөгжлийн тулгамдсан асуудлаар хийлгэх боловсрол судлалын судалгааны ажлын чиглэлийг шинэчлэн тодорхойлох, зохих түвшинд харилцан ойлголцох, хүлээн зөвшөөрөх асуудал чухал юм.

Боловсрол судлалын салбар бүрээр шавь сургууль бий болгож, мэргэжилтэн судлаачдыг мэргэшүүлэн бэлтгэх, судлаачдыг сургах, хамгаалуулах, эрдэмжүүлэх үйл ажиллагааг чанаржуулах, тавих шаардлагыг нэмэгдүүлэх явдал манай улсын боловсролын чанарыг дээшлүүлэх нэг үндсэн хөшүүрэг мөн.

Сургаж бэлтгэсэн мэргэжилтнээ мэргэшүүлэх, тэднийг олон улсын хэмжээнд таниулах, хүлээн зөвшөөрөгдөхөд нь чиглүүлэн хамтарсан судалгаанд оролцуулах, судалгааны орчин үеийн аргад мэргэжилтнүүдээ сургах нь бүс нутгийн хэмжээнд манай улсаас гадаад орнуудтай боловсролын салбарт хамтран ажиллах нэг гол чиглэл болох ёстой.

Судалгаа, сургалтын мэдээллийн эх үүсвэрийг болон мэдээлэл олж авах боломжоо нэмэгдүүлэх, судлаачдын гадаад хэл, компьютерын боловсролыг дээшлүүлэх, судалгааны орчин үеийн аргазүй эзэмшүүлж мэргэшүүлэхэд ихээхэн анхаарах шаардлагатай нь манай боловсролын салбарын өдөр тутмын ажил амьдралаас улам тод харагдах болов.

Шинжлэх ухааны судалгааны бусад чиглэлүүдтэй хамтран ажиллах, түүний ач холбогдлыг нийгэмд ойлгуулах, судалгааны үр дүнгээ хуваалцах тогтвортой

механизм бүрдүүлэх зэрэг нь боловсрол судлалаар тогтохгүй, манай нийгмийн шинжлэх ухааны салбарт бүхэлд нь хамаарах асуудал юм¹⁰³.

Багш бэлтгэх сургуулиудын сургалтын хөтөлбөрт боловсрол судлалын шинжлэх ухааны орчин үеийн онол, практикийн асуудлуудыг илүүтэй тусгах, сургалтын хөтөлбөр боловсруулах, сурах бичиг, сургалтын гарын авлага бэлтгэж хэвлүүлэх нь боловсрол судлалын хөгжилд тустайгаас гадна багш бэлтгэх ажлын чанарыг ихээхэн дээшлүүлэх ач холбогдолтой гэж үзвэл зохино. Үүний тулд бид өнгөрсөн 25 жилд ямар амжилт аль салбарт олов, мөн юу алдав, эдгээрийн шалтгаан, нөхцөл юу байв гэдгийг юуны өмнө судлан тогтоох шаардлагатай юм.

Үүнд өнгөрсөн 25 жилийн хугацаанд Монгол Улсын төр, Засгийн газраас социалист боловсролын тогтолцоог зах зээлийн нийгмийн боловсролын тогтолцоонд шилжүүлэх түүхэн зурвас үед боловсролын салбарыг шинэчлэн хөгжүүлэх талаар дэс дараатай, системтэй арга хэмжээнүүдийг авч ирсний үр дүнг тооцох, эдгээрийг хэрэгжүүлэх талаар орон нутаг, нэгж байгууллагын түвшинд авч хэрэгжүүлсэн үйл ажиллагааны ололт, дутагдалд үнэлгээ өгч, шинэчлэлийг цаашид эрчимжүүлэх талаар авах арга хэмжээний чиглэл, баримтлалыг нөхцөл байдлын шинжилгээний үндсэн дээр тогтоох шаардлагатай байгаа юм.

Тухайлбал: Монгол Улсын Боловсролын шинэ хууль (1991) батлагдсанаар тус улсын боловсрол түүхийнхээ шинэ үед орж, социалист үзэл суртлыг ертөнцийг үзэх үзлээ болгосон иргэн төлөвшүүлж, төлөвлөгөөт ажлын байранд зориулан ажиллах хүчин бэлтгэдэг байсан байсан үеэсээ олон улсын боловсролын хөгжлийн нийтлэг зүй тогтолд нийцсэн, зах зээлийн зарчимд шилжих үедээ орсон юм¹⁰⁴. Мөн 1995, 2002, 2009 онуудад Боловсролын багц хууль батлаж, нэмэлт өөрчлөлт оруулсан ба 1991, 2005, 2015 онуудад боловсролын талаар төрөөс баримтлах 3 удаагийн Үзэл баримтлалыг гаргасан боловч эдгээрийн хэрэгжилтийн үнэлгээг хийгээгүй байгаа юм.

1991 оноос Монгол Улсад боловсролын тогтолцоо нь албан ба албан бус боловсролын сектороос тогтох болж, сургууль төвтэй тогтолцооноос бүх нийтийн насан туршийн боловсролын тогтолцоог төлөвшүүлэх үе эхэлсэн нь манай орны хувьд цоо шинэ үзэгдэл юм.

¹⁰³ Бэгз Н. 2008. Боловсролын хөгжлийн онол, аргазүйн асуудлууд. УБ, 254-р тал.

¹⁰⁴ Бэгз Н. Монгол Улсын боловсрол. УБ, 1996. 11-р тал.

Гэвч насан туршийн боловсролын тогтолцоог бүрэн төлөвшүүлж чадаагүй байгаа түүхэн нөхцөл, нийгэм эдийн засгийн шалтгааныг тодорхойлох, цаашид засан сайжруулах талаар шаардлагатай арга хэмжээг төлөвлөж санал болгох нь энэ салбарт хийх судалгааны бас нэг үр дүн байхаар байна. Ерөнхий дунд боловсролын 10 жилийн сургалттай сургуулиуд, мэргэжлийн ажилчин бэлтгэдэг ТМС, дунд мэргэжлийн ажиллах хүчин бэлтгэдэг техникум, салбарын дээд сургууль, үндэсний ганц их сургуулийн тогтолцоог халж, Дэлхийн олон улсад мөрдөж байгаа ерөнхий ба мэргэжлийн боловсролын залгамж чанартай 12 жилийн бүрэн дунд боловсролын (5+4+3) сургууль, мэргэжлийн боловсролын шаталсан сургалт бүхий нийтлэг (4+2+3) тогтолцоонд шилжсэн нь Монгол улсын боловсролын салбарын түүхэн том ололт мөн.

Харин ЕБС-ийн ахлах ангиудын сургалтын агуулгыг олон улсын жишгээр а/ ерөнхий боловсролын агуулга, б/ сонгон мэргэшүүлэх агуулга гэж ангилан, төгсөөд ажиллах, дээд шатны сургуульд дэвшин суралцах чиглэлээр мэргэжлийн баримжаа авах, мэргэжлийн суурь эзэмших боломжийг суралцагчдад олгох нь чухал байна. Ингэхгүй бол бид бакалаврын 4 жилийн боловсролоор эх орондоо мэргэжлийн агуулгаар 9 жил суралцсан (ахлах ангийн 3+ бакалаврын 4+ магистрын 2 жил) гадаадын хүмүүстэй хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхөд хүрч байна. Ийнхүү манай системийн одоогийн байгаа түвшин, түүний үйл ажиллагааны үр дүн нь нийгмийн эрэлт, хэрэгцээг бүрэн дүүрэн хангахгүй байгаад дүгнэлт хийж, судалгааны хүрээнд хэрхэн үр ашигтайгаар сайжруулах санал, зөвлөмж боловсруулах шаардлагатай байгаа юм.

Боловсролын тогтолцооны удирдлага, санхүүжилт, үнэлгээ нь эрх зүйн шинэ орчинд хэрэгжээд 25 жил болж байгаа боловч бололцоогоо бүрэн дүүрэн ашиглаж чадахгүй байгаа тухай шүүмжлэлд их өртөж байна. Энэ тал дээр үнэлгээ, дүгнэлт, шинэ хандлага хэрэгтэй байгаа нь тэдгээрт хамаарах өнөөгийн нөхцөл байдлын шинжилгээ хийж дүгнэлт гаргах нь цаашид авах арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлэх шинжлэх ухааны үндэслэл болно.

Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын их дээд сургуульд оюутан, магистрант, докторант явуулан сургаж төгсгөж байгаа нь манай нийгмийн оюуны потенциалыг нэмэгдүүлж, богино хугацаанд тэдгээр орны техник, технологийг богино хугацаанд эзэмших, нутагшуулах, ингэснээрээ олон жилийн технологийн хоцрогдлыг нөхөх боломжийг олгож байгаа түүхэн боломж мөн.

Гэвч төгсгөсөн мэргэжилтнүүд эх орондоо бүрэн эргэж ирэхгүй, энэ талаар зохиож байгаа ажилд багагүй дутагдал оршиж байгаад дүгнэлт хийж, авах арга хэмжээний талаар дүгнэлт хийх шаардлагатай байгаа нь боловсролын судалгааны нийгмийн талын нэг зорилт болно. Гадаад орнуудад энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний түүхэн туршлага сургамжийн судалгаа энэ ажлын нэг хэсэг байх болно.

Сүүлийн жилүүдэд иргэдээс залуу үеийнхний хүмүүжил, төлөвшилд ихээхэн сэтгэл дундуур байгаагаа янз бүрийн төвшинд илэрхийлэх болж, төрөөс ч анхаарч эхэлж байна. Тиймээс сургууль, боловсролын байгууллагаас зохиож байгаа хүмүүжлийн ажлын үр нөлөө, хүртээмжид үнэлгээ өгч, сайжруулах санал боловсруулах нь энэ судалгааны бас нэг чухал хэсэг мөн.

Бүх шатны боловсролын агуулгын залгамж чанарыг хангах, сургалтын идэвхтэй шинэ аргыг хэрэглэх талаар боловсролын системд ихээхэн дэвшил ахиц гарч байгаа боловч, бага дунд боловсролын түвшинд сургалтын чанар хангалтгүй, мэргэжлийн боловсролын түвшинд хөдөлмөрийн зах зээлийн эрэлттэй нийцээгүй зэрэг ойрын үел шийдвэрлэх асуудал байсаар байна. Социализмын дараах орнуудын боловсролд оршиж байгаа шилжилтийн шатны онцлогтой эдгээр асуудлыг зүүн европын болон ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд хэрхэн шийдвэрлэж байгааг судлаж, өөрийн орныхтой хаоьцуулж үзэх нь энэ судалгааны нэг шийдвэрлэх асуудал байж болно.

Эдгээр зорилтуудыг хангах талаар Монгол Улсын боловсролын тогтолцоонд шинээр авч хэрэгжүүлэх, шийдвэрлэх асуудал олон байгаа ба түүнийг ойрын хугацаанд хэрэгжүүлэх үндэслэл сайтай санал, зөвлөмж боловсруулах нь энэ салбарын цаашдын судалгааны ажлын үр дүн байна.

Багшийн хөгжлийн хандлага, шийдэх асуудлууд

Багш нарын мэргэжлийг дээшлүүлэх, хөгжүүлэх тухай төр, засгийн удаа дараагийн шийдвэр, бодлогын баримт бичигт заасан нь хангалттай бий. Тухайлбал, бага, дунд боловсролын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай Монгол Улсын 2016.4.14 ний өдрийн хуулийн 3/20 дугаар зүйлийн 20.2.10 - 20.2.15 зэрэг заалтад, сургалтын агуулга, багшийн арга зүйн чиглэлээр мэргэжлийн багшид зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах талаар тодорхой заасан байдаг.

Мөн “Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого” (2014-2024 он), “Монгол Улсын Их Хурлын 2015 оны 12 дугаар тогтоол”-ын хавсралт, “Монгол Улсын

Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого” зэрэг Монгол Улсын хөгжлийн бодлого, стратеги, урт болон дунд хугацааны хөгжлийн төлөвлөгөөг тодорхойлсон баримт бичгийн үзэл санаа, зарчим зэрэгт ч багшийн хөгжих шаардлага, боловсролын удирдах ажилтныг хөгжүүлэх тухай заалт бий.

Монгол улсын төрөөс Боловсролын талаар баримтлах бодлого (2015), Монгол улсын үндэсний хөгжлийн цогц бодлого, “Боловсрол” үндэсний хөтөлбөр (2010-2021), Багш боловсролын бодлого (2015), Эрдэм боловсролтой Монгол хүн хөтөлбөр (2012), Шинжлэх ухаан технологийн талаар баримтлах бодлого, Боловсролын тухай багц хууль зэрэг бодлогын баримт бичиг, тэдгээрийн *“...Боловсролыг нийгмийн тэргүүлэх салбар болгон хөгжүүлж, үндэсний боловсролын тогтолцоог олон улсын түвшинд хүргэх, чанартай боловсрол олгох, бүтээлч, чадамжтай хүний нөөцийг тасралтгүй нэмэгдүүлэх...”* гэсэн заалтууд мөн бий. Эдгээрийн мөрөөр багш бэлтгэдэг сургууль бүр эрчимтэй ажиллах шаардлага мөн буй.

Багшийн хөгжлийн шаардлага, одоогийн багш нарын байгаа бодит байдал хоёр боловсролын салбарын, тэр дундаа багш бэлтгэдэг их, дээд сургуулийн гол асуудал, прадокс юм.

Энэ нь боловсролын салбарын бодлого боловсруулан, шийдвэр гаргагчид болон судлаач-арга зүйчид, их, дээд сургууль- багш нар хоорондын амьдлаг уялдаа бага, хэлбэр төдий, сургалт семинари, зөвөлгөөн уулзалт дээр ярихаас хэтрэхгүй байгаа нь багшийн хөгжлийг хурдацтай хөгжүүлэхэд саад учруулж байдаг. Тэгвэл, энэ асуудлыг нэгтгэн зангидах, энэ талд хойрго, дорвитой ажиллахгүй байгаа байгууллага, хариуцлагатанд хариуцлагыг үүрүүлдэг тогтолцоонд мэргэжлийн яам анхаарахгүйгээс энэ ажилд шууд хамаарах гол байгууллага тоймтой санаачилга гаргахгүй бусад ижил төсөөтэй үүрэг бүхий байгууллагын зохиосон ажилд хамтран оролцох нэрээр, бусдын далбаан дор явсаар байгааг тодруулж, шахаж шаардан ажиллах хэрэгцээ эдүгээ байсаар байгаа нь нууц биш байна.

Багш өөрөө хөгжих юм уу, тэднийг гаднаас нь удирдаж , шаардаж хөгжүүлэх юм уу, гэдэг асуудлын мөн чанарыг дахин авч үзэж, 21 дүгээр зууны багш боловсрол гэх утгаар хөгжихүй- хөгжүүлэхүй талаас нь ухаарч харах хэрэгтэй байна. Энэ тухайд багш өөрөө яаж хөгжиж байж шинэ эриний нөхцөл шаардлагад нийцэх-ахуй амьдралдаа чанарын дэвшил гаргах гэдгийг эхний эрэмбэд авч үзэх хэрэгтэй. Багшийн өөрийн нь тэмцэл хөдөлмөр гол хөдлөх хүчин болох учиртай.

Иймд багш нарын сэтгэлгээний боловсролд ахиц гаргах нь эрхэм зүйл болсон. Багш хүний өөрийн бүтээлч суралцахуй, үйлийн явцдаа бүтээлчээр суралцах, өөрийн сурах үйл ажиллагаагаа судалж өөрийгээ оношлох үйл өнөөдөр дутсаар байна. Өөрийн үнэлэмжийн онол гэж бий, энэ чиглэлээрх судлалыг хөгжүүлэн багш нарт гарын авлага, зөвлөмж бэлтгэн хүргүүлэх нь чухал байгаа билээ.

Багш бүрийн өөрийн үнэлгээ, өөрийн зохицуулалт -удирдлагатай бүтээлч суралцахуй үгүйлэгдэж байна. Өөрөө үнэлгээ хийж- өөрөө суралцаж - өөрөө хийж бүтээж туршлагаждаг, цааш хэрхэн боловсрох хүсэлтийн дагуу, хүч үл хүрэх бол гаднаас дэмжлэг туслалцаа авдаг байх ийм “өөрөө хөгжихүйн тогтолцоо”-г багш бүр бий болгох хэрэгтэй. Багш хүн өөрөө сурах орчноо бүрдүүлдэг, суралцах, хөгжихүйн хэрэгцээгээ өөрөө мэдэрдэг, хөгжихүйн төлөө тэмцдэг байх нь шинэ зууны багшийн хөгжлийн гол концепци юм. “Сургууль, боловсролын байгууллагын хөгжил, өөрчлөлт шинэчлэлт нь багш бүрийн хувь хандлага, сэтгэлгээнээс шалтгаална” гэх ойлголтыг сургуулийн удирдлага, багш нарын нэг үзэл баримтлал болгох хэрэгтэй.

Багшийн хөгжлөөр хэсгийн чанартай сургалт семинари, тоон судалгааг шүтэх бус түүнээс илүүтэйгээр, багшийн хөгжлийг судалдаг судлалыг хөгжүүлэх бодлого, механизмыг БМДИ тэргүүлэн шинэчлэх, уг байгууллага өөрөө шинэчлэгдэн хурдтай хөгжих хэрэгтэй болж байна. Багшийн хөгжлийн загвар, шатлал, хөгжих арга замыг тодорхой болгож, багш нар, багш бэлтгэдэг их, дээд сургууль, хамтран оролцогч байгууллагуудад нэг мөр цэгцтэй ойлголт өгөх, бодлогоо тов тодорхой болгох нь эрхэм зүйл болж байна.

Байгууллагын суралцахуйг тодорхой байр сууринд тавьж, “Суралцагч байгууллага, хамт олон” хэмээх хөдөлгөөн өрнүүлэн, нэр хүндийг нь өргөж алдаршуулах, урамшуулал, хөнгөлөлт үзүүлдэг тогтолцоо механизмыг бий болгох шаардлагатай. Багш нар багшийн хөгжлийн төв, интернэт орчинг сайтар ашиглах, энэ талын мэдлэг, чадвартай байх нь чухал.

Өндөр хөгжилтэй улс орнууд “Суралцагч нийгмийг бүтээх уриатай, иргэд нь ч суралцагч нийгмийн иргэн болох уриатай” юм. Ийм алсын хараа Америк, англи, Япон орныг ихээхэн үсрэнгүй хөгжүүлжээ.

Ажлын байран дээрээ хөгжих боловсрох асуудлаар багш багштайгаа ярилцдаг, оюутан, суоалцагчтайгаа ярилцдаг байх хэрэгтэй. Бие биеээсээ болон суралцагчаасаа суралцахаас нэрэлхэхгүй байх нээлттэй суралцахуй чухал. Үүнд тодорхой цаг зардаг байх хэрэгтэй. Суралцахуй-хөгжихүйн талаарх хандлага-

үнэлэмжээ багш бүр өөрчлөх хэрэгтэй. Багш өөрийнхээ хэтийн болон ойрын ирээдүйн хөгжлөө 5,10,20 жилээр төсөөлөн тооцох, төлөвлөх нь чухал.

Харилцан хөгжих, хамтарч ажиллах сонирхлоороо баг бүрдүүлэх хэрэгтэй. Үүний тулд хамт олны эвсэг, ажилсаг, тусархаг уур амьсгалыг бүрдүүлэхэд сургууль, тэнхим, дунд сургуулийн заах аргын нэгдлүүд хичээж ажиллавал зохино. Ийм ажлууд өрнөсний дараа, гаднаас тэр суралцахуй-хөгжихүйг нь хэрхэн дэмжих вэ гэдэг асуудал эрэмбэлэгдэх юм.

Багшийн суралцах-хөгжихүйд метакогнитив хөгжлийн онол арга зүйг шингээх, бүтээлч-бүтээгч байр суурийг үйл хэрэгт нь суурьшуулж өгөх нь чухал. Багшийг сайн багш, муу багш гэж үзэхээс илүүтэйгээр, өнөөгийн шаардлагыг хангаж чадаж байгаа эсэхээр нь хэмжиж, үнэлж, шаардаж, хөгжүүлэхийн зэрэгцээ багшийн хөгжлийг ажлын нь үзүүлэлтэд оруулан үнэлэхэд болохгүй зүйл үгүй юм. Учир нь боловсролын хөгжлийн түлхэх хүч бол багш бүрийн хөгжил ахиц, дэвшил юм. Багшийг багштай харьцуулах биш, багш өөрийн өсөлт ахиц өөрчлөлтийг өөр дээрээ өмнөх ба эдүгээх хэмээн харьцуулах юм. Багш бүрийн хөгжих агуулга, хэрэгцээг ижилсүүлэн төлөвлөхөд өнөөдөр амаргүй болсон, учир нь багш бүр өөр өөр зүйлийг мэддэг, мэдлэг туршлагаараа ялгаатай. Иймд “өөрийн үнэлгээ” бодитой байх болно.

Багшийн хөгжил бага цагт үнэ цэнтэй их зүйлийг хийдэгт байх болно. Альберт Эйнштейн "Амжилтын төлөө бус үнэ цэнтэй болохын төлөө зүтгэ" гэж зөвлөсөн байдаг. Багш шинэчлэгдэх гэдэг нь өмнөхөө тэр чигт нь үгүйсгэхийн нэр бас биш юм. Өмнөх сайн зүйлийг үргэлжлүүлэн улам боловсронгуй болгох нь багшийн хөгжлийн нэг хэсэг байна.

Багшийн хөгжлийг хангах нэг гол хэрэглэгдэхүүн бол интернэт сүлжээ мөн. Иймд сургууль байгууллага бүр багш ажилтнуудаа мэдээллийн технологийн боловсролтой болгож, мэдээлэл авч боловсруулах, түгээх, хөгжихөд сургах нь чухал юм. Багш бүрийг өөртөө хэрэгтэй сонголтоор бүрдсэн хөгжлийн хөтөлбөртэй, сонирхлын чиглэлдээ нийцсэн судалгааны сэдэвтэй болговол зорилгодоо хүрэхээр хичээж ажиллах болно.

Их, дээд сургуулийн багш нарыг хөгжүүлэхэд төсөв хэмнэсэн, багшийн хөгжлийн оновчтой зохион байгуулалтын нэг нь, ижил төсөөтэй мэргэжлийн тэнхим, сургууль хоорондын хамтын ажиллагаанд тулгуурлан сургууль тэнхимээс багшаа хөгжүүлэх бодлого барих, бусад улс орны болон өөрийн орны эрдэмтэдтэй хамтран ажиллаж, үзэл бодол, оюуны хүчээ нэгтгэх, эрдэмтдийн нэгдмэл орон

зайг бий болгох явдал бөгөөд энэ нь тэнхим, сургууль ажлын байрандаа багшийг хөгжүүлэх нэг бодлого байна.

Багш бэлтгэдэг аль ч сургуулийн ялгаагүй, өөрийн сургуулийн багш нараа хөгжүүлэх, суралцагчийн хөгжлийг дэмжих, багшлах арга зүйгээр дэмжих ажлыг тухайн сургуулийн боловсрол судлалын тэнхим, дидактикийн багш нар өөрийн үүрэг хэмээн ойлгож, ихээхэн ажил хийх хэрэгтэй. Учир нь, багш бэлтгэх сургуулийн багш нар өөрсдөө сайн арга зүйч байх шаардлагатай.

Мөн багшийн хөгжлийн онолын шинэ парадигмыг боловсрол судлаачид, сургах зүйчид багшлах боловсон хүчин бэлтгэдэг их сургуулийн дидактикчид, мэргэжлийн тэнхимүүд мэргэжлийн онцлогт нийцүүлэн боловсруулах шаардлагатай. Их, дээд сургуулийн сэтгэл зүй судлалын багш эрдэмтэд нь насанд хүрэгчдийн, тэр дотроо багшийн сэтгэл зүй, багшийн хөгжлийн сэтгэл зүйг онцлон үзэж, судалгааныхаа тэргүүлэх чиглэл болгон судлах хэрэгтэй байна. Өсвөр насны сэтгэл зүйн онцлогийг олон жил ярьсан бол одоо өнөө тулгамдаж байгаа эл чиглэл рүү орох хэрэгтэй.

Багшийн хөгжлийн асуудлыг онолын үндэстэй авч үзэх, багшийн хөгжлийг түүний маркетинг, менежмент асуудалтай цогцоор судлан онол арга зүйг хөгжүүлэх шаардлага бий юм. Багшийн хөгжлийг нийгэмшил, хувьсал өөрчлөлтийн онолоор баяжуулах ч чухал.

Их, дээд сургуулийн эрдэмтэн багш нар эшлэгдсэн бүтээлийнхээ тоогоор Монгол Улс азид 3 дугаарт эрэмбэлэгддэг. Харин судалгаагаа үйлдвэрлэл, мэдлэгээ бизнес дорвитой бүтээгдэхүүн болгох чадвар нь дутагдалтай байдаг байна. Иймд багш, эрдэмтдийн шилдэг технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэн гарааны компани байгуулах ажлыг дэмжих нь сургуулиудын бодлого байх. Улсын хөгжил түргэсгэхэд их сургууль, бизнес, төр гурав нийлэн ажиллах нь багшийн хөгжлийн үр дүнг ч дэмжсэн сургууль ч хөгжих суурь болох юм.

Ийнхүү, их сургуулиуд мэдлэгээр бүтсэн өндөр технологио бизнесүүдэд өгч, бизнесүүд үйлдвэрлэлд нэвтрүүлж, төр татвараар нь дэмжвэл багш эрдэмтэд хөгжихийн дээр, чанартай амьдрахуйд дэвших юм. Багш нар судалгааны ажлын хэсгийг зөвхөн нэг сургууль дотроо гэхгүй сургууль хооронд байгуулж шинэ дорвитой нээлт хийхэд зорих нь чухал. Төр, БСШУЯ, ШУТехнологийг дэмжих сангаас өнөөдрөөс илүүтэй маргаашдаа санаа тавьж, өмнөөс тооцоотой хөрөнгө оруулалт хийх хэрэгцээ байсаар байгаа юм.

Мөн эрдэмтэн багш нар нь дэлхийн түвшинг цараалж судалгаагаа хийх, сургууль байгууллага нь ч өндөр чадавх, ирээдүйтэй эрдэмтдээ гадаадад судалгаа хийлгэх, ажилд нь оролцуулж ажиллуулах, сураад ирэхэд нь лабораториор хангах энэ ажилдаа Засгийн газрын тэтгэлгийг үр ашигтай тооцоолон ашиглах, улс орнуудын Засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээр, тусламж хөрөнгийг энэ үйлсэд зарцуулах зэрэгт анхаарах нь зүйтэй байна. Гадаад орнуудад гарсан боловсрол судлал хийгээд бусад шинжлэх ухааны шилдэг бүтээлүүдийг монгол хэлэнд орчуулан хүргэх талд мэргэжлийн яам, багш бэлтгэдэг их сургуулиуд ахиц гаргавал зохино.

Олон улсын багш, мэргэжлийн судлаачдын солилцооны хэлбэрийг ашиглах талаар ч дэвшил хийх нь чухал. Мөн судлаач багш нарт зориулсан сургалтын хөтөлбөрүүдийг тодорхой нөхцөл болзлоор зарлан, гадаад дотоодын их дээд сургуулиудад урт богино хугацаагаар сургах, төрөөс хөнгөлөлтийн дэмжлэг үзүүлж төгсөлтийн дараах хариуцлагыг хянан сахиулах, улсад бүтээн байгуулалт оруулахад нь түлхэц, шаардлага тавих хэрэгтэй байна.

Боловсролын салбарын мэргэшсэн удирдах болон бусад ажилтныг багш нарын зорилтот бүлэг бүрийн эрэлтэд нийцсэн удирдлагаар хангах хийгээд тухай үеийн боловсролын шинэчлэлийн хэрэгжилтийг дэмжсэн, хүний нөөцийн төлөвлөлт, бодлоготой уялдуулан сургах, мэргэшүүлэн дадлагажуулах нөхцөлийг бүрдүүлэхэд мэргэжлийн яам, БМДИ, Боловсролын хүрээлэн, Удирдлагын институт, МУБИС хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх. Ингэхдээ боловсролын удирдах ажилтнуудын тухайд онцлох зүйл бол тэдний хэрэгцээ, онцлогт нь нийцэх урт ба, дунд, богино хугацааны ялгавартай төлөвлөгөө бүхий сургалтын модулийн тогтолцоо боловсруулан үндсэн, төрөлжсөн, хөрвөх, бие даах сургалт зохион байгуулах нь ашигтай байх болно. Энэ ажил МУБИС-ийн “Боловсролын удирдлагын тэнхимд шууд хамааралтай юм.

Гадаад улсад амьдарч багшилж байгаа монгол багш нарт үндэсний боловсрол, мэргэжлийн чадамжаа дээшлүүлэх зайн болон ажлын байран дах сургалтын нь хөтөлбөр хэрэгжүүлж ажиллах, энэ ажлыг дэмжин хамтарч ажиллах олон улсын чанартай сургалтын хөтөлбөр, зэрэг ахиулах сургалтын сертификат бүхий төрөл, хэв шинжийг нээн хөгжүүлэх нь чухал байна.

Мэргэжил дээшлүүлэх ажлын зах зээлд амжилттай өрсөлдөх, түүний орчин нөхцөл, техник технологийг бий болгох, багш хөгжилд тулгамдаж байгаа асуудлыг үндэсний онцлогт тулгуурлан шийдвэрлэх, үндэсний инновацийн чадавхийг

бэхжүүлэхэд их сургуулиуд хүчээ нэгтгэн, хамтын бодлого боловсруулан хувь нэмрээ оруулах. Ингэхдээ шинэ бүтээгдэхүүний инноваци хөгжүүлэхэд зориулсан сургалтыг дараах дөрвөн шалгуурт нийцүүлж зохион байгуулах шаардлага бий. Тухайлбал, 1/ шинжлэх ухаан технологийн хувьд шинэлэг, 2/ амьдрал, практикт хэрэгжихүйц, 3/ зах зээлд арилжаалагдах шинжтэй, 4/ хэрэглэгчдийн тодорхой эрэлт хэрэгцээг хангахуйц байх шаардлагад нийцүүлэн явуулах зэрэг болно.

Монгол улсын үндэсний цөөнхийн болон гадаад дахь монгол хүүхдийн боловсролыг цаашид хөгжүүлэх нь

а/ Үндэсний цөөнхийн хүүхдийн боловсрол

Монгол улсын казах хэл дээр сургалт явуулдаг анхны сургууль 1928 онд одоогийн Улаанхус сумын нутаг Билүүгийн ам гэдэг газарт 25 хүүхэдтэйгээр байгуулагдаж, монгол хэлийг хэрэглээний түвшинд¹⁰⁵ сургаж байжээ. МАХН-ын 9 дүгээр Их Хурлаар бичиг үсгийн боловсролын асуудлыг ээлжит зорилго болгон тавьж, явуулын багш нартай болсноор үндэсний хэлээр бичиг үсгийн боловсрол олгох ажил өрнөсөн 1930-аад оны дунд үед казах хэлээр сургалт явуулдаг сургуульд Ардын гэгээрүүлэх яамнаас ирүүлсэн сургалтын төлөвлөгөөний дагуу монгол хэл, бичгийг цөөн цагаар судалж¹⁰⁶ эхэлсэн байна. 1940-50-иад оны үед монгол хэлийг 5 дугаар ангиас буюу дунд ангиас эхлэн судалж, монгол багш хичээл заадаг байжээ¹⁰⁷. Энэ үед (1930-31 онд) Зөвлөлт Казахстан Улсаас зургаан багш ирж хэд хэдэн газарт сургууль байгуулан ажиллаж байсан ба сургалтын программ нь Зөвлөлт Казахстан Улсынх байв. Зөвлөлт Казахстан Улсын сургалтын хөтөлбөр, сурах бичгийг ерөнхий боловсролын сургалтад ашиглах нь 2000-аад он хүртэл үргэлжилсэн байна.

200-аад оны дунд үеэс Английн хүүхдийг ивээх сангийн “Казах хүүхдийн боловсролын байдлын дүн шинжилгээ” (2005), Боловсролын Хүрээлэнгийн “Казах сургуулийн сургалтын агуулга” (2010) судалгаа, Швейцарийн Хөгжлийн Агентлагаас “Казах үндэстний цөөнхийн эрхийн хэрэгжилт” (2009) судалгаа хийгдэж, Монгол улсын үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын хүртээмж, чанарын асуудлыг хөндөн тавьсан байна.

Боловсролын хүрээлэнгийн ҮЦГМХБСС нь байгуулагдсан цагаасаа дээрх судалгаагаар илрүүлсэн асуудлыг шийдэх, үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын чанар, сурлагын амжилтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох,

¹⁰⁵С.Хавшай “Шырақтан шуаққа”, 1970, Өлгий

Х.Хожанияз “Баян-Өлгий аймгийн боловсролын түүхэн хөгжил”, 2010, Өлгий

¹⁰⁶ Х.Хожанияз “Баян-Өлгий аймгийн боловсролын түүхэн хөгжил”, 2010, Өлгий

¹⁰⁷ Ахмад багш нарын өгсөн мэдээллээр

шийдвэрлэхэд судалгаа, арга зүйн ажлаа чиглүүлж ирсэн байна. Тухайлбал, секторын зүгээс 2013-2016 онд боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон НҮБ-ын Хүүхдийн сангийн дэмжлэгтэйгээр үндэсний цөөнхий хүүхдийн эх хэл (казах, тува хэл) болон монгол хэлний сургалтын үр дүнг тандах судалгааг бага, суурь боловсролын түвшинд хийсэн нь тухайн зорилтот бүлгийн хүүхдийн сурлагын амжилтад нөлөөлж буй гол хүчин зүйл болох багшлах боловсон хүчний хөгжил, хос хэлээр суралцах шаардлагатай сурагчдад хичээл зааж буй багшийн хос хэлний боловсрол, мөн хичээл заах арга зүйн асуудлыг тодорхойлох ач холбогдолтой болсон байна. Мөн казах хэлээр сургалт явуулдаг сургуульд сүүлийн 18 жилийн турш мөрдөж ирсэн сургалтын төлөвлөгөөн дэх монгол хэлний цаг нь монгол хэлээр сургалт явуулдаг сургуульд монгол хэлийг судалж буй цагаас бага боловсролын түвшинд 492 цаг буюу 36,9%-иар, суурь боловсролын түвшинд 210 цагаар буюу 29,9%-иар бага байгааг¹⁰⁸ тогтоож, холбогдох байгууллагад санал зөвлөмж хүргүүлсэн нь дээрх байдлыг засах үндэслэл болсон байна. ҮЦГМХБСС-ийн хийсэн судалгаанууд нь Монгол Улсад өөр хэл, соёл бүхий угсаатны цөөнхийн хүүхдүүд төрөлх хэлний орчинд хос хэл эзэмших боломжийг дэмжсэн дидактик, оновчтой сургалтын хөтөлбөр одоогоор байхгүй. Хос хэлний боловсролын багш нарыг бэлтгэж, тэдний мэргэжлийг дээшлүүлж ирсэн туршлага хомс байгааг мөн тогтоосон байна.

Секторын хамт олон судалгааны дүнг үндэслэн 2013-2019 онд бага болон суурь, бүрэн дунд боловсролын казах, тува хэлний сургалтын хөтөлбөрийг боловсруулах, баталгаажуулах, сурагчдад зориулсан гарын авлага, хэрэглэгдэхүүн боловсруулах, багшийн хос хэлийг дэмжих сургалт арга зүйн ажлыг зохион байгуулж иржээ. Тухайлбал, тува, казах хүүхдэд зориулсан Монгол хэл 1, 2 гарын авлага болон тува хүүхдүүдэд зориулсан Тува хэл-1, Тува хэл-2, Тува хэл-3, Тува хэл-4, Тува хэл-5 сурагчийн гарын авлагыг багшийн гарын авлагын хамт боловсруулан сургалтад ашиглаж байна. Үүний дотор Монгол Улсын тува хүүхдүүдэд зориулсан тува хэлний анхны цагаан толгойн номын зохион сургалтад ашиглах болсон нь Монголын тувачуудын бичгийн боловсролд оруулсан чухал хувь нэмэр юм.

2017 оноос Боловсролын хүрээлэнгийн тус секторын хамт олон Монгол Улсын угсаатны ялгаатай бүлгийн хүүхдийн боловсролын чанарыг сайжруулах зорилтын хүрээнд ЕАБХАБ-ын Үндэстний цөөнхийн асуудал эрхэлсэн дээд

¹⁰⁸ У.Туяа, А.Ханат "Казах хэлээр сургалт явуулдаг сургуулийн сургалтын төлөвлөгөөг боловсронгуй болгох асуудалд", Боловсрол судлал, 2012, №3

комиссар (ҮЦАЭДК) болон НҮБ-ын Хүүхдийн сантай хамтран тус ҮЦАЭДК-оос Төв Азийн зарим улс орнуудад олон хэлний боловсролын хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлж буй туршлагыг¹⁰⁹ өөрийн улсын өвөрмөц онцлогт тохируулан нутагшуулах зорилгоор дараах чиглэлээр төсөл, хөтөлбөр хэрэгжүүлж эхэлсэн байна. Үүнд:

- Монгол Улсын өвөрмөц онцлогт тохирсон хос болон хэлний боловсролын хөтөлбөр боловсруулах;
- Хос хэлний боловсролын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн чиг хандлага болж буй судлагдахуун болон хэлийг интеграцчилан суралцахуй (СХИС)-г туршиж, Баян-Өлгий аймгийн хос хэлээр сургалт явуулдаг сургуулиудад нэвтрүүлэх;
- Баян-Өлгий аймгийн ЕБС-ийн багш нарын монгол хэлний мэдлэг, чадварыг сайжруулах, хос хэлээр сургалт явуулах үйл ажиллагааг дэмжих;
- Эх хэл болон монгол хэлний сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүнийг сайжруулах;
- Баян-Өлгий аймгийн боловсролын удирдах бүрэлдэхүүнийг хос хэл болон олон хэлний боловсролын чиглэлээр мэргэжлийг нь дээшлүүлэх зэрэг болно.

Дээрх ажлын хүрээнд Боловсролын хүрээлэнгээс олон/хос хэлний боловсролын талаарх чиг хандлага, сайн туршлагыг танилцуулах хүсэлтийг холбогдох байгууллагад хүргүүлснээр ЕАБХАБ-ын ҮЦАЭДК-ын Төв Ази болон Өмнөд Кавказын төслийн зохицуулагч, Төв Азийн боловсролын хөтөлбөрийн шинжээчдийн бүрэлдэхүүнтэй баг Монгол Улсад ажиллаж олон/хос хэлт боловсролын хөтөлбөр, СХИС арга хандлыгын талаарх сургалт хэлэлцүүлгийг 2018 онд зохион байгуулсан байна. ҮЦГМХБСС-ын санаачилгаар Монгол улсын боловсролын байгууллагын төлөөлөгчид Казахстан, Кыргызстан, Тажикстан, Узбекистан улсуудын туршлагыг судалж, олон улсын бүсийн сургалтад хамрагдаж иржээ.

Секторын хамт олон 2017-2019 онд судлагдахуун болон хэлийг интеграцчилан суралцахуй (СХИС)-н (CLIL-Content and Language Integrated Learning) онол арга зүй, олон улсын сайн туршлагыг судалсны үндсэн дээр угсаатны ялгаатай бүлгийн (казах, тува) хүүхдийн боловсролын чанарыг сайжруулахын тулд Баян-Өлгий аймгийн ерөнхий боловсролын зарим сургуульд СХИС-г нэвтрүүлэн үр дүнг нь түгээхээр ажиллаж эхэлсэн байна. СХИС бол эх хэлийг үнэлж, хоёр дахь хэлийг дэмжсэн арга, хандлага бөгөөд СХИС-ийг сургалтад нэвтрүүлснээр

¹⁰⁹ ВКНМ, ОБСЕ, “Как разработать и внедрить устойчивую программу много язычного образования”, Бишкек, (2016)

сурагчдын төрийн буюу зорилтот хэлний мэдлэг дээшилж, үндэсний цөөнхийн хүүхдийн боловсролын чанарт ахиц гарч, улмаар их, дээд сургуульд элсэн орох сурагчдын тоо нэмэгдэж байгааг Казахстан, Киргизстан зэрэг Төв Азийн зарим улс орны туршлага харуулж байна.

ҮЦГМХБСС-ын зүгээс сүүлийн жилүүдэд Монгол улсын тодорхой аймаг, сумдад цөөнх болон амьдарч буй угсаатны ялгаатай бүлгийн хүүхдүүдийн эх хэлний боловсролын талаарх судалгааны ажлыг эхлүүлсний нэг нь Хөвсгөл аймгийн тува - цаатан иргэдийн хүүхдүүдийн эх хэлээ сурч буй байдлыг судалсан явдал байна. Судалгаагаар дараах 2 зүйлсийг онцлон тогтоосон нь дараа дараагийн судалгаа, арга зүйн ажилд ач холбогдолтой юм. Үүнд:

- 2018 оны байдлаар Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын ерөнхий боловсролын сургуулийн 454 сурагчийн 160 нь буюу 35 хувь нь тува хүүхдүүд байх бөгөөд тэдний цөөнгүй хувь нь гэртээ эх тува хэлээрээ харилцаж байгаад сургуульд ордог байна. Иймээс сургуулийн удирдлага, багш нар төдийгүй орон нутгийн бодлого боловсруулагчид үүнийг анхаарч сургалтын бодлого төлөвлөлтөндөө тусгах нь сурагчийн сурлагын амжилтад эерэгээр нөлөөлнө.
- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын тува – цаатан иргэд, хүүхдүүд эх хэлээ мартаж болзошгүй байна. Орон нутагт сурагчдад төдийгүй залуучуудад эх хэлийг нь эзэмшүүлэх, мартуулахгүй байх, сэргээхтэй холбоотой орон нутгийн онцлогийг харгалзсан цогц бодлого, дэмжлэг үгүйлэгдэж байна.


б/ Гадаад дахь монгол хүүхдийн боловсрол

Монголчууд 1999-ээд оноос гадаад улс орнуудад олноор амьдарч, сурч хөдөлмөрлөх болсон. Сүүлийн 20 гаран жилийн хугацаанд гадаад орнуудад шинээр мэндэлж, өсөж торниж буй болон суурь боловсрол эзэмших насан дээрээ эцэг, эхтэйгээ гадаадад амьдарч буй монгол хүүхдүүд ихэнхдээ аж төрөн буй орныхоо ерөнхий боловсролын сургуульд хамрагдан, ерөнхий эрдмийн хичээлүүдийг сурч байна. 2000-аад оны дунд үеэс гадаад улс орнуудад ажиллаж, амьдарч буй иргэд өөрсдийн санал санаачилгаар хүүхдэдээ монгол хэлний хичээл заах, улмаар сургууль, соёлын төв болон өргөжих хөдөлгөөн өрнөжээ. Монгол улсын төр засаг ч гадаадад байгаа хүүхдүүдийнхээ эрх ашгийг хамгаалж, шат дараалсан арга хэмжээг авч эхэлсний нэг нь 2015 онд Боловсролын хүрээлэнд гадаад дахь монгол хүүхдийн боловсролын судалгааны секторыг байгуулж, 2016 оноос үйл ажиллагаа нь эхэлсэн байна.

Тус сектор үйл ажиллагаагаа хилийн чанадад буй амьдарч буй монгол хүүхдэд зориулсан “Монгол хэл, соёл” сургалтын жишиг хөтөлбөр”-ийг (цаашид хөтөлбөргэх) боловсруулахаас эхэлсэн байна. Уг хөтөлбөрийг боловсруулсан ажлын хэсэгт монгол хэл уран зохиол, түүхийн багш, мэргэжилтэн, бага ангийн багш, үүний дотор хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдэд хичээл зааж буй багш нарын төлөөллөөс гадна “Хилийн чанад дахь Монголчуудын холбоо” ТББ-ын Боловсролын хорооны гишүүд оролцсон байна. Сургалтын жишиг хөтөлбөр нь 2017 оны 8 сард БСШУС-ын сайдын тушаалаар батлагдсан бөгөөд “хилийн чанадад амьдарч буй хүүхдэд Монгол хэл, бичиг, үндэсний соёл, урлаг, ёс заншил, өв уламжлалаасаа суралцахад нь дэмжлэг үзүүлэх, эх орноороо бахархах, эх хэл, түүх, соёлоо эрхэмлэн дээдлэх, монгол нутгаа судлан мэдэх, хайрлан хамгаалах, хөгжүүлэх үйлсэд хувь нэмэр оруулах, эх оронч үзэл төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх” зорилготой юм. Хөтөлбөрийн агуулга нь дараах 3 бүрэлдэхүүн хэсэгтэй.

Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр хилийн чанад дахь монгол хүүхдэд эх хэлний мэдлэг, чадвар эзэмшүүлэхээр ажиллаж буй хэл, соёлын сургалтын байгууллага, тэнд ажиллаж буй багш нар үйл ажиллагаандаа баримтлах нэгдсэн, удирдамж баримт бичигтэй болох ач холбогдолтой. Энэхүү жишиг сургалтын хөтөлбөр нь хилийн чанад дахь монгол хүүхдүүдэд зориулсан анхны хөтөлбөр бөгөөд цаашид хөгжин боловсронгуй болох нь дамжиггүй.

Дээрх жишиг сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор



БСШУС-ын Сайдын 2017 оны А/85 тоот тушаалаар цахим сурах бичиг, багшийн номыг боловсруулах ажлыг ҮЦГМХБСС-ын санаачилга, оролцоотойгоор хийж гүйцэтгэсэн нь хилийн чанад дахь хүүхдүүдэд зориулсан анхны web

суурьмай сурах бичиг болсон байна. Уг цахим сурах бичгийг монгол хэл уран зохиолын, түүхийн, бага ангийн багш нар болон хилийн чанадад амьдарч буй монгол хүүхдэд хичээл зааж байсан багш нарын оролцоотойгоор бүтээсэн байна. ҮЦГМХБСС 2018 оноос гадаадад буй монгол хүүхдүүдийн боловсролтой холбоотой мэдээлэл цуглуулах эхлэлийг тавьсан байна. Энэ чиглэлийн судалгаа хийх, мэдээлэл цуглуулах механизм тогтоогүй, эхлэл төдий буй тул секторын хамт олон 2018 онд ХБНГУ-д болсон “Гадаад дахь монголчуудын XIV дэх чуулган”-д оролцогчдын төлөөлөл болон “Хилийн чанад дахь “монгол хэл, соёл”-

ын төвийн багш нарт зориулсан сургалт”-ад оролцогчдын төлөөллөөс, 2019 онд Швед улсад болсон Европ дахь монгол эмэгтэйчүүдийн холбооноос зохион байгуулсан “Эмэгтэйчүүд: Боловсрол, шинжлэх ухаан, инновац” форумын оролцогчдоос мэдээлэл цуглуулж эхэлсэн байна. Энэхүү анхны судалгаанд мэдээлэл өгсөн оролцогчид нь ХБНГУ, АНУ, Канад, Чех, Швед, Бельги, Япон, Нидерланд улсад ажиллаж, амьдарч буй иргэд, монгол, хэл соёлын сургалтын төвийн багш нарын төлөөлөл байжээ.

Дээрх анхны судалгаагаар хилийн чанад дахь монгол хүүхдийн боловсролтой холбоотой дараах эрэлт хэрэгцээ байгааг тогтоосон нь дараа дараагийн үеийнхэнд мэдээлэл цуглуулах, үйл ажиллагаа явуулахад ач холбогдолтой болжээ. Үүнд

- Хүүхдүүдийг эх оронд нь сурагч солилцоо хийх, тэдэнд зориулсан зуны зуслан зохион байгуулах, хэвлэмэл болон цахим сонин, сэтгүүлтэй болох;
- Багш нарын хөгжилд зориулсан санхүүгийн эх эх үүсвэртэй байх;
- Сурагчдад зориулсан сурах бичиг, хэрэглэгдэхүүн боловсруулах;
- Хилийн чанад дахь монгол хэл, соёлын төвийг мэргэжлийн багшаар хангах, багшийн мэргэжлийг дээшлүүлэх, багшийн нийгмийн хангамж, төрөөс дэмжлэг авах зэрэг байна.

Мөн уг сектороос гадаад дахь монгол хэл, соёлын сургалтын төвийн багш нарт зориулсан сургалтын эхлэлийг тавьсан байна. Тухайлбал, 2018, 2019 онд гадаадад амьдарч буй монгол хүүхдүүдэд монгол хэл, соёлын хичээл зааж буй багш нарын мэргэжил, арга зүйг дэмжих сургалтыг БСШУСЯ, БМДИ-тэй хамтран зохион байгуулж, улмаар энэхүү сургалтыг цаашид уламжлал болгон зохион байгуулах эхлэлийг тавьсан байна. Анхны сургалтуудад АНУ, Канад, Чех, ХБНГУ, Швед, ОХУ, Япон, БНСУ, Белги зэрэг улсад монгол хэл, соёлын сургалт явуулдаг багш нар оролцож байжээ.

Насан туршийн боловсролын ирээдүй

НТБ-ын тогтолцоо үүссэнээр сургуулийн гаднах болон “орхигдсон бүлгийнхэн”, тухайн насандаа бага, суурь боловсрол эзэмшиж амжаагүй насанд хүрэгчид, ажлын байр, гэр орноосоо хөндийрөхгүйгээр боловсролын ерөнхий түвшингээ дээшлүүлэхийг хүссэн бусад хүмүүст үйлчлэх боловсролын үйлчилгээний шинэ хэлбэр бий болж, боловсролыг зөвхөн сургуулиар бус насанд хүрэгчдэд боломжтой үедээ, өөрт тохирсон боловсролын хэрэгцээгээ хангах нэг арга зам нээгдсэн байна. Үүний үр дүнд 1990-ээд оны эдийн засгийн хямралаас үүдсэн сургууль завсардалт ба бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахад АББ-ын Гэгээрэл

төвүүд (хуучин нэрээр)-д явагдаж байсан сургалт ихээхэн үүрэг гүйцэтгэсэн байна.

Олон улсын болон үндэсний хэмжээнд иргэд байгууллагын хоорондох хамтын ажиллагаа, түншлэл дээшилсэн: НТБ-ын хүртээмжийг дээшлүүлэх, боловсон хүчнийг чадавхижуулах, сургалтын материалын нөөц бүрдүүлэх зэрэгт гарсан амжилт нь НТБ-ын салбарт ЮНЕСКО, ЮНИСЕФ, ОУХБ, бусад олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж ирсний үр дүн юм.

Багш суралцагчдын харилцааны хэлбэрийг шинэ шатанд гаргасан. НТБ-ын үйлчилгээний үр дүнд “багшгүйгээр суралцах”, хувь хүн өөрийгээ дайчилж бие даан сурах, “сурахад суралцах”, сурч мэдсэнээ амьдрал ахуйдаа хэрэглэх боломж бий болсон юм. Жишээ нь: өрхийн орлогоо нэмэгдүүлэх, жижиг бизнес эрхлэх зэрэг зах зээлийн эрэлт хэрэгцээнд тохирсон сургалтуудаас гадна эрүүл мэндээ сахин хамгаалах, хууль эрхийн мэдлэгээ дээшлүүлэх замаар боловсролын түвшингээ дээшлүүлэхэд чиглэсэн, амьдрах ухаанд суурилсан хөтөлбөрүүд чухал үүрэг гүйцэтгэж байна

НТБ-ын салбарын үйл ажиллагаанд зөвхөн бичиг үсгийн болон бага, суурь бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалт голлож, Мастер төлөвлөгөөнд тавьсан зорилт болох 15, түүнээс дээш насны иргэдэд үзүүлэх бусад үйлчилгээ орхигдож байна. Өөрөөр хэлбэл, НТБ-ын үндсэн зорилтот бүлэг нь сургуулийн насны хүүхэд бус, харин 15, түүнээс дээш насны иргэд байх ёстой бөгөөд насанд хүрэгчдийн суралцахууд үйл ажиллагааг чиглүүлэх шаардлагатай.

Насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролыг дээшлүүлэхэд зориулсан сургалтын хүртээмж, зохион байгуулалт хангалтгүй, түүнд зориулсан санхүүжилт тодорхой бус байна. Нөгөө талаар насанд хүрэгчдийн бичиг үсгийн боловсролд шийдвэр гаргагчид болон сургууль, орон нутгийн удирдлага бага анхаарч байна. Хүн амын бичиг үсэгт тайлагдалт (97.8 хувь)-ыг аман асуулгад үндэслэсэн 2000 оны тооллогын мэдээг баримталсаар ирсэн нь санаа амирлангуй хандах байдлыг үүсгэсэн нь ч нэг шалтгаан мөн.

Бага, суурь, бүрэн дунд боловсролын дүйцсэн хөтөлбөрийн сургалт нь тухайн түвшний боловсролыг нөхөн эзэмшихийг хүссэн хэнд ч нээлттэй боловч зөвхөн сургууль завсардсан, эсвэл хөгжлийн бэхшээлтэй хүүхдэд зориулсан мэтээр үздэг явцуу ойлголт хэвээр байна. Үүний нэг жишээ нь: 2017 оны 6 дугаар сарын 4-нд гарсан Засгийн газрын тогтоолоор Хэвтрийн болон хүнд хэлбэрийн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд боловсрол нөхөн олгох асуудлыг НТБҮТ-өөр дамжуулан

олгоно гэж заасан хэдий ч үүнийг зохион байгуулах, зохицуулах ямар ч механизм байхгүй, санхүүгийн хувьд хаана ч тусгагдаагүй тул тогтоолын заалт хэрэгжих ямар ч үндэсгүй байна.

НТБ-ын үйлчилгээ нь голдуу хот суурин газрын оршин суугчдад чиглэж, алслагдсан газар амьдардаг хөдөөгийн хүн амд хүрч чадахгүй байна. Энэ нь дээр дурдсан менежмент, зохицуулалт муу байгаагийн илрэл юм. НТБ-ын төвд орон нутгийн онцлогт таарсан, суралцагчийн хэрэгцээнд тулгуурласан боловсролын үйлчилгээ муу байгаагаас тус төвүүд нь мэдээлэл түгээдэг, хүмүүст тусалдаг, тасралтгүй боловсролын орчин болж чадахгүй байна.

1990- ээд онд сургууль завсардсан хүүхдүүд эдүгээ нийгмийн амьдралд оролцох идэвхтэй үедээ ирсэн насанд хүрэгчид болсон хэдий ч боловсролын түвшин доогуур байгаа нь тэдний амьдралд нөлөөлөхөөс гадна үр хүүхдэд нь нөлөөлж байна. Түүнчлэн шилжин сууршигчид ба амьдралын доогуур түвшинд аж төрөгчдийн дотор нийгэмд тодорхой байр суурь эзлэх насандаа хүрсэн, эдийн засгийн хамгийн идэвхтэй хүн амын хэсэг болох идэр насны эрэгтэйчүүдийн боловсролын түвшин доогуур байна. Энэ нь НТБ-ын үйлчилгээг насанд хүрэгчдийн боловсролд чиглүүлэх нэг үндэслэл болж байна.

НТБ-ын салбарт чамлахааргүй олон бодлого, эрх зүйн акт гарсан ч эдгээрийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүний нэг жишээ нь 2013 онд БСШУ-ны сайдын А/242 тоот тушаалаар батлагдсан “НТБ-ын яг газар дээрээ хангалттай бус, орон нутгийн түвшинд хэрэгжих механизм болж чадахгүй байна. Тухайлбал, Засгийн газраас батлан гаргаж буй үндэсний хөтөлбөрүүдэд үйл ажиллагааг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг хэсэг нь улсын төсөв байна хэмээн заадаг нь зөвхөн цаасан дээр л үлдэж, хаанаас хэн, хэрхэн зохицуулах менежмент нь өнөөг хүртэл хийгдэхгүй байсаар иржээ.

НТБ-ын үйл ажиллагаанд орон нутгийн болон сургуулийн удирдлагын үүрэг, оролцоо хангалтгүй байна. Хэдийгээр сургуулийн гадна буй хүүхдийг боловсролын үйлчилгээнд татан оролцуулах, талаар багийн засаг дарга болон сум орон нутгийн удирдлагуудын хүлээх үүрэг хариуцлагын талаар Боловсролын хуульд хэд хэдэн заалт орсон боловч түүнийг дээшлүүлэх хөшүүрэг үгүйлэгдэж байна.

НТБ-ын үйл ажиллагаа эрхэлж буй төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүмүүсийн хоорондох ажлын уялдаа муу, зохицуулах механизм байхгүй байна. Үүнээс болж, НТБ-ын салбарт үйл ажиллагаа явуулж буй ихэнх

байгууллагууд зөвхөн завсардсан хүүхэд төдийхнөөр ажлаа хязгаарлаж, эмзэг бүлгийнхнийг бэлэнчлэх сэтгэлгээнд сургаж байна.

Төр засгийн тогтворгүй байдал тус салбарын үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Тухайлбал, “Насан туршийн боловсрол” сургалтын багц хөтөлбөрийг үндсэн 5 чиглэлийн хүрээнд боловсруулан Боловсролын хүрээлэнгээс дүгнэлт гаргуулж БШУЯ-нд хүргүүлсэн боловч өнөө хүртэл батлагдаагүй байна.

НТБ-ын төвүүд Боловсрол соёлын газар, сумын засаг даргын тамгын газар, ерөнхий боловсролын сургууль зэрэг олон газар байрладаг. Сургууль завсардалт, бичиг үсэг үл мэдэгчдийн тоо нэмэгдсэнтэй холбогдуулан 1990-ээд оны эхээр АББ-ын Гэгээрлийн төвүүдийн 87.5 хувь нь сургууль түшиглэн байгуулагдсан юм. Энэ нь бичиг үсгийн болон боловсрол нөхөн олгох сургалтыг түлхүү зохион байгуулахад тохирч байснаас гадна АББ-ын багшийг сургуулийн төсвөөс цалинжуулах, ЕБС-ийн нарийн мэргэжлийн багш нарыг дүйцсэн сургалтад татан оролцуулах, сургуулийн анги танхимыг ашиглах, суралцагчдыг сургуулийн орчинд оруулах зэрэг давуу талтай байсан. Гэвч улмаар зорилтот бүлэг ба нийгмийн сэтгэхүйд гарсан өөрчлөлтөөс болоод энэ хэлбэр тохиромжгүй болсон тул тусдаа байртай байх шаардлага гарсан. 2017 оны байдлаар аймгийн төв ба Улаанбаатар хотын дүүргүүдэд ажиллаж буй НТБ-ын 29 төвөөс өөрийн гэсэн байртай төв 4 (3 нь Улаанбаатарт, 1 нь хөдөө орон нутагт), түрээсийн байранд 6, ЕБС-д байрладаг 11, БСУГ-т байрладаг 4 төв байгаа ба үлдсэн 4 нь бусад газар байрлаж байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм.

Боловсролын эрх зүйг цаашид шинэчлэх зорилт

Боловсролын эрх зүйн шинэчлэлийн байдалд хийсэн судалгааны дүнгээс үндэслэн Монгол Улсын боловсролыг цаашид хөгжүүлэх стратегийн зорилтуудыг дор дурдснаар тодорхойлж байна:

1. Боловсролын тэгш байдлын талаарх төрийн бодлогыг шинээр тодорхойлон үе шат, залгамж холбоотойгоор хэрэгжүүлэх.
2. Бүх шатны боловсролын чанар, хөрвөх чадвар, нийгмийн үнэлэмжийг дээшлүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэчлэл хийх.
3. Даяаршлал, нийгмийн эрэлт, шинжлэх ухаан, технологийн өөрчлөлтийн дагуу боловсролын хуучирсан агуулга, стандарт, сургалт-эрдэм шинжилгээний зориулалт бүхий тоног төхөөрөмж, техник хэрэгслийг шинэчлэх.
4. Боловсролын агуулга, стандарт, техник, технологийн шинэчлэлд нийцүүлэн бүх шатны сургуулийн багш, сурган хүмүүжүүлэгчдийн мэргэжлийн ур чадвар,

ёс зүйн төлөвшлийг дээшлүүлэх, тэдний нийгмийн баталгааг сайжруулахад чиглэсэн бодлого, зохицуулалтыг шинэчлэх.

5. Хөрөнгө оруулалт, санхүүгийн олон эх үүсвэрийг ашиглах замаар сурах, сургах болон соёл, хүмүүжилийн таатай орчинг боловсролын сургалтын байгууллага бүрд бий болгох.
6. Бүх нийтээр суурь боловсрол эзэмших төрийн бодлогын мөн чанарыг нийгмийн ухамсарт жигд төлөвшүүлэхэд төрийн, төрийн бус байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга, хэлбэрийг өргөн ашиглах.
7. Бүх шатны боловсролын байгууллагын менежментийн чадавхийг дээшлүүлэх, тэдгээрийн үйл ажиллагааг өөрчлөлт, шинэчлэлийн үр дүн, ач холбогдол, үр нөлөөгөөр нь үнэлж, дүгнэдэг тогтолцоог бий болгох.
8. Боловсролын салбарын мэдээллийн хамралт, үнэн бодитой байдал, мэдээллийг боловсруулах, сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллээр үйлчлэх, мэдээллийг ашиглан судалгаа хийдэг үйл ажиллагааг багтаасан Боловсролын удирдлагын мэдээллийн нэгдсэн тогтолцоог бий болгон төлөвшүүлэх.
9. Боловсролын салбарын төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөр, төсөл, стандарт, ойрын болон хэтийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлгээ өгдөг тогтолцоог боловсронгуй болгох.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. СУРГАМЖААС ХИЙХ ДҮГНЭЛТ

1/ Олсон ололт, хүрсэн түвшинг дүгнэвэл

Монгол Улс 1990-ээд оноос хойш боловсролын тогтолцоондоо хөгжлийн үзэл баримтлал, түүнийг хэрэгжүүлэх эрх зүй, удирдлага, эдийн засаг, бүтэц, зохион байгуулалтын шинжтэй шинэчлэлтийг тасралтгүй хийж, хүртээмж, чанар, үр ашгийн зохих үр дүнд хүрчээ.

Сургуулийн өмнөх, бага дунд боловсрол, мэргэжлийн боловсрол, сургалтын болон дээд боловсролын түвшинд сургалтын агуулгыг оновчилж, орчны бүрдэл, багшлах боловсон хүчний хангамжийг сайжруулах талаар нэлээд ахиц гаргасан байна.

Төв суурин газруудад цэцэрлэг, сургуулийн барилга байшингийн хангамж, хамран сургалтын хувийг нэмэгдүүлэх, чанарыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсрол сургалтын санхүүжилт, төгсөгчдийн ажил эрхлэлтийг сайжруулах, дээд боловсролын сургалтын зохион байгуулалтыг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулах ажил үргэлжилж байна.

Сургууль завсардагчдад чиглэсэн албан бус боловсролын сургалтын тогтолцоог бэхжүүлэн, улмаар насан туршийн боловсролын тогтолцоог бий болгох асуудал эхлэлийн шинжтэй байна.

2/ Туулсан замаас олсон туршлага юу хэлж байна вэ?

Монголчууд өөрсдийнхөө сурах чадварыг хангалттай үндэслэлтэй судлаагүй бөгөөд өмнө нь сургалтын практикт ЗХУ-ын эрдэмтдийн хийсэн судалгааны үр дүнг монгол хүүхэд дээр буулгаж ярьдаг байсан нь 1990-ээд оны дунд үеэс нэг хэсэг америк, англи, японы судалгааг шууд авч хэрэглэх хандлагаар солигдсон байна.

Харин 2013 оноос монгол хүүхдийн хөгжлийн цогц судалгааг эхлүүлж, үр дүнг сургалтын бодлогод харгалзах боломжтой болж байна. Энэ судалгааг зохих давтамжтайгаар хийж, улмаар монгол хүний хөгжлийн стандартыг албан боловсролд хамрагдах насыг хамруулан боловсруулж мөрдөх шаардлагатай юм.

Нийгэмд боловсролын гүйцэтгэх 1/иргэн төлөвшүүлэх, 2/хүний хөгжлийг дэмжих, 3/мэргэжил эзэмшүүлэх 3 үндсэн зорилт жигд хангагдахгүй байна. Монгол хүүхэддээ бага насанд нь уламжлалт соёл, хэл, түүх, ёсзүйгээ эзэмшүүлэх ажил бодлоготойгоор хийгдэж чадахгүй байснаас тэд глобаль соёлын нөлөөнд илүүтэй татагдан орох байдал сүүлийн жилүүдэд нэмэгдэж, нийгмийн зүгээс шүүмжлэлтэй хандаж байна. Ялангуяа үндэсний хөтөлбөрөөр хичээллэдэггүй

хувийн хөрөнгө оруулалттай сургуульд суралцагчид бага наснаасаа уламжлалт соёлоос хөндий өсөх байдалтай болж байна.

Сүүлийн жилүүдэд хүүхэд залуучуудын хэл яриа ядуурсан, тэд эх орон, үндэстнийхээ түүхийг олигтой мэддэггүй, хот суурин газрын хүүхдүүд буруу хооллодог, гар утас, компьютерын тоглоомоос хараат болж байгаа нь энэ насныхны хүмүүжил, сургалтын бодлогод цаг үеийн онцлогтойгоор, шинэ байдлаар хандах шаардлагатай болсныг харуулж байна.

Боловсролын үйл ажиллагааны хүрээнд хүнийг бие бялдар, оюун ухаан, хэл, нийгэмшлийн талаар жигд хөгжүүлэх ажил мэргэжлийн удирдлага талаасаа ч, сургалт, хүмүүжлийн орчин талаасаа ч хангалтгүй байгааг янз бүрийн түвшинд нэлээд бичдэг юм байна. Сүүлийн 25 жилд боловсролд хийгдсэн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүүхэд залууст шинжлэх ухааны мэдлэг, чадварыг хэрхэн эзэмшүүлэх вэ гэдэг асуудалд их анхаарчээ.

Харин хэт хурдтай хотжиж байгаа орчинд бага наснаасаа сургуульд элсээд, нүүдэлчин ахуйн хүрээнд төлөвшдөг уламжлалт соёлоос улам бүр хөндийрөх байдалд орж, улмаар глобаль соёлын нөлөөнд орж байгаа хүүхэд, залуучуудын хүмүүжлийн асуудлыг шинжлэх ухааны сургалттай хэрхэн зөв хослуулах талыг дутуу орхисон байдал харагдаж байна. Гэтэл Монгол Улсын сургуулийн насны хүүхдийн эцэг, эх ихээхэн залуужсан, тэд хүүхэдтэй ажиллах туршлага нимгэн тул хүүхдийнхээ хүмүүжлийг сургуульд найддаг хэвээр байсаар байна.

Дээд боловсролын байгууллагуудад сургалт явуулж буй чиглэл, бэлтгэсэн мэргэжилтний тоо, чанар нь улс, орны хөдөлмөрийн зах зээлийн эрэлтэд тэр болгон нийцэхгүй байна. Уул уурхайн үйлдвэрлэлд түшиглэн хөгжих бодлоготой уялдсан, улс оронд чухал хэрэгтэй байгаа мэргэжилтний хэрэгцээ ба дээд боловсролд суралцагчдын мэргэжлийн чиглэл ихээхэн зөрүүтэй байна.

Мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшигчдэд иргэний төлөвшил, мэргэжилтний хариуцлага, сахилга батын мэдрэмж нийтлэгээр дутагдаж байгаагаас хэрэглэгчийн шаардлагыг хангахгүй байх явдал түгээмэл байна.

Боловсролын удирдлагын хүний нөөцийг мэргэшүүлэн бэлтгэх, үр дүнтэй ашиглах явдал улс төрөөс ангид мэргэжлийн асуудал юм. Гэвч сүүлийн жилүүдэд манай улсад улс төрийн сонгууль бүрийн дараа ёс юм шиг төв, орон нутгийн төрийн өмчийн боловсролын удирдах ажилтнуудыг хоморголон халж, өөрийн намын хүнийг мэргэжил, мэргэшил харгалзалгүй томилдог явдал бараг жишиг болон тогтсон байна.

Насанд хүрсэн хүн ам, гэрийн эзэгтэй нар, өндөр настанд хандсан боловсролын үйлчилгээ хангалтгүй байсаар байна. Насан туршийн боловсролыг боловсролын тогтолцооны бие даасан хэсэг гэж үзэж, төрөөс санхүүжилттэй, төвлөрсөн болон орон нутгийн удирдлагатай, үндэсний хэмжээний дэд тогтолцоо болгон хөгжүүлэх хэрэгтэй байна.

Монгол Улсад боловсролыг хөгжүүлэх бодлогын болон түүнийг хэрэгжүүлэх түвшний олон үзэл баримтлал, хөтөлбөр төлөвлөгөө гардаг боловч түүнийг авч хэрэгжүүлэх, мөрдөх ажлын залгамж чанарт ихээхэн дутагдал оршиж байна. Өмнөх бодлогын баримт бичгүүдийн хэрэгжсэн хугацааны үр дүнг тооцож, хөгжлийн тухайн шатны үнэлгээнд үндэслэн дараах бодлогыг төлөвлөдөг зарчимд шилжих шаардлагатай гэж үзэж байна.

3/ Гарц шийдэл

Өмнө гарсан бодлогуудаа төгөлдөржүүлэх замаар, монголын хүүхэд залууст уламжлалт монгол болон глобаль соёлыг зохистой хэмжээнд зөв хослуулан эзэмшүүлэх сургалт, хүмүүжлийн бодлогыг цаг үеийн онцлогтойгоор шинэчлэн боловсруулах шаардлагатай нь харагдаж байна.

Сургуулиуд хүүхдийн хүмүүжилд олигтой анхаарч чадахгүй байгаа, хүүхдийн хүмүүжлийн үндсэн орчин болсон гэр бүлийн хүмүүжил хангалтгүй байгаа нөхцөлд эцэг эхийн сурган хүмүүжүүлэх боловсролыг дээшлүүлэх кампанит ажил зохион байгуулбал зохих үр дүнд хүрнэ.

Мэргэжлийн болон дээд боловсрол эзэмшигчдэд иргэний төлөвшил, мэргэжлийн ёсзүйг шаардлагын хэмжээнд эзэмшүүлэхэд чиглүүлэн, сургалт, үйлдвэрлэл, судалгааны зохистой зөв хосолсон үйл ажиллагааг сургалтын байгууллагуудад төлөвшүүлэх нь асуудлыг шийдвэрлэх нэг гарц мөн.

Боловсролын мэргэшсэн удирдлага бэлтгэх стандарт боловсруулах, түүнд тулгуурлан ажиллах хүчнийг бэлтгэх, тогтвор суурьшилтай ажиллуулах нь боловсролын хөгжлийн энэ үеийн олон зангиалаа асуудлыг шийдэхэд туслана.

Монгол Улсын боловсролын хүрсэн түвшин, тулгамдаж буй асуудлыг бодитой үнэлж оношлох нь цаашдын хөгжлийн үзэл баримтлалаа зөв тодорхойлох үндэслэл мөн. Үүний нэг чухал чиглэл нь монгол хүүхэд, насанд хүрэгчид, өндөр настныхаа сурах чадварын онцлогийг судлан тогтоож, монгол хүний хөгжлийн стандарт боловсруулах явдал бөгөөд ингэснээр боловсролын агуулга, аргазүй, үнэлгээ, удирдлагыг шинжлэх ухааны үндэстэй сайжруулах боломж бүрдэнэ.

Шинжлэх ухаан, технологийн хурдтай хөгжлийн нөлөөгөөр хүний эзэмшсэн боловсрол түргэн хуучирч байна. XXI зууны тоон технологи, хиймэл оюуны үеийн монгол хүний хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэгч боловсролын зорилгыг дараах гурван түвшинтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх нь энэ цаг үеийн дуудлагад барих хамгийн зохистой хариу болно гэж үзэж байна. Үүнд:

Нэгдүгээрт, нийт хүн амаа боловсруулж, шинжлэх ухаанчаар гэгээрүүлэх, хоёрдугаарт, улс орны нийгэм, эдийн засаг, соёл, улс төр, цэргийн салбарын техник технологи, үйлдвэрлэл, үйлчилгээг гардан хэрэгжүүлэх үндэсний мэргэжилтэн, сэхээтнийг тоон технологийн хөгжлийн хандлага бүхий чиглэлүүдээр, чанарын өндөр түвшинд бэлтгэж төлөвшүүлэх, гурвдугаарт, улс үндэстнээ нэгтгэн зангидаж, шинэ эриний хөгжлийн дуудлагыг сөрөн туулах үндэсний манлайлагч, удирдагч, лидерүүдийг төрүүлэн бойжуулж, хөгжүүлэх гэсэн 3 түвшинд ялгавартайгаар төлөвлөж хэрэгжүүлэх нь зүйтэй.

XXI зууны эхний хагасын монголын боловсролын энэ гурван түвшний зорилго нь суралцагчдад 1) сургуулийн өмнөх болон бага боловсролын агуулга дахь монгол хүн төлөвшлийн суурийг шинэ зууны дэлхийн иргэний боловсролын нийтлэг шаардлага хангахуйцаар олгох, 2) дунд боловсролоор хиймэл оюуны нөхцөлд амьдрах монгол хүнийг хөгжүүлэх сургалтын агуулгыг олон улсын түвшинд, түүний дотор зэргэлдээх хоёр том үндэстний болон бүс нутгийн орнуудын хүүхэд залуучуудын боловсролоос дутахгүй түвшинд эзэмшүүлэх, 3) дундын дараах шатны боловсролоор глобаль орчинд амьдрах монгол хүний техник технологийн боловсрол, мэргэшлийн чадваруудыг эзэмшүүлж, байнга хөгжүүлэх орчин нөхцөл бүрдүүлэх замаар хэрэгжинэ гэж үзэж байна.

Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал, хиймэл оюуны үе ийнхүү тулж ирлээ. Иймээс мэргэжилтнүүдийн мэргэжил, мэргэшлийг байнга тасралтгүй дээшлүүлэх, дахин мэргэшүүлэх, насанд хүрэгчид, өндөр настныг боловсролын үйлчилгээнд тэгш хамруулах Насан туршийн боловсролын тогтолцоог ойрын жилд бүрэн утгаар нь төлөвшүүлэн хөгжүүлэх шаардлагатай байна.

ТАВДУГААР БҮЛЭГ. АЖ ҮЙЛДВЭРИЙН ДӨРӨВ ДЭХ ХУВЬСГАЛЫН ҮЕИЙН МОНГОЛЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖЛИЙН НОМЛОЛ

Нэг. Үндэслэл

Монголчууд би Дэлхий дахинд шинжлэх ухаан, технологи урьд өмнө байгаагүй хурдтайгаар хөгжиж, хүн олон сая жилийн хөгжлийнхөө явцад олж авсан оюун ухааныхаа “хохирогч” ч болж магадгүй он цагийн босгон дээр ирээд байна. Шинжлэх ухаан, технологийн хөгжлөөр тэргүүлж яваа өндөр хөгжилтэй зарим оронд бүтээсэн робот техник хүний ухаанаас давсан үйлдэл хийж, нэлээд тохиолдолд хүн “гарцаагүй ялагдагчийн байранд” очиж магадгүй байдалд хүрээд байгаагаа түрүүчээс нь мэдэрч эхэлж байна.

Нөгөө талаар одоогийн бидний амьдарч буй болон ирээдүй цаг үе нь Дэлхийн уур амьсгалын өөрчлөлт доройтол, Глобаль хөгжлийн түрэлт, Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үе гэсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтөд эрс өөрчлөлт оруулах аугаа том хүчин зүйлүүдийн огтлолцолд орсоноороо онцлог юм.

Хэдэн зууны тэртээд Аж үйлдвэрийн анхдугаар хувьсгалын дараагаар машинт том үйлдвэрлэлд массаар нь ажиллах хүчин бэлтгэхэд зориулж бий болгосон сургалтын тогтолцоо түүхэн үүргээ гүйцэтгээд, үйлдвэрлэлийн дөрөвдүгээр хувьсгал эрчээ авч буй энэ цаг үе нь боловсрол, сургалтын дараагийн шинэ зохион байгуулалтыг шаардаж байна. Монголчууд бид ч боловсролынхоо хөгжлийн бодлогыг өөр түвшинд, өөр өнцгөөс харж төлөвлөх хэрэгтэй болов.

Хоёр. Өөрчлөгдөн буй Дэлхий, амьдралын орчны хөгжлийн шинэ хандлага

Орчин үеийн хомо сапиенсууд 70,000 орчим жилийн өмнөөс анхдагч соёл иргэншлийн эхлэлийг тавьж эхэлсэн ба энэ үеийг хүн төрөлхтний түүхэнд *Танин мэдэхүйн хувьсгалын үе* гэж нэрлэдэг. Барагцаалбал 12000 жилийн өмнө эхэлсэн *Хөдөө аж ахуйн хувьсгал* түүхийн үйл явцыг улам хурдасгав. Харин ердөө 500 жилийн өмнөөс эрчээ авч эхэлсэн *Шинжлэх ухааны хувьсгал* хүн төрөлхтний түүхийг төгсгөж, огт өөр, үзэгдэж дуулдаагүй үйл явцын эхлэл ч болж магадгүй байдлын өмнө хүн төрөлхтнийг авч ирээд байна¹¹⁰.

Сүүлийн 50 гаруй жилийн хугацаанд Дэлхийн шинжлэх ухаан, технологид хаа нэгтээ гарч байгаа шинэ ололт, нээлт болон тэдгээрийн амьдралд нэвтрэх нь урьдынх шиг хэн нэгний мэдэлд юмуу аль нэг улсын хүрээнд баригдахаа больж, түүний үр дүн, үр дагавар нь нэг бүс нутгаар зогсохгүй тив дамжин маш хурдтай тархах нь хэвийн үзэгдэл болов. Энэ глобаль үйл явц нийгмийн амьдралын бусад

¹¹⁰ Юваль Ной Харари (2016) Sapience. Хүн төрөлхтний товч түүх. УБ, 11-р тал.

салбарын нэгэн адил манай орны боловсролын салбарт ч эрч хүчтэй түрэн орж ирлээ.

Глобаль соёлын нөлөө хамгийн түрүүнд нэвтэрч байгаа салбар нь боловсрол, шинжлэх ухаан юм. Үүний үр дүнд шинэ нээлт бүтээл, ашигтай санал олон арав, зуун мянгаар бий болж, шинжлэх ухаан нь хүн төрөлхтний хөгжлийн хүчирхэг хөдөлгүүр болохын хажуугаар хүний байгалийн унаган шинжийг үгүй хийж эхэллээ. XXI зууны эхэнд хомо сапиенсууд биологийн хуулийг эвдэж, оронд нь “ухаалаг төлөвлөлтийн хуулийг” бий болгосноор 4 тэрбум жилийн настай байгалийн шалгарлын явц огт өөр “нийгмийн шинжтэй” хүндрэлтэй нүүр тулгарлаа¹¹¹.

Хөгжлийн энэ үеийг Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын үе, Хиймэл оюуны үе гэж нэрлэж байна. Эрдэмтэд Дэлхийн өнцөг булан бүрд судалгааны лабораториудад ухаалаг төлөвлөлтийн аргаар 1/ биологийн инженерчлэл (*ген шилжүүлэн суулгах, мэс засал, дааврын эмчилгээний аргаар организмын хэлбэр, шинж чанарыг өөрчлөх*), 2/киборгийн инженерчлэл (*органик бодисыг органик бус бодистой хослуулсан биет үүсгэх, хорхой шавьж, ялаа зэргийг мэдээлэгч, илрүүлэгч, түгээгч зориулалтаар ашиглах*), 3/ органик бус амьдралын инженерчлэл (*өөрийгөө хөгжүүлэгч роботууд*)-ээр амьд амьтдын биологийн шинжийг нь өөрчилж байна.

Өнөөдөр шинжлэх ухаан хүнийг канондоод хувилчих хэмжээнд хүрч хөгжлөө. Хүн төрөлхтөн шинжлэх ухаан, технологийн ололтыг ашиглан хүнийг өвчин тахлаас ангижруулах арга замыг эрэлхийлж байна. Цаашдаа үхлийг ч ялж, газар Дэлхийд одоо амьдарч буй хүмүүс мөнх амьдрах асуудлыг шийдэх гэж оролдож магадгүй байна. Энэ нь хомо сапиенсе хэмээх хүний төрлийг мөнхжүүлэх үү, эсвэл түүний хөгжлийн болоод оршихуйн төгсгөл болох уу? гэдэг нь ирээдүй судлаачдын санааг зовоосон асуудал хэдийнээ болоод байна.

Дээр дурдсанаар хиймэл оюун ухаан гэх нэрээр дэлгэрээд буй шинжлэх ухаан, технологийн дэвшлийн шинэ үе нь глобаль хөгжлийн үр дүн бөгөөд Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал нь мөн чанартаа тогтвортой хөгжлийн шаардлагыг хангах “оюуны хувьсгал” бөгөөд хувьсгалыг хөтлөгч, хөдөлгөгч хүч нь бүхэлдээ глобальчлалын үр дүнд бий болж, оюунлаг хүрээг хамарч дэлгэрсэн мэдээлэл-холбооны технологи, роботжуулалт, био-, нано- технологийн хөгжлөөр

¹¹¹ Юваль Ной Харари (2016) *Sapience. Хүн төрөлхтний товч түүх*. УБ, 406-р тал.

тодорхойлогдож байна¹¹². Хүн төрөлхтөн бий болсон цагаасаа эхлээд байгалийн орчинд олон зуун мянган жил амьдарсан явцдаа өөрсдийн гараар буй болгосон “хүнлэг соёлын орчинд” саяхныг хүртэл амьдарч байв.

Харин шинжлэх ухаан, технологийн хөгжлийн одоогийн байдлаас харвал тоон технологид суурилсан хиймэл оюуны үед хүн төрөлхтөн “дан технологийн” орчинд амьдрах болж магадгүй байдалтай байна. Энэ нь одоохондоо гудамжаар дүүрэн яваа хүн бүрийн царайг таньдаг дуран, эзэн нь “жаахан үнэртүүлээд” орж ирвэл асдаггүй машин, даралт нь ихэсвэл дуугарч дохио өгдөг бугуйн цаг зэргээр эхэлж байгаа “ухаалаг” хэрэгслүүд бөгөөд яваандаа эргэн тойрон робот техник, жолоочгүй унаа тээвэр, ухаалаг орон сууц, хүний оюун санааг “хэн нэгэн хүн” алсаас уншиж, түүнийг жолоодох технологиуд болохнээ.

Энэ нь төрж, өсөж, өтөлж, үхдэг хүний биологийн ертөнцөд харш, “хиймэл, төмөр” орчин бий болно гэсэн үг. Энэ үйл явцын өрнөлийг одооноос бодлоготой, зорилготойгоор жолоодох гэж оролдож буй ч хүний хүмүүнлэг биологийн орчныг техникжүүлэх, роботжуулах энэ үйл явц урсгалаараа, магадгүй хэн нэгний бодлогоор аль хэдийн зохицуулагдахаасаа өнгөрөөд явчих шиг боллоо гэж хүн төрөлхтний зарим хэсэг ихэд санаа зовж байна.

Дэлхий “хавтгай” болж, бөмбөрцгийн нөгөө талаас хэн нэгэн хүн бидэнтэй холбоотой хэрэгтэй мэдээллээ секундын хурдтайгаар татаж аваад, “та бидний ажлын байрыг” тэр хэн нь ч мэдэгдэхгүй, нүүр нь ч харагдахгүй хүн “булаан авч” хийж эхлэх цаг хаяанд тулаад ирчихжээ. Бид хүссэн ч, хүсээгүй ч цагийн эрхээр ийм Дэлхийд бусад хүчирхэг, хөгжил өндөртэй, техникжиж, технологжсон улс, үндэстнүүдтэй зэрэгцэн амьдрах цаг ирж байна. Байдал иймдээ тулж байгаа бол, бид юу хийж, одооноос, магадгүй нэлээд хожимдсан ч гэлээ, энэ цаг үеийг яаж угтаж, өөрсдийгөө хэрхэн бэлтгэх билээ гэдэг асуулт тулгарч байна.

Гурав. Шинэ цаг үеийн монгол хүний хөгжилд тавигдаж буй шаардлагууд
Өнөө та бидний амьдарч буй цаг үеийн өнгө аясыг 1/ бидний амьдралын том орчин болох Байгаль, дэлхийд гарч буй уур амьсгалын өөрчлөлт, доройтол, 2/ глобаль соёлын түрэлт, 3/аж үйлдвэрийн 4 дэх хувьсгалын эхлэл гэх гурван том хүчин зүйлийн огтлолцол дээрх үйл явцууд тодорхойлж байна. Улс орнууд дор бүрнээ түүнд бэлтгэж, Үндэсний хороо, Зохицуулах зөвлөлүүд байгуулж, өөрсдийн онцлогт тохирсон бодлого, хөтөлбөр гарган ажиллаж байна.

¹¹² МУ-ын ШУА, (2018)Аж үйлдвэрийн 4 дэх хувьсгал ба МУ-ын хөгжлийн зангилаа асуудлууд. УБ, 8-р тал.

Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал Монгол Улсын хувьд нэг талаас эрчимтэй хөгжих бололцоог нээж байгаа боловч нөгөө талаас, засаглал, хөгжлийн бодлого, чиглэлээ шинэчлэн тодорхойлох бодит шаардлагыг бий болголоо. Энэ хувьсгал маш богино хугацаанд, 2020-2030 онд эрчимтэй өрнөж, улс орон бэлэн эсэхээс үл хамааран хүний амьдралын бүх салаа мөчрийг хамарсан нийгэм, шинжлэх ухаан, технологийн үсрэнгүй дэвшлийг бий болгоно гэж үзэж байна¹¹³. Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын энэ үе нь Дэлхий нийтээр батлан мөрдөж байгаа Тогтвортой хөгжлийн 2030 он хүртэлх зорилтуудыг хэрэгжүүлж эхэлсэн үетэй цаг хугацааны хувьд давхцаж байна. Монгол Улсын хувьд эхний шатанд глобаль хөгжлийн нөлөө, аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үйл явц, тогтвортой хөгжлийн зорилго, зорилтуудыг ухаарч, үндэснийхээ онцлогт нийцүүлэн хэрэгжүүлэх, тэдгээрийн явц, хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг тодорхойлох арга зүй, аргачиллыг шинжлэх ухааны үндэслэлтэй боловсруулах нь эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтдийн түүхэн шинэ үүрэг болоод байна¹¹⁴.

Монгол Улсын цаашдын тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч нь монгол хүн, түүнийг сурган төлөвшүүлж, хөгжүүлэх боловсрол юм. Иймээс угтан ирж буй хөгжлийн шинэ сорилтууд, амьдралын орчны доройтлын эсрэг, монгол үндэстний оршин тогтнохуйн цаашдын хувь заяаг шийдэх ухаалаг, чадвартай монгол хүнийг бэлтгэх нь цаг үеийн дуудлага гэж үзэж, шинэ цаг үеийн өөрчлөлтөд дасан зохицож, тогтвортой хөгжих монгол хүнийг боловсруулах философи, хэрэгжүүлэх номлолыг ийнхүү томъёолж байна.

Дэлхий даяар, хөгжиж байгаа болон хөгжингүй орнуудад Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалыг угтан бэлтгэж, шинжлэх ухаан, боловсролдоо их өөрчлөлт, шинэчлэлтүүдийг хийж байна. Үүнд үндэстнээ бэлтгэх, хувьсгалын үед ажиллах хүний нөөцийн бодлогоо гаргаж хэрэгжүүлж эхлэх бүхий л шатны ажлыг улсын хэмжээнд нэгдсэн зохион байгуулалттайгаар хийж эхлэхгүй бол оройтож мэднэ¹¹⁵.

Дэлхий хавтгай болж, глобаль нээлттэй мэдээлэл, харилцаа холбооны болон чөлөөтэй зорчих, амьдрах орон зай үүссэнтэй холбоотойгоор, шинэ зуун гарсаар олон улсын хөдөлмөрийн зах зээл дээрх ажлын байрны төлөөх өрсөлдөөн ширүүсч байна. Глобаль, нээлттэй хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөн амьдрах

¹¹³ МУ-ын ШУА. (2018) Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал ба Монгол Улсын хөгжлийн зангилаа асуудлууд. УБ, 27-р тал

¹¹⁴ МУ-ын ШУА-ийн 2019 оны 12-р сарын Их чуулганы илтгэл

¹¹⁵ МУ-ын ШУА. (2018) Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал ба Монгол Улсын хөгжлийн зангилаа асуудлууд. УБ, 25-р тал

XXI зууны иргэний боловсрол, хөдөлмөрийн ур чадварт тавигдах шаардлага Дэлхийн хэмжээнд, тэр дундаа Азийн бүс нутагт сүүлийн жилүүдэд улам нэмэгдэж байна¹¹⁶. Ийм нөхцөлд шинэ цаг үеийн шаардлагаар бий болсон өрсөлдөх чадвар өндөртэй боловсрол бүхий орны иргэд өндөр цалинтай, нэр хүндтэй ажлын байрыг сорчлон сонгож авч чадаж байна. Харин агуулга нь хуучирсан, “шинэ цаг үеийн мэдрэмжгүй” боловсролтой орны иргэд олон улсын хөдөлмөрийн зах зээл дээр, голдуу “хар ажил” эрхэлж байгаа нь өнөөгийн бодит үнэн юм¹¹⁷. Энэ ангилалд манай монгол иргэд ч хамаарна.

Олон мянган жил зэрэгцэн амьдарч байгаа зэргэлдээх хүчирхэг орос, хятад болон бусад үндэстнүүдийн сүүлийн жилүүдийн шинжлэх ухаан, технологийн дэвшил, нийгэм, эдийн засгийн хөгжлийн их хурд, түвшин болон тэдний цэрэг, улс төр, соёлын нөлөөний тэлэлт нь цөөн тоот монголчууд бидэнд цаашид үндэстний хувьд тэдэнтэй мөр зэрэгцэн одоогийн байдлаараа оршин тогтноход нэн хүндрэлтэй сорилт болон тавигдаж байгаа¹¹⁸ нь цаг улирах тутам улам тод мэдрэгдэх боллоо.

Нөгөө талаар хурдтай хувьсан өөрчлөгдөж байгаа Дэлхийн байгаль, уур амьсгалын доройтол, түүний зарим сөрөг нөлөө, үүнээс үүдэлтэй хүн амын эрчимтэй хотжиж байгаа үйл явц нь Дэлхий нийтийн шинжтэй үзэгдэл болж байгаа ч манай оронд түүний нөлөө бүр хүчтэй тусч, нүүдлийн мал ахуйд тулгуурласан манай уламжлалт соёл, амьдралын хэв маягт эргэлт буцалтгүй өөрчлөлт оруулж байгааг бид харж байна.

Байгаль, нийгэмд болж буй хурдтай өөрчлөлтүүдтэй холбоотойгоор гадаад орнуудын боловсролын нэр томъёонд “XXI зууны чадварууд” гэх ойлголт шинээр буй болсоныг боловсролын зорилготой уялдуулан дараах байдлаар хураангуйлж болно.¹¹⁹ Эдгээр чадваруудыг:

1. байгаль, нийгэмд гарч байгаа өөрчлөлтийг соргог мэдрэх,
2. өөрчлөлтөөс үүдэн гарч болох сөрөг үр дагаваруудыг сааруулахад чиглэсэн оновчтой шийдвэрийг хурдтай гаргах,
3. гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх

¹¹⁶ Strengthening research on Higher and lifelong education in preparation for the 4th Industrial Revolution Era. KEDI Annual Report 2018. pp.7

¹¹⁷ Бэгз,Н.(2001) Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд. УБ, 269-р тал

¹¹⁸ Бэгз,Н.(2001) Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд. УБ, 268-р тал

¹¹⁹ Harary Yuval Noah,(2018). 21 Lessons for the 21st Century, pp.97

гэсэн 3 бүлэгт багцалж болохоос гадна хүнлэг сэтгэл, орчиндоо ээлтэй хандах хандлага зэргийг ч энд оруулж байгаа нь харагдаж байх юм. Эдгээр нь манай иргэдэд тун чухлаар хамаарч, монголын сургалтын бодлого, агуулга, аргазүйд тусгалаа түргэн олох ёстой гэж үзэж байна.

Одоогоор хүн ам цөөтэй, үйлдвэрлэн бүтээх потенциал муутай байгаа манай үндэстний хувьд иргэдийнхээ амьдралын түвшинг дээшлүүлэх, үндэсний эдийн засгийн өсөлтийг хангах, цаашлаад Дэлхийн олон улсын дундаж жишигт ойртож хөгжих гол арга зам нь нийт хүн амдаа шинэ зуунд шаардагдаж байгаа боловсролыг өндөр түвшинд эзэмшүүлэх, улмаар иргэдийнхээ мэргэжлийн ур чадварыг хэлбэрэлтгүй байнга дээшлүүлж байх явдал юм.¹²⁰

Шинэ зууны монголын боловсролын бодлого нь юуны түрүүнд өөрийн өнгө аястай, боловсролынхоо хөгжлийн философийг томъёолохоос эхлэх учиртай. Системийн хөгжлийн ерөнхий зураглал болох философигүй явж ирсэн нь манай боловсролын нэг эмзэг тал юм¹²¹. Монгол хүн судлал, монгол хүний хөгжилд үзүүлэх орчны нөлөөлөл, монголчуудын менталитетийн судалгаанд суурилж монголын боловсролын философийг томъёолох, монголын хүүхэд, залуучуудын хөгжил болон сурах чадварыг судлан тогтоох, ингэснээрээ монголын хүүхэд, насанд хүрэгчид, өндөр настнуудыг сургах агуулга, технологио шинэчлэн боловсруулах явдал чухал юм.

Одоогийн байдлаар монголчуудын гадаад хэлний мэдлэг шинжлэх ухааны мэдээлэл, ололттой танилцаж, улмаар эзэмшиж ашиглах хэмжээнд хүрээгүй, аж үйлдвэрийн суурь болох хүнд үйлдвэр хөгжөөгүйгээс үндэстнээрээ орчин үеийн үйлдвэрлэлийн техник, технологийн хөгжил дорой байгаа нь шинэ технологийн орчинд ажиллаж амьдрахад технологийн бааз талаасаа ч, хүний нөөц талаасаа ч бэлэн биш байгааг харуулж байна.

Иймээс тулж ирээд байгаа технологийн шинэ хувьсгалын дуудлагад хариу барих, эдгээр асуудлыг хамарсан боловсролын шинэ зорилгыг томъёлох нь чухал болов. Шинэ технологийн хувьсгалын үед хүүхэд, залуучуудын 65.0 орчим хувь нь цоо шинээр буй болж байгаа ажлын байр, мэргэшлээр ажиллах ба тэдгээр ажлын байрны 80.0 гаруй хувьд нь ажиллагчаас шинжлэх ухаан, инженерчлэл, тоон технологи, математикийн өндөр мэдлэг, чадвар шаардсан байх төлөв харагдаж байна.

¹²⁰ “Боловсрол” Үндэсний хөтөлбөр. Хөтөлбөр батлах тухай МУ-ын ЗГ-ын 2010 оны 31-р тогтоол.

¹²¹ Бэгз, Н. нар. (2012) Боловсролын философи. УБ, 6-р тал.

Дөрөв. Монголын боловсролын шинэ бодлого

Энэ бүхнээс үндэслээд, XXI зууны тоон технологи, хиймэл оюуны үеийн монгол хүний хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэгч боловсролын зорилгыг дараах 3 түвшинтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Үүнд:

XXI зууны тоон технологи, хиймэл оюуны үеийн монгол хүний хөгжлийн бодлого, түүнийг хэрэгжүүлэгч боловсролын зорилгыг нэгдүгээрт, нийт хүн амаа боловсруулж, шинжлэх ухаанчаар гэгээрүүлэх, хоёрдугаарт, улс орны нийгэм, эдийн засаг, соёл, улс төр, цэргийн салбарын техник технологи, үйлдвэрлэл, үйлчилгээг гардан хэрэгжүүлэх үндэсний мэргэжилтэн, сэхээтнийг тоон технологийн хөгжлийн хандлага бүхий чиглэлүүдээр, чанарын өндөр дээд шатанд бэлтгэж төлөвшүүлэх, гуравдугаарт, улс үндэстнээ нэгтгэн зангидаж, шинэ эриний хөгжлийн дуудлагыг сөрөн туулах үндэсний манлайлагч, удирдагч, лидерүүдийг төрүүлэн бойжуулж хөгжүүлэх гэсэн 3 түвшинтэйгээр төлөвлөн хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзэж байна.

XXI зууны эхний хагасын монголын боловсролын энэ гурван түвшний зорилго нь суралцагчдад 1) сургуулийн өмнөх болон бага боловсролын агуулга дахь *монгол хүн төлөвшлийн суурийг* шинэ зууны дэлхийн иргэний боловсролын нийтлэг шаардлага хангахуйцаар олгох, 2) дунд боловсролоор хиймэл оюуны нөхцөлд амьдрах *монгол хүнийг хөгжүүлэх сургалтын агуулгыг* олон улсын түвшинд, түүний дотор зэргэлдээх хоёр том үндэстний болон бүс нутгийн орнуудын хүүхэд залуучуудын боловсролоос дутахгүй түвшинд эзэмшүүлэх, 3) дундын дараах шатны боловсролоор *глобаль орчинд амьдрах монгол хүний техник технологийн боловсрол, мэргэшлийн чадваруудыг* эзэмшүүлж, байнга хөгжүүлэх орчин нөхцөл бүрдүүлэх замаар хэрэгжинэ гэж үзэж байна. Үүнийг дэлгэрүүлж авч үзвэл,

Нэг. Иргэний төлөвшлийн суурь тавих

1. Орчин цагийн боловсролын суурь чадвар эзэмшүүлэх
2. Уламжлалт соёл(хэл, соёл, түүх...) эзэмшүүлэх
3. Нийгмийн харилцааны хэм хэмжээ, ёсзүй, ёс суртахуунтай болгон хүмүүжүүлэх
4. Глобаль соёлын ололтуудтай танилцуулах

Хоёр. Хүний бүх талын хөгжлийг дэмжих

1. Бие бялдарын хөгжлийг дэмжих
2. Оюун ухаан, танин мэдэхүйг хөгжүүлж, тоон технологийг эзэмших суурийг тавих
3. Эх болон гадаадын хоёроос доошгүй хэлийг төгс эзэмших*

4. Нийгмийн гишүүн болгон төлөвшүүлэх

Гурав. Мэргэжил эзэмшүүлэх, мэргэшүүлэх

1. АҮ-ийн 4 дэх хувьсгалын нөхцөлд шаардагдах мэргэжлийн анхан, дунд, дээд шатны боловсрол эзэмшүүлэх
2. Хиймэл оюуны нөхцөлд ажиллаж, амьдрахад шаардагдах тоон технологид суурилсан мэргэшил олж авах
3. Технологийн шинэчлэлтийг байнга дагаж мэргэших боломжоор хангах.

*Хүний оюун ухааны хөгжлийн бүрэлдүүн хэсэг, түүний зохистой хөгжлийн үр дүн, илэрхийлэл болох хэлний хөгжлийн асуудлыг энд тусгайлан авч үзлээ. Учир нь XXI зуунд монголчуудын хувьд эх ба бусад олон хэлний боловсрол нь цөөн тоот манай үндэстний аюулгүй оршин тогтнох, өрсөлдөх чадвараа нэмэгдүүлэх нэг гол нөхцөл болж тавигдаж буйтай холбоотойгоор ийнхүү онцлон авч үзэх үндэстэй.

Өнгөрсөн 30-аад жилийн монголын боловсролын хөгжлийн замналыг эргээд харахад бид бүх шатны сургуулийн академик боловсролд их анхаарч, харин хүн хүмүүжүүлж төлөвшүүлэх боловсролын том зорилгыг хаягдуулж ирсэн байна. Энэ болон бусад олон хүчин зүйлтэй холбоотойгоор өнөөгийн манай нийгмийн ёс суртахууны байдал их хүнд байдалд оржээ. Монгол хувь хүний, бүлгийн, үндэстний үнэт зүйлс нь өнгөрсөн цаг үетэй холбогдсон, ахмад, дунд, идэр насныхны эрхэмлэл, тэмүүлэл нь ирээдүй цагийн мэдрэмж муутай байна.

Монгол үндэстний оршин тогтнох, хөгжин дэвших гол эх сурвалж нь ийнхүү монгол хүний тасралтгүй хөгжиж байх бие, сэтгэл, оюуны чадавхи, түүнийг байнга тэтгэх боловсрол учир шинэ зуунд Монгол Улсад бүх нийтээрээ, насан туршдаа, тасралтгүй боловсрох тогтолцоог буй болгож, дэлхийн олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нийтлэг үндсэн зарчмуудад тулгуурлан хөгжүүлэх асуудал чухал болов. Одоогоор манай орны боловсролын тогтолцоо нь үндсэндээ албан боловсролын хүрээгээр хязгаарлагдаж байна.

Монголчууд бидний хувьд Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөхцөлд, Глобаль соёлын орчны түрэлт дунд, Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгалын үед түүний шууд үр дүн- хиймэл оюунд суурилсан техник, технологийн дэвшлийг бүтээлчээр хэрэглэх, энэ чиглэлд бусадтай хамтран ажиллаж амьдрах, бусдын санаа бодолд хүндэтгэлтэй хандаж, харилцан ашигтай байдлаар хамтын шийдвэр гаргах, гаргасан шийдвэрийнхээ хариуцлагыг хүлээх, бэрхшээлийг тууштай сөрөн тэмцэх хөдөлмөрч, бүтээлч, хатуужилт чанарыг эзэмших чадварыг НТБ-оор олгох нөхцөлийг бүрдүүлэхэд илүүтэй анхаарах нь чухал байна.

СУДАЛГААНД АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

а/ тайлангууд

1. АХБ-ны “Санхүүгийн хямралын үед боловсролын үйлчилгээг нийгмийн эмзэг бүлгийнхэнд хүргэх нь”
2. АХБ-ны НОРДИК-ийн сангийн дэмжлэгээр “Нийгмийн хамгааллын салбарын хөгжлийн хөтөлбөр”, 2003-2007 он
3. АХБ-НЫ “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг дээшлүүлэх төсөл” (2015-2019 он)
4. Бага, дунд боловсролын хөтөлбөрийн үнэлгээ. Бодлогын шинжилгээ. 2012
5. Бага ангийн сурагчдын сэтгэл зүйн зарим онцлог (2013)
6. Бага боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн гарааны судалгааны тайлан (2014)
7. Бага боловсролын хөтөлбөрийн хэрэгжилтийн үр дүнгийн судалгааны тайлан (2014)
8. БНСУ-ЫН КОИСА ОУБ-ын санхүүжилтээр МСПК-ийн чадавхийг бэхжүүлэх төсөл (2010-2015 он)
9. БНЭУ-ЫН “Ражив Гандийн нэрэмжит ҮУПК-ийн сургалтын орчинг сайжруулан шинэчлэх” төсөл (1995-2015 он)
10. Боловсролын салбарын хөгжил – Боловсролын чанарт нөлөөлж буй сургуулийн хүчин зүйлс, Дунд хугацааны тайлан. 2016
11. Боловсролын хүрээлэнгийн Сурах бичиг, сургалтын орчны судалгааны секторын тайлангууд (2012-2017 он)
12. Боловсролын хүрээлэн. (2009). Дунд боловсролын 12 жилийн сургуулийн сургалтын агуулгын судалгаа. УБ: Соёмбо принтинг
13. ГОУХАН-ийн “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан МБС” төсөл (2013-2016 он) I үе шат
14. ГОУХАН-ийн “Ашигт малтмалын салбар дахь түншлэлд суурилсан МБС” төсөл (2016-2019 он) II үе шат
15. Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн нэгдүгээр ангийн сурах бичигт үнэлгээ хийсэн судалгааны тайлан. 2009
16. Европын холбооны санхүүжилттэй “Монгол улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл-1” (2014-2019 он)
17. Европын холбооны санхүүжилттэй “Монгол улсын техник, мэргэжлийн боловсрол, сургалтын салбарыг дэмжих төсөл-2” (2015-2018 он)

18. Зургаагаас арван насны монгол хүүхдийн хөгжлийн судалгаа (Бага боловсролын насны хүүхдийн ачаалал ба хөгжлийн онцлог) –судалгааны тайлан (2016)
19. МБСБ-ын Чанарын баталгаа ба чанарын үнэлгээний тогтолцоог бий болгож бэхжүүлэх төсөл. Хоёр дахь шатны төсөл (2014-2015 он)
20. Монголын Мянганы Сорилтын сангийн төсөл (2008-2013)
21. Монголын хүүхэд, залуучуудын хөгжлийн шалгуур үзүүлэлтийг боловсруулах технологийг сургалтын практикт нэвтрүүлэх төслийн судалгааны тайлан (2014-2017)
22. МУБИС-ийн ажлын тайлангууд
23. НҮБ-ын Хүн амын сангийн “Залуучуудын хөгжлийн хөтөлбөр”-ийн “Амьдрах ухааны боловсрол” төсөл (2013.03-2017.04)
24. Оюутолгой ХХК-ны санхүүжилтээр “Үндэсний мэргэжилтэй ажилтан бэлтгэх хөтөлбөр” (2010-2013) I үе шат
25. Оюутолгой ХХК-ны санхүүжилтээр “Багш нарыг мэргэшүүлэх сургалт”. (2013-2015) II үе шат
26. Сингапур улсын ТЕМАСЕК сан, Сингапур ПК-Интернейшалийн хамтарсан төсөл. Нэг дэх шатны төсөл (2010-2012 он) “Монгол Улсын
27. Сургуульд хамрагдаагүй сургуулийн насны хүүхдийн танин мэдэхүй, бие бялдар, нийгэмшлийн хөгжлийн судалгааны тайлан (2015)
28. Хөвсгөл аймгийн 6-17 насны хүүхэд залуучуудын бие бялдар, нийгэмшил, танин мэдэхүйн хөгжлийн онцлог судалгааны тайлан (2016)
29. Швейцарийн хөгжлийн агентлаг “Монгол улсын баруун бүсийн МБС” төсөл (2012-2014 он)
30. 6-21 насны хүүхдийн хөгжлийн туршилт судалгааны тайлан (2014)

б/ Бодлогын бусад баримт бичиг, хөтөлбөрүүд

1. Албан бус боловсролыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 1997
2. Англи хэлний сургалтын чанарыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөр 2001
3. Бага, дунд боловсролын тухай хууль. 1995 (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт)
4. Бага, дунд боловсролын багш бэлтгэх, мэргэжил дээшлүүлэх үндэсний хөтөлбөр 2001
5. Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 2014
6. Бага, дунд боловсролын киррикулим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал. 2002

7. Бага, дунд боловсролын стандарт MNS 5420-14:2004.
8. Багш нарын мэргэжил дээшлүүлэх институт байгуулах тухай МУ-ын Засгийн газрын 2012-5-23-ны тогтоол
9. Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам /БСШУЯ-ны 2017.01.27-ны едрийн 2/789 тоот албан бичгээр хасалт хийсэн/
10. Боловсролын тухай хууль. 1991, 1995 (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт)
11. БНМАУ-д боловсролыг хөгжүүлэх үзэл баримтлал. (1991)
12. “Боловсрол” Үндэсний хөтөлбөр. (2009)
13. Боловсролын хөгжлийн 1,2,3 дугаар хөтөлбөр 2007
14. Боловсролын хүрээлэн. (2006). ЕБ-ын 11 жилийн сургуульд 2006-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ. УБ
15. Бичиг үсгийн үндэсний хөтөлбөр 2004
16. Бүх нийтэд суурь боловсрол эзэмшүүлэх үндэсний хөтөлбөр 1995
17. БСШУ-ны сайдын 236 дугаар тушаал. (2006). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого.
18. БСШУ-ны Сайдын 20 дугаар тушаал. (2007). СӨБ-ын сургалтын талаар баримтлах бодлого.
19. БСШУ-ны сайдын 202 дугаар тушаал. (2002). Бага, дунд боловсролын киррикулим, стандартыг шинэчлэн хөгжүүлэх үзэл баримтлал.
20. БСШУ-ны сайдын 236 дугаар тушаал. (2006). Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын талаар баримтлах бодлого.
21. Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 2016
22. Дээд боловсролын тухай хууль. 1995 (1998, 2000, 2002, 2006 онд оруулсан нэмэлт, өөрчлөлт).
23. Ерөнхий боловсролын сургуулийн үдийн цай хөтөлбөр 2006
24. Зайны сургалтын үндэсний хөтөлбөр 2002
25. Монгол Улсын Үндсэн Хууль. 1992.
26. Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрүүд (2008-2012, 2012-2016, 2016-2020)
27. Монгол Улсын Засгийн газраас боловсролын салбарт 1997-2005 онд хийх өөрчлөлтийн үндсэн чиглэл 1997
28. Монголын боловсролыг 2006-2015 онд хөгжүүлэх Састер төлөвлөгөө 2006
29. Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль. 2002 .

30. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль.2006.
31. Сургуулийн өмнөх боловсрол-1 Үндэсний хөтөлбөр 1995
32. Сургуулийн өмнөх боловсрол-2 Үндэсний хөтөлбөр 2001
33. Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 2015
34. Сурах бичиг, сургалтын хэрэглэгдэхүүний шинэчлэлийн бодлого. 2018
(Боловсролын хүрээлэнгийн сурах бичгийн сектор, Багш нарын улсын зөвлөгөөнд зориулж бэлтгэсэн)
35. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын
36. Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтыг хөгжүүлэх үндэсний хөтөлбөр 1998
37. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030, УБ,2016
38. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого. (1995)
39. Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, 2015
40. Шинжлэх ухаан, технологийн тухай хууль. 2002.

в/ Ном, товхимол

2. Алтангэрэл, О. (2016, 11 дүгээр сарын 03). Дээд боловсролын хөгжлийн асуудлаар хийсэн зарим судалгааны үр дүн. Өдрийн сонин, 15
3. Алтанзаяа,Л, Амартүвшин, С, нар”Боловсролын түүчээ” 2016
4. Алтанцэцэг, Д., Лувсандорж, Ц., Пүрэвсүх, Г. (2008). Ерөнхий боловсролын сургуулийг 12 жилийн тогтолцоонд шилжүүлэх бодлого, төлөвлөлт, арга зам. УБ: ЭКИМТО.
5. Амаржаргал,Н.,(2013) Англи хэлний сурах бичгийн шинжилгээ, үнэлгээний аргазүйн хувилбар боловсруулах судалгаа УБ., 7-9 дэх тал
6. Антропология. /М.А.Негашева и др. 2012, Учебник, - М.:Научный мир, - С.250.
7. Батчулуун Д. 1981. Физическое развитие детей от 1-го месяца до 17 лет и некоторые гигиенические вопросы акселерации развития школьников г. Улан-Батора: Дис. .канд. мед. наук. – Улан-Батор,– 22 с.
8. Бурлачук,Л.Ф.(2006). Психодиагностика
9. Боловсролын тухай хууль (Нэмэлт өөрчлөлт оруулсан) УБ.,2017 он
- 10.Бага дунд боловсролын тухай хууль (Нэмэлт өөрчлөлт оруулсан) УБ.,2017
- 11.Багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх журам
- 12.Багш боловсролын ирээдүй "Багш 2005" төсөл УБ., 2005 он
- 13.Баярмаа, Б., Цэцэгжаргал, Х. (2012). ЕБС-ийн сургалтын орчны талаарх эрх зүйн баримт бичгийн судалгаа, Боловсрол судлал сэтгүүл:/02

14. Баярмаа, Б., Цэцэгжаргал, Х. (2012). ЕБС-ийн сургалтын орчны өнөөгийн байдлын судалгаа; сургуулийн гадаад орчин. Боловсрол судлал сэтгүүл /03
15. Баярмаа, Б., Цэцэгжаргал, Х. (2012). ЕБС-ийн сургалтын орчны өнөөгийн байдлын судалгаа: сургуулийн дотоод орчин. Боловсрол судлал сэтгүүл/04
16. Баярмаа Г., Эрдэнэчимэг, Д. (2008). Сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох асуудал. 2007 оны шилдэг илтгэлүүд. УБ
17. Бэгз Н. (2001) Глобальчлалын үеийн Монгол Улсын боловсролын хөгжлийн онол, аргазүйн үндсэн асуудлууд. УБ.
18. Бэгз, Н. нар. (2012) Боловсролын философи. УБ
19. Бэгз, Н (2017). Монголын боловсрол судлалын шинэ парадигм, УБ.
20. Бэгз, Н., Пүрэв, О., Энхцогт, Н., Баттогтох, Д., Баярцэцэг, Б., Мягмар, П., Лхагвасүрэн, Ц., & Тунгалаг, П. (2012). *Боловсролын философи*. УБ: Соёмбо принтинг
21. БШУЯ. (2014). Боловсрол, шинжлэх ухааны салбарын бодлого, шинэчлэл 1999-2014 онд. УБ: Соёмбо принтинг.
22. Бэгз, Н., Пүрэв, О., Энхцогт, Н., Баттогтох, Д., Баярцэцэг, Б., Мягмар, П., Лхагвасүрэн, Ц., & Тунгалаг, П. (2012). Боловсролын философи. УБ: Соёмбо принтинг
23. Боловсролын хүрээлэн. (2006). ЕБ-ын 11 жилийн сургуульд 2006-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөөг хэрэгжүүлэх зөвлөмж, хичээлүүдийн агуулгын үлгэрчилсэн хүрээ. УБ: Од свит, 6
24. БСШУЯ. (2014). Бага боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 17
25. БСШУЯ. (2015). Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 19
26. БСШУЯ. (2016). Бүрэн дунд боловсролын сургалтын цөм хөтөлбөр. УБ. 13
27. БСШУЯ. (2001). Чанартай боловсрол хөгжлийн баталгаа (илтгэлүүдийн эмхтгэл). УБ. 135
28. БСШУЯ. (2010). Хөтөлбөр батлах тухай /Засгийн газрын 2010 оны 2 дугаар сарын 3 ны өдрийн 31-р тогтоол/. Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын эрх зүйн мэдээлэл, 02. УБ.
29. Ганбаатар Р. Научное обоснование нормативных требований физической подготовки призывной молодежи Монголии в возрасте 18–25 лет: Автореф. ... канд. мед. наук. – Улан-Батор, 1997. – 26 с.
30. Гэлэгжамц, Ц. (2000). Монгол Улсын ерөнхий дунд боловсролын эрх зүйн зохицуулалт /үүсэл, хөгжил, шинэчлэл, 1921-1998/, Улаанбаатар:

31. Дэлгэрсайхан, Ц.,(2013) Нийгмийн ухааны сурах бичгийн агуулга, аргазүйн уламжлал, шинэчлэлийн залгамж холбоо УБ., 14-15 дахь тал
32. Жамбалдорж,Т.,Амартүвшин,С., Банзрагч,Ц, Энхээ,Б. (2011). Зуун өртөөлсөн нэгэн жаран
33. Золзаяа,Б. (2009) Франц хэлний анхан шатны сургалтын сурах бичиг зохиож туршсан үр дүн УБ., 25-28 дахь тал
34. Лувсандорж,Ц. (2004) Кирриклүм хөгжил ба боловсролын стандарт. УБ,
35. Монгол улсад шинэ цагийн боловсрол үүсч хөгжсөний 90 жил. УБ, 2011
36. Монголоороо овоглосон эрдмийн өргөө,2011
37. Монгол Улсын хөгжлийн сүүлийн 25 жилийн ололт, сургамж, МУ-ын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал"-2030 УБ, 2016
38. Монгол Улсын Засгийн газар, Шинэчлэл-шийдэл (2012-2016)
39. МУБИС-ийн хөгжлийн хөтөлбөр, УБ, 2016
40. МУБИС,"Чанартай боловсрол-хөгжлийн баталгаа" ОПБХ ,УБ., 2000 он
41. МУБСШУЯ, БСХХ, (2001). Сургалтын менежмент. УБ. 99
42. МУГЯ. (1999). Сургалтын арга зүй. УБ. 55
43. МУ-ын ШУА, (2018) Аж үйлдвэрийн дөрөв дэх хувьсгал ба МУ-ын хөгжлийн зангилаа асуудлууд. УБ.
44. Немов, Р.С. (1995). Психология Книга-2. Москва
45. Оюун,Ц,Багшийн хөгжлийн зарим асуудал УБ., 2004 он
46. Оюун,Ц,Түмэндэмбэрэл,Д. Багшийн хөгжлийн онол, аргазүйн асуудал, УБ,2005
47. Оюун,Ц, Дээд боловсролын инновацид эрдэмтэд, багш нарын оруулах хувь нэмэр,Эрдэм шинжилгээний бичиг, Лавай №17, 2016,160-165
48. Оюун,Ц, Боловсролын шинэчлэлийн бодлого-сургууль-багш, Багш- эрдэнэ
49. Пүрэв,О.,(2003) XXI зууны Монголын түүх, нийгмийн ухааны боловсролын онол ба методологи (шинжлэх ухааны докторын диссертаци) УБ., 172 дахь тал
50. Пүрэв,О.,(2006) Боловсролын хүрээлэнгийн түүх УБ., "Соёмбо" ХХК
51. Пүрэв, О. (2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. УБ: Бит пресс. 177Роберт Солсо (2006). Когнитивная психология
52. Пүрэв, О. (2013). Монголын боловсрол, сургалтыг хүмүүншүүлэх онол, арга зүйн зарим асуудал. УБ: Бит пресс. 177

53. Ред. Бариянжав, П. (1984). Ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн үзүүлэн таниулах, сургалтын тоног төхөөрөмжийн үлгэрчилсэн жагсаалт, Улаанбаатар: АБЯ-ны сурах бичиг сэтгүүлийн нэгдсэн редакцийн газар
54. Ред. Адъяа, Д. (1990). Ерөнхий боловсролын сургуулийн кабинет, Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар
55. Содномваанчиг, Г., нарын хамтын бүтээл. (2001). Монголын бага, дунд боловсролын агуулга, арга зүйн хөгжлийн товч тойм (1911-2000 он). УБ.
56. Содномваанчиг, Г. (2008) Монголын бага, дунд боловсролын сургалтын агуулгын хөгжлийн түүхэн тойм УБ., 77 дахь тал
57. Содномваанчиг, Г., нарын хамтын бүтээл. (2001). Монголын бага, дунд боловсролын агуулга, арга зүйн хөгжлийн товч тойм (1911-2000 он). УБ.
58. Содномваанчиг, Г. (2008). Монголын бага, дунд боловсролын сургалтын агуулгын хөгжлийн түүхэн тойм. УБ: Содпресс
59. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. (1998). Суурь боловсролын агуулга, Боловсролын стандартын тогтолцоо. УБ: СХҮТ-ийн хэвлэх цех,
60. Столяренко, Ё.А. (2000). Психология педагогика Ростов --на—Дону
61. Столяренко, Л.Д. (2005). Основы психологий практикум Ростов-на –Дону
62. Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсролын сургалтын байгууллагын
63. Суурь боловсролын агуулга, Боловсролын стандартын тогтолцоо. УБ: СХҮТ-ийн хэвлэх цех, (1998).
64. Стандартчилал, хэмжилзүйн үндэсний төв. (2004). Бага, дунд боловсролын стандарт MNS 5420-14:2004. УБ.
65. Томас Л.Фрийдман. (2007) Дэлхий бөөрөнхий биш. УБ.
66. Туяа, Л. (2005) Гадаад хэлний сурах бичгийг сургалтын удирдлагын үүднээс шинжлэх асуудал УБ., 44 дахь тал
67. Т.И. Шамова и др. Управление образовательными системами. М., 2002.
68. Үүлэн, Д, Багшийн хөгжил портал сайт, мэдээлэл, интернэт мэдээ, УБ
69. Хамтын бүтээл. (2001) Монголын бага, дунд боловсролын агуулга, аргазүйн хөгжлийн товч тойм Ред. Д. Шагдар, Н. Жадамба УБ.
70. Хэл шинжлэл, Соёмбо нэвтэрхий толь, Улаанбаатар: Соёмбо принтинг.
71. Цэнджав, Д. (1971) Монгол сургуулийн наймдугаар ангийн орос хэлний сурах бичиг, түүний онол, аргазүйн үндэслэл УБ., 120 дахь тал
72. Цэдэвсүрэн, Д., (2009) Электрон сурах бичиг бүтээх аргазүйн хувилбар боловсруулж хэрэгжүүлсэн туршилт, үр дүн УБ. 8-10 дахь тал
73. Цейтлин, С.Н. (2000). Язык и ребенок. Лингвистика детской речи. Москва.

74. Чанартай боловсрол хөгжлийн баталгаа (илтгэлүүдийн эмхтгэл). УБ.
75. Шагдар,Ш., Батсайхан,Б., (2009) Монгол улсын боловсролын түүхийн тойм боть I УБ.,
76. Шагдар,Ш., Батсайхан,Б., (2010) Монгол улсын боловсролын түүхийн тойм боть II УБ.,
77. Шахнарович А.М, Юрьева, Н.М.(1990). Психолингвистический анализ семантики и грамматики (на материале онтогенеза). Москва.
78. Щеколдин, А. Г., Шагдарсүрэн, Л. (1967). Сургууль судлалын гарын авлага, Улаанбаатар: Шинжлэх Ухааны Академийн Хэвлэх үйлдвэр
79. ЭМЯ-ны харьяа НЭМ-ийн хүрээлэн. (2008). ЕБС-ийн орчны эрүүл ахуйн үнэлгээ
80. Юваль Ной Харари (2016) Sapience. Хүн төрөлхтний товч түүх. УБ
81. Alison J. Elliot. (2012). Child language, Cambridge university press.
82. Gail McCutcheon. (1982). What in the World is Curriculum Theory, Theory into practice, Curriculum Theory. 19
83. Harary Yuval Noah,(2018). 21 Lessons for the 21st Century.
84. Issues in Global Education.No 164,2001.p.4 <http://www.globaled.org>
85. Jonh W. Santrock, (2001). Life-Span Development, USA
86. Kayastha,P. (2010). Security of attachment in children and adolescents. Bangalore: Elsevier B.V.
87. Klaus Schwab,(2017). The Fourth Industrial Revolution
88. KEDI Annual Report (2018) Strengthening research on higher and lifelong education in preparation for the 4th Industrial Revolution Era.
89. McDevitt,T.,&Ormrod,J. (2004).Child Development:Educating and Working with Children and Adolescents (2nd ed.)
90. Robert J.Sternberg (2012). Cognitive Psychology
91. Lounsbury, H.J & Gordon F.V. (1978). A Curriculum for the Middle School Years. New York: Harper & Row,138
92. Peter F.Olivia. (2004). Developing the curriculum. Boston: Pearson education. 139
93. Shuayb, M. &O'Donnell, S. (2008). Aims and Values in Primary Education: England and other countries (Primary Review Research Survey 1/2), Cambridge: University of Cambridge Faculty of Education.
94. WWW.teacher.sur.mn Багшийн хөгжил портал сайт, “Боловсролын салбарын шинэчлэл” төслийн хүрээнд нээсэн.
95. Bagsh.itpd.mn

96. Urchadvar.itpd.mn

97. Gail McCutcheon. (1982). What in the World is Curriculum Theory, Theory into practice, Curriculum Theory. 19
98. Lounsbury, H.J & Gordon F.V. (1978). A Curriculum for the Middle School Years. New York: Harper & Row, 138
99. Peter F. Olivia. (2004). Developing the curriculum. Boston: Pearson education. 139
100. Shuayb, M. & O'Donnell, S. (2008). Aims and Values in Primary Education: England and other countries (Primary Review Research Survey 1/2), Cambridge: University of Cam

МБС-ын салбарт мөрдөж буй тогтоол, дүрэм, журам

1. Засгийн газрын 2011.04.13-ны 117-ны тоот тогтоол “ Мэргэжлийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журам”
2. Засгийн газрын 2012.03.28-ны 94 тоот тогтоол “Зардлын дундаж норматив батлах тухай” /МБСБ-ын нэг суралцагчид ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 4 дүгээр хавсралт/
3. Засгийн газрын 2013.01.26-ны 29 тоот тогтоол “Боловсролын салбарын албан хаагчдын нэмэгдэл хөлсний хувь тогтоох”
4. Засгийн газрын 2016.05.30-ны 290 тоот тогтоол “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн дүрэм батлах тухай”
5. Засгийн газрын 2016.06.06-ны 340 тоот тогтоол “Мэргэжлийн болон техникийн боловсролыг хөгжүүлэх Үндэсний хөтөлбөр”-ийг батлах тухай /2016-2021/”
6. Засгийн газрын 2016.08.24-ний 55 тоот тогтоол, 4-дэх хавсралт “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төв байгуулах тухай”
7. Засгийн газрын 2017.01.25-ны 27 тоот тогтоол “Мэргэжлийн боловсрол, сургалтын Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”

Үндэсний Зөвлөлийн тогтоол:

1. МБСУЗ-ийн 2011.12.30-ны 01 тоот тогтоол “Мэргэжлийн боловсрол, сургалтын мэргэшлийн түвшний загвар батлах тухай”
2. МБСУЗ-ийн 2011.12.30-ны 02 тоот тогтоол “Санхүүгийн дэмжлэгийн хувь хэмжээг тогтоох тухай”
3. Стандартчилал хэмжил, зүйн Үндэсний зөвлөлийн 2015.11.26-ны 45 тоот тогтоол “MNS 6541:2015, Мэргэжлийн боловсрол, сургалт. Ерөнхий стандарт”
4. Боловсролын Магадлан Итгэмжлэлийн Үндэсний Зөвлөлийн Удирдах зөвлөлийн даргын 2016.03.15-ны 001 тоот тогтоол “Мэргэжлийн боловсролын

сургалтын байгууллагын болон хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн шалгуур, шаардлага”

5. Стандартчилал хэмжил, зүйн Үндэсний зөвлөлийн, 2016.03.31-ний тогтоол “Жолоодох эрхийн шалгалтын төв. Ерөнхий шаардлага”
6. Стандартчилал хэмжил, зүйн Үндэсний зөвлөлийн, 2016.03.31-ний тогтоол “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх сургалтын байгууллага. Ерөнхий шаардлага” стандарт

Сайдын тушаал:

1. Хөдөлмөрийн сайдын 2013.05.28-ны А/106 тоот тушаал “Бүсийн арга зүйн төвийн дүрэм, бүтэц, орон тоог батлах тухай”
2. Хөдөлмөрийн сайдын 2013.06.12-ны А/117 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын сурах бичгийг зохиох, орчуулах, хэвшүүлэх, түгээх журам”
3. Хөдөлмөрийн сайдын 2014.09.17-ны А/197 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагад суралцагч элсүүлэх үлгэрчилсэн журам”
4. Хөдөлмөрийн сайдын 2015.07.06-ны А/131 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм”
5. Хөдөлмөрийн сайдын 2015.07.22-ны А/143 “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын удирдах зөвлөлийн бүрэлдэхүүн батлах тухай”
6. Хөдөлмөрийн сайдын 2015.10.19-ний А/197 тоот тушаал “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар батлах тухай”
7. Хөдөлмөрийн сайдын 2015.11.05-ны А/214 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол, сургалтын багшийн хөгжил” хөтөлбөр /2015-2020/
8. Хөдөлмөрийн сайдын 2016.03.03-ны А/53 тоот тушаал “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авахад бүрдүүлэх баримт бичигт тавих шаардлага”
9. Хөдөлмөрийн сайдын 2016.04.18-ны А/93 тоот тушаал “Багшид багшлах эрх, мэргэжлийн зэрэг олгох, хасах журам”
10. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017.01.27-ны А/19 “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын үлгэрчилсэн дүрэм, Удирдах зөвлөлийн үлгэрчилсэн дүрэм батлах тухай”
11. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017.01.27-ны А/21 “Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтын байгууллагын бүтэц, орон тоог батлах тухай”

12. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017.03.27-ны А/50 тоот тушаал “Төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”

Хамтарсан тушаал:

1. Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013.09.27-ны А/198, А/215 тоот тушаал “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам”
2. Хөдөлмөрийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2015.10.05-ны А/180, А/217 тоот тушаал “Тээврийн хэрэгсэл жолоодох эрхийн шалгалт авах журам”
3. Хөдөлмөрийн сайд, Хууль зүйн сайдын хамтарсан 2015.10.05-ны А/181, А/218 тоот тушаал “Жолоодох эрхийн шалгалтын төвийн үйл ажиллагааны журам”
4. Хөдөлмөрийн сайд, БСШУС-ын хамтарсан 2015.10.07-ны А/185, А/405 тоот тушаал “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”
5. Хөдөлмөрийн сайд, БСШУС-ын хамтарсан 2015.12.15-ны А/171, А/496 тоот тушаал “Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх журам”
6. БСШУС-ын сайд, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын хамтарсан 2016.11.02 А/216, А/104 тоот тушаал “Мэргэжлийн сургалтын байгууллагыг бүртгэх, сургалтын үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоох журам”
7. ХНХ-ын сайд, БСШУС-ын сайдын 2017.01.25-ны А/11, А/22 тоот хамтарсан тушаал “Чадамжийн гэрчилгээний загвар”

БСШУС-ын сайдын тушаал:

1. БСШУС-ын 2012.06.05-ны А/303 тоот тушаал “Боловсролын баримт бичгийн загвар шинэчлэн батлах тухай тушаал”
2. БСШУС-ын 2016.04.18-ны А/150 тоот тушаал “Мэргэжлийн чиглэл, индексийг шинэчлэн тогтоох тухай”

ХАВСРАЛТ

ХАВСРАЛТ 1

БСШУ-ны сайдын 1998 оны 100 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

1998-1999 оны хичээлийн жилээс мөрдөх ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөө

д/д	Хичээлийн нэр	7 хоногт үзэх цаг, ангиар										Бүгд
		I	II	III	IV	V	VI	VII	VIII	IX	X	
1	Монгол хэл	280	263	281	238	140	114	122	97	36	36	1607
2	Уран зохиол					61	81	52	52	83	72	361
3	Гадаа хэл					149	132	97	88	99	90	855
4	Математик	144	153	144	145	148	149	149	148	162	153	1495
5	Мэдээлэл зүй									36	36	72
6	Орон нутаг судлал	52	68	68								188
7	Байгалийн шинжлэл				68	62	36					166
8	Газарзүй						43	62	61	36	36	238
9	Биологи						43	70	62	36	72	283
10	Физик, одон орон							61	105	153	135	454
11	Хими							52	61	99	90	302
12	Түүх, нийгмийн ухаан				68	70	87	87	88	36	72	508
13	Дуу хөгжим	52	68	51	88	61						300
14	Дүрслэх урлаг	50	51	68	50	35	35					280
15	Зохион бүтээх хөдөлмөр, зураг төсөл	34	34	34	34	44	70	88	78	72	72	560
16	Биеийн тамир	68	68	68	68	70	70	70	70	72	72	696
17	Заавал суралцах бусад хичээл	34	34	34	34	35	35	35	35	36	36	348
18	Сургууль зохицуулах бусад хичээл	34	34	34	34	70	70	70	105	144	108	703
	Нийт цаг	748	773	782	807	945	945	1015	1050	1080	1080	9225

Тайлбар:

- Эрүүл мэнд, экологи, эдийн засаг, эрх зүй зэрэг бүх нийтийн ерөнхий боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн заавал суралцах бусад хичээлийг тухайн сургуулийн сурагчдын тооноос хамааран ангиар буюу факультет хэлбэрээр бүх сурагчдад судлахаар зохион байгуулна. Эдгээр хичээлийн агуулгыг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
- Суралцагчдын эрэлт хэрэгцээ, авьяас сонирхолд үндэслэн ерөнхий эрдмийн аль ч чиглэлээр гүнзгийрүүлсэн болон төрөлжүүлсэн сургалт мөн техник технологи, үндсэн бус гадаад хэл, байгалийн ухааны нэгдмэл хичээл зэрэг сургууль нь зохицуулах хичээлийг ангиар, бүлгээр, холимог бүлгээр хичээлийн хуваарьт оруулан зохион байгуулна. Энэ төрлийн хичээлийн агуулгыг сургуулийн сурган хүмүүжүүлэх зөвлөл тогтооно.
- Албан сургалтын хүрээнд энд заасан нийлбэр цагаас илүү цагаар сургалт зохион явуулахыг зөвшөөрөхгүй.

Хавсралт 2

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 5 дугаар сарын 20 өдрийн 164 тушаалын 2 дүгээр хавсралт

Бага боловсролын шилжилтийн сургалтын төлөвлөгөө

Боловсролын чиглэл	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг (ангиар)					Нийт цаг
		Шинэ системийн		Шилжилтийн			
		I	II	III	IV	V	
Хэл	Монгол хэлбичиг	252	252	252	252	252	1260
	Англи хэл				72	108	180
Урлаг, гоо зүй	Хөгжим, бүжиг	36	36	36	36	36	180
	Эрүүл мэнд, биеийн тамир	108	108	108	108	108	540
	Зураг, урлал	72	72	36	36	36	252
Математик	Математик,	144	144	144	144	144	720
	Мэдээлэл зүй					36	36
Нийгмийн ухаан	Хүн ба нийгэм	108	108	36	36	36	216
Байгалийн ухаан	Хүн ба байгаль			36	36	36	216
Технологи	Хөдөлмөр			36	36	36	108
Хичээлийн нийт цаг		720	720	684	756	828	3708
Долоо хоногийн хичээлийн цагийн тоо		20	20	19	21	23	
Төсөлт ажлын цаг				36	36	36	108
Төрөлх нутгаа судлах ажлын цаг		36	36	36	36	36	180
Сургуулийн мэдлийн цаг		36	36	36	36	36	180
Жилийн цагийн дээд хэмжээ		792	792	792	864	936	4176
Долоо хоногт ноогдох нийт цагийн тоо		22	22	22	24	26	

Тайлбар:

- I-II ангид “Хүн ба байгаль”, “Хүн ба нийгэм” хичээлийг нэгдмэл байдлаар “Хүрээлэн буй орчин” гэсэн агуулгаар, орон нутгийн нийгэм, соёл, ёс заншил, хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай танилцуулах байдлаар танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.
- III-V ангийн монгол хэлбичгийн цагт монгол бичгийг багтаан үзнэ.
- Төсөлт ажлыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.
- Төрөлх нутгаа судлах ажлыг орон нутгийн байгаль орчин, хүмүүсийн аж төрөх ёс, ажил, амьдрал, үнэт зүйлсийг танхимын болон танхимын бус хэлбэрээр судална.
- Сургуулийн мэдлийн цагт багтаан хамт олны ажил, секц, дугуйлан, сонгон суралцах, түр сургалтыг зохион байгуулна.

- IV ангид үзэх англи хэлний хичээлээр үсэг шууд заахгүй, харин хүүхдийн сонсох, ярих чадварыг хөгжүүлнэ.
- Эрүүл мэнд, биеийн тамирын хичээлийн 36 цагт нь эрүүл мэндийн агуулгыг тусгайд нь судална.

Эх сурвалж: Ерөнхий боловсролын сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд мөрдөх шилжилтийн сургалтын төлөвлөгөө. УБ., 2005 он

Хавсралт 3

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 5 дугаар сарын 20 өдрийн 164 тушаалын 3 дугаар хавсралт

Суурь боловсролын шилжилтийн сургалтын төлөвлөгөө

Боловсролын чиглэл	Хичээлийн нэр	Шилжилтийн ангиудын жилийн нийт цаг				Нийт цаг
		VI	VII	VIII	IX	
Хэл	Монгол хэлбичиг	148	111	111	111	1406
	Уранзохиол	74	74	74	74	
	Англи хэл	111	111	167	148	
	2 дахь гадаад хэл		92			
Урлаг, гоо зүй	Хөгжим, бүжиг	37	37	37	37	666
	Дүрслэх урлаг, дизайн	37	37			
	Эрүүл мэнд, биеийн тамир	111	111	111	111	
Математик	Математик,	148	148	148	140	740
	Мэдээлэл зүй	37	37	37	45	
Нийгмийн ухаан	Иргэншил	37	37	37	37	351
	Түүх	37	56	55	55	
Байгалийн ухаан	Байгаль шинжлэл	74	30			702
	Физик		27	56	74	
	Биологи		54	55	56	
	Газарзүй		54	55	55	
	Хими			56	56	
Технологи	Зураг төсөл			37	37	370
	Технологи	74	74	74	74	
Хичээлийн нийт цаг		925	1090	1110	1110	4235
Долоо хоногийн хичээлийн цагийн тоо		25	28-30	30	30	
Төсөлт ажлын цаг		37	37	37	37	148
Төрөлх нутгаа судлах ажлын цаг		37	37	37	37	148
Сургуулийн мэдлийн цаг		74	74	74	74	296
Жилийн цагийн дээд хэмжээ		1073	1238	1258	1258	4827
Долоо хоногт ноогдох нийт цагийн тоо		29	32-34	34	34	

Тайлбар:

- VIII, IX ангид англи, орос хэлийг хоёуланг судална.
- Иргэншил, түүх, байгаль шинжлэл, газарзүй, биологийн хичээлийн агуулгыг орон нутгийн түүх, соёл, хүмүүсийн амьдрал, байгаль, цаг агаар, аж ахуй эрхлэх арга, технологи, зан үйлийн үнэт зүйлсээр баяжуулан судална.
- Эрүүл мэнд, иргэншил, технологи болон бүхий л хичээлийн агуулгаар амьдрах ухааны суурь чадварыг эзэмшүүлнэ.

- Төсөлт ажлыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.
- Төрөлх нутгаа судлах ажлын цагт багтаан орон нутгийн байгаль орчин, хүмүүсийн аж төрөх ёс, ажил, амьдрал, үнэт зүйлсийг танхимын болон танхимын бус хэлбэрээр судална.
- Сургуулийн мэдлийн цагт багтаан хамт олны ажил, секц, дугуйлан, сонгон суралцах, түр сургалтыг зохион байгуулна.
- “2 дахь гадаад хэл” хичээлээр орос буюу өөр нэг гадаад хэлийг судалж болно.
- Эрүүл мэнд, биеийн тамирын хичээлийн 37 цагт нь эрүүл мэндийн агуулгыг тусгайд нь судална.

Эх сурвалж: Ерөнхий боловсролын сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд мөрдөх шилжилтийн сургалтын төлөвлөгөө. УБ. 2005 он

Хавсралт 4

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 5 дугаар сарын 20 өдрийн 164 тушаалын 4 дүгээр хавсралт

Бүрэн дунд боловсролын шилжилтийн сургалтын төлөвлөгөө

Боловсролын чиглэл	Судлагдахуун	Шилжилтийн Х анги		Шилжилтийн бус Х анги
		Цаг	Тайлбар	
Хэл	Монгол хэл, уранзохиол I	114	○	114
	Монгол хэл, уранзохиол II	190		
	Англи хэл I	114	○	96
	Англи хэл II	190		
	2 дахь гадаад хэл I	76	○	
	2 дахь гадаад хэл II	114		
Урлаг, гоо зүй	Эрүүл мэнд, биеийн тамир	114	□	114
Математик, мэдээлэл зүй	Математик I	133	○	162
	Математик II	209		
	Мэдээлэл зүй	38	□	38
Нийгмийн ухаан	Иргэн ба нийгэм I	57	○	76
	Иргэн ба нийгэм II	114		
Байгалийн ухаан	Физик I	95	○	141
	Физик II	152		
	Хими I	95	○	96
	Хими II	114		
	Биологи I	38	○	76
	Биологи II	76		
	Газарзүй I	38	○	38
	Газарзүй II	76		
Технологи	Зураг төсөл	38	□	76
	Технологи	76	□	
Мэргэжлийн сургалт	Мэргэжлийн технологи	162	●	
	Урлаг	162		
	Спорт	162		
Төсөлт ажлын цаг		38	□	38
Төрөлх нутгаа судлах ажлын цаг		38	□	
Сургуулийн мэдлийн цаг		76	□	114
Заавал судлах бусад хичээл				38
Нийт цаг				1217

Тэмдэглэгээ:

- Заавал судлах хичээл,
- Аль нэгийг заавал судлах,
- Мэргэжлийн сургалттай ангид хэрэгцээ, сонирхлынхоо дагуу аль нэгийг сонгон судалж болох

Тайлбар:

- Суралцагчдын хичээлийн жилийн нийт ачаалал 1330 цагаас хэтрэхгүй байна.
- Суралцагч хичээлүүдийн 2 дугаар хувилбараас дор хаяж 1-ийг заавал сонгосон байна.
- Мэргэжлийн технологийн сургалттай ангид зураг төсөл, технологийн цагийг, спортын сургалттай ангид биеийн тамирын цагийг тус тус нэмж судалж болно.
- Ахлах сургуулийн сургалтын ердийн, гүнзгийрүүлсэн, мэргэжлийн гэсэн хэв шинжид нийцүүлэн сонголтыг зохион байгуулна.
- Төсөлт ажлыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.
- Төрөлх нутгаа судлах ажлын цагт багтаан орон нутгийн байгаль орчин, хүмүүсийн аж төрөх ёс, ажил, амьдрал, үнэт зүйлсийг танхимын болон танхимын бус хэлбэрээр судална.
- Сургуулийн мэдлийн цагт багтаан хамт олны ажил, секц, дугуйлан, сонгон суралцах, түр сургалтыг зохион байгуулна.
- Гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн сургалтыг нөхцөл боломж бүрдсэн сургууль зохион байгуулна.
- Шилжилтийн бус Х ангид хичээлийг хувилбаргүйгээр судална.
- Шилжилтийн бус Х ангийн төсөлт ажлын цагт багтаан төгсөлтийн ажил хийнэ.
- Эрүүл мэнд, биеийн тамирын хичээлийн 38 цагт нь эрүүл мэндийн агуулгыг тусгайд нь судална.

Эх сурвалж: Ерөнхий боловсролын сургуульд 2005-2006 оны хичээлийн жилд мөрдөх шилжилтийн сургалтын төлөвлөгөө. УБ. 2005 он

Хавсралт 5

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 6 дугаар сарын 16 өдрийн 236 тушаалын 2 дугаар хавсралт

Ерөнхий боловсролын сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөө (11 жилийн сургуулийн бага анги)

Сургалтын хэлбэр	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг					Нийт цаг	
		I	II	III	IV	V		
Хичээл	Монгол хэл	272	272	272	238	238	1292	
	Англи хэл				68	102	170	
	Математик	170	170	170	136	136	782	
	Хүн-орчин		102	102	102	Хүн-нийгэм		170
						34	34	
						Хүн-байгаль		170
	34	34						
	Эрүүл мэнд		170					
	34	34						
			34	34	34	34	170	
			68	68	68	68	340	
Хөгжим		68	68	68	Дүрслэх урлаг		170	
					34	34		
					Технологи		170	
34	34							
Хичээлийн нийт цаг		714	714	714	714	748	3604	
Долоо хоногт оногдох хичээлийн цаг		21	21	21	21	22		
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	Сургууль зохицуулах цаг				34	34	68	
	Төсөлт ажлын цаг				34	34	68	
	Иргэний боловсрол	34	34	34	34	34	170	
Жилийн нийт ачаалал		748	748	748	816	850	3910	
Долоо хоногт ноогдох нийт цаг		22	22	22	24	25		

Тайлбар:

- Бага ангийн нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 40 минут байна.
- “Иргэний боловсрол” хичээлээс гадуурх ажлын агуулга нь суралцагчийн сургууль, нийгмийн олон талт ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдад аюулгүй амьдрах арга ухааныг эзэмшүүлэх, хүн, байгаль орчинтой харилцах зөв хандлага төлөвшүүлэх, иргэний ардчилсан нийгэмд ажиллаж амьдрах чадвар, дадал олгоход чиглэнэ.
- Сургууль зохицуулах цагт суралцагчийн хэрэгцээ сонирхлын дагуу түр сургалт, дугуйлан зэргийг хичээлээс гадуурх ажлаар зохион байгуулна.
- Төсөлт ажлыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.

Эх сурвалж дээрх тушаал

Хавсралт 6

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 6 дугаар сарын 16 өдрийн 236 тушаалын 3 дугаар хавсралт

Ерөнхий боловсролын сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөө (11 жилийн сургуулийн дунд анги)

Сургалтын хэлбэр	Хичээлий нэр	Жилийн нийт цаг				Нийт цаг
		VI	VII	VIII	IX	
Хичээл	Монгол хэл, монгол бичиг	175	105	105	105	490
	Уранзохиол	70	70	70	70	280
	Англи хэл	105	105	88	88	386
	Орос хэл		105	70	70	245
	Математик	140	140	140	140	560
	Иргэншил	35	35	35	35	140
	Түүх	70	70	70	70	280
	Байгалийн шинжлэл	70				70
	Физик		35	70	80	185
	Газарзүй		45	51	67	163
	Биологи		60	54	45	159
	Хими			87	70	157
	Эрүүл мэнд	35	35	35	35	140
	Биеийн тамир	70	70	70	70	280
	Хөгжим	35	35	35	35	140
	Дүрслэх урлаг	35	35			70
	Зураг төсөл			35	35	70
	Технологи	70	70	70	70	280
	Мэдээлэл зүй	35	35	35	35	140
Хичээлийн нийт цаг		945	1050	1120	1120	4235
Долоо хоногт оногдох хичээлийн цаг		27	30	32	32	
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	Сургууль зохицуулах цаг	35	35	35	35	140
	Төсөлт ажлын цаг	35	35	35	35	140
	Иргэний боловсрол	35	35	35	35	140
Жилийн нийт ачаалал		1050	1155	1225	1225	4655
Долоо хоногт ноогдох нийт цаг		30	33	35	35	

Тайлбар:

- Дунд ангийн нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна.
- “Иргэний боловсрол” хичээлээс гадуурх ажлын агуулга нь суралцагчийн сургууль, нийгмийн олон талт ажилд оролцох оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдад аюулгүй амьдрах арга ухааныг эзэмшүүлэх, хүн, байгаль орчинтой харилцах зөв хандлагыг төлөвшүүлэх, иргэний ардчилсан нийгэмд ажиллаж амьдрах чадвар, дадал олгоход чиглэсэн байна.

- Сургууль зохицуулах цагт тухайн цаг үеийн шаардлага, нийгмийн захиалга, суралцагчийн хэрэгцээ сонирхлын дагуу түр сургалт, дугуйлан зэргийг хичээлээс гадуурх ажлаар зохион байгуулна.
- Төсөлт ажлыг танхимын болон танхимын бус хэлбэрээр зохион байгуулна.

Эх сурвалж дээрх тушаал

Хавсралт 7

Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2006 оны 6 дугаар сарын 16 өдрийн 236 тушаалын 4 дүгээр хавсралт

Ерөнхий боловсролын сургуульд 2006-2007, 2007-2008 оны хичээлийн жилд мөрдөх сургалтын төлөвлөгөө (11 жилийн сургуулийн ахлах анги)

Сургалтын хэлбэр	Хичээлийн нэр	Жилийн нийт цаг	
		X	XI
Заавал судлах хичээл	Монгол хэл, уран зохиол	105	105
	Англи хэл	105	105
	Математик	105	105
	Нийгмийн ухаан	105	105
	Байгалийн ухаан	105	105
	Эрүүл мэнд	35	35
	Биеийн тамир	70	70
	Мэдээлэл зүй	35	35
	Технологи, зураг төсөл	70	70
Сонгон судлах хичээл	Монгол хэл	140	140
	Монгол бичиг		
	Уранзохиол		
	Гадаад хэл		
	Алгебр		
	Геометр		
	Магадлан статистик		
	Хэрэглээний математик		
	Монголын түүх		
	Иргэн ба нийгэм		
	Философи		
	Ёс зүй		
	Эрх зүй		
	Эдийн засаг		
	Логик		
	Физик		
Хими			
Биологи			
Газарзүй			
Экологи			
Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт	Ерөнхий механик, менежмент, барилгын засал чимэглэл, хүнсний технологи, оёдол эсгүүр, фермерийн аж ахуй, жолооч-засварчин, гагнуур, цахилгаан болон электрон техник, үсчин гоо засал, асрах, сувилахуй, компьютерын засвар, худалдаа үйлчилгээ, бизнес, уламжлалт технологи гэх мэт.		
Хичээлээс гадуурх үйл ажиллагаа	Иргэний боловсрол төсөлт ажил	35	35
	Сургууль зохицуулах цаг	35	35

Тайлбар:

- Суралцагчдын хичээлийн жилийн нийт ачаалал 1225 цагаас хэтрэхгүй байна.
- Ахлах ангид нэгж хичээлийн үргэлжлэх хугацаа 45 минут байна
- “Иргэний боловсрол” хичээлийн бус ажлын агуулга нь сургууль, нийгмийн олон талт ажилд суралцагчийн оролцоог нэмэгдүүлэх, суралцагчдад аюулгүй амьдрах арга ухааныг эзэмшүүлэх, хүн, байгаль орчинтой харилцах зөв хандлага төлөвшүүлэх, иргэний ардчилсан нийгэмд ажиллаж амьдрах чадвар, дадал олгоход чиглэсэн байна.
- Суралцагчид сонгон судлах хичээлээс 3-аас дээшгүй хичээлийг сонгох боломжтой бөгөөд хичээл тус бүрийг 140 цагаар судална.
- Сургууль зохицуулах цагт тухайн цаг үеийн шаардлага, нийгмийн захиалга, суралцагчийн хэрэгцээ сонирхлын дагуу түр сургалт, дугуйлан зэргийг хичээлээс гадуурх ажлаар зохион байгуулна.

Эх сурвалж дээрх тушаал

Хавсралт 8

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд хичээлүүдийн цагийн эзлэх хувь

Бага, суурь боловсролын түвшинд 1-8 (9) анги

Сургалтын төлөвлөгөөний батлагдсан бүтэц	1972 он 10 жил	1987 он 10 жил	1998 он 10 жил	2006 он 11 жил	2007 он /төсөл / 12 жил
	3+5+2	3+5+2	4+4+2	5+4+2	6+3+3
Монгол хэл уран зохиол	2310 28,9%	2269 29,9%	1781 27,7%	2062 26,3%	1920 26,4%
Гадаад хэл	770 9,6%	765 9,7%	466 7,3%	801 10,2%	485 6,6%
Математик	1632 21,1%	1621 20,7%	1172 18,3%	1308 16,6%	1198 16,5%
Байгалийн ухаан	1291 16,1%	1082 13,8%	974 15,2%	904 11,5%	919 12,6%
Нийгмийн ухаан	420 5,2%	455 5,7%	400 6,2%	590 7,5%	501 6,9%
Гоо зүй	449 5,6%	447 5,7%	609 9,5%	550 6,6%	580 7,9%
Зохион бүтээх хөдөлмөр технологи зураг төсөл	557 6,9%	622 7,9%	416 6,5%	520 6,6%	466 6,5%
Биеийн тамир эрүүл мэнд	554 6,9%	552 7,0%	552 8,6%	930 1,8%	893 12,3%
Мэдээлэл зүй	-	-	-	174 2,2%	174 2,4%
Заавал судлах нийт цаг	7983	7813	6370	7839	7275
Хичээлээс гадуурх ажлын цаг	140 1,7%	525 6,29%	272 4,0%	726 8,4%	760 9,4%
Нийт цаг	8123	8338	8 жил 6642	9 жил 8565	9 жил 8035

Хавсралт 9

Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын төлөвлөгөөнд ахлах ангийн хичээлүүдийн эзлэх цагийн харьцуулсан судалгаа

Сургалтын төлөвлөгөөний батлагдсан бүтэц	1972 он /10 жил /	1987 он /1987-1988/	1998 /10 жил/	2006 он /11 жил	2007 /төсөл / 12 жил	
					I хувилбар	II хувилбар
<i>Бүлэг хичээлүүд</i>	3+5+2	4+4+2	4+4+2	5+4+2	6+3+3	6+3+3
Монгол хэл уран зохиол	315 3,2%	280 12,3%	227 11,3%	210 11,1%	315 13,6%	350 11,0%
Гадаад хэл	245 10,5%	245 10,8%	189 10,3%	210 11,1%	630 27,2%	630 19,5%
Математик	350 14,8%	350 15,4%	387 20,6%	210 11,1%	315 13,6%	420 13,1%
Байгалийн ухаан	840 35,3%	700 30,8%	657 19,4%	210 11,1%	315 13,6%	910 28,2%
Нийгмийн ухаан	315 13,3%	140 6,2%	108 5,9%	210 11,1%	315 13,6%	315 9,7%
Гоо зүй	-	-	-	-	-	-
Зохион бүтээх хөдөлмөр технологи зураг төсөл	175 7,4%	280 12,3%	144 7,9%	140 10,1%	210 9,0%	210 6,5%
Биеийн тамир, эрүүл мэнд	140 5,9%	140 6,2%	114 6,2%	210 11,1%	210 9,0%	210 6,5%
Мэдээлэл зүй	-	-	72 3,8%	70 3,7%	210 9,0%	175 5,4%
Заавал судлах нийт цаг	2380	2275	1856	1610	2310	3220
Хичээлээс гадуурх ажлын цаг	175	490	324	140	105	455
Нийт цаг	2557	2765	2180	2030	2415	3675